

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



ТОЙМ АГУУЛГА

- ◇ Эдийн засгийн хөгжлийн асуудал
- ◇ Санхүү, татварын асуудал
- ◇ Уул уурхайн салбарын асуудал

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

“Судалгааны эмхэтгэл” (XVI боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Г.Билгээ

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

- 1.1. Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга туршлага (Харьцуулсан судалгаа) 6
Б.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Элбэгзаяа
- 1.2. Үйлдвэржүүлэлтийн бодлого, төлөвлөлтийн талаарх бусад орны арга туршлага (Харьцуулсан судалгаа) 60
Д.Байгалмаа, Ц.Элбэгзаяа
- 1.3. Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, онцлог, түүхэн хөгжлийн талаарх гадаадын зарим орны туршлага (Харьцуулсан судалгаа) 91
Д.Живгаагүнсэл, Ц.Болормаа, Г.Билгээ
- 1.4. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бусад орнуудын туршлага (Мэдээлэл лавлагаа) 165
Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаа
- 1.5. Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож ирсэн байдал, гадаадын зарим орны бүсийн нэмэгдэл олгодог туршлага (Мэдээлэл лавлагаа) 177
Д.Живгаагүнсэл
- 1.6. Логистикийн сүлжээний талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт (Мэдээлэл лавлагаа) 194
Г.Билгээ, Ч.Онончимэг

II БҮЛЭГ. САНХҮҮ, ТАТВАРЫН АСУУДАЛ

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн зохицуулалтын талаарх бусад орнуудын туршлага, олон улсын нийтлэг стандарт (Харьцуулсан судалгаа) 206
Ц.Норовдондог, Г.Алтан-Оч, Б.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Болормаа, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
- 2.2. Хувьцаа барьцаалан зээлдэх эрх зүйн зохицуулалтын талаарх зарим орнуудын туршлага (Мэдээлэл лавлагаа) 244
Д.Байгалмаа, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
- 2.3. Оффшор бүсийн тухай ойлголт, оффшор бүсэд компани байгуулах, хөрөнгө эзэмшихтэй холбоотой харилцаа болон төрийн өндөр албан тушаалтан оффшор бүсэд данс нээх, хөрөнгө эзэмших, ашиглахыг хязгаарлах асуудлаарх бусад орнуудын туршлага (Харьцуулсан судалгаа) 251
Ц.Норовдондог, Б.Байгалмаа, Г.Билгээ, Ч.Онончимэг

2.4.	Нэмэгдсэн өртгийн татвар ба худалдааны албан татвар, тэдгээрийн онцлог, давуу болон сул тал (Харьцуулсан судалгаа)	276
------	--	-----

Ц.Норовдондог, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

2.5.	Түрээсийн татварын талаарх зарим улсын эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа)	296
------	---	-----

*Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл,
Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

III БҮЛЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АСУУДАЛ

3.1.	Бүтээгдэхүүн хуваах гэрээ - Бүтээгдэхүүн хуваах зарчим, хуваарилалтын бүтэц (Бодлогын судалгаа)	318
------	--	-----

Г.Алтан-Оч

3.2.	Монгол Улс дахь ураны хайгуул, олборлолт, ашиглалттай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал (Дүн шинжилгээ)	331
------	---	-----

Ц.Болормаа, Ц.Элбэгзаяа

3.3.	Гадаадын зарим орны газрын тосны эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа (Харьцуулсан судалгаа)	349
------	--	-----

Г.Билгээ, Ч.Онончимэг

3.4.	Хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс (Мэдээлэл лавлагаа)	364
------	--	-----

Г.Алтан-Оч, Ц.Элбэгзаяа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1

БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ДЭЛХИЙД ХӨГЖЛӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЭГЧ ЗАРИМ ОРНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ТУРШЛАГА**
(Харьцуулсан судалгаа)

Д.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

1. Оросын Холбооны Улс
2. Швейцарын Холбооны Улс
3. Их Британи
4. Малайзын Холбооны Улс
5. Бүгд Найрамдах Солонгос Улс
6. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
7. Япон Улс

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Дэлхий дахинд хөгжлөөрөө тэргүүлэгч, хөгжлийн тогтвортой, тодорхой бодлого хэрэгжүүлдэг зарим орнуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онцлог, арга туршлага болон бодлого боловсруулахад баримталдаг зарчим, бодлогын хоорондын уялдаа холбоо, амжилтад хүрсэн туршлага, ирээдүйн хөгжлийн төлөвлөлт болон төсөөллийн талаарх асуудлыг судлахад оршино.

Судалгааны хамрах хүрээ

Захиалагчийн хүсэлтийн дагуу Швейцар, Их Британи, Япон, Өмнөд Солонгос, Хятад, Орос, Малайз улсуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн туршлагыг судалсан болно.

Судалгааны хураангуй

Стратеги төлөвлөлт гэдэг нь тухайн байгууллага, эсхүл салбар, бүс нутаг, үндэсний хэмжээнд хөгжлийн дотоод давуу байдал, сул тал, нөөц, боломжууд, эдийн засгийн болон бусад орчны өөрчлөлтийн нөлөөгөөр үүсэж болох хүндрэл бэрхшээл, эрсдлийг шинжлэн үнэлсний үндсэн дээр стратегийн зорилтуудаа тодорхойлж, түүнд хүрэх үйл ажиллагааг тусгасан өргөн цар хүрээтэй төлөвлөгөө юм. Мөн энэхүү баримт бичигт хөгжлийн талаар баримтлах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэглэгч, харилцагчдад хэрхэн оновчтой хүргэх арга замуудыг тодорхойлсон байдаг.

Өнөөг хүртэл хөгжлийн талаарх тодорхой “жор” бий болоогүй байна. Аливаа улсын үндэсний хөгжлийн бодлого нь сүүлийн хэдэн арван жилийн түүхээс сургамж авч, өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудыг оновчтой тогтоон, улмаар ойрын ирээдүй буюу 10-20 жилийн хугацаанд ард иргэдийн сайн сайхан амьдралыг бий болгон баталгаажуулахад чиглэгдэж байна.


Ингэхдээ хөгжлийн алтан гурвалжин болох нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлуудыг ямагт анхаарлынхаа төвд, тэнцвэртэй байлгаж байна.

Богино хугацаанд буурай хөгжлөөс хөгжингүй улс болж чадсан орнууд улсаа хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд урт, дунд, богино хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган зохион байгуулах, хянах тогтолцоог бий болгон гол удирдлагаа болгож ирсэн.

Онолын хувьд, урт хугацааны хөгжлийн бодлогод дунд хугацааны, дунд хугацааны хөгжлийн бодлогод богино хугацааны бодлого үндэслэж төлөвлөгдөх бөгөөд бодлого төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүд нь өөр хоорондоо дэвшүүлсэн зорилго, зорилт, хамрах түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээ буюу агуулга, бүтцийн хувьд харилцан уялдсан байх ёстой байдаг.

Хувь хүний ажиллах, амьдрах орчин төдийгүй тухайн улс орныг бүхэлд нь өөрчилж чадахуйц хэрэгсэл бол бодлого, төлөвлөлт юм. Зөв төлөвлөлтийн систем өөрөө зөв хөгжилд хүрэх, зөв цагт, зөв газарт байх баталгаа нь болж өгдөг байна. Энэ нь ажлын байр шинээр бий болгох, орон сууц барихаас өгсүүлээд, хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах, эрдэс, баялгийн хувь хишгийг хүн бүхэнд хүртээмжтэй хүргэх, илүү сайн боломжийг бий болгохын тулд шударгаар хуваарилах зэрэг хүмүүсийн амьдралд эерэг өөрчлөлтүүдийг авчирна. Харин муу төлөвлөлтийн систем нь эсрэгээр өнөө болон дараачийн үедээ эвдэрч нурсан байшин барилга, эмх замбараагүй байдал, түгшүүрт гэмт хэрэг бий болгож, цаашлаад улс орны хөгжилд нөхөж баршгүй хохирол учруулна. Сайн төлөвлөлт нь нэгэнт эерэг зүйл учир тулгамдсан асуудлыг тухайн бий болсон цаг үед нь биш харин урьдчилж харах, ухаалгаар даван туулах, мөн төлөвлөлтийн системийг нийтлэг ашиг сонирхолд нийцүүлэх, тулгамдсан асуудалд чиглүүлэх, хянах иж бүрэн үйл явц юм. Төлөвлөлтийн амин цөм нь **тогтвортой хөгжил** байдаг байна¹. Тогтвортой хөгжлийн үндсийг өнөө болон хойч үеийн хүн бүрд илүү сайн амьдралын баталгааг бий болгох явдал юм.

Зураг 1. Тогтвортой хөгжлийн бүтэц



Хөгжлийн талаарх хамгийн өргөн хэрэглэгддэг тодорхойлолтод... “Өнөө үеийн хэрэгцээг хойч үеийн чадварыг бууруулахгүй байдлаар хангахтай холбогдсон зүйл” гэсэн байдаг. Энэ нь хүн бүрийн хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн нийгмийн дэвшил, хүрээлэн буй орчныг үр дүнтэй хамгаалах, байгалийн баялгийг сэтгэлийн хөөрлөөр биш харин болгоомжтой, ухаалгаар ашиглах, эдийн засаг, ажил эрхлэлтийг тогтвортой, өндөр түвшинд авч явах явдал юм.

Хөгжлийн төлөвлөлт нь тухайн улс орны хэтийн стратеги зорилтод тусгагдсан тогтвортой хөгжлийн зарчмуудтай нийцсэн, нэгдмэл байдлаар хийгдэх ёстой. Бүс нутгийн төлөвлөлтийн байгууллагууд болон орон нутгийн удирдлагууд дээрх хөгжлийн

¹Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.

төлөвлөлттэй байнга зэрэгцэн явах учиртай бөгөөд хүрээлэн буй орчин, эдийн засаг хийгээд нийгмийн зорилтод хүрэхэд дорвитой түлхэц үзүүлдэг. Ялангуяа тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, боломжит нөлөөллийг бууруулахад бүс нутгийн төлөвлөлтийн байгууллагууд, орон нутгийн удирдлагууд чухал үүрэгтэй.

Үндэсний, салбарын, бүс нутгийн төлөвлөлтийн зорилгыг тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэх, тэдгээр зорилго, зорилтыг биелүүлэхэд дэмжлэг болж өгөх хөтөлбөрийг боловсруулахдаа нөөцийг хуваарилах замаар төлөвлөх ба дор дурдсан тэргүүн туршлагын зарчмууд чухал. Үүнд:

- *Нэг ижил нэр томьёо хэрэглэх.* Төлөвлөлтийн үйл явцад нэг ижил, товч тодорхой нэр томьёо хэрэглэж, тэдгээрийн талаар нэгдсэн ойлголттой байх явдал чухал бөгөөд энэ нь мөн хяналт үнэлгээ хийх үйл явцыг хөнгөвчилнө.
- *Төлөвлөлтийн үе шатууд хоорондоо уялдаатай байх.* Урт, дунд, богино төлөвлөлтийг бэлтгэхдээ үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг суурь болгож, уялдуулах.
- *Төлөвлөлт, гүйцэтгэл хоёрыг тэнцвэртэй байлгах.* Төлөвлөлтийн баримт бичгүүд хоорондоо давхардаагүй байх бөгөөд төлөвлөлтийн үйл явц бүрд хэрэг гүйцэтгэлийг байнга дүгнэж байх хэрэгтэй.

Амжилтад хүрсэн улсууд нь:

- бизнесийн тэргүүлэх салбарыг сонгох,
- тэргүүлэх чиглэл, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх,
- техник, технологийн дэвшил, ололт амжилт,
- эрчим хүч, дэд бүтцийн бодлого, нөөц баялгийг бий болгох,
- экспортын боломж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зэрэгт анхаарч төлөвлөгөө боловсруулан эдийн засгийн суурийг бэхжүүлдэг байна.

Хөгжилтэй орнуудын хөгжлийн бодлого нь аливаа улс төрийн хүчин, төрийн эрх барих хүчний харьцаанаас үл хамааран тогтвортой хэрэгжиж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр л түүнд өөрчлөлт оруулж болдог байна.

Улс орны эдийн засгийн өсөлт, амжилтыг дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ээр хэмжих нь шаардлага хангахаа больсон тул түүний оронд “Inclusive growth” буюу “өргөн хүрээг хамарсан өсөлт” гэдэг хэмжээсийг хэрэглэх саналыг анх Япон Улс гаргажээ. Өргөн хүрээг хамарсан өсөлт нь тухайн улс орны ядуурлын хэмжээг бууруулах, өсөлтийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл явц аж.

Богино хугацаанд хөгжиж чадсан улс орны нэг болох Япон улсын туршлагаас харахад: Төр нь макро түвшний болон дэд бүтэц, аж үйлдвэрлэлийн салбарт олон улсын хэмжээнд хүчин чадал хийгээд өрсөлдөх чадварыг бий болтол нь дэмжлэг үзүүлээд, түүнээс хойш чадавхжсан хувийн хэвшлийнхэн болон томоохон корпорациуд улс орны эдийн засгийг авч явдаг байна. Харин төр нь цаашид “эдийн засгийн статистик менежмент” л хийх үүрэгтэй болдог байна.

Япон Улсын хөгжил дэвшилд хүрэх, эдийн засгаа сэргээн хөгжүүлэх оновчтой бодлогын гол цөм нь дотоод, гадаад зах зээлийн боломжид нийцүүлэн хөгжүүлэх салбараа зөв сонгож авсан, аж үйлдвэрийн зохистой бүтцийг бүрдүүлж, төрөөс оновчтой дэмжлэг үзүүлж чадсан явдал юм.

Япон, Солонгос улс хөгжлийн бодлогоо төлөвлөхдөө нарийн тогтоосон зарчим, хугацаагүй боловч, тухайн асуудлын цар хүрээ, онцлогоос нь хамааруулан урт дунд богино хугацаанд төлөвлөдөг нь харагдаж байна. Тухайлбал Япон улсын хувьд урт хугацаанд харилцан уялдаатай хэрэгжүүлсэн бодлогууд болох Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөнүүдээс харахад хугацааны хувьд 8, 10, 15, 25 жил гэсэн харилцан адилгүй хугацаатай байна.

ОХУ-д стратеги төлөвлөлтийн зарчим, зорилтуудаас үзэхэд ОХУ-д нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх явдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай салшгүй холбоотой, түүнд нийцсэн байхыг шаардсан байна.

1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

1.1. Таван жилийн төлөвлөгөө

Анхны стратегийн төлөвлөгөө 1920 онд Орос улсад үүссэн бөгөөд энэ нь Орос орныг хөгжүүлэх болон цахилгаанжуулах төлөвлөгөө (ГОЭЛРО) юм.


Зөвлөлт Холбоот Улс /ЗХУ/-ын эдийн засгийг хурдацтай хөгжүүлэх төвлөрсөн эдийн засгийн төлөвлөгөөгөө таван жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байсан. Таван жилийн төлөвлөгөөг ЗХУ-ын Коммунист намын удирдлага доор Улсын төлөвлөгөөний байгууллага нийт үндэсний хэмжээнд төвлөрүүлэн боловсруулж байжээ. ЗХУ түүхэндээ нийт 13 таван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн ба анхдугаар таван жилийн төлөвлөгөөг 1929-1933 онд хэрэгжүүлэхээр 1928 онд баталсан. Харин хамгийн сүүлийн 13-р таван жилийн төлөвлөгөөг 1991-1995 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч ЗХУ задран унаснаас үүдэн хэрэгжүүлж чадаагүй. /Зураг 2./ Гэхдээ энэ хугацаанд хүнд аж үйлдвэрлэл, дэд бүтэц, газар тариалан зэрэг эдийн засгийн олон салбаруудыг хөгжүүлж чадсан.

ЗХУ-ын хөгжлийн бодлогоо таван жилээр төлөвлөх энэхүү аргыг дэлхийн 30 гаруй орон, ялангуяа хуучин социалист орнууд хэрэгжүүлж байсан. Монгол Улс тэдгээр улсуудаас хамгийн түрүүнд буюу 1945 оноос эхлэн таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Сүүлийн үед тодорхой салбар, чиглэлээр төлөвлөгөө гаргах болов. Жишээ нь эрчим хүчний стратеги, атомын эрчим хүчний хөгжлийн программ гэх мэт. Олон арван хүрээлэн, эрдэмтдийг нэгтгэсэн “Удаан хугацааны төлөвлөлт, стратеги боловсруулах” ажил ОХУ-д өрнөж байна. Тэдэнд онолын суурь мэдлэг, дэлхийн түвшинд хүрсэн эрдэмтэд, олон арван судалгааны хүрээлэн, институт байгаа болохоор үүнийг хийж чадна гэдэгт эргэлзэх зүйлгүй юм.

2006 онд “ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг боловсруулж 2008 онд баталжээ. 2012 оны 1 дүгээр сарын 24-нд ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин “ОХУ-ын нүүрсний аж үйлдвэрийг 2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр”-ийг баталж, үүний санхүүжилтэд 3,7 триллион рубль гаргахаар шийдвэрлэв. Учир нь нүүрс, нефть Орос улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл учраас үүнд гол анхаарлаа хандуулан, бусад төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг үүнтэй уялдуулан хэрэгжүүлж байна. Ингэж бодлогын хоорондын уялдаа холбоог хангаж байгаа нь авууштай сайн туршлага билээ.

Зураг 2. Хуучин Зөвлөлт Холбоот Улсын таван жилийн төлөвлөгөө



1.2. ОХУ-ын орчин үеийн стратеги, төлөвлөлтийн үндэс

ОХУ-ын Ерөнхийлөгч үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2009 оны 5-р сард “ОХУ-ын стратеги төлөвлөлтийн үндсийн тухай” 536 тоот зарлигийг² баталсан. Энэхүү үндэс нь үндэсний стратеги чиглэлүүдийг хөгжүүлэхэд холбооны, бүс нутгийн болон салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах аргачлалын үндсэн баримт бичиг юм.

Стратеги төлөвлөлт бол тус улсын тогтвортой хөгжлийн стратеги зорилгод хүрэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, санхүүжилтийг тодорхойлно.

Стратеги төлөвлөлтийн үндсэн зарчмууд

1. ОХУ-ын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээ нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай харилцан уялдаатай байх,
2. Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд ОХУ-ын төрийн байгууллагуудын бүрэн эрх болон тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулалтыг зааглах,
3. Тогтвортой хөгжилтэй холбоотой урт хугацааны шийдвэрүүд нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдтэй нийцсэн байх,
4. Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх болон эдийн засаг, соёл, оюуны хөгжлийг эрчимжүүлэх арга хэмжээг цаг үеэ олж хэрэгжүүлэх,
5. Хувь хүн, нийгэм, улс орноо зохистой хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад үндэсний стратеги чиглэлүүдэд цаг үеэ олж тодотгол хийх,
6. Тогтвортой хөгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангахад материаллаг, санхүү, боловсон хүчин, шинжлэх ухаан-технологи, мэдээлэл болон бусад нөөцийг төвлөрүүлэх.

Стратеги төлөвлөлтийн зорилго

Зорилго нь үндэсний нөөц, иргэний нийгмийн чадварыг үр ашигтай ашигласнаар Үндсэн хуулийн эрх, эрх чөлөө, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, түвшинг хангах, ОХУ-ыг тогтвортой хөгжүүлэх, улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд институциональ зохион байгуулалтын болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

²Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.

Стратеги төлөвлөлтийн зорилтууд

1. Нийгэм-эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн шинжилгээ хийж, хамгийн зохимжтой стратеги хувилбаруудыг боловсруулах,
2. Нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжилд тулгарч болзошгүй стратеги эрсдэл, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй стратеги аюулд тохиромжтой хариу өгөх цохилтын арга хэмжээг боловсруулах,
3. Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор эдийн засаг, нийгэм, улс төр, цэрэг болон бусад салбарын хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд, дэд чиглэлүүдийг тодорхойлох,
4. Тус улсыг тогтвортой хөгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хурцадмал шинжтэй үндэсний аюулгүй байдлын хэмжүүр, үзүүлэлтүүдийн анхдагч мэдээллийн санг бүрдүүлэх,
5. Үндэсний аюулгүй байдлыг хангах системийг төгөлдөржүүлэхээр ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын 2020 он хүртэлх стратеги, түүнд үндэслэн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах,
6. ОХУ-ын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх 2020 он хүртэлх урт хугацааны үзэл баримтлал, стратеги, ОХУ-ын субъектүүдийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх цогц хөтөлбөр, төр, цэрэг, нийгэм-улс төр болон бусад салбарын үзэл баримтлал, сургаал, тус улсын бодлогын үндэс, түүнчлэн салбарын хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулах,
7. Стратеги төлөвлөлтийн талаарх хууль эрх зүй, шинжлэх ухаан, арга зүйн суурийг төгөлдөржүүлэх,
8. ОХУ болон түүний субъектүүдийн хөгжлийн цогц мониторинг хийх, ялангуяа тус улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг ажиглах мэдээлэл-статистикийн улсын системийг төгөлдөржүүлэх,
9. Стратеги төлөвлөлтийг мэдээлэл, шинжилгээ, нөөц, боловсон хүчнээр хангах,
10. Тус улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын хангахад холбооны, бүс нутгийн, бүс нутаг дундын болон салбарын, салбар дундын хэмжээнд төлөвлөгдсөн нийгэм-эдийн засгийн зорилтот хөтөлбөрийн арга хэмжээнүүдийн уялдаа холбоог дүгнэх,
11. Тус улсын тогтвортой хөгжилд тулгарах шинэ стратеги эрсдлийг зогсоох үндэсний аюулгүй байдлыг хангах механизмыг боловсруулах.


Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх ба Үндэсний аюулгүй байдлыг хангах стратеги

Стратеги төлөвлөлтийн зарчим, зорилтуудаас үзэхэд ОХУ-д нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх явдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай салшгүй холбоотой, түүнд нийцсэн байхыг шаардсан байна.

ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлыг хангах стратеги нь хувь хүн, нийгэм, улсад учирч болзошгүй дотоод, гадаад аюулаас хамгаалахын тулд үндэсний стратеги чиглэлүүд, тэдгээртэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Харин Нийгэм-эдийн засгийн хөгжлийн стратеги буюу үзэл баримтлал нь ОХУ-ыг тогтвортой хөгжүүлэхэд тулгарч болзошгүй стратеги эрсдэл /богино, дунд, урт хугацааны прогноз үзүүлэлтүүд/, үндэсний стратеги чиглэлүүдийг хэрэгжүүлэх журам, арга хэмжээ, олон улсын тавцанд ОХУ-ын эзлэх байр суурь зэрэг стратеги нөхцөл байдал, улс орны улс төр, нийгэм-эдийн засгийн дотоод, гадаад байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилт зэргийг богино, дунд, урт хугацаанд шийдвэрлэх журам, аргыг боловсруулж, үндэсний аюулгүй байдлын ерөнхий нөхцөл байдлыг тодорхойлно. Энэхүү хоёр стратегийн баримт бичгийн ялгаатай талыг дараах зурагт харуулсан.

Зураг 3. Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх болон Үндэсний аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөлтийн хамрах хүрээ



Стратеги төлөвлөлтийн систем

Стратеги төлөвлөлтийн систем нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, зохион байгуулалт, институц, улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг болон бусад асуудалтай холбоотой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудыг багтаасан.

Зураг 4. Стратеги төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явц



Орчин үед Оросын эдийн засгийн өрсөлдөх чадварыг хангахад стратеги төлөвлөлтийн удирдлагын системийг үр дүнтэй зохион байгуулах нь системийн зорилго юм. Стратеги төлөвлөлтийн ерөнхий удирдлагыг ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд тус улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. Харин Аюулгүй байдлын зөвлөл нь өөрийн бүрэн эрх, чиг үүрэгт нийцүүлэн стратеги төлөвлөлтийг зохицуулахын зэрэгцээ холбогдох баримт бичгийн улсын дотоод, гадаад бодлогын асуудалд шинжилгээ хийнэ.

Тус улсын хөгжлийн түвшин, үндэсний аюулгүй байдалд тавих хяналтыг Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, ОХУ-ын субъектүүдийн

захиргааны улсын байгууллагуудын үйл ажиллагааны тайлангуудын үндэсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг судалсны үндсэн дээр хийнэ.

Мөн ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн прогноз болон хөтөлбөрийн тухай Холбооны хуульд³ зааснаар ОХУ-ын Засгийн газар, Төв банк хамтран тус улсын эдийн засгийн нөхцөл байдалд хяналт тавихын зэрэгцээ нийгэм-эдийн засгийн байдлын статистик мэдээллийг сар бүр хэвлүүлнэ.

Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүд

Стратеги төлөвлөлтийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн прогноз, үзэл баримтлалын баримт бичгүүд /үзэл баримтлал, сургаал, стратеги, үндэс/, хөтөлбөрүүд, төлөвлөгөө болон зохицуулалтын баримт бичгүүд, эрх зүйн акт, мөн мэдээлэл, судалгаа шинжилгээ, лавлагаа зэрэг туслах баримт бичгүүдийг боловсруулна.

Холбооны улсын түвшинд стратеги төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хэд хэдэн үндсэн баримт бичгүүд байна. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах стратеги,
- Шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх урт хугацааны прогноз,
- Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны прогноз,
- Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлал,
- Салбаруудыг хөгжүүлэх урт хугацааны баримт бичгүүд,
- Холбооны төсвийн урт хугацааны стратеги,
- Холбооны зорилтод хөтөлбөрүүд,
- Газар нутгийн төлөвлөлтийн схем,
- Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл,
- Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх дунд хугацааны төслүүд,
- Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны прогноз,
- Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төслүүдийн үр дүн, явцын талаарх жилийн төлөвлөгөө.

Ерөнхийлөгчийн баталсан ОХУ-ын стратеги төлөвлөлтийн үндэст⁴ зааснаар Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг Ерөнхийлөгчийн Холбооны хуралд илгээсэн илгээлт ба төсвийн тухай илгээлт, мөн гүйцэтгэх засаглалын холбооны байгууллагууд болон ОХУ-ын субъектүүдэд төрийн байгууллагуудын бэлтгэсэн албан ёсны статистик, мэдээлэл, шинжилгээ, шинжлэх ухааны судалгаа /үүнд иргэдээс авсан санал асуулга хамаарна/, дотоод, гадаадын стратеги төлөвлөлтийн туршлагад хийсэн шинжилгээ, бусад баримт бичигт нийцүүлж боловсруулна.

Ерөнхийлөгчийн Холбооны хуралд илгээсэн илгээлт ба төсвийн тухай илгээлт нь тус улсын тогтвортой хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлын хангах тухайн үеийн болон стратеги тулгуур зорилтыг тусгасан байдаг.

Стратеги төлөвлөлтийн хугацаа, тэдгээрийн уялдаа холбоо

Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг хугацааны хувьд урт /10-20 жил/, дунд /5-10 жил/ болон богино хугацаагаар /3-5 жил/ боловсруулна.

³ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ "О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ".

⁴Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 "Об Основах стратегического планирования в РФ".

Хүснэгт 1. Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийн хугацаа

Хугацаа	Прогноз	Үзэл баримтлал	Зорилтот хөтөлбөр	Төлөвлөгөө
Урт	+	+	-	-
Дунд	+	+	+	-
Богино	+	-	+	+

Урт хугацааны стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийн агуулгууд:

- Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны прогноз:
 - o нийгэм-эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшин болон дэлхийн эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд,
 - o хүн ам зүй болон шинжлэх ухаан-технологийн хөгжил, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг багтаан урт хугацааны нийгэм-эдийн засгийн хөгжлийн дотоод нөхцөл байдал, шинж чанарыг тодорхойлно,
 - o урт хугацааны төсвийн систем, мөнгө, зээлийн салбарын үндсэн үзүүлэлтүүд,
 - o урт хугацааны эдийн засгийн салбар тус бүрийн хөгжил, тээвэр болон эрчим хүчний дэд бүтцийн үзүүлэлтүүд.
- Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлал:
 - o дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь ба түүний урт хугацааны өөрчлөлтийг дүгнэх,
 - o тухайн үеийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн зорилгод хүрсэн түвшинд дүгнэлт өгөх,
 - o урт хугацааны эдийн засгийн үндсэн хандлага, тэргүүлэх чиглэл, зорилтыг тодорхойлох,
 - o нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилго болон зорилтот үзүүлэлтүүдийг тодорхойлох,
 - o нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг үнэлэх,
 - o зорилгод хүрэх тэргүүлэх чиглэл, зорилтуудыг хэрэгжүүлэх.
- Холбооны төсвийн урт хугацааны стратеги:
 - o тухайн үеийн төсвийн бодлогын үр өгөөж, үр дүнг дүгнэх,
 - o ОХУ-ын урт хугацааны төсвийн системийн параметрийн урьдчилсан төлөвийг гаргах,
 - o нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалд тогтоосон нийгэм-эдийн засгийн зорилгыг хангасан урт хугацааны төсвийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.
- Сургаал бол улсын болон салбаруудын хөгжлийн талаарх ОХУ-ын төрийн бодлогын албан ёсны үзэл санаа, постулат /postulate/, зарчмыг тусгасан байх ба хэлбэрийн хувьд Ерөнхийлөгчийн Холбооны хуралд хэлсэн үг, илгээсэн илгээлт байна.


Дунд хугацааны стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийн агуулгууд:

- Үзэл баримтлалд улсын болон салбаруудын хөгжлийн үндсэн макро үзүүлэлтүүд, зорилго, чиглэлүүдийн ОХУ-ын төрийн бодлогын тохиромжтой хувилбаруудыг тусгасан.
- Прогноз нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилго, нийгэм-эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх аргыг тодорхойлно.

- Холбооны зорилтот хөтөлбөр /ХЗХ/:
 - o ХЗХ-ийн чиглэсэн асуудлуудыг шийдвэрлэх шийдвэр,
 - o ХЗХ-ийн хэрэгжилтийн жилийн гүйцэтгэлийн явцыг харуулсан зорилтот шалгуур үзүүлэлтийн хамт ХЗХ-ийн үндсэн зорилго, зорилтууд,
 - o ХЗХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл,
 - o ХЗХ-ийн эдийн засгийн хөгжилд оруулж буй өгөөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг зэрэг ХЗХ-ийн ашгийг дүгнэх,

Мөн стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх хамрах хүрээгээр нь холбооны, бүс нутгийн /холбооны тойргууд, ОХУ-ын субъектүүд/, бүс нутаг хоорондын, салбар хооронд болон салбарын хэмжээнд боловсруулж хэрэгжүүлнэ. Эдгээр баримт бичгүүдийн уялдаа холбоог Зураг 5-т үзүүлэв.

Зураг 5. Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа холбооны ерөнхий зураглал



1.3. Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх прогноз

Урт хугацааны прогноз

Нийгэм-эдийн засгийн хөгжлийн прогноз, хөтөлбөр боловсруулах үндсэн аргачлалыг ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн прогноз болон хөтөлбөрийн тухай Холбооны хуульд⁵ тусгасан. Одоо мөрдөж байгаа ОХУ-ын Нийгэм-эдийн засгийн хөгжлийн 2020 он хүртэл урт хугацааны прогнозыг⁶ Эдийн засгийн хөгжлийн яам Ерөнхийлөгчийн Эдийн засгийн талаарх төрийн урт хугацааны бодлогын тухай зарлигт /2012 он/ нийцүүлэн боловсруулж, Засгийн газар 2013 оны 3-р сард баталсан байна.

⁵ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ "О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ".

⁶Прогноз долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2030 года. Март, 2013.

Эдийн засгийн талаарх төрийн урт хугацааны бодлого:

Эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, тус улсын эдийн засгийг технологийн хувьд тэргүүн эгнээнд хүргэх зорилгоор дараах үр дүнд хүрэхийн тулд арга хэмжээг авахыг Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:

- 2020 он гэхэд бүтээмж өндөртэй 25 мянган ажлын байрыг бий болгох, шинэчлэх,
- хөрөнгө оруулалтын хэмжээг 2015 онд ДНБ-ний 25 хувиас багагүй, 2018 онд 27 хувиас багагүй болгож нэмэгдүүлэх,
- эдийн засгийн өндөр технологит болон шинжлэх ухааны агуулгатай салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ДНБ-нд эзлэх хувийг 2018 онд 2011 оныхтой харьцуулбал 1.3 дахин нэмэгдүүлэх,
- хөдөлмөрийн бүтээмжийн ДНБ-нд эзлэх хувийг 2018 онд 2011 оныхтой харьцуулбал 1.5 дахин нэмэгдүүлэх,
- Дэлхийн банкны бизнес эрхлэх тухай судалгаанд ОХУ-ын 2011 онд эзэлсэн 120-р байрыг 2015 онд 50-р байр, 2018 онд 20-р байр болгож өсгөх.

Прогнозыг Ерөнхийлөгчийн Холбооны хуралд илгээсэн 2012 оны илгээлт болон Засгийн газрын 2018 он хүртэлх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг үндэслэж боловсруулсан ба энэ баримт бичигт бүтээмж өндөртэй ажлын байр болгож шинэчлэх, бий болгох, өндөр технологитой болон шинжлэх ухааны агуулгатай эдийн засгийн салбарын хөгжлийг түргэсгэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн орчныг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон нийгмийн хөгжлийн зорилтуудыг шийдэх зэрэг асуудлуудыг хамруулсан байна.

Ингэхдээ Холбооны хуульд тогтоосны дагуу дотоод, гадаад улс төр, эдийн засаг болон бусад хүчин зүйлүүдээс хамаарч болзошгүйг тооцоолж, зураглалыг 3 хувилбараар гаргасан байна: консерватив, шинэчилсэн болон хурдасгасан.

Зураглалуудын үндсэн ялгаа нь төсвийн зардлыг боломжтой хэмжээнд хязгаарлах урьдчилсан нөхцөл бүхий эдийн засгийн шинэчлэлээр илэрч байна. /Хүснэгт 2./

Хүснэгт 2. Гурван хувилбарт зураглалын тодорхойлолт, зарим үндсэн шалгуур үзүүлэлтүүд

Зураглал	Тодорхойлолт	2013-2030 онд хүрсэн байх жилийн дундаж үзүүлэлт
Консерватив	Эрчим хүчний түлш, нөөцийн салбарыг илүү идэвхтэй шинэчилнэ. Ингэхдээ шинэчлэл нь импортын технологи болон мэдлэгт түлхүү чиглэнэ.	ДНБ-ий жилийн дундаж өсөлт 3.0-3.2 хувь, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 4.7 хувь
Шинэчилсэн инноваци	Эдийн засгийн өсөлтөд чиглэсэн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, эрчим хүчний нөөцийн цогцолборыг шинэчлэх, орчин үеийн тээврийн дэд бүтэц, өрсөлдөх чадвартай, өндөр технологитой аж үйлдвэр болон эдийн засагт түшиглэнэ. Инновацийн хүчин зүйлүүд нь нийгмийн параметрийг сайжруулахуйц эдийн засгийн өсөлт болон хүний капиталын үр ашгийг эрх нэмэгдүүлэхээр тооцоолсон байна.	ДНБ-ий жилийн дундаж өсөлт 4.0-4.2 хувь, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 5.9 хувь
Хурдатгасан	Эдийн засгийн бүхий л үзүүлэлтүүдийг эрчимтэй өсгөх, бизнесийн орчны шинэчлэлийг түргэвчлэх, үндэсний хөрөнгийг нийгэм, эрчим хүч болон зам тээврийн дэд бүтэц, экспортын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сектор хөгжүүлэх үйл ажиллагаанд түлхүү оруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэхээр тооцоолсон байна.	ДНБ-ий жилийн дундаж өсөлт 5.0-5.4 хувь, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг 8.2 хувь

ОХУ-ын Нийгэм-эдийн засгийн хөгжлийн 2020 он хүртэл урт хугацааны прогноз нь нийт 354 хуудастай, 15 бүлэг баримт бичиг юм. Үүнд:

1. ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн 2001-2012 оны дүн.
2. Эдийн засгийн урт хугацааны хөгжлийн нөхцөлүүд.
3. Хөгжлийн ирээдүйн зураглал /сценари/.
4. Хүний капиталын хөгжил ба хүн амын амьдралын түвшин.
5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжил.
6. Хөрөнгө оруулалт.
7. Дэд бүтцийн салбарын бүтээгдэхүүн /үйлчилгээ/-ий үнэ тариф. Инфляцийн параметр, үйлдвэрлэгчдийн үнийн динамик.
8. Хүрээлэн буй орчны хамгаалал. Эдийн засгийн нөөцийн чадавхын хөгжил.
9. Дэд бүтцийн үйлдвэрлэлийн хөгжил.
10. Аж үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.
11. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын хөгжил.
12. Жижиг үйлдвэрлэл ба институциональ өөрчлөлт.
13. Нутаг дэвсгэрийн хөгжил.
14. Төсвийн системийн хөгжлийн параметрийн урт хугацааны прогноз.
15. Дотоод эдийн засгийн үйл ажиллагаа.

Үр дүнд нь урт хугацааны прогнозад үндэслэж ОХУ-ын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалыг боловсруулна.

Дунд болон богино хугацааны прогноз

ОХУ-ын Ерөнхийлөгч нь албан тушаалдаа томилогдож орсныхоо дараа Холбооны хуралд хандаж хэлсэн анхны үгэндээ улсынхаа нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны үзэл баримтлалын талаар нэг хэсэг болгон оруулах ба Засгийн газар түүнд үндэслэн Нийгэм-эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж ОХУ-ын Холбооны Зөвлөл, Төрийн Думд албан ёсоор танилцуулна.

Нийгэм-эдийн засгийн хөгжлийн богино хугацааны прогнозыг жил бүр боловсруулна. Засгийн газар нийгэм-эдийн засгийн хөгжлийн дараа жилийн прогнозыг холбооны төсвийн төсөл болон бусад холбогдох баримт бичгийн хамт Төрийн Думд өргөн барина. Харин ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнгөрсөн оны үр дүнг 2-р сар дотор Холбооны Зөвлөл, Төрийн Думд албан ёсоор танилцуулна.

1.4. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал

ОХУ-ын Нийгэм-эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалд тус улсын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх стратеги зорилт, тэргүүлэх чиглэлүүд, иргэдийн амьдралыг сайжруулах арга, эх үүсвэр, эдийн засгийн хурдацтай хөгжлийг хангах, олон улсын тавцанд ОХУ-ын байр суурийг бэхжүүлэх зэргийг боловсруулна. Ингэхдээ үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг харгалзаж үзэх ёстой. Үзэл баримтлалыг 20 жилийн хугацаатайгаар боловсруулж, 5 жил тутам тодотгоно.

Үзэл баримтлалд дараагийн 10 жилийн төлөв байдлыг дэлгэргүй байдлаар тодорхой чиглүүлнэ. Үүнд:

- эдийн засгийн салбар тус бүрийн стратеги, эсхүл хөтөлбөрт,
- тэргүүлэх чиглэлүүдийн үндэсний төслүүдэд,
- ОХУ-ын оролцон гүйцэтгэж байгаа олон улсын төслүүдэд,
- Засгийн газрын 2012 он хүртэлх үйл ажиллагааны үндсэн чиглэлд,
- Холбооны зорилтод хөтөлбөрүүдэд,
- суурь болон хавсарга судалгааны хөтөлбөрүүдэд,
- улсын болон улс-хувийн санхүүгийн байгууллагын хамтарсан төслүүдэд,

- улс, орон нутаг, улсын батлан хамгаалахын захиалгын дагуу гүйцэтгэж байгаа ажлын хэрэгцээнд бараа бүтээгдэхүүн хүргэх захиалгад,
- бусад ач холбогдол бүхий үндэсний аюулгүй байдлын төсөл, хөтөлбөрүүдэд.

ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хөгжүүлэх хүртэлх урт хугацааны үзэл баримтлал

ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалыг⁷ /цаашид Үзэл баримтлал-2020/ 2006 оны 7-р сарын 21-нд болсон Төрийн Зөвлөлийн хуралдааны дүнд Ерөнхийлөгчийн даалгаварт нийцүүлэн боловсруулж, 2008 оны 11-р сарын 17-ы Засгийн газрыг тогтоолоор баталсан.

Үзэл баримтлал-2020-ийг боловсруулах болсон зорилго нь урт хугацаанд /2008-2020 онд/ Оросын иргэдийн чинээлэг аж амьдрал, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрчимтэй хөгжлийг тогтвортой нэмэгдүүлэх, дэлхийн тавцанд ОХУ-ын байр суурийг бэхжүүлэх явдал юм.

Энэхүү зорилгын хүрээнд Үзэл баримтлал-2020-д дараах асуудлуудыг тодорхойлсон байна. Үүнд:

- улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн урт хугацааны үндсэн чиглэлүүд,
- тавьсан зорилгод хүрэх стратеги: хэрэгжүүлэх арга, чиглэл, үе шат,
- төр, бизнес, олон нийтийн стратеги түншлэлийн хэлбэр, механизм,
- нийгэм, шинжлэх ухаан-технологи, эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийн талаарх төрийн урт хугацааны бодлогын зорилго, зорилтот шалгуур үзүүлэлт, тэргүүлэх чиглэл,
- дотоодын эдийн засгийн бодлогын зорилго, тэргүүлэх чиглэл,
- Оросын эдийн засгийн хөгжлийн орон зайн параметр, нутаг дэвсгэрийн хөгжлийн зорилго, зорилт.

2. ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС

Швейцар улс нь манай улстай адил далайд гарцгүй бөгөөд 18-р зууны сүүл үе хүртэл Европын хоцрогдсон, ХАА зонхилсон салбартай орон байжээ. Газар нутгийн хувьд Герман, Франц, Итали, Австри, Лихтенштейн зэрэг 5 улстай хиллэдэг, уул нуруу, гол мөрөн элбэг ч байгалийн баялаг багатай. Тус улс нь хамгийн чухал хэрэгцээгээ мөнгө хэмээн тодорхойлж, шууд мөнгөөр солих бараа бүтээгдэхүүн, байгалийн баялаг ховор тул бусдаас давуу талаа тодорхойлж чадсан байна. Тэр нь туршлагатай, боловсорсон цэрэг арми байсан тул хөлсний цэргүүдээ гадаадад өндөр үнээр ажиллуулснаар анх эх орон руугаа чиглэсэн мөнгөний урсгалыг бий болгосон гэж үздэг. Мөнгөний эх үүсвэр нь зөвхөн арми байгаагүй бөгөөд сайн чанарын үйлчилгээ, тухайлбал банк, санхүүгийн чиглэлийн найдвартай үйлчилгээг экспортлох зэргээр хөрөнгөждөг байна. Түүнчлэн, өөрийн орны газарзүйн байршлаа зөв ашиглан дамжин өнгөрөх орон болохдоо Альпийн нурууг цоолон Европын бараа урсгалыг өөрийн орноор дамжин өнгөрөх боломжийг бүрдүүлж өгснөөр мөнгөний урсгалыг нэмэгдүүлж, банк санхүүгийн салбар нь Европ болон дэлхийн банкны төв болж чадсан байна.

XIX зуунд Швейцарын эдийн засаг огцом өсөлтийнхөө өмнө ирсэн байсан ба 1850 он гэхэд Европт Их Британийн дараах хоёр дахь үйлдвэржсэн орон болж эхэлсэн. XIX зууны сүүл хүртэл үйлдвэрлэлийн өсөлт үргэлжилж үндэсний төмөр замын бүтээн байгуулалт өрнөж, 1882 онд Saint Gotthard хоолойг ашиглалтад оруулснаар Швейцар нь дамжин өнгөрөх тээврийн төв зангилаа болсон. Хямд байгалийн баялаг, түүхий эд материалыг

⁷"Концепция долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года" Утверждена распоряжением Правительства РФ от 17 ноября 2008 г. № 1662-р.е

импортлон, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд нийлүүлж эхэлсэн. Энэ нь өнөөг хүртэл дэлхийн олон улс орнуудад экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын үлгэр загвар болж байдаг.

Швейцарын эдийн засаг нь тогтвортой, ажилгүйдэл багатай, ажиллах хүчний чадвар өндөртэй бөгөөд 2011-2012 оны Дэлхийн өрсөлдөх чадварын индексээр, 2011 онд Хүний тогтвортой хөгжлийн индексээр эхний гуравт орж байна. Тус улсын ДНБ-ий хэмжээ дэлхийн банкны статистикаар 2012 онд 632.2 их наяд ам. долларт хүрч, дэлхийд 20 дугаарт бичигдэж байна⁸. ДНБ-ий 71.1 хувь нь үйлчилгээнээс, 27.7 хувь үйлдвэрлэлээс бий болж байгаа ба үйлдвэрлэлийн хувьд тоног төхөөрөмж, нарийн хэмжилтийн багажууд, химийн бүтээгдэхүүн, цаг, оёдол нэхмэлийн үйлдвэрлэл зонхилдог. Энэхүү бүтцээ дагаад ажиллах хүчний 70 хувь нь үйлчилгээний салбарт, 26 хувь нь үйлдвэрлэлд, 5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг.

Тус улсын хөгжлийн нууцыг судлаачид үзэхдээ төрийн тогтолцоотойгоо холбоотой бөгөөд эрх мэдэл төвлөрдөггүйд байдаг гэж үздэг. Иргэд нь улс орныхоо эзэн байж, төр засгаа өөрсдөө удирдаж болдог жишээг Швейцарын ард түмэн үзүүлдэг. Асуудал бүрийг олон нийтийн санал хураалтаар шийдэж, гаргасан шийдвэрээ парламентад хүргүүлэн хуульчилдагаараа онцлогтой орон юм. Тус улсад улс төрийн соёл өндөр, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэх соёл давамгайлдаг.

Хөгжлийн төлөвлөлт ба Холбооны Зөвлөлийн Тогтвортой хөгжлийн стратеги

Швейцар нь үндэсний урт хугацааны бодлогын зорилгуудаа Холбооны Үндсэн хуульд хэд хэдэн заалтаар заасан байдаг ба 2 дугаар зүйл /article 2.1-4/-д Швейцарын Холбооны улсын тогтвортой хөгжлийн үндсэн зорилгуудыг оруулсан байдаг. Үндсэн хуулийн заалтын энэхүү зорилгуудыг биелүүлэхэд 1997 оноос хойш Холбооны зөвлөл Тогтвортой хөгжлийн стратегийн баримт бичигт эдгээр зорилгуудаа тусгажээ. Стратеги нь тогтвортой хөгжлийн ойлголт, Холбооны засгийн газрын олон төрлийн бодлогын хэрэгжүүлэлт, муж, хот, орон нутгийн хамтын ажиллагааны тогтолцоог тодорхой болгож өгдөг.

1992 оноос хойш Тогтвортой хөгжлийн стратегийн боловсруулахдаа үндсэн 5 зарчмыг баримталж, Үйл ажиллагааны төлөвлөгөө /Action plan/-нд хугацааг хуульчлан тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлж болох үйл ажиллагаануудыг заасан байдаг. Тус улсын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулахдаа 5 зарчмыг баримталдаг. Үүнд:

1. Ирээдүйд үүрэг хүлээсэн,
2. Тогтвортой хөгжлийн 3 зорилго /эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин/-ын хэмжүүрүүд нь тэнцвэржүүлсэн шийдэлтэй,
3. Бүх бодлогын цар хүрээ нь тогтвортой хөгжихөд чиглэсэн,
4. Бодлогын хүрээ нь хоорондоо нийцсэн, сайжруулсан дэс дараалалтай,
5. Тогтвортой хөгжлийн түншлэлийн харилцан итгэлцэлд үндэслэсэн байна.

Холбооны зөвлөл нь тогтвортой хөгжлийг салбарын бодлогын зөвхөн нэг элемент биш харин бүх талбар дахь бодлогын чухал шаардлагатай хэсгүүдийн бүрэлдэхүүн гэж ойлгодог.

⁸<http://data.worldbank.org/indicator>

Зураг 6.



Тогтвортой хөгжлийн 4 дэх стратегийн баримт бичиг нь 2012-2015 онуудыг хамарч байгаа ба Холбооны Засгийн газар нь бүх салбарын бодлогууддаа тогтвортой хөгжлийн зарчмыг хамруулахыг зорьдог. Холбооны зөвлөл нь Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хаана хамгийн чухал асуудал байна түүнийг онцгойлон 10 гол асуудлыг оруулдаг.

1. Цаг уурын өөрчлөлт, байгалийн бэрхшээл
2. Эрчим хүч
3. Орон зайн хөгжил ба зам тээвэр
4. Эдийн засаг, үйлдвэрлэл ба хэрэглээ
5. Байгалийн нөөцийн ашиглалт
6. Нийгмийн төвлөрөл, хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн
7. Олон нийтийн эрүүл мэнд, спорт ба биеийн хүчний дасгалыг дэмжих
8. Глобал хөгжил ба хүрээлэн буй орчны асуудал
9. Сангийн бодлого
10. Боловсрол, судалгаа ба инноваци

Дээрх гол асуудлуудын хүрээнд хөгжлийн бодлогыг тодорхойлсон байдлыг хураангуйлан харвал:

1) Цаг уурын өөрчлөлт, байгалийн бэрхшээл

Сүүлийн 10 жилд цаг уурын өөрчлөлт нь Швейцарт хурдацтай нөлөөлж байна. Үнэн хэрэгтээ тус улсад цаг уур дэлхийн дунджаас 2 дахин их хурдтай дулаарч байгаа бөгөөд энэ нь цаашид үргэлжлэх хандлагатай байна. Дулаарлын шилжилт, хүчтэй бороо, их цасны уналт, үер, хөрсний нуралтууд өсч байна.

Холбооны Зөвлөл нь шинэ CO²-ийн эрх зүйн баримт бичигт хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2020 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад хамгийн багадаа 20 хувиар бууруулахаар тусгасан. Үүнтэй холбоотойгоор татварын хөнгөлөлтүүд, хог хаягдлын худалдаа, дэмжлэгийн хөтөлбөрүүд болон зохицуулалт гэх мэт арга хэмжээний бүрдлүүдийг төлөвлөсөн. Үүнээс гадна эрүүл мэнд, биотархалт, усны түвшин, ХАА, аялал жуулчлалд нөлөөлөх цаг уурын өөрчлөлтийн нөлөөг хамгийн бага байлгахад нийцүүлсэн арга хэмжээг илүүтэй зорьсон. Эрсдлийн менежментийн цогц арга хэмжээ нь өсөн нэмэгдэж байгаа байгалийн бэрхшээлээс хүмүүс, барилга, дэд бүтцэд учрах хохирлыг арилгана гэж үзэж байна.

2) Эрчим хүч

Швейцарын эрчим хүчний 80 орчим хувь нь нөхөн үл сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашигладаг. Тус улсад нар, салхины эрчим хүч, байгалийн хий, органик түлш, газар доорх дулааны эх үүсвэрүүдийг ашиглах харьцаа 2010 онд 1,4 хувь байна. Нөхөн үл сэргээгдэх эрчим хүчний гол асуудал нь хүрээлэн буй орчин, цаг уурт хамгийн их аюул учруулдаг гэж үздэг тул эрчим хүчийг илүү тогтворжуулах арга зам нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглах явдал юм. Иймээс тус улс нь 2020 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээний 50 хувиас доошгүй хэсгийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс авч ашиглах зорилго тавьж, энэ нь Швейцарын эрчим хүчний түншлэлийн хөтөлбөрөөр амжилттай мөрдөгдөж эхлээд байна. Үүний дагуу Холбооны Зөвлөлийн 2011 оны шийдвэрээр цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг зогсоох, шинэ Эрчим Хүчний Стратеги 2050-д үйл ажиллагааны төлөвлөлтийг тусгахдаа эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүч, түүнд нийцүүлсэн үндэсний сүлжээг өргөжүүлэх, эрчим хүчний судалгаа хийх ажлуудыг илүү онцлон тусгасан байна.

3) Орон зайн хөгжил /spatial development/ ба тээвэр

Швейцарт орон зайн хөгжил нь тогтворжоогүй. Ойрын 10 жилд газрын үржил шим буурч байгаа ба газрын төрх байдал алдагдах, хотжих байдалтай болж байгаа нь биологийн төрөл зүйл, байгалийн баялаг, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна. Газрыг ховор баялаг гэж үзэн түүний ашиглалтыг илүү арви хямгатай байлгахын тулд Холбооны засгийн газар нэг хүн бүрд 400 м кв суурьшлын бүс тогтоохыг зорьдог. Шинэчлэн найруулсан Орон Зайн Төлөвлөлтийн хууль /Spatial Planning Act/-аар энэ зорилгод хүрэхийн тулд жижиг суурингуудыг хотжуулан хөгжүүлж, тэнд нь төвлөрлийг нэмэгдүүлэх талаар тусгасан. Энэ нь урт хугацаанд Швейцарын газар эдэлбэр дэх эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны эрэлтийг хангана гэж үздэг. Мөн автомашины өсөлтийн сөрөг нөлөөг бууруулахад Холбооны Засгийн газар нийтийн тээврийг өргөжүүлэх, цахилгаан тээврийг урамшуулах байдлаар дэмжлэг үзүүлдэг. Хөнгөн их биетэй хагас эсвэл бүрэн цахилгаанаар ажилладаг машин үйлдвэрлэх нь өнөөгийн шатахууны хэрэглээ, агаарын бохирдлыг бууруулах ба автомашины үнэ тогтоолт нь тус улсын тээврийн дэд бүтцийн тогтвортой санхүүжилтийг хамгаалах, автомашины цилиндрийн багтаамжийг бууруулахад нөлөө үзүүлнэ гэж үздэг.

4) Эдийн засаг, үйлдвэрлэл ба хэрэглээ

Швейцар нь “ногоон эдийн засаг”-т шилжихийг зорьж байгаа ба үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхдээ баялгийн хэрэглээг бууруулах ёстой гэж үздэг. Эдийн засгийн өсөлтийг баялгаас бүрэн тасалж байгаа болон эрчим хүчний хэрэглээ нь хэрэглээний загваруудыг шаарддаг. Үүнд жишээ болгоход, Холбооны Засгийн газар бүтээгдэхүүний худалдан авалт, барилгын бүтээн байгуулалт нь эдийн засаг, хүрээлэн буй орчинд таатай, эрүүл мэндэд аюулгүй байхаас гадна нийгмийн өмнө хариуцлагатай байхыг шаарддаг. Цаашилбал, Холбооны засгийн газар нь ногоон эдийн засагт чиглэсэн бүтээн байгуулалт, мэдээлэл болон харилцаа холбооны технологи, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл гэх мэт эдийн засгийн секторуудад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрүүдийг төлөвлөж байна.

5) Байгалийн нөөцийн ашиглалт

Ой, ус, хөдөө нутаг гэх мэт байгалийн бүтэн байдал нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрүүл байлгахтай салшгүй холбоотой. Эрчим хүч, түүхий эд материал, хүн амьтдын хүнсний хангамж гэх мэт байгалийн баялгийн эх үүсвэрийг ашиглах, хүлэмжийн хийн ялгаруулалт, хотжилт нь хүрээлэн буй орчны хөрс, ус, агаарт хор уршиг үзүүлж байна. Иймээс Холбооны Зөвлөл биологийн төрөл зүйлийг дэмжих, урамшуулах Biodiversity Strategy-ийг барьж, тэдгээрийг бодлогын бүх салбарт хамруулахыг зорьдог. Үүнд, Швейцарын ойг экожуулах, тогтвортой ойн менежментийн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд “Ойн бодлого 2020”, “Модны нөөцийн бодлого” зэрэг хөтөлбөрүүдийг гаргасан. Мөн

хөдөөгийн унаган төрхийг хамгаалахад Швейцарын Газар Нутгийн үзэл баримтлал /Swiss Landscape Concept/-ийг баталсан.

6) Төвлөрөл, хүн ам зүй ба шилжилт хөдөлгөөн

Нийгмийн төвлөрөл нь нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн тогтвортой өсөлтөд саад учруулж байна. Өөрөөр хэлбэл, ядуурал, орлогын тэгш бус хуваарилалт, төрийн үйлчилгээний хүртээмжгүй байдал, соёлын үйлчилгээ, орчны нөхцөл байдал, цагаачлалын айдас зэрэг нь төвлөрөл гэдэг ойлголтод асуудлуудыг үүсгэдэг.

Хүн ам зүйн хувьд насжилтын асуудалд анхаарал хандуулахдаа өндөр настны нийгмийн хамгааллын системийн асуудал болон өсвөр насныхны хоорондын эв нэгдлийн асуудлыг анхаарах шаардлага гарч байна. Түүнчлэн, цагаачлал өндөр байгаа нь тус улсын хүн амын өсөлтөд нөлөөлж байна. Холбооны Засгийн газар эдгээр асуудлуудыг нэгдсэн бодлогоор аль алиныг нь хамтад нь зохицуулах боломжоор хангах, цагаачлалын асуудалд эдгээр арга замууд нь тэнцүү үйлчилдэг байхыг зорьж байна. Өндөр настны нийгмийн хамгааллын систем, хүн ам зүйн хандлагад нийцүүлсэн хөдөлмөрийн зах зээлээр дамжуулан төвлөрлийн асуудлыг шийдвэрлэхийг зорилт болгон тавьж байна.

7) Нийтийн эрүүл мэнд, спорт ба биеийн хүчний дасгалыг дэмжих

Швейцарт таргалалтаас үүсэх ужиг өвчин, архи тамхины хэрэглээ өссөн зэрэг нь хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна. Ажлын байрны стресс гэх мэт шалтгаанууд нь асуудлын зөвхөн өнгөн тал юм. Өнөөдрийг хүртэл эрүүл мэндийн бодлого нь сэтгэл санааны өвчинд анхаарал хандуулж ирсэн ба цаашид өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг ухуулан таниулахад илүү ач холбогдол өгөхийг зорьж байна. Холбооны Зөвлөлөөс 2009 онд Урьдчилан сэргийлэх хууль /Prevention Act/-ийг шинээр баталсан бөгөөд энэ нь тогтвортой хөгжлийн зарчимд тусгагдсан стратегийн хэсэг болох эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бэхжүүлэх зорилготой баримт бичиг юм. Үүнийг нийгмийн бүхий л хэсгүүдэд хүргэхэд анхаарал хандуулан, дасгал хөдөлгөөн, эрүүл хооллох нь өвчнөөс урьдчилан сэргийлэх гол түлхүүр гэдгийг иргэдэд ойлгуулж, мэргэжлийн спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

8) Глобал хөгжил ба хүрээлэн буй орчны асуудал

Одоогийн байдлаар дэлхийн экосистемийн 60 гаруй хувь нь ашиглагдсан. Эрчим хүчний хэрэглээний огцом өсөлт, цаг уурын өөрчлөлтийн үр дагаврууд нь цаашид байгаль дэлхийд улам их дарамт үзүүлнэ. Энэ нь даяаршилд тэгш бус байдлыг нэмэгдүүлсэн. Холбооны зөвлөл нь бат бэх олон улсын хөгжлийн болон хүрээлэн буй орчны бодлого, түүнээс гадна илүү тогтвортой засаглалыг баталгаажуулсан. Олон улсын эв нэгдлийн илэрхийлэл нь Швейцарын үндэсний нийт орлогын хэмжээг 2015 он гэхэд 0,5 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Мянганы Хөгжлийн Зорилт /Millennium Development Goals/-ийн шинэчлэл нь 2015 онд дуусгавар болох бөгөөд үүнийг сэргээх эсэхийг 2013 оноос хойш шийдэх болно. Холбооны Зөвлөл нь чадавхтай олон улсын байгууллагуудын идэвхтэй хэсэгт тоглолт хийж, тухайн хамтын ажиллагаа нь тогтвортой хөгжлийн зорилтын даяаршлын зорилтуудыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

9) Сангийн бодлого

Тус улсын сангийн бодлого нь хүн ам зүйн насжилт өндөртэй өнөөгийн нийгмийн зардлыг хойч үедээ өр болгон дамжуулахаас урьдчилан сэргийлэхийг зорьдог. Иймээс тогтвортой эдийн засгийн хөгжлийн тогтвортой нөхцөлүүдийг бий болгохын тулд төрийн секторын төсвийг балансжуулах, өр төлбөрийг бууруулах, ДНБ-д эзлэх татварын харьцааг бууруулахад чиглэдэг. Холбооны засгийн газар нь тогтвортой хөгжлийг дэмжихдээ

иргэдийнхээ хүрээлэн буй орчны хандлагад санхүүгийн урамшуулал үзүүлэх туршигдаж, шалгарсан аргыг хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, Швейцар нь татварын хувь хэмжээгээр дэлхийд өндөрт /хувь хүний орлогын албан татварын хамгийн өндөр хувь хэмжээгээр дэлхийд 15 дугаарт орж байгаа буюу 2012 оны байдлаар 40 хувь байна⁹/ ордог тул агаарын бохирдлын татвар, ХАА-н татвар хураамж зэрэг татварын системийн урамшууллын арга хэрэгслийг ашиглах нь ирээдүйд үүсэх хүрээлэн буй орчны цочролоос хамгаалахад, нөгөө талаас иргэдийн татварын дарамтыг бууруулахад дэмжлэг болдог. Түүнчлэн, нийгмийн даатгалыг идэвхжүүлэх ажлыг зорилт болгоод байна.

10) Боловсрол, судалгаа ба инноваци

Шаардлагатай мэдлэгийн зөвхөн сургуулиас авах биш, гэр бүл, клуб, ажлын орчноос авах ёстой. Их сургууль нь зөвхөн заах түвшнээс гадна судалгааг хөгжүүлэх ёстой гэж үздэг. Холбооны Зөвлөлөөс дунд болон их дээд сургуулиуд, судалгааны секторуудыг тогтвортой хөгжүүлэх үндсэн зарчмыг баталгаажуулахыг зорьж байна. Тус улсын Дээд боловсролыг дэмжих хууль /Federal Act on Promoting Tertiary Education/, Швейцарын дээд боловсролын системийн зохицуулалт /Coordination in the Swiss Tertiary Education System/ нь 2014 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөх ба эдгээр нь их сургуулиудын мэргэшүүлэх түвшинг тогтвортой хөгжүүлэхэд илүү их үүрэгтэй оролцоно. Түүнчлэн, Холбооны засгийн газар нь албан боловсролын системээс гаднах оролцогчдыг тогтворжуулах зарчмуудад дэмжлэг үзүүлдэг.

Швейцар улсын дээрх төлөвлөлтөөс харахад тус улс нь үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийг чухалчлахаас илүүтэй ногоон хөгжилд хүрэх, бусад нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх гарц нь тэдгээрийг хөгжүүлэхэд бус улам боловсронгуй болгоход чиглэгдэж байгаа нь өндөр хөгжсөн орны хөгжлийн төлөвлөлтийн онцлог байж болох юм.

3. ИХ БРИТАНИ

Их Британи улсад Орон нутгийн төлөвлөлтийн байгууллага¹⁰ нь төлөвлөлтийн чиг үүрэг эрхэлсэн байгууллага бөгөөд төлөвлөлтийн бодлогын асуудлыг Төвлөрлийг сааруулах, хотуудын асуудал эрхэлсэн сайд, Улс төрийн шинэчлэлийн асуудлыг Ерөнхий сайдын орлогч болон Засгийн газрын бодлогын Төрийн сайд нар хариуцдаг.

Европын Холбооны гишүүд бүр Холбооны гаргасан удирдамж, хуулийг биелүүлэх үүрэгтэй байдаг тул эдгээр нь Их Британийн үндэсний төлөвлөлтийн хууль тогтоомжид шууд нөлөөлдөг. Төлөвлөлтийн хууль тогтоомжид 1990 оны Хот, орон нутгийн төлөвлөлтийн хууль, 2004 онд Төлөвлөлт, төлөвлөгдсөн газрыг худалдаж авах тухай хуульд зааснаар бүс, орон нутаг тусдаа нутаг дэвсгэрийн төлөвлөлтэй байна гэж заасан байна. 2011 онд батлагдсан Орон нутгийн ашиг сонирхлын тухай хуулиар дээрх хуулиудын зарим заалтуудыг өөрчлөв. 2008 оны Төлөвлөлтийн тухай хуульд зааснаар хөгжлийн зарим томоохон хөтөлбөрүүдийг салбар дагнасан төлөвлөлтийн Комисс (Жишээ нь: Дэд бүтцийн төлөвлөлтийн комисс) шийддэг байна.¹¹/Зураг 7./

Урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь 2011 онд батлагдсан Үндэсний Төлөвлөлтийн Бодлогын хүрээ /төсөл/ 53 хуудас бүхий уг материал нь Нэгдсэн Вант Улсын төлөвлөлтийн бодлогын үндсэн баримт бичиг юм.


⁹Эх сурвалж: Global finance сэтгүүл. <http://www.gfmag.com/tools/global-database/economic-data/12151-personal-income-tax-rates.html#axzz2JLviEHn2>

¹⁰Planning Inspectorate.

¹¹The English Planning System: An Overview, 2011, London.

Хүрээлэн буй орчин хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг төвлөрлийг сааруулах явдал нь Их Британийн стратеги чиглэлүүдийн нэг бөгөөд, хууль тогтоомжоор орон нутагт ихээхэн эрх мэдлийг өгч бие даасан байдлыг нь нэмэгдүүлжээ.

Зураг 7. Их Британийн Үндэсний Төлөвлөлтийн Бодлогын Хүрээ



Одоогоор хууль эрх зүйн баримт бичгийн статустай хүчин төгөлдөр үйлчилж байгаа төлөвлөлтийн бодлого (planning policy statements), эрдэс баялгийн бодлого (minerals policy statements) болон Үндэсний бодлого (National Policy Statements) гэдэг баримт бичгүүд байна. Мөн Засгийн газар, салбарын яамдаас гаргасан төлөвлөлтийн асуудлыг шийдэхэд бодлого болон бусад хүчин зүйлүүдэд ач холбогдол өгөх тайлан, удирдамж нэлээд жин эзэлнэ.

Зураг 8. Их Британийн Төлөвлөлтийн бодлого болон баримт бичгүүдийн үялдаа хамаарал



Их Британи Улсын Засгийн газрын Тогтвортой хөгжлийн стратеги буюу Ирээдүйг баталгаажуулахуй (Securing the Future) баримт бичгийг 2005 онд батлан гаргаж хөгжлийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл
- Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүч
- Байгалийн баялгийг хамгаалах
- Тогтвортой нийгмийг цогцлуулах

Гурван гол зарчим

- Хүмүүсийг оролцуулах
- Засгийн газар үлгэр жишээ үзүүлэх
- Үйлчилгээ хүргэхэд анхаарах

1999 оноос хойш 6 жилийн турш боловсруулагдаж гарсан уг бодлогын баримт бичиг нь хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах урт хугацааны стратеги юм. Хөгжлийн бодлого буруу явагдвал хойч үе маань өөрчлөгдсөн уур амьсгалтай, шавхагдсан нөөцтэй, бидний амьдралыг тэтгэх ногоон орчин, биологийн төрөл зүйл байхгүй байх ба тогтвортой хөгжил бол урт хугацааны асуудал. Энэ маш богино хугацаанд хүрэх зүйл биш гэдэг нь тодорхой. Ахиц дэвшил, өсөлт, хөгжил цэцэглэлт нь тогтвортой байдалтай харшлах ёсгүй.

Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл¹² (*Sustainable Consumption and Production*) гэдэг нь багаар их зүйлийг хийнэ гэсэн санаа бөгөөд бараа, үйлчилгээг хэрхэн хүргэж байна вэ гэдэгт биш харин тухайн бараа, бүтээгдэхүүн нь хүмүүсийн нийгмийн хийгээд хүрээлэн буй орчны асуудалд яаж нөлөөлж байна гэдгийг авч үзнэ. Мөн нөөц баялгийг эдийн засагт хохиролтой үр ашиг багатайгаар хэрэглэхийг бууруулснаар бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлт нь хүрээлэн буй орчныг муудахад хүргэдэг байдлыг бууруулахад чиглэгдсэн болно. Эрдэс баялгийн төлөвлөлтийг хог хаягдлын төлөвлөлттэй хамт явуулдаг нь эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах цогц бодлогыг хэрэгжүүлдэгт оршино. Үндэсний хогийн менежментийн бодлого (*National Waste Management Plan for England*)-д ба орон нутгийн захиргаа өөрсдийн нутаг дэвсгэрт хогийн удирдлагын баримт бичиг боловсруулах ба эдгээр нь дээрх үндэсний хогийн менежментийн бодлоготой нийцсэн байна.

4. МАЛАЙЗЫН ХОЛБООНЫ УЛС

Малайзын Засгийн газар хөгжлийн төлөвлөлтийг 1950-аад оноос улсын эхний таван жилийн хөгжлийн төлөвлөлт 1956-1960 /First Malaya Plan/-ийг боловсруулсан. Ерөнхий сайдын дэргэд Эдийн засгийн төлөвлөлтийн нэгж нэртэй ажлын алба байгуулж хөгжлийн төлөвлөлт боловсруулах, салбар хоорондын төлөвлөлт, хяналтын механизмыг бий болгон ажилладаг.

Хөгжлийн төлөвлөлтийн барим бичгүүд:

- *Урт хугацааны төлөвлөлт*
 - Хэтийн баримт бичиг 2020, 1991-2020,
 - Хэтийн төлөвлөгөөний эхний тойм, 1971-1990,
 - Хэтийн төлөвлөгөөний хоёр дахь тойм, 1991-1990,
 - Хэтийн төлөвлөгөөний гурав дахь тойм, 2001-2010.
- *Дунд хугацааны төлөвлөлт*
 - Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, Жишээ нь: Малайзын 10 дахь төлөвлөгөө (2011-2015).
 - Таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны хэлэлцүүлэг .
- *Богино хугацааны төлөвлөлт*
 - Жил бүрийн төсөв

1991 онд “Хэтийн баримт бичиг 2020”-ыг боловсруулсан нь 30 жилийн хугацааг хамруулсан. Энэ баримт бичиг нь үндэсний урт хугацааны хөгжлийн хүсэл эрмэлзлэлийг тусгаж, нийт үндэсний хөгжлийн чармайлтыг илэрхийлсэн байна. Хэтийн төлөвлөгөөний тоймд урт хугацааны үндэсний төлөвлөлтийн асуудлын өргөн хүрээний стратегийг оруулжээ.


¹²Securing the Future, хуудас 17, 2005 он, Лондон.

Хэтийн төлөвлөгөөний тоймыг хэрэгжүүлэх дараагийн үе шат болох дунд хугацааны төлөвлөлт нь 5 жилийн хугацаатайгаар хийгдэнэ. Энэ нь макро эдийн засгийн зорилт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэмжээ, хуваарилалтыг тодорхойлно. Мөн салбарын хөгжлийн чиглэл, хөрөнгө оруулалтын бодлогыг багтаах ба энэ нь хувийн хөрөнгө оруулалтын чиглэл болно. Одоогоор Малайзын 10 дахь төлөвлөгөө 2011-2015 онд хэрэгжиж байна. 5 жилийн төлөвлөлтийн мөчлөгийн дундуур таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны хэлэлцүүлэг болно. Энэ хэлэлцүүлгээр төлөвлөгөө нь тавьсан зорилт, хөгжлийн хуваарийн дагуу явагдаж байгаа эсэхийг төдийгүй шаардлагатай гэж үзвэл макро эдийн засаг, салбарын стратегиудад засвар хийнэ.

Хамгийн сүүлийн үе шат болох богино хугацааны төлөвлөлтийг жил бүрийн төсвөөр хийнэ. Үүнийг жилийн төсвийн дагуу Сангийн яам боловсруулж, хэрэгжүүлнэ. Эдийн засгийн төлөвлөлтийн нэгж жил бүрийн хөгжлийн төсөв дэх хөрөнгө оруулалтыг тодорхойлоход оролцоно. Малайзын хөгжлийн төлөвлөлтийн жил бүрийн төсөв нь дунд, урт хугацааны төлөвлөгөөний үр ашигтай байдлыг тодорхойлдгоороо ач холбогдолтой юм. Түүнчлэн Төв банк богино хугацааны төлөвлөлтөд санхүүгийн болон мөнгөний бодлого талаас нь оролцоно.


Малайзад эдийн засаг, нийгмийн асуудлаар шийдвэр гаргах хамгийн дээд түвшний байгууллага бол Үндэсний төлөвлөлтийн зөвлөл билээ. Энэ нь Засгийн газарт эдийн засгийн чиг үүргийг гүйцэтгэхэд дараах байдлаар оролцоно.

Зураг 9. Малайз Улсын төлөвлөлт, зохицуулалт, үнэлгээний бүтэц



Үндэсний төлөвлөлтийн зөвлөлийн гишүүд нь санхүү, олон улсын худалдаа, үйлдвэрлэл, дотоод худалдаа, үйлдвэрлэлийн хөгжил, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн гол салбарын яамдын сайд нар байна. Үндэсний төлөвлөлтийн зөвлөлөөс гадна хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн асуудлыг хариуцан, салбарын бусад яамдыг хамарсан Үндэсний хөгжлийн зөвлөл, аюулгүй байдлыг хариуцсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ажиллана. Эдгээр гурван зөвлөлийг Ерөнхий сайд ахална.

Зураг 10. Малайз Улсын Төлөвлөлтийн тогтолцоо



Малайз улсын дараагийн арван жилийн төлөвлөгөө нь үндэсний хэмжээний ихээхэн орлого болон түүхэнд тэмдэглэгдсэн хөгжлийн өөр нэгэн чухал төлөвлөгөөнд чиглэснээр 2020 он гэхэд хүрсэн байх бидний урьдчилсан тооцооны дагуу чиглэсэн болно. Бид сүүлийн 53 жилийн туршид өөрсдийн үндэсний бүтээн байгуулалтыг нийгэм эдийн засгийн хөгжлийн томоохон алхмуудаар бий болгосон хэдий ч өнөөдрийн байдлаар шинэ төрлийн хэмжээс бүхий өөрчлөлт шинэчлэлтэй нүүр тулаад байна.

Малайз улсын арав дахь төлөвлөгөө нь Засгийн газрын хөтөлбөр болон эдийн засгийн шинэхэн загвар зэргийн аль алиных нь дэмжлэгтэйгээр явагдах ба энэ нь их хэмжээний ашгийг урьдчилан тооцоолох мөн алдагдалд орохгүйгээр дэмжлэг үзүүлэх зэрэгт суурилсан байна. Нөгөө талаас энэхүү төлөвлөгөө нь дараагийн таван жилийн үндэсний хөгжлийг зайлшгүй харуулахын хажуугаар бүх Малайзчуудын хувьд хүссэн хэмжээний бүтээмжид хүрэх боломжийг харуулж байгаа юм.

Эдийн засгийн арав дахь төлөвлөгөө нь улс төрийн шинэ бодлогын хэрэгжилт, стратеги төлөвлөгөө, хэрэгжих хөтөлбөрүүд зэргийг багтаасан байх ба үндэсний хэмжээнд их хэмжээний орлого ашиг олсноороо хүч түрэн гарч ирэх, тэрхүү улсыг таниулахад томоохон боломжийг олгож байгаа юм. Ерөнхийдөө энэхүү төлөвлөгөө нь Малайз улсын дүрэм журмыг баримтлах, дагаж мөрдөх зуур улс төрийн гол түлхүүр болох засгийн газрын зүгээс гаргах шийдвэрээр явагдах хэрэгжилтэд түлхүү чиглэсэн бөгөөд нарийвчлагдсан төлөвлөгөө юм. Үүнд ард түмэн эхлээд, харин дараа нь тэдэнд хүргэх үйлчилгээ нь баталгаатай байснаар гол үйл явц нь сая нэг биеллээ олоход чиглэсэн болно.

Малайз улсын хувьд үндэсний хэмжээнд ихээхэн ашиг орлого олох мөн бид өөрсдөө бүс нутгийн болоод дэлхий нийтийн түвшинд өрсөлдөхүйц хэмжээний чадвартай болох зорилтыг тавьж байна. Энэ зорилт нь бүтээлч хөдөлмөрч болон санаачлагатай алхмуудыг хийхэд цаашлаад хөрөнгө оруулалтыг өөрийн улс орондоо татахад шаардагдах тэрхүү хүчин чармайлтыг бий болгоход хэлэлцэх асуудлыг улам эрчимтэй болгон нэмэгдүүлэх зэрэгт зайлшгүй нөлөөг үзүүлж байна. Дэлхий нийтийн түвшинд буюу дэлхий даяараа бүтээлчээр болон шинэ санаачилгаар ажиллах хүч, өрсөлдөхүйц байдлаар шинэ алхмуудыг хийхэд аливаа өндөр түвшний хөдөлмөрийн бүтээмжээр олж авсан ихээхэн ашиг орлого нь

үүний үндэс суурь нь болж өгөх юм. Үүнд хүрснээр, аливаа байдлаар туслалцаа дэмжлэг үзүүлэх, түүнтэй харилцан уялдах байдал зэргийг хэвээр үлдээх зэрэг нь дэлхий дээрх хамгийн анхны гэж болохоор онцгой гойд ур чадвар нь цаашдаа хэрэгжсэн байх болно. Харин хувийн хэвшлийн хувьд тэдний бүтээлч сэтгэлгээ, эрч хүч, идэвх санаачилга нь Малайз улсын тэмүүлж буй өндөр зэрэглэлийн хөгжил цэцэглэлтэд гол үүргийг гүйцэтгэх байдлаар дайчлагдсан байх болно. Бид хувийн хэвшлүүдэд бизнесийн болон таатай, үр бүтээлтэй тухтай орчныг бий болгохын тулд хуучны улиг болсон зохицуулалтын дүрэм журам болон бүтцийн аливаа саад бэрхшээл зэргийг замаасаа холдуулах болно. Эдийн засгийн өсөлт нь Малайз улсын өрсөлдөхүйц чадварын үр дүнгээр тус улсад байх хувийн хэвшлүүдийн нөөц бололцооны ашигтай хэрэглээний тусламж дэмжлэгтэйгээр зорилтын дагуу хэрэгжсэн байна. Өөр бусад хотууд болон хотын оршин суугчид нь дэлхий дээрх өөр бусад гол гол хотуудтай харьцуулахуйц хөгжлийн өндөр хэмжээнд мөн хүссэнээрээ амьдарч оршин сууж болохуйц өндөр түвшинд болон бас илүү бүтээлч сэтгэлгээтэй болгож хөгжүүлсэн байна.

Энэ нь бидний зүгээс Малайз улсдаа ажахуй болон хөрөнгө оруулалтын үйл явцаар тавьсан зорилгодоо чадвараараа хүрэхэд шаардагдах шийдвэрлэх алхам болж өгч байгаа юм гэж үздэг. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь хөдөө орон нутгийн оршин суугчдыг хотын оршин суугчидтай холбож өгөх ба ингэснээр эдийн засгийн ашиг орлогоос гарах ашгийг тараан хуваарилахгүйгээр улам өсөн нэмэгдүүлсэн байх юм. Харин засгийн газар нь нийгмийн эмзэг бүлгийнхний хэрэгцээг хангах, тэдний хаягийг тогтоох, үндэсний аюулгүй байдлыг улам бэхжүүлэх болон орон сууцны хөтөлбөрт хамруулах, мөн улсын орлогоос эдгээрт зохих хэмжээгээр зарцуулах цаашлаад эрх чөлөө ёс суртахуунтай байдлыг мөрдлөг болгох, мөн айл өрхүүдийн 40-өөс доошгүй хувийн амьжиргааны түвшнийг сайжруулах зэрэгт анхаарлаа хандуулж байдаг.

Малайз улсад хэрэгжих хөгжлийн төлөвлөгөө

Албан ёсны түвшинд үүнийг авч үзвэл, энэ нь Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрийг Төлөвлөх Хороонд хэлэлцүүлсний дараа батлагдсан бөгөөд энэхүү байгууллага нь (YXXTX), хөгжлийн төлөвлөгөөнд чиглэсэн улс төрийн хамгийн том форум юм.

YXXTX нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентуудыг буюу албыг ахалдаг хороо бөгөөд Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хороог тэргүүлдэг. Эдийн засгийн хөгжлийн бүрэлдэхүүнд багтах бүхий л яамдуудын тэргүүлэгчид нь Төв Банкны захирагч буюу захирал болон тус бүрэлдэхүүний бусад гишүүд зэрэг нь болно. YXXTX нь нөөц баялгийг тараан хуваарилах, төсөвлөн олгох мөн үүн дээр тулгуурлан үндэсний хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүхий л төрлийн төлөвлөгөөг хянах түүнчлэн зохицуулах зэрэгт шийдвэр гаргах ба үүрэг хариуцлагыг давхар үүрнэ. Үүнээс гадна, үндэсний хөгжлийн төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг бас хянадаг. Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явц нь Холбооны түвшинд EPU гийн зөвшөөрлөөр явагдах ба Санхүү болон Төв банкны Яам түүний хэрэгжүүлэгч агентлагууд аль болох сайтар төлөвлөснөөр явагдана.

Хэтийн төлөвийн гол санааг нарийвчлан боловсруулах ажлыг Үндэсний эдийн засгийн Зөвлөлдөх хуралдаан зохион байгуулж бодлого төлөвлөлтөд оруулна. Энэхүү зөвлөл нь өөрсдийн гишүүдээ нийгэм эдийн засгийн олон салбаруудаас жишээ нь: аж үйлдвэрийн холбоод тэдний төлөөлөгчид, эрдэмтэн судлаачид, худалдааны гишүүн байгууллагууд, улс төрийн намууд, шашны байгууллагууд, залуучуудын холбоодууд, мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, болон өөр бусад олон олон аль болох идэвхтэй хувь хүмүүс, ашгийн байгууллагууд зэргээс сонгон томилдог. Төрийн болоод дүүргийн түвшинд сонгогдох гишүүдийн төлөвлөгдсөн байдал нь доорх байдлаар үзүүлэгдсэн байна. Үүнд: Улс төрийн түвшинд, Төр эдийн засгийн Төлөвлөлтийн Хороод, мөн түүнчлэн улсын хөгжлийн асуудлыг хариуцсан албаныхан зэрэг нь Улс төрийн хөгжлийн

хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон төсөл боловсруулах зэргийг бэлтгэн гаргахад илүү өндөр үүрэг хариуцлага хүлээнэ.

Төлөвлөлтийн үйл явц

Малайз улсын хөгжлийн төлөвлөгөө нь олон төрлийн боломж бүхий хоёр үндсэн аргаар явагдах үйл явцаар хэрэгжих ба үүнд EPU гийн хооронд, нөгөө талаас яамдууд болон агентлагууд, нөгөө талаас дээрх хүснэгтэд харуулснаар байна. Энэхүү дээрээс доош болон доороос дээш явагдах үйл явцууд нь улсын бодлого стратегиудыг ард түмэнд ухааруулж байгааг баталж байгаа бөгөөд дэд бүсийн хөгжлийн түвшинд ч явагдах хөгжлийн хамаарлуудыг улс үндэстний нийт ерөнхий хөгжлийн чиг хандлагатай шууд уялдуулж өгч байгаа юм.

Холбооны түвшинд, EPU дахь зөвлөл нь өөр бусад төв агентлагуудтай байх ба үүнд Эрдэнэсийн сан, Төв Банк зэрэг нь багтана. Улс орны эдийн засгийн төлөв байдал болон чадамжийг өнгөрсөн хугацаанд үнэлсэн тоймоос энэ нь шууд харагдаж байна. Энэ нь түүнчлэн хязгаарлалт болон дутагдалтай байдлыг оршин тогтнох зэрэгт үнэлгээ өгч байдаг. Мөн EPU нь хожим макро эдийн засгийн цаашдын ерөнхий бүтцийг бэлтгэж өгдөг ба улсын байгууллагуудын хөгжил дэвшил зардал, зарлага зэрэгт байх өсөлт дэвшлийн зорилгын далд утга санаанд үнэлгээг өгч байдаг. Харин макро эдийн засгийн төлөвлөлтийн сүүлийн шатны параметрууд нь агентлаг хоорондын төлөвлөлтийн бүрэлдэхүүнүүд болон тэдгээрийн техникийн зөвлөлийн ажлын хэсэг зэргийн хоорондох хэлэлцүүлгээр тодорхойлогдон шийдвэрлэгддэг. Малайз улсын найман жилийн хөгжлийн төлөвлөгөөний бэлтгэл ажлын үе болох 2001-2005 оны хооронд нийтдээ 25 агентлагууд орон нутгийн чанартай олон олон асуудлууд, макро эдийн засгийн зарим асуудлууд, хүний нөөц, ядуурлыг бууруулах, аж үйлдвэрийн хөгжил, тээвэрлэлтийн асуудал, шинжлэх ухаан технологи, болоод нийгэм эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн талаар тус тус авч хэлэлцсэн болно.

Сонгон шалгаруулалтад урих буюу дуудах

Хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөө сонгон шалгаруулалтад дуудах буюу үүнд оролцогчдын талаарх тойм хэлэлцүүлэг нь эхлээд яамдууд руу, хууль ёсны байгууллагууд руу, эрх мэдэлтнүүд рүү мөн төр засгийн газрын байгууллагууд руу илгээснээр хэрэгжих ажил нь эхлэх ба үүнд санхүүгийн бус байгууллагууд оролцохгүй. Тендерийн дуудлагын үйл явцын зорилго нь засгийн газрын зүгээс өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж дараагийн 5 жилд хэрэгжих хөгжлийн стратеги хөтөлбөрийг санал болгосноор үнэ хаях маягаар явагдана.

Төслийг батлах үйл явц

Нэгэнт саналаа өргөн барьсан бол, EPU нь яамдууд болон тэдгээрийн бусад агентлагуудаар батлагдсан төслийн саналуудад үндэслэн 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөнд чиглэсэн хөгжлийн төсөлд үнэлгээ өгч эхэлнэ. Үүнийг яамдууд, агентлагууд, болон төрийн байгууллагуудтай хамтарч зөвлөлдөх ба засгийн газар урьд болж өнгөрсөн үйл явцуудыг хооронд нь адилтган дүгнэх, асуудлыг шийдвэрлэх, эсвэл газар нутгийн болоод цаашдын чиг хандлагын талаар авч хэлэлцсэнээр энэхүү үйл явц нь өрнөнө. Энэхүү хүчин чармайлтын үр дүнд, EPU нь санал болгогдсон хөтөлбөрүүд, түүний ерөнхий ойлголт, гол зорилго болон хөтөлбөр болгоны цар хүрээ зэргийн талаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Жишээ нь, хүн амын тоо хэмжээнээс хамаарч шинээр бий болох их дээд сургуулиудын үйл ажиллагааны цар хүрээ хэрхэн шалтгаалахыг, мөн боловсрол олгох, сургалт явуулах сургалтын стратегийн талаар болон өөр бусад холбогдолтой үйл явцууд цаашлаад барилга болон байгууламж болон материалууд зэргийн стандартын шаардлагад нийцэж хэрэглэгдэх эсэхийн талаар хүртэл авч хэлэлцэх гэх мэт.

Төслийг эн тэргүүнд тавих

Санал хураалт буюу төслийн хэрэгжүүлэлтэд ирүүлсэн материалуудын тоо болон хэмжээ нь хэвийн хэмжээнээсээ үргэлж хэтэрсэн байдаг. Иймэрхүү маягаар, ЕРУ нь хөгжлийн зорилт болон олон нийтэд түгээн дэлгэрүүлэх санхүүгийн чөлөөт дуу хоолойг хүндэтгэн үзэж шаардлагатай алхмуудыг хийсэн байна. Төсөл болон хөтөлбөрийн эцсийн жагсаалтыг гаргахаас өмнө бүс нутгийн болоод олон нийтийн хуваарилалтыг аль болох зохицсон хэмжээнд байлгахад тус төхөм болохуйц бусад зорилтуудыг засгийн газар авч хэлэлцдэг.

Хөгжлийн хөтөлбөрийн зардал тооцоо нь ойрын 5 жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдаг. (Малайз улсад хэрэгжих Хөгжлийн 10 төлөвлөгөө болон 11 хөтөлбөр төсөл). Харин яамдууд болон агентлагууд нь хөгжлийн хөтөлбөрийн төсөл болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянан шалгадаг. Нарийн шалгуураар явагдах зарим сонгон шалгаруулалт нь бүс нутгийн тэнцвэртэй байдал, ядуурлыг бууруулахад чиглэсэн, нийгмийн үүрэг хариуцлагыг ухамсарласан, зэрэг тодорхой алхмуудад чиглэсэн байх ёстой. Харин дэд бүтцийн төслийн хувьд, энэ хөгжил нь мастер төлөвлөгөөний дагуу төслийн урьдчилсан байдлыг тодорхойлоход чиглэсэн байна. Үүнээс гадна, шинэ төрлийн төслүүдийг үргэлжлүүлэн өмнөхөөс илүүтэйгээр хэрэгжүүлэх.

Төслийн хэрэгжүүлэлт болон хяналт

Төслийн хэрэгжүүлэлт болон хяналтын тогтолцоо нь Төслийн хэрэгжүүлэлт болон хяналтыг хариуцдаг бүрэлдэхүүний шийдвэрээр явагдах ба энэхүү байгууллага нь засгийн газрын бодлогын дагуу эдийн засгийн шинэ чадамжийг улам нэмэгдүүлэхийн тулд улс болоод хэлтэс хоорондын түвшинд асуудлыг авч үздэг. Судалгааны үр дүнд, засгийн газар нь стратеги хөтөлбөр хоорондын ашигтай байдлын талаар таамаглал дэвшүүлэх ба нэн ялангуяа нийгэм эдийн засгийн зорилтуудыг тодорхойлох мөн энэ маягаараа дараа дараачийн төлөвлөгөөнүүдэд илүү сайн нөлөө үзүүлэх зэрэгт анхаардаг.


Төлөвлөгөөг солих

Хэдийгээр төлөвлөгөөг зохион байгуулах үйл явц нь чанга хатуу тогтолцоотой мэт санагдах боловч үнэндээ бодит үйл явц нь илүү уян хатан ёс журмын дагуу юм. Төлөвлөгөө ийм байдаг учир нь төлөвлөгөөний нэр, хаяг, богино хугацааных, тухайн үедээ хэрэгжих боломжоор хангагдсан эсэх, мөн тэдгээр төлөвлөгөөнүүдийг цаашид аль болох өндөр түвшинд хэрэгжүүлэх болон гарч болох магадлалтай эрсдлүүдийг урьдчилан тооцоолох зэргийг судалдаг. Энэ нь шинэ төрлийн сорилтыг хурдан явуулах нэгэн аргачлал бөгөөд хэрэгжих төлөвлөгөөт хөтөлбөрийг дэмжих бас нэг боломж бололцоо болж өгдөг.

Эрсдлийн үед төлөвлөгөө гаргах


Хөгжлийн төлөвлөгөөг гаргах болон төлөвлөгөөг гаргагчид нь ёс журмын дагуу заавал байх, уян хатан чанартай, хариу өгөх мөн тэдний идэвхтэй байдлаас хамаарч ямар ч нөхцөл байдалд төлөвлөгөөг өөрчлөх тал дээр хариуцлагатай байх ёстой. Үүний хор уршгийг 1997-1998 оны хоорондох Азийн санхүүгийн хямралын үед болсон эдийн засгийн хямралаар давтагдсан үйл явц тодорхой харуулж байгаа юм. Үүний үр дүнд, хувийн хэвшлийнхэн үйлчлүүлэгчид болон хэрэглэгчдийнхээ итгэлийг алдаж хөрөнгө оруулалтын тал дээр алдагдалд орсон.

Зураг 11. Хөгжлийн таван жилийн төлөвлөлтийн бүтэц, зохион байгуулалт



Гэсэн ч энэ нь эргээд 1998 он гэхэд 7,4 хувиар дотоодын нийт бүтээгдэхүүн өссөнөөр сэргэсэн бөгөөд харин эрсдлийн хувьд ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд буюу ядуурлыг бууруулах бодлогод шууд чиглээгүй ба хүмүүсийн нийгэм эдийн засгийн ахуйн түвшинг сайжруулахад гол чиглэлээ хандуулж байсан. 1997 онд болсон хямралын уршгаар, Засгийн газар нь хоосон орон зай бүхий нойрмог байдлаасаа салж эдийн засгаа бодлоготойгоор авч явах арга замыг ойлгож ухаарсан болно. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын зөвлөлийг Ерөнхий сайд нь тэргүүлэх ба бусад бие бүрэлдэхүүнүүд нь дагалддаг.

Зураг 12. Эдийн засгийн үндсэн бодлого



5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Хөгжлийн бодлого

Дайны дараа хөдөө аж ахуйн хэвшилтэй ядуу буурай орон байсан Өмнөд Солонгос Улсын эдийн засаг 1962 оноос огцом хөгжиж, 40 жил хүрэхгүй хугацаанд “Хан мөрний гайхамшиг” хэмээн нэрлэсэн гялалзсан амжилтыг дэлхий нийтэд гайхуулж чаджээ.

Солонгос Улс 1950 аад оны үеэс улс орноо хөгжүүлэх эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг бий болгох асуудалд ихээхэн анхаарч, судлаачид хөгжлийн өөр өөрийн гэсэн онцлогийг тусгасан 3 загварыг санал болгожээ. Үүнд:

- хувийн хэвшлийн үйлдвэр голлосон ардчилсан эдийн засгийг бий болгох
- төрийн оролцоотой төрийн хэлбэр голлосон эдийн засгийг бий болгох
- барууны социал демократ аргыг сонгосон чөлөөт эдийн засгийн тогтолцоог бий болгох

Уг хөгжлийн загварууд нь тус бүрдээ өөр өөрийн гэсэн онцлогтой боловч эдийн засгийг хөгжүүлэхдээ хөгжлийн хөтөлбөрийг бий болгох замаар хөгжүүлэх ёстой гэдэг дээр санал нэгдсэн байна. Гадаадын зээл тусламжаас илүү өөрийн хүч бололцоогоо ашигласан, эдийн засаг дахь төрийн оролцоо ихтэй байх хэлбэрийг илүүд үзэж чухалчилсан нь улс орны хөгжлийн бодит суурийг тавихад нөлөөлсөн гэж үздэг.

Улс үндэстний хөгжлийн өсөлт, бууралт нь тухайн орны баримталж буй бодлоготой шууд холбоотой байдаг нь бодит үнэн. Америкийн эдийн засагч М. Олсон “Үндэсний өсөлт, уналт: эдийн засгийн өсөлт, зогсонги байдал болон нийгмийн тэсвэр” номдоо улс төр бизнесийн цөөн хэдэн бүлэглэл монополь байдлаа хадгалан, явцуу ашиг сонирхлынхоо төлөө зөвхөн өөрт ашигтай хууль журам батлуулах хандлагатай байдаг нь нийгмийн үр ашиг, бүтээмжийг бууруулдаг гэж нотолсон байдаг.¹³ Энэ нь мэдээж эдийн засагт муугаар нөлөөлөх нь тодорхой юм. Харин Өмнөд Солонгосын хувьд эдийн засгийн бодлого нь ийм сонирхлын бүлгээс хамаардаггүй байсан нь өнөөгийн хөгжлийн түвшинд хүрэхэд ихээхэн нөлөөлсөн гэж үздэг.

Солонгосын Урт хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүдээс “Vision 2025”, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүд “5 year plan”, богино хугацааны баримт бичиг “annual budget”-ийг тоймлон авч үзлээ. Солонгос улс эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөг 1962-1996 он хүртэл нийт 7 удаа хэрэгжүүлж, тэдгээр төлөвлөгөөнүүд нь тус бүрдээ Солонгосын эдийн засагт аж үйлдвэржих, экспортыг дэмжих зэрэг тодорхой зорилгод чиглэгдэж байсан. Эхний шат буюу 1962-1976 оны хооронд хэрэгжсэн эхний 3 таван жилийн төлөвлөгөө нь үндэсний үйлдвэрийн бүтцийг бий болгох, тус бүтцээ сайжруулан хөгжүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрүүдтэй болоход чиглүүлж улмаар амжилтад хүрсэн байна.

Харин дараагийн 4 таван жилийн төлөвлөгөөгөөр эрчимжсэн технологийн үйлдвэрлэл, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, өндөр технологийн салбарыг дэмжихэд чиглэгдсэн байна.

Гол нь улс орныг хөгжүүлэх оновчтой зөв бодлогын үр дүнд тухайн орон хөгждөг гэдгийг Солонгосын туршлагаас харж болох юм. Өөрөөр хэлбэл судлаачид Солонгосын хөгжлийн ид шидийг хөгжлийн хүчтэй, зөв бодлоготой нь холбон тайлбарлаж үздэг. Ялангуяа Солонгосын эдийн засгийг хөгжүүлэх үндсэн стратеги нь эдийн засгийн тав таван жилийн төлөвлөгөөнүүдэд тусгалаа олсон байдаг бөгөөд 1960-1996 он хүртэл дэлхийн 2 дахь

¹³Mancur Olson, 'The rise and Decline of Nations; Economic growth, Stagflation, and Social Rigidities,' in New Haven (Yale University Press, 1982), 44-47.

хурдан өсөлттэй орон хэмээгдэж байсан. Үүгээрээ аливаа улсын хөгжил улс төрийн дэглэмээс хамаардаг бус зөв бодлого хөгжлийн үндэс гэдгийг харуулж чадсан байна.

Өмнөд Солонгосын эдийн засгийн хөгжлийн эдгээр төлөвлөгөөнүүд нь хөдөө аж ахуйд тулгуурласан ядуу эдийн засагтай үндэстнийг аж үйлдвэржсэн орон болгон өөрчлөхөд ихээхэн хувь нэмэр оруулсан. Хөгжлийн стратеги хэмээх алс хэтийг харсан баримт бичиг байхаас гадна түүндээ хүрэх арга замыг тав таван жилээр тодорхойлсон. Өмнөд Солонгосыг хөгжүүлэх анхдугаар 5 жилийн төлөвлөгөө 1962 онд батлагдаж хэрэгжиж эхэлжээ. Энэ төлөвлөгөө нь Солонгосын эдийн засгийн хөгжлийн суурь стратегийн баримт бичиг болохын зэрэгцээ ялангуяа экспортод чиглэсэн үйлдвэрийн хөгжлийн стратегийг бий болгоход чиглэгдсэн. 1961 онд Солонгос орон ядуурал, замбараагүйтэл, авлигад идэгдсэн, дэлхийн ядуу буурай орнуудын нэг байсан. Кимчинээс өөр ямар ч үйлдвэргүй Солонгос орон дэлхийн том гүрэн болох асар том зорилго тавьсан. Солонгосын хөдөөгийн хоцрогдсон ядуу суурингуудыг өөрчлөх зорилт тавин Германаас авсан зээл тусламжаар хамгийн түрүүнд 40 аж үйлдвэрийн цогцолборыг байгуулж, юуны өмнө оймс, цамцны, өмдний гэх мэт хөнгөн аж үйлдвэрийн паркуудыг бүтээн босгосон. Улмаар эдгээр 40 аж үйлдвэрийн цогцолбор томоохон хотуудын хэмжээнд хөгжиж бүс нутгийн хөгжлийн төвүүд болжээ. Өнөөдөр эдгээр 40 аж үйлдвэрийн цогцолборуудаа мэдлэгийн аж үйлдвэрийн цогцолборууд болгон өөрчлөн хөгжүүлсэн.

Солонгосын эдийн засгийн хөгжлийн загварыг харвал хамгийн гол нь эдийн засгийн огцом өсөлт гэдэг зүйл аливаа нэг улсын хөгжлийн тогтвортой зөв бодлого, ялангуяа урт хугацааны уялдаа холбоотой нарийн төлөвлөлт төлөвлөгөөний үр дүнгээр амжилтад хүрч болдог амьд жишээ болж чадсан.¹⁴ Тодорхой зорилгод чиглэсэн, аливаа эрсдлийг урьдчилж тооцоолсон харилцан уялдаатай хөгжлийн урт хугацааны төлөвлөлт нь эдийн засгийн өсөлтийг ямар ч бэрхшээл эрсдэл бий болоход тогтвортой хадгалж чаддаг хэмээн үзжээ.

Улс орны хөгжил нь аливаа улс төрийн дэглэмээс хамааралтай гэхээсээ илүү нэгдмэл санаа, хөгжлийн урт хугацааны чамбай бодлого удирдлагад байдгийг Солонгосын хөгжлийн загвар харуулдаг байна.¹⁵

Экспортыг хөгжлийн хөдөлгүүр болгосон гадагш чиглэсэн эдийн засгийн хөгжлийн стратеги нь Солонгосын эдийн засгийн шинэчлэлд маш их хувь нэмэр оруулсан. Энэ стратегид тулгуурласан хөгжлийн хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэний үр дүнд, 1962-2007 онд Солонгосын үндэсний нийт бүтээгдэхүүн 2.3 тэрбум ам. доллар байснаас 477.0 тэрбум ам. долларт хүрч, нэг хүнд ногдох үндэсний цэвэр орлого нь 87 ам. доллараас 20045 ам. доллар болтлоо өссөн байна. Эдгээр тоо баримтууд нь БНСУ-ын авч хэрэгжүүлсэн эдийн засгийн хөтөлбөрүүдийн үр дүнг илтгэж байна.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдал нь аж үйлдвэрлэлийн дэлхий дахинд танигдах болсон хэд хэдэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсонтой нь холбоотой юм. Солонгос улс дэлхийд хамгийн том усан онгоц үйлдвэрлэгч орон бөгөөд усан онгоц үйлдвэрлэлийн салбар нь сүүлийн 4 жил дэлхийд манлайлж, дэлхийн усан онгоц үйлдвэрлэлийн захиалгын 40 хувийг гүйцэтгэж байна.

Солонгос улс аж үйлдвэрийн бодлого, чиглэлээ тогтвортой байлгаж, 10 жил тутам өөрчилж байсан нь улсынхаа эдийн засгийг цаашид улам амжилттай цэцэглэн хөгжихөд тустай алхам болсон. Үүнд:


1. Солонгос улс 1960-аад оноос экспортод тулгуурласан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, холбогдох хууль дүрмийг батлан гаргаж, экспортыг түлхүү дэмжих болсон байна.

¹⁴Стратеги судлал, 2010/1, №49, 79-р тал.

¹⁵Мөн тэнд.

2. Химийн хүнд үйлдвэрлэл 1970-аад оны үед үндэсний үйлдвэрлэлийн бодлогын цөм нь болж байсан.
3. 1980-аад оны үеэс аж үйлдвэрлэлийн салбарт бүтцийн өөрчлөлт шинэчлэлт хийгдэж, уг шинэчлэлийн зорилго нь жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг дэмжихэд чиглэсэн.
4. 1990-ээд оноос зах зээлийг нээлттэй болгож, чөлөөт зах зээлийг бий болгож, 1997 онд Азийн санхүүгийн хямрал болоход Солонгос улс хямралыг түргэн даван туулах эрс шийдвэртэй арга хэмжээ авсан байна.
5. 2000 оноос шинэ санаа, шинэ бүтээл нь үндэсний хөтөлбөрт тэргүүлэх асуудал болжээ. Үйлдвэрлэлийн салбарт илүү шинэ санаа нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд Солонгост бизнесийн таатай орчин бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэгчид болон том компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг дэмжсэн.

Зураг 13. БНСУ-ын Үндэсний тогтвортой хөгжлийн баримт бичгийн боловсруулалт



БНСУ-ын Засгийн газраас улс орныхоо нийгэм эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт, хөгжлийн стратеги, үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж байсан бодлогууд нь улсын эдийн засаг, нийгэмд ихээхэн өөрчлөлт шинэчлэлтийг оруулсан гэж үздэг. Солонгос улс 1960-аад оноос үсрэнгүй хөгжиж, дэлхийн хөгжингүй гүрнүүдийн нэг болсон нь бусад орны судлаачид төдийгүй улс төрчид, жирийн ард иргэдийн сонирхлыг татсаар ирсэн.

Солонгосын Засгийн Газар нь улс орныхоо тухайн үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засгийн төлөвлөлтийг оновчтой хийж чадсан бөгөөд уг оновчтой шийдлийн

гол тулгуур нь 1962 оноос эхэлсэн анхдугаар таван жилийн төлөвлөгөө байсан юм. 1961 онд Эдийн засгийн Төлөвлөлтийн Хороог байгуулж улс орноо тав, таван жилээр хөгжүүлэх хэтийн оновчтой төлөвлөгөө гаргаж ажилласан. Засгийн Газраас улс орноо нуруундаа үүрээд авч явж чадах үндэсний хэмжээний томоохон компаниудад бага хүүтэй зээл өгч, дэлхийд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг даалгавар өгч, томоохон компаниудаа дэмжих бодлого барьж ажилласны дүнд тэдгээр компаниуд дэлхийн хэмжээний түвшинд хүрчээ. БНСУ-ын 1962-1997 оны хооронд эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн долоон удаагийн таван жилийн төлөвлөгөөний гол онцлогуудаас товч дурдвал:

Анхдугаар таван жилийн төлөвлөгөө: 1950-1960 он буюу эдгээр 10 жилийн хугацаанд Солонгос улс 5 жилийн төлөвлөгөөгөөр эдийн засгаа хөгжүүлэх бодлого төлөвлөлтийн эхлэл тавигдаж, шинэ засгийн газрын удирдлага дор энэ үйл явц өрнөж эхэлсэн. Энэ хөгжлийн төлөвлөгөөний онцлог шинж нь хувирамтгай байдалд оршиж байв. Өөрөөр хэлбэл Засгийн газар урьдаас төлөвлөөгүй гэнэтийн зүйлтэй тулгарвал бодлогоо өөрчлөх бэлтгэлтэй байх, шаардлагатай бол төлөвлөгөөгөө 1 жилээр хойшлуулах өвөрмөц бодлого байсан.

Солонгос улс 1962 оноос эдийн засгийн хөгжлийг бодлогынхоо эн тэргүүн эгнээнд тавьж, түүний биелэлтэд бүх ард түмний хүчийг хандуулах тогтолцоог бий болгосон.

Эдийн засгийг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө нь “Эдийн засгийн хоцрогдлыг даван туулж, үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хүчирхэгжүүлэе” гэсэн уриан дор нийтдээ 3 тэрбум воны хөрөнгө оруулсан ба дунджаар 7.1 хувийн өсөлттэй байна гэсэн нь тухайн үедээ шахуу зорилт байжээ.

Хөрөнгө оруулалтын хөрөнгийг ард иргэдэд 44 хувь, Засгийн газарт 56 хувийг хуваарилсан бөгөөд ажилгүйдлийг 24-15 хувь хүртэл бууруулахаар төлөвлөсөн. Экспортын зорилт нь төлөвлөсөн оны эцэст 1960 онтой харьцуулахад 4.2 дахин буюу 130 сая ам. доллараар өссөн. Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөг эхнээс нь эхлээд хэрэгжүүлж дуусах хүртэл Эдийн засгийн төлөвлөлтийн хороо тэр үеийн эдийн засаг, санхүүгийн бүхий л асуудлыг шийддэг байжээ. Энэ хугацаанд эдийн засгийн бодлогыг боловсруулан түүний биелэлтийг хянан удирдаж, эдийн засгийн яам, хороодыг нэгтгэн удирдах байгууллага байхгүй байсан өмнөх жилүүдийн дутагдлыг засахын тулд эдийн засгийн нэгдсэн төлөвлөгөө, түүнтэй зохицсон гүйцэтгэх тогтолцоо болсон Эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулжээ. Анхдугаар таван жилийн төлөвлөгөө нь 1962-1966 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд эдийн засаг нь зөвхөн өөрт буй нөөцөө хэрхэн үр ашигтай зарцуулах вэ? гэдэгт бус аж үйлдвэрийн тогтолцоог бий болгож, үүгээрээ эдийн засгаа хөгжүүлэхээр цемент, нийлэг утас, газрын тосны боловсруулах үйлдвэр, бордооны үйлдвэр, электрон төхөөрөмжийн үйлдвэр зэргийг бий болгож, ажиллуулахад гол анхаарлаа хандуулсан. Жараад онд ХАА, хөнгөн үйлдвэрийн орон байсныг дал, наяд онуудад аж үйлдвэрийн орон болгон өөрчилж чадсан. Эдийн засгийн гол салбар болох электроник, автомашин, хими, хөлөг онгоц, болд, нэхмэл, хүнсний үйлдвэрийг хөгжүүлж чадсан.

Хоёрдугаар таван жилийн төлөвлөгөө нь 1967-1971 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд өмнөхөөсөө илүү орчин үеийн аж үйлдвэрийн тогтолцоог бий болгож, импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг орлож чадахаар зэр зэвсэг, машин, химийн үйлдвэртэй болохыг онцлон үзэж байжээ.

Гуравдугаар таван жилийн төлөвлөгөө нь 1972-1976 оныг хамрах бөгөөд энэ үед хүнд ба химийн үйлдвэрийг дэмжих экспорт уруу чиглэсэн бодлогыг авч хэрэгжүүлсэн. Тухайн үйлдвэрүүдэд төмөр, ган боловсруулах үйлдвэр, агаарын тээврийн болон машины үйлдвэр, гэр ахуйн электрон барааны үйлдвэр, усан онгоцны үйлдвэр болон химийн

үйлдвэрүүд багтаж байсан байна. Хүнд ба химийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхдээ өөрсдийн үйлдвэрүүдээ гаднаас оруулж буй завсрын импортын бүтээгдэхүүнийг орлуулж чадахуйц экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болгохыг зорьж байв. Ингэснээр гадны капиталыг багасгах, өөрийн орон дахь гадны капиталын нөлөөллийг арилгахыг зорьсон. Солонгосын өмнөд хэсэгт байгуулагдаж байсан хүнд аж үйлдвэрүүд эдийн засгийн хөгжилд тус дэм болоод зогсохгүй Сөүлийн гаднах аж үйлдвэржилтийг хөхиүлэн дэмжиж, буурай хөгжилтэй газар нутгийн оршин суугчдыг ажлын байраар хангах болсон.

Дөрөвдүгээр таван жилийн төлөвлөгөө буюу 1977-1981 оныг хамарсан тус төлөвлөгөө нь дээрх жилүүдэд дэлхийн аж үйлдвэрийн экспортын зах зээлд хүчтэй өрсөлдөж чадахуйц үйлдвэрүүдийг дэмжих бодлого байв. Эдгээр стратегийн ач холбогдолтой үйлдвэрүүдэд:

- усан онгоцны үйлдвэр,
- электроны үйлдвэр
- машины үйлдвэр гэх мэт чадварлаг ажиллах хүч бүхий үйлдвэрүүд багтдаг.

Энэ төлөвлөгөөнд төмөрлөгийн бус металл боловсруулах үйлдвэр, болд ган боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрүүд голчлон тусгагдсан. Уг төлөвлөгөөний үр дүнд 1981 оны байдлаар хүнд ба химийн үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүний нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дотор эзлэх хувь нь 58.5 хувьд хүрчээ. Тухайн үед Солонгос улс өндөр чанартай, хямд үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байснаараа усан онгоц гагын экспортод нэлээд амжилттай байсан. 1970-аад оны сүүлчээр дэлхийн өндөр хөгжилтэй улсуудын хүнд болон химийн үйлдвэрийн тоо эрс буурч эхэлсэн. Харин Солонгос улсын хувьд Засгийн газраас дотоодын машин механизм үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, гадны импортоос хамгаалах, санхүүгийн тусламж үзүүлэх зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Тавдугаар таван жилийн төлөвлөгөө нь 1982-1986 онд хэрэгжсэн бөгөөд онцлог нь макро эдийн засгийн тогтворжилт ба либералчлалд оршиж байсан хэмээн үздэг. Эдгээр нь:

- санхүүгийн либералчлал
- гадаад худалдааны либералчлал
- зах зээл дэх чөлөөт өрсөлдөөний бодлого юм.

Солонгос улс цаашид хүнд болон химийн аж үйлдвэрээс эрчимтэй технологи бүхий нарийн машин механизм, телевизор, видео хуурцаг, тоглуулагч, хагас дамжуулагч гэх мэт электрон тоног төхөөрөмжийн үйлдвэр уруу шилжихээр оролдох болсон. Гол зорилго нь дэлхийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа сайн технологитой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж гаргахад оршиж байв.

Зургаадугаар таван жилийн төлөвлөгөө нь 1987-1991 оныг хамардаг. Тухайн жилүүдэд өмнөх жилүүдийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг арай өргөн цар хүрээтэйгээр авч хэрэгжүүлэхээр болсон. Засгийн газрын гол зорилго нь импортын либералчлалыг хурдасгах, импортыг татварын бэрхшээлээс ангижруулахыг зорьж ажилласан. Мөн Засгийн газар бүх үйлдвэрүүдэд бус тодорхой үлдвэрүүдэд тухайлбал өмнө нь засгийн газрын тусламж дэмжлэгээс гадуур үлддэг байсан жижиг дунд үйлдвэрийнхэнд дэмжлэг үзүүлэхээр болсон.

Долоодугаар таван жилийн төлөвлөгөө 1992-1996 онуудыг хамардаг. Энэхүү төлөвлөгөөг 1989 онд нарийвчлан боловсруулсан бөгөөд эдгээр жилүүдэд микро электроникс, хими, хараа зүй, дэлхийн агаар мандал, биоинженерчлэл зэрэг өндөр технологи шаардсан салбаруудыг хөгжүүлэхээр зорьсон. Засгийн газраас орон даяар аж үйлдвэржилтийг газар зүйн хувьд тэнцвэртэй байгуулахын тулд алслагдсан орон нутгийн 7 хотод өндөр технологийн дэмжлэг үзүүлэх болсон. 1993 онд Ким Юн Санаар удирдуулсан шинэ засгийн газар гарч ирж тэдгээрийн авч явуулах бодлого нь мөн л 5 жилийн хугацаатай байсан. 1993-1997 оныг хамарсан шинэ эдийн засгийн хөгжлийн

төлөвлөгөөнд: бизнесийн үйл ажиллагааны дүрэм журмыг хөнгөвчлөх, засгийн газраас эдийн засагт үзүүлэх үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахаар болсон. Төлөвлөгөөнд заагдсан ёсоор гаднаас орж ирж буй бүтээгдэхүүний гаалиар нэвтрэхэд учирдаг саад бэрхшээл багасч, өрсөлдөөнд оролцох боломж нэмэгдэж байв. Засгийн газраас эдийн засгийг хөгжүүлж чадах 5 аж үйлдвэрийн салбарыг сонгож, тэдэнд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна. Солонгос улсын хөгжлийн гол амжилт нь хөгжлийнхөө гол чиглэлүүдийг зөв сонгож авсанд оршино. Солонгос улс шиг 40 жилийн хугацаанд газар тариалангийн орноос хүнд, дунд үйлдвэр хөгжсөн аж үйлдвэрлэлийн орон болж, ард иргэдийнхээ орлого болон амьдралын түвшинг эрс сайжруулж чадсан улс юм.

Эрчимтэй хөгжлийн богинохон хугацаанд ийм амжилтад хүрсэн улс төр, эдийн засгийн оновчтой бодлогын үр дүн гэдэг нь тодорхой боловч зарим нэг зүйлийг тодруулж үзье. Дээрх бодлогуудын хажуугаар өөрийн үйлдвэржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тодорхой үе шаттайгаар хөгжүүлсэн.

Хөтөлбөрийн эхний үе шатанд: Импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлийг баримталсан. Импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлд аажим аажмаар ахиц гарч яваандаа ихэнх бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэх болжээ. Үүний зэрэгцээгээр үндэсний хөрөнгөтний зарим хэсэг экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүдийг хавсран хөгжүүлэх чиг хандлагыг баримталжээ. Өөрөөр хэлбэл импортын барааг өөрсдөө үйлдвэрлэхээс гадна гадаадад бүтээгдэхүүн экспортлогч болох хоёр зорилтыг зөв зүйтэй хослуулан хөгжүүлсэн байдаг.

Хоёрдугаар шатанд: Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн суурь салбарыг хөгжүүлэх асуудлыг чухалчлан анхаарсан. 1967-1971 оны хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөнөөс эхэлж 1970-аад оны сүүлч үе хүртэл экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн төмөрлөг, хими, машины үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлсэн байна. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарч хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэрлэлийн хэрэгслийг импортоор авахад гаалийн татвараас хөнгөлөх буюу чөлөөлөх бодлого баримталжээ.

Мөн шинээр экспортод зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь гаалийн болон ашиг орлогын татвараас чөлөөлөх, хөнгөлөх арга хэмжээг хэрэгжүүлжээ. Төр засгаас олгосон энэхүү таатай боломжид тулгуулан экспортын чиглэлийн үйлдвэрлэл 1980-аад оноос эрчимтэй хөгжиж эхэлжээ. Өмнөд Солонгосын үсрэнгүй хөгжлийг экспортод чиглэсэн “эдийн засгийн гайхамшиг” гэж нэрлэдэг. Эдүгээ тус улс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байна.

Солонгосын төлөвлөлтийн систем

Солонгосын эдийн засгийн төлөвлөлтөд 6 зүйл чухал үүрэгтэй байдаг. Үүнд: Улсын удирдагч, төлөвлөгөөний хэлтэс, төсвийн хэлтэс, статистикийн хэлтэс, мэдээллийн хэрэгсэл, үндэсний эрдэмтэд. Доорх зурагт эдгээр 6 зүйлсийн хэр чухал, ялгаатай үүрэгтэй болохыг харуулсан. Энэ 6 идэвхжсэнээр дотооддоо тогтвортой эдийн засгийн төлөвлөгөө хэрэгжинэ гэж үздэг.¹⁶


Тусгай мэргэжилтнүүд төлөвлөгөө гаргагчдад тусгай мэдлэг, төлөвлөлтийн арга барилаар урт хугацааны төлөвлөгөө гаргахад нь туслалцаа үзүүлдэг. Мөн нэг зорилгод хүрэхийн тулд засгийн газрын 3 агентлаг хамтдаа ажилладаг.

Төлөвлөх хэлтэс төсөв болон статистикийн хэлтэстэй харилцах нь гол үүрэг гэж

¹⁶Korea's Capitalistic Planning Model: Policy Lessons for Mongolia.

үздэг. Төлөвлөгөөний боломжит хувилбар болон сөрөг үр дагаврыг шалгахын тулд мэдээллийн хэрэгслүүд чухал үүрэг гүйцэтгэдэг.¹⁷ Солонгос улс төлөвлөлтийн бодлогоо боловсруулахдаа салбар салбараар нь тусад нь авч үздэг байна. Тухайлбал: үндэсний нутаг дэвсгэрийн цогц төлөвлөгөө, бүс нутгийн цогц төлөвлөгөө, шинжлэх ухаан болон технологийн хөгжлийн 2025 он хүртэлх урт хугацааны төлөвлөгөө, тав таван жилийн төлөвлөгөөнүүдийг шат дараалан хэрэгжүүлдэг байна.

Зураг 14.



БНСУ-ын 2011 оны шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдэд доорх асуудлуудыг оруулсан байна.

1. Шинжлэх ухаан, технологийн шинэ систем бий болгон, үндэсний шинжлэх ухаан, технологийн институциональ байдлыг хангана.
2. 21-р зууны бүс нутгийн инновацийн шинэ засаглалыг бий болгож, олон улсын шинжлэх ухаан, бизнесийн бүсийг бий болгоно.
3. Хөгжиж буй орнуудад Солонгосын шинжлэх ухаан, технологид суурилсан хөгжлийн албан ёсны тусламжийг хөгжүүлнэ.
4. Шинжлэх ухаан, технологийн хувьд супер их гүрэн болж байгаа Хятад улсад хариу үзүүлнэ.
5. Худалдааны чөлөөт хэлэлцээр, шинжлэх ухаан, технологийн стратеги хоорондын уялдаа холбоог бэхжүүлнэ.
6. Мэдлэгт суурилсан эдийн засгийг дэмжих, шинжлэх ухаан, технологийн ажлын байр бий болгох
7. Нийгмийн сүлжээнд үндэслэсэн шинжлэх ухаан, технологийн инновацийн стратегийг хэрэгжүүлнэ.
8. Технологийн хувьд инноваци хийгдсэн жижиг бизнесүүдийг глобалчлах ажлыг хөнгөвчилнэ.
9. Хувийн хэвшлийн инновацийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
10. Ирээдүйн шинжлэх ухаанд томоохон дэмжлэг үзүүлнэ.

БНСУ-ын хөгжлийн өндөр түвшинд хүрсэн шалтгааныг эдийн засагчид, судлаачид янз бүрээр тайлбарладаг ч бодит байдалд хамгийн дөхүү хэд хэдэн шалтгаан бий. БНСУ цэргийн хатуу дэглэмийн нөхцөлд зах зээлийн эдийн засгийн ул суурьтай, ухаалаг тууштай бодлого явуулсан нь хурдацтай хөгжлийн нэг эх сурвалж байсан хэмээн үздэг. Мөн доорх хүчин зүйлсийг бас онцлох хэрэгтэй. Тухайлбал:

¹⁷Korea's Capitalistic Planning Model: Policy Lessons for Mongolia.

- Төрөөс эдийн засгийг удирдан зохион байгуулахдаа мөнгөний ханшийг унагалгүйгээр худалдаа, төлбөрийн тэнцлийг зөв барьж чадсан,
- Гадаадын хөрөнгө оруулалтыг чадамгай ашиглаж, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэхийг зохих ёсоор урамшуулах арга хэмжээ авсан,
- Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор бага хүүтэй зээл олгох явдлыг их анхаарсан,
- Гадаадын тэргүүний техник технологи, дэвшилттэй шинэ зүйлсийг худалдан авах тэдгээрийг дотооддоо боловсронгуй болгох ажлыг чадамгай хослуулсан,
- Улс орныг үйлдвэржүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар үр өгөөжтэй хэрэгжүүлсэн.¹⁸

Энэ бүх хүчин зүйлийн зэрэгцээгээр тухайн улс үндэстний хувьд дээд зэргийн сахилга бат, зохион байгуулалт, хүн ардынх нь хичээнгүй зүтгэл, зорьсондоо хүрэхийн төлөөх тэмүүлэл, үндэстний онцлог зан чанар маш ихээр нөлөөсөн гэж үздэг.

Солонгос улсын эдийн засгийн бодлогын нууц нь хамтын зах зээлийн эдийн (social market economy) засаг дээр суурилж Солонгос үндэстний сайн сайхны төлөө аливаа бодлогыг дэмжиж ажилласантай холбоотой гэж үздэг. Жижиг дунд үйлдвэр гэдэг улс орны хөгжлийн гарц биш учраас Солонгосчууд томоохон корпорациудыг (Hyundai, Kia, Samsung гэх зэрэг) байгуулан үүгээр дамжуулан дэлхийн зах зээлд гарч чадсан байна. Эдгээр томоохон компаниуд нь зөвхөн Солонгос улсын хөгжлийн төлөө байгуулагдсан нийтийн өмчийн хэлбэртэй үндэстний корпорациуд юм. Хувийн компани байгуулчихад зөвхөн өөрийнхөө төлөө бизнес хийдэг нөхдүүд хэзээ ч улс орныг хөгжүүлдэггүй гэдгийг хамтын зах зээлийн эдийн засгийн ном бүтээлүүдэд дурдсан байдаг.

Солонгосын эдийн засгийн өндөр хөгжил БНСУ-ын гурав дахь ерөнхийлөгч Пак Чон Хигийн үед улам эрчимтэй явагдаж үсрэлт болсон хэмээн үздэг. Тэрээр эхлээд улсаа экспортын баримжаатай аж үйлдвэрийн орон болгох бодлого баримталж, улс орноо өөрийгөө тэтгэх эдийн засагтай болгох үндсийг тавих, коммунизмыг шийдвэртэй эсэргүүцэх, НҮБ-ын бодлого, дүрмийг биелүүлэх, өндөр хөгжилтэй, чөлөөт капиталист орнуудтай ойртон хамтран ажиллах, улс орондоо үнийн өсөлтийг тогтворжуулж төсвийн алдагдлыг багасгах, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний нөөц хүчийг дээд зэргээр ашиглах бодлого баримталж хэрэгжүүлсэн.

БНСУ нь Азидаа ногоон хөгжлийн шинэчлэлээрээ тэргүүлэх улсын хувьд технологийн шинэчлэлээр дамжуулан ногоон эдийн засгийн хөгжил болон эрчим хүчний эх үүсвэрийг олж авах, аюулгүй цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг эрмэлзэж байна.

Судлаачид болон шинжээчдийн үзэж байгаагаар даяарчлал тус улсын эдийн засагт асар их зэрэг үр дагавар авч ирж байгаа. Эдийн засаг нь хэдий чинээ либералчилагдах тусам бүс нутгийн даяарчлалд нэгдэх үйл явц төдий чинээ хурдасна гэж үздэг. Үүний жишээ нь: Өмнөд Солонгосын ДНБ-ий 66 хувийг гадаад худалдааны өсөлтөөр хангаж байгаа нь эдийн засаг нь хэр зэрэг даяарчлагдаж байгаагийн нэгэн үзүүлэлт болдог байна.

Богино хугацааны дотор эдийн засгийн үсрэнгүй хөгжилд хүрч чадсан Солонгос улс өнөөдөр 73,000,000 хүн амтай, эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд 13-д ордог, дэлхийн шинжлэх ухаан, аж үйлдвэр, эдийн засгийн томоохон төвүүдийн нэг болж чаджээ.

¹⁸http://monua.ucoz.com/news/mnd_solongosyn_srehngj_khgzhljln_khchin_zjl/2010-01-26-533

6. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС


Хөгжлийн бодлого, түүний онцлог

Хятад улсад 1950-ад оноос эхлэн ЗХУ-ын тусламжтайгаар 200 гаруй аж үйлдвэржүүлэх, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлжээ. Хятад улс уг төслүүдээ зогсоолгүйгээр зах зээлийн эдийн засагт шилжихдээ компанийн хэлбэрт оруулсан байна. Уг төслүүдийг техник болон технологийн хувьд үе шаттайгаар шинэчилж дэлхийд өрсөлдөгч бүтээгдэхүүн гаргах үүднээс социализмын үеийн төслүүдээ устгалгүйгээр зах зээлийн менежментээр сайжруулан хөгжүүлснээр Хятадад үндэстний томоохон корпорациуд төрж эхэлжээ.

БНХАУ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шинэчлэлийг 1978 онд эхлүүлсэн. Энэ үед “Getting Rich First” буюу эхлээд баяжих хэрэгтэй гэсэн уриаг гаргаснаар 20 жилийн дотор Хятадын зүүн эргийн дагуух нутгуудад эдийн засаг эрчимтэй хөгжсөн байна. Харин баруун бүсийн нутгийн хөгжил хоцрогджээ.

Хятад улс нь “эдийн засгийн нээлттэй” бодлогыг гадаад худалдааны оновчтой бодлоготой хослуулан хэрэгжүүлснээр эдийн засгийн өндөр, тогтвортой өсөлтийг хангаж чадсан. 1978 оны нээлттэй бодлогоор Хятад улс зах зээлийн эдийн засагт шилжихдээ Хонгконгийн дэргэд байрлах Shenzhen гэдэг загасчны хуучин тосгон байсан газрыг зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх загвар хот болгож дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүн гаргаж борлуулах дэлхийн хэмжээний үйлдвэрүүдтэй болох хүсэлтэй хүмүүст зориулсан тусгай бодлогыг төрөөс баримталсан. Эдийн засгийн загвар хотыг байгуулахдаа хотын дагалдах дэд бүтцийг дэлхийн хэмжээний байхаар тооцож олон улсын стандартыг хангахуйц сургууль, цэцэрлэг, орон сууцны хороолол, соёлын төвүүд, спорт ордон зэргийг барьж байгуулсан. Мөн төрийн захиргааны газрыг болон татварын бодлогыг капитализмын хөгжилд таатай байхаар зохицуулжээ. 1978 оноос эхтэй уг шинэчлэлийн үр дүн 1990-ээд оны эхээр гарч эхэлсэн байна. Тус улсын ДНБ-ийг доорх зургаар харуулав.

Зурга 15.



Харин энэ үед Хятадын нийгэмд үүсээд байсан хамгийн том асуудал нь соёлын хувьсгалын үед үүссэн мэдлэгийн хоцрогдол байв. Хэдэн зуун сая хүнийг мэдлэгтэй болгоно гэдэг төрд эдийн засгийн хувьд асар том дарамт болж байсан нь тодорхой. 1986 онд бүх нийтийн 9 жилийн суурь боловсрол эзэмших тогтолцоо, тодорхой зорилтын тухай хууль тогтоол баталснаар Хятадын боловсролын салбарын шинэ үе эхэлсэн гэдэг. Боловсролын салбарт зориулсан төсвийг жилд дунджаар 21.6 хувиар нэмэгдүүлж байсан ба дунд сургуульд элсэн орох хүн амын коэффициент өсөн нэмэгдсээр 2007 онд 98.5 хувьд

хүрчээ. 2012 оны байдлаар, боловсролын салбарын зардлын хэмжээ ДНБ-ий 4 хувийг, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх зардлын хэмжээ ДНБ-ий 1.97 хувийг эзэлж байна. Тус улс нь нээлттэй бодлого явуулснаар хятад оюутнууд гадаад ертөнцтэй танилцах боломж нээгдэж, 1978 онд 860 оюутан гадаадад суралцахаар явж байсан бол 2007 он гэхэд 144,500 болж өссөн байна¹⁹. Гадаадын тэр тусмаа барууны орнуудад боловсрол эзэмшсэн Хятад хүмүүс эх орондоо буцан ирж асар их өөрчлөлтийг хийсэн гэж үздэг.

Боловсрол, шинжлэх ухааны тогтолцоо нь АНУ-ын тогтолцоог шууд хуулбарлан нутагшуулснаар хурдацтайгаар хөгжсөн. Баялаг үйлдвэрлэж, ажлын байрыг бий болгох зорилгоор дотоодын 100 их сургуулийг сонгон авч хөгжүүлсэн нь Хятадын үсрэнгүй хөгжлийн нэг нууц гэж үздэг. Эдгээр нийгэм, эдийн засгийн хөгжил хань үндэстэн төвлөрсөн далайн эргийн хотуудад өрнөж, харин бусад үндэстний хувьд түүхий эд нийлүүлэгч нутаг болон үлджээ.

Хятад улс хамгийн хямд ажиллах хүчнийг дэлхийн шилдэг хямд зардалтай технологитой оновчтой хослуулж олон төрлийн өргөн хэрэглээний, аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг хамгийн хямд өртгөөр асар олон тоогоор үйлдвэрлэж өөрийн улсын зах зээлийг хангаад зогсохгүй ихээхэн хэмжээгээр экспортлох болсноор бүс нутгийн зарим зах зээлийг хямд үнээр монополчилох хандлагатай болжээ. Энэ нь нэг талаас Хятадын дотоодын олон тооны үйлдвэрлэгч нарын хоорондын өрсөлдөөнөөс үүдэлтэй гэж үзэж болох боловч хямд зардалтай дэлхийн шилдэг технологийг оновчтой сонгоогүй тохиолдолд бүтээгдэхүүний хамгийн хямд өртгийг тогтоох боломжгүй юм.

Хятад улс дэлхийн үйлдвэрлэлийн олон төрлийн технологиуд дотроос хамгийн сүүлийн үеийн үр ашиг, бүтээмж өндөртэй хямд өртөгтэй технологийг сонгон авч, улсын нэгдсэн бодлого, хяналт дор дотоодын үйлдвэр аж ахуйн газруудад нэвтрүүлэх зөвшөөрөл олгодог төрийн мэдлийн тусгай Технологийн институт байгуулсан нь дээрх үр дүнд хүргэсэн.

Түүнчлэн, 2002 оны 12 дугаар сард ДХБ-д элсэн орсон нь тус улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгах нэгэн томоохон хүчин зүйл болсон. Тус улс нь ДХБ-ын гишүүн болохын тулд 15 жил зарцуулсан бөгөөд ялангуяа АНУ, Европын Холбоотой урт хугацаанд ярвигтай хэлэлцээ хийжээ. Хятад улс ДХБ-ын гишүүн болсноор гадаадын хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдэж, улмаар ажиллах хүчний цалин, улсын төсвийн орлого нэмэгдэж, шинэ технологи орж ирсэн байна. Үүний зэрэгцээ Хятад улс ДХБ-д элсэхдээ авсан амлалтын дагуу гадаад худалдааны тарифаа үе шаттайгаар бууруулснаар эдийн засгийн бүх салбарт өрсөлдөөн хурдасч худалдан авагчдын хувьд барааны сонголт, чанар сайжирч, үнэ буурчээ. Мөн өрсөлдөөн нэмэгдсэнээр Хятадын дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадвар дээшилсэн байна.

2000 оны эхээр эдийн засгийн өсөлтийн талаар Засгийн газраас барьж буй бодлогын шинэ зорилт бол аж үйлдвэрийн салбарын бүтцийг өөрчлөх замаар эдийн засгийн өсөлтийн чанар, үр ашгийг дээшлүүлэх явдал гэж тодорхойлсноор Хятадын ДНБ-ий цэвэр өсөлт жил бүр дунджаар 7.5 хувиар нэмэгдэж, 2012 оны байдлаар ДНБ нь 51.9 их наяд юань болж дэлхийд 2 дугаарт орж байна.

Тус улсын нээлттэй бодлогын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татан оруулж байгаа ба 2002 оноос хойш жилд дунджаар 41.8 тэрбум ам. долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсон байна. Одоогоор дэлхийн топ 500 үндэстэн дамнасан корпорациудаас 400 нь Хятадад хөрөнгө оруулаад байна.

¹⁹Ч.Батцэцэг. "БНХАУ-ын боловсролын шинэчлэл ба хүний нөөцийн тулгамдсан асуудал" нийтлэл.

Хөгжлийн төлөвлөлтийн талаар

БНХАУ нь Үндэсний түвшнээс орон нутаг хүртэл бүх түвшний төлөвлөлтийг Үндэсний Хөгжил, Шинэчлэлийн Хорвоо /The National Development and Reform Commission - NDRC/ хийдэг ба 1952-1998 онуудад Улсын Төлөвлөлтийн Хорвоо /The State Planning Commission - SPC/, 1998-2003 онуудад Улсын Хөгжил Төлөвлөлтийн Хорвоо /The State Development Planning Commission - SDPC/ нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан ба бусад яам, агентлаг нь төлөвлөлтийн үйл явцад оролцдог. Төлөвлөлтийн тогтолцоо нь үндэсний, бүс нутгийн, хот, тосгоны гэсэн үндсэн 4 түвшинтэй.

Зураг 16. Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийн үечлэл



БНХАУ нь “Үндэсний хөтөлбөр 21”-ийг 1992-1993 онд төлөвлөсөн нь Дэлхийн банк, Олон улсын валютын сан, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хамтран боловсруулсан “Т-21” хөгжлийн загварыг ашиглан тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцүүлсэн анхны орнуудын нэг юм.

“Т-21” загварын бодлогын гол зарчим нь бүх салбарын харилцан хамаарлыг судалсны үндсэн дээр макро эдийн засгийн урт хугацааны төлөвлөлт хийдэгт оршино. Энэхүү хөгжлийн загвараар хүрээлэн буй орчин болон нийгмийн хүчин зүйлд бодлого боловсруулагчдын гол анхаарлыг хандуулж, салбарын өөрчлөлт бусад салбартаа хэрхэн нөлөөлж байгааг тооцсоны үндсэн дээр урьдчилан төлөвлөх боломж олгодог юм байна.

Үндэсний хөтөлбөрийг зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн хорооны төлөөлөл, Улсын төлөвлөлтийн хорооны төлөөллөөс бүрдсэн удирдлагын баг 1992 оны 8 сард үүсгэн байгуулагдаж, улмаар 1994 оны 3 сард Төрийн зөвлөлөөр батлуулсан. Ингэхдээ Төрийн зөвлөл /State Council/-өөс удирдамж гарган, Үндэсний хөтөлбөр 21-ийг нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад стратеги хөтөч болгон таван жилийн төлөвлөгөө /1996-2000/-нд дэлгэрэнгүйгээр тусгаж, өдөр тутмын менежментээр хангахыг засгийн газрын бүх түвшинд үүрэг болгожээ. Үүний зэрэгцээгээр, Төрийн зөвлөл /State Council/-ийн доорх засгийн газар байгууллагууд нь өөрсдийн үйл ажиллагааны онцгой шаардлагад нийцүүлэн Үндэсний хөтөлбөр 21 болон үйл ажиллагааны төлөвлөлтөө хэсэгчлэн боловсруулж эхэлсэн байна. Жишээ нь, Ойн Яам /Ministry of Forestry/ нь “Үндэсний хөтөлбөр 21”-ийн ойн үйл ажиллагааны төлөвлөлтийг, Усны Нөөцийн Яам /Ministry of Water Resources/ нь “Үндэсний хөтөлбөр 21”-ийн усны нөөцийн төлөвлөлтийг хийх гэх мэт. Ийнхүү хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан таван жилийн төлөвлөлтөндөө оруулдаг байна.

Тус улсын төлөвлөлтийн баримт бичиг болох нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөг тав таван жилээр боловсруулдаг ба анх 1953-1957 онд баталснаас хойш өнөөг хүртэл 12 дахь таван жилийн төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 3. Сүүлийн 3 таван жилийн төлөвлөгөөний гол зорилт, агууллагууд

10 дахь таван жил, 2001-2005	11 дэх таван жил, 2006-2010	12 дахь таван жил, 2011-2015
Эдийн засгийн өсөлт Нийгмийн хөгжил Байгалийн баялаг, хүрээлэн буй орчны хамгаалал Шинэчлэл Боломж бололцоо	Дотоодын хэрэглээ Аж үйлдвэрийн дэвшил Байгалийн баялаг, хүрээлэн буй орчны хамгаалал Шинэчлэл Өөрчлөн байгуулалт Боломж бололцоо	Эдийн засгийн өсөлт Нийгмийн удирдлага Хүрээлэн буй орчин болон экологийн талаар цэвэр эрчим хүч Шинэчлэл Өөрчлөн байгуулалт Боломж бололцоо Хөдөө аж ахуй

Судалгааны захиалгад дурдагдсан хөгжлийн ямар бодлогыг гол болгон төлөвлөдөг, ирээдүйн хөгжлөө хэрхэн төлөвлөж байгаа талаар дүгнэлт хийхэд дөхөм болгож, БНХАУ-ын XII таван жилийн төлөвлөгөөний зорилго, онцлогоос²⁰ доор оруулав.

БНХАУ-ын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд 2011-2015 оны хооронд хэрэгжүүлэх төлөвлөгөө нь 12 дахь таван жилийн төлөвлөгөө болж байгаа ба нийт 16 хэсэг, 60 бүлэгтэй.

Тус төлөвлөгөөний онцлог нь өмнөх таван жилийн төлөвлөгөөний үргэлжлэл болохын хувьд ерөнхий загвар нь ижил бөгөөд хэрэгжүүлж ирсэн ажлаа цааш гүнзгийрүүлэх байдалтай хэдий ч зарим салбарт шинээр хэрэгжүүлэх зорилго зорилтуудаараа ялгарч байна. Үүнд:

1) Бүтцийн зохицуулалт хийх

Хятад улс ирэх 5 жилд эдийн засгийн өсөлтийн хэв загвараа өөрчилж, бүтцийн зохицуулалт хийх юм. Энэ нь үйлдвэрлэлийн бүтцээс хэрэглээний бүтэц рүү шилжих тухай хэлж байгаа ажээ. Энэ шилжилтээрээ уг төлөвлөгөө зөвхөн үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн XI таван жилийн бүтцийн зохицуулалтаас шууд ялгарч байгаа юм. Уг бүтцийн зохицуулалтыг хийснээр Хятад улс дэлхийн үйлдвэрлэгчээс дэлхийн зах зээл болохыг зорьж байгаа юм. Дэлхийн санхүүгийн хямралын үед Хятад улс дотоодын хэрэглээг дэмжих замаар эдийн засгаа тэтгэсэн нь амжилттай болсон тул уг бодлогоо XII таван жилийн төлөвлөгөөний нэг хэсэг болгож, дотоодын хэрэглээг тэлэх ажлыг эдийн засагт хийх стратегийн зохицуулалт, хөгжлийн хэв загварын чухал өөрчлөлт болгон оруулжээ. Учир нь Хятадын эдийн засаг олон жилийн турш хөрөнгө оруулалт болон экспортод түшиглэж ирсний улмаас хөрөнгө оруулалт-хэрэглээний зохист тэнцвэр алдагдсан юм. Тиймээс хөрөнгө оруулалт, экспорт голлосон өмнөх хэв загвараа өөрчилж, “хөрөнгө оруулалт, хэрэглээ, экспорт” гуравт түшиглэсэн өсөлт гаргах стратегийн шинжтэй бүтцийн зохицуулалтыг хийсэн байна. Энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд ирэх 5 жилд үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх жинг 4 пунктээр нэмэх нэмэх, ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 7 хувьд байлгах, хотжилтыг 4 пунктээр нэмэх, тосгоны иргэний жилийн дундаж орлогыг 2010 оны 5919 байсныг 2015 онд 8310 юань болгох, хот сууринд 45 сая ажлын байр бий болгох, ажилгүйдлийг 5 хувьд барьж, үнийн суурь түвшинг тогтвортой байлгах зэрэг зорилт дэвшүүлсэн байна.

²⁰Стратеги судлал сэтгүүл, №54, 2011 он.

2) Шинэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх

БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс “Стратегийн ач холбогдолтой шинээр хөгжиж буй үйлдвэрлэлийг хөгжүүлэн тэтгэх тухай шийдвэр”-ийг 2010 оны 8 сарын 9-нд батлан гаргажээ. Энэ шийдвэр нь XII таван жилийн төлөвлөгөөний хугацаанд шинэ чухал салбаруудыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх юм. Тус улс нь дараах 7 салбарыг стратегийн ач холбогдолтой шинэ хөгжиж буй салбар гэж үзжээ. /Хүснэгт 4/.

Хүснэгт 4.

№	Салбар	Гол төсөл	Хөгжүүлэх чиглэл
1	Шинэ эрчим хүч	Цөмийн, нарны, салхины, био эрчим хүч	Цэвэр эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчийг шат дараатай хөгжүүлэх
2	Байгальд ээлтэй, хэмнэлттэй үйлдвэрлэл	Өндөр ашигтай, хэмнэлттэй, байгальд ээлтэй, дахин ашиглагдах	Нүүрсхүчлийн хийг бууруулах, нөхөн сэргээдэх эдийн засгийг хөгжүүлэх, экологийг сэргээх
3	Шинэ эрчим хүч хэрэглэдэг машин	Хос хөдөлгүүрт болон дан хөдөлгүүрт	Хөдөлгүүрийн цэнэг зэрэг голлох техникийг үсрэнгүй хөгжүүлэх, зах зээлийн эргэлтэд оруулах
4	Шинэ материал	Тусгай материал, өндөр чанартай нийлмэл материал	Шинэ материал болоод ухаалаг ногоон үйлдвэрлэлийн системийг бүрдүүлэх
5	Биотехнологийн үйлдвэрлэл	Био эм, био ХАА, био үйлдвэр	Био эмийн судалгаа үйлдвэрийн сүлжээг бүрдүүлэх, ХАА-д сайжруулсан сортын үр тариаг нэвтрүүлэх
6	Шинэ үеийн мэдээллийн технологи	Дараагийн үеийн мэдээллийн сүлжээ, хавтгай дэлгэц, өндөр түвшний софтвер	Дараагийн үеийн интернет, технологийн сүлжээг хөгжүүлэх
7	Тэргүүний тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	Нисэх онгоц, далайн байгууламж, ухаалаг тоног төхөөрөмж	Үсрэнгүй технологи, тэргүүний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх

Стратегийн ач холбогдолтой шинэ сэргэж буй үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх нь Хятад улс ногоон хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэх нэг арга зам болох юм. Ногоон хөгжил бол XII таван жилийн төлөвлөгөөнд шинээр орж ирсэн нэр томъёо бөгөөд уг зорилтын хүрээнд эрчим хүчний зарцуулалтын 11,4 хувийг чулуулаг бус гаралтай эрчим хүч эзэлж байх, ДНБ дэх нүүрсхүчлийн ислийн хаялтыг 17 хувиар бууруулах, ой модны эзлэх талбайг 21,6 хувь хүртэл нэмэх, глобал уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зэрэг зорилго тавиад байгаа билээ.

Стратегийн ач холбогдолтой, шинэ сэргэж буй үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь шинжлэх ухаанч хөгжлийн нэг биелэл болох ба шинжлэх ухааны дэвшил гаргаж шинээр бүтээх нь эдийн засгийн хөгжлийн хэв загвараа өөрчлөхөд чухал тулгуур болно гэж үзэж байна. Шинэ төрлийн эрчим хүч, биотехнологи, мэдээллийн технологи зэрэг стратегийн ач холбогдолтой салбарыг хөгжүүлж, эдийн засгийн хуучин арга хэлбэрийг халан, ногоон хөгжлийн замд ороход шаардлагатай нэг чухал хүчин зүйл нь өндөр мэдлэгтэй боловсон хүчин юм. Иймд ДНБ-ий 2.2 хувийг судалгаа шинжилгээний зардалд зориулах, арван мянган хүн тутамд 3.3 ширхэг нээлт хийсэн патент байх зорилт тавьсны зэрэгцээ хүн амын суурь боловсролыг 93 хувьд хүргэх, 2012 онд боловсролын зардлыг ДНБ-ий 4 хувийг эзлэхээр төлөвлөжээ.

3) Дэлхийн эдийн засагт идэвхтэй оролцох

Өмнөх XI таван жилийн төлөвлөгөөнд нээлттэй бодлогоо урагшлуулах талаар “Олон улсын эдийн засагтай идэвхтэй хамтран ажиллана” гэсэн хэсэг оруулсан байсан бол XII таван жилийн төлөвлөгөөнд үүнийгээ дэлгэрүүлж “Дэлхийн эдийн засгийг тохинуулах, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох” хэмээн ихээхэн амбицтай томъёолсон нь Хятад улс G20 бүлэглэлд гол үүрэгтэй оролцох болсонтой холбоотой юм. Уг зорилтын дагуу хятад улс олон улсын дүрэм, стандартыг батлан гаргахад идэвхтэй оролцож, олон улсын эдийн засаг санхүүгийн байгууллагад илүү их үүрэг гүйцэтгэн, G20 бүлэглэлд санаачлагатай ажиллахаар төлөвлөж байна.

Хятад улс 30-аад жилийн турш нээлттэй бодлогын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагааг дотооддоо эрчимтэй дэмжиж, 2000 оноос “гадагш гарах” стратеги хэрэгжүүлж эхэлсэн ба XII таван жилийн төлөвлөгөөнд үүнийгээ үргэлжлүүлж, хилийн чанадад хийх хөрөнгө оруулалтаа нэмэн, олон улсын эрчим хүчний нөөц баялгийг нээн олборлох, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай заажээ. Дээр дурдсан зорилго зорилтуудаас гадна XII таван жилийн төлөвлөгөөнд орлогын хуваарилалт, орон сууц, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, олон нийтийн эрх ашгийг хамгаалах гэх мэт нийгмийн халамжийн чиглэлтэй зорилтууд, соёлыг цэцэглэн дэлгэрүүлэх, батлан хамгаалах салбарыг бэхжүүлэх, социалист ардчиллыг хөгжүүлэх, хууль ёсыг дэмжиж, авлигатай тэмцэх зэрэг бусад салбаруудын зорилтуудыг төлөвлөсөн ба эдгээр нь үндсэндээ XI таван жилийн төлөвлөгөөнд тусгаж байсан агуулгатай ойролцоо юм.

XII таван жилийн төлөвлөгөөний онцлогийг нэгтгэн харвал, Хятад улс олон жилийн турш бүтээгдэхүүн экспортлох замаар гол орлогоо бүрдүүлж байсан бол бүтцийн шинэчлэлийг хийснээр хэрэглэгч орон болж, эдийн засгийн өөрөө өөрийгөө тэтгэх тэнцвэртэй тогтолцоо бүрдүүлэхийг зорьж байна. Энэ тогтолцоог бүрдүүлэхэд Хятад улс урьдынх шигээ хямд ажиллах хүчинд дулдуйдсаар байвал өрсөлдөх чадварт нөлөөлөх төдийгүй газар тариалан, аж үйлдвэрийн орон хэвээр байх тул шинэ технологи нэвтрүүлэн үйлдвэрлэлийн дэвшлийг ашиглахаар шинэ тутам хөгжиж байгаа стратегийн ач холбогдолтой салбаруудыг тоочин нэрлээд байгаа юм. Энэ салбарууд нь мөн байгаль экологид ч хамаатай. Сэргээгдэх эрчим хүч гэх мэт эрчим хүчний төрөл бүрийн эх үүсвэрийг нэвтрүүлэх нь байгальд ээлтэй төдийгүй эрчим хүчний аюулгүй байдлаа хангахад нь туслах учир ногоон хөгжил, ногоон өсөлтийг эрчимтэй дэмжиж байна.

Зураг 17. XII таван жилийн төлөвлөгөөний онцлог



XII таван жилийн төлөвлөгөөнд өмнөх таван жилийн төлөвлөгөөний адилаар эдийн засгийн бүсчлэлийг ангилахдаа баруун, зүүн, зүүн хойд, төвийн гэсэн 4 том бүсийн зэрэгцээ үндэсний цөөнхүүдийн оршин суух хязгаар нутгийн буурай хөгжилтэй бүс гэж тусгайлан зааж, хөгжүүлэхээр тусгажээ.

Баруун бүсийг бодлогоор дэмжихдээ Хятадын бүсчилсэн хөгжлийн стратеги дотроос баруун бүсийн хөгжлийг тэргүүн эгнээд тавьж, тусгай бодлогоор дэмжинэ гэж заажээ. Уг тусгай бодлогыг ХКН-ын Төв хороо, Төрийн зөвлөлөөс хамтран 2010 оны 5 сард ШУӨЗО-ны асуудлаар хуралдаад дэвшүүлж гаргасан ирэх 5-10 жилд Шинжаанд хэрэгжүүлэх шинэ бодлого, тодорхой зорилтуудтай холбож ойлгож болох юм.

Тус зорилтуудын дагуу ирэх 5 жилд Шинжаанд 2.0 их наяд гаруй юанийн хөрөнгө оруулах бөгөөд энэ нь өнгөрсөн 5 жилд буюу XI таван жилийн төлөвлөгөөний хугацаанд оруулсан хөрөнгөөс даруй 2 дахин их тоо болох юм. 2015 он гэхэд ШУӨЗО-ны ДНБ-ий хэмжээг Бүх Хятадын ДНБ-ий дундаж түвшинд хүргэж, улмаар 2020 он гэхэд Шинжааныг ядуурлаас ангижруулан, “чинээлэг нийгэм”-ийг цогцлоон байгуулах зорилт тавьж байна. Хятад улс баруун бүсийнхээ хөгжлийг онцгойлон авч үзэх болсны нэг шалтгаан нь тус бүс нь Хятадын хамгийн олон үндэстэн нэг дор оршин суудаг, салан тусгаарлах үзэл бодолтой, үе үе террорист үйл ажиллагаа явуулдаг учир үүнийг саармагжуулах зорилготой, нөгөө талаар энэ бүс байгалийн арвин баялагтай учир авч ашиглах шаардлага байгаа зэрэг нь баруун бүсийг онцлоход хүргэсэн гэж үзэж болох юм.

Ирээдүйн хөгжлийн бодлогын чиг хандлага, төлөвлөлт

Хятад улсын хөгжлийн өмнөх туршлагаас харахад хямд ажиллах хүчинд тулгуурлан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, дэлхийн зах зээлд экспортлох, экспортоос олсон орлогоос баялгийг бүтээх хөгжлийн загвар байсан бол цаашид дотоодын зах зээлдээ түшиглэн дотоод эрэлт хэрэгцээгээ нэмэгдүүлж, техникийн инновацийг чухалчлан, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх шинэ хөгжлийн загварт шилжих нь зүйтэй гэж үзэж байна. Хятадын КН-ын XVIII их хуралд хөгжлийн хэв загварын өөрчлөлтийг шуурхайлж, шинжлэх ухаанчаар хөгжихийг онцлон, Хятадын онцлогтой орчин үеийн аж үйлдвэр, мэдээлэлжүүлэлт, хотжилт, ХАА-н өөрчлөлт шинэчлэлтийг хийх, энэ хүрээнд 4 салбарын өөрчлөлт шинэчлэлтийг зэрэг хэрэгжүүлэх, мэдээлэлжүүлэлт ба үйлдвэржилт, үйлдвэржилт ба хотжилт, хотжилт ба ХАА-н өөрчлөлт шинэчлэлтийг нарийн нягт уялдаа холбоотой явуулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна²¹.

Тус улс нь 2020 он гэхэд дундаж чинээлэг нийгэм байгуулна гэсэн зорилт тавьж, үүний хүрээнд ДНБ-ийг болон хот, хөдөөгийн оршин суугчдын нэг хүнд ногдох орлогыг 2010 оныхтой харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж байна.

7. ЯПОН УЛС

Япон Улсын төлөвлөлтийн бодлогын талаар

Японы хурдацтай хөгжил, эдийн засгийн өндөр өсөлт, түүнд хүрэхэд нөлөөлсөн хүчин зүйлийг судлах асуудал дэлхийн бусад улсын судлаачдын төдийгүй энгийн хүмүүсийн анхаарлыг татаж, тэд олон талаас нь судалж, янз бүрийн үнэлэлт дүгнэлт өгсөөр ирсэн.

Япон Улсын хөгжлийн загвар нь Азийн бар гэгдэх улсуудын хөгжлийн загвар, арга хэлбэр болсон байдаг. Ер нь Азийн орнууд түүний дотор Хятад Улс ч өөрийн эдийн засгийн хөгжилд Японы загварыг сонгон авснаараа эдийн засгийн өндөр өсөлтөд хүрэхэд нөлөөлсөн гэж үздэг.

Судалгааны захиалгын дагуу Япон Улсын хэрэгжүүлсэн урт, дунд, богино хугацааны Тухайлбал: "Comprehensive National Development Plan (CNDP) – 1,2,3,4", "Comprehensive National Development Plan-5 and Grand Design for the 21st Century", "Japan's Future

²¹Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Элчин зөвлөх, доктор Ц.Батбаярын ярилцлага, 2013 он.

Development Strategy and Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy", 2007 оноос хойш хэрэгжүүлж буй "Japan's Innovation-25 strategy", одоо хэрэгжүүлэхээр төсөл шатандаа явж байгаа "Japan Revitalization Strategy, Japan is back" төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг судалж үзлээ. /Дээрх төлөвлөгөөнүүдийг бүрэн эхээр нь хавсралтаар авах боломжтой/.

Дээрх төлөвлөгөөнүүдээс харахад тус улс төлөвлөлтийн бодлогыг оновчтой, тодорхой нарийн гаргадаг нь харагдаж байна. Уг асуудлыг зөвхөн төлөвлөөд орхих биш хэрхэн яаж уг зорилгодоо хүрэх, хэрэгжүүлэх арга замаа нарийн зохион байгуулж хэрэгжүүлдэг нь илэрхий байна.

Япон Улсын төлөвлөлтийн тогтолцоо нь хууль, эрх зүйн хяналт, төлөвлөлт хийх, газар төлөвлөлт, бүсчлэх, хүн амын нягтаршилыг хянах зэрэг олон бүрэлдэхүүнийг хамарсан нарийн тогтолцоо юм. Японы төлөвлөлт нь үндэсний, бүсийн, орон нутгийн гэсэн 3 түвшинд явагддаг байна.²²

Япон Улс аливаа асуудлыг том жижиг, их бага гэж ялгалгүйгээр нарийн төлөвлөлт, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг нь тэдний боловсруулан хэрэгжүүлж буй төлөвлөгөө, хөтөлбөрүүдээс тодорхой харагдаж байна. Ингэхдээ 15-25 жилийн урт хугацааны төлөвлөгөө, дунд хугацааны буюу 5 жилийн төлөвлөгөө, мөн богино хугацааны буюу жилийн төлөвлөгөө /төсвийн төлөвлөлт/ гэсэн хугацааны хувьд 3 янзын төлөвлөгөөг боловсруулж баталдаг. Хугацааны хувьд дээрх 3 төрлийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг боловч тухайн төлөвлөх гэж буй асуудлаасаа шалтгаалан ямар хугацаагаар төлөвлөхөө шийддэг байна.

Урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрт Японы ирээдүйн хөгжлийн бодлого, чиглэлийг хэтийн зорилго болгон боловсруулж баталдаг бол таван жилийн төлөвлөгөөгөөр эдийн засаг, нийгмийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тогтоож, түүнд хүрэх тоон үзүүлэлт, түвшинг тогтоодог.

Япон улсын төлөвлөлтийн баримт бичгүүдээс дурдвал:

- Урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
 - o "Japan's Innovation-25 strategy" 2025 он
 - o Comprehensive National Development Plan-1 /1962-1970 он/
 - o Comprehensive National Development Plan-2 /1969-1985 он/
 - o Comprehensive National Development Plan-3 /1977-1987 он/
 - o Comprehensive National Development Plan-4 /1987-2010 он/
 - o Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy
 - o Comprehensive National Development Plan-5 or Grand Design for the 21st Century /1998-2015 он/
 - o Japan is back, Japan Revitalization Strategy
 - o Strategic Market Creation Plan
- Дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
 - o 5 year economic plan
 - o Japan's 5-Year Science Plan
- Богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
 - o Annual report
 - o budget report
 - o other

Англи, АНУ-д эдийн засаг дахь төрийн оролцоо бага байдаг бол Японд эсрэгээр төр эдийн засагт чухал үүрэгтэй гэсэн онолоор явдаг.

²²<http://www.gdrc.org/udem/observatory/jp-overview.html> - Global Development Research Centre, 2010.

Дэлхийн 2-р дайны дараа Япон улс эдийн засаг аж ахуйгаа сэргээн хөгжүүлэх 10 гаруй төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж баталсан. Эдгээрийн анхных нь 1946 оны 3 сард Японы төрийн зүтгэлтэн, нэрт эдийн засагч Окита болон түүний багийнхны боловсруулсан “Японы эдийн засгийг сэргээн босгох үндсэн зорилт” хэмээх анхны чухал төлөвлөгөө байсан.

Уг төлөвлөгөөнд эдийн засаг, нийгмээ сэргээсний үндсэн дээр 1930 оны үед байсан хэмжээнд хүн амын амьжиргааны түвшинг ердөө 4 жилийн дотор буюу 1950 онд сэргээсэн байхаар заажээ. Тэрхүү төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж байсны нэг баталгаа нь 1951 он гэхэд аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ дэлхийн 2-р дайны өмнөх үеийн түвшинд хүрсэн явдал юм.

Японы Засгийн газраас эдийн засгийг цаашид эрчимжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөг 1950-аад оны дундуур баталсан. Уг төлөвлөгөө нь эдийн засгийн бат бөх үндсийг бий болгож бие даасан түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлэн тавьсан.

Бодитой бөгөөд тодорхой бодлого зорилтын хувьд экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийн салбарыг шинэчлэх, импортын хэмжээг багасгах ач холбогдолтой аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарал тавьжээ.

Үүнээс хойш 1950-1960 аад онуудад эдийн засгийг өндөр түвшинд хөгжүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөө, мөн 1960-аад оноос нийгмийн халамжийг сайжруулах талаар төлөвлөгөө баталж хэрэгжүүлсэн нь байгалийн бохирдол, нийгмийн хангамжид үл тохирох байдал, хүн амын нутагшилтын асуудал хурцаар тавигдаж байсан.

Японы эдийн засгийг хөгжүүлэх талаар боловсруулсан хамгийн чухал төлөвлөгөө бол “Үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлэх” төлөвлөгөө байсан. Энэ төлөвлөгөөг 1960 онд баталсан бөгөөд уг төлөвлөгөөгөөр эдийн засгийг жилд 7.2 хувиар өсгөж, 10 жилийн дотор Японы үндэсний орлогыг 2 дахин өсгөж, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх зорилго тавьсан юм. Уг төлөвлөгөө нь дотроо нийтийн аж ахуйг хөгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, экспортыг хөгжүүлэх, хөгжиж байгаа орнуудтай гадаад худалдаагаа өргөжүүлэх, шинжлэх ухааныг хөгжүүлэх, мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй болох, эдийн засгийн давхардсан бүтцийг арилгах, нийгмийн тогтвортой байдлыг хангах гэсэн үндсэн бодлогуудаас бүрдэж байжээ. Ингээд Японы эдийн засаг 1950-аад оны дунд үеэс эхлэн 1970-аад оны эхэн хүртэл үнэхээр хурдацтай өссөн.

Тухайлбал 1954 оноос хойш 14-15 жилийн дотор үндэсний орлогоо бараг 7 дахин нэмэгдүүлж жилийн дундаж өсөлтийг 15 хувьд хүргэсэн нь эдийн засгийн туйлын өндөр өсөлт байсан. Үүний тулд хуримтлалын фонд, үндсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг 11.5-13.9 дахин буюу жилд 20 орчим хувиар нэмэгдүүлж байсан байна.

Япон Улсын хөгжил дэвшилд хүрэх, эдийн засгаа сэргээн хөгжүүлэх оновчтой зөв бодлогын гол цөм нь дотоод, гадаад зах зээлд нийцүүлэн хөгжүүлэх салбараа зөв сонгож авсан, аж үйлдвэрийн зохистой бүтцийг бүрэлдүүлсэн явдал юм. Чухамдаа Японд л төрийн нарийн бодлого, зохицуулалтын үндсэн дээр автомашины, холбооны хэрэгслийн тоног төхөөрөмж, эрчим хүч, хими, электроник, төмөрлөгийн гэх мэт үйлдвэрлэлийн салбаруудыг хөгжүүлж чадсан.

Японы нэг онцлог бол Засгийн Газар нь тухайн үйлдвэрийн удирдлагуудтай хамт нарийвчилсан судалгаа хийж, ирээдүйтэй болон олон улсын зах зээлд харьцангуй давуу байр суурь эзэлдэг аж үйлдвэрийн салбаруудыг тодорхойлсон. Түүнчлэн ийм салбаруудыг хөгжүүлэхэд Засгийн газраас ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тусламж дэмжлэг үзүүлж болох талаар судалгаа хийсэн байна. Үүний тод жишээ нь автомашины үйлдвэрлэлийн салбар юм. Автомашины үйлдвэрлэлийг тэргүүлэх салбар хэмээн тодорхойлж, энэ

салбарыг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай болтол нь “гадаадын шууд хөрөнгө оруулалтыг оруулахгүй байх” зарчмыг төрөөс баримталж, эдийн засгаа гадны улс орноос үл хамаарах нөхцөлөөр бүрдүүлсэн.

Хэрэв тэр үед төрөөс гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн бол өнөөгийн Японы машины үйлдвэрлэлийн тогтвортой үндэс байхгүй байсан гэж үздэг. Энэ бол аж үйлдвэрлэлийн салбарыг оновчтой сонгон авах, өөрөө өрсөлдөх чадвартай болтол нь хөгжүүлэх, түүний дараа гаднах өрсөлдөөнд тулгуурлах гэсэн бодлогын дагуу хийгдсэн.

Гэхдээ Японы удирдлагууд шаардлагатай гэж үзсэн үйлдвэрлэлийн зарим салбаруудыг төрийн ивээлд байлгаж, дараа нь төрөөс үзүүлэх дэмжлэгийг аажмаар багасгах бодлого баримталсан. Тухайлбал нүүрс олборлолт, химийн хортой үйлдвэрлэлийн зарим салбарууд болон өөр хэд хэдэн салбаруудад ийм арга хэмжээ авчээ.

Японы ихэнх үйлдвэрлэлийн салбарууд нь жижиг засварын газар, цехээс эхлэн аажмаар хүчин чадлаа нэмэгдүүлэх замаар хөгжсөн байдаг. Үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг импортлон авсны дараа өөрсдийн хүч хөдөлмөр арга ухаанаар бага багаар сайжруулсаар анхны түвшнээс илүү боловсронгуй болгож, дараа нь байнгын өндөр түвшинд байлгаж ахиулсаар хөгжүүлж чаддаг байсан. Энэ нь Японы эдийн засгийн гайхам хөгжилд хүрэх нэг онцлог арга байсан.

Өргөн хүрээг хамарсан өсөлт /Inclusive Growth/

Япон Улс нь улсын эдийн засгийн өсөлт, амжилтыг ДНБ-ээр хэмжих нь шаардлага хангахгүй гэж үзээд түүний оронд “Inclusive growth” буюу “өргөн хүрээг хамарсан өсөлт” /ӨХХӨ/ гэдэг хэмжээсийг хэрэглэх саналыг гаргажээ. Энэ нь тухайн улс орны иргэн бүрд тэгш боломж олгон, ядуурлын хэмжээг бууруулах, өсөлтийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн, нийгмийн бүхий л хэсгүүд үр ашгийг шударга хүртэхээр эх үүсвэр, нөөцийн хуваарилалтыг үндэсний урт, дунд, богино хугацааны үр ашгийг тооцон ухаалгаар явуулна гэсэн үг юм.

ӨХХӨ нь тухайн улс орны ядуурлын хэмжээг бууруулах, өсөлтийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл явц юм. Өөрөөр хэлбэл, энэ нь нийгмийн бүхий л хэсгүүд үр ашиг хүртэхээр эх үүсвэр, нөөцийн хуваарилалтыг шударга явуулна гэсэн үг. Гэхдээ уг хуваарилалт нь өргөн хэрэглээний бараа, таваар, ажил эрхлэлт, амьжиргааны түвшин зэрэг нийгмийн урт, дунд, богино хугацааны үр ашигт үндэслэх ёстой.

Эх үүсвэрийн хуваарилах үед авлига зэрэг гадаад сөрөг хүчин зүйлс бий болдог ч амьжиргааны бүх түвшинд ажил эрхлэх адил тэгш боломжоор хангаж өгдөг. Ажлын байр нэмэгдүүлэх, зах зээл, хэрэглээг бий болгох, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг нь амьжиргааны наад захын хэрэглээний хүртээмжийг бий болгох үндэс суурь болно. Баян, ядуугийн ялгаа ихтэй улс орны хувьд энэ нь тэрхүү ялгаа заагийг багасгах оновчтой шийдэл болно.

2008 онд Японы Өсөлт, хөгжлийн комиссоос гаргасан тогтвортой өсөлт, өргөн хүрээг хамарсан хөгжлийн стратегийг тодорхойлсон байна. Энд дурдсанаар, өргөн хүрээг хамрах гэдэг нь зах зээл, ажил эрхлэлт дэх тэгш байдал, адил тэгш боломж бөгөөд эдгээр нь амжилттай явж байгаа өсөлтийн стратегийн хувьд чухал бүрдэл хэсгүүд юм. Адил тэгш боломж бол байгууллага, хувь хүмүүсийн хувьд зах зээл, эх үүсвэрийн хууль, эрх зүйн алаглалгүй орчныг бий болгоно гэсэн үг. Уг комисс боломжийн тэгш бус байдлыг авч үзэхдээ улс төрийн суваг, зөрчилдөөнөөр бий болох хөгжлийг гажуудуулагч “хор” гэсэн байна²³.

²³The Commission on Growth and Development (2008).

ӨХХӨ-ийн арга нь хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэхдээ шууд мөнгө тараах биш, харин урт удаан хугацаанд тогтвортой, бүтээлч ажил эрхлэлтийг бий болгох явдал юм. Засгийн газар ядуурлын хүчин зүйлүүдийг бууруулахын тулд богино хугацаанд орлого хуваарилалтын хөтөлбөрийг санаачилж болох хэдий ч эдгээр хөтөлбөр нь урт хугацаанд шийдэл болохгүй бөгөөд богино хугацаанд ч амжилттай болох нь эргэлзээтэй.

Мөн Өсөлт, хөгжлийн комиссын тайлангаас үзвэл, Засгийн газраас хэрэгжүүлж буй байнгын тогтвортой урт хугацааны өсөлт нь өсөлтийн стратеги амжилттай байх урьдач нөхцөл гэсэн байна.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө /Comprehensive National Development Plan/

Японы ерөнхий сайд бусад сайдуудтайгаа зөвшилцөн 1950 онд Улсын нэгдсэн хөгжлийн хууль дээр үндэслэн Улсын ерөнхий хөгжлийн төлөвлөгөөг гаргасан. Япон улс Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг /Comprehensive National Development Plan/ харилцан уялдаатай, шат дараалан хэрэгжүүлсээр ирсэн.

Анхны төлөвлөгөө 1962 онд батлагдсан. Дэлхийн II дугаар дайны дараа үйлдвэрлэл хэт өссөнөөр томоохон хотуудын нутаг дэвсгэр дээр үйлдвэржилт, хүн ам хэт ихсэж, хөдөө орон нутгуудад нийгэм эдийн засаг уруудахад хүргэсэн. Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөг гүйцээж мөн оршин байгаа том хотуудаас гадна үйлдвэрийн хотуудыг шинээр бий болгоход дэмжих зорилготой “Өсөлтийн цэгийн стратегийг” хэрэгжүүлсэн. Энэ стратегийн дагуу Шинэ үйлдвэржилтийн хотын хөгжлийн хуулийг 1964 онд баталсан. 1964-1966 онуудад 15 шинэ үйлдвэржилтийн хотыг бий болгосон. Үйлдвэржилтийн хөгжлийн зорилго, зорилт, хүн ам, газрын ашиглалт, зам, боомт, үйлдвэр барих газар, барилга байшин зэрэг асуудлыг засаг захиргааны түвшний төлөвлөгөөгөөр хангасан. Жишээ нь анхдагч үйлдвэрийн хувьцаа 1950 онд 48,5 хувиас 1960 онд 32,7 хувь болтлоо буурсан ба 1980 онд 10,9 хувь болж буурсан. Энэ цаг үед номхон далайн эрэг хавийн газруудаар хүнд болон нефть химийн үйлдвэрүүдийг дэмжиж түүний араас эдийн засгийн өндөр өсөлт бий болсон. 1960 онд Икедагийн засгийн газраас санаачилж баталсан “Үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөө” нь Японы эдийн засгийн хөгжилд асар их хувь нэмэр оруулсан гэж үздэг. Уг төлөвлөгөөнд:

1. Эдийн засгийн өсөлтийг 7.2 хувьд хүргэх,
2. 10 жилийн дотор үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлэх
3. АНУ-ын шинэ дэвшилтэт технологиос суралцах
4. Гадаад худалдааны эргэлтийг сайжруулах
5. Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй болох гэсэн зорилтуудыг тавьж хэрэгжүүлсэн.

Улсын орлогыг 2 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөө нь хугацаанаасаа 2 жилийн өмнө зорилт нь биелсэн байна.

1969 онд 2 дахь төлөвлөгөө гарсан ба үүнд үндэсний хэмжээний авто зам, хурдан галт тэрэгний замын /Шинкансен/ сүлжээний системийг том хэмжээний үйлдвэржилтийн хөгжлийн төслүүдийн хамт хэрэгжүүлэн байгуулах зэргээр нэг дэх төлөвлөгөөний үндсэн зорилгуудыг өргөжүүлэхээр зорьсон. Хэт төвлөрсөн газруудын /шилжүүлэх нутаг дэвсгэр/ үйлдвэрүүдийг арай бага хөгжсөн /дэмжлэг үзүүлж буй нутаг дэвсгэр/ газрууд руу дахин шилжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн.²⁴

1977 онд 3 дахь төлөвлөгөө гарч, ард иргэдийн амьдрах орчныг хөгжүүлэх төсөл хэлбэрээр оршин суух ая тухтай орчин бий болгох зохицуулалтуудыг гаргасан. Энэхүү гаргалаа нь үйлдвэржилтийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжсэн стратегиар хэрэгжүүлсэн.

²⁴www.gdrc.org/uem/observatory/jp-overview.html - Japan: Overview of Planning.

4 дэх төлөвлөгөө нь /1989 оноос/ Нийслэл хотын бүс нутгийг бүхэлд нь хамарч, Япон улсын хөгжилд нэлээд эерэг үзүүлэлт авчирснаараа өмнөх төлөвлөгөөнүүдээсээ ялгаатай болсон. 1989 оныг хүртэлх хугацааг хүн амын өсөлт, үйлдвэржилтийн хүчтэй өсөлттэй зэрэгцээд даяарчлал, мэдээлэл дээр тулгуурласан эдийн засаг, нийгмийн дэд бүтэц дэх томоохон хөрөнгө оруулалтууд зэрэг нь ерөнхий төрхийг бүрдүүлсэн. 4 дэх төлөвлөгөө нь 1989-2000 /15 жил/ хүртэлх үеийг хамарсан юм. Улсын нийслэл хотын бүс /National Capital Region/ нь Токио их хотын бүс нутаг болон гаднах бүс нутаг гэсэн 2 бүсэд хуваагддаг. Уг стратеги нь Улсын нийслэл хотын /NCR/ хөгжлийг улс төр, эдийн засаг болон соёлын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын хэмжээнд авч үзсэн. Байгалийн болон хүний гараар хийсэн хүрээлэн буй орчныг онцолсон олон суурьтай, ерөнхий туслах бүтцээс нийслэлийн бүсийг хотын бусад захын нутаг дэвсгэр мөн бусад бүс нутгийн төвүүдийн хоорондын харилцааг харуулсан.

5 дахь төлөвлөгөө буюу хамгийн сүүлд хэрэгжүүлж буй төлөвлөгөө нь “Grand Design for the 21st Century” хэмээх төлөвлөгөө бөгөөд уг төлөвлөгөө 2015 оныг дуустал хэрэгжинэ.

Хүснэгт 5. Японы Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө
/Comprehensive National Development Plan/ CNDP

Хөтөл- бөрүүд	Батлагд- сан он сар өдөр	Хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусах хугацаа	Үндсэн зорилт	Хөгжүүлэх арга	Агуулга
CNDP	1962.10.05	1970 он	бүс нутаг хоорондын тэнцвэртэй хөгжил	Бүс нутгийн үйл ажиллагааны хөгжил	1.Эдийн засгийн өндөр өсөлт рүү шилжих 2. хүн амын хэт өсөлт ба орлогын ялгаатай байдал 3.үндэсний орлогыг 2 дахин өсгөх
2 дахь буюу Шинэ CNDP	1969.05.30	1985 он	байгаль орчныг дахин сэргээх	Өргөн цар хүрээтэй төсөл төлөвлөгөөний үр дүн	1.Эдийн засгийн өндөр өсөлт 2.Нийслэл хотын бүсийн үйлдвэрийн болон хүн амын төвлөрөлт 3.Техник технологийн шинэчлэл болон даяарчлал, технологийн мэдээллийн дэвшил
3-дахь CNDP	1977.11.04	1977 оноос 10 жил	Амьдрах орчныг сайжруулах	Тогтвортой суурь зарчим	1.Тогтвортой эдийн засгийн өсөлт 2. Үйлдвэрлэлийн болон хүн амын төвлөрлийг сааруулах 3.Үндэсний хязгаарлагдмал нөөц болон эрчим хүчийг тодорхой болгох

4 дэх CNDP	1987.06.30	Ойролцоогоор 2010 он	Хөгжлийн дээд түвшинд хүрэх	Олон талт сүлжээний үзэл баримтлал	1.Токио хотын хүн ам болон үйл ажиллагаанд бодлогоо төвлөрүүлэх 2.Жижиг хотуудын ажиллах хүч нь тэргүүн зэргийн асуудал 3. Бүрэн хэмжээний даяаршил
5 дахь CNDP /21-р зууны үндсэн бодлого/	1998.03.31	2010-2015 он	Prepare the basics for a multi-axial structure Олон талт бодлогын үндсийг бий болгох	Хамтын ажиллагаа ба оролцоо	1.Дэлхийн цаг үе (дэлхийн хүрээлэн буй орчин, мега өрсөлдөөн, Азийн улсуудтай солилцох) 2.Хүн амын бүтцэд залуучуудыг хувийг нэмэгдүүлэх 3.Мэдээлэлд чиглэсэн нийгэм

Эх үүсвэр: <http://www.hkd.mlit.go.jp/eng/04.html>

Япон Улсын хөгжлийн өндөр түвшинд хүрсэн нь аливаа асуудлыг эртнээс бодож боловсруулдаг, нарийн тооцоо судалгааны үндсэн дээр шийдвэрээ гаргадаг, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхийн тулд урьдаас төлөвлөж бэлтгэлээ хангадаг, нэг тогтсон шийдвэрээсээ ухардаггүй зан чанар, эдийн засгийн зөв бодлого зохицуулалт, алс хэтийг харсан төлөвлөлт, арга механизмтай шууд холбоотой гэж хэлж болох боловч бүхэлдээ тухайн улсын нийгэм, эдийн засаг, ард түмний уламжлалт зан чанар, соёл уламжлал зэргээс шалтгаалсан олон талтай цогц асуудал юм.

Дэлхий дээр эдийн засгийн цар далайцаар Японд гүйцэгдээгүй үлдсэн цорын ганц орон болох АНУ-ын зүгээс Японы эдийн засгийн өндөр хөгжлийн нэг гол түлхүүр болсон удирдлага зохицуулалтын оновчтой аргыг сулруулахын тулд шүүмжлэх хандлага байдаг.

Япон улс төлөвлөлтийнхөө бодлогын дагуу экспортын баримжаатай тэргүүлэх үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэхийн зэрэгцээ ЖДҮ-ийг эрчимтэй хөгжүүлэхэд анхаарч, технологийн ноу-хауг импортлон, түүнийгээ өөрсдийн арга ухаанаар улам баяжуулж боловсронгуй болгож улмаар өөрийн болгон авч чадсан. Тус улс аж үйлдвэрийн салбарыг судалгаа шинжилгээний үндсэн дээр тэргүүлэх чиглэлүүдээ сонгож, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болтол нь төрөөс бодитойгоор дэмжсэн бодлогын үр дүн юм.

Тухайлбал: Япон улсын эдийн засагт жинтэй байр суурь эзлэх төмөрлөгийн ууган үйлдвэр “Ниппон стил” нь мэргэшсэн боловсон хүчнээ ган үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Англи, Герман зэрэг өндөр хөгжилтэй орнууд руу илгээж, шинэ технологи нэвтрүүлж ган хайлуулалтаараа Япон улс АНУ-ын дараа орж байна. Мөн автомашины үйлдвэрлэлийг тэргүүлэх салбар хэмээн зөв тодорхойлж, энэ салбарыг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай болтол нь “гадаадын шууд хөрөнгө оруулалтыг оруулахгүй байх” зарчмыг төрөөс баримталж, эдийн засгаа гадаад улс орноос үл хамаарах нөхцөлөөр бүрдүүлсэн.

1960-аад оноос эдийн засгийн байдал бэхжэсэнийг харгалзан төрийн онцгой ивээлд байсан хэдэн салбараас бусад олонх салбаруудад бусад орноос дэвшилтэт технологи импортлох явдлыг чөлөөтэй болгожээ.

Мөн Япон Улс 1960-аад оны дунд үеэс өөрийн шинжлэх ухаан техникийн ололтыг түлхүү экспортлох болсон. Улмаар 1970-аад оны сүүлчээр бүртгүүлсэн патентын тоогоороо дэлхийд өндөр үзүүлэлттэй орнуудын тоонд орж дэлхийн патент, лицензийн 10 орчим хувийг эзэмших болсон. Япон улсын хөгжлийн өндөр түвшинд хүрэхэд төрөөс баримталж хэрэгжүүлсэн бодлого шийдвэрүүд чухал нөлөөтэй боловч тухайн ард иргэдийн зан чанар, сэтгэхүй, төлөвшил ихээхэн нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Тухайлбал: Япончууд өөрсдийн амьдрал, ажил үйлсээ нийгмийн тогтсон хэм хэмжээнд тохируулан бие даан зохицуулах чадвар сайтайгаас гадна аливаа юмыг хамгийн багаас нь эхлэн дэс дараатай уйгагүй хийдэг. Нэг дор тогтвор суурьшилтай, тэсвэр тэвчээртэй ажилладаг зан чанараас үүдэн үйлдвэрлэлийн удирдлага хөдөлмөрийн харилцааг оновчтой явуулж ирсэн нь хөгжлийн нэг чухал хүчин зүйл гэж үздэг. Нийгэмдээ тус болох сэтгэлгээ болон идэвх санаачилга, ажилсаг, бүтээлч зан чанар төлөвшсөн байдаг нь тус улсын эдийн засгийг богино хугацаанд сэргээн өндөр хурдацтай хөгжүүлэх бас нэгэн хүчин зүйл юм. Мөн Япончууд арвиг хямгагч бөгөөд дунджаар орлогынхоо 18-20 хувийг хуримтлалдаа хийдэг. Мөн улс орны хэмжээнд үзвэл үндэсний орлогынхоо 30 хувийг хуримтлалын санд оруулдаг байна. Иймээс Япон улс бол дотоод хуримтлал ахиутай, түүнийгээ үйлдвэрлэл, эдийн засгийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт болгон ашигласан.

Япон улс эдийн засгийн хөгжлийнхөө эхэн үед шатанд зэвсэгт хүчнээ бэхжүүлэхэд анхаарч, хүнд болон хөнгөн аж үйлдвэрийн салбарыг голлон хөгжүүлсэн. Дэлхийн 2-р дайны дараа туйлдсан эдийн засгаа сэргээн босгохын тулд Засгийн газар нь нарийвчилсан бүрэн судалгаа хийж, олон улсын зах зээлд харьцангуй давуу байр суурь эзлэх аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, тэдгээрийг төрийн зүгээс бодитойгоор дэмжих хэд хэдэн хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Японы эдийн засаг суларч хүн ам нь ядуурч, бүр өлсгөлөнгөөр үхэж байсан түүх бий. Энэ үед Японы удирдлагууд шийдвэртэй алхам хийхийг хичээж олон төрлийн бодлогыг баримталсан байдаг. Ялангуяа Японыг дахин сэргээх бодлого нь АНУ-тай нягт холбоотойгоор хэрэгжсэн. АНУ-ын томоохон компаниуд болон засгийн газраас асар их хэмжээний зээл, буцалтгүй тусламж Японы дайнд сүйдсэн болон шинээр хөгжиж буй аж үйлдвэрт санхүүжилтээр орж ирсэн. Японы засгийн газар энэ үед төрийн зардлыг танаж, ажилчдын цалин хөлсийг багасгаж, ард түмэн нь хоосон хонож, өлсөж байж хүнд бэрх үеэ туулсан гэдэг.

Япон болон бусад оронд хэрэгжсэн дайны дараах **“Маршаллын төлөвлөгөөгөө”**-ний дагуу аж үйлдвэржсэн шинэ Япон орныг байгуулах зорилго нь амжилттай хэрэгжсэн. Гэхдээ Япон Улс өөрсдийн хөгжлийн загвараа тодорхойлохдоо Германы эдийн засаг болон мэдлэг, технологийг судалж нэвтрүүлсэн. Энэ үед Японд дэлхийн зах зээлд өрсөлдөж чадах боловсон хүчин байхгүй байсан учраас хувийн хэвшилд тулгуурласан чөлөөт зах зээлийн эдийн засгийг биш хамтын зах зээлийн эдийн засагт (**social market economy**) суурилсан үндэсний капитализмыг хөгжүүлжээ.

Үүнийхээ үндсэн дээр Toyota, Sony, Honda зэрэг нийтийн өмчийн хэлбэртэй корпорациудыг байгуулж, түүний үр ашгийг Японы нийт хүн ардын эрүүл мэнд, ажлын байр, боловсрол зэрэгт зориулан ирээдүйг харсан хөгжлийн хөтөлбөрийг маш амжилттай эхлүүлсэн юм. Эдийн засгийн өсөлтөөс олсон орлого нь зөвхөн тухайн үндэстний сайн сайхны төлөө зориулагдах ёстой байдаг гэдгийг маш сайн ойлгож авлига болон хувийн ашиг сонирхлоос хамгаалж чадсан юм.

Япончууд дэлхийн 2-р дайны дараа аж үйлдвэрийн цогцолборуудаа дахин сэргээх, илүү орчин үеийн болгож шинэчлэх ажлыг өрнүүлсэн юм. 1951 онд буюу дайнаас зургаахан жилийн дараа Японы ҮНБ дайны өмнөх түвшиндөө очиж, асар богинохон хугацааны

дотор сэргэсэн байна Японы хөгжлийн бас нэг нууц бол Япон хэл дээр нэгэнт дэлхийн мэдлэг боловсрол байхгүй тул Японы залуу үеийг барууны өндөр хөгжилтэй орнуудад мэдлэг, диплом эзэмшүүлэхээр явуулж, тэдний эзэмшсэн барууны мэдлэг боловсролоор улс орноо хөгжүүлэхэд ашигласан.

Японы эдийн засгийн хөгжил 3 үед хуваагддаг

Эхний үе шат үйлдвэрлэлийн системийг хөгжүүлэх: чулуу, нүүрс, гангийн үйлдвэр, хөлөг онгоц, модон материал зэрэг хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх байсан. Энэ үед ирээдүйн техник, технологи хөгжих эхлэл тавигдаж бүтээгдэхүүний зах зээл хөгжсөн байдаг.

Хоёрдугаар үе шатанд буюу 1960-1970 онд үйлчилгээний салбар, автомашин, цахилгаан хэрэгсэл. Дэлхийн зах зээлд Японы корпорациуд хүч түрэн гарч ирж дэлхийн зах зээлд хамгийн хүчирхэг корпорациудыг бий болгосон.

Гуравдугаар үе шат мэдлэгийн хөгжил дээр суурилдаг. Мэдлэгийн эдийн засаг, инноваци, мэдээллийн технологи, технологийн хөгжил зэргийг хөгжүүлсэн. Япончууд ирээдүйг харсан хөгжлийн бодлогыг баримталж, ирээдүйд ямар мэргэжил, технологи, шинжлэх ухаан хөгжихийг урьдчилан харж тэр чиглэлд боловсон хүчнээ бэлддэг нь дэлхийн хөгжлөөс ямагт түрүүлж явдгийнх нь илрэл юм.

Японы эдийн засаг нь хамтын зах зээлийн эдийн засаг дээр суурилж чадсан нь эдийн засгийн жинхэнэ үсрэнгүй хөгжлийг авчирсан гэж зарим улс дүгнэдэг. Хамтын зах зээлийн эдийн засаг нь нийт улс үндэстнийг нэг ч хүн орхилгүйгээр хангалуун амьдруулах бодлого юм.

Хамтын зах зээлийн эдийн засаг иргэн бүрд, өрх бүрд, компани бүхэнд үр ашгаа өгч чаддаг. Нэг ч уурхайгүй, ордгүй Япон орон дэлхийн хэмжээний аж үйлдвэржсэн, технологичсон, мэдлэгжсэн орон болж хөгжсөн байна.

Япончууд эмх журам сайтай, нэгдмэл санаатай, уялдаа зохицолдоо их сайн байдаг зан чанараараа улс орны эдийн засаг, нийгмийн амьдрал нь бүхэлдээ төрийн ухаалаг зохицуулалттай явж ирсэн юм. Жишээ нь Японд өнөөг хүртэл төрөөс гаргасан удирдлага зохицуулалтын чанартай дүрэм, журам 10 мянга гаруй байдаг байна. Японы ард иргэд ямар ч салбарт аливаа зүйлийг сэтгэн бодох, зохион бүтээх талаар шаргуу хөдөлмөрлөдөг хөдөлмөрч хүмүүс учраас техник технологийг байнга боловсронгуй болгосоор өндөр түвшинд хүргэсэн.

1960-аад оноос эдийн засгийн байдал бэхэжсэнийг харгалзан төрийн онцгой ивээлд байсан хэдэн салбараас бусад олонх салбаруудад гадаадаас дэвшилтэт технологи импортлох явдлыг чөлөөтэй болгожээ. 1945-1980 хүртэл 10000 гаруй лицензийн гэрээ, хэлэлцээр байгуулсан. Ийнхүү гадаадын шинжлэх ухаан-техникийн ололтыг өргөн авч хэрэглэсний дүнд тус улсын бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлт өндөр түвшинд хүрч, дэлхийн зах зээлд дорвитой байр суур эзлэх болжээ. Жишээ нь Японы нийт экспортод шинжлэх ухааны шингэц ихтэй бүтээгдэхүүний хувийн жин 1960 онд 18 хувь байсан бол 1978 онд 40 хувь болж нэмэгдэж байжээ.

Гэхдээ япончууд гадны технологийг шууд ашиглалгүйгээр түүнийг байнга сайжруулан түүнийг анхны хэлбэрээс нь улам боловсронгуй болгодог байжээ. Мөн Япон улс 1960-аад оны дунд үеэс өөрийн ШУ техникийн ололтыг түлхүү экспортлох болсон. Улмаар 1970-аад оны сүүлчээр бүртгүүлсэн патентын тоогоороо дэлхийд өндөр үзүүлэлттэй орнуудын тоонд орж дэлхийн патент, лицензийн 10 орчим хувийг эзэмших болсон байна.

Нийгэмдээ тус болох сэтгэлгээ болон идэвх санаачилга, ажилсаг, бүтээлч зан чанар төлөвшсөн байдаг нь тус улсын эдийн засгийг богино хугацаанд сэргээн өндөр хурдацтай хөгжүүлэх бас нэг хүчин зүйл болсон.

Япон улс нь хэдийгээр зах зээлийн эдийн засагтай орон боловч үндэсний эдийн засгийг удирдахад төрийн үүрэг оролцоо нь юуны өмнө нийт улсын төлөвлөлт, зохицуулалтаар илэрч байдаг.

Япон Улс ирээдүйн хөгжлийн түвшнээ хэрхэн төлөвлөж, төсөөлж байгаа талаар

Япон улс ирээдүйгээ хэрхэн харж төлөвлөж байгаа талаар захиалагчийн өгсөн захиалгын дагуу Японы Ерөнхий сайдын “Японы эдийн засгийн ирээдүй буюу Шинэ өсөлтийн стратеги” хэмээх илтгэлийг тоймлон орчууллаа.

Японы Ерөнхий сайдын илтгэлд дурдсанаар Япон улс “Шинэ өсөлтийн загвар”-т / Japan's New Growth Strategy/ орохын тулд дараах 3 тулгуур буюу суурь зүйлийг хийх шаардлагатай.

1. Нүүрс төрөгч багатай /low carbon/ түлшний хувьсгалаар дэлхийд тэргүүлэх
2. Эрүүл бөгөөд аюулгүй, амгалан тайван, урт наслах нийгмийг бүрдүүлэх
3. Японы сэтгэл татам зүйлсийг бусдад сурталчилж таниулах

Нийтийн болон хувийн хэвслүүдэд хийх эдгээр шийдэмгий арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр бодит ДНБ-ийг 2020 он гэхэд 120 триллионоор өсгөж, 4 сая хүнд ажлын байр бий болгоно гэж төлөвлөж байна.²⁵ Ялангуяа дараагийн 3 жилд 40-60 тэрбум иений эрэлтийг бий болгож 1,4-2 сая хүнд ажлын байр бий болгоно гэсэн зорилт тавин ажиллаж байна.

1) Нүүрс төрөгч багатай түлшний хувьсгалаар дэлхийд тэргүүлэх

Дэлхийн дулаарлыг давах нь 21-р зууны хамгийн том шалгуур болсон. Нүүрстөрөгч багатай түлш нь дээрх асуудлыг шинэ технологи, нийгмийг системийн шинэчлэлээр давах нэг арга юм. Гэр ахуйн хэрэгсэл, машин хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилж шинэчилсэн шиг нүүрстөрөгч багатай түлш нь амьдралын хэв маяг, хотын хөгжлийг шинэчлэх болно гэж тэд үзэж байна. Японы эрчим хүчний үр ашиг нь АНУ-аас 2 дахин, Европынхоос 1,7 дахин их. Тиймээс дээрх шинэчлэлтийг хийх нь дэлхийн хэмжээний эрчим хүч хэмнэх технологийг бүтээхэд үндэс суурь болох ёстой юм. 2020 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээний дахин сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2 дахин буюу дэлхий дээрх хамгийн өндөр түвшин болох 20 хувь хүртэл нэмэгдүүлнэ гэсэн зорилт тавин ажиллаж байна. 2020 он гэхэд нүүрс төрөгч багатай түлшний хувьсгалын талбарт 50 тэрбум иений зах зээл, 1,4 сая хүний ажлын байр бий болгоно хэмээн шинэ өсөлтийн стратегид дурджээ.

- *Дэлхий дээрх номер нэг нарны эрчим хүчтэй улс болох*

2020 он гэхэд нарнаас гаргадаг эрчим хүчийг одоогийнхоос 20 дахин нэмэгдүүлнэ. Нарны эрчим хүчний үе дэлхий даяар тархаж байна. Дараагийн жилүүдэд дэлхийд тэргүүлэгч байр суурийг эзлэх чухал боломж гарч ирж байна гэж үзэж байна. Үүнд хүрэхийн тулд дараах циклд цэг тавих хэрэгтэй:

- Эрэлт дутмагаас зардал өндөр гарах
- Өндөр үнэтэйгээс эрэлт нь зогсонги байдалд орох

²⁵Japan's Future Development Strategy and Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy. Speech of Prime Minister.

Үүн дээр бодлогоор дамжуулж эрэлтийг бий болгох улс төрийн хүчтэй тусламж дэмжлэг шаардлагатай. Электрон компаниуд өрх гэрт цугларсан нарны эрчим хүчийг одоогийнхоос хоёр дахин илүү үнээр худалдан авах шинэ системийг бий болгоно. Дээр нь 3 жилийн дотор улс даяар 36000 нийтийн бага, дунд, ахлах сургуулиудад нарны эрчим хүчний багаж суурилуулж эко эрчим хүчээ ашиглан хүүхдүүдийг сургаж хүмүүжүүлдэг ногоон сургуулиудыг бий болгоно. Эдгээрийн тусламжтай нарны эрчим хүчний системийн зардлыг дараагийн 3-5 жилд S дахин бууруулах зорилт тавьж байна.

- *Эко машиныг өргөн хэрэглээнд оруулсан анхны улс болох*

Япон орон цахилгаан, холимог гэх мэт эко машинуудыг өргөн хэрэглээнд оруулах анхны улс болох болно. Гурван жилийн дотор маш олноор нь үйлдвэрлэж 2020 он гэхэд 2 шинэ машин тутмын 1 машин нь эко байх болно.

Үүний тулд машины татварын хөнгөлөлтүүд хэрэгжиж эхэлсэн. Ирэх жил 1 сая орчим эко машины эрэлт бий болгохоор зорьж ажиллаж байна. Бид байгаль орчны үзүүлэлтэд нь үндэслэж машинаа сонгодог үеийг бий болгоно. Дээр нь 10 хотыг загвар хот болгон сонгон авч ирээдүйн механикжсан нийгмийн дүр зургийг харуулж сурталчлах болно. Олж авсан мэдлэг дээрээ үндэслэн дэлхийн стандартыг бий болгохын тулд бусад орнуудтай хамтарч ажиллах болно. Энэ зорилготой холбоотойгоор 20 сая иенийг эрчим хүч хэмнэх хэрэгслийг худалдан авч буй хүмүүсийг урамшуулахад зарцуулж тараана.

2) Иргэдээ эрүүл аюулгүй, урт удаан наслах нийгмийг бүрдүүлэх

Дэлхийн бусад орнуудаас илүү Японд хөгшрөлт хамгийн хурдацтай явагдаж байна. Хэдий тийм ч Японы настай хүмүүс ажиллах маш их урам зоригтой байдаг. Японд 65-ас дээш насны эрчүүдийн 30 хувь нь ажил эрхэлж байгаа. Харин энэ тоо АНУ-д 20 хувь, Европт 10 хувьтай байдаг. Японы 60-аас дээш насны хүмүүсийн 80 хувиас илүү нь ядаж 70 нас хүртлээ үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байдаг. Хэрвээ сайн эрүүл мэндийн, халамжийн үйлчилгээг бүрдүүлж хангаж чадвал дэлхийд тэргүүлэх насжилт бүхий нийгмийг бүрдүүлж чадна. Дэлхийн бусад орнуудаас түрүүлж эрүүл, урт наслалттай нийгмийг бий болгосноор эрэлтэд чиглэсэн дотоодын үйлдвэржилтийг нэмэгдүүлнэ. Уг салбарт 2020 он гэхэд 35 триллион иений шинэ зах зээл, 2,1 сая хүний ажлын байр бий болгоно.

- *Эмнэлгийн халамж, асрамжийн үйлчилгээнд 300 мянган хүний шинэ ажлын байр бий болгох*

Одоо байгаа 1,3 сая ажилчдыг дараагийн 3 жилд 300,000-аар нэмэгдүүлж 2020 он гэхэд 2,2 сая ажилчидтай болохыг зорино. Маш олон хүмүүс ажлаа алдаж байх үед ч асаргаа сувилгааны салбарт ноцтой хүн хүч дутагдаж байдаг. Одоогийн байдлаар жилийн нөхөн олговор нь бусад салбаруудын дунджаас бага буюу 1 сая иен байдаг. Дээр нь ажлын карьераа өсгөх боломж бага байдаг. Сайн чанартай асаргаа, сувиллын үйлчилгээ үзүүлэхийн тулд энэ ажлын талбарт итгэл найдвар, мөрөөдөл бий болгох хэрэгтэй. Хамгийн түрүүнд энэ салбарын нөхцөл байдлыг яаралтай сайжруулах хэрэгтэй. Үүний тулд сангуудыг өргөжүүлж энэ мөнгийг тус салбарт 3-ас дээш жил ажилласан хүний цалинг өсгөхөд зарцуулна. Дээр нь одоогийн нөхөн олговрын бүтцийг бусад компани, үйлдвэрүүдийнхтэй адил нөхцөл байдлаар цалинг нэмдэг бүтэц рүү шилжүүлж өөрчилнө. Хотжилттой холбоотойгоор үр дүнтэй урт хугацааны асаргаа сувилгааны байгууламжууд дутагдалтай байгаа нь хамгийн том асуудал болж байна. Дараагийн 3 жилийн зорилгынхоо үндсэн дээр урт хугацааны асаргаа сувилгааны төвүүдийг хөгжүүлнэ.

- *Бүсийн эрүүл мэндийн системийг дахин шинэчлэх төлөвлөгөө*

Бүс нутгийн эрүүл мэндийн салбарт эмчийн дутагдал, өвчтөн нэг эмнэлгээс нөгөө рүү шилждэг зэрэг асуудлууд их тулгарч байгаа. Мөн өдөр шөнөгүй, амралтын өдрүүдээр ч ажилладаг эмч, сувилагч нар байна. Энэ нөхцөл байдлыг даван гарч бүс нутгийн эрүүл мэндийн системийг дахин шинэчлэх шаардлагатай байна. Эдгээр асуудлуудыг дан ганц хот, тосгон, эмнэлэг шийдэж чадахгүй. Харин хөрш хот, тосгонуудтайгаа хамтран бүс нутгийн эмнэлгүүд, хувийн эмч нар, урт хугацааны асаргааны төвүүд зэргийг байгуулж иргэдээ нэгдсэн үйлчилгээгээр хангаж ажиллана. Жишээ нь яаралтай тусламжийн үндэс суурийг бүрдүүлэх, эх барих үйлчилгээг хангаж нэг эмнэлгээс нөгөө эмнэлэг рүү өвчтөнүүд шилждэг байдлыг арилгах.

Эхлээд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх бүс нутгуудаа сонгоно. Дараа нь амжилттай болсон загвараа улс даяарх 350 орчим мужуудад 10 жилийн дотор хэрэгжүүлнэ. Энэхүү төлөвлөгөөг 10 жилийн хугацаатай төсөл болгон хэрэгжүүлнэ.

3) Япон орны үзэсгэлэнг сурталчилж таниулах

Япон улс олон жилийн турш хөгжүүлсэн соёл, уламжлал дээрээ үндэслэсэн “soft power”-ийг бий болгосон. Үүнд жуулчдын анхаарлыг татсан үзэсгэлэнтэй, хөдөөгийн байгалийн үзэсгэлэнт газрууд мөн дэлхий нийтийн анхаарлыг татдаг энимэйшн, загварын ертөнц зэрэг соёлын салбарууд нь хамаардаг.

- *Жуулчдыг татсан томоохон улс*

Жуулчдыг ихээр татсан гол улс болохыг зорино. Японд ирэх жуулчдын тоог 20 сая буюу одоогийнхоос хоёр дахин нэмэгдүүлэхийг зорино. Энэ нь 4,3 триллион иений хэрэглэгчийн зах зээлийг үүсгэнэ. Харамсалтай нь дэлхийн хэмжээнд Япон улс жуулчдын тоогоороо 28-т жагсаж байна. Сэтгэл татах зүйлсээ ил гаргаж шаардлагатай бэлтгэл ажлуудыг хангаснаар гадаадын жуулчдын тоо нэмэгдэх нь гарцаагүй. Эхлээд Японд нэвтрэх гарцыг дээшлүүлнэ. Нарита олон улсын нисэх онгоцны буудал дээрх цагаачлалын шалгалтын 28 минутыг хамгийн уртдаа 15 минут болгож хоёр дахин багасгана. Наритагаас Ханеда буудал дахь дотоодын тээвэрлэгчид холбогдох 100 минутын хугацааг 50 минут болгож багасгана. Мөн жуулчдыг татах хотын үзэмжтэй газруудыг сайжруулна. Бид тухайн газар нутгийн ард иргэд нь бахархдаг хотын уламжлалт дурсгалт газруудыг нөхөн сэргээнэ. Японы аль ч газар нутгийг жуулчдыг татсан бүс болгон дахин шинэчлэх бүрэн боломжтой. Утасны шон шугамуудыг багасгаснаар жуулчдынх нь тоо хурдтай өссөн Айзугийн жишээ байна. Дараагийн 3 жилд 30 газрыг аялал жуулчлалын газар болгон сонгон авч утасны шонг багасгах зэрэг үзэмжийг нь сайжруулж сэтгэл татсан хотын дүр төрхийг хөгжүүлж бий болгоно.

Дэлхийн дахины хэрэглэгчдийг татсан компьютер тоглоом, загвар, энимэшн зэрэг зүйлсээр Япон улс асар баялаг билээ. 2020 он гэхэд 20-30 триллион иений томоохон үйлдвэрлэлийг хөгжүүлж 500 мянган хүний ажлын байр шинээр бий болгоно. Интернет болон гар утас зэргийг ашиглан зохион бүтээгчдийн бүтээл, авьяасыг хөгжүүлж бизнес болгох нь чухал. Үүний тулд эзэмших эрхийг худалдан авч борлуулалтын сувгийг хөгжүүлж гадаадад бүтээлээ гаргаж үйлдвэрлэх хөрөнгийг нэгдсэн журмаар хангадаг байгууллага бий болгоно.

Азийн өсөлт - Азийн эдийн засгийг 2 дахин нэмэгдүүлэх санал

Ази бол 21-р зууны хөгжлийн төв. Японы давуу талын нэг бол Ази тивд оршдог явдал юм. Тиймээс Японы шинэ өсөлтийн стратегийн дагуу давуу талаа бүрэн ашиглах нь чухал гэж

үзэж байна. Японы хүн амын өсөлт буурч байгаа. Азийн зах зээл Европ, Хойд Америктай харьцуулахад асар хурдацтай өсч байгаа. Зүүн Азийн хүн ам дангаараа 3,2 тэрбум. Энэ нь бараг дэлхийн хүн амын тал юм. Өнгөрсөн 4 жилд Зүүн Азийн хүн ам бараг Японы хүн амтай адил тоогоор буюу 130 саяар өссөн.

Бүхэлдээ өсч буй Азид хөрөнгө бий болгож тухайн хөрөнгийг эдийн засгийн хамтын ажиллагаа, хоорондын солилцоогоор дамжуулан Япон дахь ажил эрхлэлт, инновацид холбож өгөх нь чухал байна. Энэ нь Азийн ирээдүйн хөгжилд хүргэх болно. Ийм таатай циклийг бий болгох нь маш чухал юм. Дотоод дахь үйлдвэрлэлээ өргөжүүлэх гэж шахахын оронд Япон улс хөрөнгө өсгөх тал дээр анхаарах болно. Өөрөөр хэлбэл ДНБ-ээс Үндэсний нийт орлогыг илүүд үзэх сэтгэхүй рүү шилжүүлэх нь чухал байна.

Азийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах:

Энэ санаачилгыг бодитой болгохын тулд дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- 1) Төмөр зам, замын дэд бүтэц
- 2) Цахилгаан станц, аж үйлдвэрийн парк зэргийг тойрсон дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгтэй
- 3) Үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөгөө
- 4) Санхүүгийн бүтэц
- 5) Гаалийн бүрдүүлэлт зэргийг сайжруулах шаардлагатай.

Зүүн Өмнөд Азийн Нийгэмлэг болон Энэтхэгт 5 жилийн дотор 70 триллион иений эрэлт бүхий дэд бүтэц бий болно гэж үзэж байна. Япон улс эдгээр төсөлд оролцохоос гадна санхүүгийн эх үүсвэрээр дэмжлэг үзүүлж ажиллана. Мөн энэхүү өсөлтийн хажуугаар байгаль орчны асуудлыг мартаж болохгүй ба Японы байгальд ээлтэй технологиудыг ашиглан эдгээр төслүүдийг дэмжин хэрэгжүүлэх болно.

Японы ерөнхий сайдын хэрэгжүүлэхээр зэхэж буй “Japan Revitalization Strategy”-д дурдсанаар ирэх 10 жилд нэрлэсэн ДНБ-ийг 3.0 хувьд, бодит ДНБ-ийг 2.0 хувьд хүргэж, нэг хүнд ногдох бодит үндэсний орлогыг 1.5 сая иенээс багагүй байлгахаар тусгасан байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр

- Олон улс судлал. 2007-2013 он.
- Стратеги судлал сэтгүүл, №54, 2011 он.

Орос хэлээр

- “Концепция долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года” Утверждена распоряжением Правительства РФ от 17 ноября 2008 г. № 1662-р.
- Прогноз долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2030 года. Март, 2013.

- Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 "Об Основах стратегического планирования в РФ".
- Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 "Об Основах стратегического планирования в РФ".
- ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ "О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ".
- ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ "О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ".

Англи хэлээр

- Global finance сэтгүүл. <http://www.gfmag.com/tools/global-database/economic-data/12151-personal-income-tax-rates.html#axzz2jLvIEHH2>
- Japan: Overview of Planning. /www.gdrc.org/uem/observatory/jp-overview.html-
- Japan's Future Development Strategy and Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy. Speech of Prime Minister.
- Korea's Capitalistic Planning Model: Policy Lessons for Mongolia.
- Mancur Olson, 'The rise and Decline of Nations; Economic growth, Stagflation, and Social Rigidities,' in New Haven (Yale University Press, 1982), 44-47.
- Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.
- Securing the Future, хуудас 17, 2005 он, Лондон.
- The Commission on Growth and Development (2008).
- The English Planning System: An Overview, 2011, London.
- Швейцарын тогтвортой хөгжлийн стратеги 2012-2015 /богино хувилбар/
- http://csis.org/files/media/csis/pubs/070712_jcp.pdf
- <http://data.worldbank.org/indicator>
- http://en.wikipedia.org/wiki/Economy_of_China
- http://monua.ucoz.com/news/mnd_solongosyn_srehngj_khgzhlij_n_khchin_zjl/2010-01-26-533
- http://monua.ucoz.com/news/mnd_solongosyn_srehngj_khgzhlij_n_khchin_zjl/2010-01-26-533
- <http://www.gdrc.org/uem/observatory/jp-overview.html>-Global Development Research Centre, 2010
- http://www.kantei.go.jp/foreign/asospeech/2009/04/09speech_e.html
- http://www.kantei.go.jp/foreign/innovation/innovation_final.pdf
- <http://www.linkedin.com/today/post/article/20130630230029-260268111-japan-s-new-growth-strategy-bringing-rapid-reform-to-the-country>
- http://www.meti.go.jp/english/index_policies.html
- <http://www.meti.go.jp/english/statistics/index.html>
- <http://www.mlit.go.jp/kokudokeikaku/zs5-e/part1chap2.html>
- <http://www.swissworld.org/en/economy/>
- <http://www.west.mn/w/tanii-medlegt/medlegiindalai/83-talarhjeene/779-2010-06-11-00-04-05.html>
- <http://www5.cao.go.jp/keizai/index-e.html#pvfpes>

**ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ТАЛААРХ БУСАД ОРНЫ АРГА ТУРШЛАГА**
(Харьцуулсан судалгаа)

Д.Байгалмаа, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

1. Үйлдвэржүүлэлтийн бодлого, төлөвлөлтийн асуудал
 - 1.1. Үйлдвэржүүлэлтийн бодлогын стратеги
 - 1.2. Үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгслүүд /АНУ, Герман, Франц, Японы жишээн дээр/
 - 1.3. Үйлдвэрлэлийн ангилал /жижиг, дунд, том үйлдвэр гэсэн ойлголтыг ямар хүрээнд тодорхойлдог болох/
 - 1.4. Үйлдвэржилтийн эдийн засгийн шалгуур
2. Үйлдвэржүүлэлтийн бодлого төлөвлөлийн түүхэн замнал, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал
 - 2.1. Үйлдвэржүүлэлтийн түүхэн замнал
 - 2.2. Дэлхийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал
3. Гадаад орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагаас
 - 3.1. Чех
 - 3.2. Польш
 - 3.3. Өмнөд Солонгос
 - 3.4. Тайвань
 - 3.5. Сингапур

4. Дүгнэлт

Ашигласан материалын жагсаалт

ОРШИЛ

Судалгааны арга зүй

Үйлдвэржүүлэлтийн бодлого, төлөвлөлтийн асуудал нь зөвхөн үйлдвэр барьж байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах, эсвэл жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх төдий явцуу ойлголт биш, харин эдийн засаг, нийгмийн бүх салбарт үйлдвэрлэлийн арга, технологийн дэвшил нэвтрүүлэх, шинэ мэдлэг эзэмших, хүний нөөцийг хөгжүүлэх өргөн цар хүрээг хамарсан ойлголт бөгөөд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгааны ажлыг гүйцэтгэхдээ интернэтийн эх сурвалжуудаас хайлт хийж олдсон Польш, Чех, Солонгос, Тайвань, Сингапур зэрэг орнуудын туршлагыг харьцуулан судлав.

Судалгааг хийх явцад үйлдвэржсэн улс орнууд нь импортыг хязгаарлах, экспортыг дэмжих бодлогоор үйлдвэрлэлээ өргөжүүлж байсан чиг хандлагад үндэслэн улс орнуудын туршлагыг судлахдаа экспортын бодлого, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг түлхүү тусган харууллаа.

Судалгааны үр дүн

Орчин үед дэлхий ертөнц даяаршиж, шинжлэх ухаан технологийн дэвшил гарахын хэрээр түүхий эдийг илүү гүн боловсруулсан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглүүлэх хандлага ажиглагдаж байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд, улс орнууд нь өөрсдийн онцлогоос хамааран үйлдвэржүүлэлтийн хөгжлийн бодлогоо тодорхойлж ирсэн бөгөөд нийтлэг тал нь жижиг дунд үйлдвэрлэл /ЖДҮ/-ийг дэмжин импорт орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэгцээгээ хангах, хөгжлийн дараагийн үед экспортыг дэмжин техник технологийг хөгжүүлж гадаад зах зээлд гаргахад чиглэсэн бодлогоор өнөөгийн хөгжилд хүрсэн байна. Гэхдээ түүхэн хөгжлийн эдгээр дараалал нь тухайн орны онцлог хэрэгжүүлж буй бодлогоос хамааран хоорондын шилжилтийн хугацаа, стратеги бодлогууд нь өөр өөр, хосолж явагдах, аль нэгийг нь алгасах зэрэг олон хувилбартай байсан бөгөөд бие биенээ үгүйсгэлгүй нягт хамааралтай хөгжиж иржээ.

Хуучин социалист гэх Чех, Польш зэрэг зарим орнууд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн үеэс л аливаа саад бэрхшээлтэй учирч байсан бөгөөд тэдгээрийн зарим нь экспортын чиглэлийг өөрчлөх, хөгжүүлэх үйл явцаа амжилттай хэрэгжүүлж, шинэ зах зээлийг нээж, бүтээгдэхүүний бүтцийг түүхий эд материалаас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болгон өөрчилж, ЖДҮ-ийн нийт экспортод эзлэх хувийг нэмэгдүүлж, экспортыг дэмжих бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлснээр экспорт, ЖДҮ-ийг дэмжих байгууллагын бүтцийг оновчтой бий болгож чадсан байна.

Харин Сингапур, Тайвань зэрэг байгалийн нөөц баялаггүй Азийн орнууд нь хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо эхлээд ЖДҮ-ийг дэмжин импорт орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, дараагийн үе шатанд шинэ техник, технологийн шийдэл бүхий экспортын баримжаатай хөгжлийн стратегийг баримтлахдаа мэдлэгт суурилсан хөгжлийн загварыг бий болгож чаджээ.

Түүнчлэн Солонгос улс нь дээрх загваруудыг үйлдвэржүүлэлтийн бодлогодоо тусгахдаа химийн хүнд үйлдвэрүүдийг судалгаа хөгжил /R&D/-д тулгуурлан хөгжүүлэхэд голлон анхаарч, түлхүү хөгжүүлснээрээ онцлогтой байна.

1. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ

“Үйлдвэржүүлэлт” гэдэг нь зөвхөн үйлдвэр барьж байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах, эсвэл жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх төдий явцуу ойлголт биш, харин эдийн засаг, нийгмийн бүх салбарт үйлдвэрлэлийн арга, технологийн дэвшил нэвтрүүлэх, шинэ мэдлэг эзэмших, хүний нөөцийг хөгжүүлэх өргөн цар хүрээтэй асуудал юм.

Үйлдвэржүүлэлтийн хөгжлийн түүхэнд олон онол, урсгал гарч байсан ч улс орон бүр өөр өөрийн онцлогтой бодлогыг хэрэгжүүлсээр ирсэн. Үйлдвэржүүлэлтийн бодлогын онолын үзэл баримтлал нь импорт орлох үйлдвэржүүлэлтийн бодлогоос экспортын чиг баримжаатай бодлогод шилжих ерөнхий загварын хүрээнд тодорхой шат дараалалтайгаар хэрэгжиж буй боловч түүхэн хөгжлийн эдгээр дараалал нь тухайн орны онцлог, хэрэгжүүлж буй бодлогоосоо хамааран шилжилтийн хугацаа, стратеги нь өөр өөр, хослон явагдах, аль нэгийг нь алгасах зэрэг олон хувилбартай байж болох бөгөөд бие биенээ үгүйсгэлгүй нягт хамааралтай байсаар ирсэн.

Үйлдвэржүүлэлтийн бодлогыг боловсруулахдаа тухайн улс орны нөхцөл байдал, шинжлэх ухааны суурь асуудлууд, бизнесийн гол салбарууд, нөөц баялаг, дунд хугацааны

зорилтууд зэрэг үндэсний эдийн засагт нэн чухал хувь нэмэр оруулах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

1.1. Үйлдвэржүүлэлтийн бодлогын стратеги

Стратеги гэдэг нь хэтийн төлөвт хүрэх арга замаа тодорхойлох буюу үйлдвэржүүлэлтийн хувьд улс төр, эдийн засаг, байгалийн баялаг, нийгэм, оюун санааны бүх системийг уялдуулж төлөвлөх явдал юм. Өөрөөр хэлбэл, бүхэлд нь системтэйгээр харж, төлөвлөж стратегиа гаргана гэсэн үг юм. Үйлдвэржүүлэлтийн бодлогын хүрээнд баримталдаг доорх нийтлэг стратегиуд байна. Үүнд:

- Импортыг орлуулах, экспортод чиглэсэн стратеги
- Өөрийн байгалийн эрдэс баялаг, нөөцийг гүн боловсруулах стратеги
- Хамтын ажиллагаа, түншлэлийн стратеги
- Төлөвлөлтийн стратеги
- Нээлттэй хаалганы стратеги
- Картелийн бүлэглэлийн стратеги
- ЖДҮ-ийг хөгжүүлэх стратеги гэх мэт.

Импортыг орлуулах, экспортод чиглэсэн стратеги: Импортыг орлуулах бодлого нь Засгийн газраас тариф, тоо хэмжээний хязгаарлалтын аргаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжих явдал юм. Үйлдвэржүүлэлтийн хөгжлийн стратеги нь үндсэндээ дотоодын зах зээлд зориулж үйлдвэрлэл явуулах /импортыг орлуулах/ эсвэл гадаад зах зээлд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх /экспортод чиглэсэн/ гэсэн 2 сонголтыг хийдэг. Хөгжиж байгаа улс орнуудын үйлдвэржүүлэлтийн үндсэн стратеги нь импортыг орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Харин энэ бодлогыг амжилттай хэрэгжүүлсний дараа экспортод чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг байна.

Энэ стратегитай холбоотой үйлдвэржүүлэлтийн үе шатууд:

Хүснэгт 1.

Үе шат	Тухайн үе шатанд үр дүнтэй хамрагдаж чадсан улс орнууд	Шалгуур үзүүлэлт
1. Импортыг орлуулах үйлдвэржүүлэлтийн үе шат	Бразил, Мексик, Аргентин, Малайз, Индонез, Тайланд, Турк, Энэтхэг, Пакистан	ДНБ-д импортын эзлэх хувийн жингийн буурах өөрчлөлт /импортын коэффициент/
2. Экспортод чиглэсэн үйлдвэржүүлэлтийн үе шат	Хонгконг, Сингапур, Тайвань, Өмнөд Солонгос	ДНБ-д экспортын эзлэх хувийн жингийн өсөх өөрчлөлт /экспортын коэффициент/

Өөрийн орны байгалийн эрдэс баялаг, нөөцийг гүн боловсруулах стратеги: Байгалийн эрдэс баялгийн нөөц ихтэй улс орнууд эдгээр нөөцөө гүн боловсруулж, нэмүү өртөгтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал чухал юм. Ингэхдээ эцсийн бүтээгдэхүүнийг гүн боловсруулах үр чадвар, үйлдвэрлэлийн ноу-хауг эзэмшсэн байх шаардлага урган гарна. Хөгжингүй орнуудын хувьд үндэстэн дамнасан корпорациуд нь олон жилийн хугацаанд оршин тогтнохдоо илүү туршлагажихын хэрээр өөрийн маркетингийн, борлуулалтын сувгуудтай байх, тээвэрлэлт, хуваарилалтын сувгуудыг эзэмших зэргээр үйл ажиллагаа нь улам нарийсч мэргэшсэн байдаг. Харин хөгжиж байгаа орнуудын хувьд донор улс орнуудын худалдааны хориг саадыг бууруулах, борлуулалтыг нэмэгдүүлэхийг чармайдаг боловч өрсөлдөөнд сөрөн зогсох, даван туулах чадвар сул, орлого бага байх нь тухайн улсаас баримталсан стратеги бодлого хэрэгжихгүй байх хандлага ажиглагддаг. Иймээс хөгжиж байгаа орнуудын үйлдвэржүүлэлтийн бодлогод дэмжлэг, зөвлөмж үзүүлэх шаардлагатай.

Үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа, түншлэлийн стратеги: Бага болон дунд орлоготой улс орнуудын зах зээл бага байдаг учраас хөгжингүй орнуудын зах зээлд нэвтрэхийг оролддог боловч энэ нь хязгаарлалттай байдаг. Нөгөө талаас бүтээгдэхүүн нь сонирхол татахуйц байж чаддаггүй байна. Эдгээр орнууд зах зээлээ өргөжүүлж өрсөлдөхийн тулд өөр хоорондоо чөлөөт худалдааны гэрээ байгуулах, эдийн засгийн блог үүсгэх зэргээр хамтын ажиллагаа, түншлэлийн стратегийг баримталдаг.

Төлөвлөлтийн стратеги: Төлөвлөлтийн зорилго нь үйлдвэрлэлийн хүчин зүйлийг хамгийн үр ашигтай ашиглахын тулд хэрэгжүүлж байгаа зохион байгуулалт, эдийн засгийн бусад арга хэмжээний цогц юм. Гадна орчны өөрчлөлтийг урьдчилан харах, гарч болзошгүй асуудлыг илрүүлж тодорхойлох, эдийн засгийн өмнөө тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг тоо болон чанарын үзүүлэлтээр хангах, үйл ажиллагааг зохион байгуулах, хянах зэрэг нь төлөвлөлтийн стратегийн гол асуудал юм. Иймээс зах зээлийн төлөвлөлтийн онол арга зүйг эзэмших, зөв хэрэгжүүлэх асуудал чухал байсаар байна.

Нээлттэй хаалганы стратеги: Энэ стратегийн зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх явдал юм. Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн, экспортыг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, технологийн дэвшилд түлхэц өгөх зорилгоор экспортын чөлөөт бүсийг байгуулсан. Гадаадын хөрөнгө оруулалтын бодлого нь шинээр бий болоод удаагүй байгаа зээлийг идэвхтэй татан оролцуулах, гадаад өрийн ачааллыг багасгах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг чөлөөлөх, дэвшилтэт технологитой хөрөнгө оруулалтад татвараас чөлөөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалтын салбарыг нээлттэй болгох зэрэг аль болох таатай орчныг бүрдүүлж, гаднаас дотоод руу орох хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байдаг.

Картелийн бүлэглэлийн стратеги: 1972 онд газрын тос экспортлогч орнуудын бүлэглэлүүд нь өндөр хөгжилтэй орнуудын эдийн засагт нөлөө бүхий шийдвэрүүдийг гаргаж байсан. Эдгээр орнууд нь газрын тосны үнийг тогтоох, үйлдвэрлэл, хуваарилалтын сувгийг хянах зэргээр харилцан тохиролцож, олигополийн шинж чанартай бодлого явуулж байсан. Дэлхийн бүтээгдэхүүний зах зээлийн ихэнх хувийг эзэлдэг, орлуулах боломжгүй эрдэс /зэс, цагаан тугалга, фосфат гэх мэт/, түүхий эд үйлдвэрлэдэг улс орнуудын хувьд уг стратегийг баримтлах боломжтой.

ЖДҮ-ийг хөгжүүлэх стратеги: Жижиг үйлдвэрүүдийн шинэ санаачилга аж үйлдвэрийн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэж, ДНБ-ий хэмжээнд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Томоохон үйлдвэрүүд жижиг бизнесээс гарсан шинэ санааг худалдан авах хандлага нэлээд байна. Жижиг үйлдвэрүүд нь том үйлдвэрүүдийг бодвол хэрэглэгчийн эрэлтийг түргэн мэдэрдэг, зах зээлд хурдан зохицох, технологийн арга барилаа өөрчлөх чадвартай учраас эдийн засгийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлж байна.

1.2. Үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгслүүд

Үйлдвэржүүлэлтийн стратегийг хэрэгжүүлэхэд дунд, богино хугацааны зорилго, зорилтуудыг тавьж, түүнд хүрэхэд ямар бодлогын хэрэгслүүдийг ашиглах вэ гэдэг нь чухал юм. Үйлдвэрлэлээр тэргүүлэгч зарим орнуудын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тавьсан зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэхэд ашигласан бодлогын арга хэрэгслүүдийг доорх хүснэгтээр харьцуулан харуулав.

Хүснэгт 2.

	АНУ	Баруун Герман	Франц	Япон
Гол зорилго, зорилтууд	-өрсөлдөөн бий болгох; -технологийг хөгжүүлэх; -дампуурал хохирлын системээс урьдчилан сэргийлэх; -импортыг хязгаарлах	-шинэ технологийг дэмжих; -уналтад орж байгаа үйлдвэрүүдийг дэмжих, зохицуулалтаар хамгаалах	-“ирээдүйн үйлдвэрлэгч”-ийг хөгжүүлэх; -олон улсын өрсөлдөх чадварыг гүйцэх; -зохицуулалтаар дэмжих; -үндэсний аваргыг төрүүлэх	-судалгаа шинжилгээнд тулгуурласан технологийг хөгжүүлэх; -зохицуулалтаар дэмжих
Үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хэрэгслүүд				
Зээлийн бодлого	Үйлдвэрийн газрууд нь хувийн банк, хувийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, бонд, хамтын хөрөнгө оруулалтаар санхүүждэг. Онцгой тохиолдолд /хямралын нөхцөлд/ Засгийн газраас баталгааг гаргаж өгдөг.	Ихэнх үйлдвэрүүд зөвхөн тоног төхөөрөмж суурилуулахдаа томоохон хувийн банкаас санхүүждэг. Засгийн газар нь экспортын зээл олгох болон шинээр хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмждэг.	Шууд санхүүжилтийг 1980-аад оны эхэн үеэс илүү өргөн хэрэглэж байна. Засгийн газрын эзэмшдэг болон хяналтад байдаг банкуудаар дамжуулан үйлдвэрийн газруудыг үнэт цаас, бонд гаргахад нь зээл олгодог. Нэмэлтээр гаргах бондууд нь онцгой бодлогын ач холбогдолтой байдаг.	Үйлдвэрийн ихэнх хөрөнгө нь групп банкуудаас санхүүждэг. 1960-1980-аад оны хооронд үйлдвэрүүд нь Японы Хөгжлийн банкаас санхүүждэг байсан. 1980-аад оныг хүртэл капиталын зардал дэлхийн түвшнээс доогуур байсан ба хадгаламжийг хамгаалах олон төрлийн бодлого явуулснаар санхүүгийн секторт орох урсгалыг багасгаж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. Японы төв банкнаас банкуудыг “цонхны удирдлага”-аар чиглүүлэх бодлого барьдаг.
Татвар, татаас	Хурдацтай хэрэгжүүлсэн татварын хөнгөлөлтүүд нь 1980-аад оноос хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн. Харин сүүлийн үед шинэ хөрөнгө оруулалтын ашгийн татвар болон цалин хөлсөнд ноогдуулах татварын хөнгөлөлтийг бууруулсан.	Онцгой татварыг ашиглахдаа нүүрс, ган зэрэг буурч байгаа үйлдвэрлэлийг дэмжих эрчим хүчний бодлого, бүсийн бодлогын хэрэгсэл болгон ашигладаг.	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, компаниудыг нэгтгэхэд төрөл бүрийн татварын хөнгөлөлтүүдийг ашигладаг. Мөн Судалгаа, хөгжлийн салбарт томоохон татварын хөнгөлөлтүүд эдлүүлдэг. Улсын үйлдвэрийн газруудад татаас өгдөг.	1970-аад оноос өмнө татварын хөнгөлөлт байсан хэдий ч ганцаарчилсан, ялгаатай хөнгөлөлт эдлүүлдэг байсан бол 1970 оны дунд үеэс хойш татварын хөнгөлөлтийн хувь хэмжээ харьцангуй тэгш, нийтээр үйлчилдэг болсон.

Хамгаалалт, зохицуулалт	Демпинг, татаасын хуулийн 301 заалт нь бусад орнуудтай "сайн дурын экспорт хязгаарлах хэлэлцээ" /VERs/ хийхэд хөшүүрэг болдог. Зарим уналтанд орж байгаа үйлдвэрлэлийг квотоор болон VERs-ээр хамгаалдаг.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, сүлжмэлийн үйлдвэрлэл, уул уурхай зэрэг бодлогын чухал секторуудаас гадна уналтанд орж байгаа үйлдвэрлэлд төрөөс зохицуулалт хийдэг.	Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг /ЕЕС/-ээс тариф, квотыг тогтоодог боловч онцгой нөхцөлд стратегийн ач холбогдолтой гэж үзсэн өндөр технологи, шийдэл бүхий гадаадын хөрөнгө оруулалтыг оруулахдаа хамгаалалтын хэрэгслийг ашигладаг.	Албан ёсны хориг саад багатай. Импортыг бууруулах бодлого баримтлахдаа шууд биш хориг арга хэмжээг авдаг. Нийлүүлэлтийн системийг дэмждэг. Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарладаг.
Өрсөлдөөний бодлого	1980-аад оны эхэн үе хүртэл монополийн эсрэг бодлогыг хүчтэй явуулж эхэлсэн. Тус бодлого нь илүү хүлээн зөвшөөрөгдснөөр монополийн эсрэг чөлөөлөлт нь үр ашигтай болсон.	Өрсөлдөөний бодлогыг 1950-аад оны эхэн үеэс хүчтэй явуулсан. 1970-аад оноос уналтанд орж байгаа болон нэгдэж байгаа компани, үйлдвэрийн газруудад дэмжлэг үзүүлдэг болсон.	"Үндэсний аварга" үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор 1960 оны дунд үеэс 1980-аад оны эхэн үе хүртэл компаниудын нэгдлийг дэмжих бодлого барьсан.	1970-аад оны дунд үе хүртэл компаниудын нэгдлийг дэмждэг байсан. Монополийн эсрэг бодлого нь сул дорой; дотоодын зах зээлд үйлдвэрлэгчийн санал болгож буй харьцангуй өндөр үнээр зах зээлийн ханш тогтдог. Үгсэн хуивалддаг энэхүү үйл ажиллагаа нь бусад үйлдвэрлэгчдийг уналтанд оруулдаг.
Шинжлэх ухаан технологи	Томоохон судалгаа шинжилгээ, ололтуудыг Батлан хамгаалах яамнаас санхүүжүүлдэг ба Засгийн газрыг цэргийн бус хэрэглээнд фонд зарцуулахыг хориглодог.	Засгийн газрын санаачлагаар хийгдэж байгаа судалгаа шинжилгээ, мөн улсаас татварын хөнгөлөлт эдэлдэг Судалгаа хөгжлийн байгууллагуудын үйлдвэрлэлийн судалгаа, шинжилгээнд төрөөс томоохон дэмжлэг үзүүлдэг.	"Ирээдүйн үйлдвэрлэгч" нь тусгайлсан онцгой үйлдвэрлэгчдийг тодорхойлдог. Үйлдвэрлэлийн бодлого, судалгаа хөгжлийг улам сайжруулах, зохицуулалтанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Судалгааны яам /Ministry of Research/ -ыг Аж үйлдвэрийн яам /Ministry of Industry/ руу нэгтгэсэн.	Тус улсын Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам /MITI /- аас ивээн тэтгэсэн хамтын үйлдвэрлэлийн судалгааны төслүүд нь аж үйлдвэрийн чухал салбаруудын өрөлдөх чадварын гол дэвшил шинэчлэлтэй холбож өгдөг.

Засгийн газрын оролцоо	Үйлдвэрлэлийн эрэлттэй өндөр технологийг нэвтрүүлэхэд Засгийн газар оролцох ба Батлан хамгаалалтын худалдан авах ажиллагааны газар /DOD/ нь гол зохицуулалтыг хийдэг.	1990-ээд онд уналтад орж байсан аж үйлдвэрийн хэд хэдэн үйлдвэрийн фирмүүдийг томоохон фирмүүдийг эзэмшилдээ авсан. Засгийн Газрын оролцоо нь дотоодын бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмждэг.	Дотоодын үйлдвэрлэгчдийг худалдан авалтаар дэмждэг. Өмч хувьчлалыг идэвхитэй явуулж байгаа.	Бусад орнуудтай харьцуулахад төрийн өмчлөлтэй үйлдвэрүүд харьцангуй бага. Засгийн газрын оролцоо нь дотоодын үйлдвэрлэгчдийг худалдан авалтаар дэмждэг.
Хэрэгжүүлэгч институт	Батлан хамгаалах яам /Department of Defence/, Худалдааны төлөөлөгч газар болон бусад худалдааны чиглэлийн агентууд, тусгай хууль сахиулах байгууллага болон Ерөнхийлөгчийн зөвлөлүүд	Эдийн засгийн яам, засгийн газар-бизнесийн төлөөлөгчдийн "concertation" зөвлөл	Үйлдвэр, төлөвлөлтийн яам, эдийн засгийн хэмжээгээр болон хэсэгчилсэн төлөвлөлт, төрийн эзэмшлийн банк, байгууллагууд.	Олон улсын худалдаа, үйлдвэрийн яам, "visions" бизнес-засгийн газар-төрийн секторын төлөөлөгчийн газар



1.3. Үйлдвэрлэлийн ангилал /жижиг дунд том үйлдвэр гэсэн ойлголтыг ямар хүрээнд тодорхойлдог болох/

Дэлхийн улс орнууд өөрийн орны эдийн засгийн хөгжлийн түвшин, зах зээлийн багтаамж, бизнес дэх төрийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн байдал, төсөв мөнгөний бодлогоос хамаарч үйлдвэрлэлийн байгууллагыг өөр өөрөөр тодорхойлж ангилдаг. Ихэвчлэн дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж байна. Үүнд:

1. Ажиллагсдын тоо
2. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хэмжээ
3. Нийт борлуулалтын орлого
4. Үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн тоо
5. Үйлдвэрлэлд зарцуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ гэх мэт.

Дээрх шалгуур үзүүлэлтээс хамгийн өргөн хэрэглэгддэг, тооцоход хялбар үзүүлэлтүүд нь аж ахуйн нэгжид ажиллагсдын тоо, борлуулалтын нийт орлого юм. Эдгээрээс ажиллагсдын тооны үзүүлэлт түгээмэл хэрэглэгдэж байгаа бөгөөд улс орнуудын үйлдвэрлэл бизнесийн ангилал харилцан адилгүй байна. (3-р хүснэгт).

Жилийн дотор зохион байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрч, 18 сарын дотор хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн төлж ашигтай ажиллаж байгаа үйлдвэрлэлийг ихэнх оронд жижиг үйлдвэрлэл гэж үздэг байна. Үйлдвэрлэлийг жижиг дунд том хэмээх шалгуур үзүүлэлтээр тооцдог олон улсын байгууллага ба зарим орнуудыг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Дэлхийн зарим улс орнуудад үйлдвэрлэлийг ангилж тодорхойлсон байдал

№	Улс орнууд	Үйлдвэрлэлийн ангилал
1	Олон улсын хөдөлмөрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • 1-9 ажилчидтайг жижиг, • 10-50 хүртэлх ажилчидтайг дунд, • 50-аас дээш ажилчидтайг том,
2	Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн нийгэмлэг	<ul style="list-style-type: none"> • 19 хүртэлх ажилчидтайг хэт жижиг, • 99 хүртэлх ажилчидтайг жижиг, • 100-499 хүртэлх ажилчидтайг дунд, • 500-аас дээш ажилчидтай бол том,
3	АНУ	<ul style="list-style-type: none"> • 500 хүртэлх ажилчидтайг,
4	Англи	<ul style="list-style-type: none"> • 24 хүртэлх ажилчидтайг жижиг, • 25-200 хүртэлх ажилчидтайг дунд, • 200-аас дээш том
5	Герман	<ul style="list-style-type: none"> • 49 хүртэлх ажилчидтайг жижиг, • 50-499 хүртэлх ажилчидтайг дунд,
6	Сингапур	<ul style="list-style-type: none"> • 100 хүртэлх ажилчидтайг,
7	Франц	<ul style="list-style-type: none"> • 1-9 хүртэлх ажилчидтайг өрхийн аж ахуй, • 10-50 хүртэлх ажилчидтайг жижиг, • 51-500 бол дунд, • 500-аас дээш том
8	Болгар	<ul style="list-style-type: none"> • 50 хүртэлх ажилчидтайг жижиг, • 50-200 хүртэлх ажилчидтайг дунд,
9	Индонез	<p>Жижиг үйлдвэр:</p> <ul style="list-style-type: none"> • 0-4 ажилчидтайг доод шатны • 5-19 ажилчидтайг дунд шатны • 20-99 ажилчидтайг дээд шатны

10	Филиппин	<ul style="list-style-type: none"> • 1-9 ажилчидтайг гар ажиллагаатай жижиг үйлдвэр • 10-99 хүртэлх ажилчидтайг жижиг, • 100-199 хүртэлх ажилчидтайг дунд,
11	Швед	<ul style="list-style-type: none"> • 200 хүртэлх ажиллагсадтайг жижиг дунд

Дэлхийн банкнаас олон улсад жижиг бизнесийг тодорхойлохдоо: үндсэн хөрөнгө нь 20.0 ам. доллар 1-19 ажилчидтай бол микро, үндсэн хөрөнгө нь 100.0 мянган ам доллар 20-99 ажилчидтайг жижиг, 100-аас дээш ажиллагсадтай, 2000.0 мянган ам долларын үндсэн хөрөнгөтэй бол дунд үйлдвэрлэл хэмээн тодорхойлсон байна.

Хүснэгт 4. Ажиллагсдын тооноос хамааруулан үйлдвэрлэлийг ангилсан байдал

Улс орон	Үйлдвэрийн газрын ангилал, ажилчдын тоогоор			
	Бичил	Жижиг	Дунд	Том
Сингапур	1-9	10-19	20-199	200<
Хятад	1-9	10-99	100-299	300<
Япон	1-9	10-49	50-499	500<
ОХУ	1-29	30-99	100-199	200<
Солонгос	1-19	20-99	100-499	500<
Испани	1-9	10-19	20-199	200-299
Турк	1-19	20-99	100-499	500<
Герман	1-9	10-49	50-499	500-аас дээш
Итали	1-19	20-99	100-499	500<
Франц	1-19	20-99	100-499	500<

Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн ангиллыг үйл ажиллагааны төрөл, ажиллагсдын тоогоор ангилсан байдал

Улс орон	Жижиг дунд үйлдвэрийг тодорхойлсон байдал	
ОХУ	Аж үйлдвэр, барилга, тээврийн салбар	100 хүртэлх ажиллагсадтай
	ХАА-н салбар	60 хүртэлх ажиллагсадтай
	Шинжлэх ухаан техникийн салбар	60 хүртэлх ажиллагсадтай
	Бөөний худалдааны салбар	50 хүртэлх ажиллагсадтай
	Жижиглэн худалдааны ба ахуйн үйлчилгээний салбар	30 хүртэлх ажиллагсадтай
	Бусад	50 хүртэлх ажиллагсадтай
Солонгос	Уул, уурхай аж үйлдвэр тээвэр	300 хүртэлх ажиллагсадтай
	Барилга	200 хүртэлх ажиллагсадтай
	Худалдаа болон бусад үйлчилгээ	20 хүртэлх ажиллагсадтай
Япон	Аж үйлдвэр	300 хүртэлх ажиллагсадтай
	Бөөний худалдаа	100 хүртэлх ажиллагсадтай
	Жижиглэн худалдаа	50 хүртэлх ажиллагсадтай

1.4. Үйлдвэржилтийн эдийн засгийн шалгуур

Олон улсын судалгааны байгууллагуудаас дэлхийн улс орнуудыг аж үйлдвэржсэн байдлаар нь хөгжингүй /developed/ буюу аж үйлдвэржсэн орон /industrialized countries/, хөгжиж байгаа орон /developing and emerging industrial economies, newly industrializing country/ зэргээр ангилан хуваадаг. Аж үйлдвэржилтийн хөгжлийн харьцуулсан түвшнүүдийг хэмжих нь түвэгтэй байдаг бөгөөд статистикийн аргаар нэг улс нөгөөгөө бодвол илүү хөгжсөн болон үйлдвэрлэлийн стандартын өсөлтийн түвшний ялгааг тайлбарлах, нэг нь нөгөө улстай харьцуулахад хэд дахин эсвэл хэдээр илүү хөгжсөнийг гаргах зэрэг боломжтой болдог.

Шинээр аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох хэд хэдэн аргуудыг харьцуулсан хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6.

№	Арга	Шалгуур үзүүлэлтүүд	Шалгуурыг хангасан орнууд
1	Tuner /1982/ RIIA	Дэлхийн худалдаанд оролцож буй боловсруулах үйлдвэрлэлийн салбарын оролцоо	Солонгос, Тайвань, Хонгконг, Сингапур, Бразил, Мексик, Аргентин, Энэтхэг
2	Ballassa /1980/	ДНБ-ий 1 хүнд ноогдох орлого \$ 1100-с дээш, Боловсруулах салбарын эзлэх хувь 20%-с дээш	Дундаас дээш орлоготой орнууд
3	OECD /1979/ ЭЗХАХБ	1. Нийт ажил эрхлэлтэнд аж үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь, түвшин хурдацтай өсөлттэй, 2. Дэлхийн аж үйлдвэрийн салбарын экспортод эзлэх хувь өсч байгаа 3. Нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлт хурдацтай	Испани, Португал, Грек, Югослав, Бразил, Мексик, Хонгконг, Солонгос, Сингапур, Тайвань
4	UNDP /1990/	Хүний хөгжлийн индекс /0-1 хүртэл үнэлгээтэй/. Худалдан авах чадвар + амьдралын түвшин+бичиг үсэг тайлалт	
5	Түүвэр статистикийн аргын тооцоолол	1. Хадгаламжийн түвшин 15%-с дээш байх 2. Нэг хүнд ноогдох ДНБ \$1000-с дээш байх 3. ДНБ болон нийт ажил эрхлэлтэд боловсруулах салбарын эзлэх хувь 20%-с дээш байх 4. Хүний хөгжлийн индекс 0,75-аас дээш байх	Нийт 22 орон уг жагсаалтад багтсан.

Дээрх шалгууруудаас түүвэр статистик аргын тооцооллоор жагсаалтыг тэргүүлэгч орнууд нь Азийн орнууд байсан ба тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг тухайн үе /1988 он/- ийн байдлаар харуулав.

Хүснэгт 7.

Улс	Дотоодын нийт хадгаламжийн хувь	Нэг хүнд ноогдох ДНБ /\$/	Боловсруулах салбарын эзлэх хувь	Хүний хөгжлийн индекс
Тайвань	99	4,960	39	0.920
Сингапур	41	9,070	30	0.899
Хонг-Конг	33	9,200	22	0.936
Өмнөд Солонгос	38	3,600	32	0.903
Тайланд	34	1,000	24	0.783
Малайз	36	1,940	23	0.800

Эдгээр Зүүн өмнөд Азийн орнуудын хөгжлийн суурь түвшин нь маш эрчимтэй өссөн бөгөөд өнөөдөр дэлхийн хөгжлийн хамгийн эрчимтэй хөгжиж байгаа бүс болж чадсан байна.

Шинээр үйлдвэржсэн орнуудын төстэй талууд

Нийтлэг төстэй талууд	Үйлдвэржүүлэлтийн онцлогоор	Хэрэгжүүлсэн арга хэмжээгээр
1950-аад оны үед колончлолоос чөлөөлөгдсөн. 1960-аад оны үеэс үйлдвэржиж эхэлсэн Колончлолд байсан учраас тухайн орны туршлага, соёлоос нэвтрүүлсэн. Эрдэс түүхий эдийн нөөц хомс, далайн харилцаа хөгжсөн	Аж үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ, үр ашиг дээшилж, дотоодын хуримтлал их болсон. Хүнд үйлдвэрлэл давамгайлж дэлхийн стандартын түвшинд хүрсэн. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг тэтгэн дэмжсэний зэрэгцээ импортыг орлуулах бодлого баримталсны үр дүнд дотоод зах зээлийн багтаамжаа нэмэгдүүлсэн. Гадаад орнуудтай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлж, хүн ам зүйн болон нийгмийн хүрээний хөгжилд эерэг нөлөөлж, түлхэц үзүүлсэн.	Аж үйлдвэрийн салбаруудаас боловсруулах салбарыг хөгжүүлэхэд голлож анхаарсан. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ гадаад болон дотоодод аль болох түргэн борлогдох таваарын эрэлт хэрэгцээний байдалд тохируулсан.

2. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ТӨЛӨВШЛИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Үйлдвэржүүлэлтийн түүхэн замнал

Одоогоос 260-аад жилийн тэртээ дэлхийн аж үйлдвэрлэлийн төв нь Ази байжээ. Тэр үед дэлхийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 33 хувийг Хятад, 25 хувийг Энэтхэг улс хийж байсан байна. Гэтэл Англид аж үйлдвэрийн хувьсгал өрнөж, 1760-аад оноос тэргүүлсэн зуу орчим жилийн хугацаанд дэлхийн аж үйлдвэрлэлд эзлэх Английн жин 2 хувиас 23 хувь болтлоо буюу арав гаруй дахин нэмэгдсэн байна. Эдийн засгийн энэ өрсөлдөөнд Азийн уламжлалт аж үйлдвэр ялагдан сүйрч дэлхийн үйлдвэрлэлд нөлөөгөө алдан Хятадын эзлэх жин 4 хувь, Энэтхэгийнх 1 хувь болтлоо унаж, тэд дэлхийн аж үйлдвэрийн гол төвөөс дорой буурай хөгжилтэй улсууд болон хувирсан түүхтэй.

Үйлдвэрлэлээр тэргүүлэгч Англи улстай өрсөлдөн Европын бусад улс болон АНУ нь 1938 он гэхэд тэргүүн эгнээнд гарч чаджээ. Энэ үед АНУ-ын эзлэх хувь 33, эх газрын Европынх 24 хувь болсон бол Английнх 13 хувь болж буурсан байна. Эдгээр улс нь Английг гүйцэхийн тулд эдийн засгийн Хөгжлийн Стандарт Загварыг авч хэрэгжүүлжээ.

Хөгжлийн Стандарт загвар гэж юу вэ?

Хөгжлийн Стандарт Загвар /ХСЗ/ нь дөрвөн хэсгээс бүрддэг бөгөөд эдгээр нь:

1. Төмөр замын сүлжээ, бусад дэд бүтцийг хөгжүүлэх замаар үндэсний хэмжээний зах зээлийг бий болгох,
2. Дотоодын аж үйлдвэрийг татвар, тарифийн хүчээр хамгаалах,
3. Үндэсний банкуудыг хөгжүүлэн мөнгөний бодлогыг тогтвортой байлгах, том төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх,
4. Бүх нийтийн боловсрол, тэр дундаа ажилчдын мэдлэг боловсролыг тухайн үеийн эрэлт шаардлагад хүргэх бодлого юм.

Хөгжлийн энэ загварыг бүрэн хэрэгжүүлж чадсанаар АНУ болон Европын бусад улсууд дэлхийн тэргүүний хөгжилтэй улс болон бусдаасаа тасарч өнөөдрийг хүртэл тэргүүлсэн хэвээр байна. Өөрөөр хэлбэл, эдгээр улсын эдийн засаг 1820 оноос өнөөг хүртэл 17-25 дахин өссөн хэрэг юм. Эдгээр улсын нэг хүнд ногдох жилийн дундаж орлого нь 30,000-40,000 ам. доллартай тэнцэж байгаа бол Ази болон Латин Америкийн олонх орны энэ үзүүлэлт 5,000-10,000 ам. долларт эргэлдэж байна. Энэ нь 4-6 дахин доогуур байгааг харуулна.

1850-аад оны сүүлээс эхлэн Европ болон АНУ-ын араас Орос, Япон зэрэг улсууд дээрх загварыг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлж, Орос Улс 1913 он гэхэд 71,000 км төмөр зам тавьж дотоод, гадаад зах зээлээ холбон, жилд 4 сая тонн төмөр үйлдвэрлэж ДНБ-д хүнд аж үйлдвэрийн эзлэх жин 1885 онд 2 хувь байсныг 1913 онд 8 хувь болтол нь өсгөж чаджээ.

Япон улс 1867 оноос 1940 он хүртэл Мэйжигийн болон Эзэн хааны үеүдийг дамжуулан энэ загварыг хэрэгжүүлж эхэлжээ. Бүх нийтийг боловсролтой болгосон нь тэргүүний технологи эзэмшихэд нь нэн тустай байсан байна. Япончууд барууны технологийг өөрийн нөхцөлд тохируулан загварыг шинэчлэн өөрчилж хэрэглэх явдал асар их түгээмэл болж түүнийгээ “Сува арга” гэж нэрлэдэг байсан нь япончлох арга юм. Энэ үед Японд суурь үйлдвэр, төмөрлөгийн болон гангийн, химийн зэрэг аж үйлдвэрүүд байгуулагдан хүнд аж үйлдвэрийн ДНБ-д эзлэх жин бараг хоёр дахин өссөн байна. Тэдгээр орнууд улс орныхоо ерөнхий хөгжлийг нэмэгдүүлж чадсан боловч үйлдвэрлэл өндөр хөгжсөн улсуудыг гүйцэж чадаагүй тул хөгжлийн өөр загварыг хайхад хүрчээ. Энэ үед Хөгжлийн Стандарт Загвар өөрийн боломжийг үндсэндээ шавхсан гэж үзэж болох ч энэ загвар нь цаашид эрчимтэй хөгжих суурь үндсийг бүрдүүлж өгдөг тул хөгжлөөр доогуур улс үүнийг ашиглах нь зүйтэй гэж зарим эрдэмтэд үздэг.


Үйлдвэрлэл өндөр хөгжсөн улсуудыг Зөвлөлт Холбоот Улс /ЗХУ/ эхэлж гүйцэж ирсэн боловч сүүлдээ задран унасан байна. Харин Азийн орнуудаас Япон, БНСУ, Тайвань болон Азийн бусад улс гүйцэж, зарим нь гүйцэхэд ойрхон ирсэн бөгөөд одоо БНХАУ-д үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байна. Дээрх орнууд нь хөгжлийн асар их ялгааг 50-60 жилийн түүхэн богино хугацаанд яаж, ямар загвараар хөгжин гүйцэв? гэдэг асуулт гарна. Эрдэмтэд хөгжлийн олон янзын загваруудыг боловсруулан гарган тавьж ирсэн боловч бодит амьдрал дээр олон арван жилийн хугацаанд өөрийнхөө үр нөлөөтэйг нотолсон дээрх орнуудын туршлагыг эрдэмтэд хожим нь нэгтгэн судлаад түүнийг хөгжлийн Хүчтэй Түлхэх Загвар /ХТЗ/ хэмээн тодорхойлжээ. Барууны гүрнүүдийг гүйцсэн эдгээр орнууд ХТЗ-ыг тууштай хэрэгжүүлсний дүнд ийм амжилтад хүрээд байгаа бөгөөд аливаа буурай хөгжилтэй улс энэ загварыг тууштай хэрэгжүүлж чадвал хөгжлийн зөрүүг богино хугацаанд арилган тэргүүний хөгжилд хүрч чадна гэдгийг эрдэмтэд онол талаас нь тогтоосон байдаг.

Хүчтэй түлхэх загвар гэж юу вэ?

Энэ загвар нь хөгжлийн эдийн засаг болон сайн сайхан аж байдлын эдийн засгийн үзэл баримтлалыг тусгадаг бөгөөд эдийн засгийн хөгжлийн эхлэл нь үйлдвэржилт гэдгийг тодорхойлдог.

Үйлдвэрлэлийн зардал, үйлдвэрлэлийн эрсдлийг өөртөө авч, олигополь зах зээлийн бүтцийг бий болгодог энэ онолыг Paul Rosenstein-Rodan 1943 онд үндэслэсэн бөгөөд сүүлд АНУ-ын эдийн засагч Kevin Miles Murphy, Robert Ward Vishny нар хөгжүүлэн боловсруулсан. Энэ загварын гол онцлог нь хэд хэдэн томоохон секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт нь Хүчтэй түлхэх загварын онолын суурь үндэс нь юм.

Зураг 1.

Эх сурвалж: <http://en.wikipedia.org>

Япон улс Хүчтэй Түлхэх Загварыг хэрэгжүүлснээр нэг хүнд ногдох орлогыг 1950-1990 оны хоорондох 40 жилийн хугацаанд жилд дунджаар бараг 6 хувь өсгөснөөр 1990 он гэхэд эдийн засгийн хөгжил, амьдралын түвшнээр барууны орнуудыг гүйцэж чадсан байна. Барууны технологийг хуулах, “япончлох” бодлогоо халж, хамгийн орчин үеийн тэргүүний технологийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, тэргүүний технологийг зөвхөн хэрэглэх төдийгүй түүнийг өөрсдөө зохион бүтээгч болох бодлогыг тууштай хэрэгжүүлжээ. Японы хөрөнгө оруулалт 1970 он гэхэд Үндэсний орлогын гуравны нэгтэй нь тэнцсэн байна. ЗХУ-ын жишээнээс төлөвлөлт нэн чухал үүрэгтэйг ойлгон стратегийн төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлжээ. Гангийн үйлдвэрлэл Японы хөгжлийн нэг том ололт болсон байна. Япон 1923 онд 2.4 сая тонн ган үйлдвэрлэж байсан бол 1975 он гэхэд 100 гаруй сая тонныг үйлдвэрлэжээ. Түүнийг даган хөлөг онгоцны, автомашины, суурь машины, барилгын зэрэг олон салбар цэцэглэн хөгжсөн байна.

Солонгос болон Тайвань зэрэг улсууд Японыг дуурайх, хуулбарлах, дагах замаар Хүчтэй Түлхэх Загварыг эрчимтэй хэрэгжүүлсэн байна. Хүнд аж үйлдвэр, түүний дотор гангийн үйлдвэрлэл, хөлөг онгоц, автомашин, цахилгаан болон цахим үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө хүч, төрийн бодлого, зохицуулалтыг төвлөрүүлж тууштай ажилласны хүчинд нэг хүнд ногдох орлогоороо 2011 оны байдлаар 30,000-аад ам. долларт хүрээд байгаа нь өнгөрсөн хугацаанд 20 дахин өссөнийг харуулна. /Солонгос болон Тайвань улсын үйлдвэржүүлэлтийн туршлагыг доор дэлгэрэнгүйгээр оруулсан болно/. Ийнхүү Япон тэргүүлэн бусад нь дагаж хөгжсөн Азийн орнуудын туршлагыг “Галуун цуваа”-ны бодлого гэж нэрлэх нь бий.

БНХАУ барууны гүрнүүдийг бүр ч илүү богино хугацаанд гүйцэх төлөв тодорсоор байна. БНХАУ хөгжлийн Хүчтэй Түлхэх Загварыг хэрэгжүүлэхийг бүр эхнээсээ эрмэлзэж байсан нь тухайн үедээ бүтэлгүйтсэн Их Үсрэлт /1958-60/, Соёлын Хувьсгал /1967-69/ зэргээс тод харагддаг. Тэдгээр нь эдийн засгийн биш, харин улс төрийн тэмцлийн зэвсэг болж хувирчээ. ХТЗ-ыг Дэн Сяопины 1978 онд эхлүүлсэн шинэчлэлийн бодлогын дагуу 30 гаруй жил хэрэгжүүлэн гарамгай амжилтад хүрсээр байна. Хятад Улс энэ загварыг хэрэгжүүлсний ачаар олсон зарим амжилтыг тоогоор харуулбал гангийн үйлдвэрлэл нь жилд 500 сая тоннд хүрснээр дэлхийн бүх дээд амжилтыг эвдээд байна. АНУ, ЗХУ, Япон жилдээ 150 сая тонноос илүү ган үйлдвэрлэж байсангүй. Нэг хүнд ногдох үндэсний орлого нь 1978-2006 оны хооронд жилд дунджаар 6.7 хувиар өсч ирсэн нь том үзүүлэлт юм. Хятад хүний дундаж наслалт 1930-аад онд 30 байсан бол 2000 онд 70-д хүрсэн нь хөгжлийн зэрэг нөлөөний тод илрэл гэж үздэг.

2.2. Дэлхийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал


Судалгааны захиалгад үйлдвэрлэл хөгжсөн дэлхийн улс орнуудын холбогдох үзүүлэлтүүдийг тусгахтай холбогдуулан дэлхийн үйлдвэрлэлийн статистикийн талаарх мэдээллийг оруулав. Ингэхдээ дэлхийн үйлдвэрлэлийн статистик нь ерөнхий чиг хандлагаараа байнга өссөөр ирсэн ба тухайн цаг үеийн нөлөөлөх төрөл бүрийн хүчин зүйлсээс хамааран хэлбэлзэж байсан нь тодорхой юм. Тиймээс дэлхийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сүүлийн үе /2013 оны I улирал/-ийн байдлаар мэдээллийг хамруулав.

НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага /UNIDO/-аас улирал тутам гаргадаг статистикийн мэдээллээс дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт сүүлийн жилүүдийн байдлаар 2010 оноос хойш буурч байсан ба 2013 оны эхний улирлаас өсөх хандлага ажиглагдаж байна. Энэхүү өсөлтөд АНУ, Хятадын үйлдвэрлэл голлох нөлөөг үзүүлж байгаа бол өндөр хөгжсөн Европын улс орнуудын хатуу, хэмнэлттэй бодлого баримталсан зогсонги байдал нь өсөлтөд сөргөөр нөлөөлсөн бол хөгжиж байгаа орнуудын хувьд дээрх хөгжингүй орнуудын эдийн засгийн уналтаас шалтгаалан гадаад эрэлт буурсан нь үйлдвэрлэлийн өсөлтөд мөн сөргөөр нөлөөлсөн. 2013 оны эхний улиралд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар, 2012 оны эцсээс 1.3 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэлийг улс орны хөгжлийн байдлаар нь бүсчлэн харахад:

- Өндөр хөгжилтэй орнууд /Хойд Америк, Зүүн Ази, Европ/. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиг хандлага нь 2013 оны эхний улиралд салаалсан утгыг илэрхийлж байна /Зураг 2/.

Зураг 2.




Хойд Америкийн бүсийн дараалсан 3 жилийн өсөлтөд АНУ-ын үйлдвэрлэлийн гарцын тогтвортой өсөлт нөлөөлж байна. Эрчим хүчний үнийн болон тээврийн зардлын бууралт, хэрэглэгчдийн итгэлийн нэмэгдүүлэхэд гадаад эх үүсвэрийг багасгахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд нь АНУ-ын үйлдвэрлэлийн гарц нэмэгдэхэд нөлөөлж байна.

2012 оны эхэн үеэс Зүүн Азид бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом буурсан бөгөөд энэ нь өнөөг хүртэл /2013 он/ үргэлжилсээр байна. Үүнийг дотор нь, улсаар нь задлан харахад Өмнөд Солонгос 5.1 хувийн өсөлттэй байхад Малайз, Сингапур өсөлтгүй, Япон 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Японы

иений ханш унасан нь экспортыг цаашид нэмэгдүүлсэн ч бараа бүтээгдэхүүний үнэ буурах хандлагатай байна. 2013 оны эхний улиралд Европт үйлдвэрлэлийн гарц 2.5 хувиар буурсан. Бууралтын хэмжээ нь евро бүсийн орнуудад илүү хүчтэй байгаа ба Францад 4.2 хувиар, Германд 1.7 хувиар, Италид 4.5 хувиар буурсан байгаа нь Европт хэрэгжүүлсэн хатуу бодлого үйлдвэрлэлийн өсөлтөд ийнхүү сөргөөр нөлөөлжээ.

- Хөгжиж байгаа орнууд /Хятад, бусад хөгжиж байгаа орнууд/-ын үйлдвэрлэлийн гарц 2013 онд өмнөх үетэй харьцуулахад 6.8 хувиар өссөн ба энэ өсөлтөд Хятадын үйлдвэрлэл гол нөлөө үзүүлжээ. Зураг-3-т хөгжиж байгаа орнуудын үйлдвэрлэлийн гарцыг хувиар илэрхийлэв. Дэлхийн томоохон үйлдвэрлэгч Хятад улсын үйлдвэрлэл нь бусад хөгжиж байгаа орнуудын үйлдвэрлэлийн дунджаас 2013 оны 1-р улиралд 9.7 хувиар илүү өсөлттэй хэдий ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар буурсан байна. /Зураг 3./


Зураг 3.



Харин үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлсэн орнуудыг дурдвал; Бразил 1.6 хувиар, Энэтхэг 2.5 хувиар, Индонез 4.5 хувиар, Мексик 1.1 хувиар, Турк 4.0 хувиар тус тус өссөн байна. Хөгжиж байгаа орнуудын үйлдвэрлэлд гадаад хүчин зүйл буюу үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудын эдийн засгаас ихээхэн хамаарах бөгөөд энэ нь ерөнхийдөө дотоодын зах зээлийн эрэлтэд нөлөөлж байна. Гэхдээ энэ нь улс орон бүр өөр байдлаар илэрч байна. Жишээ нь, Бразилд гадаад худалдааны хомсдол үүссэнээр инфляц нэмэгдэж байхад, Энэтхэгт эрчим хүчний байнгын тасалдал нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бууруулж байна.

Дэлхийн үйлдвэрлэлийн өсөлтийг үйлдвэрийн сектороор харахад 2013 оны эхний улиралд эдийн засгийн зогсонги байдлын улмаас орлого буурч, алдагдал ихэссэн нь тоног төхөөрөмжийн эрэлт болон гэр ахуйн удаан эдэлгээтэй барааны эрэлтийг бууруулсан. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж 2.2 хувиар, радио, телевиз, харилцаа холбооны тоног төхөөрөмж 0.3 хувиар, автомашины үйлдвэрлэл 2.5 хувиар тус тус буурчээ. Хамгийн их өсөлттэй зайлшгүй хэрэгцээт бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу хүнс болон ундаа усны үйлдвэрлэл 2.9 хувиар, хувцас хэрэглэл 5.1 хувиар, химийн бүтээгдэхүүн 3.0 хувиар тус тус өссөн байна. Үүнийг өндөр хөгжилтэй орнууд болон хөгжиж байгаа орнуудаар 2 ангилан зургаар харуулбал:

Зураг 4.



Дэлхийн үйлдвэрлэлийн өнөөгийн чиг хандлага ерөнхийдөө дээрх байдалтай байгаа бөгөөд олдсон мэдээллийн хүрээнд зарим улс орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагыг дараагийн бүлгээр оруулав.

3. ГАДААД ОРНУУДЫН ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН ТУРШЛАГААС

3.1. ЧЕХ УЛС

Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор тус улсын засгийн газраас 1999 оны 4-р сард “үйлдвэрлэлийг тогтворжуулах төлөвлөгөө”-г баталжээ. Энэхүү төлөвлөгөөнд хамгийн тэргүүлэх гэж үзсэн 10 салбарыг тодорхойлсон бөгөөд aliachem, ckd praha, spolana, skoda plzen, tatra, vitkovice, zetor и zps zlin компаниуд багтсан байна.

Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хамгийн таатай нөхцөлийг бий болгоход анхаарч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 10 сая доллараас дээш хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд 10 жилийн турш бүх төрлийн татвараас чөлөөлж, шинээр бий болгосон ажлын байр бүрд урамшуулал олгож байснаас гадна тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлсөн байна.

Энэхүү бодлогын үр дүнд 2000 он гэхэд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 80 хувь, экспорт 45 хувь өсч, гадаадын шууд хөрөнгө оруулалт 15,5 млрд долларт хүрч, гадаадын хөрөнгө оруулалттай 47 мянган компани ажиллах болжээ.

Чех улс нь цахилгаан эрчим хүч, машин үйлдвэрлэл, хими, нэхмэл, хүнс, шил шаазан эдлэлийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн улс юм. Эдгээрийн дотроос машин үйлдвэрлэл чухал байр суурийг эзэлдэг: нийт экспортын 50 хувь, үйлдвэрийн нийт ажиллагсдын 1/3 нь тус салбарт ажилладаг. 1925 онд байгуулагдсан “школа” машины үйлдвэр 90-д оны дунд үеэс германы volkswagen концернд худалдагдаж үйл ажиллагаагаа европын зах зээлд явуулах болжээ. Тус компанийн нийт хувьцааны 70 хувь нь Volkswagen концерны мэдэлд харин 30 хувь нь Чехийн засгийн газрын мэдэлд байгаа бөгөөд засгийн газар ашгаас хувь хүртэж байх талаар хатуу болзолтой гэрээ хийсэн байна.

Түүнчлэн зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд амьдрах чадваргүй болсон үйлдвэр аж ахуйн газруудыг сэргээх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор

“Үйлдвэрлэлийн бүс”- ийг ажилгүйдлийн түвшин өндөр, хямралд өртсөн хуучин үйлдвэрийн районуудад бий болгосон байна. Үйлдвэрлэлийн бүсэд шинэ ажлын байрыг бий болгосныхоо төлөө хөрөнгө оруулагчид зөвхөн татварын хөнгөлөлт төдийгүй урамшуулал хүртэж байсан ба бүсийн төрлөөс (a, b, c, d) хамаарч урамшууллын хэмжээ нь 80-200 мянган крон байжээ. Тухайлбал, Острав дахь үйлдвэрлэлийн бүсийг ажиллуулахын тулд дэд бүтцийн асуудлыг (шинээр зам тавих) шийдвэрлэх шаардлагатай болсноор 5000 ажлын байр бий болж, дараа нь үйлдвэрлэлийн бүс ашиглалтад орсноор 15000 хүн шинээр ажлын байртай болжээ. Ийм байдлаар Чех орон үйлдвэрлэлийн бүсийг бий болгосноороо дан ганц үйлдвэржүүлэлтийг бус дэд бүтцийн хөгжил, ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг төрөл бүрийн ашгийг хүртэж чадсан байна.

Чех улсын хэрэгжүүлсэн ЖДҮ-ийн экспортыг дэмжих бодлого, арга хэмжээний талаар

Чех улсын ЖДҮ-ийн баримжаатай экспортыг дэмжих бодлого нь экспортын баримжаатай бодлого болон ЖДҮ-г хөгжүүлэх бодлогоос уялдан гарчээ. Чех улс үйлдвэрлэлийг дэмжих бодлогын урт хугацааны зорилтоо *нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн нөхцөл болох үндэсний эдийн засгийн бүтээгдэхүүн, технологийн өсөлт, өрсөлдөх чадвар, ажилгүйдэл болон бүс нутгийн, нийгэм эдийн засгийн ялгаатай байдлыг бууруулах түвшинд хувь нэмэр оруулах боломжтой байхаар жижиг ба дунд үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж болох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино* хэмээн тодорхойлсон байна.

Энэхүү зорилтын биелэлт нь эдийн засгийн бүтээгдэхүүн, ажил эрхлэлтэд ЖДҮ-ийн эзлэх хувийн өсөлтөөр хэмжигдэх болно. Үүнээс гадна уг бодлогын зорилтууд хэрэгжсэнээр Европын, дэлхийн бусад хөгжингүй орнуудын гүйцэтгэлтэй харьцуулахад Чех улсын байр суурь үндэсний болон бүс нутгийн түвшинд сайжрах болно хэмээн үзжээ.

ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогын дунд хугацааны зорилтыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийн шинэчлэл, экспортыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, бүтцийн хувьд өөрчлөгдөж буй эдийн засгийн хувьд хоцрогдсон бүс нутгийг эдийн засгийн сэргэлт зэрэгт гүйцэтгэх ЖДҮ-ийн хувийг нэмэгдүүлэх,
- ЕХ-ны зах зээлд амжилттай нэвтрэхэд ЖДҮ-т тааламжтай нөхцөл бүрдүүлэх зорилгоор ЖДҮ-ийн ашиглаж буй технологи, өрсөлдөх чадварыг сайжруулах,
- Бүтээлч ЖДҮ, их сургуулиудын судалгааны төв, Чех улсын Шинжлэх Ухааны Академи, хувийн ба төрийн судалгааны хүрээлэн, том үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааг дэмжих,
- Хувь хүмүүст бизнес эхлэхэд нь тусламж үзүүлэх,
- ЖДҮ-ийг дэмжихэд чиглэсэн хэрэгсэл, механизмыг ЕХ-ны хууль тогтоомжийн дагуу хэрэглэж, тусламжийг хуваарилах механизмыг оновчтой болгох.

Чех улсын экспортын баримжаатай бодлогыг дараах 3 стратеги зорилтоор тодорхойлсон. Үүнд:

- Бусад Европын орнуудтай харьцуулж болохуйц хэмжээнд нэг хүнд ноогдох экспортын хэмжээг нэмэгдүүлэх,
- Экспортын өсөлт, нэн ялангуяа илүү өндөр нэмүү өртөг бүхий экспорт, худалдааны балансын үр дүнд эерэг нөлөө бий болгохыг дэмжих,
- Нийт экспортод эзлэх ЖДҮ-ийн хувийг нэмэгдүүлэх.

1990-ээд онд нийт эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл ба гадаад худалдааны өргөн цар хүрээтэй өөрчлөлтийн хүрээнд экспортыг дэмжих төрийн бодлогыг боловсруулсан байна. Төвлөрсөн төрийн захиргааг экспортыг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байгууллагын нэгэн адил өөрчлөн зохион байгуулжээ. Их бага хэмжээгээр экспортыг дэмжих үйл

ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллагыг байгуулахад шаардлагатай эрх зүйн нөхцөлийг бүрдүүлсэн байв. Экспортын баримжаатай гол байгууллага болох Экспортын зээлийн даатгалын компани 1992 онд, Экспортын банк 1995 онд, Худалдааг дэмжих агентлаг 1997 онд тус тус байгуулагджээ. 1999 онд Худалдаа, үйлдвэрийн яам нь Чех улсын Худалдаа, экспортыг дэмжих зөвлөлийг санаачлан байгуулсан байна.

Экспортын баримжаатай бодлого аргачлал, арга хэмжээг улсын экспортыг дэмжих загварыг үндсэн 5 чиглэлээр тодорхойлжээ. Үүнд:

1. Экспортын тариф, тарифын бус саад бэрхшээлийг арилгах, гадаад худалдааны стратегийг боловсруулах, экспортын баримжаатай төрийн бодлогыг зохицуулах,
2. Төрийн дэмжлэгтэйгээр экспортыг санхүүжүүлэх, даатгуулах болон хөгжлийн тусламжид хандах,
3. Мэдээллийн технологи, зөвлөгөө өгөх, тусламж ба мэргэжлийн боловсрол,
4. Чех улсын бүтээгдэхүүн ба компаниудыг гадаадад сурталчлах ба таниулах,
5. Богино хугацааны экспортын баримжаатай арга хэмжээг нэмэх.

Чех улс нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэр дундаа ЖДҮ-ийг хөгжүүлэх, дэмжих хэд хэдэн хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн.

ЖДҮ-ийг дэмжих МАРКЕТ хөтөлбөрийн зорилго нь гадаадын болон дотоодын зах зээл дахь ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулахад оршиж байв. Дэмжлэгийг чанарын удирдлагын гэрчилгээ авахад нь татаас хэлбэрээр үзүүлж байжээ.

Эдгээр татаасыг 50-250 ажилчинтай дунд зэргийн хэмжээтэй компаниудад итгэмжлэгдсэн гэрчилгээ олгодог байгууллагаас ИСО 14001-ны дагуу орчны удирдлагын гэрчилгээ буюу ИСО 9001:2001 ба ИСО 14001-ны дагуу хамтран хэрэгжүүлэх ба баталгаажуулсан чанарын хяналтын тогтолцооны гэрчилгээг олгоход зориулжээ.

Жижиг хэмжээний компани буюу 0-50 ажилчинтай компаниудын хувьд татаасыг ИСО 9001:2001-ны дагуу чанарын хяналтын тогтолцооны гэрчилгээг баталгаажуулдаг байгууллагаас авахад олгож байв.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ нь гэрчилгээ авах төлбөр болон гэрчилгээ авахтай холбогдуулан мэргэжлийн зөвлөгөө авах үйлчилгээний зардлын 50 хувь хүртэлх хэмжээнд гэрчилгээний татаас авах хүртээмжтэй болсон юм. Нэгдсэн тогтолцооны гэрчилгээг ИСО 14001 ба ИСО 9001:2001-ны дагуу авах тохиолдолд татаасны дээд хэмжээ нь 300,000 Чех крон байсан бөгөөд бусад тохиолдолд 200,000 Чех крон байжээ.

Экспорттой холбоотой мэдээлэл, зөвлөгөө, боловсролын үйлчилгээгээр дамжуулан ЖДҮ-ийг дэмжих МАРКЕТИНГ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийн зорилго, зорилт нь Чех улсын үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гарах боломжийг нэмэгдүүлэх, ЖДҮ-үүд болон бусад орнуудад үйлчилж буй мэдээлэл, зөвлөгөө ба боловсролын үйлчилгээний хүрээ, чанарын ялгааг бууруулахад оршиж байв. Энэ хөтөлбөрийн үр дүнд ЖДҮ-д дэлхийн зах зээл дээр гарах боломжийг олж авснаар эргэлтийн хөрөнгө, ашгаа нэмэгдүүлж чаджээ. Тус хөтөлбөрийг хүрээнд төрөөс дараах дэмжлэгүүдийг үзүүлжээ. Үүнд:

Маркетингийн мэдээлэл - маркетингийн мэдээллийн нийт зардлын 50 хувьд татаас авах боломжийг бизнес эрхлэгчдэд олгожээ. Уг татаасны дээд хэмжээ нь жилд 100,000 Чех крон,

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Чех улсын Худалдаа дэмжих агентлаг нь өөрийн төлөөлөгчийн газартай орнуудад маркетингийн судалгаа бэлтгэжээ. Үүнээс гадна Чех

улсын агентлаг нь зорилтот зах зээл дээр гадаадын түншүүдтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхэд бизнесийн зуучлалын боломжийг олгожээ.

Маркетингийн боловсрол - Энэхүү хөтөлбөр нь маркетингийн боловсролын нийт зардлын 50 хувьд татаас авах боломжийг компаниудад олгосон. Уг татаасны дээд хэмжээ нь жилдээ 200,000 чех крон байжээ. Сургалтын хөтөлбөрүүдийг Чех улсын агентлаг болон Боловсролын Яамнаас итгэмжлэгдсэн экспортын баримжаатай сургалтын байгууллага боловсруулах буюу хамтран зохион байгуулж байсан бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд сургалтын хөтөлбөрийг хамтран санхүүжүүлж байжээ.

Маркетингийн сурталчилгааны материал, Интернет маркетинг - Уг хөтөлбөр нь сурталчилгааны материал боловсруулан хэвлэх нийт зардлын 50 хувьд татаас авах боломжийг бизнесменүүдэд олгожээ. Уг татаасны дээд хэмжээ жилдээ 150,000 Чех крон байжээ. Сурталчилгааны материалд ухуулах хуудас, гарын авлага, сурталчилгаа, Интернетийн веб сайт, гадаад хэл дээрх урилга зэрэг материалууд ордог.

Илтгэл, үзэсгэлэн худалдааны шоунд зориулсан татаас - Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Худалдаа, үйлдвэрийн яамны албан ёсны оролцоо бүхий арга хэмжээнээс бусад гадаадын үзэсгэлэн болон худалдааны шоунд оролцоходоо татаас авах боломжийг бизнес эрхлэгчдэд олгожээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараах зорилгоор татаас авч болно:

Үзэсгэлэнгийн талбайн нийт зардлын 50 хувьд буюу дээд хэмжээ нь 100,000 Чех крон, Жилдээ нэг арга хэмжээнд булан байршуулах, ажиллуулах нийт зардлын 50 хувьд буюу дээд хэмжээ нь 50,000 Чех крон,

ЖДҮ-ийн дизайны үйл ажиллагааг дэмжих ДИЗАЙН хөтөлбөр - Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь Чех улсын бүтээгдэхүүний дизайн болон өрсөлдөх чадварыг сайжруулахад оршиж байв. Энэхүү хөтөлбөр нь дизайныг бизнесийн стратегитай нэгтгэхэд аргачлалын туслалцаа үзүүлэх, дизайнерыг сонгоход туслах, дизайнер болон бизнесменүүдийн хоорондын үр өгөөжтэй хамтын ажиллагааг өрнүүлэх оновчтой нөхцөлийг бүрдүүлэх, чанартай дизайны ажлыг худалдан авах зэрэг боломжийг ЖДҮ-т олгожээ.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд компаниуд нь дизайн бүтээх төлбөрийн 50 хувьтай дүйцэх хэмжээний дизайны үйлчилгээний татаас авах боломжтой байжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд уг татаасыг жилдээ нэг л удаа авах боломжтой байв. Чех улсын экспортод эзлэх ЖДҮ-ийн хувь нь харьцангуй бага байсан учраас засгийн газар нь ЖДҮ-ийн экспортыг эрчимжүүлэн дэмжихэд ихээхэн хүчин чармайлт зарцуулсан байна.

Үйлдвэрлэгч компаниуд болон нийлүүлэгчдийг гадаадын үйлдвэрлэгчид, импортлогчидтой холбох үйлчилгээг үзүүлдэг Чех улсын агентлагийг, мөн Экспортын банк болон Экспортын зээлийн даатгалын компани зэрэг байгууллагыг байгуулж ажиллуулсан. Чех улсын Худалдааг дэмжих агентлаг нь бүс нутгийн болон олон улсын төлөөлөгчдөөс бүрдсэн өргөн цар хүрээтэй сүлжээг байгуулж чаджээ. Тус агентлаг нь экспортын баримжаатай үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд болон экспортыг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах төрийн өмчийн бусад байгууллагуудтай нягт хамтран ажилладаг юм байна.

Улсын төсөв, бүс нутгийн төсөв, компаниудын хөрөнгө, Европын Холбооны Фар хөтөлбөр болон Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага хөтөлбөрөөс экспортыг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлдэг.

3.2. ПОЛЬШ УЛС

Эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгосон нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгох замаар тус улсын эдийн засагт ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Засгийн газраас 1994 онд “Эдийн засгийн тусгай бүсийн тухай” хуулийг батлан гаргасан. Тусгай бүсэд хөрөнгө оруулагчдад тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлж байсан хэдий ч “Төрийн дэмжлэгийн тухай”, “Төрийн хамтын ажиллагааны тухай” хуулиар үйл ажиллагааг нь нарийн чанд зохицуулж байжээ. Тусгай бүсэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдад бий болгосон ажлын байр, оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс нь хамааруулан татварын хөнгөлөлт эдлүүлж байсан. Хөнгөлөлтийн хэмжээ нь нийт хөрөнгө оруулалтын 50 хуваас хэтрэхгүй байжээ. Түүнчлэн тусгай бүсэд ажиллаж буй жижиг дунд үйлдвэрийн газруудад ч зохих дэмжлэг хөнгөлөлт үзүүлсэн байна. Тухайлбал, “Краковскийн технопарк”-д үзүүлсэн дэмжлэгийн 40 хувь нь том, 60 хувь нь жижиг үйлдвэрт ногдож байв. Польш улс эдийн засгийн тусгай бүсийг бий болгосноор гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татаж үйлдвэрлэлийн салбараа сэргээсэн төдийгүй, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зэрэг нийгмийн олон эмзэг асуудлыг зэрэг шийдвэрлэж чадсан байна.

Польш улсын хэрэгжүүлж ирсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого

1995 оноос эхлэн Польшийн Засгийн газар нь үйлдвэрлэлийг тэр дундаа ЖДҮ-ийг хөгжүүлэн дэмжих, ЖДҮ-ийн экспортыг дэмжих зорилгоор хэд хэдэн хөтөлбөр бэлтгэн боловсруулж, үндэсний эдийн засаг дахь ЖДҮ-ийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, ЖДҮ-ийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх, ЖДҮ-ийг дэмжих үйлчилгээний орчин үеийн салбарыг бий болгох зорилт тавин ажиллаж эхэлжээ. Польшийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр нь экспорт байсан бөгөөд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд экспортыг нэмэгдүүлэх дэмжих бодлого баримталж, ингэснээр экспортын хэмжээ 2003 онд 1990 онтой харьцуулахад 374 хувиар нэмэгдэж байжээ. Польш улсын хувьд 1980 аад онд экспортын барааны бүтэц нь зэс, нүүрс зэрэг түүхий эдээс бүрдэж байсан бол 1995 онд экспортын гол бүтээгдэхүүн нь аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн болж эдгээр нь нийт экспортынх нь 69 хувийг эзэлж байсан байна.

Үндэсний эдийн засаг дахь жижиг дунд үйлдвэр ба жижиг дунд үйлдвэрт чиглэсэн бодлого гэсэн баримт бичгийг 1995 онд баталснаар 1995-1997 онуудад үйлдвэрлэлд чиглэсэн бодлогуудыг тодорхойлсон байдаг. Дээрх онуудад ЖДҮ хөгжүүлэх анхан шатны арга хэмжээнүүдийг авч эхлэлээ амжилттай тавьсан. Үйлдвэрлэлд зориулсан хөтөлбөрүүдээ улсын төсөв, олон улсын байгууллага, гадаадын хандивлагчдын сан ба дэмжлэгийн хөтөлбөр, компаниудын өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байсан.

Тус хөтөлбөрийн дараа “2002 он хүртэлх ЖДҮ-д чиглэсэн төрийн бодлого” баримт бичгийг баталж дунд хугацааны 3 үндсэн зорилт дэвшүүлэн тавьсан байна.

1-р зорилтын хүрээнд: ЖДҮ-ийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх

2-р зорилтын хүрээнд: ЖДҮ-ийн экспортыг нэмэгдүүлэх, гадаадын үзэсгэлэн яармагт оролцох бололцоог хангаж улсын төсвөөс хамтран санхүүжүүлэх, бусад оронд суугаа Польшийн элчин сайдын яамдаас хүргүүлсэн мэдээллийг үндэслэн экспортын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх

3-р зорилтын хүрээнд: үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүндээ баталгаат зээлийн тогтолцоог хөгжүүлж экспортод зориулсан зээл болон банк санхүүгийн үйл ажиллагааг үйлдвэрлэгчдэд хүртээмжтэй болгох

2003-2006 онд жижиг дунд үйлдвэрүүдэд чиглэсэн хөтөлбөрийн үндсэн зорилго нь ЖДҮ-ийн салбарын эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тус салбар дахь ажил эрхлэлтийн өсөлт, өрсөлдөх чадвар, Европын Нэгдмэл Зах Зээл дээр үйл ажиллагаагаа явуулах чадварыг тус тус нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. ЖДҮ-ийн салбарт чиглэсэн засгийн газрын үйл ажиллагаа 4 чиглэлд үндэслэн хэрэгжсэн бөгөөд эдгээрийн 3 нь шууд ба шууд бусаар экспорттой холбоотой байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн хөгжилд үр нөлөө үзүүлэх санаачилгыг дэмжих, Үүнд бизнес эрхлэх, өргөжүүлэх талаар мэдлэг, мэдээлэл олж авах боломжоор бизнес эрхлэгчдийг хангах, төрөлжсөн зөвлөгөө өгөх үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгох, бизнесийн үйл ажиллагааг тохируулах, төрөлжүүлэх, өргөжүүлэх зэрэг үйл явцад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.
- ЖДҮ-ийн салбарын байгууллагын орчныг хөгжүүлэхдээ үйлдвэрлэлд зориулсан зээл, зээлийн баталгааны сан байгуулах, европын холбооны эрх зүйн зохицуулалтын талаар болон экспортын боломжууд шинэ техник технологийн талаар интернет мэдээллийн сан байгуулж өргөжүүлэх, бизнес эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгдөг байгууллагыг дэмжих, санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн.
- Олон улсын тавцан дээр компани, пүүс тэдгээрийн үйл ажиллагааг нэгтгэх асуудлыг дэмжих, ингэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: эдийн засгийн нэгдсэн 1 зорилготой, зах зээл дээр өрсөлдөх чадвараа илүү болгох зорилготой ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын нэгтгэх явцыг дэмжих, улмаар тэдний хамтын бизнес сурталчилгааны үйл ажиллагааг нь санхүүжүүлэх хэлбэрээр дэмжих, Польшийн төвүүдийг гадны улс орнуудад байгуулах, үзэсгэлэн яармаг худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх
- ЖДҮ-ийн салбарын эрх зүйн орчныг сайжруулж, нийгэмд бизнес эрхлэх хандлагыг хөгжүүлэх.

Польш улс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг дэмжих бодлогыг олон арга замаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд экспортыг дэмжих бодлого нь сүүлийн 14 жилийн дотор 1 төслөөс олон арван төсөл хөтөлбөрөөс бүрдсэн цогц тогтолцоо болтлоо хөгжиж ирсэн байна.

Экспортыг дэмжих төсөл хөтөлбөрүүд нь:

Польш улс үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, экспортыг дэмжих үүднээс **ЭКСПРОМ I, II ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ** экспортлогчдын хэрэгцээнд үндэслэн боловсруулсан байна. Тус хөтөлбөрийн зорилго нь экспортын чадавхыг сайжруулахад чиглэсэн хэдий ч ЖДҮ-ийн экспортлогч уруу чиглэгдээгүй байжээ. Экспром 1 хөтөлбөрийг 1993-1996 оны хооронд хэрэгжүүлсэн бөгөөд тус хөтөлбөрт экспортлогч бүх компаниуд оролцох эрхтэй байсан боловч ихэнх нь ЖДҮ-ийн салбарынх байсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад компани хоорондын хамтын ажиллагаа дутмаг байна хэмээн үзсэн. Тухайлбал: оёдлын үйлдвэр гэхэд импортын даавуу хэрэглэж байхад, даавуу үйлдвэрлэгчид даавуугаа шууд экспортод гаргаж байх жишээтэй. Иймээс хүмүүсийг хооронд нь холбох хөтөлбөрийг оёдол, арьс, шир гутлын үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ төсөл нь Польш улсын хамгийн том экспортын салбар болсон оёдлын салбарын цаашдын хөгжилд түлхүү нөлөөлсөн гэж үздэг. Уг хөтөлбөрт хамрагдсан компаниудын экспортын хэмжээ 2 жилийн дотор 30-60 хувиар өсчээ.

ЭКСПРОМ I хөтөлбөрөөр олж авсан туршлага дээрээ үндэслэн техник туслалцааны шинэ хөтөлбөр ЭКСПРОМ II-ийг (1997-2000) хэрэгжүүлж эхэлжээ.

ЖДҮ-ийн экспортыг дэмжих хөтөлбөрийг боловсруулахдаа эмийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, оёдол, хөнгөн тэрэгний сэлбэг, хэсэг бүрэлдэхүүн, ган цутгах үйлдвэрийн

бүтээгдэхүүн, хуванцар бүтээгдэхүүн, тавилга зэрэг дэмжлэг авах 6 үйлдвэрлэлийн салбарыг сонгож хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд зорилтот зах зээлд шаардагдах чанарын удирдлагын ISO-9000 стандарт, бүтээгдэхүүний гэрчилгээ авах, гадаадын зах зээлийн шаардлагад бүтээгдэхүүн үйлчилгээний сав баглааг нийцүүлэх, компаниуд гадаадын үзэсгэлэнд оролцох, хамтран ажиллах түнш тогтоох, интернетээр сурталчилгаа хийх зэрэгт дэмжлэг үзүүлсэн. Тус хөтөлбөрт хамрагдсан компаниуд нь зардлыг хуваах үндсэн дээр экспорттой холбогдолтой хөрөнгө оруулалтад буцалтгүй зээл авах эрхтэй байжээ. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд жишээ нь эмийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчид Бразиль, Зүүн Европын шинэ зах зээлд нэвтрэн орж чадсан байна. Хамрагдсан бүх компаниуд бүтээгдэхүүний гэрчилгээ авах эсвэл ИСО-9000 стандартын дагуу чанарын тогтолцоог нэвтрүүлж чаджээ. Уг хөтөлбөрийн 80 хувийг Европын Холбоо/Фар хөтөлбөр санхүүжүүлсэн бол 20 хувийг хөтөлбөрт хамрагдсан компани, байгууллагууд санхүүжүүлжээ.

Польш улс **ҮНДЭСНИЙ ЭКСПОРТЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР** нэртэй дараагийн хөтөлбөрийг 2002 онд Польшийн Аж ахуйн нэгжийн хөгжлийн Агентлаг хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү хөтөлбөрийн ерөнхий зорилго нь ЖДҮ-ийн салбарын экспортын өсөлтийг эрчимжүүлэхэд чиглэжээ. Энэхүү хөтөлбөр нь буцалтгүй тусламж болон техникийн тусламж гэсэн 2 хэсгээс бүрдэх ба эхний хэсэг нь ЖДҮ, тэдгээрийн экспортын чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж, харин хоёрдугаар хэсэг нь компаниудын зардлыг хамтран санхүүжүүлэхэд зориулагдсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд бүтээгдэхүүн боловсруулах, гадаадын зах зээл дээр сурталчилгааны компанид ажил өрнүүлэх, сурталчилгааны материал боловсруулахад гарах зардалд зориулан ЖДҮ бүрд 1,500-10,000 Еврогийн буцалтгүй тусламж өгч байсан зардлын 60 хувиас илүүгүй зардлыг буцалтгүй тусламжаас гаргадаг байжээ.

Польшийн эдийн засгийн яам экспортыг дэмжих, экспортын сурталчилгааны зардлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх хэд хэдэн арга хэмжээг хэрэглэсэн. Үүнд:

- **Гадаадын яармаг худалдаанд оролцсон зардлын зарим хэсгийг нөхөн төлөх:** Эдийн засгийн яам гадаадын худалдааны яармаг үзэсгэлэнд оролцох зардлыг хамтран санхүүжүүлсэн. Жил бүр тус яамнаас зардлыг дааж оролцуулах гадаадын үзэсгэлэн яармагуудын жагсаалт гаргадаг. Нөхөж авах боломжтой зардалд: 4,000 ам. доллар хүртэлх өртөг бүхий үзэсгэлэнгийн орон зай, стандартын булан /самбар/, Үзэсгэлэнд тавих бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50 хувь хүртэлх зардал, гэхдээ энэ нь 650 ам. доллараас хэтэрч болохгүй гэх мэт
- **Гадаадын худалдааны үзэсгэлэнд явахдаа худалдааны аялалд оролцсон зарим зардлын нөхөн төлбөр:** Бизнесийг дэмжих байгууллага, бүс нутгийн удирдлагын зохион байгуулж буй худалдааны аялалд оролцсон компани нь аяллын зардлын хэсгийг буцааж авч болдог байна. Нэг компани нь нийт зардлын 50 хувь хүртэлх хэмжээтэй /НӨТ ороогүй/ дүйцэхүйц буцалтгүй тусламж авч болох боловч энэ хэмжээ нь ойролцоогоор 2,000 ам. доллараас хэтэрч болохгүй.
- **Бүтээгдэхүүний гэрчилгээний зардалд зориулсан татаас:** Энэхүү арга хэмжээний хүрээнд компаниудад гадаадын зах зээл дээр шаардах бүтээгдэхүүний гэрчилгээг авахад хэрэгцээтэй зардлын зарим хэсгийг санхүүжүүлэхэд тусламж үзүүлдэг. Буцалтгүй тусламж нь бүтээгдэхүүний гэрчилгээ авахтай холбоотой зөвлөгөө авах үйлчилгээний зардлын 50 хувь хүртэлх, нэг компанид ноогдох буцалтгүй тусламжийн хэмжээ нь ойролцоо 13,000 ам. доллар байдаг байна.
- **Сурталчилгааны түүвэрлэсэн хөтөлбөр:** Энэхүү аргачлал, арга хэмжээг нэг салбарын бүлэг компаниудыг дэмжих, тэдгээрийг хамтран ажиллах, экспортыг дэмжих хамтарсан үйл ажиллагаа явуулахыг нь эрчимжүүлэх зорилготой юм. Буцалтгүй тусламжийн хэмжээ нь 13,000 ам. доллар хүртэлх байж болох боловч төслийн 50 хувиас илүү хэтэрч болохгүй.

Польш улс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортоо нэмэгдүүлэх бодлогын хүрээнд **Экспортлогчдыг хөгжүүлэх хөтөлбөрийг** боловсруулж хэрэгжүүлсэн байна. Тус хөтөлбөрийн зорилго нь бүс нутгийн экспортод оролцох ЖДҮ-ийн оролцоо, бүс нутгийн ДНБ-д оруулах хувь нэмрийг нь нэмэгдүүлэх, гадаадын зах зээл дээрх өрсөлдөх чадвар, үр өгөөжтэй байдлыг сайжруулахад чиглэгдсэн. Ажилгүйдлийн өндөр түвшинтэй сонгосон 5 бүс нутгийн экспортлогчид ба экспорт хийх боломжтой этгээдүүд энэхүү хөтөлбөрт оролцох эрхтэйгээр тусгасан бөгөөд хөтөлбөрийг 2004-2005 онд хэрэгжүүлжээ. Уг хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийн доод хэмжээ нь 500 ам. доллар байх бөгөөд дээд хэмжээ нь 10,000 ам. доллараас хэтрэхгүй байх ёстой. Буцалтгүй тусламжийг зардлаа хуваах зарчим дээр олгоно. Хөтөлбөрийн төсвөөс гарах хамтарсан санхүүжилтийн дээд хэмжээ нь төслийн авч болох нийт зардлын 50 хувьтай тэнцэнэ. Үлдсэн зардлыг компани өөрийн хөрөнгөөс гаргах ёстой. Мөн экспортын төлбөртэй холбогдсон эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор экспортын зээлийн даатгалын корпораци байгуулсан бөгөөд энэ нь аюулгүй арилжаа хөгжүүлэх, шинэ зах зээлийг олж авах боломжийг олгоно гэж үзжээ. Тус корпораци нь экспортын авлагын даатгал, зах зээлийн бус эрсдлийн эсрэг даатгал, экспортын зах зээл хайх зардлыг даатгуулах, экспортын зээлийн баталгааны сан, экспортын зээлийн хүүгийн төлбөрт зориулсан татаас зэрэг олон арга хэмжээнүүдийг шат дараалан авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: зарим улс орны жишээн дээр бий болсон тогтмол хүүтэй экспортын хүүд зориулсан татаасны тухай /ДОКЕ/ хууль 2001 онд баталж тус хөтөлбөрийн хүрээнд экспортлогчид Польшийн буюу гадаадын банк, олон улсын санхүүгийн байгууллагаас авсан экспортын зээлийн тогтмол хүүд зориулж улсын төсвөөс татаас авах эрхтэй.

3.3. СОЛОНГОС УЛС

Өмнөд Солонгос улс нь эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөө 5 жилээр хийж ирсэн ба энэ нь 1962-1993 он хүртэлх долоон 5 жилийг хамардаг. Дэлхийн банкны ангиллаар тус улсын үйлдвэржүүлэлтийн бодлогын эдгээр жилүүдийг 2 үе болгон ангилдаг ба зарим судлаачид өнөөг хүртэлх 3 үе шатанд хувааж байна. Эдгээрээс тоочвол:

I үе шат: Энэ үе шатанд 1-р 5 жил буюу 1962-1966 онууд хамрагдах ба бие даасан аж үйлдвэрийн үндэс суурийг тавьж эхэлсэн. Эдийн засгийн хараат бус үйлдвэрлэлийг бий болгохыг зорьж импортыг хязгаарлах хатуу бодлого явуулсны үр дүнд үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалж зөвхөн машин техник, тоног төхөөрөмжийн импортыг хүлээн зөвшөөрч байжээ. Импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлийг баримталж бүх хүчээ төмөрлөгийн үйлдвэр барихад зориулж, ашиглалтад оруулж чадсанаар импортоор авдаг бүтээгдэхүүнийг өөртөө үйлдвэрлэдэг болжээ. Мөн цахилгаан эрчим хүч, бордоо, боловсруулаагүй газрын тос, нийлэг бөс даавуу, цементийн салбаруудын хөгжлийн эхлэл тавигдсан. Үүний хажуугаар экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүдийг хөгжүүлж ирсэн байна.

II үе шат: Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж эдийн засгийн суурь салбарыг хөгжүүлэх асуудлыг чухалчилж анхаарсан. 1967-1971 оны 2-р таван жилийн төлөвлөгөөнөөс эхэлж 1972-1976 оны 3-р 5 жилийг дуустал үргэлжилсэн хоёр дахь шатны үндсэн дээр экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн төмөрлөг, машины үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлжээ. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарч хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэртээ зориулж импортоор оруулж байгаа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх бодлого баримталж байжээ. Мөн шинээр экспортод зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гаалийн болон ашиг орлогын татвараас хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Шинэ аж үйлдвэрийн чухал стратеги бүхий цогцолборыг нутгийн өмнөд хэсэгт бүтээн байгуулснаар Сөүлээс бусад бүс нутгийг аж үйлдвэржүүлж, эдийн засгийн хөгжлийг хурдасган, ажиллах хүчнийг нэмэгдүүлсэн.

III үе шат: Энэ үед 4-7-р таван жилийн төлөвлөлтийн үе хамрагдана. Дээрх арга хэмжээний үр дүнд экспортын чиглэлийн үйлдвэрлэлийн салбар 1980-аад оноос илүү хурдацтай хөгжиж эхэлсэн байна. 1980 оны эхэн үеэс орхигдсон хүнд болон химийн үйлдвэрлэл /НСИ/-ийг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан анхаарч хөгжүүлж эхэлсэн. Эдийн засгийн салбарын хямрал, хоёрдогч газрын тосны шокноос үүссэн төлбөрийн балансын хямрал зэрэг тооцоолоогүй нөхцөл байдлууд нь бодлогын өөрчлөлт хийхийг шаардаж байсан. Хүнд үйлдвэрлэлд эрчимтэй оролцохоос зайлсхийх нь нүдээ олсон. Энэ нь Солонгост хүлээн зөвшөөрөгдсөн 1980-аад оны экспортын бөмбөгдөлтийн давуу тал байсан ба АНУ-тай хамтын ажиллагаагаа хэвээр хадгалах арга зам нь худалдааны либералчлал байсан. Мөн санхүүгийн секторыг чөлөөлж эхэлсэн боловч энэ салбарт дорвитой ахиц гараагүй. 1990-ээд оноос зах зээлийг нээлттэй болгож, чөлөөт зах зээлийг бий болгосон бөгөөд 1997 онд Азийн санхүүгийн хямрал болоход Солонгос Улс хямралыг түргэн даван туулах эрс шийдвэртэй арга хэмжээ авсан.

2000 оноос шинэ санаа, шинэ бүтээл нь үндэсний хөтөлбөрт тэргүүлэх асуудал болжээ. Үйлдвэрлэлийн салбарт илүү шинэ санаа нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд Солонгост бизнесийн таатай орчин бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэгчид болон том компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг дэмжин хөгжүүлж байна.

Солонгосын шинэ үйлдвэржүүлэлтийн бодлого нь 1985 онд Аж үйлдвэрийн хөгжлийн хууль /The Industrial Development Law/-д тусгалаа олсон нь сонгомол аж үйлдвэржүүлэлтийг хуулиар хамгаалах тухайн цаг үеийн өөрчлөлт болсон. Бодлогын гол тулгуур нь зээллэгийн оронд судалгаа, технологийг дэмжихэд чиглэгдэж байсан. Засгийн газар нь тусгай нөхцөлд үйлдвэрлэлд оролцохоос татгалздаггүй байсан. Экспортод гаргах хэмжээгээр л үйлдвэрлэх ёстой гэсэн хязгаарыг тавьдаг байсан. Жишээ нь, Samsung-ийг автомашины зах зээлд гаргах бүтээгдэхүүний тоонд хязгаар тогтоосон.

Машин техник, хөлөг онгоцны үйлдвэр, бусад томоохон үйлдвэрүүдийг томоохон эрсдэлд хүрсэн тохиолдолд Засгийн газрын зөвшөөрлөөр нэгтгэх, эрх хасах, хориглох гэх мэт арга хэмжээнүүдийг авч байжээ. Үүнд:

1. Санхүүгийн салбарын төлбөрийн чадварт муугаар нөлөөлж байгаа хамгийн гол гэж үзсэн 8 үйлдвэрт “Аж үйлдвэрийн хөгжлийн хууль”-д нийцүүлэн зохицуулалт хийсэн.
2. Сүлжмэлийн үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулсан зээлд хөрөнгийн баталгааг өгсөн.
3. Үр ашиггүй ажиллаж байсан төмрийн хайлш, бордооны 2 үйлдвэрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох бодлогыг тодорхойлсон. Эдгээр үйлдвэрүүд нь өмнө нь Японы “Уналтад орсон үйлдвэрүүдийн хууль” /Depressed industries law/-ийн хязгаарлалттай төстэй загварыг ашиглаж байсан.
4. Дотоодын монополчлолыг тогтоон, хоорондоо нэгдсэн зэс хайлуулах 2 үйлдвэрт хориг тавьсан. Хар гангийн 3 үйлдвэрийг Pohand Steel компанитай урт хугацааны, онцгой эрхтэйгээр нэгтгэж, Худалдаа, аж үйлдвэрийн яам /MTI/-аас тусгай болзолтойгоор гэрээ хийсэн.


БНСУ нь аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахдаа дэлхийд танигдах хэд хэдэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолдогтой холбоотой. Тийм ч учраас өнөөдөр дэлхийн гол 10 экспортлогч орны нэг, телевизор үйлдвэрлэлээр дэлхийд 1, хөлөг онгоц үйлдвэрлэлээр 2, бэлэн хувцас, гэр ахуйн цахилгаан бараагаар 3-т, нэхмэл бөс бараагаар 4-т азийн шинээр хөгжиж байгаа орнууд дотор цахилгаан техникийн бараагаар 2-р байранд ордог болсон төдийгүй ДНБ-ий өсөлтийн 66 хувийг гадаад худалдааны өсөлтөөр хангаж байна.

Хүснэгт 8. Солонгос улсаас экспортолж байгаа эхний 10 бүтээгдэхүүн /оноор/

№	1960	1970	1980	1990	2000
1	Төмрийн хүдэр	Нэхмэл эдлэл	Нэхмэл эдлэл	Цахилгаан	Хагас дамжуулагч
2	Түхий вольфром	Наамал банз	Цахилгаан	Нэхмэл эдлэл	Компьютер
3	Торго	Хиймэл үс	Төмөр болон ган бүтээгдэхүүн	Гутал	Автомашин
4	Чулуун нүүрс	Төмрийн хүдэр	Гутал	Төмөр болон ган бүтээгдэхүүн	Нефть химийн бүтээгдэхүүн
5	Cuttlefish	Цахилгаан	Усан онгоц	Усан онгоц	Усан онгоц
6	Амьд загас	Жимс, хүнсний ногоо	Нийлэг мяндас	Автомашин	Утасгүй харилцааны тоног төхөөрөмж
7	Байгалийн бал чулуу	Гутал	Металл эдлэл	Химийн бүтээгдэхүүн	Төмөр болон ган бүтээгдэхүүн
8	Наамал банз	Тамхи	Наамал банз	Тоног төхөөрөмж	Нэхмэл эдлэл
9	Будаа	Төмөр болон ган бүтээгдэхүүн	Загас	Пластик бүтээгдэхүүн	Нэхмэл даавуу
10	Үслэг эдлэл	Металл эдлэл	Электрон бараа	Чингэлэг / container/	Гэрийн цахилгаан хэрэгсэл

Экспортыг хөгжлийн хөдөлгүүр болгон гадагш чиглэсэн эдийн засгийн хөгжлийн стратеги нь 40-өөд жилийн хугацаанд Солонгосын үндэсний нийт бүтээгдэхүүнийг 2.3 тэрбум ам доллароос 477.0 тэрбум ам.долларт хүргэж, нэг хүнд ноогдох ДНБ нь 87 ам.доллараос 16,413 ам доллар болтлоо өссөн байна. /Зураг 5/

Зураг 5.



Сүүлийн 30 жилийн турш Солонгосын эдийн засгийн дундаж өсөлт 8.6 хувь байсан бөгөөд гадаад худалдааны эргэлтийн хэмжээгээр дэлхийд 11 дүгээрт орж байна.

3.4. ТАЙВАНЬ УЛС

Тус улсын аж үйлдвэрлэлийн суурь 1949 оноос эхэлсэн ба энэ үеэс импортыг орлуулах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.

1-р үе шат буюу 1949 оноос 1950-аад оны сүүлч хүртэл: Энэ үед импортыг орлуулах анхны суурь тавигдсан. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэдэг гол нэрийн хэрэглээний бараануудын импортыг багасгаж, тариф, квот тогтоосон. Засгийн газраас нэхмэл ба хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бусад эрчимтэй ажиллаж байсан үйлдвэрүүдийг дэмжиж, урамшуулж байв. 1957 оноос шил, төмөр арматур, лаазалсан жимс, машин үйлдвэрлэлийн үндсийг тавьсан.

2-р үе шат буюу 1950 оны сүүлээс 1960-аад оны сүүлч үе хүртэл: Энэ үед импортыг орлуулах бодлогыг үргэлжлүүлэхийн хамт эрчимтэй үйлдвэрлэж байгаа салбаруудад экспортод чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэв. Мөн энэ хугацаанд хүнд болон химийн үйлдвэрүүдийн үндэс суурийг тавьсан ба Тайванийн эдийн засаг сэргэж, үйлдвэржилтийн өсөлт хурдацтай нэмэгдсэн. 1961-1968 онуудад 4 жилийн хугацаатай үечилсэн бодлогын төлөвлөлт хийж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 9.

Хугацаа	Төлөвлөлт
1-р 4 жил /1961-1964/	Эдийн засгийн хөгжлөө тогтвортой удаан хугацаанд барихад хүнд үйлдвэрүүд нь аж үйлдвэржилтийн гол түлхүүр гэж үзэн капитал бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлсэн.
2-р 4 жил /1964-1968/	Хөгжлийг илүү хурдасгахын тулд завсрын бүтээгдэхүүн боловсруулдаг үйлдвэрүүдийг, түүн дотроо химийн болон газрын тосны бүтээгдэхүүн, өндөр нэгдэл бүхий төмөрлөг, даавууны үйлдвэрлэлийг онцлон хөгжүүлэх төлөвлөлт хийсэн.


1963 оноос гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, электроникийн үйлдвэрлэлийн үндсийг бий болгох зорилт тавьж хэрэгжүүлснээр Тайвань өнөөдөр дэлхийн электрон барааны томоохон үйлдвэрлэгч, энэ салбарын хөгжлийг тодорхойлогч болоод байгаа билээ.

3-р үе шат буюу 1970-1980-аад он: Энэ үеийг аж үйлдвэржүүлэлтийн өргөжилтийн үе гэж нэрлэдэг. Учир нь энэ үед экспортын хэмжээ нэмэгдэж, хөдөлмөрийн багтаамжтай бүтээгдэхүүнээс нэмүү өртөг өндөртэй, ур чадвар шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болов. Тайванийн эдийн засаг импортыг орлуулах бодлогын сүүлчийн шатанд шилжив. Дотоодын үйлдвэрлэлээр олон төрлийн капиталын эрчимжсэн үйлдвэрүүдийн /завсрын бүтээгдэхүүн, капиталын бүтээгдэхүүн/ бүтээгдэхүүний импортыг орлуулах болов. Хүнд болон химийн үйлдвэрүүдийг дэмжиж, зарим томоохон бүсүүдийн дэд бүтцийг хөгжүүлж ирсэн.

4-р үе шат буюу 1980-аад оноос хойш: Засгийн газраас өндөр технологи бүхий эрчимжүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарал хандуулж, энэ салбарын үйлдвэрүүдийг дэмжиж эхэлсэн.

Тайванийн боловсруулах үйлдвэрлэлд хүнд үйлдвэрүүдийн эзлэх хувь байнга өссөөр 1990 он гэхэд 60 хувьд хүрч, маш хурдацтай хөгжсөн байна. Үүнийг зургаар харуулав.

Зураг 6. Тайванийн боловсруулах үйлдвэрлэлд хүнд болон хөнгөн үйлдвэрүүдийн эзлэх хувийн жин



Тайванийн үйлдвэржүүлэлтийн бодлогын гол амжилт нь “либералчлал”-тай холбоотой гэж үздэг. Импортыг орлуулах үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлсний үр дүнд макро эдийн засгийн хүрээнд дараах өөрчлөлтүүд гарсан. Үүнд:

1. Гадаад улс орнуудтай хийх гадаад худалдааны харилцаагаа өргөжүүлсэн. Дотоодын бүтээгдэхүүнээр импортыг орлуулахад технологи болон тоног төхөөрөмж, түүхий эд болон капитал бүтээгдэхүүн худалдан авахын тулд гадаад улс орнуудтай өргөн хүрээнд худалдаа арилжаа хийх шаардлага гарсан.
2. Гадаадын эдийн засгаас хамаарах хамаарал буурсан. Тайванийн Засгийн газар аж үйлдвэрүүдийг санхүүжүүлэхийн тулд АНУ-ын тусламжаас ихээхэн хамааралтай байв. Тухайлбал, 1950 онд Тайванийн нийт хөрөнгө оруулалтын 40 хувийг бүрдүүлж байсан. Гэвч АНУ-ын Засгийн газраас 1959 онд үзүүлж байсан тусламжаа зогсооход Тайванийн Засгийн газар төлбөрийн балансын алдагдалд орсон.
3. Хятад улсын аюул занал багассан. 1940-1970 онуудад Хятад улсаас Тайваньд цэргийн хүчээр байнга аюул занал үзүүлж байсан. Үүнээс хамгаалахын тулд батлан хамгаалахын хүчин чадлыг бэхжүүлэхэд эдийн засгаа тогтвортой байлгах шаардлага гарсан. Ялангуяа, эдийн засгийн хөгжлийн шаардлагаар бус батлан хамгаалах, аюулгүй байдлаа хангах явдлыг дэмжих чадвартай хүчирхэг үндэсний үйлдвэрүүд чухал байсан тул үүнд чиглэсэн төлөвлөгөө боловсруулсан. Мөн нөгөө талаас Хятадын эдийн засагт нөлөөгөө тогтоохын тулд экспортыг дэмжих шаардлага гарсан.
4. Экспортод чиглэсэн үйлдвэржилтийн үндэс суурь тавигдсан.
 - 1960-аад онд үндсэндээ хөдөлмөр зарцуулалт ихтэй, нэмэгдсэн өртөг багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан хэдий ч хүнд үйлдвэрүүд нь экспортод чиглэсэн секторуудыг хурдацтай өргөжүүлэхэд шаардлагатай завсрын болон капитал бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол эх үүсвэр нь болж байв.
 - Тайванийн Засгийн газар 1965 оноос экспортод чиглэсэн аж үйлдвэржүүлэлтийн стратегийг хэрэгжүүлж эхэлсэн.
 - Засгийн газар төсвийн хөрөнгөөр улсын үйлдвэрүүдэд хөрөнгө оруулалт хийх, банкны салбарын зүгээс үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох бодлого баримталсан байна.

Импортыг орлуулах чиглэлийн үйлдвэрүүд зөвхөн дотоод зах зээлээ хангаад зогсохгүй гадаад зах зээл; бүтээгдэхүүнээ гаргаж, тэндээс олсон орлогоороо үйлдвэрлэлээ өргөжүүлэхийн зэрэгцээ улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байв. Үүнийг схемээр харуулбал /Зураг 7/:

Зураг 7. Импортыг орлуулах үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгжилтэнд нөлөөлсөн гол хүчин зүйл



Эдгээр хүчин зүйлсийн уялдааг хангах замаар импортыг орлуулах үйлдвэржүүлэлтийн бодлогыг явуулсан.

Экспортод чиглэсэн үйлдвэржүүлэлтийн бодлогыг явуулахдаа:

1. Засгийн газраас дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарсан. Үүнд:
 - 1973 онд Ерөнхий сайд Chaing Ching-Kuo томоохон 10 төслийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан ба үүнд дэд бүтцийг хөгжүүлэх төслүүдээс гадна нефтийн үйлдвэр барих, тээврийн хэрэгсэл, усан онгоцны үйлдвэр барих төслүүдийг эхлүүлсэн.
 - Хөрөнгө оруулалтын нөөцөөс төрийн өмчит дэд бүтцийг сайжруулах чиглэлтэй хүнд үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд зарцуулсан. /1970-аад онд /
 - Төмөр зам, хурдны замуудыг тавьсан.
2. Засгийн газар, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, банкны салбарын хооронд нягт хамтын ажиллагааг бий болгосон. Энэхүү зохион байгуулалтын онцлог нь төрийн чиглүүлэгч агентлаг нь уг гурвалсан холбооны төв нь болж, банк санхүүгийн салбарын нөөцийг төрийн үйлдвэрүүдэд хөрөнгө оруулахад зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь бодлогын гол хэрэгжүүлэгч болж байсан.

Төрийн өмчит үйлдвэрийн газрууд. Тайвань улсын эдийн засагт нөлөө бүхий томоохон үйлдвэрийн газруудыг төрөөс хянадаг ба төрийн өмчит газрууд эрчим хүч, хий, ус, төмөр зам болон харилцаа холбооны салбарт монополь байв. Мөн шатахуун, газрын тосны бүтээгдэхүүн, ган ба бусад металлууд, усан онгоц, хүнд машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, бордооны үйлдвэрүүдийг хянадаг. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд нь улсын нийт орлогын 10-25 хувийг, улсын нийт капиталын 45 хувийг тус тус бүрдүүлдэг ба төрийн өмчит 6 том үйлдвэр нь хувийн 50 том үйлдвэрүүдтэй ижил хэмжээний борлуулалт хийдэг.

Банк, санхүүгийн салбар. Тайванийн Засгийн газраас банк, санхүүгийн салбарт 1970-аад оны сүүлчээс хяналтаа тогтоож эхэлсэн ба тус салбар нь Засгийн газраас гадна удирдагч намын давхар хяналтад ажилладаг байв. Төрийн өмчит үйлдвэрүүд нь Засгийн газрын үйлдвэржилтийн бодлогын гол нэвтрүүлэгч байсан тул банкны зээлийн хуваарилалт нь төрийн өмчит үйлдвэрүүд рүү чиглэгдэж байв. Тоо дурдахад, үйлдвэрлэлжүүлэлтийн бодлогын хэрэгжилт эхэлж байсан 1965-1975 оны хооронд 32 төрийн өмчит үйлдвэр, 19 хувийн томоохон үйлдвэрүүд Тайваний Төв банкнаас шууд хөрөнгө оруулалт авч байсан байна.

Нөгөө талаар, Тайваний хөгжлийг түргэсгэсэн гол гурван хүчин зүйл байдаг гэж үздэг бөгөөд эдгээр нь **газрын шинэчлэл, өмч хувьчлал, жижиг дунд үйлдвэрийг** (ЖДҮ) амжилттай хөгжүүлсэн явдал юм.

Тайвань улс 1967 онд дэлхийд анх удаа “ЖДҮ-ийн үйл ажиллагааг зохицуулах хууль” (The Small and Medium Enterprise Guidance Regulations) гаргаж, зах зээлийн хямрал, байгалийн гамшиг гэх мэт давагдашгүй хүчин зүйлс өртсөн эрсдлийг бууруулах, нөхөн олговор олгох, сургалт явуулах зорилготой ЖДҮ-ийн төв болон дэмжих санг бүх хотуудад байгуулжээ.

Тайвань жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд онцгой анхаарч ирсэн ба хөрөнгө оруулалт, түүхий эдийн дутагдал, гадны хамаарал ихтэй үед үйлдвэржүүлэх хамгийн оновчтой зам нь ЖДҮ-ийг хөгжүүлэх явдал байдгийг харуулж чадсан юм. Тайваний Засгийн газар техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, шинжлэх ухаан судалгааны ажилд ч маш их хөрөнгө зарцуулжээ. Жижиг үйлдвэрлэлийг овог, гэр бүлийн уламжлалд тулгуурлан төрөлжүүлж, том үйлдвэрүүдийн нэгдсэн бодлогод захируулж, дасгаж чадсаны ачаар дэлхийн тэргүүлэх компаниуд Apple, Dell, Fujitsu, Hewlett Packard, IBM, Siemens, Sony, Toshiba-ийн захиалгыг өрхийн үйлдвэрлэгчид чанарын өндөр түвшинд хийх хэмжээнд очжээ.

3.5. СИНГАПУР УЛС

1960-аад оны үед Сингапур төдийгүй Зүүн өмнөд Азийн шинээр төрсөн улс орнуудын нийгэм, улс төрийн сул дорой байдал, колончлолын дараах засгийн газрын эрх зүйн статус, газар нутгийн маргаан, гадаад хөндлөнгийн оролцоо зэрэг нь тухайн бүс нутгийн геополитикийн гол шинж болж байв.

Тухайн үед Британийн хувьд Зүүн Өмнөд Азид цэргийн хяналт тавихад Сингапур нэн тохиромжтой, чухал газрын нэг байсан боловч 1964 онд Британийн засгийн эрхэнд Хөдөлмөрийн нам гарснаар хилийн чанад дахь батлан хамгаалах хүчний зардал багасгаж, 1966 оны сүүлээр хилийн чанад дахь цэргийн хүчнээ татаж эхэлсэн байна.

Британийн цэргийн бааз Сингапурын нутагт байрлаж байсан нь нэг талаар эдийн засгийн хувьд ашигтай байсан ба Британийн цэргийн бааз Сингапурын хөдөлмөр эрхлэлтийн 16 хувийг бүрдүүлж байсны дээр ДНБ-ий 14 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөтэй байжээ.


Британи нэгэн зууны туршид арлын онцлог байрлал, стратегийн ач холбогдлыг үнэлэн цэргээ байршуулахдаа Сингапурыг худалдаачдын дамжин өнгөрөх болон бөөний худалдааны төв болгожээ.

Тухайн үед Сингапур улс ажилгүйдлийн асуудалтай тулгарч үүнээс гарах гарц бол үйлдвэржүүлэлт гэдгийг тодорхойлжээ. Бусдын эд барааг дамжуулан худалдах явдал Сингапурт оргилдоо хүрч, улмаар явцгүй болсон, улс орны эдийн засгийн хөгжилд өгөөжгүй, баялгийг шинээр бий болгож чадахгүй бөгөөд бараа бүтээгдэхүүнийг зөвхөн дамжуулах үүрэг гүйцэтгэж байгаа нь бодитой харагдаж байв.


Тус улс нь аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлсэн нь олон хүнийг ажлын байраар хангаж, амьжиргааны эх үүсвэр болж байсан хэдий ч ажилгүйдлийг арилгах асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй нь тодорхой болсон. Иймээс үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар энэ байдлаас гарах нь зүйтэй гэдгийг тооцоолж, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих бодлого баримтлав. Дотоодын зах зээл бага, хүн ам цөөн, дөнгөж 2 сая байсан хэдий ч Сингапурт ирээдүйд үйлдвэрлэх автомашин, хөргөгч, агааржуулагч, радио хүлээн авагч, телевизор,

магнитофон зэргийг үйлдвэрлэх, түүнчлэн ургамлын тос, гоо сайхны бүтээгдэхүүн, жорлонгийн цаас, лааны тосон бөмбөлөг хийх жижиг үйлдвэр байгуулах гэсэн дотоодын хөрөнгө оруулагчдаа маш сайн дэмжих бодлого баримталж байв.

Зураг 8.



Зураг 9.



Эх сурвалж: Singapore yearbook of statistics

Энэ бүхний үр дүнд хөрш зэргэлдээ орнуудын хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагаа эрчимжсэн ба нэхмэл, бэлэн хувцас, тоглоомын үйлдвэрүүд олноор байгуулагдаж эхэлсэн байна. Эхэндээ үр дүн муутай байсан ч сүүлдээ аж үйлдвэрийн томоохон төв болсон Сингапурын баруун хэсэгт орших Журонг үйлдвэрийн бүсэд ихээхэн хөрөнгө зарж дэд бүтэцтэй болгосон. Журонг дахь хөлөг онгоцны засварын газрыг түшиглэн “Ishikawajima-Harima” гэсэн хамтарсан хөрөнгө оруулалттай компанийг байгуулан онгоц үйлдвэрлэх, засварлах ажлыг эхлүүлсэн. Гэвч хэсэг хугацааны дараа ихээхэн хөдөлмөр шаардсан, ашиг олж чадахгүй үйлдвэр болж хувирсан. Энэ нь хөрөнгө оруулалт хийж л байвал дэмжих бодлого барьж байсан ч дутуу төлөвлөлт зарим талаар алдаанд хүргэдэг гэдгийг харуулсан. Зүй нь дээрх үйлдвэрийг цогцоор нь нэг дор байгуулах асуудал орхигдсон байсан нь хожим мэдэгдэж, түүнийгээ зөв шийдвэрлэж чадсан байна.

Туршлага багатайн улмаас нэлээд алдаа гаргаж, хохирол амссан гэж үздэг. Тухайлбал, цэвэр усны нөөц бага, эрэг орчмын усаа бохирдуулж болохгүй байсныг урьдчилан тооцоогүй, техник технологийн талаар ямар ч туршлагагүй ч хаягдал цаасны үйлдвэр, шаазангийн үйлдвэрийг байгуулахаар ихээхэн хөрөнгө зарцуулсан ба туршлага муутай гадны хөрөнгө оруулагчдад найдаж байсан.

Сингапур колонийн үед үлдээсэн эдийн засаг, улс төрийн үндэс суурьт түшиглэж байв. Британийн цэргийн анги, цэргийн тоо эрс цөөрч түүнтэй холбоотойгоор Британийн тусламжийн гэрээ хийх үед Сингапурын Засгийн газар зөв бодлого явуулж, эдийн засгийн биеэ даасан улс болохыг зорьж байсан. Гадны тусламжид найдаж болохгүй гэдгийг ард иргэддээ сануулан “Хорвоо ертөнц биднийг тэжээх албагүй, бид ч гуйлгаар амьжиргаагаа залгах учиргүй” гэдэг уриалгыг гаргаж, аль болох боломжоороо олон үйлдвэр аж ахуйн газар байгуулж, ард иргэдээ ажлын байраар хангахыг зорьсноор иргэдийнхээ бусдыг харж амьдрах муу зуршлаас ангижруулж чаджээ.

Нөгөөтэйгүүр, гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүйн тулд ихээхэн чармайн ажиллаж байсны зэрэгцээ дэлхийн өнцөг булан бүрээс хөрөнгө оруулагчдыг татах ажил эрчимтэй өрнүүлсэн байна. Үүний зэрэгцээ мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж техник технологийн чиглэлээр залуусыг гадаадад суралцуулах, туршлагаас судлуулахаас гадна гадаадын мэргэжилтнүүдээс зөвлөмж авах, эрдэмтэн, доктор профессоруудаар лекц, шинэ мэдээлэл хийлгэх зэрэг нь бодлогыг зөв тодорхойлж, хэрэгжүүлэхэд их

нөлөө болсон гэж үздэг. Үүний тод жишээ нь 1961 онд Алберт Винсемусаар удирдуулсан судалгааны багийг авч ажиллуулсан ба энэ багийн ажлын тайланд олон ажил тусгагдсанаас татварын бүтэц, аж үйлдвэрийн харилцааны өөрчлөлт, ажилчдыг бэлтгэх, ажлын байр бий болгох гээд ихэнх санал нь тэр даруйдаа хэрэгжиж эхэлжээ. Түүнчлэн анх судалгаа хийсэн багийн гишүүдтэйгээ харилцаагаа огт таслаагүй нь тус улсын бас нэг онцлог юм.

1970-аад оноос эхлэн Сингапур нь экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлэх 10 жилийн хөтөлбөрийг боловсруулжээ. Үүнтэй холбоотойгоор Сингапур аж үйлдвэрээ хөгжүүлж чадсан өөртэйгээ адил жижиг улсуудыг судалж Нидерланд, Швед, Бельги, Израилийг загвараа болгож, Нидерландын гадаадын хөрөнгө оруулалтыг амжилттай татаж чадсан. Мөн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор төрийн бус, улс төрийн ашиг сонирхлыг агуулаагүй Эдийн засгийн хөгжлийн зөвлөл /ЭЗХЗ/-ийг байгуулсан.

Сингапур дахь АНУ-аас орж ирсэн олон үндэстний корпораци нь өндөр технологи ашигладаг, хамрах хүрээ өргөнтэй учраас ажлын байрыг олноор бий болгож, хөрөнгийн эргэлт сайтай, ашиг орлого нэмэгдэх хандлагатай байсан тул хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд 1980-аад оны эхэн үе гэхэд ажилгүйдлийг бууруулж 3.5 хувьд хүргэж, үйлдвэрлэлийн салбарын огцом өсөлтийг бий болгож чадсан.

Үйлдвэрлэлийн хөгжлийг хангахдаа дэд бүтцийг бүрдүүлсэн, сайтар төлөвлөсөн үйлдвэрлэлийн бүс зохион байгуулж, санхүү, татвар, экспортын таатай нөхцөл бүрдүүлж чадсанаар томоохон амжилтуудыг олсон. Энэ бүгд нь Сингапур улсын аж үйлдвэржүүлэлтийн туршлагын нэгээхэн хэсэг, гэхдээ хэн ч анхаарч үзэхээр зөв уялдааг хангасан, цаг үеэ олсон, зайлшгүй байх асуудлуудыг хамруулсан, тэдгээр нь үр өгөөжөө өгсөн зэргээрээ онцлог байна.

Сингапур улс нь ЖДҮ-ийг дэмжих стратеги, дараа нь экспортод чиглэсэн үйлдвэржүүлэлтийн стратегийг баримталж, үйлдвэржүүлэлтийн бодлогоо хэрэгжүүлж чадсанаар өнөөгийн мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд саад учраагүй бөгөөд дэлхийн хөгжингүй орнуудыг тэргүүлж, олон бараа бүтээгдэхүүнээрээ гадаад зах зээлд байр сууриа эзэлсэн, өндөр аж үйлдвэржсэн, хүчирхэг эдийн засагтай улс болж чадсан. Нөгөө талаар, Сингапур улс нь байгалийн нөөц баялаггүй боловч арлын жижиг улсаас орчин үеийн хот улс болтлоо хөгжсөн амжилт нь үйлдвэржүүлэлтийн хөгжлийн асуудлаа хөндөхдөө төлөвлөлт сайтайгаар, бүх талаас нь бодож боловсруулж байж хэрэгжүүлсэнд оршино.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- World manufacturing production, statistics for 2013-I, UNIDO /<http://www.unido.org/statistics>
- Korean industrial policy /World bank/ <http://books.google.mn>
- "The Singapore model of industrial policy", Chia Siow Yue, 2005. <http://www.adbi.org>
- "Шинэ үйлдвэржилтийн бодлогын судалгаа", Б.Даваасүрэн, 2008 он.
- "Үйлдвэржүүлэлтийн бодлогын судалгаа: өнөө ба ирээдүй /Дархан-Уул, Завхан, Хэнтий аймгийн жишээн дээр", ГТХАН-ийн "Бүс нутгийн эдийн засгийг дэмжих" судалгааны баг, 2009 он.
- "Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд" Хөдөлмөрийн Яамны Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн "Монголд үйлдвэрлэл хөгжүүлсе-2" төсөл. 2013 он.
- Монгол Улс болон шилжилтийн улс орнуудын жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих бодлого, аргачлал, арга хэмжээний талаарх судалгааны дүн шинжилгээ, 2004 он. Эва Готц-Дэбница, Байгалмаа.

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ, ТҮҮХЭН
ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**
(Харьцуулсан судалгаа)

Д.Живгаагүнсэл, Г.Билгээ, Ц.Болормаа

АГУУЛГА

Судалгааны хураангуй

1. Дэлхийн эдийн засгийн чөлөөт бүсийн түүхэн хөгжил, хувьсал
 - 1.1. Дэлхийн эдийн засгийн интеграц ба эдийн засгийн чөлөөт бүсүүд
 - 1.2. Эдийн засгийн чөлөөт бүсүүдийн төрөл хэлбэрүүд
 - 1.3. Чөлөөт бүсийн хувьсал, хөгжлийн үе шатууд
2. Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчин, өнөөгийн байдал
3. Чөлөөт бүсийн хөгжил, эрх зүйн орчны талаарх бусад орны туршлага
 - 3.1. Оросын Холбооны Улс
 - 3.2. Бүгд Найрамдах Казахстан Улс
 - 3.3. Бүгд Найрамдах Беларусь Улс
 - 3.4. Бүгд Найрамдах Серб Улс
 - 3.5. Доминиканы Бүгд Найрамдах Улс
 - 3.6. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
 - 3.7. Бүгд Найрамдах Солонгос Улс
 - 3.8. Бүгд Найрамдах Турк Улс
 - 3.9. Тайвань Улс
 - 3.10. Малайзын Холбооны Улс

Ашигласан материал

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны зорилго: Захиалагчийн хүсэлтийн дагуу Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчны өнөөгийн байдал болон үйлдвэрлэл, чөлөөт худалдааны зах зээл өндөр хөгжсөн дэлхийн бусад орнуудын чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, түүний онцлог, түүхэн хөгжлийн талаарх асуудлыг судлахад чиглэгдэнэ.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж байгаа болон хөгжлийн түвшнээр манай улстай ойролцоо зэрэг зарим нөхцөл байдлыг харгалзан ОХУ, БНКазахстан Улс, БНБеларус Улс, БНСерби Улс, Доминиканы БНУ, БНХАУ, БНСУ, БНТурк Улс, Тайвань, Малайзын Холбооны Улс зэрэг 10 орныг сонгон авч холбогдох хууль эрх зүйн орчныг харьцуулан судлав. Мөн Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийв.

Ерөнхий мэдээлэл: Чөлөөт бүс гэдэг нь гаалийн болон татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байрлах, хөрөнгө оруулалт болон аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий нутаг дэвсгэрийг хэлнэ. Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, аялал жуулчлалын, үйлчилгээний, санхүүгийн, хөдөө аж ахуйн, эдийн засгийн гэсэн төрөл хэлбэрүүдтэй байна. Эдийн засгийн чөлөөт бүс /ЭЗЧБ/ гэдэг нь илүү өргөн хүрээтэй ойлголт юм. ЭЗЧБ-д чөлөөт бүсийн дээрх бүх хэлбэрүүд багтах ба тухайн орны бусад хэсэгт үл хамаарах хөнгөлөлттэй болон урамшууллын онцгой систем тогтоосон байх тул үндэсний эдийн засгийн орон зайн нэгээхэн хэсэг гэж үзэж болно.

Судалгааны үр дүн: Судалгаанаас үзэхэд Монгол Улсад чөлөөт бүсийн харилцааг зохицуулсан суурь болон дагалдах хуулиуд батлагдсан хэдий ч эрх зүйн орчны хүрээнд зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлууд бүрэн тусгагдаагүй, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын идэвх, уялдаа холбоо муу байгаа зэрэг дутагдлууд ажиглагдаж байна. Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлсэн бусад орнуудын туршлагаас үзэхэд, дараах асуудлуудыг хуульчлан тогтоосон байх тул Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжид өөрчлөлт оруулахдаа дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй болов уу. Үүнд:

1. **Чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлт:** Чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийн асуудлыг БНСУ, Турк, Серби, Тайвань, БНХАУ зэрэг орнуудын холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгасан байх бөгөөд манай улсад бүсийн хөгжлийн төлөвлөлт болон чөлөөт бүсийн төлөвлөлтийн бүтцийн байгууллага нь энэ асуудлыг орхигдуулсан нь бүсүүдийн үйл ажиллагаанд нөлөөлж байна.
2. **Чөлөөт бүсийн цогц хөгжлийн асуудал:** Үүнд чөлөөт бүсийн суурьшил, бүсийн ажил эрхлэлт, бүтээн байгуулалт буюу оршин суугчдын амьдралын нөхцөл, боловсрол, эрүүл мэнд нийгмийн цогц үйлчилгээний асуудал манай улсад хууль тогтоомжийн хүрээнд орхигдсон гэж хэлж болохоор байна. Гэтэл судалгаанд хамрагдсан бусад улсын жишгээс үзвэл дээр дурдсан асуудлуудыг хуульчилсан байх бөгөөд түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин тухайн бүсийн харьяат оршин суугчдаас үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан бэлтгэх, сургах, ажлаар хангахыг дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад шаардах, олон тооны ажлын байр бий болгосон тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал үзүүлэх зэрэг олон хэлбэрийн арга хэмжээг авч байна.
3. **Бүсийн иргэншил, харьяалал:** Хэдийгээр манай улсад “Чөлөөт бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журам” үйлчилж байгаа хэдий ч бүсийн цогц хөгжлийн асуудлыг хангалттай тооцоолоогүйгээс энэ харилцаа мөн л хангалттай шийдвэрлэгдээгүй байна гэж үзэж болохоор байна.
4. **Бүсийн менежмент, удирдлагын хэлбэр:** Бусад улс орны хувьд чөлөөт бүсүүдийг хувийн өмчлөлд шилжүүлсэн эсвэл бүсийн өдөр тутмын үйл ажиллагаа менежментийг хувийн сектор эрхлэн, харин зөвшөөрөл олгох, бүс үүсгэн байгуулах, татан буулгах, хугацаа сунгах болон бодлого тодорхойлохтой холбоотой харилцааг төрийн мэдэлд байлгах зохицуулалт зонхилж байна.
5. **Бүсийн өөрийн орлого, сангийн тухай:** Турк улсад бүсийн үйл ажиллагаанаасаа олсон аливаа санхүүжилт нь Төв банкны ЭЗЧБ-ийн тусгай санд хуримтлагдах бөгөөд тус санд хуримтлагдсан орлогыг тухайн бүсийн хөгжил, бүтээн байгуулалт, бүсийн оршин суугчдын амьдралын нөхцөлийг сайжруулахад зарцуулдаг жишээ байх бөгөөд судалгаанд хамрагдсан бусад орнуудад энэ мэт санаа авахуйц зохицуулалт нэлээд байна.
6. **Урамшуулал:** Судалгаанд хамрагдсан улс орнуудад тухайн бүсэд хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдийг татах болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилготой урамшууллын тогтолцоо маш өндөр хөгжсөн байгааг хууль болон холбогдох мэдээллүүдээс харж болохоор байна.
7. **Бүтээн байгуулалтын ажлын хяналт:** Нэгэнт үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, төлөвлөсөн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эхлэх хугацааг хуульчлан тогтоосон улс орон байдаг нь судалгааны мэдээлэл боловсруулах явцад ажиглагдаж байлаа. Энэ нь төр засгийн шийдвэр тасралтгүй үргэлжлэхэд нөлөөлөх хүчин зүйлийн нэг бөгөөд ингэснээр хариуцлагыг тодорхой болгож байна. Бүтээн байгуулалтын хяналттай холбоотойгоор бүсийн менежментийн асуудал мөн сөхөгдөж байна.
8. **Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого:** Судалгаанаас үзэхэд чөлөөт бүсэд дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих зорилгоор үйлдвэрлэлд хэрэглэгдэх түүхий эд, тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлж, гаалийн бүрдүүлэлтээс

хөнгөлдөг туршлага ихэнх оронд байна. Түүнчлэн БНСУ-ын хувьд хэрэв дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний эд анги, найрлага, материал нь 50-100 хувь дотоодод үйлдвэрлэгдсэн бол хувь тус бүрд харгалзан хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллын хэмжээг тогтоосон байна.

9. **Чөлөөт бүсийн газар зохион байгуулалт, газрын төлөвлөлт, чөлөөлөлтийн асуудал:** Ялангуяа манай орны хувьд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг тул үйлдвэрлэлийн болон худалдааны чөлөөт бүс байгуулахаар төлөвлөсөн газар бэлчээрийн болон бусад газартай давхцах тохиолдол үүсч болох талтай

/Дэлгэрэнгүйг судалгааны үндсэн тайлангаас үзнэ үү./

I. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ХУВЬСАЛ

ЭЗЧБ-ийн мөн чанар: Дэлхийн аж ахуйн системд олон улсын бараа эргэлтийн идэвхжил, эдийн засгийн интеграцийн процессийг өргөтгөх замаар бодит байдлууд дээр тооцоологдон гарч ирсэн эдийн засгийн түвшнийг хурдасгах гол үзүүлэлт бол ЭЗЧБ юм. ЭЗЧБ нь хөнгөлөлттэй болон урамшууллын онцгой системийг багтаасан тус орны бусад хэсэгт үл хэрэглэгдэх, үндэсний эдийн засгийн орон зайн хэсэг нь юм.

Олон улсын корпорациуд нь өөрийн үйл ажиллагаандаа хөнгөлөлттэй нөхцөлөөр ЭЗЧБ-ийг цэвэр ашиг олж болох тааламжтай орчин гэж үздэг. 1990-ээд онуудад дэлхийд ЭЗЧБ-ийн олон төрлүүд тодорхойлогдсон байдаг.

ЭЗЧБ-ийг бий болгох гол зорилго нь:

- Зохион байгуулж буй орнуудын нийгэм эдийн засгийн хөгжүүлэх
- Аж ахуйг хөгжүүлэх, хэтийн төлөвлөгөө зэргээс хамаардаг байна.

Иймээс ЭЗЧБ-ийг бий болгох, үүсгэх шалтгаан, зорилго нь тодорхой нөхцөл бүрд бие биесээ ялгаатай байна.

Жишээ нь үйлдвэрлэл хөгжсөн АНУ, Их Британи, Франц зэрэг орнуудад гадаад эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, улс хоорондын хөгжлийн ялгааг арилгах бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ жижиг болон дунд бизнесийн үйл ажиллагааг сэргээх зэрэгт зориулж ЭЗЧБ-ийг бий болгодог. Харин хөгжиж байгаа орнуудад гадаадын хөрөнгө оруулалт, технологи нэвтрүүлэх, ажиллах хүчний мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зэрэг зорилгоор ЭЗЧБ-ийг бий болгодог байна.

Иймд ЭЗЧБ-ийн төрлүүдийг бий болгохдоо бүсийн зорилгыг нарийн тодорхойлох нь нэн чухал байна.

ЭЗЧБ-ийг бий болгоход 3 үндсэн үүрэг байдаг байна. Энэ нь:

- Экспортын үйлдвэрлэлийг урамшуулсны үндсэн дээр валютын эх үүсвэртэй болох
- Эзлэх байр суурийн түвшин ажлын байр өсгөх
- Аж ахуйг эзэмших шинэ аргыг ЭЗЧБ дээр туршиж, үр дүнд нь үндэсний аж ахуйн өсөлтийг нэмэгдүүлэх

Мөн ЭЗЧБ-ийн онцлог нь гааль, татвар, хөрөнгө оруулалтын тогтолцоо, гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчдад хамгийн тааламжтай нөхцөлийг хангасан байх явдал юм.

Дэлхийн эдийн засаг дахь ЭЗЧБ-үүдийн хувьсал:

Сүүлийн хэдэн үеийн туршид худалдаа арилжааны либериалчлал, санхүүгийн интернационализм ба бүтээгдэхүүний интеграц гэх мэтчилэн дэлхийн эдийн засгийн интеграцчилалд асар их дэвшил гарсан. Олон улсын хөдөлмөрийн нэгдэлд олон орон идэвхтэй оролцох болсон нь буурай хөгжилтэй орнуудын хувьд улс үндэстнийхээ эдийн засгийг өргөжүүлэн хөгжүүлэх боломж болж өгдөг. Хөгжилтэй орнууд дахь он удаан жил болсон үйлдвэрүүдийг буурай хөгжилтэй орнууд руу шилжүүлэн байршуулж ажиллуулах явдлыг ихэвчлэн бүтээгдэхүүний эргэлт гэх тэргүүтэн онолуудаар тайлбарлацгаадаг. Эхлээд ажиллах хүч нэн шаардлагатай (бөс даавуу, оёдол, гутал зэрэг) үйлдвэрүүд, дараа нь хөрөнгө шаардлагатай (ган болд, хөлөг онгоц, түлш шатахууны, электроникийн гэх мэт) үйлдвэрүүдийг буурай хөгжилтэй орнууд руу шилжүүлэн байршуулж ажиллуулснаар ажлын хүчний тухай “Шинэ орон зайн нэгдэл хөдөлгөөний” онолыг гаргахад хүргэсэн юм. Олон буурай хөгжилтэй орнуудад аж үйлдвэрийн салбар асар хурдацтай өссөн нь тэдгээр нь гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлтэй, дэлхийн зах зээлд төвлөсөн экспортын чиглэлийн аж үйлдвэрлэлийн бодлого зэргийн үр дүн байв. Аж үйлдвэржилт зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй ба, тухайн улс үндэстний бизнесийн тогтолцооны орчинд суралцах ба зохицох үйл явдал юм.

Хамгийн анхны экспортын чиглэлийн бүсүүд 1960-аад оны үед Ирланд, Тайвань зэрэг орнуудад аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хөгжилтэй орнууд өөр хоорондоо болон хөгжилтэй орнуудаас бага буурай хөгжилтэй орнуудад шилжүүлэн байршуулах зорилгоор байгуулагдсан байдаг. Тэр цагаас хойш экспортыг голлон анхаардаг олон бага буурай орнуудад Экспортын чиглэлийн бүсүүд бий болсон байна.

1960-аад оноос эхлэн дэлхий даяар төрөл зүйлийн хувьд маш олон янзын ЭЗЧБ-үүд, тэдгээртэй холбогдол бүхий бодлогууд бий болсон.

1990-ээд онд Роберт Ж. МакКалла 1986 оныг хүртэлх бүтэц болон цар хүрээний хувьсалыг нь ЭЗЧБ-ийн хэд хэдэн жишээгээр судлаад чөлөөт боомтууд, чөлөөт худалдааны бүсүүд, чөлөөт экспортын бүсүүд ба чөлөөт аялал жуулчлалын бүсүүд гэх мэт хуваасан байдаг. Мөн Сиангмин Чэн 1990-ээд оны дунд үед чөлөөт эдийн засгийн бүсийн түүхэн ба орчин үеийн чөлөөт экспортын бүс, эдийн засгийн онцгой бүс, шинжлэх ухаанд суурилсан аж үйлдвэрийн парк, хил дамнасан хөгжлийн гурвалжин гэх зэрэг загваруудыг санал болгон гаргасан байна. Харин БНХАУ-ын эрдэмтэн Мэнгуан Вен эдгээр төрөл хэлбэрүүд нь гагцхүү эдийн засгийн бус басхүү улс төр, нийгэм-соёлын болон орон зайн нөхцөлүүдээр ЭЗЧБ-ийн хөгжил, хувьсалд нөлөөлдөг хэмээн үзжээ.

1.1. Дэлхийн эдийн засгийн интеграц ба ЭЗЧБ-үүд

Дэлхийн эдийн засгийн хөгжлийн явц дэлхийн эдийн засгийн интеграцчилал ба эдийн засгийн даяаршил руу чиглэж буй хандлага ажиглагдаж байна. Дэлхийн эдийн засаг нь илүү ойр харилцаа холбоог тогтоож, орон зайн хувьд ч үнэхээр глобалчлагдаж байна. Ийнхүү “дэлхийн эдийн засаг” ба “эдийн засгийн даяарчил”-ын бүрэлдэхүүн хэсэг болсон ЭЗЧБ-үүд нь өнөө цагийн дэлхийн эдийн засаг, ялангуяа бага болон буурай хөгжилтэй улс орнуудын эдийн засагт зонхилох үүргийг гүйцэтгэж байна.

Дэлхийн эдийн засгийн интеграц

Өнөөг хүртэл бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн “дэлхийн эдийн засгийн интеграц” гэх тодорхойлолт байдаггүй гэж эдийн засагчид үздэг байна. Учир нь энэ үйл явц дөнгөж л эхлэл шатандаа явж байна. Гэсэн хэдий ч үүнийг одоо цагийн интеграцийн шатны зарим гол шинж төрхөөр нь тодорхойлон тайлбарлаж болох юм.

Интеграцийн тухай үндсэн тодорхойлолтууд:

- Дэлхий дахины хөрөнгө ба ажиллах хүчний чөлөөт урсгал дахь аливаа хүнээс хамааралтай саад тотгорыг бүрэн арилгасан байх явдал;
- Бүх улс орнуудын түвшинд худалдааны либериализм бодитой оршсон байх;
- Бүтээгдэхүүний гол хүчин зүйлс ба үнийг тэнцвэржүүлэх хүчин зүйлсийн дэлхий нийтийн чөлөөт урсгал дахь саадуудыг арилгасан байх;
- Бүтээгдэхүүнийг дахин үйлдвэрлэх бүх шатан дахь эдийн засгийн хүчин зүйлсийн дэлхий нийтийн чөлөөт урсгалын элдэв саадыг арилгах зэрэг болно.

Энд дурдсан бүх тодорхойлолтууд нь интеграцчилалын өөр өөр шатууд дахь төрх байдлуудыг тодорхойлж байгаа ба эдийн засгийн интеграц болон байгуулалтыг төдийлөн хөндөж үзээгүй болно.

Өнөөдөр дэлхий нийт дэх бүс нутгийн эдийн засгийн интеграцийг ажиглан үзэхэд харилцан адилгүй өөр өөр бүс нутагт, хөгжлийн өөр өөр түвшинд, бас өөр өөр бүс нутгийн загварчлал бүхий байгаа нь харагдаж байна.

Хүсэгт 1. Дэлхийн эдийн засгийн интеграцийн хэлбэр ба логик уялдаа холбоо

<ul style="list-style-type: none"> • Үүрэг, үйл ажиллагааны интеграци • Нэгдсэн байгууллагын хэлбэр • Бүс нутгийн интеграц • ЭЗЧБ 		Дэлхийн эдийн засгийн интеграц

Бүс нутгийн эдийн засгийн интеграцчилал

Дэлхийн эдийн засгийн интеграц ба бүс нутгийн эдийн засгийн интеграц нь хөгжлийн зорилт болон үе шатуудын хувьд хоорондоо бүхэлдээ болон хэсэгчлэн уялдаа холбоотой байдаг. Нэг нь нөгөөгөө ямагт дэмжин, өргөжүүлж байдаг. Нэгдүгээрт, дэлхийн эдийн засгийн интеграц нь бүс нутгийн интеграцийн хөгжлийн зорилт бөгөөд хөрс суурь болдог. Дэлхийн эдийн засгийн интеграц нь нэг бүс нутагт хэдийн байгуулагдсан нэгдсэн байгууллагууд өөр бүс нутгийн адил байгууллагуудтай нэгдэх, үйл ажиллагаагаа хамтатгах, аль эсвэл гишүүн элсүүлэх зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх боломжийг нээж өгдөг юм.

Хоёрдугаарт, бүс нутгийн интеграц нь дэлхийн эдийн засгийн интеграцийн хөгжлийг дэмжих суурь болж байдаг юм. Бүс нутгууд эдийн засаг, улс төр, соёл, шашны хувьд асар их ялгаатай байдаг тул эхлээд зөвхөн зарим тодорхой нутаг дэвсгэр ба секторт л таатай нөхцөл бүрэлдүүлэн бүс нутгийн интеграц хөгжүүлэх боломжтой.

Интеграцийн түвшин, байгаль цаг уурын нөхцөл, газар зүйн байршил, эдийн засгийн чадамж, улс төрийн тогтолцоо, шашин соёлоос хамааран бүс нутгийн эдийн засгийн интеграц нь глобал түвшинд үзэхэд “Европын Холбоо”-ны загвараас “Хойд Америкийн чөлөөт худалдааны бүс” (NAFTA), “Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа” (APEC) хүртэл харилцан адилгүй өөр өөр байдаг. Энэхүү хувьсалыг дагалдан эдийн засгийн интеграц нь тус тусдаа гаалийн татваргүй болох, нэгдсэн гаалийн татвартай болох, нэгдсэн зах зээлтэй болох зэргээр хувиран өөрчлөгдсөн байна.

Чөлөөт худалдааны нутаг дэвсгэр, гаалийн холбоо ба нэгдсэн зах зээл зэрэг шатуудад бараа бүтээгдэхүүн, хөрөнгө, үйлчилгээ, боловсон хүчний чөлөөт урсгалын нэгдсэн нийтлэг эдийн засгийн бодлого боловсруулах зэргийг бодитой хэрэгжүүлснээс дурдвал Европын холбоо гэх мэт үндэстэн дамнасан байгууллага байгуулагдсан явдал юм.

Олон улсын худалдааны тухайд дэлхийн эдийн засгийн эхэн шаталбар ба үндсэн хэлбэр байдгийн адилаар Худалдаа арилжааны либериалчлал нь Дэлхийн Эдийн Засгийн Интеграцийн эхэн шат бөгөөд үндсэн шинж чанар нь болно. Худалдаа арилжааны хөгжил нь бүх нийтийн зах зээл байгуулагдах суурь нөхцөл болсон байна. Энэ нь бүс нутгийн хэмжээний худалдаа арилжаанаас цаашид чөлөөт худалдааны хэлэлцээрүүд, гаалийн холбоод, олон улсын худалдааны систем болон хөгжих замаар бий болдог.

Ерөөс худалдаа-үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ-үүд байгуулагдаж хөгжсөнөөр тэдгээр чөлөөт бүсүүд болон дэлхийн эдийн засгийн, эсвэл дэлхийн эдийн засаг ба чөлөөт бүсүүдийн хоорондох санхүүгийн интеграц нэгдлийг нөхцөлдүүлж байгаа юм.

Бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт бүхий бүрэн Чөлөөт эдийн засгийн бүсүүд хөгжингүй орнуудад, ялангуяа буурай хөгжилтэй орнуудад бий болж хөгжсөн нь дэлхий дахины бүтээгдэхүүний интеграцчилалын үр нөлөө юм.

ЭЗЧБ-ийн тодорхойлолт: ЭЗЧБ-ийн ерөнхий шинж чанар нь эдийн засаг ба улс төрийн зорилтуудыг эдийн засаг хийгээд засаг захиргааны элдэв дарамтгүй “эрх чөлөө”-тэй, таатай нөхцөлд хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгох явдал юм.


ЭЗЧБ нь газар зүй болон засаг захиргааны хамаарлаар хязгаарлагдаж гагцхүү эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:

- ЭЗЧБ нь таатай гадаад арилжаа худалдаа гэх мэт микро эдийн засгийн зорилтууд, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги ба бүтцийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зэрэг макро эдийн засаг болон улс төрийн зорилтуудыг хэрэгжүүлэх,
- “Эрх чөлөө” гэдэг нь тухайн “бүс”-д санхүүгийн таатай нөхцөл, эдийн засгийн болон захиргааны онцгой эрх олгохыг хэлнэ. Тухайн бүсэд улсын татварын систем, бусад гадаад худалдааны хориг хязгаарлалтууд, зарим төрлийн улс төр эдийн засгийн бодлогууд үйлчлэхгүй гэсэн үг болно.
- Эдийн засгийн онцгой таатай бодлого бүхий эдийн засгийн бүсүүд нь харилцан адилгүй өөр өөр хэмжээтэй байхаас гадна нэг улс орны нутаг дэвсгэр дотор ч байна, бас хэд хэдэн орны хилийн бүс нутгийг хамран орших нь ч бий. Ийм бүсийг гагц чөлөөт худалдааг эрхлэн явуулахад бус, бас тухайн улсын эдийн засгийг дэлхийн эдийн засгийн сөрөг муу үр нөлөөнөөс хамгаалан удирдах зорилгоор хэрэглэдэг.
- ЭЗЧБ нь тухайн бүсийн дотоодод аливаа улсын төрийн хамааралгүйгээр гагц эдийн засгийн үйл ажиллагаа явуулна. ЭЗЧБ бүрд тэргүүлэх сектор, салбар байдаг: худалдаа ба усан тээвэр, тээвэр ба агуулах, зарим энгийн боловсруулах үйлдвэрлэл нь Чөлөөт усан боомт, Чөлөөт худалдааны бүс ба Гаалийн агуулахын тэргүүлэх сектор; үйлдвэр, шинэ болон өндөр технологийн үйлдвэр ба худалдаа нь Экспортын чиглэлийн чөлөөт бүс, Чөлөөт арилжааны бүс болон ШУ-д суурилсан аж үйлдвэрийн паркийн тэргүүлэх салбар; санхүү, даатгал, мөрийтэй тоглоом ба аялал жуулчлал бол Чөлөөт үйлчилгээний бүсийн тэргүүлэх сектор, харин Чөлөөт эдийн засгийн бүсийн тэргүүлэх секторууд нь дээрх бүгд байдаг.

1.2 ЭЗЧБ-үүдийн төрөл хэлбэрүүд


ЭЗЧБ-ийн түүхээс үзэхэд 15-р зуунаас Европ тивд үүссэн гэж үздэг байна. Дэлхийн II Дайны дараа ЭЗЧБ нь асар хурдацтай хөгжиж, дэлхий дахины үйл хэрэг болж хувирсан. Хөгжлийн болон улс төр, эдийн засгийн харилцан адилгүй өөр өөр нөхцөл байдлаас хамааран ЭЗЧБ-үүдийн төрөл хэлбэр маш олон байдаг. Тухайлбал **хөгжлийн үе шат, байршил, дэглэм, үйл ажиллагааны төрлөөр болон зорилгоос** шалтгаалан өөр өөр хэлбэрүүдтэй байна. Зураг 1-д ЭЗЧБ-үүдийн ерөнхий төрлүүдийг үзүүлсэн байна.

Зураг 1. ЭЗЧБ-үүдийн ерөнхий хэлбэр, хувьсалууд




Зураг 2-т ЭЗЧБ-ийг дэглэмийн хэлбэр болон газар нутгийн хэлбэршлийн хувьд хэрхэн ангилсныг үзүүлсэн бөгөөд ЭЗЧБ-ийг дэглэмийн хувьд даатгагдсан, татваргүй, өндөр технологийн зэргээр ангилсан байна.

Зураг 2. ЭЗЧБ-үүдийн газар нутаг, дэглэмийн хэлбэржилтийн бүсүүд



Доорх зурагт /Зураг 3./ ЭЗЧБ-үүдийг байршил болон үйл ажиллагааны төрлөөр нь ангилсан байгаагаас үзвэл байршлаар нь *улс дамнасан, хил дамнасан, үндэстэн дамнасан* гэж ерөнхийд нь хуваах бөгөөд *эрэг орчмын, нутгийн гүн дэх, боомт, хотын, тусгаарлагдсан* зэргээр төрөлжүүлдэг байна. Харин үйл ажиллагааны төрлөөр нь *худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, санхүүгийн, шинжлэх ухааны, бүрэн* гэж ангилдаг байна.

**Зураг 3. Байршил болон Үйлдвэрлэлийн бүтцээс шалтгаалсан
ЭЗЧБ-үүдийн хэлбэршил, хувьсал**



1.3. ЭЗЧБ-ийн хувьсал, хөгжлийн үе шатууд

Онолын хувьд ЭЗЧБ-ийг судлаачид дараах байдлаар үечлэн хуваадаг.Үүнд:

- 1) **Анхдугаар үе шат:** 16-р зууны сүүлчээс 1940-өөд оныг хүртэлх Худалдаанд суурилсан ЭЗЧБ:
 - а) *1-р шат:* 16-18 дугаар зууны эхэн үеийн Европын анхны Чөлөөт хот ба чөлөөт усан боомт,
 - б) *2-р шат:* 18-р зууны дунд үеэс 1940-өөд онд Чөлөөт хотууд нь чөлөөт боомт ба чөлөөт худалдааны бүс болж өөрчлөгдсөн.
- 2) **Хоёр ба гуравдугаар үе шат:** 1940-1970 он хүртэлх Үйлдвэрлэл, үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ
 - а) *1-р шат:* 1945-1959 онд Чөлөөт боомтууд/Чөлөөт худалдааны бүсүүд дахин зохион байгуулалтад орж шинэ төрлийн ЭЗЧБ үүссэн,
 - б) *2-р шат:* 1960-1970 онд Үйлдвэрлэл ба үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ,
- 3) **Дөрөв ба тавдугаар үе шат:** 1970-1980-аад онд ШУ-нд суурилсан бүрэн ЭЗЧБ,
- 4) **Зургаадугаар үе шат:** 1990 оноос хойш Хил дамнасан ЭЗЧБ.

Хамгийн эртний ЭЗЧБ нь “Чөлөөт усан боомт”-ын үр хөврөл хэлбэрээр байсан гэж үзвэл тэр нь эртний (Грек дэх) Ромын Делос боомт байдаг. Мөн дундад эртний үеийн газар дундын тэнгисийн зүүн болон өмнөд эрэг дагуух хот улсуудад тухайн бүс нутагт худалдаа арилжаа дахин сэргэж байсантай холбоотойгоор боомтууд үүсч байсан байдаг. 1228 онд өмнөд Францын Марсель хотод “чөлөөт худалдааны боомт” байгуулагдаж байжээ. 13-р зууны сүүлч үеэр Умард болон Балтын тэнгисийн хотуудаар “Hanseatic League” хэмээгдэх “Чөлөөт худалдааны Эвлэл” байгуулж байв. Энэ эвлэлийн дотроо Гамбург, Бремен хотууд “чөлөөт хот” байсан тул чөлөөт худалдаанд ноёлох байр суурьтай байсан байдаг. 1547 онд Италийн эргийн хот Генуад байгуулагдсан Лейгхорн Чөлөөт усан боомтыг хамгийн анхны Чөлөөт усан боомт байсан гэж үздэг. Тэгэхээр Гамбург чөлөөт хот ба Лейгхорны чөлөөт усан боомтыг ЭЗЧБ төрж гарсны бэлгэдэл гэх аж. Дэлхийн II Дайнаас хойших улс төр ба технологийн асар хурдацтай хөгжил дэвшлийн үр дүнд “дэлхийн эдийн засаг” нь “улс үндэстний эдийн засгаас” үнэнхүү “Дэлхийн эдийн засгийн интеграц” болж биежсэн юм. Дэлхийн эдийн засгийн интеграцийн хамгийн анхдагч бөгөөд зайлшгүй алхам болсон дэлхийн худалдааны либералчлал, санхүүгийн интернационализм, бараа бүтээгдэхүүний интеграц, олон улсын байгууллага

ба Бүс нутгийн эдийн засгийн бүс тэргүүтнийг олон төрөл хэлбэрийн ЭЗЧБ-үүд нь тэтгэн хөгжүүлсэн байдаг.

1) Анхдугаар үе шат: 16-р зууны сүүлчээс 1940-өөд оныг хүртлэх Худалдаанд суурилсан ЭЗЧБ-үүд

ЭЗЧБ-үүдийн хамгийн эртний бөгөөд сайтар мэдэгдэж байгаа хэлбэр бол худалдаа суурилсан ЭЗЧБ юм. 1950-аад оныг хүртэл дэлхийн ЭЗЧБ-үүд нь бүгд энэ хэлбэрийн бүсэд хамаарагдаж байв. Шууд ба шууд бус эдийн засгийн ашиг олохын тулд “Чөлөөт худалдааны бүсүүд” нь газар зүйн хувьд гол төлөв усан боомт, нисэх буудал, мэдээлэл харилцааны төвүүдийн дэргэд буюу ойролцоо байрладаг, хүрээлэн буй тухайн улсын бусад нутаг дэвсгэрээс хашаа эсвэл бусад хаалтаар тусгаарлагдсан, тэндэх чөлөөт худалдаа ба чөлөөт эдийн засгийн бодлогуудыг нь дэлхий нийт хүлээн зөвшөөрсөн, боомтын худалдаа, агуулах, боловсруулах ба бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг нь эдийн засгийн гол үйл ажиллагаа болдог тийм бүсүүд байв. Худалдаанд суурилсан ЭЗЧБ-үүдэд Хонгконг, Сингапур, Гранд Бхама, Ханбург, Бремен, Дуйсбург зэрэг Чөлөөт боомтууд; Колон (Панам), Барселон, Генуа, Икуйке (Чили) зэрэг Чөлөөт худалдааны бүсүүд; Бари, Ром, Бонес-Айрес зэрэг Баталгаат агуулахын бүсүүд; Сантос бүс (Бразил), Энэтхэгийн Кальката бүс зэрэг Чөлөөт транзит ба худалдааны бүсүүд бүгд багтан орж болно. Энэ шат нь дотроо хоёр үетэй. Үүнд:

а) 1-р шат: 16-р зууны сүүлчээс 18-р зууны эхэн үеийн Европын анхны Чөлөөт Хотууд ба Чөлөөт усан боомтууд

16-р зууны сүүлч үед олон улсын худалдаа хөрөнгөтний гар үйлдвэрлэлийн хөгжил ба усан замын аялал, нэн ялангуяа “Шинэ тивийг нээсэн”-тэй холбоотойгоор асар их өргөжин хөгжсөн байдаг. Чөлөөт хотууд ба Чөлөөт боомтууд анх Газар дундын тэнгисийн эргээр үүсч, дараа нь умраас Балтийн тэнгис рүү тэлэн дэлгэрсэн байна. Тэдгээр нь Газар дундын тэнгис орчмын улс орнуудын хоорондох, түүгээр ч үл барам газар дундын тэнгисийн бүс нутаг ба бусад тивүүдийн (тухайлбал Ази тив) хоорондох “чөлөөт худалдаа”-ны гол хэрэгсэл болж байв. Тэдгээр нь худалдаанаас гадна бас Хансийтик лигийн дотор далайн дээрмээс урьдчилан сэргийлэх гол хүчин болж байжээ. 17-р зууны үеийн Чөлөөт хотууд ба Чөлөөт боомтууд нь Италийн Наплес, Венец ба Триесте, Португалийн Порто, Францын Дункеркуе, Денмаркийн Копенгаген, тэрчлэн Германы Хамбург, Бремен, Любек, Рүүтсток, Данзиг ба Коенигсберг зэрэг байлаа. Ийнхүү 18-р зууны эхэн үеийг хүртэл Чөлөөт хот ба Чөлөөт усан боомт гэсэн хоёр төрлийн “Чөлөөт эдийн засгийн бүс” байв. Ингэхдээ Чөлөөт усан боомт нь Чөлөөт хотоосоо хөгжин гарч ирсэн ба зөвхөн Европт, ялангуяа Газар дундын тэнгисийн бүс нутгаар умраасаа Балтын тэнгис рүү дэлгэрч байсан байдаг.

б) 2-р шат: 18-р зууны дунд үеэс 1940-өөд он хүртэлх “Чөлөөт хотууд” нь “Чөлөөт боомтууд” ба “Чөлөөт худалдааны бүсүүд” болж өөрчлөгдсөн

“Чөлөөт хот”-ууд ба “Чөлөөт боомт”-ууд ба “Чөлөөт эдийн засгийн бүс”-үүд нь хөрөнгөтний бараа бүтээгдэхүүний эдийн засгийн хөгжлийн үр дүн байсан боловч эргээд феодалын ёсны тусгаар байдлыг эвдэж, худалдаа арилжааг өргөжүүлэн дэлгэрүүлснээрээ түүний хөгжилд түлхэц өгсөн юм. 18-19-р зуунд олон тооны колониуд ба Чөлөөт боомтууд эхлээд Европ ба Карибын тэнгисийн арлуудад, дараа нь Ази, Африкт байгуулагдаж эхэлжээ. 1900 он гэхэд Европ болон Латин Америкийн хооронд шууд худалдаа хөгжсөн тул Карибын бүсүүд үгүй болсон боловч ихэнх Азийн бүсүүд оршсон хэвээр үлдсэн. 19-р зууны сүүлчээс 1920-оод оныг хүртэлх “Хоёрдугаар Аж үйлдвэрийн хувьсгал” нь “Чөлөөт эдийн засгийн бүс”-үүдийг “Чөлөөт хот”-оос “Чөлөөт боомт” ба “Чөлөөт Худалдааны бүс” болж өөрчлөгдөхөд түлхэц болов. Энэ өөрчлөлтөд Хамбург гол үүрэг гүйцэтгэсэн байдаг. Бараа бүтээгдэхүүн дамжуулан өнгөрүүлэх болон үйлдвэрлэх чөлөөт боомтууд нь үндсэндээ “Хамбург загварчлал” хэмээн нэрлэж болно.

Америк дахь Чөлөөт боомтууд ба Чөлөөт худалдааны бүсүүд нь Дэлхийн I Дайны дараа үүссэн юм. 1923 онд Урагвай улс Колонид Чөлөөт Худалдааны Бүс байгуулсан бол Мексик нь өөрийн хойд хилийн Мексикали, Тижуана хэмээх хоёр хотдоо “Хилийн чөлөөт бүс”-үүдийг байгуулсан байдаг. 1934 онд АНУ-ын Конгресс өөрийн улсын дотор гадаад худалдааны бүсүүдийг бий болгохыг хууль ёсоор зөвшөөрсөн “Гадаад Худалдааны Бүсийн тухай Хууль” (“The Foreign Trade Zone Act”) баталсан байдаг. Ингээд 1936 онд Нью-Йорк хотод АНУ-ын хамгийн анхны Чөлөөт худалдааны бүс байгуулагдсан түүхтэй.

Гэхдээ эдгээр чөлөөт боомт ба чөлөөт худалдааны бүсүүд нь усан тээвэр, агуулах, савлах ба дахин экспортлох зэрэг зөвхөн худалдаа арилжааны үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байлаа. 1950 оны байдлаар АНУ-д зөвхөн 4 бүс үйл ажиллагаа явуулж байв. Тэдгээр нь Нью-Йорк, Нью-Орлеанс, Сан-Франциско, Сеаттл байв. Товчлон хураангуйлж өгүүлвээс, Чөлөөт хот, чөлөөт боомт ба чөлөөт худалдааны бүс анх газар дундын тэнгисийн бүс нутагт Умард ба Балтын тэнгисийн эргээр үүссэн ба, дараа нь Дэлхийн II дайн хүртэл Ази, Африк ба Америк тивийг хүртэл дэлгэрсэн. 1900 оны байдлаар дэлхийд ердөө л 11 (Европт 7, Азид 4) Чөлөөт боомт ба чөлөөт худалдааны бүсүүд байв. Улмаар 1940-өөд оны байдлаар, нийт 26 улс оронд 75 орчим чөлөөт боомт болон чөлөөт худалдааны бүсүүдийг байгуулаад байсан юм. Өмнөд Америк ба Карибын арлуудын Чөлөөт боомтууд ба Чөлөөт худалдааны бүсүүдийг Испани, Португал, Их Британи улсууд, харин Ази болон Африк тив дэх бүсүүдийг Их Британи ба Франц улсууд байгуулсан байдаг. Энэ үеийн чөлөөт хот ба чөлөөт боомтуудын их зонхи нь худалдаа арилжаанд суурилсан Чөлөөт эдийн засгийн бүсүүд байлаа. Зөвхөн цөөн тооны чөлөөт боомтын тусгай хэлбэр бүхий чөлөөт хотууд өнөөг хүртэл өөрсдийн статусыг хадгалж ирсэн юм. Тухайлбал, Хонгконг, Сингапур. Энэ үед “чөлөөт эдийн засгийн бүс”-үүд анх “Чөлөөт хот”-ын хэлбэртэй байгаад “Чөлөөт боомт” болж, дараа нь “чөлөөт боомт”-оос “чөлөөт худалдааны бүс” болж өөрчлөгдөн хөгжсөн байдаг. Энэ хувьсалыг илтгэх гол нэгэн жишээ бол Хамбург чөлөөт хот мөн. Тэгэхээр Чөлөөт боомт ба чөлөөт худалдааны бүс нь “Чөлөөт эдийн засгийн бүс”-ийн үүслийн анхдугаар үед хамаарна. Үүнээс гадна, бас үндэстэн дамнасан “Бүс нутгийн эдийн засгийн интеграц бүхий байгууллага” байгуулагдаж байв. Жишээлэхэд, 1930-аад оны үед Нидерланд, Бельги ба Люксембургийн хооронд “Гааль ба мөнгөний холбоо” байгуулагдаж байжээ.

2) Хоёр ба гуравдугаар үе шат: Үйлдвэрлэл, үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ-үүдийн: 1940-өөд оны сүүлчээс 1970-аад он

Дэлхийн Хоёрдугаар Дайны дараагаар дэлхийн эдийн засаг, дэлхийн улс төр ба, дэлхийн шинжлэх ухаан хийгээд техник технологийн хөгжилд асар их өөрчлөлт гарсан нь ЭЗЧБ-үүдийн хөгжилд онцгой үр нөлөө болсон юм. Чухам энэ бол ЭЗЧБ-үүд алтан үедээ хүрсэн байдаг. Олон тооны шинэ төрөл хэлбэрийн ЭЗЧБ-үүд үүссэн ба, худалдаа голлосон ЭЗЧБ-үүд шинэчлэгдэн хөгжсөн юм. ЭЗЧБ-үүдийн хөгжлийн энэ шат дотроо бас хоёр үетэй. Энэ нь:

а) 1-р шат: 1945-1959 онд Чөлөөт боомтууд/Чөлөөт худалдааны бүсүүдийн дахин зохион байгуулалт ба шинэ төрлийн ЭЗЧБ-үүд үүссэн

Дэлхийн хоёрдугаар дайны олон улс орон Чөлөөт боомтууд болон Чөлөөт худалдааны бүсүүдээ сэргээн барьж, байгуулахын сацуу шинийг үүсгэн байгуулсаар байв. Жишээ нь: Генуа, Хамбург, Роттердам, Сингапур, Хонгконг зэрэг хотуудад сэргээн барих ажил өрнөж, улмаар дахин олон улсын усан тээвэр ба худалдааны төвүүд болцгоожээ. Энэ үеийн нэгэн гол шинж бол Латин Америкийн маш олон буурай хөгжилтэй орнууд Чөлөөт боомтууд ба Чөлөөт худалдааны бүсүүдийг байгуулсан байдаг. Хонгконг гэхэд 1950-1969 оны хооронд урд олон жил явж ирсэн зөвхөн бараа бүтээгдэхүүнийг усаар тээвэрлэх үүргийг өөрчилж олон талын үйл ажиллагаа бүхий болж хөгжсөн байдаг.

Анхны Экспортын чиглэлийн бүс 1959 онд Ирландын Шаннон нисэх онгоцны буудалд байгуулагдсан байна. Энэ үед Ирландын аж үйлдвэрийн бодлого нь импортлогчоос экспортлогч болон хөгжих өөрчлөлтийн замд байв. Шаннон Экспортын үйлдвэрлэлийн бүс нь 1960-аад оны үед тус улсын экспортын чиглэлийн аж үйлдвэрийн анхдагч бөгөөд амжилттай хөгжиж буй салбар хэмээгдэж байсан байдаг. Шаннон бол 1947 онд байгуулагдсан дэлхийн хамгийн анхны гаалийн татваргүй нисэх буудал юм.


b) 2-р шат: 1960-1970-аад он: Үйлдвэрлэл ба үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ

Үйлдвэрлэлд суурилсан ЭЗЧБ-үүд нь худалдаанд суурилсан ЭЗЧБ-үүдийг цаашид боловсруулан хөгжүүлсэн хэлбэр мөн.

3) 4 ба 5-р үе шат: 1970-1980-аад онд ШУ-нд суурилсан ба бүрэн ЭЗЧБ-үүд

Дэлхийн улс төр ба эдийн засгийн хөгжил хийгээд технологийн хувьсгалыг дагалдан ЭЗЧБ-үүд нь үйлдвэрлэл ба үйлчилгээнд суурилсан “Экспортын үйлдвэрлэлийн бүсийн хэлбэрээс шинжлэх ухаанд суурилсан ЭЗЧБ буюу шинжлэх ухаанд суурилсан аж үйлдвэрийн парк гэх мэт хөгжсөн нь ЭЗЧБ-ийн 4-р үе, харин бүрэн ЭЗЧБ болж хөгжсөн нь 1970-аад оноос эхэлсэн 5-р үе байлаа.

Зураг 4. ЭЗЧБ-үүдийн Аж үйлдвэрийн бүтэц ба хувьсалын шатанд суурилсан хөгжлийн үе шатууд



4) Зургадугаар үе шат: 1990-ээд оноос хойших Хил дамнасан ЭЗЧБ-үүд

Сонгодог ЭЗЧБ-үүд олон тоогоор байгуулагдахын хэрээр Дэлхийн Эдийн Засгийн Интеграцийг дэмжиж, дотоодын (ЭЗЧБ) болон дэлхийн эдийн засгийн хоорондох эдийн засгийн харилцааг улам бүр өргөжүүлэн, гүнзгийрүүлж иржээ. Дэлхийн эдийн засгийн интеграцилал нь ч эргээд сонгодог ЭЗЧБ-үүдийн хувьсал хөгжилд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлсэн байдаг.

ЭЗЧБ ба “Бүс нутгийн чөлөөт бүс”-ийн хоорондох ЭЗЧБ-ийн шинэ шилжилтийн хэлбэр болох “Хил дамнасан чөлөөт эдийн засгийн бүс” хэмээх шинэ ойлголт, үзэл баримтлалыг эдийн засагчид болоод газарзүйчид аажмаар хүлээн зөвшөөрдөг болж эхэлсэн юм. “Хил дамнасан чөлөөт эдийн засгийн бүс” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш тооны улс орон буюу нутаг дэвсгэрүүд хил дамнасан тусгай нутгийг сонгож, тэндээ хамтын ажиллагаа ба байгууллагын тогтолцоог хангах дээд түвшний засаглалын бүтцийг бий болгодог. Тухайн бүсийн засаг захиргаа ба томоохон бизнесийн байгууллагуудын гол үүрэг хариуцлага нь зах зээлийн эдийн засгийн үндсэн дээр эдийн засгийн хамтын ажиллагаа ба эдийн засгийн хөгжлийг цогцлоох явдал мөн. Тухайн бүс нь харилцан адилгүй өөр өөр түвшний засаг захиргаа ба байгууллагуудаас санал болгодог эдийн засгийн маш таатай бодлогууд ба санхүүгийн дэмжлэг, басхүү макро эдийн засаг ба улс төрийн хэтийн зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс нарийн сайн дэд бүтэц зэргээр хангагдсан байна.

ЭЗЧБ-үүдийн бүтэц ба орон зайн хувьсалын загвар

Нэг талдаа, ЭЗЧБ-үүд нь эдийн засаг ба улс төрийн зорилтуудыг хэрэгжүүлэх хэрэгсэл болж байв. Нөгөө талд, дэлхийн эдийн засаг, улс төрийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн дэвшил нь ЭЗЧБ-үүдийн өөр өөр цаг үеийн хувьсалд нөлөөлөх, эс бөгөөс тэрхүү хувьсалыг тодорхойлох болно. ЭЗЧБ-үүдийн хувьсалыг байршил, орон зайн хэмжээс, зорилт, үүрэг ба үйл ажиллагаа, эдийн загийн сектор, таатай бодлого, захиргааны загвар гэх зэрэг маш олон өөр өөр хүчин зүйлсээр тодорхойлдог. ЭЗЧБ-үүдийн хөгжлийн өөр өөр үеүдийг шинжлэн үзэхэд, ЭЗЧБ-ийн хувьсал хөгжлийн шинж чанаруудыг энэ хэсэгт хураангуйлан өгүүлж болно.


ЭЗЧБ-үүдийн дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг роль ба зорилтууд

Харилцан адилгүй өөр тооцоо судалгааны дүнгүүдээс үзэхэд, дэлхийн янз бүрийн хэлбэрийн ЭЗЧБ-үүдийн тоо цаг ямагт өсөн нэмэгдэж ирсэн байдаг. 1900-аад оны үед Европ болон Азийн цөөн хэдхэн улс оронд л нийт 11 “Чөлөөт боомт” байсан бол 1975 он гэхэд буурай хөгжилтэй 25 оронд нийт 79 орчим Экспортын чиглэлийн бүсүүд үйл ажиллагаа явуулах болжээ. Ингээд 1986 оны байдлаар үзэхэд энэ тоо 47 улс оронд 176 болж өссөн байдаг. 2000-аад оны судалгаагаар үзэхэд, 1990-ээд онд дэлхийн 90 орон ба нутаг дэвсгэрт янз бүрийн хэлбэрийн 1000 гаруй ЭЗЧБ-үүд үйл ажиллагаа явуулж байсан байна. Ойрын үеийн тооцоогоор бол, 1979 онд бүх ЭЗЧБ-үүдийн дэлхийн нийт худалдаанд эзлэх хэмжээ 7.7 хувь байснаас 1985 онд 20 хувь, 1990-ээд оны эхээр бараг 30 хувь болж өсчээ. Өөрөөр хэлбэл, ЭЗЧБ-үүдийн тоо асар ихээр нэмэгдсэн ба, 1500-аад оноос хойш тэдгээр нь дэлхийн, улс орны, бүс нутгийн эдийн засагт улам бүр чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн аж. Энэ үүрэг роль нь микро эдийн засгаас макро эдийн засаг руу, эдийн засгийн шинэчлэлээс улс төрийн шинэчлэл рүү урван өөрчлөгдөж хөгжсөөр ирсэн юм.

ЧЭЗБ нь зарим тодорхой эдийн засгийн, нийгэм, улс төрийн зорилгуудыг хэрэгжүүлэх хэрэгсэл болж байлаа. Зорилт бол ЧЭЗБ-үүдийн нэгэн гол түлхүүр шинж чанар бөгөөд хөдөлгөгч хүчин болж байв. Зорилтыг цаашид микро болон макро, ерөнхий болон тусгай хэмээн ангилж болох ба, аажмаар эдийн засгийнхаас нийгэм, улс төрийн түвшин рүү хувьсан байдаг. Ерөнхийдөө, ЧЭЗБ-үүд микро эдийн засгийн зорилтуудын хувьд илүүтэй

ижил төстэй байдаг боловч макро эдийн засгийн зорилтуудын хувьд нэг нь нөгөөгөөсөө ялгаатай байдаг байна. Тэдгээр зорилтууд нь шууд микро эдийн засгийнхаас шууд бус макро эдийн засгийн зорилтууд болж хувьсах ба, эс бөгөөс эргээд худалдаа суурилсан ЧЭЗБ-ийн микро ба макро эдийн засгийн зорилтууд нь түүнийг цаашид бүрэн бөгөөд хил дамнасан ЧЭЗБ болгон хувьсгадаг байна. Ийм бүрэн бөгөөд хил дамнасан ЧЭЗБ нь олон зүйл зорилтууд ба илүүтэй макро эдийн засгийн зорилтуудтай байдаг байна. Микро зорилтууд нь худалдаа, экспорт, ажил эрхлэлт, гадаад арилжааг бий болгох, илүү дэвшингүй технологи нэвтрүүлж, боловсон хүчнийг бэлтгэх боломж бүхий гадаад мөнгө, хөрөнгө оруулалтыг татах зэргээс хувьсан гарч ирдэг байхад, мазро зорилтууд нь бүтцийн шинэчлэл бүхий бүс нутгийн хөгжил дэвшил, бүс нутгийн эдийн засгийн хатын ажиллагаа, интеграц зэргээс хувьсан гарч ирдэг байна. ЧЭЗБ-ийн эцсийн зорилго бол “Бүс нутгийн эдийн засгийн интеграц” юм. ЭЗЧБ-үүдийн зорилтын өөрчлөлтийг зураг 5-аас үзнэ үү.

Зураг 5. ЭЗЧБ-үүдийн зорилтын хувьсал



ЭЗЧБ-үүдийн таатай бодлого


Зарим тодорхой зорилтуудад хүрэх үүднээс, ЭЗЧБ-үүдийг тусгайлан сонгосон бүсэд байгуулж, дэд бүтэц сайтай бөгөөд таатай бодлогоор буюу хууль, тогтоомжоор хангагдсан зэрэг хөрөнгө оруулалтын тогтвортой бөгөөд ашигтай орчныг бүрэлдүүлж өгдөг. Түүний хувьсал өөрчлөлт нь тухайн улс үндэстний болон олон улсын эдийн засгийн хөгжил, тэрчлэн ЭЗЧБ-үүдийн зорилтууд ба тэдгээрийн хөгжлөөр тодорхойлогддог юм.

Тухайлсан нэг ЭЗЧБ-ийн тухайд, ямар нэг таатай бодлогыг боловсруулан хөгжүүлж болох ба, тэр нь алсдаа хууль, тогтоомж болон журамлагдах, аль эсвэл тухайн бодлого нь зөвхөн нэг бүс нутгийн чиглэлээсээ бүс нутаг ба аж үйлдвэр хосолсон чиглэлийн болон өргөжиж болох юм. ЭЗЧБ нь өөрийн гэсэн засаг захиргааны хууль, тогтоолтой, мөн эдийн засгийн хууль тогтоомжуудтай (худалдааны, бараа бүтээгдэхүүний хяналтын, хөрөнгө оруулалтын, санхүүгийн, худалдааны маргааны тухай гэх зэрэг хуулиудтай) ба эдийн засгийн онцгой таатай нөхцөл ба боломж (таатай бодлого) бүхий байна. Эдийн засгийн хууль, тогтоомжууд нь ЭЗЧБ-үүдийн таатай бодлого ба боломж нөхцөлүүдийг бодитой, тодорхой болгож өгдөг. Хууль журамтай харьцуулахад, бодлого бол абстракт хийсвэр бөгөөд ерөнхий зарчмууд бүхий байдаг тул тэр нь илүүтэй уян хатан бөгөөд

өөрчилж болохуйц байдаг. ЭЗЧБ-үүдийн хөгжилтэй уялдан, бодлого нь практик үйл ажиллагааны явцад хууль болдог. Түүнийг “бодлого-практик-хууль” гэж нэрлэдэг. Гэхдээ хөгжилтэй орнуудын хуучны “Чөлөөт боомт” ба “Чөлөөт худалдааны бүс”-үүд зэрэг ЭЗЧБ-үүдэд хууль, тогтоомжуур, эсвэл хууль тогтоомж ба таатай бодлогын аль алианаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Олон ЭЗЧБ-ийн хууль, тогтоомжуудыг анхны Чөлөөт боомт болох Лейпхорн гэх зэрэг зарим хуучны Чөлөөт боомтуудаас олж үзэж болно.

Ерөнхийдөө, таатай бодлого нь ЭЗЧБ-үүдийн чухал бөгөөд анхны үе шат мөн тул ЭЗЧБ-үүдийн хууль тогтоомжуудыг төлөөлөн илэрхийлэх боломжтой юм.

Зураг 6. ЭЗЧБ-үүдийн таатай бодлогын хувьсал



Таатай бодлогын агуулга ба түвшин нь ЭЗЧБ-үүдийн худалдаанд суурилсан хэлбэрээс Бүрэн бөгөөд Хил дамнасан ЭЗЧБ болон хөгжих хувьсалыг баяжуулан өргөжүүлж байдаг юм. Энэ нь худалдаа арилжаанаас цаашид үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, захиргааны болон нийгмийн, тэр бүү хэл улс төрийн салбар болж өргөждөг байна. Үүнээс гадна, таатай бодлого нь бас цаашид гадаадын хөрөнгө оруулагчдыг ЭЗЧБ-үүдийн дотор болон гадна татах улс үндэстний менежмент гэх зэргээр ЭЗЧБ-үүдийн гаднах бүс нутгууд руу хүртэл өргөжин тэлдэг байна. Үүний дээр маш сайн интеграцлагдсан бүс нутагт бол ЭЗЧБ-үүд нь Чөлөөт худалдааны бүс, Гаалийн холбоо, Нэгдсэн зах зээл гэх мэт зарим төрлийн бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн орох ба, таатай бодлого нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийн үндсэн зарчим ба нэгдсэн эдийн засгийн бодлого болж хувирах буюу түүгээр солигддог байна. Гэхдээ зарим ЭЗЧБ-үүдийн “Бүс нутгийн эдийн засгийн интеграц”-ийн хэлэлцээрийн гадна байна хэмээн үзсэн хэвээр байдаг тохиолдол бий. Жишээлбэл, Европын Холбоо ЭЗЧБ нь Европын Холбооны нэгдсэн гаалийн тогтолцооны нэг хэсэг мөн хэмээн үзэх боловч ЭЗЧБ-ийн доторх гуравдагч орнуудыг оролцуулан бүх бараа бүтээгдэхүүнийг Европын Холбооноос ангид гадуур гэж шийдвэрлэсэн байдаг. Тэгэхээр, сайтар интеграцлагдсан бүс нутаг дахь ЭЗЧБ-үүд нь өнөө хэр нь чөлөөт худалдааны хөгжил ба “Бүс нутгийн эдийн засгийн интеграц”-члалыг сурталчлан дэмжих үүрэг бүхий байсаар байгаа юм.

ЭЗЧБ-үүдийн захиргааны бүтэц


Амжилттай сайн ЭЗЧБ нь хариуцлага өндөртэй, маш их үр дүнтэй, уян хатан, сайтар төлөвлөгдсөн алс хэтийн зорилт ба ашиг сонирхолтой, захирагч ба зохицуулагчтай, бүсийн дотроо эдийн засаг ба нийгмийн үйл ажиллагааг улс үндэстнийхээ засгийн газартай нягт хамтын ажиллагаагаар хөгжүүлдэг засаглалын бүтэцтэй байдаг.

Тэгэхээр ЭЗЧБ-ийн үзасаг захиргааг бий болгож, ажиллуулах нь тус бүсийн захиргааны байгуулалтын үндсэн зорилт юм.

Хэдийгээр ЭЗЧБ-үүдийн эдийн засгийн ажиллагаанд ерөнхийдөө засгийн газрын оролцоо саадгүй, улс төрийн хатуу хяналтгүй байгаа боловч бүсүүд нь бүгд их, бага ямар нэг хэмжээгээр олон улс, улс үндэстэн ба бүс нутгийн засаг захиргааны харъяа, засаглалын хамааралтай байхын тулд төрийн нөлөөнөөс бүрэн дүүрэн ангид хараахан биш юм. Ихэнх ЭЗЧБ-үүдийг захиргааны дөрвөн түвшинд ангилан үзэж болно: Улс үндэстэн хоорондын түвшний байгууллага бол ЭЗЧБ-үүдийн үндэстэн дамнасан эдийн засаг, нийгэм, улс төрийн хамтын ажиллагааг хариуцна. Харин улс үндэстний захиргааны тогтолцоо бол ЭЗЧБ-үүдийн хууль, эрх зүй ба удирдлага гэх зэрэг макро түвшний шийдвэрийг гаргах асуудлыг хариуцна. Бүс нутгийн захиргааны тогтолцоо нь, тодорхой хэлбэл, мужийн, улсын болон аймгийн түвшний шийдвэрийг муж нь ЭЗЧБ-үүдийн эдийн засаг ба нийгмийн хэргийг засаглан удирдана. Гэхдээ ЭЗЧБ-үүдийн захиргаа өөрөө өөрийнхөө эдийн засаг ба нийгмийн үйл ажиллагааг хариуцна. ЭЗЧБ-үүдийн захиргаанд засгийн газар ба аж ахуйн нэгжийн чиглэлийн загвар, холимог ба тусгаар загвар, захиргааны нэгжийн загвар, хил дамнасан захиргааны загвар зэрэг багтана.

ЭЗЧБ-үүдийн захиргааны загварын хувьсал өөрчлөлт нь төрөл бүрийн ЭЗЧБ-үүд ба бүс нутаг, улс үндэстэн хийгээд олон улсын эдийн засгийн хөгжил ба бодлогуудтай холбоотой. Нэгдүгээрт, ЭЗЧБ-үүдийн захиргааны загвар нь улс үндэстнийхээс бүс нутгийн ЭЗЧБ-ийн түвшинд хувьсдаг. Учир нь ЭЗЧБ бол эхлээд тухайн улс орны үйл хэрэг, дараа нь орон нутгийн засаг захиргааны хэрэг явдал байдагт оршино. Хоёрдугаарт, ЭЗЧБ-ийн засаг захиргаа нь засгийн газрын, аж ахуйн нэгжийн ба эдгээр хольмог чиглэлээс засаг захиргааны нэгжийн загвар руу хувьсдаг. ЭЗЧБ байгуулах нь засгийн газрын шийдвэр мөн тул төв засгийн газар, орон нутгийн захиргаа, орон нутгийн боомт ба, орон нутгийн гаалийн захиргааны тушаал шийдвэр ба зөвшөөрлөөр эхлэнэ. Буурай хөгжилтэй орнууд эхэндээ засгийн газрын дэмжлэгтэй буюу чиг баримжаатай загварыг сонгон хэрэглэдэг байсан боловч ЭЗЧБ-үүдийнхээ хөгжил ба улс төр, эдийн засгийн шинэчлэлд олсон ахиц амжилтын дүнд эдүгээ зах зээлийн эдийн засгийн хөгжилтэй хөл нийлүүлэхийн тулд аж ахуйн нэгжийн чиг баримжаатай, аль эсвэл холимог загварт илүүтэй анхаарах болжээ. Үүний дээр, олон ЭЗЧБ-үүд (бүрэн ЭЗЧБ-үүд) нь захиргааны нэгж ба ЭЗЧБ-ийн хосолсон загвар бүхий байх болжээ. Гуравдугаарт, хил дамнасан ЭЗЧБ үүссэнтэй холбоотойгоор “Хил дамнасан захиргаа”-ны загвар бий болсон байдаг. Учир нь “хил дамнасан ЭЗЧБ”-ийг нэг улс дангаараа захирч чадахгүй. Тиймээс, түүнийг хоёр буюу түүнээс дээш тооны улс орон ЭЗЧБ ба “Бүс нутгийн эдийн засгийн интеграц”-ийн шинж чанар бүхий хил дамнасан захиргааны загварыг бий болгодог. Эцэст нь, улс үндэстний захиргааны тогтолцоо ба хил дамнасан захиргааны загвар нь дэлхийн бүс нутгийн интеграцийн үндэстэн дамнасан байгууллага руу хувьсан хөгждөг.

Зураг 7. ЭЗЧБ-үүдийн захиргааны загварын хувьсал



II. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрх зүйн орчны өнөөгийн байдал

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хувьд Эдийн засгийн чөлөөт бүс /ЭЗЧБ/ болон түүнтэй холбоотой аливаа харилцааг зохицуулах салбарын гол хууль нь 2002 онд Улсын Их Хурлаас баталсан Чөлөөт бүсийн тухай хууль байна. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй Худалдааны болон Эдийн засгийн чөлөөт бүс тус бүрийн эрх зүйн байдлын тухай хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмуудаас чөлөөт бүсийн эрх зүйн орчин бүрдэж байна. Үүнд:

Бодлогын баримт бичиг:

- 1) Монгол Улсад ЭЗЧБ байгуулах үзэл баримтлал²⁶

Хууль:

- 1) Чөлөөт бүсийн тухай хууль
- 2) “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль
- 3) “Замын-Үүд” ЭЗЧБ-ийн эрх зүйн байдлын тухай хууль
- 4) “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль

Журам:

- 1) Чөлөөт бүсэд шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулах журам
- 2) Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн бүртгэлийн журам
- 3) Чөлөөт бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журам
- 4) Чөлөөт бүсэд виз олгох хялбарчилсан журам
- 5) Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам гэсэн цогц эрх зүйн орчин бүрдсэн мэт харагдаж байна. Үүнээс Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид анализ хийн, гарсан үр дүнг тус судалгааны ажилд сонгон авсан бусад улс орны эрх зүйн орчинтой харьцуулан судлахыг зорив.

Эрх зүйн орчны шинжилгээг хийхдээ чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой аливаа харилцааг бүлэглэн, тухайн асуудлыг хэрхэн зохицуулсан талаар тоймлон судалж, тухайн зохицуулалт эцсийн зорилгоо хангаж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийх зарчмаар гүйцэтгэнэ. Бүлэглэлт нь дараах байдлаар ангилагдана. Үүнд:

²⁶Засгийн газрын 1995 оны 87 тушаалын хавсралтаар.

- Чөлөөт бүс /ЧБ/-ийн хэлбэр
- ЧБ дэх тусгай дэглэм
- ЧБ-ийн удирдлага
- ЧБ-ийн санхүүжилт буюу төсөв
- ЧБ-д аж ахуй эрхлэх
- Бүртгэл
- Татварын хөнгөлөлт чөлөөлөлт
- ЧБ үүсгэн байгуулах, зохион байгуулах, татан буулгах

зэрэг асуудлыг хуулиар хэрхэн зохицуулсныг доорх хүснэгтээр үзүүлэв.

Харилцаа	Зохицуулалт
Тодорхойлолт	“Чөлөөт бүс” гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.
ЧБ-ийн хэлбэр	<ul style="list-style-type: none"> - Худалдааны - Үйлдвэрлэлийн - Хөдөө аж ахуйн - Аялал жуулчлал-үйлчилгээний - Эдийн засгийн
ЧБ дэх тусгай дэглэм	<ul style="list-style-type: none"> - Татварын хөнгөлөлттэй нөхцөл, аж ахуйн нэгж (ААН)-ийн бүртгэлийн хөнгөвчилсөн журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим үйлчилнэ. - Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг ЧБ-д зөвхөн гаалийн хяналт бүхий гарцаар нэвтрүүлнэ. - Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг ЧБ-д нэвтрүүлэхийг хориглоно. - Хилийн чанадаас ЧБ-д оруулах, ЧБ-ээс хилийн чанадад гаргах бараанд тарифийн бус хязгаарлалт тогтоохгүй. - Төлбөр тооцоогүндэсний болон гадаад валютаар хийнэ. ЧБ-д валютын зохицуулалтын тусгай журам үйлчилнэ. Валютын зохицуулалтын журмыг Монголбанк тогтооно.
ЧБ-ийн удирдлага	<p>ЧБ-ийн захирагч: Захирагч нь ЧБ-д төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн. Захирагчийг эдийн засгийн хөгжлийн сайд томилж, чөлөөлөх ба ажлаа эдийн засгийн хөгжлийн сайдын өмнө хариуцна. Захирагч ажлын албатай байна. Ажлын албаны орон тооны болон зардлын хязгаарыг Засгийн газар тогтооно. Дараах бүрэн эрхийг эдэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - ЧБ-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ЧБ-ийг төлөөлөх, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах; - ЧБ-ийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах; - ЧБ-д хөрөнгө оруулах, үйл ажиллагаа явуулах ААН, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх; - ЧБ-ийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх - ЧБ-ийн ажиллах хүчний болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх; - ЧБ-д ажиллаж байгаа ААН, байгууллагын аж ахуйн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх хүсэлтийг хянан шийдвэрлэх; - ЧБ-д олгосон газар, төрийн өмчийн барилга, байгууламжийг ашиглуулах тухай шийдвэр гаргаж, тэдгээрийн ашиглалтад тавих хяналтыг хэрэгжүүлэх; - ЧБ дэх мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; - ЧБ-ийн ерөнхий менежерийг томилох, чөлөөлөх; - Иргэн, ААН, байгууллагад ЧБ-ийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох; - ЧБ-д хөрөнгө оруулагчдын зөвлөл, хувийн хэвшлийн байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах, <p>ЧБ-ийн ерөнхий менежер /ЕМ/: Энэ нь ЧБ-д аж ахуйн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан мөн. ЕМ нь ЧБ-ийн нийгэм, соёл, ахуйн үйлчилгээ, хот тохижилт, газар зохион байгуулалтын асуудлыг хариуцах бөгөөд эдгээр арга хэмжээг хөрөнгө оруулагчдын зөвлөл, нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ. ЕМ нь ажлаа Захирагчид тайлагнаж, ЧБ дэх хөрөнгө оруулагчдын Зөвлөлд хуульд заасан 3 чиглэлээр танилцуулна.</p> <p>Мэргэжлийн хяналтын алба: Энэ нь бие даасан алба байна. Тус албаны орон тооны хязгаар зохион байгуулалтыг ЧБ-ийн хэлбэр, байршил, үйл ажиллагааны онцлогоос хамааруулан Засгийн газар тогтооно.</p> <p>Хөрөнгө оруулагчдын Зөвлөл: Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтыг татах, ЧБ-ийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн хөрөнгө оруулагчдын зөвлөл /цаашид “чөлөөт бүсийн зөвлөл” гэх/-тэй байж болно. Зөвлөлийн хурлаар баталсан дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.</p>

Бүртгэл	<p>Бүртгэлийн шалгуур:</p> <ul style="list-style-type: none"> - ЧБ-д эрхлэх, татварын хөнгөлөлтөд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ нь тухайн ЧБ-ийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлд нийцэх - ЧБ-д эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь үндэсний болон олон улсын стандартад нийцсэн дэвшилтэт арга, технологи эзэмших - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулах. - ЧБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх ААН нь Захирагчийн ажлын албанд бүртгүүлэхээр холбогдох бичиг баримтыг өгнө. - ААН-ийн зохион байгуулалтын хэлбэр, оноосон нэр, оршин байх газар, улсын харьяалал, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, хэмжээ, хөрөнгө оруулах үндсэн чиглэл, эрхлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх хугацаа, үе шатыг заасан эрх бүхий этгээдийн өргөдөл - Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол ААН-ийн гэрчилгээний хуулбар, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; - Үүсгэн байгуулагч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, товч намтар - Шаардлагатай бол аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл - Гэрээ, дүрэм - Шинээр байгуулах ААН-ийн хувьд оноосон нэрийн зөвшөөрөл <p>Захирагч өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт шийдвэрлэнэ.</p>
ЧБ-ийн санхүүжилт буюу төсөв	<p>ЧБ бие даасан төсөвтэй байна. Төсвийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу улсын төсвийн тусгай зүйл болгон УИХ батална. ЧБ-ийн төсвийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> - ЧБ дэх ААН, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж; - ЧБ-ийн эзэмшлийн газар, байгалийн баялаг, төрийн өмчийн барилга, байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр - ЧБ байгуулахад зориулж улсын болон орон нутгийн төсвөөс ЧБ-ийн төсөвт хуваарилсан төсвийн санхүүжилт; - ААН, байгууллага, иргэний тусламж, хандив; - ЧБ-ийн төсөвт орох бусад орлого. <p>Төсвөөс дараах зардлыг санхүүжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - урсгал зардал; - бусдад үзүүлэх үйлчилгээний зардал; - ЧБ-ийн харуул хамгаалалтын зардал; - мэргэжлийн хяналтын албаны зардал.
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт	<p>Бараа оруулахад дараах албан татварыг ногдуулахгүй:</p> <ul style="list-style-type: none"> - ЧБ-д барааг хилийн чанадаас оруулахад импортын гаалийн, НӨАТ болон онцгой албан татвар ногдуулахгүй - Импортын гаалийн, онцгой болон НӨАТ төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг ЧБ-д оруулахад экспортын гаалийн албан татвар ногдуулахгүй. <p>Татвар ногдуулах, Буцаан олгох:</p> <ul style="list-style-type: none"> - Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс ЧБ-д оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, НӨАТ-ыг буцаан олгоно. <p>Бараа гаргахад дараах албан татварыг ногдуулах болон албан татвараас чөлөөлнө:</p> <ul style="list-style-type: none"> - барааг ЧБ-ээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулна; - барааг ЧБ-ээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад дараах татвар ногдуулахгүй: - импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. - Монголын барааг буцаан оруулахад импортын гаалийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Энэ тохиолдолд экспортын гаалийн татварыг буцаан олгож, нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулна. - барааг хилийн чанадад гаргахад экспортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Хуулиар тусгайлан ногдуулсан бол экспортын албан татвар ногдуулна. - бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх асуудлыг ЧБ-ийн байршил, хэлбэрийг харгалзан хуулиар тогтооно. - ЧБ-д газар ашиглах, эзэмших гэрээ байгуулсан дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, эзэмших, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлөх буюу чөлөөлж болно. - газрын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх хугацаа, хувь хэмжээ тогтоох асуудлыг Засгийн газрын санал болгосноор УИХ шийдвэрлэнэ.

ЧБ үүсгэн байгуулах	Тусгааргүй
Зохион байгуулах	Тусгааргүй
Татан буулгах	Тусгааргүй
Хөгжлийн төлөвлөгөө	Тусгааргүй
Бүтээн байгуулалтын төлөвлөгөө	Тусгааргүй
Төлөвлөгөө өөрчлөх	Тусгааргүй
ЧБ-ийн сан, ашиглалт	Тусгааргүй
ЧБ-ийн өмчийн хэлбэр	Төрийн өмч
ЧБ дэх амьдралын нөхцөл	Тусгааргүй
ЧБ дэх иргэншил	Тусгааргүй
ЧБ дэх үл хөдлөх хөрөнгө өмчлөл, ашиглалт	Тусгааргүй

Монгол Улс дахь чөлөөт бүсийн харилцааг зохицуулсан гол хуулийн зохицуулалтыг дээр хүснэгтлэхдээ мөн чөлөөт бүсийг амжилттай хэрэгжүүлсэн зарим орнуудын /тус судалгаанд хамруулсан, 3-р бүлгээс үзнэ үү/ хуулинд заасан бусад зохицуулалт Монгол Улсын холбогдох хуульд тусгалаа олсон эсэхийг үзэх зорилгоор манай улсын хуульд тусгагдаагүй асуудлыг ч хүснэгтийн эхний баганад оруулав.

Түүнчлэн манай улс зарим орны нэгэн адилаар /судалгаанд хамрагдсан орнуудаас БНХАУ-аас бусад нь /“Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын чөлөөт бүсүүдэд тус бүрчлэн бие даасан хууль баталсан хэдий ч чөлөөт бүсийн хөгжил, түүнийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, амьдралын нөхцөлийн талаар ямар ч зохицуулалт хийгээгүй байна. Энэ нь үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүд ашиггүй ажиллах, үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн чөлөөт бүс нь үйл ажиллагаагаа бүрэн эхэлж чадахгүй байгаа зэрэгт нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна. Сайн туршлага бүхий улс орны хувьд хуулиндаа дээр дурдсан асуудлуудыг цогцоор нь тусгасан байна. Тэрчлэн БНСУ-ын хуулинд “хэрэв чөлөөт бүс байгуулах шийдвэр гарч, төлөвлөгөө батлагдсан бол батлагдсанаас 1 жилийн дараа эхлэх ёстой” гэж хуульчилсан нь цаг хугацааны тухайд бүтээн байгуулалтын ажил хийхэд нэн тохиромжтой зохицуулалт болж байна.

Энэ мэтчилэн тус судалгаанд харьцуулан судалсан 10 орны /3-р бүлгээс үзнэ үү/ эрх зүйн зохицуулалт болоод туршлагаас харахад манай улсын чөлөөт бүсийг бий болгох, хөгжүүлэх асуудалд цогц шинэчлэл шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, татвар, гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллын асуудалд анхаарал хандуулахаас илүүтэйгээр чөлөөт бүс үүсгэн байгуулах болон түүнийг дагасан хотжилт, бүтээн байгуулалтын, газар зохион байгуулалтын, газрын доорх бөгөөд газар дээрх байгууламжийн, бүсэд оршин суугчдын ажил эрхлэлт, амьдрах орчин, боловсрол, эрүүл мэндийн цогц үйлчилгээ, бүсийн өөрийгөө санхүүжүүлэх чадвар боломж, өөрийн санхүүжилтээс бүс өөрийгөө хөгжүүлэх боломж, бүсийн менежмент зэрэг бүхий л асуудлыг цогцоор шийдэх эрх зүйн болон бүтцийн тогтолцоо бий болгох шаардлагатай гэдэг нь тодорхой байна. Энэ тал дээр БНТурк улс, БНСУ, БНКаЗУ зэрэг нарийвчлан судалбал зохилтой сайн туршлага бүхий улс орон цөөнгүй байна.

III. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Эдийн засгийн онцгой бүсийн хөгжил

1980-аад оны II хагас: Хуучин Зөвлөл улсад 1980-аад оны сүүлээр ЭЗЧБ байгуулах тухай идэвхтэй яригдаж, анх тухайн үеийн төр засаг Приморийн хязгаар болон Ленинград мужийн удирдлагын “Находка”, “Выборг” гэсэн ЭЗЧБ-ийг байгуулах тухай саналыг дэмжиж баталжээ.

Гадаад улсуудад байгуулсан ЭЗЧБ-үүдийн үйл ажиллагаа нь сайн үр дүнтэй, гадаадын хөрөнгө оруулагчид нь нэмэгдэж, үйлдвэрлэл нь хурдацтай хөгжих болсон нь Оросын янз бүрийн мужуудаас ЭЗЧБ байгуулах санал ирэх болсонтой холбоотой.

Тухайн үед ихэнх бүсүүдийг эрдэс баялгийн нөөц олборлох, боловсруулах чиглэлээр ажиллах санал ирж байсан боловч хангалттай хөрөнгө мөнгө дутмаг, эрх зүйн орчин бүрдээгүй байжээ. Тийм учраас бүс нутгуудын удирдлага нутаг дэвсгэртээ ЭЗЧБ-ийг байгуулахад өөрсдийн хүчин чадал болон гадаадын хөрөнгө оруулалтад найдахгүйгээр холбооны засгийн газар тэднийг хөрөнгө мөнгөөр хангах ёстой хэмээн үзэж байсан. Ингэхдээ бүсийн эхэн үеийн хөрөнгө оруулалтын тухай яригдаагүй, аж үйлдвэрлэл болон тухайн үед сулхан хөгжсөн нийгмийн хөгжлийн санхүүжилтийг шаардаж байсан. Энэ үед тус улсын нутаг дэвсгэрт 100 орчим ЭЗЧБ байгуулагдсан, ингэхдээ тухайн үеийн төсөвт хүнд дарамт болж байжээ.

1990-1991 он: ЭЗЧБ-ийн хөгжлийн 2-р шатанд энэ салбартай холбоотой харилцааг зохицуулах хэд хэдэн эрх зүйн баримт бичгүүд батлагдсан. Тэдгээрийн нэг нь 1991 онб 9-р сард хүчин төгөлдөр болсон ЗСБНХУ-д гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэг бүлэг нь ЭЗЧБ-ийн харилцааг зохицуулах болсон. Хуулиар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, гадаадын тэргүүлэх техник, технолог, удирдах туршлага зэргийг нэвтрүүлэх, экспортын хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилгоор ЭЗЧБ-ийг байгуулахыг заасан. Гадаадын хөрөнгө оруулагч, оролцогчдод зориулж хөнгөлөлтүүдийг санал болгож, бүртгэлтэй холбоотой процессыг хялбаршуулсан байна.

1992-1994 он: ЭЗЧБ-ийн хөгжлийн энэ үед нэг асуудал ойлгомжтой болсон: чөлөөт бүсийг олон тоогоор байгуулах нь амьдрал дээр тэр болгон амжилттай хэрэгжихгүй болсон. Эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдал, ЭЗЧБ-ийг байгуулах үеийн хөрөнгө оруулалт байхгүй зэрэг олон асуудлуудаас төлөвлөсөн олон төслийг хэрэгжүүлж чадаагүй. Энэ бүхнээс үүдэн Орост ЭЗЧБ-ийн тухай хуулийг боловсруулж эхэлсэн, хэрэгжиж байсан эрх зүйн баримт бичгүүдийг сайжруулж эхэлсэн, байгуулагдсан бүсүүдээс газар зүйн таатай байршилтай, дэд бүтцийн зардал хамгийн багаар гаргах бүсийг сонгон, төрөлжүүлж эхэлсэн. Тухайлбал, Холбооны ач холбогдол бүхий дотоод худалдааны бүс, гаалийн чөлөөт бүс, шинжлэх ухаан-техникийн бүс, аялал жуулчлалын бүс, мөн эдийн засгийн тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бүс гэж төрөлжих болсон.

1995-2005 он: Энэ үеэс ЭЗЧБ-үүдийг хууль баталж Эдийн засгийн онцгой бүс /ЭЗОБ/-үүдийг байгуулж эхэлсэн. Тухайлбал, Калининград мужийн эдийн засгийн онцгой бүсийн тухай, Магаданск мужийн эдийн засгийн онцгой бүсийн тухай холбооны хуулиуд батлагдан гарсан.

2006 оноос хойш: 2005 онд ОХУ дахь эдийн засгийн онцгой бүсийн тухай хууль²⁷ батлагдсан.

Хууль, эрх зүйн зохицуулалт

Эдийн засгийн онцгой бүс /ЭЗОБ/ бол ОХУ-ын Засгийн газраас тогтоосон, үйлдвэрлэл явуулах онцгой дэглэмтэй, мөн гаалийн чөлөөт бүсийн гаалийн хяналт үйлчилдэг ОХУ-ын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ хэмээн ОХУ дахь эдийн засгийн онцгой бүсийн тухай хуульд томьёолсон байна.

2005 онд батлагдсан ОХУ дахь эдийн засгийн онцгой бүсийн тухай хууль²⁸ нь бүтцийн хувьд 9 бүлэг, 41 зүйлтэй. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: ЭЗОБ-тэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хуульд хэрэглэгдэж буй үндсэн нэр томьёонуудын тодорхойлолт, ЭЗОБ байгуулах зорилго, төрлүүд, байгуулах нөхцөл, татварын харилцаа.
- 2-р бүлэг - ЭЗОБ байгуулах, татан буулгах: ЭЗОБ байгуулах, татан буулгах, төсвийн хөрөнгөөр дэд бүтэц барихад хөрөнгө оруулах.
- 3-р бүлэг - ЭЗОБ-ийн захиргаа: ЭЗОБ-ийн захиргааны байгууллагыг байгуулах, түүний эрх, үйл ажиллагаа, ЭЗОБ-ийг удирдах тухай гэрээ.
- 4-р бүлэг - ЭЗОБ-ийн оршин суугчийн эрх зүйн байдал: Оршин суугч, ЭЗОБ-д аж үйлдвэр байгуулах журам, төрийн хяналт.
- 5-р бүлэг - Боомтын ЭЗОБ-д аж үйлдвэрлэл, техник, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах тухай гэрээ: Боомтын ЭЗОБ-д аж үйлдвэрлэл, техник, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах тухай гэрээний зүйл, нөхцөл, бусад шаардлагатай бичиг баримт, гэрээ байгуулах дэг, хэлбэр, хугацаа, гэрээний нөхцөл өөрчлөх, гэрээ хүчингүй болох, эсхүл цуцлах, түүнээс үүссэн үр дагавар, газрын түрээсний гэрээ, түүний төлбөр.
- 7-р бүлэг - ЭЗОБ-ийн хилд байрлах газрыг олгох, заасан газрыг ашиглах журам: ЭЗОБ-д газар ашиглах, ЭЗОБ-ийн хил дээр дэд бүтэц, барилга барихад сервитут тогтоох, газрын түрээсийн гэрээ, төлбөр.
- 8-р бүлэг - ЭЗОБ-ийн Гаалийн чөлөөт бүсэд гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх: Гаалийн чөлөөт бүсэд гаалийн үйл ажиллагаа, гаалиар бараа дамжин өнгөрөх үйл ажиллагаа, барааны тайлан, тооцоо, гаалийн хяналт, аж үйлдвэрлэл, эсхүл техникийн эдийн засгийн тусгай бүсэд бараа түр хадгалах, боомтын ЭЗОБ-д бараа оруулах.
- 9-р бүлэг - ЭЗОБ-ийн оршин суучдын баталгаа: ОХУ-д татвар, төлбөрийн хууль тогтоомжид таагүй нөхцөл өөрчлөлтийн баталгаа, маргаан шийдвэрлэх.
- 10-р бүлэг - Төгсгөлийн хэсэг.

Эдийн засгийн онцгой бүс (ЭЗОБ)

ЭЗОБ байгуулах зорилго нь эдийн засгийн өндөр технологи болон боловсруулах салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлал, сувилалын газрууд, боомт болон тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, технологи, коммерциализацийг боловсруулах, шинэ төрлийг бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал хэмээн Эдийн засгийн онцгой бүсийн тухай хуулиар тодорхойлсон байна.

²⁷Федеральный закон от 22.07.2005 N 116-ФЗ (ред. от 23.07.2013) "Об особых экономических зонах в Российской Федерации".

²⁸Федеральный закон от 22.07.2005 N 116-ФЗ (ред. от 23.07.2013) "Об особых экономических зонах в Российской Федерации".

ОХУ-ын нутаг дэвсгэрт дараах 4 төрлийн ЭЗОБ-ийг байгуулна. Үүнд:

1. үйлдвэрлэлийн ЭЗОБ
2. техникийн ЭЗОБ,
3. аялал жуулчлалын ЭЗОБ,
4. боомтын ЭЗОБ.

Нэг төрлийн, эсхүл хэд хэдэн төрлийн ЭЗОБ-үүдийг нэгтгэх, ЭЗОБ-ийн талбайг нэмэх асуудлуудыг Засгийн газрын тогтоолоор шийдвэрлэнэ. Онцгой бүсийг 49 жилийн хугацаатайгаар байгуулах ба хугацааг сунгахгүй.

ЭЗОБ байгуулах, татах буулгах

ЭЗОБ-ийг улсын, орон нутгийн нутаг дэвсгэр дээр, эсхүл иргэд, хуулийн этгээдийн өмчлөлд, эзэмшилд шилжүүлсэн газарт байгуулж болно. Аялал жуулчлалын ЭЗОБ-ийг тусгай хамгаалалттай газар нутаг, ойн сан бүхий газар болон хөдөө аж ахуйн зориулалттай газар байгуулж болно.

ОХУ-ын субъектүүдйн гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага нь холбооны, бүс нутгийн, орон нутгийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ЭЗОБ-ийг байгуулах тухай саналаа төв Засгийн газрын эрх бүхий байгууллагад хүргүүлж, ЭЗОБ-ийг тус улсын Засгийн газрын шийдвэрээр байгуулна. Засгийн газар ийнхүү шийдвэрлэхдээ бүсийн явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг санхүүжүүлэх журам болон хуульд заасан бусад асуудлуудыг хамтад нь тогтооно.

Дараах тохиолдолд ЭЗОБ-ийн үйл ажиллагааг хугацаанаас нь өмнө Засгийн газар татан буулгана. Үүнд:

- хүний эрүүл мэнд, байгаль орчин, соёлын өв болон улсын батлан хамгаалах, аюулгүй байдлын хамгаалах шаардлага гарсан бол,
- ЭЗОБ-ийг байгуулснаас хойш 3 жилийн турш ямар ч гэрээ байгуулаагүй бол,
- ЭЗОБ-д оршин суугчид нь 3 жилийн турш дэд бүтэц, барилга байгууламж бариагүй бол.

ЭЗОБ-ийн нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

1. минерал улс болон бусад эмчилгээний нөөцөөс бусад ашигт малтмалыг олборлохыг,
2. автомашин, мотоциклоос бусад онцгой албан татвар ногдуулбал зохих барааг үйлдвэрлэхийг,
3. хориглосон бусад бүтээгдэхүүний жагсаалтыг Засгийн газар гаргана.

ЭЗОБ-ийн удирдах байгууллага

ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага нь онцгой бүсийг байгуулах, үйл ажиллагаа явуулахад төрийн нэгдсэн бодлогыг боловсруулж, удирдлагыг хэрэгжүүлнэ. Засгийн газраас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага, ОХУ-ын субъектүүдйн гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь нэгдсэн төв удирдлагын системийг бүрдүүлнэ. Уг хоёр байгууллага болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд, Удирдах компанийн төлөөлөгчид, мөн бүсийн оршин суугчдын төлөөлөгчид, тэр дундаа ЭЗОБ-ийн байрлаж буй орон нутаг, эсхүл хилийн зааг дээр үйл ажиллагаа явуулдаг боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөгчид ЭЗОБ-ийн Хяналтын зөвлөлд хамрагдана.

ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчийг ЭЗОБ-ийн оршин суугчаар бүртгэх, бүртгэлийг хөтлөх,
- Засгийн газрын тогтоосон журмын дагуу жил бүр ЭЗОБ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, Засгийн газарт танилцуулах,
- бүсийн оршин суугчдын үйл ажиллагааг хянах,
- сар бүр олон нийтийн хэвлэл мэдээллээр мэдээлэл гаргах,
- ЭЗОБ-ийн нутаг дэвсгэрт гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах,
- бүсийн газрыг хуваарилах, удирдах,
- газар болон бусад хөрөнгийн түрээслэх,
- бусад.

Удирдах компани нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- ЭЗОБ байгуулах тухай гэрээний дагуу бүсийн дэд бүтэц болон бүсийн үйл ажиллагааг хангах бусад объектыг байгуулах
- оршин суугчид болон хөрөнгө оруулагчдыг татах /ялангуяа бүсийн дэд бүтцийн объектуудыг байгуулахад/,
- бүсийн төлөвлөгөөний төслийг боловсруулах,
- хуулиар тогтоосон бусад үйл ажиллагаа.

ЭЗОБ-д инженерийн, тээврийн, нийгмийн болон бусад дэд бүтцийн барилга, байгууламжийг барихад хууль тогтоомжийн дагуу холбооны, түүний субъектүүдын, орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулна.

ЭЗОБ-ийн оршин суугч

ОХУ дахь эдийн засгийн онцгой бүсийн тухай хуулиар ЭЗОБ-ийн оршин суугчийг төрөл тус бүрээр нарийн тодорхойлж өгсөн байна. Тухайлбал,

1. Үйлдвэрлэлийн ЭЗОБ-ийн оршин суугч - үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, эсхүл логиستيкийн үйл ажиллагаа эрхлэх ашгийн байгууллага,
2. Техникийн ЭЗОБ-ийн оргин суугч - техниктэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх хувиараа аж ахуй эрхлэгч, эсхүл ашгийн байгууллага,
3. Аялал жуулчлалын ЭЗОБ-ийн оршин суугч - аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх хувиараа аж ахуй эрхлэгч, эсхүл ашгийн байгууллага,
4. Боомтын ЭЗОБ-ийн оршин суугч - боомтын үйл ажиллагаа эрхлэх ашгийн байгууллага.

Аль ч оршин суугч нь нэгдсэн үйл ажиллагаа явуулаагүй байх ба ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн, тухайн бүсийн удирдлагатай холбогдох үйл ажиллагааны гэрээг байгуулсан байна.

Оршин суугчийг ОХУ дахь эдийн засгийн онцгой бүсийн тухай хуулийн дагуу зөвхөн шүүхийн шийдвэрээр бүртгэлээс хасна.

Төрийн хяналт

Холбооны гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага, Холбооны субъектүүдын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь холбооны төрийн хяналт, бүс нутгийн төрийн хяналт, орон нутгийн хяналтыг тус тус тавина.

Эдгээр төрийн хяналтын байгууллагууд нь хамтран төлөвлөгөөт шалгалтыг ажлын 15 хоногийн дотор хийнэ. Шалгалтын явцад зөрчил илрүүлбэл зөрчлийг засах тухай баримтыг хүргүүлэх ба түүнээс 2 сарын дараа зөрлийг арилгасан эсэхийг хянахаар төлөвлөгөөт

бус шалгалт 5 хоногийн дотор хийнэ. Төлөвлөгөөт бус шалгалтаар зөрчил арилгаагүй тохиолдолд шүүхийн шийдвэрээр ЭЗОБ-ийн оршин суугчийг бүртгэлээс хасна.

“Тольятти” үйлдвэрлэлийн ЭЗОБ

Үйлдвэрлэлийн ЭЗОБ-д тэргүүлэх дараах чиглэлүүдээр үйл ажиллагаа эрхэлж байна.

- автомашин, автомашины бүрэлдэхүүн,
- барилгын материал,
- хими, нефть-химийн бүтээгдэхүүн,
- ахуйн цахилгаан хэрэгсэл.

Тольятти ЭЗОБ бол Самарск мужийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэгч бүс бөгөөд 660 га талбайг хамарч үйл ажиллагаа явуулдаг байна. Тус бүсэд хөрөнгө оруулалтыг 2013 оны 10-р сарын байдлаар дараах хүснэгтээс үзье.

Хүснэгт 2. Тольятти ЭЗОБ-д оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ

Эх үүсвэр	Хөрөнгө оруулалт, тэрбум рубль	Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь
Холбооны төсвийн хөрөнгө оруулалт	7,2	53,1
Төсвийн бус хөрөнгө оруулалт	5,6	41,2
Самара мужийн төсвийн хөрөнгө оруулалт	0,8	5,7
Нийт	13,6	100

3.2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Эдийн засгийн тусгай бүсийн хөгжил

Одоо хэрэгжиж байгаа Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуульд *эдийн засгийн тусгай бүс*²⁹ /ЭЗТБ/ бол тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тодорхой хилийн хязгаарт эрх зүйн тусгайлан зохицуулалт бүхий БНКУ-ын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ хэмээн томъёолсон байна.

Казахстанд анх 1990 онд Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль³⁰ батлагдаж, уг бүсэд хуульд заасан бүх төрлийн үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрсөн байна. Бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй эрхлэгчид буюу оролцогчдод гаалийн болон бусад албан татварын хөнгөлөлт үзүүлж байсан.

Тус улсад 1991-1996 оны хооронд 9 ЭЗЧБ байгуулагдаж байжээ. Томоохон нутаг дэвсгэрийг ЭЗЧБ гэж зарласан ч шаардлагатай судалгаа шинжилгээ хийгдээгүй, хууль эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын механизмыг нарийн тогтоогоогүй, санхүү, татвар зэрэг олон асуудлуудыг бие даан шийдэх хангалттай эрх мэдэл байгаагүй зэрэг нийтлэг асуудлуудаас болж ЭЗЧБ-үүдийн үйл ажиллагаа нь хүссэн үр дүндээ хүрч чадаагүй.

ЭЗЧБ-ийг байгуулах гэсэн анхны оролдлого амжилтгүй болж, амжилттай үйл ажиллагаа явуулж байсан эсэхээс үл хамааран 1996 онд бүх ЭЗЧБ-үүдийг татан буулгажээ. Төр засаг бүгдийг дахин шинээр эхлэхээр шийдэж Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийг³¹ 1996 онд батлан гаргажээ.

²⁹Специальная экономическая зона - СЭЗ.

³⁰Закон Казахской ССР от 30 ноября 1990 г. “О свободных экономических зонах в Казахской ССР”.

³¹Закон РК от 26 января 1996 г. “О специальных экономических зонах в Республике Казахстан”.

2002 оноос шинэ үеийн анхны бүсийг байгуулж эхэлсэн бөгөөд одоо ажиллаж байгаа ЭЗТБ бүр өөрийн зорилго, түүнд нийцсэн үйл ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна.

2007 онд дахин Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийг шинэчлэн баталсан боловч одоо ЭЗТБ-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг 2011 онд батлагдсан Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулж байна. Одоо хэрэгжүүлж буй хуулиар бүсийн удирдлага, үйл ажиллагааны системийг сайжруулахад чиглэсэн байна.

ЭЗТБ-ийн хөгжлийг удаашруулж байсан асуудлуудын нэг бол олон улсын зах зээлтэй хангалттай харилцаа байгаагүй явдал ба үүнээс болж гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг татах боломжгүй байсан хэмээн үзэж, энэ тал дээр түлхүү анхаарах болсон байна. Мөн хөрөнгө оруулагчдыг татах үүднээс зөвшөөрөл авах процессыг “нэг цонх”-ны зарчмыг хуулиар тогтоосон нь төрийн үйлчилгээг боломжийн хэмжээнд хялбаршуулсан гэж үзэж байгаа аж.

Зураг 8. Казахстанд үйл ажиллагаа явуулж буй ЭЗТБ-үүдийн байршил



Казахстаны Худалдаа, аж үйлдвэрийн танхимын мэдээллээр 2011 оны эцэст ЭЗТБ-ийн 300 гаруй оролцогчид бүртгүүлж, 10 мянган ажилын байр бий болж, 254 тэрбум тенгеийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Астана - шинэ хот, Морпорт Актау, Мэдээллийн технологийн парк, Оңтүстік, Үндэсний нефть-химийн технопарк, Бурабай зэрэг ЭЗТБ-ийн хөрөнгө оруулалт 625 тэрбум тенге байгаа нь 2009 оныхтой харьцуулахад 15 дахин өссөн байна. ЭЗТБ-үүдийн дэд бүтцэд улсын төсвөөс 129 тэрбум тенгеийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хууль, эрх зүйн зохицуулалт

Казахстанд эдийн засгийн тусгай бүстэй холбоотой харилцааг дараах хууль тогтоомжуудаар зохицуулна:

- Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль³² - ЭЗТБ-ийн үйл ажиллагааг зохицуулж буй үндсэн хууль,
- Татварын тухай хууль³³ - ЭЗТБ-д оролцогчдын татварын харилцааг зохицуулна,

³²Закон Республики Казахстан «О специальных экономических зонах» от 21 июля 2011 года.

³³Налоговый кодекс

- Гаалийн холбооны³⁴ гаалийн нутаг дэвсгэрт болон гаалийн чөлөөт бүсийн гаалийн үйл явц дахь эдийн засгийн чөлөөт /тусгай, онцгой/ бүсийн асуудалтай холбоотой гэрээ³⁵ - ЭЗТБ-д гаальтай холбоотой харилцааг зохицуулна. /2017 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл түр хугацаагаар хэрэгжүүлнэ./

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль нь БНКУ-ын нутаг дэвсгэр дээр ЭЗТБ үүсгэн байгуулах, зохион байгуулах, татан буулгахад олон нийттэй холбоотой харилцааг зохицуулна.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 6 бүлэг, 26 зүйлтэй. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: Хуульд хэрэглэгдэх гол нэр томъёонуудын тодорхойлолт, ЭЗЧБ-ийн хууль тогтоомж, ЭЗТБ байгуулах зорилго.
- 2-р бүлэг - ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд дэх төрийн зохицуулалт: ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд төрийн зохицуулалт хийж буй төрийн байгууллагуудын эрх, үүрэг.
- 3-р бүлэг - ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах: ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах нөхцөл, өргөдөл гаргачид тавигдах шаардлага, түүнийг хянаж үзэх, туслах үйл ажиллагаа явуулахыг хүсэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх бичиг баримт, татан буулгах.
- 4-р бүлэг - ЭЗТБ-ийг захиргаа: ЭЗТБ-ийн захиргааны байгууллагыг байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдах компанийн удирдлагын бүрэлдэхүүнийг сонгох, түүний эрх, үүрэг, Үйл ажиллагааны хэрэгжилтийн гэрээний нөхцөлийн биелэлтийг хянах, Захиргааны үйл ажиллагааг санхүүжүүлэх, татан бүүлгах.
- 5-р бүлэг - ЭЗТБ-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, нөхцөл: ЭЗТБ-ийн эрх зүйн тусгай зохицуулалт, татвар, гаалийн харилцаа, Гаалийн чөлөөт бүсээр өнгөрөх бараа, Гадаадаас ажиллах хүч оруулах, Бүсийн оролцогчдын эрх зүйн баталгаа.
- 6-р бүлэг - Шилжилтийн нөхцөл.

ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах

ЭЗТБ байгуулах зорилго нь орчин үеийн үр дүнтэй, өрсөлдөх чадвартай аж үйлдвэрлэлийн хөгжүүлэх, эдийн засаг, бүс нутагт хөрөнгө оруулагчдыг татах, шинэ технологи нэвтрүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх явдал хэмээн Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулиар тодорхойлсон байна.

Гүйцэтгэх засаглалын төв болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, эсхүл хэд хэдэн хуулийн этгээд хамтран ЭЗТБ-ийг байгуулах хүсэлтээ эрх бүхий байгууллагад гаргана. Хүсэлт гаргахдаа байгуулах зорилго, байршил, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа, хүчин чадал, тухайн бүс байрлаж байгаа бүс нутгийн эдийн засгийн нөхцөл байдал, ЭЗТБ байгуулснаар эдийн засагт хэрхэн нөлөөлөх зэргийг боловсруулж өгнө.

Хүсэлтийг шинжилгээний баг хянаж үзээд дүгнэлтээ гаргана. Шинжилгээний алба нь ЭЗТБ-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх зорилгоор БНКУ-ын Ерөнхий сайдын байгуулсан байгууллага дундын зөвлөх байгууллага юм.

³⁴Гаалийн холбоо нь хоёр ба түүнээс олон орнууд хоорондоо байгуулсан гэрээний дагуу өөр хоорондоо худалдааны татвараас чөлөөлөх, хамтран гуравдагч орноос гаалийн тарифаар дамжуулан хамгаалах зорилготой. Одоогийн байдлаар хэд хэдэн гаалийн холбоо байх ба түүний нэг нь Евроазийн эдийн засгийн нийгэмлэгийн хүрээнд буюу Беларус, Казахстан, Оросын хооронд байгуулагдсан гаалийн холбоо /Таможенный союз ЕврАзЭС/ юм.

³⁵Соглашение по вопросам свободных (специальных, особых) экономических зон на таможенной территории таможенного союза и таможенной процедуры свободной таможенной зоны.

ЭЗТБ байгуулах тухай шийдвэрийг Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч шийдвэрлэнэ. Ингэхдээ Ерөнхийлөгч нь тус бүсийн журам, үйл ажиллагааны зорилго, зорилго хэрэгжээгүйд тооцох ноцтой түвшин, тэдгээрийн шалгуурыг тогтооно.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулиар ЭЗТБ-ийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх тэргүүлэх болон туслах чиглэлийн үйл ажиллагааг заасан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл - Бүс байгуулах зорилгод нийцсэн үндсэн үйл ажиллагааны төрлүүд багтах ба ийм үйл ажиллагаа явуулж буй компаниудыг ЭЗТБ-д оролцогчид байна.
- Үйл ажиллагааны туслах чиглэл - Бүсэд оролцогчдын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах шаардлагатай туслах үйл ажиллагааг эрхлэх бөгөөд ЭЗТБ-ийн оролцогчид тооцохгүй.

ЭЗТБ-ийг 25 хүртэл жилийн хугацаатай байгуулна.

Дараах субъектүүд ЭЗТБ-ийн оролцогчид хамаарахгүй:

- Газрын хэвлийг ашиглагч,
- Онцгой албан татвар ногдуулдаг барааны худалдааг эрхэлдэг байгууллага /Татварын тухай хуулийн дагуу/,
- Татварын тусгай зохицуулалттай байгууллага,
- Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт эдэлдэг байгууллага.

ЭЗТБ-ийг дараах 2 тохиолдолд татан буулгана. *Нэгдүгээрт*, Ерөнхийлөгчийн ЭЗТБ байгуулах тухай шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон бол татан буулгана. *Хоёрдугаарт*, Ерөнхийлөгчийн тогтоосон тухайн бүсийн зорилго хэрэгжээгүйд тооцох ноцтой түвшинд хүрсэн үзэж үзвэл Ерөнхийлөгчийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө татан буулгана.

ЭЗТБ-ийн удирдлага буюу удирдах компани

ЭЗТБ-ийн удирдах компани нь Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн дагуу бүсийн үйл ажиллагааг хангахын тулд байгуулагдсан хуулийн этгээд юм. Удирдах компанийг Казахстаны Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон дотоод, гадаадын хуулийн этгээд байгуулж болно.

ЭЗТБ-ийг төрийн байгууллагын саналаар байгуулж байгаа тохиолдолд удирдах компанийн саналын 50-аас багагүй хувийг, хувийн хөрөнгө оруулагчийн саналаар байгуулж байгаа тохиолдолд саналын 26-аас багагүй хувийг төр эзэмшинэ.

Үйл ажиллагааны хэрэгжилтийн гэрээний нөхцөлийн биелэлтийн хяналтыг ЭЗТБ-ийн захиргааны тайланд үндэслэж эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

Удирдах компанийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- Удирдах компанийн ЭЗТБ-д оролцогчидод үзүүлж буй үйлчилгээний урамшуулал,
- Төлбөрийн орлого,
- Дэд бүтцийн объект, газар болон бусад хөрөнгийн түрээсийн орлого,
- Бусад орлого.

ЭЗЧБ-ийн оролцогч

ЭЗТБ-д татвар төлөгчөөр бүртгэгдсэн, тус бүсэд тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байгаа дотоод, гадаадын хуулийн этгээд ЭЗТБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу оролцогч байна.

ЭЗТБ-д оролцогчид дараах эрхтэй:

- Оролцогчид зориулсан хууль тогтоомжоор тогтоосон татварын болон бусад хөнгөлөлтүүдийг эдэлж, эрхээ хамгаалуулах,
- Газар авч, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулагдсан дэд бүтцийн объект барих,
- Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад туслах үйл ажиллагаа эрхлэгчдийг татан оролцуулах,
- Бусад эрх.

ЭЗТБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу оролцогчид дараах үүрэгтэй:

- Үйл ажиллагааны жилийн тайланг ЭЗТБ-ийн удирдах компанид өгөх,
- Казахстаны хууль тогтоомж болон гэрээнд заасан үүргээ биелүүлэх.

ЭЗЧБ-ийн хөнгөлөлтүүд

ЭЗТБ-ийн оролцогчдод үзүүлж буй татварын хөнгөлөлтийг Казахстаны Татварын тухай хуулиар зохицуулсан ба дараах албан татварын хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн албан татвараас чөлөөлөх,
- Газрын албан татвараас чөлөөлөх,
- Хөрөнгийн татвараас чөлөөлөх,
- ЭЗТБ-ийн зорилгод нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай барааны татварыг тэглэх /барааны жагсаалтыг Засгийн газар тогтооно/.

“Астана - шинэ хот” болон “Мэдээллийн технологийн парк” гэсэн хоёр ЭЗТБ-д оролцогчид татварын нэмэлт хөнгөлөлтийг үзүүлнэ.

“Астана - шинэ хот” ЭЗТБ-ийн нутаг дэвсгэрт батлагдсан зураг төслийн дагуу дэд бүтэц, эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сургууль, хүүхдийн цэцэрлэг, музей, театр, номын сан, сурагчдын ордон, биеийн тамирын цогцолбор, захиргааны байр, орон сууцны хорооллын барилгыг барихад шаардагдах барааны татварыг тэглэх /барааны жагсаалтыг Засгийн газар тогтооно/.

“Мэдээлэл технологийн парк” ЭЗТБ-д оролцогчдыг нийгмийн татвараас 5 жил чөлөөлнө. Тухайн оролцогчийн хөдөлмөрийн хөлсний зардал нь жилийн орлогын 50-аас багагүй хувь, мөн хөдөлмөрийн хөлсний зардлын 90 хувийг Казахстанд бүртгэлтэй “Мэдээлэл технологийн парк”-ийн ЭЗТБ-ийн гадна байрлалтай тус улсын аж ахуй нэгжид зарцуулсан тохиолдолд дээрх хөнгөлөлтийг үзүүлнэ. Уг бүсийн оролцогчдын хувьд тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны бүтээгдэхүүнээс олсон орлого нь нийт орлогын 70 хувийг олсон байх шаардлагыг тавьсан.

ЭЗТБ-ийн оролцогчдод үзүүлж буй өөр нэг хөнгөлөлт нь гадаадаас ажиллах хүч оруулахад дотоодын хөдөлмөрийн зах зээлээс нэр дэвшигч оролцуулахгүйгээр шийдвэрлэх явдал юм. Мөн оролцогчдод 10 жилийн хугацаатайгаар газар үнэ төлбөргүй эзэмшүүлнэ.

Оролцогчдын хувьд татварын болон бусад хөнгөлөлтийг эдлэхийн тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Оролцогчид ЭЗТБ-д татвар төлөгчийн хувиар бүртгүүлсэн байх,
2. Бүсийн гадна салбаргүй байх,
3. Бүсийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны бүтээгдэхүүнээс олсон орлого нь нийт орлогын 90 хувь /“Мэдээлэл технологийн парк” ЭЗТБ-д оролцогчдын хувьд 70 хувь/-ийг олсон байх.

Казахстанд үйл ажиллагаа явуулж буй ЭЗТБ-үүд

Казахстанд одоогийн байдлаар дараах 9 ЭЗТБ-үүд үйл ажиллагааг явуулж байна.

Хүснэгт 3.

Үйл ажиллагааны үндсэн төрөл	ЭЗТБ-ийн нэр	Үйл ажиллагааны төрөл
Аж үйлдвэрийн	1. Морпорт Актау	логистик, тээвэр
	2. Оңтүстік	нэхмэл эдлэл
	3. Үндэсний нефть - химийн технопарк	нефть-байгалийн хийн автомашины үйлдвэрлэл, нефть-хими
	4. Павлодар	хими
	5. Сарыарқа	төмөрлөг, төмөрлөг боловсруулалт
	6. Астана - шинэ хот	барилга, аж үйлдвэрлэл
Үйлчилгээний	7. Бурабай	аялал жуулчлал
	8. Хоргос - Дорнын үүд	худалдаа, логистик
Технологийн	9. Мэдээллийн технологийн парк	мэдээллийн технологи

1) “Астана - шинэ хот” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2001 он
 Хэрэгжүүлэх хугацаа: 2026 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл
 Байршил: Астана хот
 Тайлбай: 5900,9 га

Зорилго: Хөрөнгө оруулалтыг татах, барилгын тэргүүлэх чиглэлийн технологийг ашиглах, мөн өндөр бүтээмжтэй, өрсөлдөх чадвартай орчин үеийн аж үйлдвэрийг байгуулах, шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргаж авах замаар Астана хотын хөгжлийг хурдасгах.

Үйл ажиллагааны төрлүүд:

- химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- резин, хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- бусад төмөр бус минерал бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- ахуйн цахилгаан тоноглолын үйлдвэрлэл,
- автомашин болон түүний тоноглолын үйлдвэрлэл,
- төмөрлөгийн аж үйлдвэрлэл,
- цахилгааны тоноглол, тэр дундаа цахилгаан гэрэлтүүлгийн тоноглолын үйлдвэрлэл,
- гэрэлтүүлгийн шилэн тоноглолын үйлдвэрлэл,
- хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- модны зутан болон эслэг эд, цаас болон картон цаасны үйлдвэрлэл,
- тавилгын үйлдвэрлэл,
- автотээврийн хэрэгсэл, чиргүүлийн үйлдвэрлэл,
- галт тэрэг, түүний хөдөлгүүрийн үйлдвэрлэл,
- агаарын болон сансарын нисэгч төхөөрөмжийн үйлдвэрлэл,
- үндсэн эм зүйн бүтээгдэхүүн, эм, тарианы үйлдвэрлэл,
- цахилгааны эд ангийн үйлдвэрлэл,
- төсөлд тусгагдсан дэд бүтэц, эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сургууль, хүүхдийн цэцэрлэг, музей, театр, номын сан, сурагчдын ордон, биеийн тамирын цогцолбор, захиргааны байр, орон сууцны хорооллын барилгыг барих.

“Астана - шинэ хот” ЭЗТБ-ийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 12 тэрбум ам. долларын хөрөнгө оруулсан ба үүнээс 2,8 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалтыг дэд бүтэц болон нийгэм, соёлын барилгад зориулж улсын төсвөөс оруулсан байна. 2011 оны байдлаар 900 гаруй хүнийг байнгын ажлын байраар хангасан 49 аж ахуй эрхлэгч үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус ЭЗТБ-д хэрэгжиж байгаа томоохон төслүүдийг дурдвал: галт тэрэг, ЕС-145 маркийн нисдэг тэрэгний угсралт, засварын үйлдвэрүүд, мөн төмөр бетон бүтээгдэхүүн, “сэндвич” хавтангийн үйлдвэрүүд аж.

2) “Үндэсний нефть-химийн технопарк” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2007 он
Хэрэгжүүлэх хугацаа: 2032 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл
Байршил: Атырауск муж
Тайлбай: 3475,9 га

Зорилго: Инновацийн технологид суурилсан Казахстаны нүүрс улстөрөгчийн нөөцийг бүрэн боловсруулах нефть-химийн үйлдвэрийг хөгжүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- нефть-химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

“Үндэсний нефть-химийн технопарк” ЭЗТБ-ийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 100 сая ам. долларын хөрөнгө оруулсан бөгөөд 2011 оны байдлаар 6 аж ахуй эрхлэгч байгууллагууд барилгын ажлаа эхэлсэн байна.

3) “Морпорт Актау” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2002 он
Хэрэгжүүлэх хугацаа: 2028 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл
Байршил: Мангистауск мужийн Актау хот
Тайлбай: 2000 га

Зорилго: олон улсын бизнесийн систем руу бүгд найрамдах улсын эдийн засгийн оролцоог идэвхжүүлэхийн тулд бүс нутгийн хурдацтай хөгжүүлэх, өндөр технологи болон өрсөлдөх чадвартай өндөр бүтээмж бүхий аж үйлдвэрийг байгуулах, шинэ бүтээгдэхүүн гаргаж авах, хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн харилцааны эрх зүйн хэм хэмжээг төгөлдөржүүлэх, удирдах болон ажил хэрэг, мөн нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх орчин үеийн аргуудыг хэрэгжүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- ахуйн цахилгаан тоноглолын үйлдвэрлэл,
- арьсан эдлэлийн үйлдвэрлэл,
- химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- резин, хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- бусад төмөр бус минерал бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- төмөрлөгийн аж үйлдвэрлэл,
- бэлэн төмөр эдлэлийн үйлдвэрлэл,
- автомашин болон түүний тоноглолын үйлдвэрлэл,
- нефть-химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- агуулах болон туслах тээврийн үйл ажиллагаа.

2011 оны байдлаар “Морпорт Актау” ЭЗТБ-ийг байгуулагдсанаас хойш ойролцоогоор 160 сая ам.долларын хөрөнгө оруулсан ба 1 мянган хүнийг байнгын ажлын байраар хангасан 33 оролцогчид үйл ажиллагаагаа явуулж байна.

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

4) “Мэдээллийн технологийн парк” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2003 он
Хэрэгжүүлэх хугацаа: 2028 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл
Байршил: Алмата хотын Медеуск дүүрэг
Тайлбай: 163,02 га

Зорилгын чиглэл:

- мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх,
- шинэ мэдээллийн технологийг үйлдвэрлэх,
- мэдээллийн технологийн салбарт шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргаж авах.

Энэхүү ЭЗТБ-д 2011 оны байдлаар 47 оролцогчид үйл ажиллагаа явуулж, 1100 гаруй хүнийг байнгын ажлын байраар хангаж байна. Үйлдвэрүүд шингэн болор дэлгэцтэй зурагт болон монитор, компьютер, зөөврийн компьютер, сервер, программ хангамжийн бүтээгдэхүүн боловсруулах, утасгүй төхөөрөмж болон бусад техник хэрэгслүүдийг үйлдвэрлэж байна.

5) “Оңтүстік” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2005 он
Хэрэгжүүлэх хугацаа: 2030 оны 7-р сарын 1-ний өдөр хүртэл
Байршил: Өмнөд Казахстанск муж
Тайлбай: 200 га

Зорилго: нэхмэл эдлэлийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- нэхмэл бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл /хувцаснаас бусад/,
- сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл,
- нэхмэл бүтээгдэхүүнээр хувцас үйлдвэрлэх,
- торгон давуу болон түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- нэхээгүй давуу болон түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- хивс, хивсэн эдлэл, бүрээс, аравч үйлдвэрлэх,
- хөвөн эслэг болон түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- хөвөнгөөс дээд зэргийн цаас үйлдвэрлэх,
- арьсан эдлэлийн үйлдвэрлэл.

Тус ЭЗТБ-ийг Ерөнхийлөгчийн 2005 оны 7-р сарын 6-ны өдрийн “Оңтүстік” ЭЗТБ-ийг байгуулах тухай 1605 тоот тогтоолоор байгуулсан. Байгуулагдсан цагаас хойш “Оңтүстік” ЭЗТБ-д 133 сая орчим ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд 2011 оны байдлаар 484 хүнийг байнгын ажлын байраар хангаж буй 2 аж ахуй эрхлэгч үйл ажиллагаагаа явуулж байна.

“Оңтүстік” ЭЗТБ-ийн давуу талууд:

- тээврийн дэд бүтцийн ашигтай байрлал,
- газар зүйн ашигтай байрлал, өөрөөр хэлбэл, хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн импортлогч томоохон зах зээлтэй ойрхон,
- Гаалийн холбооны нутаг дэвсгэр дээр хөвөнгийн ургамал тарьдаг ганц газар бол Өмнөд Казахстанск мужид,
- цахилгаан хангамж шийдэгдсэн.

6) “Бурабай” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2008 он
 Хэрэгжүүлэх хугацаа: 2017 оны 12-р сарын 1-ний өдөр хүртэл
 Байршил: Акмолинск муж
 Тайлбай: 370 га

Зорилго: дотоод, гадаадын жуулчдын хэрэгцээг хангах, сэтгэлд нийцсэн үр дүнтэй, өрсөлдөх чадвартай аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах.

Үйл ажиллагааны төрлүүд:

- төсөлд тусгагдсан зочид буудал, амралтын газар, сувиллын газрын барилга барих /тоглоомын газар орохгүй/
- аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх.

Байгуулагдсан цагаас хойш “Бурабай” ЭЗТБ-д ойролцоогоор 8,5 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд хувийн хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр аялал жуулчлалд зориулагдсан барилгууд баригдаж байна. “Бурабай” аялал жуулчлалын төвийн мастер төлөвлөгөөг 2021 оныг хүртэл 12 жилийн хугацаанд 7 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

7) “Павлодар” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2011 он
 Хэрэгжүүлэх хугацаа: 2036 оны 12-р сарын 1-ний өдөр хүртэл
 Байршил: Павлодар хот /Аж үйлдвэрийн хойд район/
 Тайлбай: 3300 га

Зорилго: орчин үеийн экологийн тэнцвэрийг хадгалсан технологийг ашиглаж өндөр өртөгтэй экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх хими, нефть-химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- нефть-химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

8) “Сарыарқа” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2011 он
 Хэрэгжүүлэх хугацаа: 2036 оны 12-р сарын 1-ний өдөр хүртэл
 Байршил: Карагандинск муж
 Тайлбай: 534,9 га

Зорилго: дэлхийн худалдааны тэмдэг үйлдвэрлэгчдийг татаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар төмөрлөгийн аж үйлдвэрлэл болон төмөр боловсруулах салбарыг хөгжүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- төмөрлөгийн аж үйлдвэрийн түүхий эд үйлдвэрлэл,
- автомашин болон түүний тоноглол, автотээврийн хэрэгсэл, чиргүүл, компьютер, цахилгаан болон гэрлийн бүтээгдэхүүний бэлэн төмөр эдлэлийн үйлдвэрлэл,
- химийн аж үйлдвэрийн, резин болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- барилгын материалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

9) “Хоргос - Дорнын үүд” ЭЗТБ

Байгуулагдсан он: 2011 он
 Хэрэгжүүлэх хугацаа: 2035 он хүртэл
 Байршил: Алматинск муж
 Тайлбай: 5740 га

Зорилго: худалдаа, экспорт болон дамжин өнгөрөх тээврийн хэрэгцээг хангасан, үр ашигтай тээвэр-логистик болон аж үйлдвэрийн төв байгуулах, дотоодын бүтээгдэхүүнийг олон улсад интеграцчилах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах таатай орчин бүрдүүлэх, олон улсын зах зээлд бүгд найрамдах улсын эдийн засгийн оролцоог идэвхжүүлэхийн тулд бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх.

Үйл ажиллагааны төрлүүд:

- агуулахын болон туслах тээврийн үйл ажиллагаа,
- хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- арьс, арьсан эдлэлийн үйлдвэрлэл,
- нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл,
- бусад төсөр бус минерал бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- бэлэн төмөр бүтээгдэхүүний үйлдвэрлэл /автомашин болон түүний тоноглол хамаарахгүй/,
- автомашин болон түүний тоноглолын үйлдвэрлэл,
- төсөлд тусгагдсан үзэсгэлэнгийн танхим, музей, агуулах болон захиргааны барилга барих.

Хоргос ЭЗТБ нь Казахстан, Хятадын хилийн орчимд байгуулагдсан бөгөөд түүнээс холгүй Монголын Цагааннуур ХЧБ байрладаг нь ирээдүйд энэ хоёр бүсийн хооронд барааны урсгал явагдах магадлалтай.

3.3. БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУС УЛС**Эрх зүйн зохицуулалт**

Беларус улсад Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль³⁶ 1998 онд батлагдсан. Уг хуульд *эдийн засгийн чөлөөт бүс /ЭЗЧБ/* гэдгийг тогтоосон хил хязгаартай, дотроо тухайн ЭЗЧБ-ийн оршин суугчдад хамаарах тусгай хуулийн зохицуулалттай мөн хөрөнгө оруулалтын болон хувиараа бизнес эрхлэх үйл ажиллагаа явуулахад үр ашигтай БНБУ-ын нутаг дэвсгэрийн нэг хэсэг хэмээн томъёолсон байна.

Энд дурдагдаж буй ЭЗЧБ-ийн *тусгай хуулийн зохицуулалт* нь хөрөнгө оруулалтын болон хувиараа бизнес эрхлэх үйл ажиллагаа явуулах ерөнхий нөхцөлүүдээс илүү тааламжтай байх эрх зүйн хэм хэмжээний бүрдэл гэж хуульд томъёолсон байна.

Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 6 бүлэг, 26 зүйлтэй. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: Хуульд хэрэглэгдэх гол нэр томьёонууд болон тэдгээрийн тодорхойлолт, ЭЗЧБ-ийн хууль тогтоомж, ЭЗЧБ байгуулах зорилго, төрөл, хориотой үйл ажиллагаа.
- 2-р бүлэг - ЭЗЧБ дэх төрийн зохицуулалт болон хяналт: ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд төрийн зохицуулалт хийж буй төрийн байгууллагууд, тэдгээрийн бүрэн эрх, ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа болон түүний үр ашгийн ерөнхий хяналт.

³⁶Закон Республики Беларусь 7 декабря 1998 г. № 213-З О свободных экономических зонах.

- 3-р бүлэг - ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах, түүний хилийн заагийг өөрчлөх: ЭЗЧБ байгуулах, хилийн заагийг өөрчлөх, үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах, татан буулгах.
- 4-р бүлэг - ЭЗЧБ-ийн менежмент болон санхүүжилт: ЭЗЧБ-ийн захиргаа, түүний бүрэн эрх, Хяналтын зөвлөл, Хөгжлийн сангийн санхүүжилт.
- 5-р бүлэг - ЭЗЧБ-ийн оршин суугч: ЭЗЧБ-ийн оршин суугчаар бүртгүүлэх, ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээнд тухайн бүсийн оршин суугчийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл, Бүсийн оршин суугчаар бүртгүүлсэн хуулийн этгээдийг өөрчлөх, оршин суугчийн статусаа алдах, эсхүл хасуулах.
- 6-р бүлэг - ЭЗЧБ-ийн тусгай эрх зүйн зохицуулалт. ЭЗЧБ-ийн оршин суугчдын улсын баталгаа: ЭЗЧБ-ийн татвар, Гаалийн чөлөөт бүс, ЭЗЧБ дэх Газрын харилцааны зохицуулалт, хөдөлмөрийн болон холбогдох харилцааны зохицуулалт, Бүсийн оршин суугчдын улсын баталгаа.

ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах

Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуулийн 3-р зүйлд тодорхойлсон ЭЗЧБ байгуулах зорилго нь ЭЗЧБ-ийг Беларус улсын нийгэм эдийн засгийн хөгжил, биеэ даасан удирдлага, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд нөлөөлөх, шинэ өндөр технологид суурилсан экспортод чиглэсэн импортыг орлох хөрөнгө оруулалтыг татах болон ЭЗЧБ байгуулахад тодорхойлсон бусад зорилгыг харгалзан үзэж байгуулна гэсэн байна.

ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд төрийн зохицуулалтыг БНБУ-ын Ерөнхийлөгч, Сайд нарын Зөвлөл /СЗ/, тухайн бүс нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо болон ЭЗЧБ-ийн захиргаа зэрэг төрийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

Бүсийн захиргаа нь энэ хуульд заасан дүрэм журам, загвараар байгуулагдсан ЭЗЧБ-ын менежментийн үндсэн хэсэг хэмээн Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуульд томъёолжээ.

Эрх бүхий субъектүүд нь бүсийн үйл ажиллагаатай холбоотой дараах саналуудыг гаргана:

- СЗ, тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороо нь ЭЗЧБ-ийг байгуулах тухай саналыг гаргана.
 - о *Тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороо нь саналаа хуульд заасан бичиг баримтын хавсралтын хамт СЗ-д хүргүүлнэ.*
- СЗ, тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороо, ЭЗЧБ-ийн захиргаа нь бүсийн хилийн заагийг өөрчлөх, үйл ажиллагааны хугацааг сунгах, эсхүл хугацаа нь дуусахаас өмнө татан буулгах саналыг гаргана.
 - о *Тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороо нь саналаа, хавсралтын хамт СЗ-д хүргүүлнэ. Харин ЭЗЧБ-ийн захиргаа нь саналаа тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороогоор дамжуулан СЗ-д хүргүүлнэ.*

ЭЗЧБ-ийг байгуулах, хилийн заагийг өөрчлөх, үйл ажиллагааны хугацааг сунгах, эсхүл хугацаа нь дуусахаас өмнө татан буулгах тухай саналуудыг СЗ хүлээн авч, Ерөнхийлөгчид хүргүүлснээр шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

СЗ нь Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль, ЭЗЧБ байгуулах тухай Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүсийн хөгжлийн хөтөлбөр, түүний зохицуулалтыг батлах, ЭЗЧБ-ийн захиргааг байгуулах болон түүний дүрмийг батлах үүрэгтэй.

ЭЗЧБ-ийг дараах 2 тохиолдолд татан буулгана. *Нэгдүгээрт*, ЭЗЧБ-ийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр хугацааг нь сунгаагүй л бол анх байгуулахад заасан хугацаа дууссанаар татан буулгана.

Хоёрдугаарт, тухайн хугацаа дуусахаас өмнө ЭЗЧБ-ийг зөвхөн дараах тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэрээр татан буулгана. Үүнд:

- Хүний амь болон эрүүл мэнд, байгаль орчин, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, үндэсний аюулгүй байдал болон улсын батлан хамгаалах хүчийг хангах шаардлагын улмаас,
- Бүс байгуулсан өдрөөс эхлээд нэг жилийн дотор нэг ч хуулийн этгээд болон хувиараа бизнес эрхлэгч тухайн бүсийн оршин суугчаар бүртгүүлээгүй,
- Дараалан 12 сарын турш бүсийн бүх оршин суугчид санал болгосон хөрөнгө оруулалтын төслөө хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулаагүй,
- ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусаа алдсанаас болж тухайн бүс нэг ч оршин суугчгүй болсон, бүсийн хамгийн сүүлчийн оршин суугч статусаа алдсан өдрөөс эхлэн нэг жилийн дотор нэг ч хуулийн этгээд болон хувиараа бизнес эрхлэгч оршин суугчаар бүртгүүлээгүй,
- ЭЗЧБ байгуулах Ерөнхийлөгчийн зарлигт тодорхойлсон бүс бүс байгуулах зорилгыг бусад шалтгааны улмаас биелүүлэх боломжгүй болсон.

ЭЗЧБ-ийг татан буулгахтай холбоотой боловсон хүчний болон бусад асуудлыг шийдвэрлэхдээ СЗ нь татан буулгах комиссыг байгуулах ба ЭЗЧБ-ийн захиргаа, түүний оршин суугч, бусад байгууллага, хуулийн этгээд нарын хоорондын харилцааны зохицуулалтаар комиссын бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тодорхойлж бүсийг татан буулгах журмыг батална.

Хуулиар хориотой үйл ажиллагааг ЭЗЧБ-д явуулахыг зөвшөөрөхгүй, мөн тухайн бүсэд түүний оршин суугчид дараах үйл ажиллагааг явуулах хориотой. Үүнд:

- Буу, тэсрэх сум, тэсэлгээний бодос болон тэсэлгээний багаж төхөөрөмжийг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах болон худалдаалах;
- Цацраг идэвхт болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, цэвэрлэх болон худалдаалах;
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис болон тэдгээрийн бэлдмэлийг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, худалдаалах болон устгах;
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх болон хордуулагч бодис агуулсан үржүүлэгчийг тариалах, ургуулах, боловсруулах, хадгалах болон худалдаалах;
- Оргилуун дарс, вино, шар айргаас бусад согтууруулах ундааны үйлдвэрлэл;
- Тамхины төрлийн үйлдвэрлэл;
- Үнэт цаас, банкны мөнгөн тэмдэгт, зоосон мөнгө, шуудангийн марк үйлдвэрлэх;
- Хонжворт сугалааны үйл ажиллагаа;
- Радио телевизийн техникийн үйлчилгээнээс бусад дуу бичлэгийн болон телевизийн хөтөлбөр бэлтгэх, нэвтрүүлэх;
- Хүн амын эрүүл мэндэд аюул учруулж буй өвчтэй хүмүүсийн эмчилгээ;
- Онц аюултай өвчин туссан амьтдын эмчилгээ;
- БНБУ-ын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй иргэд болон БНБУ-д түр хугацаагаар суугаа иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйл ажиллагаа.

Бүсийн үйл ажиллагааны төрлүүдийг ямар ЭЗЧБ байгуулах гэж байгаа, тухайн бүсэд явуулах үйл ажиллагааны мөн чанарыг харгалзан үзэн тодорхойлно. Мөн эдийн засгийн цогцолбор чөлөөт бүсийн үйл ажиллагааг явуулах, зорилгыг хэрэгжүүлэхдээ чөлөөт бүсийн янз бүрийн чиг үүргийн төрлүүдтэй нийцүүлэх шаардлагатай.

ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа болон түүний үр ашгийн ерөнхий хяналтыг Беларус улсын СЗ, тус улсын Төрийн Хяналтын Комисс, бүс нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо хэрэгжүүлнэ.

ЭЗЧБ-ийн менежмент болон санхүүжилт

ЭЗЧБ-ийн захиргаа нь СЗ-ийн институт хэлбэрээр байгуулсан БНУ-ын хуулийн этгээд юм. Бүсийн захиргааг тухайн бүсийн /Минск хот/ гүйцэтгэх хорооны саналаар СЗ-ийн албанд томилсон ЭЗЧБ-ийн захиргааны дарга удирдана. Харин захиргааны дэд дарга нарыг тухайн бүсийн гүйцэтгэх хороотой зөвшилцсөний үндсэн дээр ЭЗЧБ-ийн дарга албан тушаалд нь томилно.

Бүсийн захиргааны бүрэн эрхийн хүрээнд тус захиргааны дарга нь ЭЗЧБ-ийн захиргааны зөвлөлийг байгуулж болно.

Мөн ЭЗЧБ-ийн Хяналтын зөвлөлийг БНУ-ын болон орон нутгийн ашиг сонирхол, бүсийн оршин суугчид, бусад байгууллага, хувиараа бизнес эрхлэгч нарын ашиг сонирхлын зохистой нэгдлийг хангах зорилгоор СЗ, ЭЗЧБ-ийн дарга, СЗ-ийн төлөөлөгчид, тухайн бүс нутгийн гүйцэтгэх хороо, бусад байгууллага болон хувиараа бизнес эрхлэгч нарыг оролцуулан байгуулж болно. ЭЗЧБ-ийн Хяналтын Зөвлөлийн бүрэлдэхүүн болон зохицуулалтыг СЗ батална.

ЭЗЧБ-ийг байгуулах, аж үйлдвэрийн, технологийн, тээврийн болон бусад дэд бүтэц зэргийг хөгжүүлэх, ЭЗЧБ-ийн захиргаанд шилжүүлсэн өмчийг бүгд найрамдах улсын өмч хэвээр байхад нь туслах, ЭЗЧБ-ийн захиргаа зэрэг бүсийн үйл ажиллагаатай холбоотой бусад зардлын санхүүжилтыг хуулийн дагуу БНУ-ын төсөв болон бусад эх үүсвэрээс гаргана.

Чөлөөт бүсийн дэд бүтэц, зар сурталчилгаа, хэвлэлийн ажил, бүсийн захиргааны ажилчдын мөнгөн урамшуулал болон бусад санхүүжилтийг ЭЗЧБ-ийн Хөгжлийн сан гаргана. Тус Хөгжлийн сангийн хөрөнгийг ЭЗЧБ-ийн захиргаа хуваарилах эрхтэй ба хүлээн авсан хөрөнгийг зүй зохистой хэрэглэх зорилгоор Сангийн зөвлөл байгуулна. Хөгжлийн санг байгуулах тусгай эх үүсвэр, түүний хөрөнгийг зарцуулах чиглэл, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн болон бүрэн эрхийг ЭЗЧБ-ийн захиргааны саналаар СЗ баталсан ЭЗЧБ-ийн хөгжлийн сангийн зохицуулалтаар тодорхойлно.

ЭЗЧБ-ийн оршин суугч

ЭЗЧБ-ийн оршин суугч бол ЭЗЧБ-ын захиргааны хууль тогтоомжийн дагуу бүсийн оршин суугчаар бүртгэсэн БНБУ-ийн хуулийн этгээд, эсхүл БНБУ-ын хувиараа бизнес эрхлэгч байна хэмээн Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуульд томъёолсон байна.

ЭЗЧБ-ийн захиргаа нь зөвхөн бүсийн хилийн зааг дотор байрлах газартай, бүсийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээ байгуулсан БНБУ-ын хуулийн этгээд, эсхүл БНБУ-ын хувиараа бизнес эрхлэгч нар буюу субъектүүдыг бүсийн оршин суугчаар бүртгэх ба оршин суугчаар бүртгүүлэхэд татвар төлнө.

Хуулийн зорилгод хувиараа бизнес эрхлэгчийн байрлах газар нь тухайн хувиараа бизнес эрхлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тодорхойлогдсон түүний оршин суух газар байна.

Эдгээр субъектүүдыг ЭЗЧБ-ийн оршин суугчаар бүртгэх ажлыг ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээг байгуулсан өдөр, тухайн гэрээний үйлчлэх хугацаанд

хийх ба бүртгэл хийсэн өдрөөс эхлэн ажлын 3 өдрийн дотор ЭЗЧБ-ийн захиргаа нь СЗ-ийн баталсан загварын дагуу тухайн субъектүүдыг бүсийн оршин суугчаар бүртгэсэн гэрчилгээг олгоно.

Хэрэв чөлөөт бүсийн оршин суугчаар бүртгэхээс татгалзсан тохиолдолд ЭЗЧБ-ийн захиргаа шийдвэр гарснаас 3 ажлын хоногт багтан тухайн субъектүүдэд бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд субъектүүд тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш сарын дотор эдийн засгийн шүүхэд хандаж болно.

БНБУ-ын хууль эрх зүйн актад заасан жагсаалтад байгаа тодорхой үйл ажиллагааг ЭЗЧБ-ийн оршин суугч зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулна.

ЭЗЧБ-ын хууль тогтоомж, бусад хуулиар ЭЗЧБ-ийн оршин суугчдад баталгаа гаргана. Энэ нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжид зааснаар хөрөнгө оруулагчийн эрхийн болон хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгаа нь ЭЗЧБ-ийн оршин суугчдад хамаарах аж.

Бүсийн оршин суугчаар бүртгүүлсэн хуулийн этгээдийг өөрчлөхөд тухайн ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусыг хадгалах, шилжүүлэхийг дараах тохиолдолд зөвшөөрнө. Үүнд:

- ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусыг шинэ /өөрчлөгдсөн/ хуулийн этгээдэд хадгалуулна:
 - o өөр нэг хуулийн этгээдийг элсүүлэх хэлбэрээр өөрчлөхөд,
 - o нэг, эсхүл хэд хэдэн хуулийн этгээдэд хуваагдах хэлбэрээр өөрчлөхөд.
- ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусыг шинээр бий болсон хуулийн этгээдийн улсын бүртгэлд орсон цагаас эхлэн шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлнэ:
 - o өөрөө хувирах хэлбэрээр өөрчлөхөд.

Бүсийн оршин суугчийн өргөдлөөр ЭЗЧБ-ийн захиргааны шийдвэрийн дагуу, бүсийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээний нөхцөлийг биелүүлээгүй, эсхүл зохисгүй байдлаар биелүүлсэн, хуулиар тогтоосон капиталын хуримтлалын нөхцөл болон хууль тогтоомжид заасан бусад нөхцөлийн дагуу статусаа хасуулна.

Хуулийн этгээд, эсхүл хувиараа бизнес эрхлэгч буюу субъект нь ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусаа дараах тохиолдолд алдана. Үүнд:

- Бүсийг татан буулгах,
- Субъектэд өгсөн газар нь ЭЗЧБ-ийн хилийн заагаас хасагдсан,
- Тухайн субъектын явуулж буй үйл ажиллагаа дуусгавар болох,
- Хэрэв шинээр олгосон газар нь тухайн ЭЗЧБ-ийн нутаг дэвсгэрийн гадна байрлах болсноор тухайн субъектэд олгосон газрын байршил нь өөрчлөгдсөн,
- Бүсийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээ хүчингүй болсон.

ЭЗЧБ-ийг татан буулгасан, эсхүл тухайн субъектэд өгсөн газар нь ЭЗЧБ-ийн хилийн заагаас хасагдсанаас болж бүсийн оршин суугчийн статусаа алдсан субъект нь ерөнхий нөхцөлийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа бол төрийн өмчит газар, барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө түрээслэх гэрээ, хуульд заасны дагуу дуусгавар болсон эрх үүргийн гэрээг өгөгдсөн өмчийг шилжүүлэх эрхтэй төрийн болон бусад байгууллага тухайн субъектын хүсэлтээр түрээсийн үлдсэн хугацаанаас хэтрүүлэхгүйгээр дахин байгуулна. Газар түрээслэх гэрээнээс бусад гэрээний хувьд адилхан нөхцөлөөр дахин байгуулна.

ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээ

Оршин суугч нь хууль тогтоомж, ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулна. Гэрээг хуулийн этгээд, эсхүл хувиараа бизнес эрхлэгч болон ЭЗЧБ-ийн захиргааны хооронд байгуулна. Гэрээнд бүсийн оршин суугчийн санал болгосон хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн журам, нөхцөлийг тодорхойлж, төслийн хэрэгжих хугацааны турш байгуулна. Оршин суугч нь гэрээнд заасан эрх, үүргээ өөр нэг хуулийн этгээд болон хувиараа бизнес эрхлэгчээр төлөөлүүлэхийг хуулиар хориглоно.

Гэрээг оршин суугчийн өргөдөл дэх талуудын зөвшилцлөөр сунгаж болох ба өргөдлийг тухайн гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө 1 сараас хэтрэхгүй хугацаанд ЭЗЧБ-ийн захиргаанд мэдэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг үргэлжлүүлэх шаардлагатай, мөн боломжтойг нотолсон ЭЗЧБ-д хэрэгжих тухайн төслийн бизнес төлөвлөгөөг өргөдлийн хамт хүргүүлнэ.

ЭЗЧБ-ийн захиргаа тухайн баримт бичгийг ирсэн өдрөөс ажлын 10 хоногийн дотор авч хэлэлцэж шийдвэрлээд, оршин суугчид 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Гэрээг сунгахад ЭЗЧБ-ийн оршин суугчаар бүртгүүлэх хугацаа хамт сунгагдана.

Оршин суугч нь хууль тогтоомжид заасан ерөнхий журмын дагуу чөлөөт бүсийн гадна хөрөнгө оруулалтын болон хувиараа бизнес эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тухайн үйл ажиллагаа нь ЭЗЧБ-ийн тусгай эрх зүйн зохицуулалтад хамаарахгүй.

Бүсийг үүсгэн байгуулагч нь нутгийн өөрөө удирдах байгууллага юм. Аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчид болон бүсийг үүсгэн байгуулагчтай гэрээ байгуулсан бусад аж ахуйн нэгжүүд нь Бүсэд үйл ажиллагаа явуулахдаа бүсийн менежментийг хэрэгжүүлэгч компаниар дамжуулан, бүсийн зүгээс баталсан өргөдлийн маягтын дагуу хүсэлт гаргана.

Бүсийн үндэслэн байгуулалт нь эрх бүхий нутгийн өөрөө удирдах байгууллага, компани, эсхүл хувиараа бизнес эрхлэгчийн шийдвэрийг батлах, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага, компани, эсхүл хувиараа бизнес эрхлэгчтэй чөлөөт бүс байгуулах гэрээ хийх.

ЭЗЧБ-ийн тусгай эрх зүйн зохицуулалт

ЭЗЧБ-ийн татварын онцгой нөхцөлүүдийг БНБУ-ын Татварын Хууль, БНБУ-ын бусад хууль, БНБУ-ын Ерөнхийлөгчийн акт, БНБУ-ын гэрээний дагуу тогтоосон байна.

Гаалийн чөлөөт бүс

ЭЗЧБ-ийн нутаг дэвсгэрт оршин суугчдад зориулж гаалийн чөлөөт бүсийг байгуулна. Гаалийн чөлөөт бүсийг байгуулах болон үйл ажиллагааг дуусгавар болгох журам, түүний тоног төхөөрөмжийн шаардлага, ЭЗЧБ-ийн түрээслэгчдийн эрх үүргийг хууль эрх зүйн актын дагуу тодорхойлно.

Газрын харилцааны зохицуулалт

ЭЗЧБ дэх газрын харилцааг газар ашиглах болон хамгаалах талаарх хууль тогтоомжоор зохицуулна. ЭЗЧБ-д түрээсийн газрыг зохион байгуулах, ашиглах, төлбөр төлөх талаарх харилцааг ЭЗЧБ-ийн хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу эрх зүйн актаар зохицуулна.

Хөдөлмөрийн болон холбогдох харилцааны зохицуулалт

ЭЗЧБ дэх хөдөлмөрийн болон холбогдох харилцааг хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

ЭЗЧБ-ийн хөдөлмөрийн нөөцийн нөхцөлийн хувьд юуны өмнө орон нутгаас, мөн ажил олгогчийн хүсэлтээр БНБУ-ын бусад нутаг дэвсгэрээс, хуулийн дагуу гадаадын иргэд болон харьяалалгүй иргэдийг оролцуулах замаар бүрдүүлнэ.

3.4. БҮГД НАЙРАМДАХ СЕРБИ УЛС

Эрх зүйн зохицуулалт

Серби улсад чөлөөт бүстэй холбоотой харилцааг 2006 онд батлагдсан Чөлөөт бүсийн тухай хуулиар³⁷ зохицуулах ба энэхүү хууль нь чөлөөт бүс байгуулах, чөлөөт бүст үйл ажиллагаа эрхлэх, чөлөөт бүсийг татан буулгах болон чөлөөт бүсийн удирдлагын бүрэн эрхийг тодорхойлно.

Бүсийг үүсгэн байгуулагч, Бүсийн менежментийн компани болон Бүсийн хэрэглэгчийн хуулиар тогтоосон эрх нь бусад ямар ч хууль, эсхүл зохицуулалтаар хязгаарлагдахгүй байх баталгаат эрхийг Чөлөөт бүсийн тухай хуулиар баталгаажуулсан байна.

Чөлөөт бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 9 бүлэг, 39 зүйлтэй:

- I. Нийтлэг үндэслэл: Хуулийн агуулга, Нэр томьёоны ойлголт, Баталгаат Эрх.
- II. Орон зайн тодорхойлолт: Бүсийн Орон зайн Тодорхойлолт, Өргөдлийн шаардлага, Өргөдлийн Агуулга.
- III. Бүсийн журам болон менежмент: Бүсийн Менежмент, Бүсийн хэрэглэгчид, Бүсийн Журам, Үйл ажиллагааны эхлэл.
- IV. Бүсийн бизнесийн үйл ажиллагаа: Бүсэд Үйл Ажиллагаа Явуулах.
- V. Бүсийн үйл ажиллагааг зогсоох: Бүсийн орон зайг тодорхойлох зөвшөөрлийг хүчингүй болгох, Бүсийн Үйл Ажиллагааг Зогсоох.
- VI. Чөлөөт бүсийн захиргаа: Чөлөөт Бүсийн Захиргааны Бүрэн Эрх
- VII. Хуулийн хэрэгжилтийн хяналт.
- VIII. Хуулиар шийтгэх нөхцөл.
- IX. Шилжилтийн болон төгсгөлийн нөхцөл.

Энэхүү Хуульд хэрэглэгдэх доорх нэр томьёог дараах утгаар ойлгоно:

1. **Бүсийн менежментийн компани** нь Бүс дотор үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөхцөлөөр хангах компани;
2. **Холбогдох этгээд** корпорацийн ашгийн татварыг зохицуулах хуулийн хүрээний хүн;
3. **Бүсийн хэрэглэгч** нь бүс дотор үйл ажиллагаа явуулах хувь хүн буюу хуулийн этгээд;

ЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах

Чөлөөт бүс нь Серби улсын нутаг дэвсгэрийн нэг хэсгийг тусгайлан хилээр загалсан байх ба бүс доторх үйл ажиллагаа нь Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу явагдана.

Бүсийн орон зай нь кадастраар тодорхойлсон газар болон боломжит хэмжих нэгжээр илэрхийлсэн гадаргуу хэсэг хэмээн Чөлөөт бүсийн тухай хуульд томьёолсон байна. Бүсийн менежментийн компани нь Сангийн ямаар дамжуулан Засгийн газарт бүсийн

³⁷Law on free zone, "RS Official Gazette", No 62/2006.

орон зайн тодорхойлолтын зөвшөөрөл хүссэн өргөдлөө ирүүлэх ба бүсийн орон зайг Засгийн Газар шийдвэрлэнэ.

Бүсийн менежментийн компани нь бүсийн орон зайн тодорхойлолтын зөвшөөрөл хүссэн өргөдөл хүргүүлэхдээ:

1. Бүсийн менежментийн компани үүсгэн байгуулагчид нь бүсийн үүсгэн байгуулагч байх ба зөвхөн нэг бүсийн менежментийн компанийн үүсгэн байгуулагч байна,
2. Бүсийн менежментийн үйл ажиллагаа явуулахад Эдийн засгийн операторуудын бүртгэлд орно;
3. Бүсийг үүсгэн байгуулагч хариуцлагатай этгээд нь эдийн засаг, эд хөрөнгө, хууль бус худалдаа, болон албан үүргийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэн шийтгэгдээгүй байх. Эхний догол мөрөнд хамаарах шаардлага нь Бүсийн менежментийн компанид холбогдох этгээд болон эрх зүйн залгамжлагч нь Бүсийн менежментийн компани байх хуулийн этгээдэд хамаарна;
4. Бүсийн менежментийн компанийн хариуцлагатай этгээд нь өмнөх 3 жилд удирдах зөвлөлийн болон хяналтын зөвлөлийн гишүүн байгаагүй, үйл ажиллагаа нь татан буугдсан, эсхүл дампуурсан хуулийн этгээдтэй хамааралгүй байх;
5. Бүсийг үүсгэн байгуулагч нь чөлөөт бүсийн менежментийн компанийн үүсгэн байгуулагч байж болохгүй ба энэ тохиолдолд засгийн газрын шийдвэрээр чөлөөт бүс үүсгэн байгуулах зөвшөөрөл нь хүчингүй болно. Энэ шаардлага нь нутгийн өөрөө удирдах байгууллагад хамаарахгүй.

Сангийн яам өргөдлийн эдийн засгийн зохицуулалтыг нь хийж саналыг Засгийн газарт хүргүүлнэ. Хэрэв судалгааны дүгнэлт нь гадаадын хөрөнгийг татах, бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон үйлчилгээний нөхцөл, хөдөлмөр эрхлэлт, шинэ технологийн шилжилт, эдийн засгийн шинэчлэлийн эерэг үр дүн, мөн бүсийн үйл ажиллагаа нь Засгийн газрын хөгжлийн стратеги, эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд эергээр нөлөөлж байхаар гарсан бол ЧБ-ийн орон зайг тогтоох явц нь эдийн засгийн хувьд зохицуулалттай байна гэсэн үг юм. Засгийн газар нь бүсийн орон зайг тогтоохын тулд эдийн засгийн зохицуулалтын дүгнэлтийн талаарх дээрх дурдагдсан шалгууруудыг гаргах ёстой.

Засгийн газар нь холбогдох газар төслөө өгсөн өдрөөс 30 хоногийн дотор Бүсийн орон зайг тогтоох шийдвэрээ гаргах ба шийдвэр гарснаас хойш 2 жилийн дотор бүсийн үйл ажиллагаа эхлүүлэхгүй бол хүчингүй болно. Бүсийн орон зайг тогтоох зөвшөөрөлд холбогдох хуулийн нөхцөл нь бүсийг өргөтгөхөд мөн хамаарна.

Бүсийг эхлүүлэх шаардлагын дагуу үйл ажиллагааг холбогдох удирдлагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн комиссын саналыг үндэслэн Сангийн яамнаас тодорхойлно. Комисс нь бүсэд үйл ажиллагаа явуулах өргөн уудам орон зай, эрчим хүч, байгал орчныг хамгаалах болон бусад техникийн шаардлагын дагуу гаалийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны шаардлага, гаалийн хяналтын ажлыг гүйцэтгэх шаардлагуудыг тодорхойлно. Сангийн сайд комиссын саналыг хүлээж авснаас 30 хоногийн дотор шийдвэрээ гаргана.

Бүсэд үйл ажиллагаа явуулахад Чөлөөт бүсийн тухай хуулиас гадна бүсийн менежментийн компанитай хийсэн гэрээний дагуу хэрэглэгч бүс доторх үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөлийг мөрдөх ба байгал орчин, хүний эрүүл мэнд, бараа бүтээгдэхүүн болон улсын аюулгүй байдалд аюул учруулахгүй байх ёстой.

Бүс доторх гадаад худалдаа нь гэрээний дагуу ямар нэгэн хязгаарлалтгүй байна. Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, импорт нь хязгаарлалтгүй байх, тэдгээрийн тоо хэмжээний хязгаарлалт болон худалдааны бодлогын хэмжүүр байх ёсгүй. Хэрэв

тухайн бараа бүтээгдэхүүний худалдаа нь хориотой бол бүсэд тус барааг экспортлож, импортлохыг хориглоно.

Бүсэд оруулж ирсэн, бүсээс гаргасан, бүсэд хадгалж байгаа бараа бүтээгдэхүүнийг гаалийн бараа бүтээгдэхүүн гэж үзнэ.

Дараах зорилгоор барааг түр хугацаагаар бүсээс гарган БНСУ-ын нутаг дэвсгэрийн өөр нэг хэсэгт байрлуулах, эсхүл БНСУ-ын өөр нэг хэсгээс бүсэд бараа оруулж ирж болно. Үүнд:

- Хэрэглэгч нь дотоод, гадаад боловсруулалтын технологийн үе шатанд оруулах зорилготой бол,
- Хэрэглэгч нь туршиж үзэх, албан ёсны баталгаа, сэргээн засах болон маркетингийн танилцуулга хийх зорилготой бол.

Холбогдох гаалийн мэргэжилтнүүд тогтоосон бараа бүтээгдэхүүний гаалийн зөвшөөрсөн үйлчилгээг үзүүлэх ба заасан нөхцөлийн дагуу тухайн бараа нь бүс дотор үйлдвэрлэгдсэн болохыг баталсан гэрчилгээ олгоно.

Хэрэглэгч гаалийн хяналт шалгалтын арга хэмжээний гүйцэтгэлийг хангах болон импортын /бүсэд орж ирсэн/, экспортын /бүсээс гарсан, бүсэд хэрэглэгдсэн барааны/ бүртгэлийг хадгалах үүрэгтэй.

Бүсийн орон зайн зөвшөөрлийг Засгийн газрын актаар хүчингүй болно. Үүнд:

1. Бүсийн үйл ажиллагааны явцад бүсийг үүсгэн байгуулах Чөлөөт бүсийн тухай хуульд заасан техникийн шаардлагыг байнга биелүүлэхгүй байгаа тохиолдолд,
2. Бүсийн менежментийн компанийн хариуцлагатай этгээд болон хууль ёсны залгамжлагч нь бүсийн менежментийн компани байх хуулийн этгээдийн хариуцлагатай этгээд нь эдийн засаг, өмч хөрөнгө, албан татварын эсрэг, эсхүл хууль бус наймааны гэмт хэрэг үйлдэн шүүхийн шийдвэрээр яллагдаж байсан тохиолдолд,
3. Бүсийн үйл ажиллагааны талаар сангийн яамны саналаар:
4. Дараах тохиолдолд бүсийн орон зайг тогтоох зөвшөөрлийг хүчингүй болгох Сангийн яамны саналаар:
 - Засгийн газар бүсийн бизнесийн үйл ажиллагаа нь бүсийн орон зайг тогтоох эдийн засгийн зохицуулалтын судалгаанд оруулсан зорилтыг биелүүлээгүй гэж дүгнэсэн тохиолдолд,
 - Бүсийн менежментийн компани зөрчил гаргасан тохиолдолд,
 - Бүсийн менежментийн компани нь бүсэд бизнесийн үйл ажиллагаа явуулах шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд,
 - Хэрэглэгч-хуулийн этгээд зөрчил гаргасан бүсийн хэрэглэгчидтэй гэрээгээ цуцлах арга хэмжээ аваагүй тохиолдолд,
 - Гаалийн систем болон процедурыг зохицуулж буй хуульд заасан ямар нэгэн зөрчил гаргасан
5. Бүсийн менежментийн компанийн хүсэлтээр;

Бүс нь Засгийн газар бүсийн орон зайг тогтоох зөвшөөрлийг хүчингүй болгосон актыг гаргаснаас 90 хоногийн хугацаа өнгөрснөөр үйл ажиллагаагаа зогсооно.

Бүсийн менежментийн компани, тухайлбал хэрэглэгч нь дээрх хугацаа дууссанаас 60 хоногийн дотор хийлийн чанадаас импортолсон барааг зарж дуусгах, тэдгээр барааг гадаад орон руу буцаах, эсхүл үнэгүй борлуулахаар гаалийн газарт хүргүүлэх үүрэгтэй.

Гааль, бусад импортын татвар нь барааны нөхцөлийн дагуу болон гаалийн мэдүүлгийг хүлээж авсан өдрөөс хүчин төгөлдөр болсон зохицуулалтын дагуу гаалийн газарт хүргүүлэх бараанд тооцно. Энэ нөхцөлд онцгойлон бүсэд үйл ажиллагаа явуулах зорилгоор бүсийн үйл ажиллагааг зогсоохоос хамгийн багадаа 3 жилийн өмнө бүсэд импортоор орж ирсэн тоног төхөөрөмжид гаалийн татвар ногдуулахгүй. Гэхдээ энэ нөхцөл нь гааль, бусад импортын татварын төлбөрөөс чөлөөлөхөд үндэслэсэн бусад журмыг хэрэглэхгүй.

Бүсийн менежмент

Бүсийн менежментэд бүртгэгдсэн бүсийн менежментийн компани нь бүсийг удирдана. Бүсийг зөвхөн нэг бүсийн менежментийн компани удирдаж болно. Бүсийн менежментийн компани нь бүс дотор үйл ажиллагаа явуулахад зохион байгуулалтын болон техникийн шаардлагуудыг тусгайлан заана. Хуульд заасан баримтаар Бүсийн ажлын цаг, бүс доторх хүн болон барааны шилжилт, бүсийг ашиглахад хангалттай орон зай, техникийн болон зохион байгуулалтын шаардлагыг хангах бүсийн менежментийн компанийн хүлээсэн үүрэг, бүс доторх хөдөлмөр хамгааллын болон байгал орчин хамгаалах ажлууд, бүсийг үүсгэн байгуулагчтай холбогдох бүсийн хэрэглэгчдийн эрх үүрэг зэргийг тодорхойлно. Бүсийн менежментийн компани нь Чөлөөт Бүсийн Захиргааны зөвшөөрлийг авахдаа хуульд заасан баримтыг хүргүүлэх үүрэгтэй. Бүсийн менежментийн компани нь бүсийн хэрэглэгчтэй өөрсдийн харилцан эрх үүрэг болон хуульд заасан баримтын элементүүдийг багтаасан гэрээ байгуулна.

Бүсийн менежментийн компани нь бүсийн бизнесийн үйл ажиллагааны тайланг хуанлийн жил дууссанаас 90 өдрийн дотор Чөлөөт Бүсийн Захиргаанд өгөх үүрэгтэй. Бүсийн бизнесийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Бүсийн менежментийн компанийн орлого;
- Хэрэглэгчдийн тоо болон тэдний явуулсан үйл ажиллагаа;
- Бүсэд хийгдсэн үйлчилгээ болон үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүний нийт өртөг;
- Бүсийн экспорт импортын нийт хэмжээ;
- Гадаадын капиталын хэмжээ;
- Бүсийн менежментийн компанийн ажилчдын тоо болон бүсийн хэрэглэгчдийн ажилчдын тоо;

Бүсийн журам

Бүс нь хашигдсан, орох гарах хаалган дээрээ болон голын эрэг дагуу чөлөөт бүс гэсэн таних тэмдэгтэй байна. Бүс нь ганц үйл ажиллагааны нэгжтэй хэд хэдэн хэсэгтэй байна. Хэрэв бүс хэд хэдэн хэсгээс бүрдэж байвал бүс, эсхүл түүний хэсэг нь тусгаарлах хашаатай, таних тэмдэгтэй, бараа бүтээгдэхүүн болон иргэдийг бүс рүү орох болон бүсээс гарахад тусгай орох гарах хаалгыг байрлуулах зэргээр зохицуулалт хийнэ. Хашлага, орох гарах хаалга нь чөлөөтэй, аюулгүй байдал хангасан байх ба шөнө гэрэлтүүлэгтэй байна. Бүсийн менежментийн компани нь гаалийн мэргэжилтнүүдийг үйл ажиллагаа явуулахад нь урьдчилсан нөхцөлөөр хангах ёстой. Гаалийн шалгалт, хяналтын арга хэмжээ нь гаалийн систем болон процедурыг зохицуулдаг хуулийн нөхцөлийн дагуу бүс рүү орж гарсан бараа бүтээгдэхүүн, түүнчлэн бүсэд хадгалагдаж байгаа бараанд тавигдана.

Бүсийн хэрэглэгчид

Бүсийн хэрэглэгч нь бүсийг үүсгэн байгуулагч, бүсийн менежментийн компани болон бусад дотоод гадаадын хуулийн этгээд болон хувь хүн байна (цаашид “хэрэглэгчид” гэх). Хэрэглэгчид нь журмын дагуу бүсийн менежментийн компанитай хамтын эрх үүргээ зохицуулах гэрээг үндэслэн бүсэд эдийн засгийн үйл ажиллагаа явуулна. Хэрэглэгчид бүсийн үйл ажиллагааны орлого зарлага бүртгэх, эсхүл бүсэд явагдаж буй тэдний

бизнесийн үйл ажиллагааны хэсэгт тусад нь орлого зарлага бүртгэх үүрэгтэй. Хэрэглэгчид нь Чөлөөт Бүсийн Захиргааны хүсэлтээр бизнесийн үйл ажиллагааныхаа мэдээллийг Захиргаанд өгөх үүрэгтэй.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Бүсэд үйл ажиллагаа явуулах болон барилга барихад зориулагдсан бараа бүтээгдэхүүний импортод гаалийн татвар болон бусад импортын татвар ноогдуулахгүй. Бүсээс БНСУ-ын нутаг дэвсгэрийн зах зээлд гарсан бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар болон бусад импортын татвар ноогдуулна. Бараа бүтээгдэхүүнийг БНСУ-ын нутаг дэвсгэрийн зах зээлд гаргасан этгээд тохиромжтой гаалийн процедурын гүйцэтгэлийг хангахын тулд гаалийн газарт тухайн барааны талаар мэдэгдэх үүрэгтэй.

Хуульд заасан бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар болон бусад импортын татвар төлөх өр нь бүсээс барааг БНСУ-ын нутаг дэвсгэрт гаргасан өдрөөс эхэлнэ. Барааны гаалийн татвар болон бусад импортын татварын хэмжээ нь барааны нөхцөл болон гаалийн мэдүүлэг хүлээн авсан өдрийн хүчинтэй зохицуулалтын дагуу тодорхойлогдоно. Мөн барааны гаалийн үнэ болон гаалийн өрийн хэмжээ нь гаалийн систем болон процедурыг зохицуулдаг хуулийн нөхцөлийн дагуу тодорхойлогдоно.

Нэмүү өртгийн татварыг зохицуулдаг хуулийн нөхцөл нь бүсэд бараа бүтээгдэхүүн оруулах болон үйлчилгээ үзүүлэхэд хамаарна. Хэрэглэгчид, тухайлбал бүсийн менежментийн компанид, корпорацийн ашгийн татвар, хөдлөх хөрөнгийн татвар болон хувийн ашгийн татварыг зохицуулдаг журмын дагуу татварын хөнгөлөлт үзүүлж болно.

Чөлөөт бүсийн захиргаа

ЧБ-ийн захиргаа нь чөлөөт бүсийн салбарт төрийн захиргааны ажил явуулах зорилгоор сангийн яамны дотор захиргааны нэгж хэлбэрээр байгуулагдах ба захиргааг захирал удирдана.

ЧБ-ийн захиргаа нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Бүсийн хөгжилтэй холбоотой, улсын ашиг сонирхолд нийцсэн:
 - Шууд хөрөнгө оруулалтын урсгал болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бүсийн хөгжлийн төлөө үндэсний бодлогыг хэрэгжүүлэх,
 - Бүсийн үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж боловсруулахад оролцох;
 - Бүсийн орон зайг тогтоох зөвшөөрлийн өргөдөлтэй танилцан саналыг сангийн яаманд хүргүүлэх,
 - Хуулийн зохистой хэрэгжилт, бусад хууль журамд нийцүүлэн түүнийг хангах зорилгоор бүсийн үйл ажиллагааны талаар тусгай шинжээчийн дүгнэлтийг холбогдох төрийн удирдлагуудтай хамтран санаачлах болон уялдуулах,
 - Холбогдох төрийн удирдлагууд, бүсийн менежментийн компани, хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийн хооронд хамтын ажиллагаа зохион байгуулах, уялдуулах,
 - Бүсэд хөрөнгө оруулах талаар шийдвэр гаргах явцад, хөтөлбөр хэрэгжүүлэх бүх шатанд хөрөнгө оруулагчид болон менежментийн компаниудад шинжээчийн туслалцаа үзүүлэх,
 - Хөрөнгө оруулагчид, бүсийн менежментийн компаниуд хооронд шууд гэрээ байгуулах,
 - Сербийн Худалдааны Танхим, ашгийн бус болон сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллах,
 - Бүсийн талаар олон улсын байгууллага болон шинжээч нартай хамтран ажиллах;

- Бүсийн менежментийн компанитай хамтран ажиллах хүрээнд бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх.
- 2. Бүсийг дэмжихэд холбогдох:
 - Сангийн яам болон Сербийн Хөрөнгө Оруулалт, Экспортыг Дэмжих Агентлагын /СИЭПА/ баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу онцгой урамшуулал, бизнесийн боломж олгох замаар бүсэд хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг дэмжих тал дээр СИЭПА-тай хамтран ажиллах;
 - Бүсэд хөрөнгө оруулахын давуу талын талаар хөрөнгө оруулагчдад мэдээлэх;
 - СИЭПА-тай хамтран ажиллах хүрээнд бүсийн мэдээллийн баазыг шинэчлэх, Сербийн бизнесийн үйл ажиллагааны давуу талыг бий болгох.
- 3. Бүсийн хяналт шалгалтад холбогдох:
 - Бүсийн үйл ажиллагааны талаарх тайланг авч үзэх, тэднийг батлуулах тал дээр сангийн яаманд санал хүргүүлэх;
 - Сербийн бүх бүсүүдийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Бүсийн орон зайг тогтоох зөвшөөрлийн өргөдлийн маягтын агуулга болон загвар, бизнесийн үйл ажиллагаа, бүс болон хэрэглэгчийн үйл ажиллагааны хяналтын талаар Сангийн яаманд санал хүргүүлэх;
 - Шаардлагатай гэж үзвэл бүсийн бизнесийн үйл ажиллагааны хяналтын нэмэлт арга хэмжээний талаар холбогдох төрийн удирдлагуудад санал хүргүүлэх.

3.5. ДОМИНИКАНЫ БҮГД НАЙРАМДАХ УЛС

Доминиканы Бүгд Найрамдах Улс нь олон улсын шилдэг туршлагыг ашиглан ХЧБ-ийг байгуулан ажиллаж буй орон юм.

Тус улс нь хойгуураа АНУ-тай, баруун талаараа Хайти Улстай хил залгаж, Карибийн арлын төв дунд оршдог, 48,000 км² газар нутагтай, 8.8 сая хүн амтай бөгөөд түүнээс 3 сая нь ажиллах хүч, экспорт US\$5.3 тэрбум, импорт нь US\$ 8.7 тэрбум байдаг байна.

1969 онд улс оронд шинэ ажлын байр бий болгох, гадаад валют солилцоог нэмэгдүүлэх, экспортын бус бүтээгдэхүүнүүдийг нэмэгдүүлэх зорилготойгоор анхны ХЧБ-ийн хөтөлбөрийг ямар нэгэн зардал үр ашгийн тооцоогүйгээр хэрэгжүүлж эхэлсэн байдаг.

Одоогоор тус улс нь 53 ХЧБ-ийн хөтөлбөрөөр 520 компанийг бий болгож, 171,000 хүнийг ажлын байраар ханган, нийт 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Нийт үйлдвэрлэлийн 50 хувийг хувцасны үйлдвэрлэл, 17 хувийг үйлчилгээ, 5 хувийг электрон барааны үйлдвэрлэл, 5 хувийг үнэт эдлэл, 3 хувийг эмийн үйлдвэрлэл, 12 хувийг гутлын үйлдвэрлэл, хэвлэх болон бусад үйлдвэрлэл эзэлдэг.

АНУ нь тус улсын ХЧБ-ийн экспортын хувьд хамгийн том зах зээл болдог бөгөөд нийт бүтээгдэхүүний 90 гаруй хувийг авдаг.

Доминиканы ХЧБ-ийн хөтөлбөр нь эрс ялгаатай 2 өөр үе шатанд хуваагдах ба энэ нь хөтөлбөрийн орчныг бүрдүүлэхтэй шууд холбоотойгоор үр дүнгээ өгсөн байна. Тухайлбал,

А. 1-р үе: 1969-1980

Энэ үед тус хөтөлбөр нь дараах асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байсан. Үүнд:

- Тодорхой хугацаанд татвараас чөлөөлөх явдлыг онцгойлон дэмжсэн нь санхүүгийн өсөлтийг бий болгосон. Тиймээс татвараас хязгаарлалтгүй чөлөөлөх, барааг татваргүй болгох

- Хууль эрх зүйн тогтолцоо сул.
- Орон нутгийн эдийн засагтай холбоо харилцаагүй
- Валютын ханшийг тогтвортой барих бодлогыг боловсруулах
- Орон нутгийн зах зээлд хууль бусаар хил давуулсан бараанд хяналт тавих гаалийн хүчтэй үүрэг ролийг эс тооцвол эрх мэдэл бүхий удирдлагын тогтолцоо байхгүй
- ХЧБ-ийн хөтөлбөрөөр нь нийслэл хот руу чиглэж байгаа суурьшигчдийн хөдөлгөөнийг эсрэг зүгт шилжүүлэх (туйлын өсөлтийн) бодлогыг баримталсан.
- Зар сурталчилгааны дэмжлэг сул байсан

Энэхүү үеийн үр дүнд нийт 3 ХЧБ-ийн хөтөлбөр хэрэгжиж, 71 компани үйл ажиллагаагаа явуулж эхлэн нийт 16,000 ажлын байр бий болсон хэдий ч дээрх асуудлуудыг бүрэн шийдвэрлэж чадаагүй юм. Энэ үеийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн ихэнхийг буюу 95 гаруй хувийг АНУ эзэлж байжээ. Бүсийн компаниудад хувцасны үйлдвэрлэл зонхилж, АНУ-д дахин экспортод гаргадаг байсан байна. Энэ үе шатанд хөтөлбөрийн гол давуу тал нь **оёдлын үйлдвэрлэлийн 1980 оны хүртэлх тус улсын квотын чөлөөт байдал** байсан юм.

В. 2-р үе шат: 1980-2002

Энэ үед тус хөтөлбөр нь эдийн засгийн шинэчлэлтийг нийт орон даяар хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнээс **хамгийн чухал нь валютын ханшийг чөлөөлсөн явдал** байжээ. Мөн дараах асуудлуудыг шийдвэрлэхээр зорьсон байна. Тухайлбал,

- Өрсөлдөхүйц хууль эрх зүйн орчин, тохирсон дүрэм журмуудыг бий болгох
- Тусгай мэргэжлийн ХЧБ-ийн удирдлагыг бий болгож хооронд нь нэгтгэх
- Зах зээлийн эрэлт дээр үндэслэсэн ХЧБ-ийг байгуулах
- Сурталчилгааны идэвхтэй үйл ажиллагаа эрчимжүүлэх

Хоёрдугаар үе шатанд хууль эрх зүйн орчныг бүрдүүлснээр 50 Худалдааны Чөлөөт Бүс, 449 компани, 155,000 ажлын байруудыг шинээр бий болгож чадсан байна. Татварын шинэ бодлого, санхүүгийн эрх чөлөөг дээрх хоёр үе шатны аль алинд баримтлан хэрэгжүүлсэн нь 2-р үе шатанд хурдацтай өсөлт гарах боломжийг бүрдүүлсэн гэж үздэг.

Оёдлын экспорт ХЧБ-үүдийн үйл ажиллагаанд дарамт болоогүйгээр барахгүй, 1980 онд квотын практикийг анх нэвтрүүлж байх үед 65 байсан бол 2-р үе шатанд 225 болтлоо өссөн явдал нь үйлдвэрлэлийн түүхэн туршлага дээр үндэслэсэн хувийн хэвшлүүдийн оролцоотой үйл явц байсан байна.

ХЧБ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- Урт хугацаанд үргэлжилсэн ажилгүйдлийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чадсан
- Доминиканы эзэмшлийн олон компаниуд технологийн шилжилтийг амжилттай ашиглах болсон
- Экспортын үйл ажиллагааны туршлагатай, үндэсний мэдлэг чадвартай хувийн хэвшлийнхний анги бий болж эхэлсэн
- Гадаад валютын гүйлгээ нь 1 тэрбум ам. долларт хүрсэн нь валютын нөөцийг нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн
- Ажилчдын 90 гаруй хувь нь татвар авах хэмжээнээс бага орлоготой байсан учир орлогын татварыг маш багаар тогтоосон. Хэдийгээр ХЧБ нь орон нутгийн худалдаанд чухал эерэг нөлөө үзүүлсэн талаар үнэлэмж байхгүй боловч ажилчдын худалдан авах чадвар дээшилснээс улсын төсөвт шууд бус орлогыг нэмэгдүүлж, ХЧБ-ийн байгууллага албан газрууд тэдгээрийн ажилчдад үйлчилгээ явуулах зорилго бүхий жижиг болон дунд үйлдвэрлэлүүдийг шинээр бий болгож өгсөн зэрэг олон давуу талууд бий болсон байна.

Доминиканы ХЧБ-ийн хөтөлбөр нь микро түвшинд амжилттай хэрэгжсэнийг дээрх дүгнэлтээс тодорхой харж болно. Гэвч санхүүгийн эрх чөлөө, хаалттай маягийн орчин нь Дэлхийн худалдааны байгууллагын нөхцөлд зааснаар экспортоос татаас авагч болдог учраас бусад төв Америкийн болон Карибын бүсийн улсуудтай худалдааны чөлөөт бүсийн гэрээ хэлэлцээрийг байгуулахад гол бэрхшээл болсоор байгаа юм байна.

Хууль, эрх зүйн зохицуулалт

Тус улс ХЧБ-ийн хөтөлбөрийн 2-р үе шатандаа хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт тавьж Чөлөөт бүсийн үйл ажиллагааг зохицуулдаг бие даасан хууль боловсруулсан. “Чөлөөт бүсийг дэмжих тухай” хуулийг 1990 оны 1 сарын 15-нд баталсан бөгөөд хууль нь 12 бүлэг 52 зүйлтэй. Хуулийн гол зорилго нь шинээр үүсгэн байгуулагдах чөлөөт бүс болон үйл ажиллагаа явуулж буй чөлөөт бүсүүдийн хөгжлийг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, энд дэвшүүлсэн зорилгод хүрэхэд улсын болон хувийн секторуудын хүчин чармайлтыг чиглүүлэхэд оршино.

“Чөлөөт бүсийг дэмжих тухай” хуульд тодорхойлсноор чөлөөт бүс гэдэг нь гадаадын зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой компаниуд үйл ажиллагаагаа явуулж, цаашдын хөгжилд нь таатай боломж урамшууллуудыг эдэлдэг хуулиар үндэслэгдсэн санхүү болон гаалийн хяналтын тусгай нөхцөл бүхий газар нутгийг хэлдэг байна.

Тус хуулийн 3 дугаар бүлгийн 6-р зүйлд Чөлөөт бүсийн байршил, төрөл зүйлийг 3 ангилсан. Үүнд:

- *Аж ахуйн үйл ажиллагаа болон үйлчилгээний чөлөөт бүс*- Энэ нь үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа явуулах бүс бөгөөд уг чөлөөт бүсийг газар нутгийн хаана ч, хэн ч байгуулахыг зөвшөөрдөг боловч чөлөөт бүсийн захиргаанаас шинэ техник технологи, өндөр мэдлэг, чадвар бүхий боловсон хүчний шалгуурыг тавьж болдог байна.
- *Хилийн чөлөөт бүс*- энэ бүс нь Доминикан Улс болон Хайти хоёр улсын хилээс 3 километрээс багагүй, 25 километрээс холгүй зайд байрлуулна. Энэ бүсэд хуулиар олгосон урамшуулал, хөнгөлөлтүүдээс гадна орон нутаг, чөлөөт бүсийн захиргаанаас мөн хөнгөлөлт, урамшууллыг үзүүлж болдог.
- *Тусгай чөлөөт бүс*- энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон боловсруулахад шаардлагатай хөдөлгөж, тээвэрлэх боломжгүй байгалийн баялаг байх тохиолдолд түүний ойролцоо болон дэргэд нь тусгай бүсийг түр болон удаан хугацаагаар байгуулж болно. Ингэхдээ энэ хуулийн дагуу тусгай бүс байгуулах компаниудад бүтээгдэхүүнийхээ 80 хувийг экспортолдог, багадаа 1 байршилд 200 ажилтантай байх шаардлага тавьдаг байна.

Чөлөөт бүсийн удирдлага зохион байгуулалт:

Чөлөөт бүсийн асуудлыг хуульд заасны дагуу Чөлөөт Бүсийн Үндэсний Консулын /ЧБҮК/ газар хариуцдаг. Консулын газар нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж, компани, үйлчилгээний байгууллага, хувь хүмүүсийн харилцааг зохицуулж, экспортын чөлөөт бүс байгуулах өргөдөл хүсэлтийг шийдвэрлэн, үнэлэх, тодорхойлох, гүйцэтгэх эрх мэдлийг санал болгох, үйл ажиллагааны зөвшөөрлийг өгөх, сунгах, татгалзсан санал өгөх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигчдөд зохих арга хэмжээ авах хүртэл өргөн хүрээний үүрэгтэй томоохон эрх бүхий алба юм.

ЧБҮК нь Экспортын чөлөөт бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхээс гадна улс үндэстний болон гадаадын гэрээ хэлэлцээр байгуулахад оролцох, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, чөлөөт бүсийн хөгжлийн бодлогыг тоймлох санал оруулах эрхтэй. ЧБҮК-ын гишүүд нь улсын болон хувийн секторуудын төлөөллөөс бүрддэг.

Чөлөөт бүсийн хөнгөлөлт, чөлөөлөлт:

Хуулийн гол онцлог нь бүтээгдэхүүнийг өсгөх, ажлын байрыг бий болгох, гадаад арилжаа худалдааны таатай боломжийг бүрдүүлсэн татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг бий болгосон явдал юм. Чөлөөт бүсийн оролцогч компани, аж ахуйн нэгжүүд нь гааль, санхүүгийн дэглэмээр хамгаалагдах ба олон татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг эдэлдэг. Чөлөөт бүсийн тухай хуулийн 7-р бүлгийн 24-р зүйлдд зааснаар дараах төрлийн татваруудаас 100 хувь чөлөөлнө. Тухайлбал,

- Чөлөөт бүсэд хийгдэж буй бүтээн байгуулалтад хэрэглэгдэх түүхий эд, материал, багаж, тоног төхөөрөмж, машин техник оруулж ирж байгаа тохиолдолд, мөн чөлөөт бүсийн ажилтнууд болон оршин суугчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор импортлосон бүтээгдэхүүн, үйлчилгээг импортын татвараас
- Тодорхой нөхцөлүүдийг харгалзан орлогын албан татвараас
- Бүх экспорт болон дахин экспортолсны татвараас
- Бүх импортын зөвлөгөөний татвараас
- Патент, үл хөдлөх хөрөнгийн татвараас
- Чөлөөт бүсэд бүртгүүлэх, шилжүүлэх татвар, зээлийн татвар, барилгын татвар, бизнесийн компани байгуулсны татвар, хөрөнгө хуримтлуулсны татвараас тус тус чөлөөлнө.

Дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хилийн дагуу байрласан бол 20 жил, түүнээс өөр бусад нутаг дэвсгэрт байрласан бол 15 жил хүртэл хугацаагаар эдлэх бөгөөд ЧБҮК-ын олгосон үйл ажиллагааны зөвшөөрлийн хугацаанд эдэлдэг байна.

3.6. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ нь Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлсэн орнуудын нэг юм. Тус улсын хувьд “Эдийн засгийн чөлөөт бүс”-үүдийг байгуулсан нь эдийн засгаа либералчлах чухал алхамуудын нэг болсон төдийгүй дэлхийн эдийн засагтай интеграцлагдах нэгэн тулгын чулуу нь болсон байна.

1949 оныг хүртэлх хугацаанд Хятадын эдийн засгийн хуваарилалт маш **тэнцвэргүй** байсан байдаг. Аж үйлдвэр, харилцаа холбооны сүлжээний шугамууд, үйлчилгээний газрууд зэрэг нь тухайн улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 12 хувь болох эрэг дагуух бүс нутгуудад төвлөрч байсан байна. Харин 1949-1977 оны үеийн Хятадын эдийн засгийн үндсэн шинж чанар бол бүс нутгийн **тэнцвэртэй хөгжлийн бодлого** байсан юм. Энэ нь Хятадын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үндсэн зарчим байсан. 1978 оноос хойш эдийн засгийн бодлого нь алгуурхнаар нээлттэй бөгөөд гадагш чиглэсэн чиг хандлагатай болж, бүс нутгийн **тэнцвэргүй хөгжлийн бодлогыг** дахин баримтлах болсон нь эцсийн дүндээ бүсийн тэнцвэртэй хөгжилд хүрэх зорилт байв. Үүний тулд бүс нутгийн эдийн засгийн чадавхад тулгуурлан, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин зүйлсийг аажмаар Зүүн, Төв, Баруун эрэг гэсэн гурван бүс нутагт хуваарилах нь зүйтэй гэж үзэн 6-р таван жилийн төлөвлөгөөний үеэс эхлэн далайн эргийн бүс нутгуудыг Хятадын хөрөнгө оруулалтын чухал бүс болгосон байна.

Хятадын Чөлөөт эдийн засгийн бүсүүд

БНХАУ 1979 онд анх чөлөөт бүсийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хэт тэнцвэргүй экспортын чиглэлээс зайлсхийн “импортоор дутуугаа нөхөх” (import substitution-IS) зарчимд тулгуурласан нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж, өргөн уудам бүс нутаг, олон тооны аж үйлдвэрийн секторууд, ялангуяа далайн эрэг орчмын нутгуудын аж

үйлдвэрүүд гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй болсон юм. Хятад Улс худалдааны чөлөөт бүс гэхээсээ илүү “ЭЗЧБ”-үүдийг байгуулж амжилтад хүрч байгаа юм.

Хамгийн анхны дөрвөн “ЭЗЧБ”-ийг Өмнөд Хятадын далайн эрэг дагуу туршилтын журмаар байгуулсан ба 1980-аад оноос эхлэн тэндээсээ Умард руу өргөжүүлэн тэлж, 1990-ээд оноос далай эрэг орчмын бүс нутгаас нутгийн гүн рүүгээ байгуулах болсон.

Тус улсын Чөлөөт бүсийн хөгжлийн түүхэн үечлэлийг авч үзвэл, анх 1979-1988 онд Эдийн засгийн тусгай бүс, 1984-1994 онд Эдийн засаг, техникийн хөгжлийн бүс, 1988-1992 онд Шинэ болон өндөр технологийн бүс, 1990 онд Нэгдсэн хөгжлийн бүс, 1990-1992 онд Чөлөөт худалдааны бүсүүдийг байгуулан хөгжүүлэх бодлогыг явуулж иржээ.

Өнөөдөр Хятадад олон тооны бүс нутаг болон орон нутгийн хэмжээний ЭЗЧБ-үүдээс гадна **улс үндэстний түвшний 125 орчим** ЭЗЧБ-үүд ажиллаж байна³⁸. Үүнд:

- эдийн засгийн тусгай бүс (SEZ) - 5,
- эдийн засаг ба технологийн хөгжлийн бүсүүд (ETDZs) - 35,
- бүрэн хөгжлийн бүс (CDZs) - 2,
- шинэ болон өндөр технологийн хөгжлийн парк (NHIPS) - 53,
- **чөлөөт худалдааны бүс (FTZs) - 15,**
- хилийн чөлөөт бүс (FFTZs) - 13,
- хил дамнасан хөгжлийн гурвалжин (CTGs) - 2,
- экспортын бүс (EPZs) - 13 зэрэг болно.

Мөн 2003 оноос хойш 8 логистикийн бүс байгуулсан. Тэдгээрийн үндсэн зорилго нь боомтууд хоорондын болон одоо ажиллаж байгаа ХЧБ-үүд хоорондын харилцан үйлчлэлийг идэвхжүүлэх, урамшуулах, хооронд нь холбох, гадаад зах зээлд гарах боломжийг олгох явдал юм.

Чөлөөт бүсийн удирдлага зохион байгуулалт

Хятад улсын хувьд хуучин төр засгийн газрын мэдэлд байсан бүсүүдийг хотын буюу орон нутгийн засаг захиргааны мэдэл, үүрэг хариуцлагад шилжүүлсэн. Ингэхдээ чөлөөт бүсийн зохион байгуулалт буюу засгийн газрын үүрэг, бүсийн бизнесийн үйл ажиллагаа буюу бизнесийн чиглэлийн үүргийг зааглаж өгсөн. 2003 оны эхэн үеэс Засгийн газрын үүргийг улсын эзэмшлийн компаниудад хариуцуулсан байна.

ЧЭЗБ-үүдийг тэдгээрийн байршил, эдийн засаг ба улс төрийн харилцаа холбоо, аж үйлдвэрийн салбар, тэдгээрийн захиргааны бүтэц зэргээс хамааран хэд хэдэн төрлүүдэд ангилан үздэг. Тухайлбал,

Хүснэгт 4. Хятадын ЧЭЗБ-үүдийн төрөл зүйлүүд

Үндэсний ЧЭЗБ-үүд Хил дамнасан ЧЭЗБ-үүд	Тусгай эдийн засаг ба захиргааны бүс, Тусгай эдийн засгийн бүс, Бүрэн хөгжлийн бүс, Эдийн засаг & технологийн хөгжлийн бүс, Шинэ ба өндөр технологийн аж үйлдвэрийн парк, чөлөөт хилийн худалдааны бүс, хил дамнасан хөгжлийн гурвалжин
Мужийн ЧЭЗБ-үүд	Эдийн засаг, технологийн хөгжлийн бүс, Шинэ болон өндөр технологийн үйлдвэрийн бүс, чөлөөт хилийн худалдааны бүс
Сумын ЧЭЗБ-үүд	Орон нутгийн хөгжлийн бүс

³⁸<http://archiv.ub.uni-heidelberg.de/volltextserver/3244/1/fez-meng.pdf> - The Theory and Practice of Free Economic Zones: A Case Study of Tianjin, People's Republic of China.

Бусад орнуудын ЧЭЗБ-үүдтэй ижил төстэй боловч аж үйлдвэрийн салбар, захиргааны бүтэц шатлалууд нь ЧЭЗБ-үүдийг ангилах чухал итгэлцүүр болдог.

ЧЭЗБ-үүд нь эдийн засгийн хөгжил ба шинэчлэлд харилцан адилгүй өөр өөр үүрэг роль гүйцэтгэх ба өөр өөр байр суурийг эзэлдэг учраас тэдгээрийг үүсгэн байгуулахад зохих шатны засаг захиргааны байгууллагаас /улсын, мужийн, сумын гэх мэт/ зөвшөөрөл авдаг байна.

Хятадын зарим ЧЭЗБ-үүд нь “засаг захиргааны ба эдийн засгийн тусгай бүс” гэх зэрэг засаг захиргааны тусгай байр суурь, тэрчлэн захиргааны бүтцийн хэд хэдэн тусгай хэлбэртэй байдаг учраас захиргааны загвар нь бас нэгэн индикатор болдог.

Мужийн болон сумын ЧЭЗБ-үүд нь микро түвшний байршилд хамаарах бөгөөд энэ нь макро-байршилын загвартай адилгүй, судалгаанд төдийлөн анхаарал хандуулдаггүй.

Энэ мэт байршлын шалгуураараа ЧЭЗБ нь хэд хэдэн төрөл зүйлд хамаарагдаж болно. Жишээлэхэд, Шинжан (Shenzhen) Эдийн засгийн тусгай бүс нь тусгаар, хилд тулгуурласан Эдийн засгийн тусгай бүс юм. Харин “Тяньжины Эдийн Засаг ба Технологийн хөгжлийн бүс” бол тусгаар бөгөөд боомтод тулгуурласан ЧЭЗБ юм.

Хятадын ихэнх Эдийн засгийн тусгай бүсүүд, Эдийн засаг ба технологийн хөгжлийн бүсүүд, Чөлөөт худалдааны бүсүүд, Бүрэн хөгжлийн бүс, Шинэ ба өндөр технологийн аж үйлдвэрийн паркууд зэрэг нь **улсын доторх болон эрэг орчмын чиглэлийн ЧЭЗБ-үүд** байдаг.

Эрэг болон хилээс хол ба хилийн чиглэлийн ЧЭЗБ-үүдэд Эдийн засаг ба Технологийн хөгжлийн бүсүүд, шинэ ба өндөр технологийн аж үйлдвэрийн парк, чөлөөт хилийн худалдааны бүс зэрэг багтана. Хил дамнасан ЧЭЗБ-үүдэд зөвхөн Түмэн болон Меконг мөрний хил дамнасан хөгжлийн гурвалжингууд багтана. Тяньжиний Эдийн засаг ба технологийн хөгжлийн нутаг бол Хятад дахь улсын доторх бөгөөд эрэг орчмын чиглэлийн ЧЭЗБ юм.

Хятадын захиргааны бүтцэд суурилсан ЧЭЗБ-үүдийн тухайд дараах хэд хэдэн шинэ шинж чанарууд байдаг:

Засгийн газар-чиглэлийн загвар: Энэ нь засаглалын бүтцэд их төвлөрсөн, ЧЭЗБ-ийн захиргааны алба нь макро-засаглал ба ЧЭЗБ-ийн бизнес менежментийн аль алийг нь хариуцдаг. Засаглал ба зохион байгуулалтай энэ загварыг ЧЭЗБ-үүдийн хөгжлийн эхэн шатанд түгээмэл ашигладаг боловч хөгжлийн явцад захиргаа ба бизнесийн менежмент хоёрын хоорондох ажил үүргийн хуваарилалт тодорхойгүйн улмаас хүнд суртал бий болж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа уналтад орох нь маш элбэг байдаг байна. Тяньжины эдийн засгийн хөгжлийн нутаг ба Нантонгийн эдийн засаг ба технологийн хөгжлийн бүс зэрэг Хятадын маш олон ЧЭЗБ-үүд эхэн үедээ энэ загварыг хэрэглэж байжээ. Өнөөдөр Лиан-Юунгангийн Эдийн засаг ба технологийн хөгжлийн бүс энэ загварыг хэрэглэсээр байгаа билээ.

Холимог загвар: Энэ бол Хятадын ЧЭЗБ-үүдийн хувьд маш түгээмэл захиргааны загвар юм. 1990-ээд оны байдлаар гэхэд л Хятадын 11 Эдийн засгийн ба технологийн хөгжлийн бүсүүд энэ загварыг хэрэглэдэг байжээ. Энэ нь захиргааны хороо буюу алба нь захиргааны бүх үйл ажиллагаа, эрх мэдлийг барих боловч ерөнхий хөгжлийн компани буюу мэргэжлийн компани нь бие даасан үйл ажиллагаа, менежментийг эрхлэн явуулна гэсэн үг. Тэгэхээр засаг захиргааны албан хэрэг ба компанийн үйл ажиллагаа хоёр ангид тусгаар байдаг.


Энэ загвар нь цаашид гурван дэд төрөл зүйлд хуваагддаг. Тухайлбал, **Захиргааны алба ба ерөнхий компани хоёр зэрэгцэн орших** тохиолдолд захиргааны алба нь макро түвшинд удирдлага болон эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах, төслүүдийг хянан шалгах ба зөвшөөрөл олгоход шийдвэр гаргагч байна. Харин ерөнхий компани нь янз бүрийн төслийг татах, дэд бүтэц ба нийтийн ахуй хэрэглээний үйл ажиллагааг эрхлэн явуулна. Гуанжоу ба Тянжины эдийн засгийн хөгжлийн нутаг бол энэ загварын хоёр жишээ юм. Харин дараагийн төрөл нь ЧЭЗБ-үүд нь захиргааны хороодыг ба хэд хэдэн мэргэжсэн компаниудыг байгуулдаг. Тэдгээрийн үйл ажиллагаа нь эхнийхтэйгээ адил байна. Фужоу-гийн Эдийн засаг ба технологийн хөгжлийн бүс энэ жишээгээр ажилладаг. Өөр нэг төрөл нь **Захиргааны хороо ба хөгжлийн хамтарсан хувьцаат компани** бөгөөд хөгжлийн компани нь үнэндээ хувьцаат компани байх ба, захиргааны хороо ба төрийн болон хувийн компаниудаас байгуулагдсан байна. Хамтарсан хувьцаат компани нь ЧЭЗБ-ийн төлөвлөлт, барилга байгуулалт, үйл ажиллагаа ба менежментийг хариуцна.

Аж ахуйн нэгжийн чиглэлийн загвар: Үүнийг бас “захиргааны хороо”-гүй загвар гэж нэрлэдэг. Энд хамтарсан хөрөнгө оруулалттай компани ЧЭЗБ-ийн төлөвлөлт, үйл ажиллагаа, менежментийг хариуцахын зэрэгцээ зарим засаг захиргааны эрх үүргийг хүлээн хэрэгжүүлдэг байна. Гэхдээ зарим холбогдох орон нутгийн захиргааны газрууд ЧЭЗБ ба орон нутаг хоёрын хоорондын харилцааг зохицуулах ажлыг хийх ба, төслүүдийг хянаж, зөвшөөрөн батлах ба, нийгмийн үйлчилгээ болон захиргаагаар ханган тусална.

Энэ загварын жишээнүүд гэвэл Минханг, Хонгкиао, Каохэжинг-ийн “Эдийн засаг ба технологийн хөгжлийн бүсүүд” юм. Минхангийн хөгжлийн компани ба Хонгкиао-гийн “Эдийн засаг ба технологийн хөгжлийн бүс”, бас Хонгконгийн нэгэн компани нийлж хамтарсан хувьцаат компани байгуулсан байдаг. Ингээд тэр компани нь тус бүсийн дотор дэд бүтэц, барилга байгуулалт, гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн үйл ажиллагааны менежмент зэргийг хариуцах ба, зарим зүйл засаг захиргааны эрх үүргийг эдэлдэг байна. Үүний сайн тал нь засаг захиргааны элдэв саадыг арилгаснаар компанийн үйл ажиллагааны хүч чадавхыг нэмэгдүүлэн батжуулдагт оршино. Гэхдээ эдийн засгийн хөгжлийн явцад ийм хөгжлийн хамтарсан хувьцаат компани нь зөвхөн эдийн засгийн, бизнесийн байгууллага тул ЧЭЗБ-ийн төлөвлөлт ба макро-засаглалыг цаашид үргэлжлүүлэн хариуцаж чадахгүйд хүрдэг. Тиймээс энэ үүргийг нь “Шанхайн гадаад хөрөнгө оруулалтын явдлын хороо” өөртөө хүлээн авсан байдаг.

Чөлөөт бүсийн хөнгөлөлт, чөлөөлөлт

Хятад Улс нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй компани, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудад дараах хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлдэг. Мөн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалт, гаалийн татварын хувь хэмжээг хөнгөлдөг байна. Жишээлбэл,



Хүснэгт 5. Чөлөөт бүс дэх татварын хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт³⁹

№	Татварын ангилал	Татвар ноогдуулах бүтээгдэхүүн	Татварын хэмжээ	Тайлбар
1	Орлогын албан татвар /Enterprise income tax/	- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орлого, - Бизнесийн үйл ажиллагаа болон бусад орлогоос авах татвар	15%	10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан үйлдвэр, компаниуд нь ашгийн жилүүддээ эхний 2 жилийн татвараас бүрэн чөлөөлөгдөнө. 3 дахь жилээс татвар ноогдуулах бөгөөд хэрэв өндөр технологийн компани бол 8 дахь жилээс, өөрсдийн бүтээгдэхүүний 70-аас дээш хувийг экспортлодог бол 6 дахь жилээс 10 хувийн /нарийн технологийн компани бол 11 дэх жилээс/ татвар авдаг.
2	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлогын албан татвар /Bizness tax/	- татвар ноогдуулах үйлчилгээний орлого, - материаллаг бус эд хөрөнгийг шилжүүлэх - бодит хөрөнгийг худалдаалснаас авах татвар	3-10%	Мөн компани аж ахуйн нэгжүүд чөлөөт бүсэд хаус барьж худалдаалж байгаа тохиолдолд худалдаалсан, эсвэл ашиглалтад оруулсан сараас хойш 5 жилийн хугацаанд үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлдөг.
3	Хувь хүний орлогын албан татвар /Individual income tax/	- Хувь хүний орлогоос авах татвар	5-45%	Хувь хүний сар бүрийн орлогоос 800 юанийг хасаад үлдсэн дүнг татвар ногдох орлого гэнэ.
4	Нэмэгдсэн өртгийн албан татвар НӨАТ /Value-added tax/	- Чөлөөт бүсээс импортлогдсон өргөн хэрэглээний бараа - Дотоодын зах зээлд худалдаалагдсан бараанаас авах татвар	17%	Экспортын бараа болон чөлөөт бүс дэх бэлэн мөнгөний арилжаа нь НӨАТ-аас чөлөөлөгдөнө.
5	Хэрэглээний татвар /Consumption tax/	- Чөлөөт бүсээс импортлогдсон бараанаас авах татвар	3-45%	

Гаалийн хөнгөлөлтийн хувьд:

- Хилийн чанадаас чөлөөт бүсэд тээвэрлэгдэн ирсэн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, барилгын үндсэн угсралт хийхэд ашиглагддаг барилгын үндсэн материалыг импортын гаалийн тариф, татвараас чөлөөлдөг.

³⁹<http://www.by-cpa.com/html/news/20076/754.html> - Comparison of Free trade zone and Non-free trade zone.

- Чөлөөт бүсэд үйлдвэрийн барилга байгууламж, агуулах барих зорилгоор импортлон оруулж буй барилгын материал, багаж хэрэгсэл, шатах тослох материал, тоног төхөөрөмж, оффисын тавилга хэрэгсэл мөн гаалийн тариф, татвараас чөлөөлөгдөнө.
- Экспортын барааг тус бүсэд эцэслэн үйлдвэрлэж, экспортлож байгаа тохиолдолд экспортын гаалийн татвараас чөлөөлнө. Харин дотоодын зах зээлд худалдаалах импортын түүхий эд материал, бүрдэл хэсэгт импортын тариф ноогдуулна.

Зөвхөн татвараас хөнгөлөлт чөлөөлөлт олгоод зогсохгүй гадаадын хөрөнгө оруулалтад аятай таатай, баталгаатай нөхцөл байдлыг бүрдүүлэх зорилгоор дараах хөнгөлөлтүүдийг эдлүүлдэг. Тухайлбал,

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид худалдаа, агуулах, тээвэрлэлт, үзэсгэлэнгийн чиглэлээр ЧХБ-д компани, үйлдвэр байгуулж болно. Эм, тамхи зэрэг бараанаас бусад үйлдвэрлэлийн чиглэлийн төслүүд ГЕГ-ын зохицуулалтын дагуу холбогдох үндэсний хэмжээний хэлтсээс зөвшөөрөл авна. Харин бусад төрлийн төслүүд ЧХБ-ийн захиргаанаас зөвшөөрөл авна.
- Үндэсний хэмжээнд хориглосон бараанаас бусад чиглэлээр бизнесийн цар хүрээнд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй.
- Чөлөөт худалдааны бүс болон гадаадын орнуудын хооронд шилжиж байгаа бараа бүтээгдэхүүн, барааг илгээгч, хүлээн авагч, агентууд зөвхөн гаалийн бүртгэл, мэдээлэлд бүртгүүлэхэд л болно. Зарим нэг онцгой бараанд тогтоосон экспорт, импортын квот, лиценз байхгүй.

3.7. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

ЭЗЧБ гэж гадаадын хөрөнгө оруулалттай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин болон гадаад иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор хөгжүүлж буй, хуульд заасны дагуу төлөвлөсөн, нэрлэсэн бүсийг ойлгоно.

БНСУ-д Хөрөнгө оруулалтын ерөнхий процедур дараах үе шатаар явагдана. Үүнийг зургаар үзүүлэв.

Хөрөнгө оруулалтын ерөнхий процедур



Чөлөөт бүсийн Хөрөнгө оруулалтыг доорх байдлаар тайлагнадаг байна.

Хүснэгт 6. Хөрөнгө оруулалтыг тайлагнах процесс

Тайлан	Тайлагнах зүйл	Санамж хугацаа
Урьдчилсан тайлан	Шинэ хувьцаа худалдан авах эсвэл санд хөрөнгө оруулах гэх мэтээр хөрөнгө оруулж байгаа эсвэл хөрөнгө оруулалтын агуулгын бүхий л өөрчлөлтийг тайлагнах.	
	Байсан хувьцаа худалдан авах замаар хөрөнгө оруулах эсвэл хөрөнгө оруулалтын агуулгын бүхий л өөрчлөлтийг тайлагнах.	Гадны хөрөнгө оруулагч нь жагсаалтад орсон компанийн хувьцааг худалдаж авбал тайлагнах хугацаа нь худалдан авалтаас эхлэн 30 хоног байна.
	Урт хугацааны зээлийн нийлүүлэлтээр хийгдэж байгаа гадны хөрөнгө оруулалт эсвэл хөрөнгө оруулалтын агуулгын бүхий л өөрчлөлтийг тайлагнах.	
Хоёрдогч тайлан	File a report on the acquisition of shares on the occasion of an M&A - Гадаадын хөрөнгө оруулалттай фирмийн /ханшийн өсөлтийн нөөцийн сангаас энгийн болон шинэ хувьцааг худалдан авах/эзэмших - Хамтарсан компанийн хувьцааг Хөрөнгийн зах зээл дээр нэгтгэх эсвэл салгаснаас олж авсан төлбөр - Хувьцаанаас ноогдол ашиг капиталчлах - Хувьцаа худалдан авах, өв залгамжлах, гэрээслэлээр авах, эсвэл бэлэглэлээр авах.	Худалдан авалтаас 30 хоногийн дотор тайлагнана.
	Хувьцааг шилжүүлсэн талаар тайлагнах	Гэрээний гүйцэтгэл хийгдсэн өдрөөс 30 хоногийн дотор тайлагнана.
	Хувьцааны уналтыг тайлагнах	30 хоногийн дотор тайлагнах
	Гадны хөрөнгө оруулалттай компанийн бүртгэл, бүртгэлийн өөрчлөлт, бүртгэлээс хасах зэргийг тайлагнах.	30 хоногийн дотор тайлагнах

Юуны өмнө БНСУ-д Чөлөөт бүстэй холбоотой аливаа харилцааг “Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль”-иар голлон зохицуулах бөгөөд түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журам, түүнчлэн бусад салбарын хуулиудаар зохицуулдаг байна. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль, Төрийн өмчийн менежментийн тухай орон нутгийн журам, Газрын тухай хууль гэх мэтчилэн салбарын хуулиудад шаардлагатай зохицуулалтыг суулгасан байна.

БНСУ-ын ЭЗЧБ-ийн гол хууль нь бүтцийн хувьд 8 бүлэг, 35 зүйлтэй байна. Тус хуулийн зорилго нь ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментээр дамжуулан гадаадын хөрөнгө оруулалттай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин, гадаад иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үндэсний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, бүс нутаг хоорондын тогтвортой хөгжлийг хангахад оршино гэж заажээ.

Хуульд зааснаар ЭЗЧБ-ийг хөгжүүлэх төлөвлөгөө нь:

1. ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 1.1. ЭЗЧБ-ийн нэр, байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ;
 - 1.2. ЭЗЧБ-ээр төлөвлөгдсөн байх;
 - 1.3. ЭЗЧБ-д хэрэгжүүлж буй хөгжлийн төслийн оператор;
 - 1.4. Хөгжлийн төслийг хэрэгжүүлэх үе шат;

- 1.5. Санхүүгийн нөөцийг бэхжүүлэх арга зам;
 - 1.6. Газар ашиглалт болон үндсэн дэд бүтцийн хөтөлбөр;
 - 1.7. Хүн амын байр сууц, оршин суух газрыг барьж байгуулах хөтөлбөр;
 - 1.8. Замын хөдөлгөөний зохицуулалтын хөтөлбөр;
 - 1.9. Аж үйлдвэр хөгжүүлэх хөтөлбөр;
 - 1.10. Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн хангамжийн газар байгуулах хөтөлбөр;
 - 1.11. Байгаль орчин хамгаалах хөтөлбөр;
 - 1.12. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад иргэд оршин суух орчныг бүрдүүлэх хөтөлбөр;
 - 1.13. Ерөнхийлөгчийн Зарлигт заасан бусад зүйлс.
2. Худалдаа, Аж Үйлдвэр, Эрчим Хүчний Сайд ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөө гаргахад шаардлагатай тэдгээр зүйлсийг нийтэд зарлаж болно.

Түүнчлэн ЭЗЧБ-ийг хөгжүүлэх төлөвлөгөө нь бусад төлөвлөгөөтэй хэрхэн нийцэх талаар хуулинд *“Энэ хуулинд заасан эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөө нь Үндэсний газрын тухай суурь хуулийн 6.2.1-д заасан үндэсний газрын нэгдсэн төлөвлөгөө, Сөүл хотын нутаг дэвсгэрийн дахин төлөвлөлтийн тухай хуулинд заасан Сөүл хотын нутаг дэвсгэрийн дахин төлөвлөлт, Цэргийн бааз болон байгууламжийг хамгаалах тухай хуулинд заасан төлөвлөгөөнөөс бусад хуулинд заасан хөгжлийн төлөвлөгөөнөөс илүү давуу эрхтэй байна.”*⁴⁰

Мөн чөлөөт бүсийг хөгжүүлэх төслийн эхлэх хугацааг мөн хуулинд заасан бөгөөд хөгжлийн төслийг эхлүүлэх эцсийн хугацаа нь 9.1 дүгээр зүйлийн дагуу хэрэгжүүлэх төлөвлөгөөний зөвшөөрөл авсан өдрөөс хойш нэг жил байна. Худалдаа, аж үйлдвэр, Эрчим хүчний сайд тухайн хөгжлийн төслийг эхлүүлэх хугацааг сунгах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эцсийн хугацааг нэг жилийн дотор зөвхөн нэг удаа сунгаж болно гэж заасан байна.

Түүнчлэн хуулийн 15-р зүйлд Татвар, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай дараах байдлаар заасан бөгөөд дэлгэрэнгүйг доор хүснэгтээр үзүүлсэн болно:

- ЭЗЧБ-д хөгжлийн төслийн тогтвортой хэрэгжүүлэлтийг хангахын тулд улс болон орон нутгаас хөгжлийн төслийн хэрэгжилтэд оролцогчид гаалийн татвар, орлогын татвар, ашгийн татвар зэрэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно.
- ЭЗЧБ-д хөгжлийн төслийг тогтвортой хэрэгжилтийг хангах шаардлагатай тохиолдолд улс болон орон нутгаас хөгжлийн төслийн хэрэгжилтэд оролцогчдод фермерийн газрын хамгаалалт, хөгжүүлэлтийн төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно. Хөгжлийн тухай хууль, Хөдөө аж ахуйн бүс нутгийн тухай хууль, Бэлчээрийн тухай хууль, Уулын бүсийн менежментийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны менежмент, нөхөн сэргээлтийн тухай хууль, Орчны сайжруулалтын зардал ноогдуулах тухай хууль, Улсын газар төлөвлөлт болон ашиглалтын тухай хууль, Хотын бүсийн тээвэрлэлтийн менежментийн тусгай хуулиар батлагдсан хураамж, байгалийн нөхөн сэргээлтийн төлбөр, ойжуулалтын төлбөр, тээвэрлэлтийн ачаалал үүсгэсний төлбөр, экологийн систем хадгалалтын төлбөр, нийтийн хэрэглээний ус ашигласны эсвэл эзэмшсэний төлбөр, орчны сайжруулалтын төлбөр, дэд бүтэц барилгын төлбөр, бүх тээвэрлэлтийн хэрэгслийн төлбөр.

⁴⁰Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль, 3 дугаар зүйл.

Түүнчлэн татварын болоод санхүүгийн дэмжлэг урамшууллын талаар тус хуулийн 16-р зүйлд заасан бөгөөд дэлгэрэнгүйг татварын үр ашиг, бизнесийн дэмжлэгийг үзүүлсэн хүснэгтээс харж болно.

Чөлөөт бүсийн Хороог байгуулах болон Хорооны үйл ажиллагааны талаар хуулийн 6-р бүлэгт заасан бөгөөд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

1. Эдийн засгийн чөлөөт бүсийн хороо нь Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яаманд байгуулагдах бөгөөд эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлыг эрхэлнэ.
2. Эдийн засгийн чөлөөт бүсийн хороо дараах асуудлуудыг хариуцан ажиллана. Үүнд:
 - 1.1. ЭЗЧБ-ийн нэгдсэн бодлого болон нэгдсэн системийн асуудлууд;
 - 1.2. ЭЗЧБ-ийн төлөвлөлт, төлөвлөлтийн цуцлалт болон өөрчлөлттэй холбоотой асуудлууд;
 - 1.3. 6 зүйлд заасан эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудлууд;
 - 1.4. ЭЗЧБ-д үйл ажиллагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд шаардлагатай засаг захиргааны үйлчилгээг хангахтай холбоотой асуудлууд;
 - 1.5. ЭЗЧБ-үүдийн хөгжилтэй холбоотой асуудлууд;
 - 1.6. Төвийн захиргааны агентлагуудын дарга болон хотын Засаг дарга, захирагчтай эдийн засгийн чөлөөт бүстэй холбоотой асуудлаар санал нэгдэх асуудлууд;
 - 1.7. Ерөнхийлөгчийн зарлигт заасан эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны төрөл болон менежменттэй холбоотой бусад чухал асуудлууд.
2. Эдийн засгийн чөлөөт бүсийн зөвлөл нь нэг дарга, нэг дэд дарга, орон тооны бус болон арваас дээшгүй орон тооны гишүүнтэй байна.
3. Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайд ЭЗЧБ-ийн зөвлөлийн дарга байх бөгөөд дэд даргыг (6)-р зүйлд заасны дагуу орон тооны гишүүдээс сонгоно.
4. Орон тооны бус гишүүд нь Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу төвийн захиргааны агентлагуудын удирдлага болон харьяа байгууллагуудын удирдлагуудаас сонгогдоно.
5. Эдийн засгийн чөлөөт бүсийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дарга баталгаажуулах бөгөөд гишүүдийг төрийн албан хаагч бус, ЭЗЧБ-ийн менежмент болон хөгжлийг хангаж чадахуйц мэдлэг ба туршлагатай хүмүүсээс сонгоно.
6. Эдийн засгийн чөлөөт бүсийн зөвлөлийн удирдлага, бүтэцтэй холбоотой асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигт тусгана гэж заажээ.

Мөн хуулийн 27-дугаар зүйлийн 3-т Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны ерөнхий дүрмүүдийн тухай дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

1. Захиргааны байгууллагын тэргүүн нь байгууллага болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд зориулсан ерөнхий ажиллагааны дүрмүүдийг бэлтгэж томилогдсон өдрөөс нэг сарын дотор Засаг дарга/захирагч баталгаажуулалт хүсэх үүрэгтэй. Гэрээ шинэчлэлтийг хүлээн зөвшөөрч тусгагдсан ямар нэгэн ижил зүйл ч мөн адил үүрэг хүлээнэ.
2. Ерөнхий ажиллагааны дүрмүүд нь доорх зүйлсийг багтаана. Үүнд:
 - 2.1. Шаардлага хангасан бизнес болон түүний явцын талаарх ерөнхий хэргүүд;
 - 2.2. Байгууллага болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг хамааруулсан болон нийтийн ажилчдын дэс дараалсан тоотой холбогдолтой хэргүүд;
 - 2.3. Захиргааны байгууллагын тэргүүний хяналтанд байх нийтийн ажилчдын менежменттэй холбогдолтой хэргүүд;
 - 2.4. Төсөв болон тайлан тооцоотой холбогдолтой хэргүүд;

- 2.5. Захиргааны байгууллага үр бүтээлтэй ажиллагааны тулд, Ерөнхийлөгчийн Тушаалаар баталгаажуулагдсан бусад холбогдолтой хэргүүд байна гэж заасан байна.

Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын урамшуулалын хэлбэр болоод түүнтэй холбоотой аливаа зүйлийн зохицуулалтыг хэрхэн хийсэн талаарх хуулийн зохицуулалтыг дор хүснэгтээр үзүүлэв.

Хөрөнгө оруулалтын урамшуулал

БНСУ-ын хувьд ЭЗЧБ-д үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд тухайн улсад хөрөнгө оруулсных нь төлөө дараах төрлийн урамшуулал эдлүүлдэг байна. Үүнд:

1. *Татварын үр ашиг*
2. *Бизнесийн дэмжлэг*
3. *Төрийн зохицуулалтыг халах*
4. *Амьдрах нөхцөл*
5. *Захиргааны дэмжлэг*

1. Татварын үр ашиг:

Ашиг хүртэх зүйл	Урамшуулал 5 жил	Урамшуулал 7 жил
Хууль зүйн үндэслэл	Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль	
Ажлын байр бий болгосны урамшуулал авах болзол хангасан хуулийн этгээд	Дотоодын компани, 100% Гадаадын хөрөнгө оруулалттай фирм, Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрийн 10-аас дээш хувийг эзэмшигч	
Татварын ашиг хүртэх болзол хангасан хуулийн этгээд	ЭЗЧБ-д ажлын байр бий болгосон гадаадын хөрөнгө оруулсан фирм	
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн шалгуур	<ul style="list-style-type: none"> - Боловсруулах үйлдвэр - 10 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай - Аялал жуулчлал - 10 сая ам.доллараас дээш бол - Амралтын газар - 10 сая ам.доллараас дээш бол - Олон улсын хурал, зөвлөгөөн - 10 сая ам.доллараас дээш бол - Залуучуудын төв - 10 сая ам.доллараас дээш бол - Логистик - 5 сая ам.доллараас дээш бол - Эрүүл мэндийн хүрээлэн 5 сая ам.доллараас дээш бол - Судлаач болон Боловсруулагч - 1 сая ам.доллараас илүү (Хүсэлт гаргагч нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй 3-аас дээш жилийн туршлагатай байнгын орон тооны 10 судлаачдыг ажилд авсан байх ёстой). - Project developer: Гадны хөрөнгө оруулагч нь 30 сая ам. доллараас их хөрөнгө оруулах ёстой, эсвэл хамтарсан үйлдвэрийн хувьд төслийн эцсийн дүн нь 500 сая ам. доллараас их байх ба гадны хөрөнгө оруулагч нь 50-аас их хувийг санхүүжүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> - Боловсруулах үйлдвэр - 30 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай - Аялал жуулчлал - 20 сая ам.доллараас дээш бол - Амралтын газар - 20 сая ам.доллараас дээш бол - Олон улсын хурал, зөвлөгөөн - 20 сая ам.доллараас дээш бол - Залуучуудын төв : 20 сая ам.доллараас дээш бол - Логистик - 10 сая ам.доллараас дээш бол - SOC - 10 сая ам.доллараас дээш бол - Хамтарсан төсөл - 30 сая ам.доллараас дээш бол - Судалгаа болон Хөгжил - 2 сая ам. доллараас дээш бол <p>(Хүсэлт гаргагч нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй 3-аас дээш жилийн туршлагатай байнгын орон тооны 10 судлаачдыг ажилд авсан байх ёстой).</p>

Улсын татвар	<ul style="list-style-type: none"> - Гаалийн татвар - 5 жил чөлөөлнө (импортлож буй үйлдвэрлэлийн хэрэгсэл) - ААН-ийн орлогын албан татвар - 3 жилийн хугацаанд 100% чөлөөлнө, дараагийн 2 жилд 50 % бууруулна. 	<ul style="list-style-type: none"> - Гаалийн татвар, Тансаг хэрэглээний татвар (special consumption tax), НӨАТ - 5 жил чөлөөлнө - ААНӨАТ - эхний 3 жилд 100% чөлөөлөх ба дараагийн 2 жилд 50% бууруулна
Орон нутгийн татвар	<ul style="list-style-type: none"> - Хуримтлалын татвар (Acquisition tax), Үл хөдлөх хөрөнгийн татвараас 15 жил 100 % чөлөөлнө. * Татварын чөлөөлөлт болон хугацааг батлах болон сунгах асуудлыг орон нутгийн засаг захиргааны журмаар зохицуулна. 	

2. Бизнесийн дэмжлэг:

Хөнгөлөлт, чөлөөлөлт		
Хууль зүйн үндэслэл	<ul style="list-style-type: none"> - ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль⁴¹ - Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль⁴² - Төрийн өмчийн менежментийн тухай орон нутгийн журам⁴³ 	
Түрээс	<ul style="list-style-type: none"> - Гадаадын хөрөнгө оруулагч төрийн болон олон нийтийн өмчийг 50 жил хүртэл хугацаанд түрээслэж болно. - Түрээсийн төлбөрийг тодорхойлохдоо үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний Түрээсийн төлбөр нь өмчийн өртгөөс (хариуцсан Агентлагаар тогтоогдох ёстой) хувь (10/1000 -аас дээш) тооцсноор тодорхойлогдоно 	
Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт	<ul style="list-style-type: none"> - 1 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай сүүлийн технологи бүхий аж ахуйн үйл ажиллагаа - Гадаадын хөрөнгө оруулагчдын 20 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалт - Өдөр бүр дунджаар 300-аас дээш ажилчид ажилладаг бол - Нийт бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортолдог болон эд анги, орц, материал нь 100% дотоодын бүтээгдэхүүн бол - Нийт бүтээгдэхүүнийг 100% экспортод гаргадаг бол 	Түрээсийн төлбөрөөс 100% чөлөөлнө
	<ul style="list-style-type: none"> - Гадаадын хөрөнгө оруулагчид 10-20 сая ам.долларын хөрөнгө оруулбал - Өдөр бүр дунджаар 200-300 ажилчид ажилладаг бол - Нийт бүтээгдэхүүний 50%-ийг экспортолдог болон бүтээгдэхүүний эд анги, орц, материалын 75 % -ийг дотоодод үйлдвэрлэсэн бол - Нийт бүтээгдэхүүний 75%-ийг экспортолдог бол 	Түрээсийн төлбөрөөс 75%
	<ul style="list-style-type: none"> - Гадаадын хөрөнгө оруулагчид 5-10 сая ам.долларын хөрөнгө оруулсан бол - Өдөр бүр дунджаар 100-200 ажилчид ажил эрхэлдэг бол - Нийт бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортолдог болон бүтээгдэхүүний эд анги, орц, материалын 50-75 хүртэл хувийг дотоодод үйлдвэрлэсэн бол - Нийт бүтээгдэхүүний ойролцоогоор 50-70 хувийг экспортолдог бол 	Түрээсийн төлбөрөөс 50% чөлөөлнө
Худалдан авалт	Гадаадын хөрөнгө оруулагч нь улсын болон хувийн хөрөнгийг хувийн тохиролцооны гэрээгээр өмчийн бодит өртөгтэй тэнцэх үнээр авч болно.	

⁴¹Special Act on Designation and Management of FEZ

⁴²Foreign Investment Promotion Act

⁴³Local Regulation on Managing Public Properties

Санхүүгийн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> - Худалдан авалтын төлбөрийг хэсэгчилэн төлөх буюу төлбөрийг хойшлуулж болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> o Төрийн өмч (төлбөр төлөх хугацааг дээд тал нь нэг жил хойшлуулж болох бөгөөд 20 жилд хэсэгчилэн төлнө), o Нийтийн өмч (20 жилийн турш хэсэгчилэн төлж болох бөгөөд жил бүр 3 хувийн хүүтэй) - Үйлдвэрлэлийн паркард татаас олгож болно: өөр түрээсийн төлбөр болон сав баглаа боодлын үнэ тогтсон түрээсийн төлбөр болон, сав баглаа боодлын үнээс хамааран 50 хувьд нь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. - Мөнгөн гүйлгээ хүлээн авагч хэн нэг тал нь мөнгөн гүйлгээний хөрөнгө оруулалтын дүнгээс 5% (10 сая ам.доллараас дээш, дээд хязгаар нь 5 тэрбум вон) давхар тооцоо хийхгүй байхыг зөвшөөрөх. - Ажил эрхлэлтийн татаас - 20-иос илүү хөлсний ажилтан байвал сар тутам шинэ ажилтан бүрт 500 000 вон төлнө (for up to 6 months and the aggregate limit of 500 million won) - Боловсролын болон сургалтын тэтгэлэг - 100,000-500,000 воныг сар тутамд шинэ ажилтан бүрт
--------------------	---

3. Төрийн зохицуулалтыг халах:

Хууль зүйн үндэслэл	- ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль
Хөдөлмөрийн Хяналтаас үзүүлэх дэмжлэг	<ul style="list-style-type: none"> - Unpaid leave, including unpaid menstrual leave, is permitted - May expand the type of work and terms of dispatched worker assignments - Not bound by the legal ban on the entrance into specially designated small company businesses by big companies - Not obliged to fill vacant job positions with "persons of national merit", the disabled, or the elderly
Нийслэлээс үзүүлж буй бодлогын болон журмын дэмжлэг	ЭЗЧБ дэх ямар ч гадны хөрөнгө оруулалттай компани нь Сөүл хотын хэт суурьшлын бүсийн хяналтын актыг дагаж мөрдөх шаардлагаас чөлөөлөгдөнө.
Санхүүгийн орчин дахь сайжралт	Гадны хөрөнгө оруулалттай компани нь бизнес үйл ажиллагааг тодорхой болгохын тулд гадны мөнгөн тэмдэгтийн гүйлгээг шууд эрхлэж болно (дээд хязгаар нь 10000 ам. доллар)
Бусад	Гадны хөрөнгө оруулалттай компани нь улсын болон олон нийтийн өмчийг хамгийн дээд тал нь 50 жилээр түрээслэх ыоломжтой, мөн түрээслэсэн өмчдөө засварын ажил хийж болно.

4. Амьдрах нөхцөл:

Хууль зүйн үндэслэл	ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хууль
Гадаад хэлний үйлчилгээ	Олон нийтийн бичиг баримтууд нь гадаад хэл дээр гардаг ба олон нийтийн агентлагууд нь бичиг баримтуудыг гадаад хэл дээр хүлээн авч боловсруулдаг байна.
Боловсролын орчин	Шинжлэх ухаан болон Боловсролын яамны зөвшөөрлөөр гадны боловсролын хүрээлэнгүүд байгуулагдаж болно.
Эмнэлэгийн орчин	<ul style="list-style-type: none"> - Гадаадын эрүүл мэндийн хүрээлэн эсвэл гадаадын иргэний эмийн сан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж болно - Эрүүл мэндийн байгууллагын охин бизнесийн (халуун рашаан сувилал гэх мэт) хувьд онцгой хасалт зөвшөөрөгдөж болно - Гадны эрүүл мэндийн байгууллагуудад зориулсан тусгай хууль хэрэгжинэ.

Бусад	<ul style="list-style-type: none"> - Зөвхөн гадаадын иргэдэд зориулсан казино гадны хөрөнгө оруулагчдад (500 сая ам. доллараас дээш хөрөнгө оруулсан) зөвшөөрөгдөнө - Гадны телевизийн сувгууд орон нутгийн кабелийн сүлжээгээр цацагдах болно - ЭЧБ нь орон сууцны нийлүүлэлтийн нийт тооны 10 хүртэл хувьд тэнцэх хэмжээний орон сууцны газрыг гадаадын иргэдэд зориулсан орон сууцны барилгын ажилд гаргаж өгнө.
-------	--

5. Захиргааны дэмжлэг:

Төлөвлөгөө батлахад томилох (хуулийн 8 дугаар зүйлийн дагуу)	<ul style="list-style-type: none"> - ЭЗЧБ-ийг төлөвлөх үед дараахыг хамтад нь томило буюу батална. Үүнд: - Хотын хөгжлийн бүс, Хотын хөгжлийн төлөвлөгөөний дэд төлөвлөгөө, салбар төлөвлөгөөг батлах - Хотын сүүлийн үеийн үйлдвэрлэлийн цогцолбор, улсын болон орон нутгийн үйлдвэрлэлийн паркийн төлөвлөгөө батлахад - Аялал жуулчлалын газар болон аялал жуулчлалын цогцолборын төлөвлөлт - Логистикийн цогцолборын төлөвлөлт - Хотын ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлтийг Газар, Зам Тээвэр, Далайн Хэргийн Сайдын зөвшөөрлөөр батална - Нийтийн Усны Менежментийн суурь төлөвлөгөөг өөрчлөх - Далайн эргийн цогцолбор газрын менежментийн төлөвлөгөө болон далайн эргийн газрын менежментийн бүсийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт - Гол мөрний менежментийн ерөнхий төлөвлөгөө, Усан хангамжийн менежментийн ерөнхий төлөвлөгөө, эсвэл Бохир усны менежментийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт
--	--

3.8. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

Чөлөөт бүс: Чөлөөт бүс нь Турк улсын улс төрийн хил хязгаарт багтдаг ч татварын бүсийн гадна орших ба экспортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг өсгөхөөр зориулагдсан тусгай бүс юм. Өөрөөр хэлбэл, Турк улсын чөлөөт бүсэд тухайн улсад үйлчилдэг худалдаа, санхүү, эдийн засгийн салбарын хуулийн болон засаг захиргааны аливаа зохицуулалт нь бүхлээрээ эсвэл зарим талаараа хэрэгждэггүй бөгөөд илүү олон хөнгөлөлтийг тус бүсэд явагдаж буй үйлдвэрлэлийн болон худалдааны үйл ажиллагаанд олгодог байна. Туркт 21 чөлөөт бүс үйл ажиллагаа явуулж байна.

Чөлөөт бүсийн эрх зүйн орчин: Бүгд Найрамдах Турк улсад Чөлөөт бүсийн тухай хуулийг 1985 онд баталсан бөгөөд 1993 онд тус хуульд нийцүүлэн Чөлөөт бүсийн журмыг баталсан байна. Чөлөөт бүсийн хууль №3218 нь 1985 оны 6-р сарын 15-ны №18785 дугаар бүхий Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн, мөн Чөлөөт бүсийн тухай журам нь тус сонины 1993 оны 3-р сарын 10-ны №21520-д нийтлэгджээ. Чөлөөт бүсийн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журамд Чөлөөт бүс байгуулах нөхцөл байдал, байршил, хил хязгаарын тодорхойлолт, засаг захиргаа, үйл ажиллагааны салбар буюу худалдаа, үйлдвэрлэл, агуулах, угсрах, задлах үйл ажиллагаа, түрээс, банк санхүүгийн үйлчилгээ, оффшор банк, даатгал, техникийн засвар үйлчилгээ, технологийн хөгжил дэвшлийг ашигласан бизнес эрхлэх боломжтойг заасан бөгөөд ингэхдээ чөлөөт бүс тус бүрээр нь ангилан үйл ажиллагааг ялгавартай тогтоожээ. Тухайлбал, Мауритус худалдааны чөлөөт бүсэд бараа агуулах, хадгалах, реэкспорт, дамжуулан тээвэрлэлт хийх, бага хэмжээний боловсруулалт, угсралтын үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн байдаг.

Түүнчлэн дээрх бие даасан хуулиас гадна бусад салбарын хуулийн (*хөрөнгө оруулалтын тухай хууль, Гаалийн татварын тухай хууль, Татварын тухай хууль, худалдааны хууль иргэний хууль гэх мэт салбарын бусад хуулиуд*) зарим зохицуулалтаар Чөлөөт бүсийн аливаа харилцааг бүхэлд нь зохицуулна.

Чөлөөт бүсийн үүрэг : Чөлөөт бүс нь дараах үүрэгтэй:

- Гадны хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд тохиромжтой бүсийг бий болгох,
- Үйлдвэрлэгчдэд шаардлагатай түүхий эд болон завсрын таваарыг хэрэгтэй хэмжээгээр цаг хугацааны хувьд хоцрогдолгүйгээр худалдан авах,
- Худалдааны давуу талууд болон татвар аливаа хөнгөлөлтүүд дээр суурилж бүтээгдэхүүний бага өртөгт үйлдвэрлэл болон экспортыг дэмжих,
- Гадны улс хоорондын транзит худалдааг хөнгөвчлөх,
- Ажлын байрны шинэ боломжийг бий болгох,
- Экспортын бүтээгдэхүүний экспортыг хөнгөвчлөх, хурдасгах хөшүүргийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Турк дахь Чөлөөт бүсүүд: Турк улсад нийт 21 чөлөөт бүс үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийг дор дурдъя. Үүнд:

Нэр	Харьяалал	Байгуулагдсан он
Mersin Free Zone	Мерсин	1987
Antalya Free Zone	Анталая	1987
Ege Free Zone	Измир	1990
İstanbul Atatürk Airport Free Zone	Истанбул	1990
Trabzon Free Zone	Трабзон	1992
İstanbul Leather Industry Free Zone	Истанбул	1995
East Anatolia Free Zone	Эрзурум	1995
Mardin Free Zone	Мардин	1995
İstanbul Stock Exchange Free Zone (İMKB)	Истанбул	1997
İzmir Menemen Leather Free Zone	Измир (Menemen)	1998
Rize Free Zone	Ризэ	1998
Samsun Free Zone	Самсун	1998
İstanbul Tracia Free Zone	Истанбул	1998
Kayseri Free Zone	Каусэри	1998
Adana Yumurtalık Free Zone	Адана (Yumurtalık)	1998
European Free Zone	Тэкирдаг (Zorlu)	1999
Gaziantep Free Zone	Газиянтэп	1999
Bursa Free Zone	Бурса	2001
Kocaeli Free Zone	Коциали	2001
Denizli Free Zone	Денизли	2002
Tubitak Free Zone	Коциали (Gebze)	2002

Дээрх 21 Чөлөөт бүсээс жишээ болгон Европын Чөлөөт бүсийн талаар товч мэдээлийг оруулъя.

Турк Улсын хувийн аж үйлдвэрийн паркуудын нэг болох Европын чөлөөт бүс /ЕЧБ/ нь 1996 онд Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр 2.000.000 м2 нутаг дэвсгэртэйгээр байгуулагдсан ба 1999 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. ЕЧБ нь газар зүйн хувьд стратегийн ач холбогдол бүхий байрлалтай учир Туркийн гадаад худалдаанд чухал байр суурийг эзэлдэг байна. 2008 оны эхээр худалдааны хэмжээ нь 2 тэрбум ам.долларт хүрсэн байна.

ЕЧБ-д үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж дараах давуу талуудыг эдэлнэ. Үүнд:

Санхүүгийн давуу тал

- *Татвараас 100% чөлөөлнө:* Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд корпорацийн буюу аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, орлогын татвараас 100% чөлөөлөгдөнө. (Турк улсад корпорацийн татварын хэмжээ 20%.)
- *Гаалийн татвараас чөлөөлнө:* Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд Нэмэгдсэн Өртгийн Татвар болон бусад бүх төрлийн гаалийн татвараас чөлөөлөгдөнө.
- *Орлогын албан татвараас чөлөөлөгдөнө:* Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийхээ 85% болон түүнээс дээш хувийг Туркаас бусад оронд зарсан компанийг 100% орлогын албан татвараас чөлөөлнө.
- *Мөнгөний ханшийн хяналт:* Бүсэд гүйлгээг хөрвөх чадвартай гадаад валютаар хийснээр дотоодын инфляцын түвшин худалдах, худалдан авах үйл ажиллагаа, бараа материалын хяналт, санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.
- *Орлогоо шилжүүлэхэд саадгүй:* Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа компани олсон орлогоо Турк улсын бусад нутаг дэвсгэрт болон хилийн чанадад ямар нэгэн зөвшөөрөл авахгүйгээр шилжүүлж болно.

Худалдааны давуу тал

- Турк улсаас чөлөөт бүс рүү хийсэн худалдаа нь экспорт болдог тул чөлөөт бүс дэх компаниуд нь дотоодын үнээс доогуур байдаг экспортын үнээр барааг худалдан авах давуу талтай.
- Түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүнийг чөлөөт бүсээс дотоодын зах зээлд борлуулахад ямар нэгэн хориг байхгүй.
- Турк улс Европын Гаалийн Холбооны гишүүн болсноор чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн барааг Европын Холбооны улсууд руу чөлөөтэй гаргах эрхтэй болсон.
- Барааг чөлөөт бүсэд хадгалахад цаг хугацааны хязгаарлалт байхгүй. Барааг Туркын нутаг дэвсгэр болон хилийн чанад руу хэсэгчлэн зөөж болно.
- Хүнд суртлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулсан.
- Чөлөөт бүсээр дамжин өнгөрөх болон бартерын худалдаа явуулах боломжтой. Чөлөөт бүсэд барааг сэргээн сайжруулах боломжтой.

Хөрөнгө оруулалтын давуу тал

- *Дэд бүтэц:* Цахилгаан, байгалийн хий, телефон утас, цэвэр ус, бохир ус, цэвэрлэх систем зэрэг дэд бүтцийг үйлдвэрүүдэд суурилуулахад бэлэн болсон.
- *Гадаадын хөрөнгө оруулалтад адил тэгш нөхцлөөр хангах:* Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай байж болно.
- *Өмчийн эрх:* Гадаадын иргэд чөлөөт бүсийн дотор газар эзэмшиж болох ба тухайн газар болон барилга байгууламжийг гуравдагч талд зарж болно. Чөлөөт бүсэд худалдах - худалдан авах татвар байхгүй. /Турк улсад худалдах - худалдан авах татвар 3% байдаг/
- *Хялбаршуулсан процедур:* Хөрөнгө оруулалтад шаардагдах дүрэм журам бага. Чөлөөт бүсэд илүү өргөн хүрээтэй, хязгаарлалтгүй хөнгөлөлттэй учраас хөрөнгө оруулагчдад хөнгөлөлтийн сертификат шаардлагагүй.
- Хуучин машин чөлөөтэй оруулж болно: Хөрөнгө оруулагч компани хуучин автомашиныг ямар нэгэн хязгаарлалт, татваргүйгээр чөлөөт бүсэд оруулж болно.

ЕЧБ дэх газрын түрээсийн үнэ болон зарим төрлийн үйлчилгээний үнийг 2012 оны байдлаар доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7.

Газрын үнэ	
1 м2	110 ам.доллар
Хувийн агуулахын үнэ	
1 нэгж /240 м2/	150000 ам.доллар

Түрээсийн үнэ	
Орон зай	Ам.доллар/м2/сард
Албан газар	
10-44 м2	13
45-90 м2	12
91-180 м2	11
Хувийн агуулах	
240 м2	9
480 м2	8
720 м2	7
960 м2	6
1200 м2	5
Үйлдвэрийн байр	
1000 м2 болон түүнээс дээш	4

Энгийн агуулах		
0-29 өдөрт	Барааны өртгийн 10000 тутамд 3.5 * өдөр	Урьдчилан
30 өдөр болон түүнээс дээш	Барааны өртгийн 10000 тутамд 4.5 * өдөр	Урьдчилан

Задгай талбайн түрээсийн төлбөр	
1 м2 /жилд/	36 ам.доллар
1 м2 /сард/	3 ам.доллар

Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагаа: Боломжит үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Үйлдвэрлэл
- Судалгаа
- Угсралт болон нураалт
- Техникийн засвар үйлчилгээ
- Банкны үйлчилгээ
- Ан деррайтерийн үйлчилгээ
- Санхүүгийн түрээсийн
- Агуулахын
- Оффис түрээсийн болон бусад

Чөлөөт бүсийн давуу тал болон урамшуулал:

2004 оны 2-р сарын 6-ны байдлаар хувь хүн болон аж ахуйн нэгжүүд Туркийн аль ч чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт хуулиар олгосон аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагааныхаа зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах болон үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдаад олсон аливаа ашиг нь татварын хугацаа дуусах буюу Европын Холбооны гишүүн болох хүртэл орлогын болон аж ахуйн нэгжийн албан татвараас чөлөөлөгдөнө.

- Санхүүгийн Яамнаас Шууд хөрөнгө оруулалтын тухай хууль №5084, ба Чөлөөт бүсийн тухай хууль № 3218- тай холбоотойгоор хөрөнгө оруулалт болон чөлөөт бүс дэх татварын харилцааг зохицуулахаар гаргасан “Аж ахуйн нэгжийн татварын ерөнхий мэдэгдэл” -85-р дугаар (Corporation Tax General Communiquй - Serial No.

85) нь 2004 оны 9-р сарын 4-ний өдрийн “Төрийн Сонин”-ы 25573 дугаарт (Official Gazette No. 25573) хэвлүүлж, тэр өдрөөсөө хүчин төгөлдөр болжээ. Уг мэдэгдэлд 2004 оны 2-р сарын 7-ны өдрөөс өмнө зөвшөөрөл авсан хэрэглэгчдийн хувьд 2009 оныг хүртэл татвараас чөлөөлөх тухай дүрмүүдийг тодотгож өгсөн байдаг. Энд бас орлогын ба аж ахуйн нэгжийн албан татвараас чөлөөлөгдөх нөхцөл нь Бүтээгдэхүүний Зөвшөөрөл авсан ба авах чөлөөт бүсийн хэрэглэгчдийн хувьд Европын Холбооны гишүүн болох хүртэл хэвээр байхыг тодруулж өгсөн байна.

- Лиценз бүхий компаниудад үйл ажиллагааны зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай олгох ба, тэдгээр компаниуд үйл ажиллагаагаа урьдчилан бэлтгэсэн албан байрыг түрээсэлж явуулна (Энэ зөвшөөрөл нь бүтээгдэхүүний талбар дээрээ буй компаниудад 15 жил байна). Өөрөөр хэлбэл, Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасны дагуу чөлөөт бүс дэх үл хөдлөх хөрөнгийг тус хуульд заасан нөхцөл журмын дагуу түрээсийн гэрээ байгуулан аж ахуйн үйл ажиллагаагаа эрхлэн явуулах бөгөөд энэ тохиолдолд 10 жилийн хугацаатай зөвшөөрөл олгоно. Харин өөрсдийн бизнесийн байрыг барьсны дараа үйл ажиллагаагаа явуулах хөрөнгө оруулагч-хэрэглэгч компаниудын хувьд 20 жил байна (Бүтээгдэхүүний талбар дээрээ буй компаниудад энэ нь 30 жил байна).
- Чөлөөт бүсийн үйл ажиллагаанаас олсон ашгийг гадаадын улс орнууд болон Туркийн бусад нутаг дэвсгэр рүү ямар нэг тусгай зөвшөөрөлгүйгээр шилжүүлж болно.
- Чөлөөт бүсүүд нь нэгэнт гаалийн хяналтын бүсээс гадуур тул чөлөөт бүсүүд ба Туркийн бусад нутаг дэвсгэрийн хоорондох худалдаанд гадаад худалдааны хуулийн зохицуулалтын нөхцөлүүд үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, Турк улс дахь 21 чөлөөт бүсүүдэд Туркийн худалдаж буй эд бараанд Экспортын хууль дүрэм үйлчлэх ба, чөлөөт бүсүүдээс Туркэд худалдаж буй бараа бүтээгдэхүүний тухайд Импортын хууль дүрмүүд үйлчилнэ гэсэн үг. Чөлөөт бүсийг хэрэглэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид Туркээс худалдаж авч буй бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь экспортын үнээр байна (НӨАТ-гүй байна). Нөгөө талд, Гадаад Худалдааны хуулийн нөхцөлүүд нь чөлөөт бүс ба бусад орнуудын хооронд, түүнчлэн чөлөөт бүсүүдийн хооронд хийж буй худалдаанд хамааралгүй байна.
- Нэгэнт Туркийн эсвэл Европын Холбооны гаралтай бараа бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн үйлчилгээ чөлөөт эргэлтийн байр суурь, эсхүл Туркт болон Европын Холбооны нутаг дэвсгэр дэх бараа материалын чөлөөт эргэлт нь аль ч чөлөөт бүсэд оруулахад огтхон ч өөрчлөгдөхгүй. Турк эсвэл Европын Холбооны гишүүн орнуудад оруулахад гаалийн татваргүй байна. Цаашилбал, гуравдагч орны гаралтай эд барааг чөлөөт бүсэд оруулахад ч гаалийн татваргүй байна. Түүнчлэн тийм эд барааг Турк эсвэл Европын Холбооны орнуудаас бусад гуравдагч орнууд руу гаргахад гаалийн татваргүй байна. Гэхдээ гуравдагч орнуудын эд бараанд Нийтийн Гаалийн Тариф-т тусгайлан заасан тарифаар гаалийн татвар ноогдуулах боломжтой ба, тэдгээрийг чөлөөт бүсээс Турк болон Европын Холбооны орнууд руу чөлөөтэй эргэлтэнд оруулах болон гаргахгүй болно.
- Чөлөөт бүсүүдийг нэгэнт “Турк-Европын Холбооны Гаалийн Холбооны Гаалийн Бүс Нутаг”-ын бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх учраас Туркын болон Европын Холбооны гаралтай ба Турк улсын дотоодод чөлөөт эргэлтэд орж буй бараа бүтээгдэхүүнийг Европын Холбоо руу гаргахдаа А.ТR гэрчилгээтэй байна. Нөгөө талд, гуравдагч орны бараа бүтээгдэхүүнийг Нэгдсэн Гаалийн Тарифийн дагуу татварыг чөлөөт бүсийн гаалийн албанд төлж чөлөөт эргэлтэд оруулсны дараагаар сая А.ТR гэрчилгээтэйгээр Европын Холбоо руу гаргаж болно.

- Чөлөөт бүсийн урамшуулал ба давуу талыг дотоод ба гадаадын бүх компаниуд адил тэгш эдэлнэ.
- Улсын болон бусад байгууллагуудад хандан албан ёсоор тогтоосон үнэ, чанар ба стандарт зэрэг нь чөлөөт бүсүүдэд үйлчлэхгүй.
- Өргөдөл хүсэлт ба үйл ажиллагааны бүх хүнд суртал хамгийн бага хэмжээндээ хүртэл буурсан байна. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг хувийн секторын компаниуд эрхлэн явуулдаг юм. Өөрөөр хэлбэл оператор (operator) нь хувийн компаниуд байна

Чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийх: Чөлөөт бүсүүдэд үйл ажиллагаа явуулахын тулд Гадаад Худалдааны Тамгын Газар ба Чөлөөт Бүсүүдийн Ерөнхий Захирлын Зөвлөлөөс (Free Zones General Directorate) Үйл ажиллагааны зөвшөөрөл авах ёстой. Үйл ажиллагааны зөвшөөрөл авахад дараах бичиг баримтуудыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- а) Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн маягт ба түүний хуулбар. Үүнийг Чөлөөт Бүсүүдийн Захирлын Зөвлөл, холбогдох чөлөөт бүсийн захирлын зөвлөл, эсвэл чөлөөт бүсийн оператор компаниас авна.
- б) Өргөдөл гаргагчийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл ба эрхлэн явуулах гэж буй үйл ажиллагааны тухай танилцуулгыг бичгийн хэлбэрээр өгнө.
- в) Өргөдөл гаргагчийн албан ёсны гэрчилгээ ба баталгаат гарын үсэг, компанийн төлөөлөгчийн (хэрвээ байгаа бол) албан ёсны гэрчилгээ ба баталгаат гарын үсэг
- г) Өргөдөл гаргагчийн компани байгуулагдсан тухай ба хөрөнгийн байдал, хувьцаа эзэмшлийн бүтэц зэргийн тухай нийтэлсэн материал бүхий Туркын Худалдааны Бүртгэлийн Сэтгүүл, эсвэл Худалдааны танхим эс бөгөөс Аж үйлдвэрийн бүртгэлийн лавлагаа (гадаадын компанийн тухайд бол Турк дахь тухайн орны төлөөлөгчийн газрын баталгаа бүхий үүсгэн байгуулагдсан тухай албан ёсны бичиг баримтын хуулбар),
- д) Компанийн тайлан балансын хуудас, сүүлийн гурван жилийн ашиг, алдагдлын тухай мэдүүлэг,
- е) Өргөдлийн төлбөрийг Төв Банкинд тушаасныг гэрчлэх банкны баримт эх хувиараа болон нэг хувь хуулбарын хамт (Турк Улсын Төв Банкны 951 101 301 дансанд 5000 ам долларын депозит хийнэ)
- ж) Сүүлийн гурван жилийн хугацаанд Туркт оруулж ирсэн гадаад арилжааны дүн хэмжээг илэрхийлсэн бичиг баримт (хэрвээ байгаа бол)

Эдгээр бичиг баримтуудыг өргөдлийн хамтаар шууд биечлэн өгөх, эсвэл баталгаат шуудангаар илгээж болно.

Ерөнхий Захирлын Зөвлөл нягтлаад тохиромжтой гэж үзсэн компаниудад Үйл ажиллагааны зөвшөөрлийг 30 өдрийн дотор авч, тухайн чөлөөт бүсийн оператор компани, аль эсвэл тэндэхийн лицензтэй аль нэгэн компанитай албан байрны түрээсийн гэрээндээ үзэглэх эрхтэй болох ажээ.

Чөлөөт бүсийн санхүүжилт: Турк улс өөрийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаанаас олсон бүх орлогыг Туркийн Төв Банкинд байрлах “Чөлөөт бүсийн орлогын тусгай данс” (Special Account for FTZ Revenue)-д татан төвлөрүүлдэг байна. Тус дансанд хуримтлагдсан орлогын 10 хувийг буцаагаад Чөлөөт бүсүүдийн хөгжил, бүтээн байгуулалт, үйлчилгээ, үйл ажиллагаанд зориулдаг. Тус санд дараах эх үүсвэрээс орлого хуримтлуулдаг байна. Үүнд:

- Үйл ажиллагааны лицензын төлбөр
- Бүсэд нэвтэрсэн болон орхин гарсан бараа бүтээгдэхүүний CIF, FOB үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хураамж

- Чөлөөт бүсийг удирдаж байгаа хувь хүн, хуулийн этгээдтэй хийсэн гэрээний дагуу төлөгдөж буй тусгай төлбөр
- Бусад орлого

Үйл ажиллагааны мэдүүлгийн энгийн хураамж нь 5000 ам доллар байдаг. Харин 49-99 жилийн хугацаатай онцгой чухал төслүүдийн хувьд мэдүүлгийн хураамж нь дараах хэмжээтэй байна. Үүнд:

Лицензийн хураамж	
Үйл ажиллагаа явуулахаар хүссэн хугацаа	Лицензийн төлбөр /ам.доллараар/
49 жил	100000
99 жил	250000

Чөлөөт бүсийн тухай хуулийн агуулга

Чөлөөт бүсийн тухай хууль дараах агуулгатай байна. Үүнд:

Ерөнхий зүйл нэгдүгээр бүлэгт хуулийн бодлого, хамрах хүрээ, хууль зүйн үндэслэл, нэр томъёоны тайлбар болон хуулийн тодорхойлолтууд багтсан байна.

- 1) Хоёрдугаар бүлэгт Чөлөөт бүс байгуулах, Чөлөөт бүсийн удирдлагууд, Зохицуулах Зөвлөлийн тухай багтсан бөгөөд тус бүлэг нь 5 хэсэгтэй. Үүнд:
 - а) Нэгдүгээр хэсэг: Чөлөөт бүсийн Захирлуудын Зөвлөл, Бүсийн удирдлага, Бүсийн хил хязгаар, Барилга байгууламжийн дээд ба доод байгууламж, тэдгээрийн хамгаалалт
 - б) Хоёрдугаар хэсэг: Талбайн үйл ажиллагаа, Ашиглалтын лиценз, Үйлдвэрлэлийн болон Худалдааны бүртгэл, Бүсэд орох бүсээс гарах
 - в) Гуравдугаар хэсэг: Бүсийн болон Хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах журам, хамгаалалт
 - г) Дөрөвдүгээр хэсэг: Бүсийн үүсгэн байгуулагч болон ажиллуулагч
 - д) Тавдугаар хэсэг: Гаалийн татвар, Татварын хөнгөлөлт чөлөөлөлт болон урамшуулал
- 2) Гуравдугаар бүлэгт Чөлөөт бүсийн бараа бүтээгдэхүүн, түрээс болон үйлчилгээний гэрээ, тарифтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус бүлэг нь 2 хэсэгтэй. Үүнд:
 - а) Нэгдүгээр хэсэг: Бараа бүтээгдэхүүн экспортлох, импортлох болон Дамжин өнгөрөх бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртөг
 - б) Хоёрдугаар хэсэг: Бүсэд бараа бүтээгдэхүүн орох, гарах
- 3) Дөрөвдүгээр бүлэгт Тусгай данс болон Чөлөөт бүсийн орлого зэргийг нарийвчлан зохицуулсан бөгөөд тус бүлэг нь 2 хэсэгтэй байна. Үүнд:
 - а) Нэгдүгээр хэсэг: Тусгай данс болон Чөлөөт бүсийн орлого
 - б) Хоёрдугаар хэсэг: Түрээсийн үнэ болон Түрээсийн гэрээ
- 4) Тавдугаар бүлэгт гадаад валют солилцоо, банкны үйлчилгээ, даатгал болон бусад үйлчилгээ. Тус бүлэг нь дараах хэсгүүдтэй. Үүнд:
 - а) Нэгдүгээр хэсэг: Гадаад валют солилцоо, банкны үйлчилгээ, даатгалын үйлчилгээ
 - б) Хоёрдугаар хэсэг: Ачих, буулгах болон бусад үйлчилгээ
- 5) Бусад зүйл.

3.9. ТАЙВАНЬ УЛС

Тайвань Улс Хятад, Тайланд, Вьетнам зэрэг дэлхийн үйлдвэрлэлийн төвүүдтэй ойрхон байрладаг давуу талдаа тулгуурлан тэдний бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд түгээх логистикт чиглэсэн Худалдааны Чөлөөт Бүсийг амжилттай хөгжүүлж байна.

Чөлөөт худалдааны бүсийн хууль эрх зүйн орчин

Тайвань Улс Чөлөөт худалдааны бүсийн хууль эрх зүйн орчин нь боловсронгуй, бизнесийн таатай орчныг бүрдүүлсэн орнуудын нэг юм. Тус улсад чөлөөт худалдааны үйл ажиллагааг зохицуулдаг холбогдох 17 хууль үйлчилж байна. Түүнээс хамгийн гол нь “Худалдааны чөлөөт бүс байгуулах ба менежментийн тухай хууль” бөгөөд уг хуулийг 2003 онд баталсан. Хууль нь 7 бүлэг 42 зүйлтэй. Энэхүү хуулийн зорилго нь глобал тээвэр зуучлал ба менежментийн системийн үйл ажиллагааны хэлбэршилтийг хөгжүүлэх, худалдааны либерализм ба интернационализмыг эрчимтэй дэмжих явдалд нөлөөлөх, боловсон хүчин, бараа бүтээгдэхүүн, санхүү, технологийн саадгүй урсгалыг нөхцөлдүүлэх, улс үндэстний өрсөлдөх хүч чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэхэд оршино.

Худалдааны чөлөөт бүс байгуулах ба түүний менежментийн тухай харилцааг энэ хуулинд заасан нөхцөлүүдээр зохицуулах ба энэ хуулинд заагдаагүй асуудлуудыг бусад холбогдох хууль тогтоомжуудад журамласнаар зохицуулах, хэрвээ тэдгээр холбогдох хууль тогтоомжуудад энэ хуульд зааснаас илүү таатай нөхцөлөөр зохицуулсан бол хамгийн таатай хуулийг нь баримтлан журамлахаар заажээ.

Мөрдөгдөж буй хууль, дүрэм

1. Act for the Establishment and Management of Free trade zones
2. Regulations Governing Entry, Departure and Inhabitation in Free Trade Zones
3. Regulations Governing the Approval and Transfer of “Selective Landing Visa” of Free Trade Zone Administration
4. Regulations Governing Profit-seeking Enterprise Income Tax Exemption for Foreign Profit-seeking Enterprises Conducting Goods Storage and/or Simple Processing Operations in Free Trade Zone
5. Regulations Governing Applications for the Establishment of Free Trade Zones
6. Regulations Governing the Operation and Management of Free Trade Zones Enterprises
7. The Regulations Governing Customs Clearance for Goods in Free Trade Zones
8. Guidelines for the Establishment of the Free Trade Zone Coordinating Committee of the Executive Yuan(pdf)
9. General Introduction to the Regulations Governing the Operation and Management of Free Trade Zones Enterprises Administered by the Ministry of Transportation and Communications(pdf)
10. General Introduction to the Regulations Governing Applications for the establishment of Free Trade Zones(pdf)
11. Act for the Establishment and Management of Free trade zones
12. Суао чөлөөт усан боомтын үйлчилгээний жагсаалт
13. Тайпэй чөлөөт усан боомтын үйлчилгээний жагсаалт
14. General Description on the MOTC Notice for the Review of Applications for Outsourced Processing Projects
15. Operational Notice of the Verification for the Application of Outsourcing Processing by the Ministry of Transportation and Communications(pdf)
16. Operational Notice of the Verification for the Application of Outsourcing Processing by the Ministry of Transportation and Communications (pdf)

Чөлөөт худалдааны бүсийн тогтолцоо

Тус улс газар нутгийн байршлаас шалтгаалан усан боомууддаа түшиглэн чөлөөт худалдааны бүс байгуулж, худалдаа бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаардаг. Хуульд зааснаар **чөлөөт бүс** гэдэг нь гүйцэтгэх засгийн зөвшөөрөл бүхий олон улсын нисэх буудал эсвэл олон улсын усан боомтын хяналтын дүүрэг дотор байрлах нутаг дэвсгэрийг хэлдэг.

Харин худалдааны чөлөөт бүсийн аж ахуйн нэгжүүд гэж худалдааны чөлөөт бүсийн дотор худалдаа, агуулах, тээвэр зуучлал, цуглуулах, (карго ачааны) чингэлэг түгээх, транзит хийх, транс усан тээвэр хийх, дамжуулан илгээх, гаалийн бүрдүүлэлт хийх, угсралт хийх, ангилалт хийх, сав баглаа боодол, засвар хийх, дахин боловсруулалт хийх, боловсруулах, үйлдвэрлэх, нягтлах, шалгах, үзэсгэлэн гаргах, технологийн үйлчилгээ хийх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүд юм.

Чөлөөт-боомтын бус аж ахуйн нэгж нь аливаа санхүүгийн ажил, усан зогсоолын ажил, хүнсний хангамж, зочид буудал, бизнесийн уулзалт зөвлөгөөн, транс усан тээвэрлэлт ба худалдааны чөлөөт бүсийн аж ахуйн нэгж биш боловч худалдааны чөлөөт бүс дотор үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд байна.

Зураг 9. Чөлөөт бүсийн бүтэц, үйл ажиллагааны схем



Улсын газар нутгийн дотор орших боловч гаалиас гадуур орших тусгай бүс нь бараа бүтээгдэхүүний арилжаа, худалдаа, хүмүүсийн урсгалдахь саад бэрхшээлийг багасгаснаар үндэстэн хоорондын бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.


Тээвэр зуучлал, агаарын болон усан тээвэрлэлтийн нэмүү өртгийн тусгай бүс нь нийлүүлэлтийн менежментийн хэрэгцээ, шаардлагыг хангасан усан болон нисэх буудлын үйл ажиллагааг хослуулсан хэлбэр юм. Ингэснээр чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих өрсөлдөөнийг бий болгож байна. Тусгай бүсүүд нь бүрэн худалдааны либералчлалын түршилтын шат болдог бөгөөд аж ахуйн нэгжийн биеэ даасан байдлыг чухалчилдаг.

Зураг 10.



Чөлөөт бүсийн удирдлага, зохион байгуулалт: Тайвань Улсын хуульд зааснаар чөлөөт бүсийн үйл ажиллагааг удирдан зохицуулдаг Чөлөөт Худалдааны Бүсийн Хороо хэмээх бие даасан байгууллага байдаг. Тус хороо нь улс болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн гишүүдтэй. Доороо Ажлын алба болон чөлөөт бүсүүдэд ажилладаг захиргааны албадуудтай. Энэ нь чөлөөт бүсийн үйл ажиллагааг зохицуулахад хялбар систем юм.


Зураг 11.



Чөлөөт худалдааны бүсүүд

Тайвань Улс таван худалдааны чөлөөт бүстэй. Эдгээр нь худалдаа, тээвэр үйлчилгээ, үйлдвэрлэл, бизнесийн татварын болон хууль эрх зүйн орчин сайтайгаас гадна байршлын хувьд логистик ийн тааламжтай нөхцөлийг бүрдүүлсэн, өндөр техник технологийн үйлчилгээ, хамгаалалт, агуулахын автомат системтэй, гадны хөрөнгө оруулалт, ажиллах хүчийг өөртөө татаж чадсан худалдаа, үйлчилгээний өндөр хөгжилтэй бүсүүд юм.

Зураг 12. Тайваны Чөлөөт худалдааны бүсүүд



1.Keelung боомтын худалдааны чөлөөт бүс:

Keelung боомтын худалдааны чөлөөт бүс нь тус боомтын зүүн банкны 6-22 болон баруун банкны 7-33 хэсгийг хамарсан 71,16 га талбай юм. Тус чөлөөт худалдааны бүсийг Keelung боомтын хэлтсээс байгуулсан бөгөөд энэ нь Тайпэй хотын ойролцоо байрлах бөгөөд Умард Тайваны хэрэглээний зах зээл болон улс төрийн төвд байдаг. Эргэн тойрондоо Xizhi, Nangang, Neihu Шинжлэх ухааны парк, мөн Dawulun, Ruifang, Liudu дахь аж үйлдвэрийн парк зэрэг газруудаар хүрээлэгдсэн.

Тус боомтын чөлөөт худалдааны бүс нь хөлөг онгоцны тээвэрлэлт, олон улсын логистик, хадгалалт агуулах, томоохон худалдааны газар, улс хоорондын импорт, экспортын худалдаачдад өөрсдийн боомтыг ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь тээвэрлэлтийг хялбарчлах, нэмэгдүүлэх, түгээлтийг төвлөрүүлэх, улс хоорондын тээврийн засвар үйлчилгээг хийх, тээвэрлэлтийн энгийн боловсруулалтыг хийх зэргээр аж ахуй бизнес эрхлэгчдийн цагийг хэмнэн, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна. Аж үйлдвэрийн салбарууд нь агуулах, логистик, угсралт, түгээлт, төвлөрүүлэх, баглах, энгийн боловсруулалт хийх, ачаа тээврийн зардлыг шилжүүлэх, шилжүүлэн ачилт, боомтод онцгойлон тохиромжтой тээврийн хэрэгслүүд зэргийг бүлэглэн хамруулсан байдаг. Энэ нь мөн л аж үйлдвэрүүдэд аль хэдий нь үр нөлөөгөө үзүүлээд байгаа.

2. Таіреі боомтын худалдааны чөлөөт бүс:

Таирей боомт нь 3,102 га талбайтай. Түүнээс 79 га талбайд Таирей-ийн худалдааны чөлөөт бүс үйл ажиллагаа явуулдаг. Газар нутгийн хэмжээг Keelung боомтын захиргаа болон Таирей хотын захиргаанаас тогтоосон.

Боомтын агуулахын хэсэг болон дэд бүтцийн төлөвлөлт нь худалдааны чөлөөт бүсэд ашиглахад ихээхэн тохиромжтой. Таирей боомт нь одоогоор автоомбайл логистиктой. Цаашдаа том хэмжээний агуулахын хэсэг, тос агуулах төв бий болгохоор төлөвлөсөн.

Тайpei боомтын чөлөөт худалдааны бүс нь Taipei хотын оршин суугчдад ойрхон, эргэн тойрондоо Tucheng, Wugu, Linkou, Shulin зэрэг аж үйлдвэрийн бүстэй хөрш зэргэлдээ

байрлахаас гадна Таоуан-ы нисэх онгоцны буудлаас 23-хан км зайд байрладаг учир томоохон зах зээлтэд тооцогддог.

3.Su-ao боомтын худалдааны чөлөөт бүс:

Su-ao боомтыг чөлөөт бүс болгох хүсэлтийг 2010 оны 9 сарын 13 өдөр Зам Тээврийн Харилцааны яамнаас зөвшөөрсөн. Энэ бүс нь 3 ерөнхий талбайг хамардаг. /контейнерийн талбай, 1, 2-р логистик ийн бүс/ Боомт нь тухайн хэсгийн 71.5 га талбайг эзэлдэг.

Su-ao худалдааны чөлөөт бүс нь эртнээс <Green energy> буюу ногоон үйлдвэржилтийг өөртөө татсан бөгөөд 25 сая долларын хөрөнгө оруулалтыг авахаар болсон.

4.Taichung боомтын худалдааны чөлөөт бүс:

Taichung боомтын худалдааны чөлөөт бүс нь нийт 536 га талбайг хамрах ба Тайванийн газар нутгийн төвд оршдог бөгөөд Cingcuangang олон улсын нисэх онгоцны буудалтай хурдны замаар холбогддог. Энэ нь далайн болон агаарын тээвэрлэлт илүү хөгжих боломжийг бий болгосон. Мөн БНХАУ-ын Шанхайгаас Хонгконг хүрэх тээвэрлэлтийн замын дунд буюу Хятадын зүүн өмнөд эргийн бүх боомтуудтай харьцангуй ойр байрладаг. Энэ нь Тайвань, Хятад улсын хооронд тээвэрлэлт хийх тааламжтай давуу тал болдог байна.

Тус бүс нь Taichung эргийн экспортын бүс, аж үйлдвэрлэлийн бүс, аж үйлдвэрийн парк, Changhua эргийн аж үйлдвэрийн парк, Тайваны Шинжлэх ухааны төв парк, Машин технологийн аж үйлдвэрийн парк, Tanzih экспортын бүс зэрэгтэй хөрш зэргэлдээ оршдог. Энэ нь тээвэрлэлт, логиستيкийг дэмжих, бүс нутгийн дахин экспортлох үйл ажиллагаа, бараа үйлчилгээний чанарт сайнаар нөлөөлдөг байна. Мөн худалдааны чөлөөт бүсийн нэгдлийн давуу тал нь дотоодын логистикоос олон улсын логистик болон дэвшихээс гадна боомтын зогсоолын (terminal) ачилт тээвэрлэлт, бараа бүтээгдэхүүний агуулах, хадгалалт, үйлдвэрийн боловсруулалт зэрэг нь нэгдмэл болж цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой.

5.Kaohsiung худалдааны чөлөөт бүс:

Kaohsiung боомтын худалдааны чөлөөт бүс нь 1-5 боомтын зогсоолыг /terminal/ хамарсан 415 га талбайг эзэлдэг.

Kaohsiung боомт нь Тайванийн умард хэсэгт оршдог, газар тариалан, загасчлал, мал аж ахуйн бүс нутаг юм. Дэвшилтэт олон давхаргаар хөлдөөх хүчин чадал бүхий агуулах байгууламжтай. Боомтын чөлөөт бүсийн агуулахын зогсоол нь Siaogang олон улсын нисэх онгоцны буудлаас 3 км-ын зайтай, хурдны замуудтай чөлөөтэй холбогдсон. Аж үйлдвэрийн бүсүүд нь Kaohsiung боомтыг оролцуулаад Tainan хот, Pingtung мужтай ойрхон байрладаг. Kaohsiung хотын хэсэг нь МОЕА-ийн экспортын бүс, Тайванийн умард шинжлэх ухааны парк, Yang Ming группийн YES логистик корпораци, нутгийн контейнер зогсоолууд болон 7 экспортын бүс болох Kaohsiung, Nanzih, Chenggong, Kaohsiung агаарын карго, Linguang, Kaohsiung программ хангамжийн технологи, Pintung зэргийг хамарна. Тайваны засгийн газраас Kaohsiung эргийн газарт Kaohsiung хотын "Star South project" төслийг ашиглан нарны эрчим хүчийг ашиглах аж үйлдвэрийн бүсийг чөлөөт бүсдээ байгуулахыг уриалсан.

3.10. МАЛАЙЗЫН ХОЛБООНЫ УЛС

Малайз Улс боомтуудад түшиглэсэн Чөлөөт Худалдааны Бүсүүд /Free Commercial Zones/, Чөлөөт Аж Үйлдвэрийн Бүсүүд /Free Industrial Zones/ өндөр хөгжсөн орон юм.

Чөлөөт бүсүүд нь худалдаа (жижиглэнгийн худалдаанаас бусад), боловсруулалт, дахин боловсруулалт, логистик ба шилжүүлэн ачих зэрэг худалдаа арилжааны үйл ажиллагаа бүхий “чөлөөт худалдаа арилжааны бүс” болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүхий “чөлөөт аж үйлдвэрийн бүс”-ээс бүтнэ.

Малайзид хойд, өмнөд, баруун боомтуудад байрласан 11 Чөлөөт Худалдааны Бүс /ЧХБ/ ажиллаж байна. Тэдгээр нь Кланг боомтын ЧХБ, Пулау MILS Логистик Төв, Баттерворт, Баян Лийс, KLIA, Рантау Панжанг, Пенкалан Кубор, Стуланг Лаут, Жохор Боомт ба, Танжунг Пелепас /Port Klang Free Zone, Pulau Indah MILS Logistic Hub, Butterworth, Bayan Leas, KLIA, Rantau Panjang, Pengkalan Kubor, Stulang Laut, Johor Port and Port of Tanjung Pelepas/ зэрэг болно.

Харин 18 Чөлөөт Аж Үйлдвэрийн бүстэй бөгөөд тэдгээр нь Pasir Gudang, Tanjung Pelepas, Batu Berendam I, Batu Berendam II, Tanjung Kling, Telok Panglima Garang, Pulau Indah (PKFZ), Sungai Way I, Sungai Way II, Ulu Kelang, Jelapang II, Kinta, Bayan Lepas I, II, III, IV, Seberang Perai, Sama Jaya зэрэг газруудад байрлаж байна.

Чөлөөт Аж Үйлдвэрийн Бүсүүд нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ шаардлагатай буй түүхий эд, техник тоног төхөөрөмж, машин техник зэргийг татваргүй импортлохын сацуу өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг мөн адил гаалийн бага бүрдүүлэлттэйгээр экспортолдог.

Чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчин

Малайз Улс анх 1971 онд Чөлөөт Худалдааны Бүсийн хуулийг баталсан бөгөөд энэ нь цаг хугацааны шалгуураар эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чадваргүй болох нь тодорхой болж, дахин хуулийг шинэчлэх хэрэгтэй болсон байна. Тиймээс 1990 онд “Чөлөөт бүсийн хууль”-ийн төслийг боловсруулж, худалдаа болон аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор улс орондоо Чөлөөт бүсүүдийг байгуулах шинэ чиг хандлагыг дэвшүүлсэн. Хуулийн төсөл дэмжигдэж Чөлөөт бүсийн хууль (Free Zones Act 1990)-ийг батлан 1991 оны 9-р сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр хуульчилжээ. Хуулийн хэрэгжилтийг хангуулах 1991 оны Чөлөөт Бүсийн Журам (Free Zones Regulations)-ыг мөн баталсан байна. Энэ хууль нь Малайзын усан боомт ба нисэх буудлуудын уламжлалт үүрэг ролийг өөрчилж, татваргүй чөлөөт бүс болох аливаа алхам бүрийг дэмжих боломжийг бүрдүүлсэн.

“Чөлөөт бүсийн хууль”-ийн 3-р хэсгийн 1-д зааснаар “Чөлөөт бүс” гэдэг нь чөлөөт боомтын худалдааг дэмжих ба аж үйлдвэрүүд экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа бүхий Сангийн Сайдын шийдвэрээр тогтоосон татваргүй бүс нутгийг хэлдэг байна.

Чөлөөт бүс байгуулах, удирдлага зохион байгуулалт

Чөлөөт бүсийн үйл ажиллагааг Малайз улсын Сангийн Сайд ерөнхийд нь хариуцдаг бөгөөд Олон Улсын Худалдаа, Аж үйлдвэрийн яам, агентлагууд хариуцан, эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг нь зохицуулдаг. Чөлөөт бүс байгуулах асуудлыг дээрх яам агентлагууд хэлэлцэн шийдвэрлэдэг ч Сангийн сайд аливаа нутаг дэвсгэрийг чөлөөт худалдаа арилжааны эсвэл чөлөөт аж үйлдвэрийн бүс хэмээн зарлаж Сонинд энэ тухай

мэдээлэл нийтлүүлэх эрх мэдэлтэй байдаг. Энэхүү сонины мэдээлэл нь тухайн нэг бүсийн цар хүрээг тодорхойлно. Зарим нэг онцгой нөхцөлд Олон Улсын Худалдаа, Аж Үйлдвэрийн Яам 80 хувиас багагүй экспорт хийдэг компаниудад Чөлөөт бүсэд байрлах зөвшөөрөл олгодог.

Чөлөөт бүсийн дотор үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн өргөдлийг чөлөөт бүсийн дотор үйл ажиллагаа явуулахыг хүссэн хэн боловч түүний захиргаанд FZ No. 4 маягтыг бөглөн өргөдөл өгнө. Зөвшөөрлийг FZ No. 6 маягтаар олгох бөгөөд зөвшөөрөлийн нөхцөл нь Бүсийн Захиргааны шийдвэрээс хамаарна. Мөн зөвшөөрлийн хуулбарыг Гаалийн Ерөнхий Захиралд өгсөн байх шаардлагатай байдаг байна.

Харин чөлөөт бүсийн дотор барилга барих, түрээслэх, байр эзэмших зөвшөөрлийг авахдаа FZ No. 5 маягтаар өргөдөл үйлдэх ёстой. Үүний дагуу Бүсийн захиргаа хянан үзээд зөвшөөрлийг FZ No. 6 маягтаар олгох ба түүний хуулбарыг мөн Гаалийн Ерөнхий Захиралд өгсөн байх ёстой. Бүсийн захиргааны зөвшөөрөлгүйгээр барилга ба түүний бүтцэд ямар ч нэмэлт өөрчлөлт хийж болохгүй.

Чөлөөт бүсийн хуулийн 3-р хэсгийн 1-д журамласнаар чөлөөт бүсийн захиргааны хэргийг Сангийн сайд хариуцаж, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах Бүсийн захиргаанд дараах албадыг тохоон томилж болно. Үүнд:

1. Холбооны хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан дотоод дүрэм журам бүхий ямарваа байгууллага эсвэл
2. Малайзын Засгийн газрын аль нэгэн алба эсвэл
3. Хэрвээ аль нэгэн Муж улс зөвшөөрөл өгсөн бол тухайн Муж улсын хууль ёсны дагуу үүсгэн байгуулагдсан байгууллага эсвэл
4. Муж улсын Засгийн газрын аль нэг алба, газар эсвэл
5. Аливаа компани

Чөлөөт бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах Бүсийн захиргаа нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. Чөлөөт бүсийн хил хязгаарын дагуу хоёр зэрэгцээ хашаа эсвэл ханыг орох ба гарах үүдтэйгээр босгож, засвар үйлчилгээг нь хийх
2. Үүд хаалган дээр Гаалийн алба ба Шалгалтын байрыг байршуулах
3. Оператор аж ахуйн нэгжүүд Чөлөөт бүсийн хууль, дүрмийг баримтлан ажиллаж буй эсэхэд хяналт тавих
4. Өөрийн үйл ажиллагаа ба бодлогын тайланг жил бүр Сангийн Яаманд өгнө.
5. Чөлөөт бүсэд нэвтэрч, гарч буй хүмүүс ба бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хянах.
6. Гаалийн үүргийг хамгаалж, гаалийн татвар хураамжид хамааралтай бараа чөлөөт бүсийн дотор хадгалуулахгүй байхыг хариуцах.
7. Гаалийн Ерөнхий Захирлын өгсөн аливаа бусад бүх чиглэлийг сахин биелүүлэх зэрэг болно.

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулагчид болон операторууд нь дараах үүрэг хариуцлагыг хүлээхээр хуульчилсан байна. Тухайлбал,

1. Улсын татвар болон Чөлөөт Бүсийн зохистой үйл ажиллагааг хамгаалах, хадгалах зорилгоор Бүсийн Захиргаанаас оператороос операторын бүх үйл ажиллагааны бүрэн тэмдэглэл хөтлөхийг шаардаж болно.
2. Тэмдэглэлийг гагцхүү Бүсийн Захиргаа, Гаалийн байгууллагатай зөвлөлдсөний дараа өгсөн зөвшөөрлөөр устгаж болно.
3. Оператор нь Бүсийн Захиргаанд өмнөх сарын тайланг сар бүрийн 10-наас өмнө мэдүүлэх ёстой.
4. Ямар ч оператор Захиргааны зөвшөөрөлгүйгээр ямар ч эд зүйлийг устгах ёсгүй.

Чөлөөт бүсийн хөнгөлөлт, чөлөөлөлт

Хуульд үндэслэснээр чөлөөт бүсийн үйл ажиллагаа, аж үйлдвэрүүд нь гаалийн бүрдүүлэлт хамгийн бага байх ёстой ба, 1967 оны “Гаалийн хууль”-ийн 31-р хэсэгт зааснаар импортолж, экспортлохыг хориглосноос бусдаар үндсэн гаалийн хамаарах хүрээнээс гадуур байна.

Чөлөөт бүсийн дотор оруулж ирсэн, бүтээсэн, үйлдвэрлэсэн, ханган нийлүүлсэн хуулиар тусгайлан зааж, бүрэн хориглосноос бусад аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд гааль, дотоод зах зээлийн барааны, худалдаа, үйлчилгээний зэрэг татвар хураамжийг төлөхгүй.

Гэхдээ Сангийн Сайд “Газетте” сонин дээр аль нэгэн бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээг чөлөөт бүсэд нэвтрүүлэхгүй гэсэн шийдвэрийг гарган хэвлүүлж болно. Ийнхүү шийдвэр гарсан бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээнээс Чөлөөт бүс нь гаалийн, дотоод зах зээлийн барааны, худалдааны, үйлчилгээний гэх мэт татвар хураамжуудыг авдаг.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИЛ**Монгол Улс**

- ЗГ-ын 1995 оны 87 дугаар тушаалын хавсралт.
- Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал⁴⁴
- Чөлөөт бүсийн тухай хууль,
- “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль,
- “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль,
- “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль.
- Чөлөөт бүсэд шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулах журам,
- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн бүртгэлийн журам,
- Чөлөөт бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журам,
- Чөлөөт бүсэд виз олгох хялбарчилсан журам,
- Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам.

⁴⁴Засгийн газрын 1995 оны 87 тушаалын хавсралтаар

ОХУ

- Федеральный закон от 22.07.2005 N 116-ФЗ (ред. от 23.07.2013) "Об особых экономических зонах в Российской Федерации".

БНКазахстан Улс

- Закон РК «О специальных экономических зонах» от 21 июля 2011 года.
- Налоговый кодекс РК.

БНБеларус Улс

- Закон Республики Беларусь 7 декабря 1998 г. № 213-З О свободных экономических зонах.

БН Сербия Улс

- Law on free zone, "RS Official Gazette", No 62/2006.

БНСолонгос Улс

- Korean Special Act on Designation and Management of FEZ.
- Korean Foreign Investment Promotion Act.
- Korean Local Regulation on Managing Public Properties⁶

БНХАУ

- http://en.wikipedia.org/wiki/Free_zone
- http://en.wikipedia.org/wiki/China#-Economic_history_and_growth
- <http://archiv.ub.uni-heidelberg.de/volltextserver/3244/1/fez-meng.pdf>- The Theory and Practice of Free Economic Zones: A Case Study of Tianjin, People's Republic of China
- <http://english.mofcom.gov.cn/article/policyrelease/Businessregulations/?-> ministry of commerce people's republic of china
- <http://www.by-cpa.com/html/news/20076/754.html>- Comparison of Free trade zone and Non-free trade zone.

Доминиканы БНУ

- www.lexadin.com-Law № 8-90 on the Promotion of Free Zones, Official Gazette 9775, January 15, 1990.

БНТурк Улс

- Чөлөөт бүсийн тухай хууль №3218. 1985 оны 6-р сарын 15-ны №18785 дугаар Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн.
- Чөлөөт бүсийн тухай журам №21520. 1993 оны 3-р сарын 10-ны Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн.

Тайвань Улс

- <http://taiwan-ftz.com/lp.asp?CtNode=533&CtUnit=164&BaseDSD=7&mp=3->
- <http://investtaiwan.nat.gov.tw/eng/show.jsp?ID=445&MID=2->
- <http://investtaiwan.nat.gov.tw/eng/show.jsp?ID=8&MID=3->
- [http://law.moj.gov.tw/Eng/-](http://law.moj.gov.tw/Eng/)
- http://taiwanftz.com/lp.asp?CtNode=533&CtUnit=164&BaseDSD=7&mp=3&xq_xCat=02
- <http://taiwan-ftz.com/lp.asp?CtNode=533&CtUnit=164&BaseDSD=7&mp=3>

Малайз Улс

- http://www.portsworld.com/customs/proc_freezone.htm
- www.lexadin.com – act Free zone in Malaiz, 1990

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, БҮС
НУТГУУДАД ХУВААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**
(Мэдээлэл лавлагаа)

Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаа

АГУУЛГА

Удиртгал

1. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага, хүн амын төвлөрлийг сааруулах арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт
 - 1.1. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага
 - 1.2. Хүн амын төвлөрлийг сааруулах арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт
2. Бүсчлэн хөгжүүлэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлсэн бусад орнуудын туршлага
 - 2.1. Англи
 - 2.2. ХБНГУ
 - 2.3. ОХУ
 - 2.4. Канад

Ашигласан материал

УДИРТГАЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага, хүн амын төвлөрлийг сааруулах арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бүсчлэн хөгжүүлэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг судлахад оршино.

Судалгааны үр дүн

Судалгааны сэдвийн хүрээнд дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж ирсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн арга, төрийн зохицуулалтын асуудлууд, бүс нутгийн хөгжлийг дэмжих институцийг бүрдүүлэх асуудлуудыг тусгасан болно.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлсэн улс орнуудын хөгжлийн үндсэн чиглэл нь нутаг дэвсгэрээ харьцангуй тэнцвэртэй бүсчлэн хөгжүүлэх, хүн амын амьдралын жигд нөхцөлийг хангах асуудал, эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгмийн байгууллын хэлбэрээс үл хамааран ихэнх улс орны төрийн бодлогын нэг чиглэл болсоор ирсэн байна.

Хөгжингүй орнууд нь бүсийн бодлогыг нутаг дэвсгэрээ тэнцвэртэй хөгжүүлэх гол арга зам гэж үзэж, хөрөнгө хүч, бодлого, төлөвлөлтийн хувьд ихээхэн анхаарч, дараах асуудлуудын хүрээг хамарсан цогц арга хэмжээг нарийн төлөвлөж хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Улс орны бүх мужийг үндэсний нэгдсэн зах зээл болгон хувиргах
- Хоцрогдсон хөдөө аж ахуйн мужийн эдийн засгийг дэмжих, бүсийн ялгааг багасгах
- Хот, хөдөөгийн шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулах
- Хөдөлмөрийн болон байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах
- Аж үйлдвэрийн шинэ төвүүдийг оновчтой байршуулах зэрэг болно.

Ихэнх улс орнууд бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ санхүүгийн дэмжлэг, бизнесийн орчныг сайжруулах, төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох зэрэг нийтлэг арга хэрэгслээр зохицуулалт хийжээ.

Төвлөрлийг сааруулах асуудлыг дэлхийн улс орнууд тодорхой түвшин, хэмжээнд байх ёстой зүйл гэж үздэг ч, харин түүнийг хэрхэн ямар хүрээнд, ямар арга зам сонгон хэрэгжүүлэх вэ гэдгийг өөр өөрсдөө аль үр дүнтэй гэсэн хувилбараар зохион байгуулдаг байна.

Шилжих хөдөлгөөн тулгамдсан асуудал болж, энэ талаар бодлого хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагаас үзэхэд ерөнхийдөө 4 чиглэлээр асуудалд хандсан байна.

1. Шилжих хөдөлгөөнийг зогсоох.
2. Шилжих хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх.
3. Шилжих хөдөлгөөнийг урьдчилан сэргийлэх.
4. Шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг арилгах

Эдгээр зохицуулалтын хүрээнд зарим хотыг хаалттай болгох, зөвшөөрөлгүй иргэдийг хүчээр нүүлгэх, хаягийн бүртгэлээр дэглэм тогтоох, ажил эрхлэлтэд хяналт тавих, орон сууцтай болох боломжийг хязгаарлах, хүнсний норм тогтоох, шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг голлох шалтгаан болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг багасгахад чиглэгдсэн тэднийг ядууралд орохоос сэргийлэх арга хэмжээг авсан нь багагүй амжилтад хүрчээ.

Түүнчлэн хөгжиж буй зарим орон ядуусын хороолол болон зөвшөөрөлгүй оршин суугчдын асуудлыг хуульчилсан нь тэдний аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалсан хүнлэг үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Дэлхийн улс орнууд бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ улс орноо бүхэлд нь хамарсан, эсвэл тодорхой бүс нутгийг онцгойлон анхаарсан гэсэн хоёр үндсэн чиглэлийг баримталж иржээ.

Эхний чиглэлийг Англи, Франц, Япон, Швед зэрэг оронд голлон баримталж байсан бол дараах чиглэлийг АНУ, Канад, ХБНГУ, Голланд, Бельги, Норвеги, Дани зэрэг оронд анхлан хэрэгжүүлсэн байна.

Бүс нутгийн хөгжлийн бодлогоо боловсруулахдаа бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьжиргааны үзүүлэлт, төв (*нийслэл*)-өөс алслагдсан байдал, тухайн бүс нутгийн байгаль цаг уур, хөгжлийн судалгааг үндэслэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, Англи улсын хувьд хүн амыг тараан байршуулах, сул хөгжилтэй бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байсан бол, ХБНГУ-ын хувьд хөдөөнөөс хүн ам нягт шигүү суурьшсан хот суурин газар уруу чиглэсэн хүн амын хөдөлгөөнийг сааруулах арга хэмжээ авах жижиг дунд хэмжээний суурин газрын дэд бүтцийг хэвээр нь хадгалж, өргөтгөн хөгжүүлэх, хүн ам тархуу суурьшсан газарт ч иргэдэд соёл, ахуйн үйлчилгээ, улсын болон хувийн секторын ажил үйлчилгээг ойртуулан эрэлт хэрэгцээг нь хангахад чиглэсэн бодлого боловсруулан хэрэгжүүлсэн байна.

Эдгээр орнуудын хөгжлийн туршлагаас харахад эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин өнөөгийхтэй нь харьцуулахад ерөнхийдөө доогуур байсан үед улс орныхоо нутаг дэвсгэрийг жигд хамруулсан бүсчилсэн хөгжлийн бодлогыг түлхүү хэрэгжүүлж байсан байна.⁴⁵

⁴⁵“Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн туршлагаас” Илтгэл, доктор Л.Цэдэндамба.

Ихэнх улс орнуудад бүсийн хөгжлийн бодлогыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эсвэл бодлого гэсэн бодлогын баримт бичгүүдэд төрөөс бүс нутгийн хөгжлийг дэмжих бодлогыг түлхүү тусгаж, Парламент, Засгийн газар, шууд захиргааных нь байгууллагууд, тэдгээрийн доод шатны төрийн захиргааны харьяа газрууд, нутгийн захиргааны байгууллагууд хариуцан ажилладаг. Мөн хувийн хэвшлийнхэн болон иргэд, хуулийн этгээдүүдийг татан оролцуулдаг байна.

Бүс нутгийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааны үр нөлөө нь эцсийн дүндээ үндэсний болон орон нутгийн түвшинд бодлого, институци хоёрыг хэрхэн уялдаатай зохион байгуулж чадах нь чухал ач холбогдолтой.

Учир нь бүс нутгийн бодлогын хүрээг тодорхойлохдоо түүнийг хэрэгжүүлэх институцийн хангалттай бааз суурь бүрдүүлээгүй, өмнөх дэглэмийн институцийг шинэ нөхцөлд түүнийг орлох институцийг байгуулалгүйгээр татан буулгасан, эсвэл зохих ёсоор тухайн институцийг бэхжүүлээгүйгээс үр дүнд хүрээгүй байна.

Дэлхийн олон оронд бүс нутгуудыг хөгжүүлэх болон ядуурлыг бууруулах хүчирхэг хөшүүрэг Кластер нэг талаас төрийн, нөгөө талаас хувийн хэвшлийнхний санаачилга давамгайлсан хоёр хэлбэртэй байх бөгөөд хөгжиж буй орнуудаас эхний хувилбарыг сонгосон нь илүү амжилтад хүрчээ. *Тухайлбал, АНУ, Япон, Финлянд, Унгар, Польш, Словак, Чех, Словен, Болгор, Румын* зэрэг орнууд хөгжлийн бодлогоо кластерийн хандлагын үүднээс тодорхойлж Засгийн газар дэмжлэг үзүүлжээ.

Кластер нь *нэгд* үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой хэсгүүдэд шаардлагатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бий болгоход суурилсан, *хоёрт* үйлдвэрлэлийн үйл явцад суурилсан, *гуравт* инновацийн, *дөрөвт* тээвэр логистикийн гэсэн хэв шинжтэй байдаг.

Кластерын зарчмаар ажилласнаар үйлдвэрлэл, үйлчилгээний зардал буурч ашигт ажиллагааны түвшин ихээхэн дээшилдэг. Мөн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх таатай орчин бүрддэг, гадаад, дотоод зах зээлд гарах боломж сайжирдаг, Засгийн газар, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллагын гурвалсан холбоо үүсдэг гээд сайн тал их ажээ.⁵

Дашрамд дурдахад хөндөж тавихыг оролдсон асуудлууд ихээхэн өргөн хүрээтэй, нарийн түвэгтэй байсан учраас бүх зүйлийн агуулга, ач холбогдлыг нэг бүрчлэн гарган харуулах боломжгүй нийтлэг зохицуулалтыг авч үзсэн болно.

НЭГ. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага, хүн амын төвлөрлийг сааруулах арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт

1.1. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага

Аливаа улс оронд хэрэгжүүлж ирсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын нийтлэг хандлага нь эдийн засаг, нийгмийн дэд бүтцийн хөгжлийг ойролцоо түвшинд хүргэх замаар хүн амын амьдрах, ажил эрхлэх, боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалах нөхцөлийг нутаг дэвсгэрийн нийт хэмжээнд харьцангуй жигд бүрдүүлэх явдал юм.

Бүсийн бодлогын үндсэн чиглэл нь нутаг дэвсгэрээ бүсчлэн харьцангуй тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын амьдралын жигд нөхцөлийг хангах асуудал эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгмийн байгууллын хэлбэрээс үл хамааран ихэнх улс орны төрийн бодлогын нэг чиглэл болсоор ирсэн.

⁴⁶"Кластерийн хандлагад тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хурдасгах зарим арга" Илтгэл, УБ., 2010 он, Л.Цэдэндамба.

Бүсийн бодлого нь тухайн улс орны үндэсний хөгжлийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дараах үндсэн чиглэлийг хамаарна. Үүнд:

- Бүсийн хөгжлийн хөдөлгөгч хүч, тэдгээрийн харилцан үйлчлэлийн /механизмыг эдийн засгийн улсын болон хувийн сектор, бүсийн хөгжлийн гадаад, дотоод хүчин зүйлс, арга хэрэгсэл/ тодорхойлох
- Хөгжлийн нийт үндэсний болон бүсийн хүрээ, эдийн засгийн удирдлагын төвийн болон бүсийн түвшний харьцааг тогтоох
- Хоцрогдсон бүс нутгийн эдийн засгийг өөд татах, шинэ бүс нутаг, нөөцийг эзэмших
- Үндэстэн, угсаатны асуудал /олон үндэстний улсын хувьд/
- Хүн ам зүй, хотжилт шилжих хөдөлгөөний асуудлууд орно

Эдгээр чиглэл бүрд хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ байх бөгөөд эдгээр нь төрийн бүсчилсэн хөгжлийн бодлогын агуулгыг тодорхойлно. Бүсийн идэвхтэй бодлого явуулдаг ихэнх орны хувьд бодлогын агуулга нь ерөнхийдөө дараах хүрээг хамаардаг байна.

- Харьцангуй сул хөгжилтэй бүс нутгийг дэмжих
- Аж үйлдвэр хэт бөөгнөрсөн хот суурингийн төвлөрлийг багасгах
- Нэгэнт бүрэлдэн тогтсон төвүүдээс гадна аж үйлдвэрийн шинэ цогцолборуудыг бий болгох асуудал хамаарна.

Хөгжингүй орнууд бүсийн бодлогыг нутаг дэвсгэрээ тэнцвэртэй хөгжүүлэх гол арга зам гэж үзэж, хөрөнгө хүч, бодлого, төлөвлөлтийн хувьд ихээхэн анхаарч, ач холбогдол өгч байдаг бол буурай хөгжилтэй орнуудын хувьд энэ нь хэдийгээр хамгийн тулгамдсан асуудлын нэг боловч цогцоор шийдвэрлэнэ гэхэд хөрөнгө мөнгө, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын чадавх байнга дутагдах нийтлэг бэрхшээл байдаг.

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд бүсийн бодлого дараах асуудлын хүрээг хамарч байна. Үүнд:

- Улс орны бүх мужийг үндэсний нэгдсэн зах зээл болгон хувиргах
- Хоцрогдсон хөдөө аж ахуйн мужийн эдийн засгийг дэмжих, бүсийн ялгааг багасгах
- Хот, хөдөөгийн шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулах
- Хөдөлмөрийн болон байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах
- Аж үйлдвэрийн шинэ төвүүдийг оновчтой байршуулах зэрэг болно.

1.2. Хүн амын төвлөрлийг сааруулах арга, зохицуулалт, хөгжингүй орнуудын туршлага

Улс орнуудын бүсийн төвлөрлийг сааруулах арга зохицуулалтыг тайлбарлах ойлголтын хүрээ ихэд өргөн учраас төлөвлөлтийн арга зүй, аргачлалын асуудлуудаас хүн амын төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжүүлсэн зарим орны туршлагаас авч үзье.

Төвлөрлийг сааруулах асуудлыг дэлхийн улс орнууд тодорхой түвшин, хэмжээнд байх ёстой зүйл гэж үздэг ч, харин түүнийг хэрхэн ямар хүрээнд, ямар арга зам сонгон хэрэгжүүлэх вэ гэдгийг өөр өөрсдөө аль үр дүнтэй гэсэн хувилбараар зохион байгуулдаг байна.

Бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт

Зах зээлийн тогтолцоотой улс орнуудад баримталж буй онол, арга зүйн хандлагын хүрээнд бүсчилсэн хөгжлийн бодлогын хамрах хүрээ, гол гол чиглэлүүдийг илрүүлэхдээ олон тооны шалгуур үзүүлэлтийг хэрэглэж иржээ. Үүнд:

- хүн амын амьжиргааны түвшин /нэг хүнд ноогдох бодит орлого, ажилгүйдлийн түвшин/ гэх мэт,
- дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ,

- аж үйлдвэрийн бүтэц,
- бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын байдал,
- хүн ам зүйн үзүүлэлтүүд,
- эдийн засгийн голлох үзүүлэлт,
- нийгмийн хөгжлийн ерөнхий түвшин,
- байгалийн нөхцөл, нөөц баялаг,
- газарзүйн байрлал.

Улс орнууд өөрийн онцлогийг харгалзан дээрх шалгуур үзүүлэлтүүдээс сонгон аль нэгийг буюу хэсэг бүлгийг авч ашигласан байдаг. *Тухайлбал*, Скандинавын орнууд байгалийн нөхцөл, нөөц баялаг, газарзүйн байрлалыг, Франц хотжилтын түвшнийг, Англи хүн амын нягтаршил, тухайн бүс нутгийн төвөөс алслагдсан байдлыг онцгойлон сонгон авч бүсийн хөгжлийн бодлогоо тодорхойлоход анхаарсан байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд

Бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүй, аргачлалын хувьд үндэсний хэмжээний нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегид бүс нутгийн хөгжлийн асуудал чухал байр суурь эзэлдэг, хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгө, хүч, хэрэглэлийг тодорхойлж, хуваарилсан, үйлдвэрлэх хүчнийг зохистой байршуулах үндсэн зарчмыг боловсруулж хэрэгжүүлсэн, бүс нутгийн хөгжлийн шууд болон шууд бус үр дүнгийн төсөөллийг гаргаж, хотжилт, шилжилт хөдөлгөөн ба хүрээлэн буй орчны өөрчлөлтийн нөлөөллийг тооцсон арга зүйд тулгуурлан дараах аргачлал ашигладаг байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах аргачлал ашигладаг. Үүнд:

- Санхүүгийн дэмжлэг;
- Бизнесийн орчныг сайжруулах;
- Төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох.

Санхүүгийн дэмжлэгт хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх, тээврийн хөнгөлөлт үзүүлэх, бүсийн нэмэгдэл олгох (*бүсийн, хилийн, хүйтний, алслалтын гэх мэт*), ажлын байр шинээр бий болгосны шагнал олгох зэрэг багтдаг.

Бизнесийн таатай орчныг дэмжих нь орчин үеийн бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл бөгөөд нийгмийн ба үйлдвэрлэл, үйлчилгээ, банк санхүүгийн тогтолцоо, дэд бүтэц, төрөл бүрийн бирж байгуулах, мэдээллийн сүлжээ зэргийг боловсронгуй болгон сайжруулахад чиглэгддэг байна.

Төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох нь улсын болон бүс нутгийн ашиг сонирхол, эдийн засаг, нийгмийн салбарын хүрээний бодлогыг уялдуулан зохицуулахад чухал үүрэгтэй юм. Бүсийн төлөвлөлтийн арга зүйн зарчмуудаас хамгийн чухал нь бүсийн асуудалд бүхэлд нь иж бүрэн хандах явдал гэж үздэг. Энэ чиглэлд хоёр үзэл санаа давамгайлж байна.

Нэг дэх нь⁴⁷, Бүсийн төлөвлөлт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн ихээхэн ялгаа үүсч төрийн оролцоо зайлшгүй болсон “хямралтай” бүс нутгуудыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулснаар хязгаарлагдана гэж үзэх үзэл юм. /АНУ, ОХУ-д илүү өргөн тархсан/ Энэ үзэл санаа нь санхүүгийн болон хүний нөөцийн хомсдолтой, үндэсний хэмжээнд бүсийн асуудлыг бүрэн шийдвэрлэх бололцоогүй ядуу буурай орнуудад хамгийн тохиромжтой бодлого гэж үзсэн байна.

⁴⁷“Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд”, УБ., 2004 он. Р.Ринчинбаатар.

Илүү олон орны дэмжлэгийг хүлээж буй **Хоёр дахь** чиглэл нь нутаг дэвсгэрийнхээ тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор бүс нутгийг хамарсан иж бүрэн хандлага /Франц, Итали зэрэг орон хэрэглэсэн/ юм. Иж бүрэн хандлага гэдэг нь тухайн улс орны эдийн засаг, улс төрийн байдал, үндэсний хөгжлийн түвшин, бусад тодорхой нөхцөлүүдээс хамаарч бүсийн төлөвлөлт нь ялгаатай байх нь ойлгомжтой юм.

Шилжих хөдөлгөөн тулгамдсан асуудал болж, энэ талаар бодлого хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагаас үзэхэд ерөнхийдөө дөрвөн чиглэлээр асуудалд хандсан байна.

1. *Шилжих хөдөлгөөнийг зогсоох.* Энэ хүрээнд зарим хотыг хаалттай болгох, зөвшөөрөлгүй иргэдийг хүчээр нүүлгэх, хаягийн бүртгэлээр дэглэм тогтоох, ажил эрхлэлтэнд хяналт тавих, орон сууцтай болох боломжийг хязгаарлах, хүнсний норм тогтоох зэрэг шилжих ирэгсдэд янз бүрийн хориг тавих арга хэмжээ багтдаг байна. Энэ бодлогын 1950-1970 онд хэрэгжүүлж байжээ. Энэ нь шилжих хөдөлгөөний зогсооход шууд нөлөөлдөг ч хүний эрхэд халдсанаараа байнгын эсэргүүцэлтэй тулгарч байсан байна.
2. *Шилжих хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх.* Энэ бодлого нь шилжих хөдөлгөөн зайлшгүй байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч, түүний эерэг үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөний урсгалыг шаардлагатай гэж үзсэн бүс нутаг руу чиглүүлэн шилжигсдэд ажил эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах болон бусад боломжийг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлдэг. Ийм бодлогыг Мексик, БНСУ, үр дүнтэй явуулсан боловч шилжих хөдөлгөөний урсгал хөгжлөөр давуу бүс нутгууд руу чиглэн, бусад хэсэгт суурьших нь мөн л бага байсаар байжээ.
3. *Шилжих хөдөлгөөний урьдчилан сэргийлэх.* Энэхүү бодлогын хүрээнд шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг голлох шалтгаан болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах замаар хүн амыг орон нутагт нь тогтоон барихад чиглэсэн арга хэмжээ авдаг. Харин ихээхэн хөрөнгө хүч шаарддаг, үр дүн нь урт хугацааны дараа мэдрэгддэг онцлогтой. Энэхүү аргыг Латин Америкийн зарим орон, тухайлбал, Перу улсад хэрэгжүүлж, энэ хүрээнд хөдөөгийн фермер, хоршоологчдыг дэмжин, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар ихээхэн үр дүнд хүрсэн хэдий ч технологийн шинэчлэл нь эргээд ажиллах хүчний илүүдэл бий болгож байжээ.
4. *Шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаварыг арилгах.* Энэ бодлого нь шилжих хөдөлгөөний үр дагаварыг шилжин явагчдын уугуул болон шилжин явсан нутаг дэвсгэрт нь багасгахад чиглэгддэг ба шилжин ирэгчид тухайн хотын хөгжилд зохих хувь нэмэр оруулж, хөдөөд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн үүрэгтэй гэж үзэж, дэмжих арга хэмжээг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, Малайзын Каула Лумпур хотод гудамжны жижиг худалдаачдыг сургалтанд хамруулж, тоног төхөөрөмж, ажлын байраар хангах зэргээр тэднийг ядууралд орохоос сэргийлэх арга хэмжээг авсан нь багагүй амжилтанд хүрчээ. Түүнчлэн хөгжиж буй зарим орон ядуусын хороолол болон зөвшөөрөлгүй оршин суугчдын асуудлыг хуульчилсан нь тэдний аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалсан хүнлэг үр дүнтэй арга хэмжээ авсан байна.

Хүн амын шилжих хөдөлгөөн өнөө үед ялангуяа хөгжиж буй орнуудад ихээхэн түгээмэл байгаа бөгөөд өндөг хөгжилтэй Япон улс гэхэд шилжих хөдөлгөөнийг сааруулж, хөдөө амьдарч байгаа иргэдийг тэнд нь тогтвортой суурьшуулахын тулд эдийн засаг, нийгэм, соёлын төрөл бүрийн арга хэмжээ авч үүнд асар их хөрөнгө оруулдаг ажээ.

ХОЁР. Бүсчилсэн хөгжүүлэх бодлого үр дүнтэй хэрэгжүүлсэн гадаадын зарим орнуудын туршлага

Дэлхийн улс орнууд бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ улс орноо бүхэлд нь хамарсан, эсвэл тодорхой бүс нутгийг онцгойлон анхаарсан гэсэн хоёр үндсэн чиглэлийг баримталж иржээ.

Эхний чиглэлийг Англи, Франц, Япон, Швед зэрэг оронд голлон баримталж байсан бол дараах чиглэлийг АНУ, Канад, ХБНГУ, Голланд, Бельги, Норвеги, Дани зэрэг оронд анхлан хэрэгжүүлсэн байна.

Бүс нутгийн хөгжлийн бодлогоо боловсруулахдаа бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьжиргааны үзүүлэлт, төв (нийслэл)-өөс алслагдсан байдал, тухайн бүс нутгийн байгаль цаг уур, хөгжлийн судалгааг үндэслэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.

2.1. Англи улс

Англи улс нь улс орноо бүхэлд нь бүсчлэн хөгжүүлсэн орнуудын нэг бөгөөд Европын орнуудаас хамгийн түрүүнд 1920 оноос эхлэн төр засгийн түвшинд эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн асуудлыг авч үзсэн байдаг. [Mc Crone. (1969)].

XX зууны эхэн үед Европод аж үйлдвэрийн хувьсгал эхэлж нүүрсний болон төмрийн хүдрийн ордуудыг тойрсон аж үйлдвэрийн төвлөрөл бий болж эхэлсэн бөгөөд Английн Шотланд, Уэльс, Умард бүс, Өмнөд Мидленд, Германы Рур, Бельгийн Валани, Францын Умард бүс болон Лотаринг зэрэг бүс нутагт энэ төвлөрөл эрчимтэй явагдаж, нүүрс олборлолт, хар металлург, хөлөг онгоц, хүнд машин болон нэхмэлийн аж үйлдвэр түлхүү хөгжих болсон байна.

Автомашин, нисэх онгоц, цахилгаан техник, радиоэлектроник, хэвлэлийн болон химийн үйлдвэрлэл зэрэг аж үйлдвэрийн шинэ шинэ салбарууд Европын эдийн засаг-газарзүйн тохиромжтой байршил бүхий бүсүүдэд бий болсноор урьд нь хөгжилтэйд тооцогдож байсан зарим бүс нутгийн хөгжил хоцрогдох болж, Английн дээр дурдсан Шотланд, Уэльс, Умард бүсүүдэд ажилгүйдэл ихэсч, хүн амын амьдралын түвшин доройтсоноос бусад бүс нутгууд руу чиглэсэн “Их нүүдэл” эхэлжээ.

Энэ үед /1928 онд/ Англи улсын Засгийн газраас сул хөгжилтэй бүс нутгуудын ажилгүйчүүдэд шинээр мэргэшил олгох, туслах ажлыг зохион байгуулж эхэлсэн нь бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр авсан анхны томоохон арга хэмжээ болсон. 1929-1932 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараа бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төрийн бодлого улам эрчимжиж Шотланд, Өмнөд Уэльс болон Умард бүсийн баруун, зүүн хэсгийн хөгжлийг дэмжих талаар **1934 онд тусгай хууль** гаргажээ. Энэ хууль нь бүхэлдээ дээрх 4 бүсэд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж ажлын байр олноор бий болгоход чиглэсэн юм.

1967 онд “Хөгжлийн онцгой бүсүүд”-ийг тогтоож тэдгээрт төр, засгийн зүгээс үзүүлэх тусламжийг үлэмж нэмэгдүүлж 1969-1979 оны хооронд зөвхөн аж үйлдвэрийн салбарыг дэмжих зорилгоор гэхэд 5 тэрбум фунт стерлинг зарцуулсан байна. 1970-аад оноос Англи улс Европын холбоонд элсэн орсноор бүс нутгийн хөгжлийн асуудлууд олон улсын шинж чанартай болж Европын холбооны бүс нутгийн хөгжлийн сан 1975 оноос эхлэн Английн сул хөгжилтэй бүс нутгуудад тусалж эхэлжээ. Европын холбооны энэхүү тусламж нь Английн төр, засгаас энэ талаар явуулж байсан бодлоготой нягт уялдан зохицсон байсан нь чамлалтгүй үр дүнд хүрэхэд нөлөөлсөн байна.

Энэ үед Англи улсын Засгийн газраас дараах тодорхой арга хэмжээ, үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- **Татварын хөнгөлөлт, урамшуулал олгох**- Сул хөгжилтэй бүс нутгуудад аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд онцгой анхаарч компани, аж ахуйн нэгж хөгжлийн онцгой бүсэд өөрийн салбараа нээсэн тохиолдолд барилга байгууламж, тоног төхөөрөмжийнхөө үнийн 22 хүртэлх хувийг хөнгөлөх ба ажлын байр шинээр бий болгосны шагнал олгодог.
- **Ажлын байр бий болгох**- Өндөр мэргэшилтэй ажиллах хүчийг бусад бүс нутгаас шилжүүлснээс гарах зардлыг улсаас төлөх, улсын захиалгыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох.
- **Түрээсийн хөнгөлөлт үзүүлэх**- Сул хөгжилтэй бүс нутагт үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий байрыг хөнгөлөлттэй түрээслэх боломж олгох
- **Мэдээллээр хангах**- Үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллээр тогтмол хангаж, орон нутгийн засаг захиргааны зүгээс тусламж дэмжлэг тогтмол үзүүлэх.

Эдгээр арга хэмжээ нь хувийн секторт түлхүү хэрэгжиж байсан байна.

Үүний зэрэгцээ Англи улсын төр, засгийн зүгээс сул хөгжилтэй бүс нутгуудад **хүн амын нийгмийн асуудлуудыг** шийдвэрлэх чиглэлээр ихээхэн анхаардаг байсан байна. Тухайлбал, **хэт төвлөрлийг сааруулах бодлогыг бүс нутгуудыг хөгжүүлэх** зорилготой нягт уялдуулан явуулж байсан байна. Үүнд:

- Төр захиргааны томоохон байгууллагуудыг шилжүүлэн байршуулах
- Нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийг тэтгэх голомт болж чадах хотуудыг бий болгох зорилгоор Шотланд, Баруун умард бүсэд тус бүр 4, Умард бүсэд 3, Уэльсэд 2-ыг хотуудыг байгуулах
- Мөн тухайн бүс нутгуудад гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах зэрэг болно.

Англи улсад бүс нутгийн хөгжлийн талаар явуулж байгаа бодлого нь ямар нам төр засгийн эрхэнд байгаагаас хамаарч зарим үед энэ бодлого эрчимжиж, зарим үед саарах хандлагатай байсан байна.

Засгийн газрын түвшинд бүс нутгийн хөгжлийн бодлогыг **Аж үйлдвэрийн болон Байгаль орчны яам** голлон хариуцдаг. Энэ яам нь тухайн бүс нутгийн хөгжлийг дэмжих бүсүүдийн хил хязгаарыг илрүүлэн баталж, аж үйлдвэрийн чиглэлээр сертификат олгож, улсын зээл тусламжийн хэмжээг тогтоож өгдөг. Түүнчлэн тухайн бүс нутгуудад тус яамны салбар байгууллагууд идэвхтэй ажилладаг байна. [Сдасюк.Г.В, Шевченко. Л.М., (1974)].

2.2.ХБНГУ

Герман улс нь 1960 оноос улс орноо бүсчлэн хөгжүүлэх бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Тус улсад бүсчлэн хөгжүүлэх асуудлыг “ХБНГУ-ын Үндсэн хууль”, “Орон зайн бүсчлэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна. Анх 1969 онд батлагдсан “Орон зайн бүсчлэлийн тухай хуулинд орон зайн бүсчлэлийн талаарх үзэл, баримтлал, зорилт”-ыг хэрэгжүүлэх зарчмуудыг тодорхойлж, төр захиргааны бүх шатны /улс, муж, орон нутгийн/ байгууллагад мөрдүүлэх дүрэм журмыг оролцогч бүх талтай зөвшилцөн гаргадаг.

ХБНГУ-ын туршлагаар эдийн засгийн бүсийн хөгжлийн нөөц боломжийг судлахдаа **төлөвлөлтийн асуудлыг эн тэргүүнд тавьдаг бөгөөд бүсийн хэсэг нэг бүрийн бүтцийг харгалзан, тэнд амьдарч буй хүмүүсийг татан оролцуулдаг байна.**

Төлөвлөлтийн зорилго нь тухайн тавьсан зорилго биелэх хүртэл хэрэгжүүлэх арга ажиллагааг үе шат нэг бүрээр нь тодорхойлоход оршино. Өөрөөр хэлбэл, тодорхой шийдвэр гаргах, арга хэмжээ авах үндэс нь төлөвлөлт болдог. Төлөвлөлтийн гол бүрэлдэхүүн хэсэг нь:

- **Орон зайн бүсчлэлийн төлөвлөлт** - */Бүс нутгийн бүтцийн давуу, сул талуудыг илтгэн харуулсан эдийн засгийн мэдээ баримтаар чиг баримжаа авч, сул бүтэцтэй бүс нутаг салбарыг илрүүлэх/*
- **Салбарын төлөвлөлт** - */орон зайн төлөвлөлт нь өргөн хүрээтэй, ерөнхий байдаг учраас түүнийг салбар, ажил үүргийн тодорхой чиглэлээр нарийвчилж өгөх шаардлагатай. Энэ зорилгоор улс, муж улс, хот тосгоноос салбарын төлөвлөгөөг гарган ажилладаг/*
- **Санхүүгийн төлөвлөлт** - */Орон зайн бүсчлэлийн болон санхүүгийн салбарын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн төлөвлөлтийг хийхдээ урсгал зардал, орлогыг тусгасан захиргааны төсөв буюу төлөвлөгөөт төсөв, хөрөнгө оруулалтын зардлыг тооцсон хөрөнгийн төсөв буюу төлөвлөгөөт бүс төсвүүдийг тусгасан байх/ зэрэг болно.*

Нөхцөл байдлыг судалж тодорхой зорилгоор боловсруулсан орон зайн бүсчлэлийн төлөвлөлт, салбар, санхүүгийн төлөвлөгөө нь эдийн засгийн бүсийг хөгжүүлэх тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх нэг үндэс болдог байна. Энэхүү төлөвлөлт төлөвлөгөө үндэслэн ХБНГУ нь дараах хөгжлийн онол, бодлогыг боловсруулжээ. Үүнд:

Хөдөөнөөс хүн ам нягт шигүү суурьшсан хот суурин газар уруу чиглэсэн хүн амын хөдөлгөөнийг сааруулах арга хэмжээ авах жижиг дунд хэмжээний суурин газрын дэд бүтцийг хэвээр нь хадгалж, өргөтгөн хөгжүүлэх хүн ам тархуу суурьшсан газарт ч иргэдэд соёл, ахуйн үйлчилгээ, улсын болон хувийн секторын ажил үйлчилгээг ойртуулан эрэлт хэрэгцээг нь хангахад чиглэнэ.

ХБНГУ-д Муж улсууд нь сумдад харьяалагддаггүй бие даасан хотууд болон сумдад хуваагдах ба сум нь олон хот, тосгоныг өөртөө нэгтгэдэг бөгөөд нутгийн өөртөө захирах ёс үйлчилдэг зарчмын дагуу орон нутгийн бүх асуудлыг хуулийн хүрээнд өөрсдөө хариуцдаг эрх эдэлж, үүрэг хүлээдэг байна. Энэ ч үүднээс эдийн засгийн бүсийн хөгжлийн асуудлыг Парламент, Засгийн газар, шууд захиргааных нь байгууллагууд, тэдгээрийн доод шатны төрийн захиргааны харьяа газрууд, нутгийн захиргааны байгууллагууд хариуцан ажилладаг. Мөн хувийн хэвшлийнхэн болон иргэд, хуулийн этгээдүүдийг татан оролцуулдаг байна.

2.3.ОХУ

Оросын умард хязгаар түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад */ажилчин, албан хаагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчид, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуульд суралцагсад/* тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан тэдгээрийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийг тодорхой коэффициентээр /районный коэффициент/ нэмэгдүүлэн олгодог.

Бүсийн нэмэгдлийн коэффициентийн хэмжээ нь тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, алслагдсан зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, хамгийн алслагдсан Хойд мөсөн далайн арлууд, Саха /Якут/, Чукотка, Курилийн арлууд, Камчатка, Сахалин мужийн тодорхой нутагт оршин суугчдын бүсийн нэмэгдлийн коэффициент 2.0 байхад Красноярск, Мурманск, Хабаровск, Тюмень, Томск, Эрхүү муж, Алс Дорнодод 1.80-1.40 байдаг байна.

Мөн говь, цөлийн бүсэд болон далайн түвшнээс 1500 метрээс дээш оршдог газар нутгийн оршин суугчдад 1.40 хүртэл коэффициентийн нэмэгдэл олгодог.

Бүсийн нэмэгдлийн коэффициентийн хэмжээ, хэрэглэх журмыг ОХУ-ын холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Тухайлбал, ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу умард хязгаар, түүнтэй адилтгах бүс нутагт ажиллагсад тухайн бүс нутагт тасралтгүй ажилласан хугацааг харгалзан тодорхой хувийн цалингийн нэмэгдэл олгодог ажээ. */Трудовой кодекс РФ от 30.12.2001 статья 317/*

Мөн дээрх бүс нутагт нэг жилээс дээш амьдарч буй 30 хүртэлх насны залуучуудад ажилд орсон эхний 6 сараас эхлэн хагас жил тутамд 20 хувь улмаар 60 хүртэл хувийн нэмэгдлийг цаашид олгодог байна. */Постановление Совета Министров РСФСР от 22.10.1990 №458/* Энэхүү нэмэгдэл дээр бүсийн нэмэгдлийн коэффициентийг давхар хэрэглэдэг байна.

Үүнээс гадна дээрх бүс нутгуудад оршин суугчдад нэмэлт амралтын өдөр /цалингүй/, ажлын богиносгосон долоо хоног, ээлжийн амралтын нэмэлт хоног, эмчилгээний замын зардал, шилжин суурьших зардал олгох зэрэг хөнгөлөлт үзүүлэхээр заажээ. */Трудовой кодекс РФ от 30.12.2001 статья 319-323, 325-327/*

Төсвийн байгууллагад ажиллагсдын бүс нутгийн нэмэгдлийг холбооны болон мужийн төсөв, орон нутгийн засаг захиргааны төсвөөс гаргах бөгөөд төсвийн бус салбарт ажиллагсдын нэмэгдлийг тухайн ажил олгогч нар хариуцдаг. */Закон РФ "О государственных гарантиях и компенсациях для лиц работающих и проживающих в районах Крайнего Севера и приравненных к ним местностях" от 02.06.1993 №5082, статья 3/*

ОХУ-ын умард хязгаар, түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад бүсийн коэффициент, умардын нэмэгдлийг олгодог шалтгаан, үндэслэлийг Оросын эрдэмтэн судлаачид "нийгэм-эдийн засгийн" /социально-экономический/, "биологийн" /медико-биологический/ гэж хоёр ангилж үздэг байна. Энгийнээр хэлбэл алслагдсан болон умардын хязгаар нутагт амьдрахад "өртөг өндөр, эрүүл мэндэд хохиролтой" гэж үздэг.

1) Нийгэм-эдийн засгийн үндэслэл

а/ төвөөс алслагдсан, дэд бүтэц сул хөгжсөн тул бүтээгдэхүүний өртөг, тээвэрлэлтийн зардал харьцангуй их байдгаас бараа үйлчилгээний үнэ хөлс өндөр;

б/ хоол хүнс, хувцаслалт, халаалт, түлш, цахилгаанд илүү их зардал гаргадаг

в/ ажиллах хүч ялангуяа мэргэжлийн ажилчид, боловсон хүчнээр тасралтгүй хангаж тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай;

г/ бусад бүс нутгийнхантай харьцуулахад ахуй, соёлын түвшин доогуур;

д/ үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх боломж хязгаарлагдмал, үр ашиг бага;

2) Эмнэлэг-биологийн үндэслэл

ОХУ-ын умард хязгаар түүнтэй адилтгаж болох газар нутгийн байгаль цаг уурын хахир хүйтэн, хатуу ширүүн нөхцөл нь хүний эрүүл мэнд, бие организмд сөрөг нөлөө үзүүлдэг талаар эрдэмтэд судалж, бүс нутгийн жилийн дундаж температур, хамгийн хүйтэн, хамгийн халуун сар, улирлууд, агаарын чийгшилт, салхины хүч, агаарын даралт, хүнд хор учруулагч хорхой шавжийн тархалт зэргийг тодорхойлжээ.

Ер нь агаарын температур -7°C-аас бага байх үед салхины хүчний нөлөөгөөр температурын заалт улам доошилдог. Тодруулбал, салхины хурд нэг метрээр нэмэгдэхэд агаарын температур 2°C-аар хүйтэрдэг байна. ОХУ-д хүйтний улиралд гадаа ил орчинд

ажиллахыг хүнд, хортой нөхцөлд тооцож шатлал тогтоосон байдаг. Жич: /10*С-аас -15*С хүртэл-1-р зэрэглэлийн, -15*С-аас-20*С бол 2-р зэрэглэлийн, -20*-аас дээш бол 3-р зэрэглэлийн хүнд, хортой нөхцөлд тооцогддог байна/

Ийнхүү байгаль цаг уурын онцгой болон алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд төрөөс дэмжлэг үзүүлэх нь тэднийг тухайн бүс нутагт амьдрах боломж бололцоогоор хангах төдийгүй хүн амын шилжилт хөдөлгөөн, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг зохицуулахад чухал түлхэц болж байна.

2.4. Канад

Канад улс алслагдсан бүс нутгийн оршин суугчид, ажил олгогч нартаа тухайн газар нутгийн алслалт, байгаль цаг уурын байдал зэрэг нөхцөлүүдийг харгалзан тэдгээрийн цалин, орлогод ногдох орлогын албан татвараас тодорхой шалгуурыг үндэслэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт хэлбэрээр бүс нутгийн иргэдээ дэмждэг байна.

Ийм хөнгөлөлтийг 1987 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд дараах 2 үндэслэлээр олгодог. Үүнд:

- Цаг агаарын хүнд, бараа үйлчилгээний хязгаарлагдмал нөхцөл
- Гол зах зээлээс алслагдсан тул амьдралын өртөг өндөр

Энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг “Хүн амын орлогын албан татварын хууль”-аар зохицуулдаг. Тус хуулиар хоёр төрлийн, гурван хэлбэрийн хөнгөлөлт, хасалт хийдэг байна.

- **Хүн амын орлогоос:**
 - а) Өдрийн 15\$-аар бодож жилд 5475\$-ыг орлогын албан татварын нийлбэрээс хасч тооцох,
- **Ажил олгогчоос:**
 - б) Ажилтны амралтаараа нутагтаа очих зардлыг жилд 2 удаа ажил олгогч санхүүжүүлсэн бол,
 - в) Тогтоосон ямар нэг хязгааргүйгээр эмнэлгийн үйлчилгээ авах зардлыг санхүүжүүлсэн бол тус тус хасалт хийнэ.

Татварын хөнгөлөлтийн хэмжээг бүс нутгийн алслалт, байгаль цаг уурын онцлог, бараа бүтээгдэхүүний өртөг зэрэг хүчин зүйлсээс улбаатай зардлуудын дарамтыг сулруулах үүднээс ялгавартай тогтоохдоо А буюу Умардын, Б буюу Завсрын бүсүүдэд хуваадаг байна. Чөлөөлөлтөд хамрагдах оршин суугчид тухайн бүс нутагт буюу А, Б бүсүүдэд хамгийн багадаа 6-аас доошгүй сар амьдарсан байх шалгуур үзүүлэлтийг ч тавьдаг.

Эдгээр бүсийг газарзүйн хувьд уртраг өргөргөөр нь маш нарийн тогтоосон байдаг.

А буюу Умардын бүсэд:

- Yukon
- Nunavut
- Quebec
- British Columbia
- Manitoba
- Ontario-ын хойд хэсгүүд, Мөн зүүн хойд бүсийн /“Labrador and Northwest territories”/ нийт нутгуудад оршин суугчид нь хөнгөлөлт буюу хасалтын (deduction) 100 хувийг эдлэх,

Б буюу Завсрын бүсэд доорх нутгуудын өмнөд хэсгүүд:

- British Columbia
- Alberta
- Saskatchewan
- Manitoba
- Ontario
- Quebec мөн Queen Charlotte, Anticosti Island, Sable Island” арлуудын нутгийн нийт оршин суугчид хөнгөлөлт буюу хасалтын (deduction) 50 хувийг тус тус эдэлдэг байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ном:

- “Бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд”, УБ., 2004 он, Р.Ринчинбазар
- “Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд”, УБ., 2004 он. Р.Ринчинбазар
- “Монгол орныг бүсчлэн хөгжүүлэхэд төрийн бус байгууллагын үүрэг роль, түүний ач тус, ашиглах зарим арга замын тухай”, УБ., 2004 он. Д.Тэрбиш
- “Монгол Улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудал” Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, УБ., 2001 он,
- “Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн туршлагаас” Илтгэл, доктор Л.Цэдэндамба

Цахим мэдээлэл:

- “Большая Российская Энциклопедия” www.slovari.yandex.ru
- <http://microeco.blog.gogo.mn/read/entry41563> - Эдийн засгаа бүсчлэн хөгжүүлсэн Англи улсын туршлага.
- <http://ubregion.ub.gov.mn/index.php?Option=com> - Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн өнөөгийн байдал,Цаашдын зорилт” сэдэвт үндэсний зөвлөлгөөний тэмдэглэл
- <http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html/> - Хуулиуд

**МОНГОЛ УЛСАД БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОЖ ИРСЭН БАЙДАЛ,
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОДОГ ТУРШЛАГА**
(Мэдээлэл лавлагаа)

Д.Живгаагүнсэл

АГУУЛГА

Удиртгал

Монгол улсын бүсийн нэмэгдэл олгож ирсэн байдал, гадаадын зарим орны бүсийн нэмэгдэл олгодог туршлага

1. Бүсийн нэмэгдэл олгох онолын үндэслэл
 - 1.1. Бүсийн нэмэгдэл олгох үндэслэл
 - 1.2. Бүсийн нэмэгдэл олгох хэлбэрүүд
2. Монгол улсад бүсийн нэмэгдэл олгож байсан туршлага, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын талаарх мэдээлэл
 - 2.1. Говийн нэмэгдэл
 - 2.2. Хилийн нэмэгдэл
3. Гадаад орнуудад бүсийн нэмэгдэл олгож буй туршлага
 - 3.1. Оросын Холбооны Улс
 - 3.2. Канад⁴⁸

Ашигласан материалын жагсаалт

УДИРТГАЛ

Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож ирсэн байдал, олгох болсон шаардлага, үр дүн, бүсийн нэмэгдлийг олгох шийдвэрийг цуцалсан шалтгаан, үр дагавар, мөн гадаад улс орнуудад бүсийн нэмэгдэл олгодог туршлагыг судлахад оршино.

Судалгааны үр дүн

Судалгааны сэдвийн хүрээнд бүсийн нэмэгдэл олгох шаардлагатай бүс нутгийг тогтоох онолын үндэслэл, шалгуур үзүүлэлт, Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож байсан туршлага, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын талаарх мэдээлэл, гадаадын зарим оронд бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсийн нэмэгдэл олгодог туршлага зэрэг асуудлуудыг тусгасан болно.

Макро эдийн засгийн болоод нийгмийн үзүүлэлтээр хангалтгүй байгаа, төвөөс алслагдсан, дэд бүтэц, үйлдвэрлэл сул хөгжсөн бүс нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор бүсийн нэмэгдэл олгодог бөгөөд энэ нь онолын үүднээс авч үзвэл эдийн засгийн судалгааны аргаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх бүсүүдийг оновчтой илрүүлэх шаардлагыг агуулдгаараа бүсчилсэн хөгжлийг хангах талаар төрөөс явуулж байгаа бодлогын томоохон хэсэг юм.

⁴⁸“Хүн амын орлогын албан татварын хууль” - <http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html/>

Бүсийн нэмэгдлийг тогтоохдоо хөгжлийн түвшин, газар нутгийн тогтоц, дэд бүтцийн хөгжлийн онцлог, байгаль цаг уурын онцлог, хүний эрүүл мэнд сэтгэл зүйд таагүй нөлөөлөх хүчин зүйлийн үндэслэл зэргийг харгалзан үздэг байна.

Бүсийн аливаа нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь бүсчилсэн хөгжлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэлд хамаарах бөгөөд Монгол Улсын хувьд Говийн болон Хилийн нэмэгдлийг дараах зорилгоор олгож ирсэн. Үүнд:

- Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа **төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох** замаар тогтвор суурьшилтай ажиллуулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх (1-р хүснэгт),
- Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор хилийн заставуудыг байгаль цаг уурын нөхцөлөөр нь ангилан тогтоож, тэдгээрт алба хааж байгаа офицер, албан хаагчдад хилийн нэмэгдэл олгох (2-р хүснэгт),

Эдгээр нэмэгдлүүдийг 1970 оноос олгож эхэлсэн бөгөөд 1990 оноос хойш ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн СнЗ, Засгийн газрын зарим тогтоол, захирамжийг хүчингүй болгоход Говийн нэмэгдлийг олгосон тогтоолыг мөн хүчингүй болгожээ.

Хөгжиж байгаа улс орнууд бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьжиргааны үзүүлэлт, төв (нийслэл)-өөс алслагдсан байдал, тухайн бүс нутгийн байгаль цаг уур, хөгжлийн судалгааг үндэслэн бүс нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих “Санхүүгийн дэмжлэг” үзүүлэх зорилгоор бүсийн нэмэгдэл олгодог байна. Тухайлбал, Оросын умард хязгаар түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад /ажилчин, албан хаагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчид, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуульд суралцагсад /тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан тэдгээрийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийг тодорхой коэффициентээр /районный коэффициент/ нэмэгдүүлэн олгодог туршлага байна.

МОНГОЛ УЛСЫН БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОЖ ИРСЭН БАЙДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОДОГ ТУРШЛАГА

Макро эдийн засгийн болоод нийгмийн үзүүлэлтээр хангалтгүй байгаа, төвөөс алслагдсан, дэд бүтэц, үйлдвэрлэл сул хөгжсөн бүс нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор бүсийн нэмэгдэл олгодог бөгөөд энэ нь онолын үүднээс авч үзвэл эдийн засгийн судалгааны аргаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх бүсүүдийг оновчтой илрүүлэх шаардлагыг агуулдгаараа бүсчилсэн хөгжлийг хангах талаар төрөөс явуулж байгаа бодлогын томоохон хэсэг юм.

НЭГ. Бүсийн нэмэгдэл олгох онолын үндэслэл

1.1. Бүсийн нэмэгдэл олгох үндэслэл

Бүсийн төлөв байдлыг тодорхойлж буй судалгааны үзүүлэлтийн чиглэл, ангилал, бусад орны туршлага, зарим судлаачдын бүтээлүүдэд бүсийн нэмэгдэл олгох үндэслэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. *Хөгжлийн өнөөгийн түвшинг харгалзах үндэслэл.*
 - Макро эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг харьцуулсан хөгжлийн түвшин
2. *Газар нутгийн тогтоц, дэд бүтцийн хөгжлийн онцлогийн үндэслэл.*
 - Газар нутгийн тогтоц, алслагдсан байдал
 - Нутаг дэвсгэрийн хэмжээ, ашигт малтмалын нөөц

- Дэд бүтцийн хөгжлийн үзүүлэлт (Шатахуун, тээвэр, эрчим хүч, ус дулааны үнэ тариф)
- 3. *Байгаль цаг уурын онцлог, хүний эрүүл мэнд сэтгэл зүйд таагүй нөлөөлөх хүчин зүйлийн үндэслэл.*
 - а) Байгаль цаг уурын онцлогийг харгалзан:
 - Уур амьсгалын эрс тэс, хатуу ширүүн байдал /Бодманы индексээр/
 - Говийн
 - Цөлийн
 - Өндөр уулын
 - Тагийн
 - Халууны
 - Хүйтний
 - Далайн
 - б) Бүс нутгийн онцлогийг харгалзан:
 - Экологийн гамшгийн (цөлжилт, бэлчээр талхлалт)
 - Цаг агаарын хүнд нөхцөлийн (цас, бороо, салхи)
 - Цацраг идэвхжилийн нөлөөлөл зэргийг үндэслэл болгон тогтоодог байна.

1.2. Бүсийн нэмэгдэл олгох хэлбэрүүд

Бүсийн нэмэгдэл олгохдоо 1.1-д тодорхойлсон үндэслэлийн алинд нь хамаарахыг тодорхойлох нь нэмэгдлийг зохистой олгох боломжийг бүрдүүлдэг.

1. *Хөгжлийн ерөнхий түвшинг харгалзан олгох нэмэгдлийн төрлүүд:*
 - а) Тухайн бүс нутагт ажиллаж амьдрагсдад бүсийн ерөнхий нэмэгдлийг цалин, тэтгэвэр, тэтгэмж, орлогын /ажилгүйчүүдэд цалингийн баталгаажих түвшний/ тодорхой хувиар олгох,
 - б) Тухайн бүсэд байгуулсан үйлдвэр, үйлчилгээний газруудад гааль, НӨАТ, орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх,
 - в) Бүс нутагт ажиллагсдад хөнгөлөлттэй урт хугацааны зээл олгох нөхцөл бүрдүүлэх, зээлийн баталгааг төрөөс даах,
 - г) Албан хаагчдын ажлын цагийг багасгасан 7 хоног бий болгох,
 - д) Ээлжийн амралт дээр нь нэмэгдэл хоног олгох,
 - е) Тухайн бүс нутагт шилжин суурьших зардал олгох,
2. *Газар нутгийн тогтоц, дэд бүтцийн хөгжлийн онцлогийн үндэслэлээр олгох бүсийн нэмэгдлийн төрлүүд:*
 - а) Алслалтын нэмэгдлийг тухайн бүс нутагт оршин суугчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, ашиг орлогын /ажилгүйчүүдэд цалингийн баталгаажих түвшний/ тодорхой хувиар тооцож олгох,
 - б) Газар нутгийн тогтоцыг харгалзан:
 - Говийн
 - Цөлийн
 - Өндөр уулын
 - Тагийн
 - Далайн гэх төрлийн нэмэгдлийг тус бүсэд оршин суугчдын цалин, тэтгэвэр тэтгэмж, ашиг орлогын, /ажилгүйчүүдэд цалингийн баталгаажих түвшин/-ий тодорхой хувиар тооцож олгох,
 - в) Мөн 1.2.1-ийн б, в, г, д, е-д заасан нэмэгдлийн тодорхой төрлийг 1.2.2-ын а.б-д заасан нэмэгдэл дээр давхардуулан олгож болдог байна.
3. *Байгаль цаг уурын онцлог, хүний эрүүл мэнд сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн үндэслэлээр олгох бүсийн нэмэгдлийн төрлүүд:*

- а) Байгаль цаг уурын хахир хүйтэн, хэт халуун, хуурай эсвэл хэт чийглэг зэрэг нөхцөл нь хүний эрүүл мэнд, бие организм, сэтгэл санаанд сөрөг нөлөө үзүүлдэг талаар судалгааны олон баримт мэдээлэл байна. Цаг уурын онцлог, шинж чанарыг Г.Бодманы индекс (S)-ээр тодорхойлдог бөгөөд $S=(10.04T)^*(1+0.272V)$ томъёогоор тооцоолдог.

Энд Т-Агаарын температур, V-Хүйтэн сэрүүн улирлын салхины хурд, $S<1$ бол ширүүн бус буюу зөөлөн, $S=1-2$ бол ширүүвтэр, $S=2-3$ бол ширүүн, $S=3-4$ бол хатуувтар, $S=4-5$ бол хатуу ширүүн, $S=5-6$ бол хахир хатуу цаг ууртай гэж үздэг байна.

Энэхүү цаг уурын таагүй нөхцөл нь хүний эрүүл мэнд, бие организм, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдгийг шинжлэх ухаан нэгэнтээ нотолсон тул тийм бүс нутагт оршин суугаа ард иргэдэд Г.Бодманы индексийг үндэслэн ширүүн цаг ууртайгаас дээш нөхцөлтэй нутгийн оршин суугчдад цалин тэтгэвэр, тэтгэмж, орлогын (ажилгүйчүүдэд цалингийн баталгаажих түвшний) тодорхой хувиар тооцож цаг уурын онцлогийг тусгасан бүсийн нэмэгдэл олгодог.

- б) Мөн тухайн бүс нутгийн оршин суугчдад, цаг уурын хүнд нөхцөлийн нэмэгдлээс гадна бүс нутгийн байгаль орчны бусад нөлөөлөл (цацраг идэвхжил)-ийн нэмэгдлийг давхардуулан олгох үндэстэй байдаг.

**ХОЁР. Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож байсан
туршлага, холбогдох хууль тогтоомж, бусад эрх
зүйн актуудын талаарх мэдээлэл**

2.1. Говийн нэмэгдэл

Говь, түүнтэй ойролцоо байгаль цаг уурын нөхцөлд оршин суугчдын материаллаг аж байдлыг дээшлүүлэх, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай амьдрах сонирхлыг төрүүлэх үүднээс говийн нэмэгдэл (1-р хүснэгт) олгож байжээ.

Хүснэгт 1. Говийн нэмэгдэл

Д/д	Актын төрөл, огноо	Эрх зүйн актын нэр	Холбогдох зүйл, заалт	Цуцалсан шийдвэр	Тайлбар
1	НТХ,СнЗ-ийн тогтоол 1971.06.03 №132/169	Ерөнхий боловсролын сургуулиас үйлдвэрлэлд шилжин ажиллагчдын талаар авах арга хэмжээний тухай	в/ Говийн бүсийн мал аж ахуйн үйлдвэрлэлд хүүхдийнхээ хамт зохион байгуулалтай шилжин суурьшигчдад хөдөлмөрийн хөлсийг нийтийн журмаар олгохын хамт эхний 3 жил дараалан 10 хувийн нэмэгдлийг жил бүрийн эцэст олгож байна.	Засгийн газрын 1990 оны 1-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.	
2	НТХ,СнЗ-ийн тогтоол 1972.04.21 №148	Халх голд байгуулах сангийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай	4.а/ Халх голд байгуулах сангийн аж ахуй, түүнийг түшиглэсэн байгууллагын ажилчин, албан хаагчид, малчдад 1976 оныг дуустал үндсэн цалин дээр нь 10 хувийн нэмэгдэл олгож байсугай.	СнЗ-ийн 1989 оны 108-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.	

3	СнЗ-ийн тогтоол 1979.01.31 №04	Халх голд сангийн аж ахуйг бэхжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	11.Халх голын районыг эзэмших улс төр, эдийн засгийн онцгой ач холбогдол болон улсын хилд ойрхон байдгийг харгалзан энэ районд ажиллаж байгаа сумын төвийн нам, улс, олон нийт, хоршооллын байгууллага, үйлдвэр, аж ахуйн газар, сангийн аж ахуйн ажилчин, албан хаагчдад 20 хувь , тасаг, ферм, бригадын төвд ажиллагсдад 25 хувь , малчдад 30 хувийн нэмэгдлийг 1979.07.01-нээс эхлэн албан тушаалын буюу тарифт цалингаас олгож байх журам тогтосугай.	Засгийн газрын 1990 оны 1-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.	
4	СнЗ-ийн тогтоол 1982.12.29 №48	Говийн нэмэгдэл авдаг мэргэжилтний хүрээг өргөтгөх тухай	1.Говь болон түүнтэй ойролцоо байгаль цаг уурын нөхцөлд ажилладаг дээд, тусгай дунд боловсролтой ажилтан, албан хаагчдад сар бүр дор дурдсан хэмжээний нэмэгдэл олгож байхаар тогтоосугай: а/Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн хавсралтад заасан сум, хороодын хүн, малын их, бага эмч, багш /захирал, хичээлийн эрхлэгч/, зоотехникч, агрономч, агротехникч, хөдөө аж ахуй цахилгаанжуулалт, механикжуулалт, усжуулалтын инженер- техникийн ажилтан нарт тэдгээрийн албан тушаалын сарын цалингийн 15 хувиар ; б/Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн дүгээр хавсралтад заасан сум, хороодын нам, улс, олон нийт, хоршооллын байгууллагад ажиллаж байгаа дээр дурдсанаас бусад мэргэжлийн ажилтан, албан хаагчид болон Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай аймгийн төв, Дорноговь, Дундговь, Говь-Алтай аймгийн хавсралтад заасан сум, хороодын нам, улс, олон нийт, хоршооллын байгууллагад ажиллаж байгаа бүх мэргэжлийн ажилтан, албан хаагчдад тэдгээрийн албан тушаалын сарын цалингийн 10 хувиар ;	Засгийн газрын 1994 оны 90-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.	

5	МУ-ын хууль 2005.12.08	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай	5-р зүйл. Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт 5.1.8. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;	-	
6	МУ-ын хууль 2005.12.08	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай	5.1.9. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;	-	
7	Засгийн газрын тогтоол 2007.02.21 №44	Орон нутагт ажилласан дүнгийн тухай	Төрийн албан хаагчдад олгодог “Говийн нэмэгдэл”- ийг орон нутгийн төсөвт тусгаж байх асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авах	-	

2.2 Хилийн нэмэгдэл

Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор хилийн заставуудыг байгаль цаг уурын нөхцөлөөр нь ангилан тогтоож, тэдгээрт алба хааж байгаа офицер, албан хаагчдад хилийн нэмэгдэл олгож байна.

Хил дээр ажиллаж байгаа гаалийн хороо, алба, салбарын ажилтнуудын сарын цалингийн 25 хувиар, гаалийн удирдах төв байгууллагаас хилийн боомтод томилолтоор ажиллагсдад сарын цалингийн 15 хувиар хилийн нэмэгдэл олгох шийдвэр (2-р хүснэгт) хэрэгжиж байна.

УИИ-МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 2. Хилийн нэмэгдэл

Д/д	Актын төрөл, огноо	Эрх зүйн актын нэр	Холбогдох зүйл заалт	Цуцалсан шийдвэр	Тайлбар
1	МУ-ын хууль 1993.10.21	МУ-ын хилийн тухай хууль	<p>36-р зүйл. Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, иргэний эрх зүйн баталгаа</p> <p>2. Улсын хилд хил хамгаалах албан үүргээ биечлэн гүйцэтгэж байгаа иргэн гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.</p> <p>3. Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг тус тус улсаас олгоно.</p> <p>6. Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн суманд 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн хороонд 35 хувь, нийслэл, аймгийн төв, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн хороо, агаарын довтолгооноос хамгаалах салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.</p> <p>7. Энэ зүйлийн 2, 3-р заалтад хамаарагдах иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн сарын үндсэн цалинг хил хамгаалах байгууллагын ахлагчийн цалинтай адилтган тооцно</p>	-	
2	СнЗ-ийн тогтоол 1982.12.06 №365	Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай	<p>1. БНМАУ-ын өмнөд хилийн заставуудыг байгаль, цаг уурын нөхцөлөөр нь доорх 3 зэрэгт ангилж, тэдгээрт алба хааж байгаа офицер, цэргийн улирсан албан хаагч, энгийн ажилтнуудад дүгээр хавсралтад заасан хилийн нэмэгдэл олгож байхаар тогтоосугай.</p> <p>1-т: Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт байгаа заставууд;</p> <p>2-т: Баян-Өлгий, Ховд аймгийн нутагт байгаа заставууд;</p> <p>3-т: Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт байгаа заставууд;</p> <p>а/ хилийн 6,7,9-р отрядын төвийн болон нийт байцаан өнгөрүүлэхийн офицер, цэргийн улирсан албан хаагчдад олгох хилийн нэмэгдлийг 15 хувиар тогтоох;</p>	Засгийн газрын 1994 оны 90-р тогтоолоор хүчингүй болсон тооцсон.	

3	Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороо, Сангийн яамны коллегийн хурлын тогтоол 1983.10.18 №256	Улсын хил хамгаалалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	1.в/ Замын-үүдийн шалган нэвтрүүлэх боомтын офицер, цэргийн улирсан албан хаагч, энгийн ажилчин, албан хаагчдад олгох хилийн нэмэгдлийг 15 хувиар тогтоох. 7."хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1982.12.06-ны өдрийн 365-р тогтоолын 5.а-г хилийн 6,7,9-р отрядын төвийн болон Замын-Үүдээс бусад хилийн шалган нэвтрүүлэх боомт, Монгол Зөвлөлтийн хилийн орчмын постуудад ажиллаж байгаа офицер, цэргийн улирсан албан хаагчдад олгох хилийн нэмэгдлийг 15 хувиар , хилийн бусад отрядын төвийн офицер, цэргийн улирсан албан хаагчид болон 6,7,9,12-р отрядын төвийн энгийн ажилчин, албан хаагчдад олгох хилийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тус тус тогтоох.	Засгийн газрын 2003 оны 274-р тогтоолоор хүчингүй болсон тооцсон	1962-1995 онд батлагдсан бөгөөд ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн СнЗ, Засгийн газрын зарим тогтоол, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.
4	СнЗ-ийн тогтоол 1994.05.09 №90	Улсын хил хамгаалалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хил хамгаалалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" СнЗ-ийн 1982.12.06-ны 365-р тогтоолын 5-р зүйлийг "хилийн 6,7,9-р хорооны төвийн офицер, ахлагч нарт олгох хилийн нэмэгдлийг 15 хувиар, Сүхбаатарын шалган нэвтрүүлэх тусгай боомт болон хилийн бусад хороо, ангийн төвийн офицер ахлагч, 6,7,9,12-р хорооны төвийн энгийн ажилчин, албан хаагчдад олгох хилийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тус тус тогтоох;	-	
5	Засгийн газрын тогтоол 1997.06.25 №153	Журам батлах тухай /гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох, гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам/	3. Улсын хил дээр ажиллаж буй гаалийн газар, хороо, алба, салбарын гаалийн ажилтнуудад албан тушаалын сарын цалингийнх нь 25 хувиар бодож хилийн нэмэгдэл олгож байх, 4. Гаалийн удирдах төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооны ажилтнуудын түр буюу улирлын ажиллагаатай хилийн боомтод томилолтоор ажиллах хугацаанд тэдэнд албан тушаалын сарын цалингийнх нь 15 хувиар хилийн нэмэгдэл олгож байх.	-	
6	Засгийн газрын тогтоол 1995.01.04 №01	Журам батлах тухай /Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох журам/	г/ хилийн нэмэгдэл	-	

**Хүснэгт 2. Алслагдсан бүс нутгийн хөгжлийг дэмжих тухайд /Үргэлжлэл/
/1996 оноос одоог хүртэл/**

	Актын огноо /дугаар	Актын төрөл	Эх сурвалжийн нэр	Эрх зүйн зохицуулалт
1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ				
1	2002.05.03	МУ-ын хууль	Боловсролын тухай хууль	43.1.5. тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг үзүүлэх /Энэ заалтыг 2006.12.08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
2	2005.12.08	МУ-ын хууль	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай	5-р зүйл. Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт 5.1.8. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
3	2005.12.08	МУ-ын хууль	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай	5.1.9. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
4	1998.05.07	МУ-ын хууль	Эрүүл мэндийн хууль	10-р зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх 10.1.7. орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах; /Энэ заалтыг 2006.01.19-ний өдрийн хуулиар нэмсэн/
2. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ				
1	1996.11.01 №61	УИХ-ын тогтоол	МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	2.Эдийн засгийн хүрээнд хийх шинэчлэлт Алслагдсан бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн татварын хөнгөлөлттэй бодлого явуулна.
2	2000.01.06	УИХ-ын тогтоол	МУ-ын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	- Хөдөөгийн алслагдсан сумдын сургуулийг багшаар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад онцгой анхаарч тэднийг урамшуулах хөшүүргийг бий болгох
3	2000.09.01 №33	УИХ-ын тогтоол	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	1.Нийгмийн бодлого - Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, багш, эмч нарт тусгай нэмэгдэл олгодог болно. - Бүс нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг урамшуулах гааль, татварын ялгавартай уян хатан бодлого хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 30 хүртэл хувиар бууруулна. 3. Бүс нутаг, хөдөөгийн бодлого
4	2001.06.14 №57	УИХ-ын тогтоол	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	3.5.Бүсүүдийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даан даасан тогтолцоог бүрдүүлэхдээ, алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийн хөгжлийг дэмжихийн хамт бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж, түүнд ойр байгаа бусад нутгийг татан оролцуулах чиглэл баримтална; 4.7.2.в. алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. 4.7.4.д. алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх; 5.1.1. Алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгуудын нийгмийн дэвшлийг түргэтгэх хөтөлбөр боловсруулж, дэмжин зохион байгуулна.

5	2001.11.15 №84	УИХ-ын тогтоол	МУ-ын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	- Сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж төгссөн хүмүүсээс орон нутаг, түүний дотор суманд очиж, дутагдаж буй мэргэжлээр ажилласан тохиолдолд орон нутгийн алслагдсан байдлыг харгалзан зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөх, одоогийн мөрдөж буй журамд заасан хугацааг богиносгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.
6	2003.06.1№24	УИХ-ын тогтоол	Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги /2010 он хүртэл/	<p>1.10.7. алслагдсан болон сул хөгжилтэй бүс, говийн бүсийн нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг төсвийн татаасын болон гааль, татварын ялгавартай бодлогоор дэмжих;</p> <p>1.10.8.алслагдсан болон сул хөгжилтэй бүс, хөдөө орон нутагт үйлдвэрлэлийг өсгөх, ажлын байр бий болгоход хөрөнгө оруулалт хийсэн иргэн, хуулийн этгээдэд орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох;</p> <p>1.10.13. алслагдсан болон сул хөгжилтэй бүсэд экспортын болон импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор өргөн хэрэглээний бараа материал, технологийн тоног төхөөрөмжийг гадаадад гаргах, гаднаас оруулахад ногдуулах онцгой албан татвар, гаалийн татварыг тэдгээр барааны зах зээлд өрсөлдөх чадвар, хүн амын хүнсэнд болон байгаль орчинд хоргүй байдлыг нь харгалзан ялгавартай тогтоох;</p> <p>3.Монгол Улсын макро эдийн засгийн тогтворжилтын цаашдын хандлагатай уялдуулан баруун Монголын хүн амын оюуны болон амьдрах орчны чадавхийг дээшлүүлэх зорилгод газар, түүний баялаг, мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг бүрэн зохистой хоршин ашиглах зах зээлийн харилцааны үндсийг бүрдүүлэх үндсэн дээр бүсийн аймгууд төвөөс алслагдсан газарзүйн байрлалаараа нэгдэн нийлж, аж ахуйн талаар хоршин бүсийнхээ хэмжээнд харьцангуй бие даан хөгжих “харилцан хамаарал”-ын орчныг тогтоох явдлыг Баруун бүсийн хөгжлийн дунд хугацааны стратегийн зорилго болгоно.</p> <p>е) баруун 5 аймгийн эдийн засгийн төвүүдээс алслагдсан байдлыг харгалзан, эхний ээлжинд энэ бүс нутгийн хүн амын мэргэжил, боловсролын түвшинг жигд дээшлүүлэх, оюутан, сурагчдын дотоод, гадаадад суралцах нөхцөлийг сайжруулах, албан хаагчдын цалин хангамжийг нэмэгдүүлэх чиглэл баримтална.</p> <p>а) Баруун бүсийн аймгууд төвөөс хэт алслагдсан байдал, хөгжлийн түвшин доогуур, дотоод ялгаа ихтэй зэргийг харгалзан улсаас жил бүр олгодог төсвийн шилжүүлгийн хэмжээг ихэсгэсэн норматив (итгэлцүүр)-аар тогтоож, түүнийг Бүсийн зөвлөлийн мэдэлд өгөх бөгөөд Зөвлөл уул татаасыг бүс нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх шаардлагыг чухалчлан аймгуудад тодорхой болзолтойгоор хуваарилах, аймгууд улсын төсвөөс авсан шилжүүлгийн эх үүсвэрийг сумдаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг бодолцон мөн дээрх жишгээр сумдад дахин хуваарилах боломжийг судалж шийдвэрлэнэ;</p> <p>4/ Баруун бүсийн аймгуудын төвөөс алслагдсан бэрхшээл багасч, бүс дотроо, хөрш зэргэлдээ орнуудын хүрээлэлд харилцан хамааралтай хөгжих хамтын ажиллагааны шижим түлхэцүүд бий болж, Монголын баруун хэсэгт эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах ирээдүйн загвар тодорч эхлэх.</p>

7	2004.04.30 №24	УИХ-ын тогтоол	МУ-ын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг батлах тухай	<p>- Урт хугацаанд төрийн албаны сургалтыг “худалдан авагч-нийлүүлэгч” гэсэн загварыг үндэслэн явуулах бөгөөд ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яам, түүнчлэн Төрийн албаны зөвлөл нь сургалтын үйлчилгээг нийлүүлэгчээснь худалданавч, нийлүүлэгчийн дунд өрсөлдөөн өрнүүлэхийг идэвхитэй дэмжих болно. Цаашид, байгууллагын хэрэгцээт тусгай сургалтыг тэднээс ирүүлсэн санал, хандивлагчдын дэмжлэгийн бололцоог судлан, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яамнаас өгсөн үнэлгээнд үндэслэн улсын төсвөөс санхүүжүүлэх болно. Алслагдсан бүс нутагт ажиллаж буй төрийн албан хаагчийн сургалтанд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх үүднээс зайны сургалтын аргачлалыг сургалтанд нэвтрүүлэн ашиглана.</p> <p>- Ялангуяа алслагдсан бүс нутагт “үйлдвэрлэлийг оновчтой хэмжээнд тогтоох” буюу ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд Засгийн газраас үйлчилгээ хүргэх арга хэрэгслээ өөрчлөх, тухайлбал, үйлчилгээ хүргэх цэгүүдийг нэгтгэн “нэгцэгийн үйлчилгээ” үзүүлэх зэргээр өөр өөр альтернатив арга хэрэгсэлтэй хослуулах боломжийг судалж үзнэ. Үүнд төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах стратегийн нэг хэсэг болгон нутгийн захиргааны нэгж болон үүрэг хариуцлагыг нэгтгэх асуудлыг ч хамруулж болох юм.</p> <p>- Стратеги чиг үүргийг хянан үзэхдээ тодорхой зарим салбарын чиг үүрэг, бүтцийг өөрчлөх болон Засгийн газарт (А) шаардлагагүй болсон чиг үүрэг; (б) Засгийн газрын стратегийн тэргүүлэх чиглэл болон орчин үеийн зах зээлийн эдийн засгийн хэрэгцээг үндэслэн бодитойгоор шинэчлэн өөрчлөх шаардлагатай чиг үүрэг буюу үйлчилгээг хүргэх хэрэгслийн өөр өөр хувилбар; (в) стратеги шийдвэрээс үүдэлтэй бүтцийн чанартай үр дагавар; (г) ялангуяа алслагдсан бүс нутагт байгууллагын уламжлалт хил хязгаараас давсан үйлчилгээг хүргэх шинэлэг арга хэрэгслийг тодорхойлон тогтоох зэрэг асуудлаар зөвлөмж гаргана.</p>
8	2008.01.31 №12	УИХ-ын тогтоол	МУ-ын мянганы зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	Бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгана.
3. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ				
1	1997.01.02 №06	ЗГ-ын тогтоол	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	<p>- Алслагдсан бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн татварын хөнгөлөлттэй бодлого явуулна.</p> <p>- Амьжиргааны баталгаажих доод түвшинг алслагдсан аймаг, орон нутаг, бүс нутгаар ялгавартай тогтооно. Амьжиргааны түвшний өөрчлөлттэй уялдуулан өндөр настан, тахир дутуу иргэд, тэжээгчээ алдагчийн тэтгэврийг тэргүүн ээлжинд нэмэгдүүлэх, өндөр насны тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээ авна.</p>

2	1999.08.04 №120	ЗГ-ын тогтоол	Ховд аймгийн Алтайн чанад дахь бүс нутгийн хөгжлийн талаар авах арга хэмжээний тухай	Алтайн нурууны чанад дахь Ховд аймгийн Алтай, Булган, Үенч сумдад аймгийн төвөөс алслагдсан нийгэм, эдийн засгийн хувьд хоцрогдсон, хүн амын амьжиргаа доройтон, хил орчмын стратегийн бүс нутаг эзгүйрч байгааг харгалзан хөрөнгө батлах
3	2000.03.15 №41	ЗГ-ын тогтоол	Баруун аймгуудын талаар авах зарим арга хэмжээний тухай	1. Төвөөс алслагдсан баруун бүс /Баян- өлгий, Говь-алтай, Завхан, Увс, Ховд аймаг/ нутгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор хүн амын орлогын татварыг хөнгөлөх, цалин, тэтгэвэр тэтгэмжид хязгаарын бүсийн нэмэгдэл тогтоох, тус бүс нутагт хөрөнгө оруулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг тодорхой хугацаанд орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх санал боловсруулж энэ оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин нарт даалгасугай.
4	2002.05.24 №103	ЗГ-ын тогтоол	Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газрын лиценз эзэмшигчидтэй гэрээ байгуулах, хайгуулын ажилд хөрөнгө оруулагчдыг татварын тогтвортой байдлын гэрээнд хамруулах, үндсэн ордыг ашиглахад нөөц ашигласны төлбөрийг бууруулах, лиценз эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг зохих хуулиудад тусгах. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын багц хуульд хөрөнгө оруулалт, зарим төрлийн ашигт малтмалын олборлолтыг нэмэгдүүлэх, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, дэд бүтцийн барилга байгууламжийг барих болон төвөөс алслагдсан бүс нутагт үйлдвэр байгуулахад татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх зэрэг заалтууд оруулах.
5	2003.12.24 №264	ЗГ-ын тогтоол	Ерөнхий төлөвлөгөө батлах тухай	бэлчээрийн төлбөрийг сум дотроо ялгавартай тогтоож, сумын төвөөс алслагдсан айлуудыг төлбөрөөс чөлөөлөх зэрэг нь бэлчээрийг талхлагдалтаас хамгаалах.
6	2005.09.28 №202	ЗГ-ын тогтоол	Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай	Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 1-р хавсралт, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 2-р хавсралт, Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 3-р хавсралт, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 4-р хавсралт ёсоор баталсан

ГУРАВ. Гадаад орнуудад бүсийн нэмэгдэл олгож буй туршлага

Өндөр хөгжилд хүрсэн улс орнуудын туршлагаас үзэхэд бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо доорх 2 үндсэн чиглэлийг барьж, төсөл хөтөлбөр боловсруулдаг байна. Үүнд:

1. Улс орноо бүхэлд нь хамарсан бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
2. Улс орныхоо тодорхой бүс нутгийг онцгойлон анхаарч хөтөлбөр хэрэгжүүлэх.

Дээрх чиглэлээр хөгжиж байгаа улс орнууд аль аль нь бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьжиргааны үзүүлэлт, төв (нийслэл)-өөс алслагдсан байдал, тухайн бүс нутгийн байгаль цаг уур, хөгжлийн судалгааг үндэслэн бүс нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих “Санхүүгийн дэмжлэг” бүсийн нэмэгдэл олгодог байна. Зарим улс орнуудад бүсийн нэмэгдэл олгодог туршлагыг авч үзвэл:

3.1. Оросын Холбооны Улс

Оросын умард хязгаар түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад /ажилчин, албан хаагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчид, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуульд суралцагсад /тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан тэдгээрийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийг тодорхой коэффициентээр /районный коэффициент/ нэмэгдүүлэн олгодог.

Бүсийн нэмэгдлийн коэффициентийн хэмжээ, хэрэглэх журмыг ОХУ-ын холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Үүнд:

- Трудовой кодекс РФ от 30.12.2001 Глава 50
- Закон РФ “О государственных гарантиях и компенсациях для лиц работающих и проживающих в районах Крайнего Севера и приравненных к ним местностях” от 02.06.1993 Раздел II статья 10-12
- Постановление Совета Министров РСФСР от 22.10.1990 №458 “Об упорядочении компенсации гражданам, проживающим в районах Севера”
- Постановление Совета Министров СССР от 03.01.1983 №12
- Постановление Правительства РФ от 17.04.2006 №216 гэх мэт.

Бүсийн нэмэгдлийн коэффициентийн хэмжээ тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, алслагдсан Хойд мөсөн далайн арлууд, Саха /Якут/, Чукотка, Курилийн арлууд, Камчатка, Сахалин мужийн тодорхой нутагт оршин суугчдын бүсийн нэмэгдлийн коэффициент 2.0 байхад Красноярск, Мурманск, Хабаровск, Тюмень, Томск, Эрхүү муж, Алс Дорнодод 1.80-1.40 байдаг байна.

Мөн Монгол Улсын Баян-Өлгий, Увс, Завхан Хөвсгөл, Дорнод аймгуудтай хил залгаа оршдог байгаль цаг уурын ижил төстэй нөхцөлтэй Алтайн хязгаарт 1.40, Тувад 1.50-1.40, Буриадад 1.30-1.20, Чита мужад 1.30 коэффициентийн бүсийн нэмэгдэл олгодог.

Манай улсын Увс аймгийн Сагил сумтай хил залгаа Тува улсын Мөнгөн тайгын /Монгун Тайгинский/ районыг ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор Умард хязгаарын бүс нутгийн жагсаалтад онцгойлон оруулсан байдаг.⁴⁹

Мөн говь, цөлийн бүсэд болон далайн түвшнээс 1500 метрээс дээш оршдог газар нутгийн оршин суугчдад 1.40 хүртэл коэффициентийн нэмэгдэл олгодог.⁵⁰

Түүнчлэн ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу умард хязгаар, түүнтэй адилтгах бүс нутагт ажиллагсдад тухайн бүс нутагт тасралтгүй ажилласан хугацааг харгалзан тодорхой хувийн цалингийн нэмэгдэл олгодог ажээ.⁵¹

Мөн дээрх бүс нутагт нэг жилээс дээш амьдарч буй 30 хүртэлх насны залуучуудад ажилд орсон эхний 6 сараас эхлэн хагас жил тутамд 20 хувь улмаар 60 хүртэл хувийн нэмэгдлийг цаашид олгодог байна.⁵² Энэхүү нэмэгдэл дээр бүсийн нэмэгдлийн коэффициентийг давхар хэрэглэдэг байна.

Үүнээс гадна дээрх бүс нутгуудад оршин суугчдад

- нэмэлт амралтын өдөр /цалингүй/,
- ажлын богиносгосон долоо хоног,
- ээлжийн амралтын нэмэлт хоног,

⁴⁹Постановление Правительства РФ от 18.07.1994 №856/

⁵⁰Большая Российская Энциклопедия www.slovari.yandex.ru/

⁵¹Трудовой кодекс РФ от 30.12.2001 статья 317.

⁵²Постановление Совета Министров РСФСР от 22.10.1990 №458/

- эмчилгээний замын зардал,
- шилжин суурьших зардал олгох зэрэг хөнгөлөлт үзүүлэхээр заасан байна.⁵³

Төсвийн байгууллагад ажиллагсдын бүс нутгийн нэмэгдлийг холбооны болон мужийн төсөв, орон нутгийн засаг захиргааны төсвөөс гаргах бөгөөд төсвийн бус салбарт ажиллагсдын нэмэгдлийг тухайн ажил олгогч нар хариуцдаг.⁵⁴

Жич: Дээр дурдагдсан СССР, РСФСР-ын үеийн эрх зүйн актууд нь зохих нэмэлт өөрчлөлт хийгдэн өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болно.

ОХУ-ын умард хязгаар, түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад бүсийн коэффициент, умардын нэмэгдлийг олгодог шалтгаан, үндэслэлийг Оросын эрдэмтэн судлаачид “нийгэм-эдийн засгийн” /социально-экономический/, “биологийн” /медико-биологический/ гэж хоёр ангилж үздэг байна. Энгийнээр хэлбэл алслагдсан болон умардын хязгаар нутагт амьдрахад “өртөг өндөр, эрүүл мэндэд хохиролтой” /“Всё дорого”, “вредно для здоровья”/ гэж үздэг байна.

1. Нийгэм-эдийн засгийн үндэслэл

- а) төвөөс алслагдсан, дэд бүтэц сул хөгжсөн тул бүтээгдэхүүний өртөг, тээвэрлэлтийн зардал харьцангуй их байдгаас бараа үйлчилгээний үнэ хөлс өндөр;
- б) хоол хүнс, хувцаслалт, халаалт, түлш, цахилгаанд илүү их зардал гаргадаг;
- в) ажиллах хүч ялангуяа мэргэжлийн ажилчид, боловсон хүчнээр тасралтгүй хангаж тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай;
- г) бусад бүс нутгийнхантай харьцуулахад ахуй, соёлын түвшин доогуур;
- д) үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх боломж хязгаарлагдмал, үр ашиг бага;

2. Эмнэлэг-биологийн үндэслэл

ОХУ-ын умард хязгаар түүнтэй адилтгаж болох газар нутгийн байгаль цаг уурын хахир хүйтэн, хатуу ширүүн нөхцөл нь хүний эрүүл мэнд, бие организмд сөрөг нөлөө үзүүлдэг талаар эрдэмтэд судалсан байдаг.

Өнгөрсөн зууны 70-80-аад онуудад Н.Ф.Реймерс, О.Р.Назаревский, А.Г.Исаченко нарын эрдэмтэд байгалийн хүнд нөхцөл, хатуу ширүүн уур амьсгал хүний бие организмд хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа явуулж, ЗХУ-ын байгаль цаг уурын атласыг бүтээсэн бөгөөд уг бүтээлдээ дээрх бүс нутгийн жилийн дундаж температур, хамгийн хүйтэн, хамгийн халуун сар, улирлууд, агаарын чийгшилт, салхины хүч, агаарын даралт, хүнд хор учруулагч хорхой шавжийн тархалт зэргийг цогцоор нь үзүүлжээ.

Ер нь агаарын температур -7°C -аас бага байх үед салхины хүчний нөлөөгөөр температурын заалт улам доошилдог. Тодруулбал, салхины хурд нэг метрээр нэмэгдэхэд агаарын температур 2°C -аар хүйтэрдэг байна. ОХУ-д хүйтний улиралд гадаа ил орчинд ажиллахыг хүнд, хортой нөхцөлд тооцож шатлал тогтоосон байдаг.

Жич: 10°C - 15°C хүртэл 1-р зэрэглэлийн, -15°C - 20°C хүртэл 2-р зэрэглэлийн, -20° -аас дээш бол 3-р зэрэглэлийн хүнд, хортой нөхцөлд тооцогддог байна/

Мөн Бүгд найрамдах Казахстан улсын Хөдөлмөрийн хуулиар экологийн гамшиг /цөлжилт, хуурайшилт/-т нэрвэгдсэн газар нутаг, цацрагийн эрсдэлтэй бүс /зона радиационного риска/-эд ажилладаг хүмүүст төрөөс баталгаа гаргаж нөхөн олговор олгодог байна.⁵⁵

⁵³Трудовой кодекс РФ от 30.12.2001 статья 319-323, 325-327.

⁵⁴Закон РФ “О государственных гарантиях и компенсациях для лиц работающих и проживающих в районах Крайнего Севера и приравненных к ним местностях” от 02.06.1993 №5082, статья 3.

⁵⁵Трудовой кодекс Республики Казахстан. Статья 154 - www.zakon.kz/

3.2 Канад⁵⁶

Канад улс алслагдсан бүс нутгийн оршин суугчид, ажил олгогч нартаа тухайн газар нутгийн алслалт, байгаль цаг уурын байдал зэрэг нөхцөлүүдийг харгалзан тэдгээрийн цалин, орлогод ногдох орлогын албан татвараас тодорхой шалгуурыг үндэслэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (deduction) хэлбэрээр бүс нутгийн иргэдээ дэмждэг байна. Ийм хөнгөлөлтийг 1987 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд дараах 2 үндэслэлээр олгодог. Үүнд:

1. Цаг агаарын хүнд, бараа үйлчилгээний хязгаарлагдмал нөхцөл
2. Гол зах зээлээс алслагдсан тул амьдралын өртөг өндөр

Энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг “Хүн амын орлогын албан татварын хууль”-аар зохицуулдаг. Тус хуулиар хоёр төрлийн, гурван хэлбэрийн хөнгөлөлт, хасалт (deduction) хийдэг байна. /2006 оны байдлаар/

I. Хүн амын орлогоос:

- а) Өдрийн 15\$-аар бодож жилд 5475\$-ыг орлогын албан татварын нийлбэрээс хасч тооцох,

II. Ажил олгогчоос:

- б) Ажилтны амралтаараа нутагтаа очих зардлыг жилд 2 удаа ажил олгогч санхүүжүүлсэн бол,
- в) Тогтоосон ямар нэг хязгааргүйгээр эмнэлгийн үйлчилгээ авах зардлыг санхүүжүүлсэн бол тус тус хасалт хийнэ.

Татварын хөнгөлөлтийн хэмжээг бүс нутгийн алслалт, байгаль цаг уурын онцлог, бараа бүтээгдэхүүний өртөг зэрэг хүчин зүйлсээс улбаатай зардлуудын дарамтыг сулруулах үүднээс ялгавартай тогтоохдоо А буюу Умардын, Б буюу Завсрын бүсүүдэд хуваадаг байна. Чөлөөлөлтөд хамрагдах оршин суугчид тухайн бүс нутагт буюу А, Б бүсүүдэд хамгийн багадаа 6-аас доошгүй сар амьдарсан байх шалгуур үзүүлэлтийг ч тавьдаг.

Эдгээр бүсийг газарзүйн хувьд уртраг өргөрөгөөр нь маш нарийн тогтоосон байдаг.

А буюу Умардын бүсэд:

- Yukon
- Nunavut
- Quebec
- British Columbia
- Manitoba
- Ontario - ын хойд хэсгүүд, Мөн зүүн хойд бүсийн /“Labrador and Northwest territories”/ нийт нутгуудад оршин суугчид нь хөнгөлөлт буюу хасалтыг (deduction) 100 хувиар эдлэх,

Б буюу Завсрын бүсэд доорх нутгуудын өмнөд хэсгүүд:

- “British Columbia
- Alberta
- Saskatchewan
- Manitoba
- Ontario
- Quebec мөн Queen Charlotte, Anticosti Island, Sable Island” арлуудын нутгийн нийт оршин суугчид хөнгөлөлт буюу хасалтын (deduction) 50 хувиар тус тус эдэлдэг байна. /Мөнгөний нэгж нь Канадын доллараар илэрхийлэгдэнэ./

⁵⁶“Хүн амын орлогын албан татварын хууль” - <http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html/>

Хүснэгт 3. Гадаад улсуудад ашиглаж байгаа бүсийн нэмэгдлийн мэдээллийн товчоо

Д/д	Улсын нэр	Бүсийн нэмэгдлийг зохицуулсан эрх зүйн акт	Бүсийн нэмэгдэл олгодог үндэслэл	Нэмэгдлийн хэлбэр	Тоо хэмжээ
1	ОХУ	<ul style="list-style-type: none"> - Холбооны хууль - Хөдөлмөрийн хууль - ОХУ-ын Засгийн газрын тогтоол - ОХУ-ын СнЗ-ийн тогтоол - ЗХУ-ын хууль 	<ul style="list-style-type: none"> • Байгаль цаг уурын онцлогийг харгалзан - Говь, цөлийн - Өндөр уулын (далайн түвшнээс 1500 м) - Туйлын - Халууны - Хүйтний - Далайн • Төвөөс алслагдсан байдлыг үндэслэн - Умардын - Хойд туйлын • Умард хязгаар түүнтэй адилтгах нутагт ажиллагсад 	<ul style="list-style-type: none"> - Коэффициентээр - Коэффициентээр - Цалингийн нэмэгдэл - Ажлын богиносгосон 7 хоног - Ээлжийн амралт дээр нэмэгдэл хоног олгох - Эмчилгээний зардал - Шилжин суурьших зардал 	<ul style="list-style-type: none"> - Красноярск, Мурманск, Кабаровск, Тюмень, Томск, Эрхүү, Алс дорнод 1.80-1.40 коэффициентээр нэмэгдэл олгодог. - Якут, Чукотка, Курил, Камчатка, Сахалад 2.0 коэффициентээр нэмэгдэл олгодог. - 20-60 хувийн нэмэгдэл дээр бүс нутгийн нэмэгдэл давхар олгодог.
2	Канад	Хүн амын орлогын албан татварын тухай хууль	<ul style="list-style-type: none"> • Цаг агаарын хүнд, бараа үйлчилгээний хязгаарлагдмал нөхцөл • Гол зах зээлээс алслагдсан тул амьжиргааны өртөг өндөр • Бүс нутгийн алслалтыг үндэслэн - Умардын (А) бүс - Завсрын (Б) бүсүүдэд 6-аас доошгүй сар амьдарсан бол 	<ul style="list-style-type: none"> - Хүн амын албан татвараас хасч тооцох - Амралтаараа нутагтаа очих зардал - Хөнгөлөлт - Татварын хөнгөлөлт а) А бүсэд оршин суугчид б) Б бүсэд оршин суугчид 	<ul style="list-style-type: none"> - Жилд 2 удаа очих зардлыг ажил олгогч хариуцах - Татварын хөнгөлөлт буюу хасалтын 100% - Татварын хөнгөлөлт буюу хасалтын 50%-д тус тус эдлэх
3	Казахстан	Хөдөлмөрийн хууль	Экологийн гамшиг, цацрагийн эрсдэлтэй бүсэд оршин суугчдад	- Нөхөн олговор	

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Д.Цэвээнжав. Бүсчилсэн хөгжил гарын авлага. УБ. 2005 он
- Р.Ринчинбазар. Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд. УБ. 2004 он
- Г.Цэдэндамба. Хөрөнгийн үнэлгээний эдийн засаг. УБ. 2002 он
- Үндэсний Хөгжлийн хүрээлэн. МУ-ын хөгжлийн судалгаа 2003

- Бүсчлэн хөгжүүлэхэд төрийн бус байгууллагын үүрэг роль 2003 он
- Бага хурлын материал. Монгол Улсын Бүсчилсэн хөгжил хот байгуулалтын асуудал. 2001 он
- Статистикийн хороо. ХАА-н салбар 2007 он
- Статистикийн эмхэтгэл 2000-2012 он
- Зам харилцааны атлас 1991 он
- Трудовой кодекс Республики Казахстан.Статья 154 www.zakon.kz/
- Трудовой кодекс РФ от 30.12.2001 Глава 50
- Закон РФ “О государственных гарантиях и компенсациях для лиц работающих и проживающих в районах Крайнего Севера и приравненных к ним местностях “от 02.06.1993 Раздел II статья 10-12
- Постановление Совета Министров РСФСР от 22.10.1990 №458 “Об упорядочении компенсации гражданам, проживающим в районах Севера”
- Постановление Совета Министров СССР от 03.01.1983 №12
- Постановление Правительства РФ от 17.04.2006 №216
- [/http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html](http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html)
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн www.legalinfo.mn вэб сайт
- Хөдөө, орон нутгийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв судалгааны тайлан, УБ., 2009 он;
- Монгол Улс хууль – 4 боть, УБ., 2008 он;
- НТХ,СнЗ-ийн тогтоолын сан;
- УИХ-ын тогтоолын сан;
- Засгийн газрын тогтоолын сан

**ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**
(Мэдээлэл лавлагаа)

Г.Билгээ, Ч.Онончимээ

АГУУЛГА

Оршил

Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа

1. Монгол Улсын хууль
2. УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг
3. Олон улсын гэрээ, конвенц
4. Засгийн газрын тогтоол

ОРШИЛ

Судалгааны зорилго

Монгол Улсын хууль тогтоомжид тээвэр, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгааны дулаан дамжуулах шугам, бараа бүтээгдэхүүний агуулах, тээврийн нэгдсэн логистикийн сүлжээний асуудлыг хэрхэн зохицуулсан талаар мэдээлэл бэлтгэхэд оршино. Энэхүү ерөнхий зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд дээр дурдсан салбаруудын логистикийн сүлжээг Олон Улсын гэрээ, конвенци, Монгол Улсын хууль тогтоомжийн гол заалт, зохицуулалтыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн www.legalinfo.mn сайтаас хайлт хийсэн болно.

Судалгаанд дараах баримт бичгүүдийг хамруулсан болно.

№	Баримт бичиг	Хайлтын тоо хэмжээ	Хайлтын үр дүн
1	Логистикийн асуудлаар Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц	138	5
2	Монгол Улсын хууль	543	24
3	Бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд	1314	28

Судалгааны үр дүн

Манай улсын хувьд логистикийн тухай ойлголт нь дан ганц үйлчилгээний салбарын тээвэр гэсэн ойлголтоор төсөөлөн үзэж, асуудал нь хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалдаг гэсэн хандлага нийтлэг юм. Гэвч логистикийн тухай ойлголт нь нийгмийн бүхий л салбарыг хамарсан, маш өргөн цар хүрээтэй, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг салбар юм.

Өмнө гүйцэтгэсэн “Логистикийн систем, гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгаанд логистикийн салбарын талаар ойлголт, манай улсын логистикийн өнөөгийн байдал, чиг хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн бөгөөд энэ удаагийн мэдээлэл лавлагаанд манай орны логистикийн салбарын эрх зүйн зохицуулалтыг маш ерөнхий байдлаар түүвэрлэн товч авч үзсэн болно.

Учир нь манай улсын хувьд логистикийн салбарын хөгжил муу, энэ талаарх ойлголт нь шинэлэг учир эрх зүйн зохицуулалт нь маш хангалтгүй байлаа. Харин 2012.05.22-ны

өдөр батлагдсан Инновацийн тухай хуулийн 21.1.5-д “агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн зохицуулалтаас бусдаар логистикийн салбарын зохицуулалт бараг байхгүй гэж үзэж болохоор байлаа.

Мөн манай улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хүрээнд логистикийн салбарын эрх зүйн зохицуулалт дутмаг төдийгүй, аливаа нэг салбарын хувьд бүрэн цогц байдлаар зохицуулсан байдал хангалтгүй, нэгдсэн бодлого байхгүй байна.

Иймд цаашид логистикийн салбарын өндөр ач холбогдол, эдийн засгийн тэргүүн зэргийн үүргийг олон нийт болон эрх барих түвшинд таниулах, сурталчлах, улмаар энэ талаар бодлого, боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын бүтцэд яам, агентлагт нэгжийг бий болгох, мөн түүнчлэн логистиктой холбоотой төрийн бодлогыг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байгаа юм.

Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа

1. Монгол Улсын хууль

№	Баримт бичгийн нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	Автотээврийн тухай хууль /1999.06.04/ 1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1.1. “автотээврийн хэрэгсэл” гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгслийг	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
2	Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2002.06.28/ 4.1. “Алтанбулаг” бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно. 4.2. “Алтанбулаг” бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. 4.3. “Алтанбулаг” бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа, 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ
3	Авто замын тухай хууль /1998.01.02/ 1.1. Энэ хуулийн зорилт нь авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, ашиглах, санхүүжүүлэх, хянах болон төр, зам ашиглагч байгууллага, иргэний хооронд энэ талаар үүсэх харилцааг зохицуулахад оршино. 5.1. Төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.3. авто замын сүлжээн дэх олон улсын болон улсын чанартай замын жагсаалт /замын чиглэл, урт/-ыг батлах; 6.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1. авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан тухайн орон нутгийн авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчилж хамгаалах бодлого боловсруулж төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах; 10.1. Авто замын сүлжээ нь олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замуудаас бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> Тээврийн нэгдсэн логистик Бараа бүтээгдэхүүн худалдааны логистик

4	<p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006.06.29/ 12.1.Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно: 12.1.33.үйлдвэрлэл, технологийн паркийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө.</p>	<ul style="list-style-type: none"> цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ 								
5	<p>Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль /2003.05.30/ 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайг нисэхэд ашиглах, Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.лсын агаарын зайг нисэхэд ашиглах, Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1. Энэ хууль нь Монгол Улсын агаарын зайг иргэний болон улсын нисэхэд ашиглахад үйлчилнэ.</p>	<ul style="list-style-type: none"> Агаарын тээврийн логистик 								
6	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/</p> <table border="1" data-bbox="239 733 903 1279"> <thead> <tr> <th data-bbox="239 733 396 875" rowspan="2">Төслийн ангилал</th><th colspan="2" data-bbox="396 733 903 771">Хариуцан гүйцэтгэгч</th></tr> <tr> <th data-bbox="396 771 665 875">Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</th><th data-bbox="665 771 903 875">Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар</th></tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="239 875 396 1279">5.Дэд бүтцийн хөгжлийн төсөл</td><td data-bbox="396 875 665 1279"> <ul style="list-style-type: none"> - 1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам - дулааны шугам - усан цахилгаан станц - төмөр зам - нисэх буудал - улс, хот хоорондын зам - улс хот хоорондын холбоо - нефтийн бүтээгдэхүүний агуулах </td><td data-bbox="665 875 903 1279"> <ul style="list-style-type: none"> - 1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам - орон нутгийн чанартай зам, холбоо -шатахуун түгээх станц </td></tr> </tbody> </table>	Төслийн ангилал	Хариуцан гүйцэтгэгч		Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	5.Дэд бүтцийн хөгжлийн төсөл	<ul style="list-style-type: none"> - 1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам - дулааны шугам - усан цахилгаан станц - төмөр зам - нисэх буудал - улс, хот хоорондын зам - улс хот хоорондын холбоо - нефтийн бүтээгдэхүүний агуулах 	<ul style="list-style-type: none"> - 1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам - орон нутгийн чанартай зам, холбоо -шатахуун түгээх станц 	<ul style="list-style-type: none"> Дулаан, эрчим хүчний шугам сүлжээ
Төслийн ангилал	Хариуцан гүйцэтгэгч									
	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар								
5.Дэд бүтцийн хөгжлийн төсөл	<ul style="list-style-type: none"> - 1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам - дулааны шугам - усан цахилгаан станц - төмөр зам - нисэх буудал - улс, хот хоорондын зам - улс хот хоорондын холбоо - нефтийн бүтээгдэхүүний агуулах 	<ul style="list-style-type: none"> - 1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам - орон нутгийн чанартай зам, холбоо -шатахуун түгээх станц 								
7	<p>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль /2012.05.17/ 6.1.4.эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.</p>	<ul style="list-style-type: none"> Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх Цахилгаан, эрчим хүчи дамжин өнгөрөх логистик 								

8	<p>Гаалийн тухай хууль /2008.05.20/</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэдээс гомдол гаргах, түүнийг нь гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3.1.13.“гаалийн бүрдүүлэлтийн горим” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар тогтоосон хэм хэмжээ, нөхцөл, шаардлагыг;</p> <p>3.1.18.“гаалийн хяналтын бүс” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайг;</p> <p>5.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө.</p> <p>6.1. Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ /цаашид “олон улсын гэрээ” гэх/-нд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй.</p> <p>6.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр орсон үеэс мэдүүлэгчид олгох хүртэл, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлсэн үеэс улсын хилээр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно.</p> <p>39 дүгээр зүйл. Барааг түр хадгалах</p> <p>39.1.Барааг гаалийн хяналтад авсан үеэс гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах хүртэлх хугацаанд гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтгүйгээр түр агуулахад хадгална.</p> <p>39.2.Мэдүүлэгч энэ хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаанд бараатай холбогдсон мэдээллийг гаалийн байгууллагаас авч болно.</p> <p>40 дүгээр зүйл.Түр агуулах</p> <p>40.1.Түр агуулах нь битүү агуулах байр, эсхүл задгай талбай байж болно.</p> <p>44 дүгээр зүйл. Хадгалалтын хугацаа</p> <p>44.1.Барааг түр агуулахад 2 сар хүртэл хугацаанд хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 1 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.</p> <p>44.2.Түргэн гэмтэх, эсхүл аюултай барааг 7 хоног хүртэл хугацаагаар хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 7 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.</p> <p>44.3.Барааг түр агуулахад оруулсан, эсхүл шилжүүлсэн гэж тооцсон өдрөөс эхлэн түр хадгалах хугацааг тоолно.</p> <p>44.4.Энэ хуулийн 42.3-т заасан бараанд мөн хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаа хамаарахгүй.</p> <p>45 дугаар зүйл. Түр агуулахад хадгалах бараанд хийгдэх ажиллагаа</p> <p>45.1.Түр агуулахад хадгалагдаж байгаа бараанд болон түүний сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр гаалийн байгууллагын зөвшөөрлөөр арчилгаа, үйлчилгээ хийж болно.</p> <p>45.2.Мэдүүлэгч нь гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө барааг үзэж сорьц, дээж, загвар авч болно.</p> <p>48 дугаар зүйл. Түр агуулахад тавигдах шаардлага</p> <p>48.1.Түр агуулах нь бараа хадгалах дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:</p> <p>48.1.2.бараа ачих, буулгах, шилжүүлэн ачих тоног төхөөрөмж, гаалийн хяналтын техник хэрэгсэл, тавцан, зам, талбай, цахилгаан, ус суваг, холбооны шугам сүлжээтэй байх;</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай • Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
---	---	--

9	<p>Замын-Үүд худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.06.20/</p> <p>5.4."Замын-Үүд" бүсэд дараах чиглэлээр албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ:</p> <p>5.4.1.эрчим хүчний шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто, төмөр зам, харилцаа холбооны үндсэн сүлжээнд аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно;</p> <p>5.4.2.бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тухайн бүсээс олох орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө;</p> <p>5.4.3."Замын-Үүд" бүсэд 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p> <p>5.5."Замын-Үүд" бүсэд дараах чиглэлээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ:</p> <p>5.5.1.худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 3 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө;</p> <p>5.5.2.энэ хуулийн 5.4.1-д заасан бүсийн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай • Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх • эрчим хүчний шугам сүлжээ
10	<p>Инновацийн тухай /2012.05.22/</p> <p>21.1.Паркийн нутаг дэвсгэрт дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна:</p> <p>21.1.1.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулах, дэвшилтэт техник, технологийг дамжуулах;</p> <p>21.1.2.инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;</p> <p>21.1.3.сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох;</p> <p>21.1.4.нийгмийн суурь үйлчилгээ, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг тухайн бүс, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолбороор байгуулах;</p> <p>21.1.5.агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх;</p> <p>21.1.6.паркийн нутаг дэвсгэрт хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> • Нэгдсэн логистикийн үйлчилгээ үзүүлэх • сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох;
11	<p>Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлах тухай хууль /2010.10.21/</p> <p>Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>12. "Хил дамнанс байгууламж" гэж хилийн шугамыг дайран гарсан төмөр зам, авто зам, газрын тос, хий дамжуулах хоолой, цахилгаан, холбооны шугам, гүүр, усны далан, усны хашлага зэрэг байгууламжийг хэлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж
12	<p>Өрсөлдөөний тухай хууль /2010.06.10/</p> <p>7.1.3.аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах. Энэ нь бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй;</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик
13	<p>Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль /2007.01.11/</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэх, нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>10.1. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай үйлдвэрлэгч, дамжуулагчийн хоорондын гэрээг эрчим хүчний зохицуулах газраас баталсан загварын дагуу байгуулна.</p> <p>10.2. Энэ хуулийн 10.1-д заасан гэрээнд үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны чадал, чанарын үзүүлэлт, хэмжээ, тариф, хугацаа, цахилгааны тоолуур, хэмжих хэрэгслийн байршил, түүний төрөл, загвар, нарийвчлал, итгэлцүүрийн хэмжээ, дугаар, цахилгааны төлбөр, тооцооны нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тусгана.</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик

14	<p>Төмөр замын тээврийн тухай хууль /2007.07.05/</p> <p>3.1.23."төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа" гэж ачаа, тээш, ачаан тээш, чингэлгийг тээвэрлэхэд бэлтгэх, хүлээн авах, ачих, тээвэрлэх, буулгах, хүлээлгэн өгөх болон зорчигч тээвэрлэх, сэлгээний ажил гүйцэтгэх үеийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаатай цогцолбор ажил, үйлчилгээг;</p> <p>21.1.Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон дайвар үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж өөрийн зам, талбайд ачаа, ачаан тээш, вагон, чингэлгийг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, буулгах, хадгалах үйлчилгээ үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
15	<p>Усан замын тээврийн тухай хууль /2003.11.28/</p> <p>1.1.Энэхүү хуулийн зорилт нь усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, усан замын тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3.1.8."тээвэрлэлт" гэж усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачааг усан замын нэг зогсоолоос нөгөө зогсоолд шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг;</p> <p>3.1.9."тээвэрлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;</p> <p>3.1.10."тээвэрлүүлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгчийг;</p> <p>11 дүгээр зүйл. Тээвэрлэлт гүйцэтгэх</p> <p>11.1.Усан замын тээвэрлэлтийг Иргэний хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.</p> <p>11.2.Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
16	<p>Улсын нисэхийн тухай хууль /2003.05.30/</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>10.1. Улсын агаарын хөлгийн нислэг дараах ангилалтай байна:</p> <p>10.1.1. байлдааны үүргийн нислэг;</p> <p>10.1.2. онцгой үүргийн нислэг;</p> <p>10.1.3. тусгай үүргийн нислэг;</p> <p>10.1.4. арилжааны нислэг.</p> <p>10.3.2. тогтоосон агаарын замаас гадна зайлшгүй шаардлагатай үйлдэх улсын агаарын хөлгийн нислэг.</p> <p>10.5. Улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хуулийг баримтална.</p>	<ul style="list-style-type: none"> • Агаарын тээврийн логистик
17	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхийн эдийн биржийн тухай хууль /2011.06.02/</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
18	<p>Хүнсний тухай хууль /2012.12.20/</p> <p>11.2.4.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх.</p>	<ul style="list-style-type: none"> • Бараа бүтээгдэхүүний агуулах

19	<p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай /2012.12.20/</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино</p> <p>4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
20	<p>Харилцаа холбооны тухай хууль /2001.10.18/</p> <p>11.1.Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор шуудангийн болон цахилгаан холбооны бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг тус тус бүрдүүлж, зарцуулна.</p> <p>16.1.Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
21	<p>Хот байгуулалтын тухай хууль /2008.05.29/</p> <p>14.3.Инженерийн шугам сүлжээний болон зам тээврийн бүсэд төмөр зам, усан болон авто тээвэр, агаарын тээвэр, инженерийн /цэвэр, бохир усны, дулаан, холбоо, цахилгааны гэх мэт/ шугам сүлжээний барилга байгууламжийг төлөвлөнө.</p> <p>21.1.Хот байгуулалтын үйл ажиллагааг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:</p> <p>21.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах;</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
22	<p>Чөлөөт бүсийн тухай хууль /2002.06.28/</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Чөлөөт бүс, түүний хэлбэр</p> <p>3.1.“Чөлөөт бүс” гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.</p> <p>3.2.Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна.</p> <p>3.3.Худалдааны чөлөөт бүсэд бараа, бүтээгдэхүүний мөн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав баглаа, боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>3.4. Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд тэргүүний, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>3.5. Хөдөө аж ахуйн чөлөөт бүсэд газар тариалан, мал аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>3.6.Аялал жуулчлал-үйлчилгээний чөлөөт бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээ эрхэлнэ.</p> <p>3.7. Эдийн засгийн чөлөөт бүсэд энэ хуулийн 3.3-3.6-д заасан үйл ажиллагааг хосолсон буюу нэгтгэсэн байдлаар эрхэлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах

23	<p>Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.12.18/</p> <p>4.1."Цагааннуур" бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.</p> <p>4.2."Цагааннуур" бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p> <p>4.3."Цагааннуур" бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах • цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж
24	<p>Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3.1.5."нэгдсэн сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш аймгийн төвийг хамран цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг;</p> <p>3.1.7."цахилгаан дамжуулах сүлжээ" гэж цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кв, түүнээс дээш хүчдлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдлийн шугам, дэд станцыг;</p> <p>3.1.8."цахилгаан түгээх сүлжээ" гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх шугам, дэд станцыг;</p>	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж

2. УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

№	Баримт бичгийн нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	<p>УИХ-ын 2010.06.24 №32 тогтоол "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"</p> <p>1/ Монгол Улсын экспортын ачааны тээвэрлэлтийг ОХУ болон БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд тухайн улсын төмөр замын байгууллагаас ижил төрлийн ачааны тээвэрлэлтэд үзүүлж байгаа тээврийн болон вагон ашиглалтын хамгийн доод хөлс, ачаа хүргэх хугацаа, бусад төлбөр, хураамжтай дүйцэх буюу илүү хөнгөлөлттэй нөхцөлийг урт хугацаанд мөрдөхөөр тохиролцож, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тусгагдсан тухайн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик дамжин өнгөрөх
2	<p>УИХ-ын 2008.01.31 №12 тогтоол "Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого" батлах тухай</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик • эрчим хүчний шугам сүлжээ
3	<p>УИХ-ын 2003.06.12 № 24 тогтоол Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай</p>	<ul style="list-style-type: none"> • Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах, • эрчим хүчний шугам сүлжээ

4	УИХ-ын 2005.04.21 № 25 тогтоол Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах, эрчим хүчний шугам сүлжээ
5	УИХ-ын 1996.05.03 №26 Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах,
6	УИХ-ын 2010.06.24 №34 тогтоол Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах,
7	УИХ-ын 2010.06.24. №32 тогтоол Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах,
8	УИХ-ын 2005.06.09 №32 Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай	<ul style="list-style-type: none"> эрчим хүчний шугам сүлжээ

3. Олон улсын гэрээ, конвенц

№	Баримт бичгийн нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	<p>Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц 1965 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталж, 1967 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон</p> <p>Дамжин өнгөрч буй бараанд гаалийн хураамж ногдуулахгүй Дамжин өнгөрөгч тээврийн хэрэгсэлд дамжин өнгөрүүлэгч улсын тээврийн хэрэгсэлд ногдуулдагаас илүү татвар буюу хураамжийг ногдуулахгүй. iii) бусад тээврийн хэрэгсэл, түүнчлэн хэлэлцэн тохирогч холбогдох улсууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дамжуулагч хоолой болон байгалийн хий дамжуулах шугам зэргийг дамжин өнгөрөх хөдөлгөөнд энэ зүйлийн агуулгад нийцүүлэн ашиглаж буй тохиолдолд тус тус багтаана.</p> <ol style="list-style-type: none"> Энэхүү конвенцийн заалтын дагуу дамжин өнгөрөх хөдөлгөөн болон тээврийн хэрэгсэлд дамжин өнгөрөх эрх чөлөөг олгоно. Энэхүү конвенцийн бусад заалтын дагуу хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн хөдөлгөөнийг зохицуулах болон хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээ нь хэлэлцэн тохирогч тухайн улсуудын харилцан хүлээн зөвшөөрсөн, одоогоор ашиглагдаж буй замын чиглэлийн дагуу дамжин өнгөрөх тээвэр хийхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдэнэ. Дамжин өнгөрөх хөдөлгөөнийг шаардлагагүйгээр саатуулахгүйн тулд хэлэлцэн тохирогч улсууд бололцоотой бол оруулах, гаргах цэгүүд болон шаардлагатай гэж үзвэл шилжүүлэн ачих цэгүүдэд, зохих тээврийн хэрэгсэл болон ачиж буулгах тоног төхөөрөмжөөр хангах үүрэг хүлээнэ. 	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах,
2	<p>Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай марракешийн хэлэлцээр 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон</p> <p>Экспортын өрсөлдөөний талаархи үүрэг амлалт Гишүүн бүр энэхүү хэлэлцээр болон тухайн гишүүний буултын жагсаалтад заасан үүрэг амлалттай тохирч байгаагаас өөр тохиолдолд экспортын татаас олгох үүрэг хүлээхгүй</p> <p>(е) экспортын бараа нийлүүлэхэд зориулан экспортын бус ачааны тээврийнхтэй харьцуулахад илүү таатай нөхцөлөөр засгийн газраас тогтоосон буюу эрх олгосон дотоодын тээврийн тариф</p>	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах, Худалдааны логистик

3	<p>Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдөр</p> <p>Хил нэвтрэх Талууд зорчигч, ачаа тээш, бараа, тээврийн хэрэгслийг тогтоосон боомтоор хил нэвтрүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх
4	<p>Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенц 1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр баталж, 1988 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон</p> <p>(1) Хэрэв худалдагч гэрээ буюу энэхүү конвенцийн дагуу барааг тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн бөгөөд хэрэв дээр нь тэмдэглэл хийх, тээврийн баримт бичигт заах буюу бусад аргаар барааг гэрээний зорилгод нарийвчлан тодорхойлоогүй бол худалдагч барааг ачуулсан тухай мэдэгдэлд тухайн барааг тодорхойлон худалдан авагчид өгөх ёстой. (2) Хэрэв худалдагч барааг тээвэрлүүлэх үүрэг хүлээсэн бол барааг хүлээн авах газар хүртэл тухайн нөхцөл байдалд тохирсон тээврийн хэрэгслээр болон ийм тээвэрлэлтэд хэрэглэдэг ердийн нөхцөлөөр тээвэрлэхэд шаардлагатай гэрээг байгуулах ёстой (2) Гэсэн хэдий ч дээр нь тэмдэглэл хийх, тээврийн баримт бичигт заах, худалдагчид мэдэгдэл өгөх буюу бусад аргаар барааг гэрээний зорилгод нарийвчлан тодорхойлох хүртэл эрсдэл худалдан авагчид шилжихгүй.</p>	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх Бараа бүтээгдэхүүн агуулах,
5	<p>Аж уйлдвэрийн өмчийг хамгаалах тухай парисын конвенц 1970 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр буюу 1970 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон /Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан/ Тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр: Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласан барааг импортлоход хураах (4) Эрх бүхий байгууллагууд бараа дамжин өнгөрөх тохиолдолд хураах үүрэг хүлээхгүй.</p>	<ul style="list-style-type: none"> Тээврийн логистик дамжин өнгөрөх

4. Засгийн газрын тогтоол

№	Баримт бичгийн нэр, агуулга	Зохицуулж буй салбар
1	"Шинэ төмөр зам төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2013.01.26 №28	Тээврийн логистик дамжин өнгөрөх
2	Монгол-Хятадын авто тээврийн хэлэлцээр батлах тухай 2011.08.24 №259	Тээврийн логистик дамжин өнгөрөх
3	Беларус улстай Олон Улсын автотээврийн харилцааны тухай 2004.04.23 №93	Тээврийн логистик дамжин өнгөрөх
4	БНАСАУ-тай худалдааны далайн тээврийн салбарт хамтран ажиллах тухай 2007.08.08 №195	Тээврийн логистик дамжин өнгөрөх
5	Украин улстай Олон Улсын автотээврийн харилцааны тухай төмөр замын салбарт хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулах тухай 1995.10.11 №180	Тээврийн логистик дамжин өнгөрөх
6	Төмөр замын дагуух шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2004.04.12 №80	Цахилгаан, сүлжээ
7	Улс хоорондын тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2006.10.25 №257	Тээврийн логистик дамжин өнгөрөх
8	Монгол Улс далайд гаргах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 №167	Тээврийн логистик дамжин өнгөрөх
9	Мэдээлэл холбооны сүлжээний давхардлыг арилгах тухай 2013.01.12 №6	Мэдээллийн сүлжээ

10	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.03.16 №100	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
11	Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн гаалийн бүс байгуулах ажлыг зохион байгуулах тухай 2013.06.22 №225	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
12	Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тухай 2012.12.01 №150	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
13	Далайд гаргах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.04.27 №152	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
14	Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам 2003.01.22 №20	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
15	Олон Улсын автозам, замын байгууламж журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай 2011.04.06 №106	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
16	“Улаанбаатарын дулааны 5-р цахилгаан станц”-ыг барих тухай 2012.12.22 №191	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
17	Автозамын тухай /Ухаа худаг нүүрсний орд газраас Гашуунсухайт боомт хүртэлх/ 2010.03.31 №83	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
18	Бичигт-Зүүн хатавчийн боомтыг байнгын ажиллагаатай болгох тухай 1992.12.24 №249	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
19	“Ус-15” дулааны станц барих тухай 2013.01.26 №35	• Цахилгаан, сүлжээ
20	“Шинэ төмөр зам” төслийн санхүүжилтийн тухай 2013.03.07 №82	• Тээврийн логистик дамжин өнгөрөх

2

БҮЛЭГ

САНХҮҮ, ТАТВАРЫН САЛБАР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ СТАНДАРТ**
(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог, Г.Алтан-Оч, Д.Байгалмаа,
Г.Билгээ, Ц.Болормаа, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

Оршил

1. Судалгааны хураангуй
 - 1.1. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, нийтлэг зарчим, олон улсын стандарт
 - 1.2. Судалгаанд хамрагдсан орнуудын туршлага, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн зохицуулалттай холбоотой харьцуулсан судалгааны үр дүн
2. Дүн шинжилгээний хэсэг
 - 2.1. Олон улсын компанийн засаглалын загварууд ба онцлог
 - 2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой судалгааны мэдээлэл, дүн шинжилгээ
3. Судалгааны дэлгэрэнгүй хэсэг /Бусад орнуудын эрх зүйн зохицуулалт/
 - 3.1. Америкийн Нэгдсэн Улс
 - 3.2. Их Британи
 - 3.3. Оросын Холбооны Улс
 - 3.4. Бүгд Найрамдах Турк Улс
 - 3.5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Судалгааны захиалгад тусгагдсан асуудлуудын хүрээнд хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн холбогдолтой практикт зөрчил үүсгэж буй тодорхой асуудлуудыг бусад орнуудын хууль тогтоомжоор хэрхэн зохицуулсан, олон улсад баримталдаг зохицуулалтын нийтлэг стандарт нь ямар байдаг, судлаачид, мэргэжлийн хүмүүс хэрхэн үзэж байгаа талаар судалгааны мэдээллийн хайлт хийж, олдсон мэдээллийн хүрээнд асуудлыг тодруулан гаргах, захиалагчид тодорхой мэдлэг, ойлголт өгөхөд чиглэгдэнэ.

Судалгааны арга зүй

Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх.

Судалгааны хамрах хүрээ

Захиалгад дурдсан асуудлуудын хүрээнд дараах байдлаар асуудлыг судлах. Үүнд:

- Олон улсын хөгжлийн агентлаг (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын зохицуулалтын олон улсын зарчим ба хэрэгжүүлэх механизм”
- Үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо (IOSCO)-ноос баталсан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим, хэрэгжүүлэх механизм”

- Бусад орнуудын Хувьцаат компанийн үйл ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн актуудыг судалж, олдсон мэдээллийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тодруулан гаргах (АНУ, Англи, ОХУ, Турк, Герман улс).

Судалгааны мэдээллийн хайлтыг өргөн хүрээнд явуулж олдсон мэдээллийн байдал, судалгаанд ашиглах боломж зэргийг харгалзан АНУ, Англи, ОХУ, Турк, Герман гэсэн 5 улсыг сонгон авлаа. Мөн Компанийн засаглалын зарчмыг тогтоосон олон улсын стандарт, олон улсын түвшинд хийгдсэн судалгааны мэдээллүүд, мэргэжлийн хүмүүсийн дэвшүүлсэн санал, нийтлэл зэрэг бусад судалгааны эх сурвалжуудыг ашиглан асуудлыг онол, практикийн түвшинд ул суурьтай тодруулахыг зорьсон болно.

Орнуудын сонголтыг хийхдээ, манай улстай ижил төстэй боловч ахисан түвшинд эрх зүйн зохицуулалтаа хийж чадсан ОХУ, Турк улсыг сонгосноос гадна, дэлхий нийтээр түлхүү ашиглаж байгаа компанийн засаглалын сонгодог тогтолцоо буюу Англо-америкийн загвар бүхий эрх зүйн зохицуулалттай АНУ, Англи Улсыг, мөн эх газрын эрх зүйн системтэй орнуудаас Герман Улсын хуулийг сонгон авсан болно. Мөн түүнчлэн дэлхийн бусад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтын онцлогийг аналитик түвшинд харьцуулан судалж, судалгааны тайланд тусгасан болно.

Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг ба тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой практикт тулгардаг, захиалгад дурдсан зөрчилтэй асуудлуудыг бусад орнуудад хуульчилсан байдлыг судлах явцад тухайн орны эрх зүйн системийн онцлог, хуулийн бичвэр, асуудалд хандах хандлагаас шалтгаалан өөр өөр байгаа нь харагдлаа. Тухайлбал, Судалгаанд авагдсан орнуудын хуулийн цар хүрээ маш өргөн, мэргэжлийн хэллэгээр бичигдсэн, маш олон (760 хуудас ч байлаа) хуудастай байсан ба эдгээр хуулиудаас хайлт хийхэд хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг хүчингүй болгохтой холбоотой, захиалгад дурдсантай ижил агуулга бүхий зохицуулалт олдоогүй болно. Ижил төстэй зохицуулалт байлаа гэхэд агуулгын хувьд ихээхэн өөр, зарим нэг асуудлаар саналын эрхийг хязгаарлахтай холбоотой ойлголт болох нь харагдаж байна. Жишээ нь, саналын эрхийг хязгаарлах асуудал нь энгийн хувьцаанаас өөр төрлийн (давуу эрхийн) хувьцаанд хамаарах ойлголт болох нь тодорхой байна. Зарим оронд, жишээ нь, ОХУ-д давуу эрхийн хувьцаа ч зарим тохиолдолд саналын эрхтэй байж болохоор хуульчилсан байна. “Саналын эрх” гэдэг нь олон улсад тогтсон ойлголтоор энгийн хувьцаа эзэмшигчийн компанийг удирдахад оролцох, шийдвэр гаргах эрхээ эдлэх үндсэн 6 эрхийн нэг тул үүнийг хүчингүй болгох, хязгаарлах асуудалд ихээхэн болгоомжтой, уян хатан хандах шаардлагатай юм байна.

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой олон улсын стандарт, эрх зүйн зохицуулалтын чиг хандлагаас үзэхэд, компанийн засаглалыг сайжруулах хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудалд түлхүү анхаарч, энэ чиглэлээр эрх зүйн олон хамгаалалтуудыг улс орон бүр хууль тогтоомждоо тусгасаар байгаа нь сүүлийн үед зарим нэг сөрөг үр дагавар бий болгож байгааг хуульчид болон судлаачид, мэргэжлийн хүмүүс шүүмжилж асуудал дэвшүүлсэн ярилцлага, нийтлэлүүд нэлээд гаргах болжээ. Жишээ нь, ОХУ-ын **Le Boeuf, Lamb, Greene & MacRae** олон улсын хуулийн фирмийн зөвлөх, хуульч Василиса Стриж хэлэхдээ⁵⁷, “Хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөх асуудал зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдэд төдийгүй том хувьцаа эзэмшигчдэд тулгарах боллоо. Хувьцаа эзэмшигч бүхэн эцсийн дүндээ компанийг аль болох сайн ажиллуулж, ашгаас нь хувь хүртэх зорилготой. Эзэмшиж байгаа хувьцаа, оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хувьцаа эзэмшигч компанийн удирдлагад нөлөөлөх, хяналт тавих эрхтэй байх ёстой. Жижиг хувьцаа эзэмшигчдийн

⁵⁷www.corp-gov.ru/news/arch.php3?news_id=241: Компаний засаглалыг хөгжүүлэх ОХУ-ын Эдийн засгийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ба Дэлхийн банкны хамтарсан төслийн албан ёсны сайт www.ipa-moscow.com-д өгсөн ярилцлага

эрхийг хамгаалах асуудалд ихээхэн анхаарч хуулийн хамгаалалтууд хийх атлаа том хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах талаар хуулинд тусгадаггүй нь сүүлийн үед гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зүгээс ихээхэн асуудал дагуулж, эрх нь зөрчигдөж байгаа олон тохиолдлууд хуулийн практикт гарч байна. Тэд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хангалттай эрх эдэлж чадахгүй байна. Хуулийн цоорхойг ашиглан компанийн менежерүүд болон жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс том хувьцаа эзэмшигчдийг аль болохоор компанийн удирдлага, хяналтаас хол байлгах, шантаажлах асуудлууд гарч байгаа нь нууц биш юм. Жишээ нь, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар тухайн хуралд оролцоогүй буюу эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч районы шүүхэд гомдол гаргахад л шүүхээс хувьцааг нь тусгаарлах, хэлцэл хийх процессыг зогсоох гэх мэтийн арга хэмжээ авчихаж байгаа нь том хувьцаа эзэмшигчдэд хохиролтой байна...” гэжээ.

Иймд хувьцаат компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг зохицуулах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, компанийн засаглалыг сайжруулах асуудал ялангуяа нээлттэй хувьцаат компанийн хувьд чухал юм.

Нэг. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

1.1. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, нийтлэг зарчим, олон улсын стандарт

Компанийн засаглалыг боловсронгуй болгох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын олон улсын нийтлэг стандартыг Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”⁵⁸ (1999, 2004), Олон улсын Үнэт цаасны хороодын байгууллага (IOSCO)-аас баталсан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчмууд” (2003, 2010) ба түүнийг хэрэгжүүлэх аргачлал, зөвлөмжөөр зохицуулсан байдаг. Энэхүү баримт бичигт заасан компанийн засаглалын 6 үндсэн зарчим, үүн дотроо хувьцаа эзэмшигчийн 7 төрлийн эрх, 5 төрлийн үүргийг OECD-ийн гишүүн ба гишүүн бус орнууд дагаж мөрдөх, эрх зүйн зохицуулалтын гол зарчмаа болгох шаардлага бий. Үүнд:

- a) Үр нөлөөтэй компанийн засаглалын бүтэц дэх суурь хамгаалалт
- b) Хувьцаа эзэмшигчдийн эрх
- c) Хувьцаа эзэмшигчдийн шударга харьцаа
- d) Компанийн засаглал дахь хувьцаа эзэмшигчдийн үүрэг
- e) Нээлттэй, ил тод байдал
- f) Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлага гэсэн 6 үндсэн зарчим байна.

“Компанийн засаглалын зарчим”-д тусгасан хувьцаа эзэмшигчдийн эрх

a/ Хувьцаат компанийн удирдлагын зарчим нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэгдэх ёстой. Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх нь:

1. Өмчлөх эрхээ баталгаажуулах
2. Хувьцаа шилжүүлэх болон дамжуулах
3. Компанийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн болон чухал мэдээллүүдийг цаг алдалгүй тогтмол авах
4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх
5. Захирлуудын зөвлөлийг сонгох, өөрчлөх
6. Компанийн ашгаас ногдол ашиг авах

⁵⁸Principles of Corporate Governance. OECD, 2004.

б/ Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахуйц дараах шийдвэрүүдийг гаргахад оролцох, шаардлагатай мэдээллээр хангуулах эрхтэй. Үүнд:

1. Компанийн дүрэм, үүсгэн байгуулах гэрээ болон тэдгээртэй адилтгах, компанийн үйл ажиллагааг зохицуулах баримт бичигт өөрчлөлт болон нэмэлт оруулах
2. Нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл олгох
3. Их хэмжээний хэлцэл хийх, тухайлбал нийт актив хөрөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдах, энэ нь компанийг бүхэлд нь худалдахад хүргэж болзошгүй гэх мэт.

в/ Хувьцаа эзэмшигчид компанийн Хувьцаа эзэмшигчдийн Ерөнхий Хуралд⁵⁹ биечлэн оролцож санал өгөх, санал хураалтын дүрэм, журмын талаар мэдээлэл авах боломжтой байх. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдэд Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов, хуралдаан болох газар, хурлын хөтөлбөр хэлэлцэн шийдвэрлэх асуудлын талаарх бүрэн мэдээллийг цаг алдалгүй хүргэх
- Хувьцаа эзэмшигчид Захирлуудын зөвлөлөөс асуулт асуух, жилийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүнг хэлэлцэх, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд санал оруулах, хэлэлцсэн асуудлаар шийдвэрийн төсөл танилцуулах зэрэг боломжтой байх
- Захирлуудын зөвлөлд нэр дэвшүүлэх, сонгох зэрэг компанийн удирдлага, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрлэх зарим асуудлуудыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцох нь зүйтэй. Хувьцаа эзэмшигчид Захирлуудын зөвлөлийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шагнаж урамшуулах бодлогын асуудлаар саналаа хэлэх боломжтой байх. Захирлуудын зөвлөлийн гишүүд болон ажилтнуудыг шагнаж урамшуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх
- Хувьцаа эзэмшигчид саналаа өөрийн биеэр, эсхүл эчнээгээр өгөх боломжтой байх. Өөрийн биеэр болон эчнээ өгсөн саналын аль аль нь хүчин төгөлдөр байна.

г/ Хөрөнгийн бүтэц, тодорхой хувьцаа эзэмшигчид хяналтын багц эзэмшсэн, тэдгээрийн компанийн нийт хөрөнгөд эзэмшиж буй хувь хэмжээ үнэмлэхүй түвшинд хүрсэн зэрэг мэдээллүүдийг ил тод болгох шаардлагатай.

д/ Хөрөнгийн зах зээл, компанийн хяналтын үр ашигтай, ил тод механизмыг бий болгох

- Хөрөнгийн зах зээл дэх компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, их хэмжээний хэлцэл хийхтэй холбоотой дүрэм журам, үйл ажиллагааны процедурыг тодорхой, ил тод болгож хөрөнгө оруулагчдад өөрсдийн эрхээ мэдэж авах, эрхээ хамгаалуулах боломжийг олгох. Хэлцэл хийх процесс тэгш эрхийн зарчмаар, шударга үнээр, тухайн төрлийн хувьцааг эзэмшиж буй бүх хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг алагчлалгүй хангасан байдлаар хийгдэх ёстой.
- “Компанийг залгих”-аас хамгаалах механизмуудыг Компанийн удирдлага болон Захирлуудын зөвлөл ашиглаж болохгүй бөгөөд хариуцлагаас мултлах шалтгаан болохгүй.

е/ Бүх хувьцаа эзэмшигчид, түүн дотроо институциональ хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг хэрэгжүүлэх ёстой.

- Итгэмжлэлийн дагуу ажиллаж буй институциональ хөрөнгө оруулагчид компанийн удирдлагын бодлого, хөрөнгө оруулалтын асуудлаар санал хураалт, саналын эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмаа ил тод болгоно.

⁵⁹Хувьцаа эзэмшигчдийн Ерөнхий хурал буюу General shareholder meeting гэдгийг Хувьцаа эзэмшигчдийн Бүгд Хурал гэж ойлгоно уу

- Итгэмжлэлийн дагуу ажиллаж буй институциональ хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны явцад бий болж байгаа өмчлөх эрхэд нөлөөлөхүйц ашиг сонирхлын зөрчлийн асуудлаа ямар журмаар зохицуулдаг талаар мэдээлэл ёстой.

ё/ Бүх хувьцаа эзэмшигчид, түүн дотор институциональ хувьцаа эзэмшигчид өөрсдийн хууль ёсны эрхийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хоорондоо зөвлөлдөх нь зүй бус хохирлоос сэргийлэх нөхцөл болно.

“Компанийн засаглалын зарчим”-д тусгасан Хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш нөхцөл бүрдүүлэх зарчмууд

Компанийн удирдлагын систем нь жижиг хувьцаа эзэмшигчид болон гадаадын хувьцаа эзэмшигчдийг оруулаад бүх хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Эрх нь зөрчигдсөн тохиолдолд бүх хувьцаа эзэмшигч эрхээ бодитойгоор хамгаалуулах нөхцөл бүрдүүлэх ёстой. Үүнд:

а/ Ижил төрлийн хувьцаа эзэмшигч буй хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш эрх эдлүүлнэ:

- Нэг ангиллын, нэг төрлийн бүх хувьцаа ижил эрхтэй байна. Хувьцаа худалдан авахаасаа өмнө нэг ангиллын, нэг төрлийн хувьцаанд хөрөнгө оруулж буй этгээдүүд тухайн хувьцаагаар олгох эрхийн талаар жигд мэдээлэл авах боломжтой байх ёстой. Тухайн ангиллын хувьцааны саналын эрхэд оруулах өөрчлөлт нь хувьцаа эзэмшигчдэд сөргөөр нөлөөлөхгүй байх үүднээс тухайн бүлгийн хувьцаа эзэмшигчдээр зөвшөөрөгдсөн байх ёстой.
- Хяналтын багцыг шууд болон шууд бусаар эзэмшигч этгээдүүд ашиг сонирхол, эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт үйлдлээс жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах, эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд сэргээлгэх боломжоор хангагдсан байна.

Энэ зарчмын талаар OECD-ээс дараах тайлбарыг албан ёсоор гаргасан байна.

Ихэнх нээлттэй компаниуд Хяналтын багц эзэмшигч⁶⁰ буюу том хувьцаа эзэмшигчидтэй байдаг. Хяналтын багц эзэмшигчтэй байх нь компанийн удирдлагыг нягт хянаж, байгууллагын менежментийн мониторинг болон бусад асуудлыг дэмжих боловч, тухайн орны холбогдох хууль, журмын зохицуулалт сул байгаа тохиолдолд Хяналтын багц эзэмшигчид нь бусад хувьцаа эзэмшигчдийг дарамтлах, эрх мэдлээ урвуулан ашиглахад хүргэх магадлалтай.

Пирамид бүтэц, саналын олон тооны эрх зэрэг давуу байдлаа ашиглан Хяналтын багц эзэмших болон өмчлөх эрхээ өөрт ашигтайгаар урвуулан ашиглах замаар хяналтын багц эзэмшигчид компанийн удирдлагад хяналтаа тогтоож бусад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох, эрсдэлд оруулах магадлал өндөртэй гэж үздэг. Хяналтын багц эзэмшигч нь эрх мэдлээ урвуулан ашиглах байдал нь олон янзаар илэрнэ. Тухайлбал, компанид ажилладаг гэр бүлийн гишүүддээ ижил төрлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг бусад албан хаагчаас илүү өндөр цалин, урамшуулал өгөх замаар компанийн ашгаас хувьдаа завших, харилцагч байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилтэй худалдаа болон гүйлгээ хийх, бизнесийн шийдвэр гаргахдаа гажуудал гаргах, хяналтын багц хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлэн нэмэлт хувьцаа гарган хөрөнгийн бүтцийг өөрчлөх гэх мэтийн аргууд байна.

Иймд эдгээр эрсдэл буюу хяналтын хувьцаа эзэмшигчдийн зүгээс жижиг хувьцаа эзэмшигчдэд хор учруулах, эрх ашгийг нь зөрчихөөс хамгаалах нэг арга болгон Төлөөлөн

⁶⁰Controlling Shareholder

удирдах зөвлөлийн гишүүд нь компани болон бүх хувьцаа эзэмшигчдийн өмнө үнэнч, шударгаар ажиллах үүргийг тодорхой болгох нь чухал. Өөрөөр хэлбэл **жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хамгийн гол арга хэрэгсэл нь OECD-ын гишүүн болон гишүүн бус бусад орнуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагыг маш тодорхой хуульчлан тогтоох явдал бөгөөд ингэхдээ шударга ёсны зарчимд тулгуурлах нь зүйтэй**⁶¹ гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

Компанийн хуулийн эрх зүйн зохицуулалт султай орнуудад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчих, дарамтлах болон том хувьцаа эзэмшигчид өөрсдийн эрх мэдлийг урвуулан ашиглах явдал хамгийн их байдгийг OECD-ын судалгаагаар нотолсон байна. Иймд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалтыг улс орон бүр Үндэсний хууль тогтоомждоо баттай суулгах нь чухал юм.

- Кастодиан болон нэрлэсэн эзэмшигчийн санал хураалтад оролцох үйл ажиллагааг бодит хувьцаа эзэмшигчтэй зөвшилцсөн журмын дагуу хэрэгжүүлнэ
- Гадаадад байгаа хувьцаа эзэмшигч санал хураалтад оролцоход үүсэх саад бэрхшээлүүдийг арилгасан байх.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах журам, үйл ажиллагаа нь бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш харилцах боломжийг бий болгох. Санал хураалтын журам, ажиллагааг үндэслэлгүйгээр хүндрүүлэх, зардал чирэгдэл ихтэй болгож болохгүй.

б/ Компанийн дотоод мэдээллийг ашиглан, хувийн ашиг сонирхлын үүднээс хууль бус хэлцэл хийхийг хориглоно.

в/ Захирлуудын зөвлөлийн гишүүд болон голлох удирдах албан тушаалтнууд нь компанийн эрх ашигтай холбоотой ямар нэгэн асуудлаар шууд болон шууд бусаар, эсхүл гуравдагч этгээдтэй холбоотой ямар нэгэн ашиг сонирхол байгаа тухайгаа Захирлуудын зөвлөлд мэдээлнэ.

“Компанийн засаглалын зарчим”-д тусгасан хувьцаа эзэмшигчдийн үүргийн зарчмууд

Компанийн засаглалын бүтэц нь хууль тогтоомжоор олгогдсон хувьцаа эзэмшигчдийн эрх болон харилцан тохиролцсоны үндсэн дээр бий болсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэж, компани болон хувьцаа эзэмшигчдийн хооронд баялаг бүтээх, ажлын байр бий болгох, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн идэвхтэй хамтын ажиллагааг дэмжин ажиллана. Үүнд:

- а/ Хувьцаа эзэмшигчдийн хуулиар олгогдсон эрх болон харилцан тохиролцсоны үндсэн дээр бий болсон эрхийг хүндэтгэх
- б/ Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хуулиар хамгаалах ба хувьцаа эзэмшигчдийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломжийг бодитоор бүрдүүлэх шаардлагатай
- в/ Үр ашгийн механизмыг боловсронгуй болгоход албан хаагчдын оролцоог бий болгох.
- г/ Компанийн засаглалын үйл явцад хувьцаа эзэмшигчдийг оролцуулахын тулд байнгын болон цаг үеийн үнэн зөв, баталгаатай, шаардлагатай мэдээллээр хангана
- д/ Хувьцаа эзэмшигчид, компанийн ажилтан албан хаагчид, биет төлөөлөгчдийг чадваржуулах, хоорондоо нээлттэй харилцан ойлголцох, хууль бус, ёс зүйгүй байдлаас ангид байлгахын тулд ёс зүйн дүрэм журамтай байна

⁶¹OECD Principles of Corporate Governance, 2004. 42-р хуудас.

1.2. Судалгаанд хамрагдсан орнуудын туршлага, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн зохицуулалттай холбоотой харьцуулсан судалгааны үр дүн

Судалгаанд АНУ, Их Британи, ОХУ, БНТУ, ХБНГУ зэрэг 5 орны хувьцаат компанийн эрх зүйн харилцааг зохицуулсан дараах хуулиудыг ашиглав. Үүнд:

1. АНУ-ын “Делаверийн компанийн ерөнхий хууль” (The Delaware General Corporation law)
2. Их Британийн “Компанийн хууль” (Companies Act)
3. ХБНГУ-ын “Хувьцааны тухай хууль” (Aktiengesetz)
4. ОХУ-ын “Хувьцаат нийгэмлэгийн тухай хууль” (Закон об акционерных обществах)
5. БНТУ-ын “Худалдааны хууль” (Commercial law)

Эдгээр хуулиар захиалгад дурдсан асуудлуудыг хэрхэн зохицуулсаныг дор тоймлон харуулсан бөгөөд дэлгэрэнгүйг судалгааны тайлангаас үзнэ үү. /2, 3-р бүлэг/

Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмших эрхийн тухайд

Судалгаанд хамруулсан бүх орнуудад хувьцаа эзэмшигчдийн эрхийг олон улсын стандарт, өөрийн орны онцлогт нийцүүлэн тусгайлсан хуулиар зохицуулсан.

- АНУ-д хувьцаа эзэмшигчдийн нэг хувьцаа саналын нэг эрхтэй байх энгийн хувьцаа эзэмшигчдэд олгогдсон нийтлэг эрх нь компанийн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгоход санал өгөх (§109), өөрийн итгэмжлэчийг томилох (§212), хувьцааг худалдаж, худалдан авах (§151, §262, §159) зэрэг эрхтэй. Харин компани бусад компанитай нэгдэхийг нь эсэргүүцэж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шударга үнээр худалдан авах үүрэгтэй (§262).
- Их Британид хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх нь үндсэн 3 эрх болох саналын эрх, ногдол ашиг авах эрх, татан буугдахад компанийн эд хөрөнгөөс ногдол хувь авах эрхээс гадна мэдээлэл авах эрх буюу компанийн хувьцаа эзэмшигч нарт илгээсэн мэдээлэл, дансны болон тайлантай холбоотой мэдээллүүдийг хуулбарлан авах (§146), захирлын болон компанийн оны эцсийн тайлан, аудитын дүгнэлт зэргийг үнэ төлбөргүй гаргуулан авах (§431), хувьцаат компани хувийн компани болон өөрчлөн байгуулагдсан нөхцөлд тус шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах (§97), бүх гишүүдийн хурлыг зарлахыг шаардах (§303) зэргээр бусад эрхүүдийн хамт зохицуулсан байна. Английн компанийн тухай хуулиас харахад тус хууль нь эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарсан бүтцийн хувьд манай хууль тогтоомжтой адилгүй юм. Тухайлбал: манай хууль тогтоомжуудад аливаа эрх үүрэг, хариуцлагыг багцлан жагсаасан байдалтай хуулинд тусгадаг бол Английн уг хуулинд энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг нэг бүлэг, зүйлд суулгаж өгөлгүйгээр тухайн асуудал бүрийн хувьд тодорхойлдог байна.
- ОХУ-д Хувьцаат компанийн тухай хуулиар энгийн хувьцаа эзэмшигчид тэгш эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд өөрийн эрх мэдлийн хүрээний бүх асуудлуудад саналын эрхтэй оролцож, ногдол ашиг авах эрхтэй. Компанийн эзэмшиж буй хувьцааны хувиас шалтгаалж эзэмшигчдийн эрх нь ялгамжтай тогтоосон байна. Тухайлбал, хувьцааны 1 хувийг эзэмшиж байгаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд оролцох эрхтэй этгээдүүдийн нэрсийн жагсаалттай танилцах эрхтэй (§51.4) бол хувьцааны хувь нэмэгдэх тутам бүгд хурлын хэлэлцэх асуудалд асуудал оруулах, удирдах байгууллагад нэр дэвшүүлэх (§71.5, §53, §55, §83) гэх мэтээр эрх нь нэмэгдэж байна.

- Турк Улсын 2011 онд батлагдсан Худалдааны тухай хуулиар хувьцаа эзэмшигчид болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг Европын эрх зүйтэй адил нэлээд хэдэн чиглэлээр өргөжүүлсэн байна. Нэгдүгээрт, хувьцаа эзэмшигч болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийн агуулга, нөлөөллийг өргөжүүлсэн. Тухайлбал, актив болон пассив мэдээлэл авах эрх, зөвхөн жижиг хувьцаа эзэмшигч нарт олгосон тусгай хянах эрх, судлах эрх хамаарна. Хоёрдугаарт, хувьцаа эзэмшигчид олгосон нэг шинэ эрх нь нэхэмжлэх эрх юм. Өөрөөр хэлбэл, Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэх эрх, компанийн нэгдэх, тусгаарлах, салах зэрэг хэлбэрийг нь өөрчлөхтэй холбогдох шийдвэрийн эсрэг өгсөн хувьцаа эзэмшигч хувь нийлүүлэгчээс гарах эрх (компани хувьцаагаа худалдан авах шаардлага) бүхий шалтгаанаар компанийг татан буулгах. Жижиг хувьцаа эзэмшигчид олгосон шинэ эрх гэвэл жилийн тайланд хянагчийг, тусгай хянагч томилох, зөвлөлүүдэд гишүүн сонгох эрх юм. Мөн компанийн хувьцааны 90 болон 95 хүртэлх хувийг эзэмшигч нь ямар нэг шалтгаангүйгээр 5 хувь хүртэл жижиг хувьцаа эзэмшигчийг компаниас гаргах эрхтэй гэх мэт.
- ХБНГУ-д компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эрхтэй холбоотой асуудлыг бүлэглэсэн 7 заалт (§53а, §56.1, §56.2, §56.4, §57.1-3) бүхий эрхтэй байхаар заасан ба хувьцаа эзэмшигчдэд ижил нөхцөлд тэгш хандахыг зарчим болгож, хувьцааг батлан даах (underwriting) - тай холбоотой хязгаарлалтуудыг оруулсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийг хязгаарлах талаар

- АНУ-д хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа худалдах, шилжүүлэхэд хязгаарлалтуудыг түлхүү заасан бол ОХУ-д тухайн компани нь нэг хувьцаа эзэмшигчид ногдох хувьцааны тоо, түүний нийт нэрлэсэн хувьцааны үнэ, мөн нэг хувьцаа эзэмшигчид саналын эрхийн дээд хязгаарыг компанийн дүрмээр хязгаарлах, энэ нь бүх хувьцаа эзэмшигчдэд хамааралтай байдлаар зохицуулжээ.
- Харин Турк Улсад хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг хязгаарлахдаа хувьцаа эзэмшигч өөрөө, эсвэл түүний нөхөр /эхнэр/, үр хүүхэд, аав ээж, эсхүл тэдгээрийн хувь нийлүүлсэн компанитай, компани хооронд хувь хүний шинжтэй ажил хэрэг, үйл ажиллагаа эсхүл ямар нэг шүүх байгууллага, арбитраж нэхэмжлэлтэй холбогдох асуудлаар санал өгөхийг хязгаарладаг байна.
- ХБНГУ-д саналын эрхийг хувьцааны нэрлэсэн үнээр, ширхэгийн хувьцааны хувьд түүний тоогоор тодорхойлно. Хувьцааны төлбөрийг бүрэн гүйцэтгэснээр саналын эрх нээгдэх ба саналын эрх хэрэгжүүлэх хэлбэрийг дүрмээр тогтооно. Саналын эрхгүй болоход доорх нөхцөлүүдийг харгалзана.
 - (1) Тухайн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх (өөртэй нь холбоотой санхүүгийн тайланг хэлэлцэх) буюу өрийн бичгийг нь хүчингүй болгох (өөртэй нь холбоотой өр, зээлийн асуудлыг хэлэлцэх), эсвэл нийгэмлэгээс тухайн этгээдтэй холбоотой хариуцлага тооцох асуудлаар шийдвэр гаргахад өөрөө буюу өрөөлийг төлөөлж саналын эрх эдлэхгүй. Ингэж саналын эрхгүй болсон хувьцаануудыг бусад этгээд ч ашиглах боломжгүй.
 - (2) Нийгэмлэг, нийгэмлэгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) буюу Хяналтын Зөвлөл (ХЗ)-ийн, эсвэл хараат аж ахуйн нэгж (ААН)-ийн даалгавраар (шахалтаар) хувьцаа эзэмшигч санал өгөх үүрэг хүлээсэн бол аливаа гэрээ хэлцэл хүчингүй. Мөн ТУЗ буюу ХЗ-ийн саналаар санал өгөх үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл хүчингүй.

Хувьцаат компанийн хяналтын багц эзэмшигч этгээдийн бусад хувьцаа эзэмшигчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага

- АНУ-д хувьцаат компанийн хяналтын багц эзэмшигчийн үүрэгтэй холбоотой асуудлыг тус хуулиар нарийвчлан заагаагүй бөгөөд АНУ-ын хувьд үүнтэй

холбоотой асуудлууд нь Жишгийн эрх зүй буюу “case law”-д тулгуурладаг. Делаверийн компанийн хуулийн 253-р зүйлд тусгагдсан нэг заалт нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахтай холбоотойгоор охин компанийн хувьцааны 90-эс доошгүй хувийг эзэмшдэг тохиолдолд хамтарсан компани болж нэгдэх болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг мөнгөөр худалдан авахыг зөвшөөрдөг. Жижиг хувьцаа эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авах шаардлагагүй бөгөөд хувьцааг зах зээлийн боломжит үнээр худалдан авах үүрэг хүлээнэ. Жижиг хувьцаа эзэмшигчтэй тохиролцоо хийхгүй зөвхөн хувьцааны зах зээлийн үнээр худалдан авах үүрэгтэй. Жижиг хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын төлбөрийн чадвараас үл хамааран шударга бусаар ноогдол хувь өгөхгүй байхаас сэргийлсэн гэрээ хийх зохицуулалттай байна.

- ОХУ-ын хуулиар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг саналын эрхээр дамжуулан хамгаалдаг байна. Тухайлбал, Хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд оролцогчдын олонхын буюу 3/4 саналаар шийдвэрлэх (§49.4), Компанийн захирлуудын зөвлөлийн гишүүнийг сонгохдоо санал хураалтын кумулятив аргыг хэрэглэх (§66.4) гэх мэт. ОХУ-д 1-ээс доошгүй хувийн хувьцаа эзэмшигч нь компанид өөрийн үйл ажиллагаагаараа, эсхүл эс үйлдэхүйгээрээ хохирол учруулсан компанийн удирдлагад компанийн нэрийн өмнөөс гомдол гаргах (§71.5), 25-аас багагүй хувийн хувьцаа эзэмшигч нь санхүүгийн тайлан тооцооны баримт бичиг болон удирдлагын хурлын протоколтой танилцах (§91.1) эрхтэй.

Мөн 30-аас илүү хувийн хувьцаа (дараа нь 50 хувь, 75 хувь, 95 хувь) эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг тогтоосон үнээс доогуур үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй. (§84.2.1, §84.2.4, §84.7)

- ХБНГУ-д компанийн хувьцааны 25 хувь, 50 хувиас илүү хувийг эзэмшсэн, эсвэл буурсан, үгүй болсон бол хувь эзэмшигчдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдлийг нийгэмлэгийн хуудсаар хүргүүлнэ. Харин нийгэмлэгийн хувь хэмжээ бусад хөрөнгийн компанийн 25 хувиас давсан бол оролцоотой аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэнэ.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой бусад орнуудын туршлага

- АНУ-д жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн баримт бичгүүдийн нэг нь Сарбанэс-Окслийн хууль (Sarbanes-Oxley Act) юм. Энэ нь тодорхой нарийвчилсан зүйл заалтаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахаас илүү хуулийн зарчим нь өөрөө хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгсэл болж байна. Хуулинд нээлттэй хувьцаат компаниудын нягтлан бодох бүртгэлийг хянах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэвтрүүлэх, санхүүгийн тайлан бүртгэлийг сайжруулах шаардлагууд тавигдсан нь том, жижиг хувьцаа эзэмшигчдийн аль алиных нь эрх ашгийг хамгаалсан, тэднийг компанийн засаглалд хүчтэй байх үндэслэл болохоос гадна хөрөнгө оруулагчдыг татах арга хэрэгсэл болж байна.
- Их Британид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалахдаа Компанийн тухай хуулиар хувьцаа эзэмшигч нь компанийн өдөр тутмын ажил хэрэг, гарсан буюу гарах гэж байгаа аливаа шийдвэр нь өөрийн болон нийт гишүүдийн эсхүл зохих бүлэг хүмүүст шударга бус, эрх ашгийг нь хөндөж байна гэж үзвэл энэ талаар шүүхэд гомдол гаргаж болох талаарх эрхийг тус хуулийн 994-р зүйлд тусгасан байна. Мөн компанийн захирлын хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн талаар компанийн нэрийн өмнөөс шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг байна.

- ХБНГУ-д жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалахтай холбоотой заалтуудад бүх гишүүдийн хурлыг цөөнхийн шаардсанаар зарлаж болох ба ингэхдээ:
 - (1) Хэрэв үндсэн хөрөнгийн 1/20-ийг нийлээд эзэмших хувьцаа эзэмшигчид шаардсан бол бүх гишүүдийн хурлыг зарлана.
 - (2) Нийлээд үндсэн хөрөнгийн 1/20 буюу 500.000 еврогийн хувь хэмжээ эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн шаардсанаар бүх гишүүдийн шийдвэртэй холбоотой зүйлийг танилцуулж болно.
 - (3) Нийлээд үндсэн хөрөнгийн 10 хувь эзэмших цөөнх бүх гишүүдийн хурал дээр хяналтын зөвлөлийн сонгуульд нэр дэвшүүлэх бол түүнийг санал хураалтаар шийдвэрлэнэ.
- Турк Улсад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн тогтолцооны төвд тусгай хянагч томилох эрх оруулсан. Учир нь тусгай хянагчийн илтгэл нь хариуцлагатай холбогдох нэхэмжлэл гаргах замыг нээх боломжтой. Тайлангийн хэлэлцүүлгийг хойшлуулж болно. Нөгөө талаас тусгай хянагч ажиллуулах механизм байхгүй бол жижиг хувьцаа эзэмшигчийн эрх зөрчигдөж, хүлээж байсан ашгаа авахгүй байх магадлалтай. Хянагч нарыг шүүхээс сонгох боломжтой, компанийг татан буулгахыг шаардах, санхүүгийн тайланг судалж байгаа хянагчийг үндэслэл байгаа болон, хараат бус байдлаа алдсан гэж үзвэл жижиг хувьцаа эзэмшигч түүнийг үүрэгт ажлаас нь халах, түүнчлэн шинэ хянагч томилохыг нэхэмжлэх эрхтэй. Компанийн хөрөнгийн 1/10-ийг төлөөлж байгаа хувьцаа эзэмшигчдэд олгосон эрх:
 - Удирдах зөвлөлийн гишүүн, хянагчийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй.
 - Балансын асуудлыг хойшлуулах эрхтэй. (1 сар хүртэлх хугацаагаар)
 - Тусгай хянагчийг томилох, хянагч нарт гомдол гаргах, шаардлагатай гэж үзвэл хянагч уг асуудлыг судалж үзээд тухайн гомдлын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд асуудал оруулах эрхтэй.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох талаарх хуулийн зохицуулалт

- АНУ-ын Дэлаверийн Компанийн ерөнхий хуулийн 216-р зүйлээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болохдоо хурлаар хэлэлцэх асуудлаа 2 хувааж, мөн шийдвэр гаргах хэлбэрийг 2 ангилсан байна. Үүнд:
 - 1. Хурлаар хэлэлцэх асуудлыг
 - төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад бүх асуудал
 - төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудал
 - 2. Шийдвэр гаргах хэлбэр нь
 - 51 хувийн саналаар шийдвэр гаргах
 - Хамгийн олон саналаар шийдвэр гаргах ба хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь олонхын саналаар гардаг юм байна.
- Их Британид компанийн тухай хуулийн 282, 283-р зүйлд зааснаар компанийн гишүүдийн хурлын шийдвэр нь энгийн болон тусгай гэсэн 2 төрлөөр гардаг. Энгийн шийдвэр нь компанийн гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэрлэгддэг бол тусгай шийдвэр нь 75-аас доошгүй хувийн саналаар шийдвэрлэгдэнэ.
- Тусгай шийдвэр гэдэг нь Компанийн тухай хуулийн 283-р зүйлд зааснаар 75 хувиас доошгүй олонхын саналаар шийдвэрлэгдсэн шийдвэрийг хэлнэ. Хувийн компанийн тухайд тус шийдвэр нь тусгай шийдвэр байна хэмээн заасан бол 75 хувиас багагүй саналаар шийдвэрлэнэ. Бичгээр гарсан шийдвэр нь тусгай шийдвэр байхаар заагаагүй бол энгийн шийдвэр байна.

- ОХУ-д хурлын шийдвэр нь хуралд оролцогсдын 3/4-ийн саналаар шийдвэрлэгддэг байна.
- Турк Улсад тухайн компанийн хөрөнгийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа гишүүд хүрэлцэн ирж, тэдгээрийн олонхын саналаар шийдвэрлэгдсэн шийдвэр хүчин төгөлдөрт тооцогдоно.
- ХБНГУ-д үндсэн хөрөнгийн 3/4-аас дээш хувь эзэмшиж буй олонхын саналаар Бүх гишүүдийн хурал (БГХ)-ыг зохион байгуулна. БГХ-аас гарсан шийдвэр бүрийг нотариатаар баталгаажуулж, түүнийг аж ахуйн нэгжийн бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ. Хууль буюу дүрмээр илүү олонхын санал, нөхцөлийн тусгайлан заагаагүй бол хурлын шийдвэр хураагдсан саналын энгийн олонхоор гарна. Сонгуультай холбоотой асуудлаар дүрмээр өөр зохицуулалт хийж болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох хуулийн зохицуулалт

- АНУ-д хувьцаа эзэмшигчдээр шийдвэрлүүлэх тодорхой асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай саналын хувьтай холбоотой асуудлын хувьд хувьцаа гаргах эрхтэй аливаа компанийн үүсгэн байгуулагдсаны гэрчилгээ эсвэл дүрэмд саналын эрхтэй хувьцаа буюу бусад төрлийн үнэт цаасны тоог зааж болох бөгөөд тэдгээрийн эзэмшигчид нь аливаа хуралд өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож, хурлын ирц болон шийдвэрлэх асуудлын саналын хувийг бүрдүүлэх боловч хурлын ирц нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 1/3-ээс доошгүй хувиас бүрдэх бөгөөд өөр төрөл, ангиллын хувьцаа эзэмшигчдийн саналыг тусад нь авах шаардлагатай болох тохиолдолд тухайн ангилал, төрлийн хувьцаа эзэмшигчдийн 1/3-ээс доошгүй хувь хүрэлцэн ирснээр ирц бүрдэнэ (Делаверийн компанийн хууль, §216, §216(1)).
- Их Британид хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг компанийн тухай хуулийн 318-р зүйлд заахдаа компанийн дүрмээр зохицуулахаар тусгасан байна.
- ОХУ-д Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүгд хурал нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн талаас илүү хувь нь хуралд оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- Турк улсад хувьцаа эзэмшигчдийн хурал болон гэрээнд хүндрүүлсэн нөхцөл заагаагүй бол компанийн хөрөнгийн 1/4-ийг эзэмшиж байгаа гишүүд ирсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал ирц бүрдсэн (§418) гэж үзэж хуралдана. Гэхдээ хуралдааны туршид 1/4 гэсэн тоог хадгална. Эхний удаагийн хуралд 1/4 гэсэн ирц бүрдээгүй тохиолдолд дараагийн хурлыг хийхэд 1/4 гэсэн ирцийн хязгаарлалт тавихгүй. Уг хуралдаанд ирсэн гишүүдийн олонхын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэнэ.
 - Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахдаа хөрөнгийн 50-иас доошгүй хувийг эзэмшигчид хуралд оролцсоноор ирц бүрдсэнд тооцож, олонхын саналаар шийдвэрлэнэ. Эхний хурлын ирц бүрдээгүй бол 2 дахь хурлын ирцийг 1/3 болгоно. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, нэрийн хувийг бусдад дамжуулах асуудлыг 75 хувийн ирцтэйгээр шийдвэрлэнэ. Бусад асуудлуудын хувьд 1/4 гэснээр шийдвэрлэнэ.

Хоёр. ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

2.1. Олон улсын компанийн засаглалын загварууд ба онцлог

Хувьцаат компанийн өмчлөлийн бүтэц, хувьцааны төвлөрлийн хэмжээ, санхүүгийн зах зээл болон компанийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин болон үндэсний хөрөнгийн зах зээлийн хөгжлийн онцлогоос шалтгаалан компанийн засаглалын систем орон бүрд өөр өөр түвшинд бүрэлдэн бий болж байна.

Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн практикт компанийн засаглалын уламжлалт 2 загвар зохицуулалт хадгалагддаг. Үүнд:

1. **Англо-америкийн загвар.** Онцлог нь - хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол, хяналтын механизмыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан хэрэгжүүлдэг.
2. **Эх газрын загвар.** Банкуудын оролцоо, хяналтын механизм голлох үүрэгтэй. Банк болон түүнийг төлөөлж байгаа захирлын зөвлөлийн гишүүний компанийн удирдлагад гүйцэтгэх үүрэг өндөр.

Үүнээс гадна уламжлалт, үндэсний болон орчин үеийн зохицуулалтын арга, хэлбэрүүд даяаршил ба шинжлэх ухаан, технологийн хөгжлийн нөлөөгөөр холимог загварыг бий болгож байна. Жишээ нь, **Германы загвараас үзэхэд, хувьцаа эзэмшигчид компанийн стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй** оролцох ба компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын ашиг сонирхол, үүрэг хариуцлагыг тэнцвэртэй хадгалахад голлон анхаардаг. **Тэгвэл англо-америкийн загвар бүхий орнуудад гол анхаарлыг хувьцаа эзэмшигчдийн санхүүгийн ашиг сонирхлыг хангахад чиглүүлдэг.** Америкийн загвар илүү динамик шинжтэй бол Германых тогтвортой байдлаараа ялгардаг. **Японы загварын хувьд компанийн түвшинд нийгмийн үүрэг хариуцлага, тухайн салбарынхаа хувьд ажил, хэргийн үүрэг, хариуцлагыг** голлон анхаардаг.

ОХУ-ын хувьд компанийг өмчлөх болон удирдах эрхийг нэгэн зэрэг хэрэгжүүлэх сонирхол давамгайлсан “инсайдер” загвар бүрдэж байна гэж судлаачид үздэг.

Хувьцаа эзэмшигчдийн бүх гишүүдийн хурал дээр шийдвэрлэх *хамгийн гол асуудлууд бол компанийг өөрчлөн байгуулах, нэгтгэх, үнэт цаас гаргах, компанийн удирдлагыг томилох, их хэмжээний хэлцэл хийх, мэдээлэл авахтай* холбоотой асуудлууд байдаг.

Компанийн засаглалын удирдлагын зарчим нь Захирлуудын зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн өмнө, менежерүүд нь Захирлуудын зөвлөлийн өмнө, том хувьцаа эзэмшигчид нь жижиг хувьцаа эзэмшигчдийн өмнө, компани нь ажилтнууд болон худалдан авагч, нийгмийн өмнө хариуцлага хүлээж, ажлаа тайлагнадаг байхаар зохицуулагдах ёстой. Хамгийн гол зарчим бол эдгээр субъектүүд харилцан бие биенийхээ ашиг сонирхол, эрх ашгийг дээд зэргээр хангаж ажиллах явдал юм.

Хувьцааны тодорхой хэсгийг /багц/ эзэмшигч бүрийн эдлэх эрх, хүлээх үүрэг нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны саналын эрхийн тоо, нийт хувьцаанд эзэлж буй хувь хэмжээнээс хамааран өөр өөр байдаг байна. Жишээ нь, ОХУ-ын хуулиар:

- | | |
|-----|--|
| 1% | хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй танилцах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрх |
| 2% | хувьцаа эзэмшигчдийн бүх гишүүдийн хуралд хэлэлцэх асуудлаар санал гаргах, удирдлагад нэр дэвшүүлэх, хэлэлцэн батлах эрх |
| 10% | ээлжит бус хурал зарлан хуралдуулах эрх |
| 25% | блоклок эрхтэй багц, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон |

- компанийн удирдах байгууллагын хурлын протокол, бусад бичиг баримттай танилцах эрх;
- 75% Компани хувьцаа гаргах, хувьцаагаа эргүүлэн худалдан авах, хувьцааны төрөл, тоо хэмжээ, олгогдох эрхийг тогтоох, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, компанийг татан буулгах, өөрчлөн байгуулах эрх;
- 100% Хувьцаа эзэмшигчдийн хурлыг товлон эсэх.

Эдгээр бүх механизм, арга хэрэгслүүд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, ногдол ашгийн бус аргаар компанийн менежерүүд болон том хувьцаа эзэмшигчид компанийн ашгаас хувьдаа завших (трансфертное ценообразование)-аас сэргийлэх ач холбогдолтой. Мөн өөр нэг арга бол хөрөнгийн зах зээлийн боломжийг ашиглах явдал юм. Хувьцаа эзэмшигчдэд хэрвээ компанийн удирдлагын үйл ажиллагаа эргэлзээ төрүүлж, ашиг орлогогүй санагдвал хувьцаагаа зарах эрх нь нээлттэй байдаг (рынок корпоративного контроля). Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байна гэдэг нь тухайн компанийн хувьцааны зах зээлийн үнийг бууруулан тогтоох ба цагаан рейдерүүдэд хувьцааны үнийн өсөлт, бууралтан дээр ажиллах боломжийг гаргаж өгч байдаг юм (рейдерства).

Англо-америкийн загвар бүхий компанийн засаглалтай орнуудад эрх зүйн дараах механизмуудыг ашиглаж байна. Үүнд:

- Компанийн баримт бичгүүдээр ихэнх харилцааг албажуулах, зарим нэг том компаниуд бие даасан засаглалын кодекс батлах,
- Захирлуудын зөвлөлд жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг оруулах (үйлдвэрчин гэх мэтийн ашиг сонирхлоороо нэгдсэн төлөөллөөс оруулах)
- Менежерүүд нь Захирлуудын зөвлөлийн өмнө, Захирлуудын зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн өмнө ажлаа бүрэн хариуцаж тайлагнадаг байх,
- Өдөр тутмын үйл ажиллагаанаас бусад чухал асуудлуудыг Захирлуудын зөвлөл болон ХЭХ-аар хэлэлцдэг байх,
- Ашиг сонирхлын зөрчил, хуйвалдаанаас сэргийлэх үүднээс хараат бус захирлаар компанийн менежмент, хувьцаа эзэмшигчдээс ангид мэргэжлийн хүнийг томилох,
- Хувийн ашиг сонирхол үүссэн үед тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх,
- Захирлыг менежерүүдээс хараат бус ажиллуулахын тулд ТУЗ цалин хангамжийг нь тогтоож өгөх,
- Хянагч болон хяналтад хамагдаж буй субъектүүдыг аль болох бие биеэс нь ангид байлгах. Санхүүгийн тайлан, аудитын дүнг захирлуудын зөвлөлөөр бус ТУЗ-ээр хэлэлцдэг байх,
- Компанийн санхүүгийн үйл ажиллагааны таларх мэдээллийг аль болох нээлттэй, ил тод байлгах, хэвлэн нийтэлдэг байх, менежмент болон том хувьцаа эзэмшигчдийн хооронд ашиг сонирхлын нэгдэл байхгүй гэдгийг нотлох, гэх мэт.

Компанийн засаглалын зарчмуудыг нээлттэй, шударгаар ашиглаж байгаа компаниудын хувьд хөрөнгө оруулалт татах (инвестиций IPO) боломж нэмэгдэж эрсдэл буурдаг.

Хөгжиж байгаа орнуудын хувьд компанийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх явдал туйлын чухал. Яагаад гэвэл олон улсын хөрөнгө оруулагчид эдгээр орнуудыг сонирхож хөрөнгө оруулах магадлал нэмэгдэж байгаа энэ үед компанийн ил тод байдал, шударга үйл ажиллагаа чухал гэдэг нь ойлгомжтой. Судалгаанаас үзэхэд, Арабын орнууд, Латин Америкийн орнууд, Турк, ОХУ, Малайз, Индонез гэх мэтийн орнуудад компанийн засаглалын эрх зүйн зохицуулалт харьцангуй сайн, энэ хэмжээгээр компаниудынх нь хөрөнгийн зах зээл дээрх үнэлгээ нийт зах зээлийн дунджаас өндөр байгаа нь харагдаж байна.

ОХУ-д төлөвшиж байгаа «инсайдерская модель корпоративного управления» загвар бол ерөнхийдөө шүүмжлэлтэй хандах асуудал. Өөрөөр хэлбэл, том хувьцаа эзэмшигчид компанийн менежментийг гартаа авснаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хөсөрдүүлэх боломж бүрдсэн гэж судлаачид үзэж байна. Энэхүү загварын онцлог нь:

- Компанийн өмчлөл болон удирдлага нэг гарт төвлөрсөн учраас хувийн компанийн адилаар нээлттэй хувьцаат компаниудыг ажиллуулж байна
- Компанийн менежментэд тавих хяналтын механизм сул. Том хувьцаа эзэмшигчид нь менежерүүдтэйгээ хуйвалдах, ашиг сонирхлоороо нэгдэх боломж бүрдсэн
- Ногдол ашгийн бус аргаар ашиг олох, хөрөнгө, орлогыг завших боломж бүрдсэн
- Компанийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй
- Ёс зүйн зөрчилтэй, хууль зөрчсөн аргуудыг ихээхэн ашигладаг хувьцааны багцыг угаах, актив хөрөнгө зувчуулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулахгүй байх, хувьцааг нь барьцаалах гэх мэтийн хууль бус аргуудыг хэрэглэдэг

Ер нь төр засгийн зүгээс бизнесийн эрүүл саруул орчин бүрдүүлж, бодлогын хувьд дэмжихгүй байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, компаниудын засаглалын хэм хэмжээ алдагдах боломж бүрддэг нь судалгаанаас үзэхэд тодорхой байна. хөгжиж байгаа зарим орнуудын хувьд, ялангуяа Монгол Улсад зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирох бус том хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг шүүх, хүчний байгууллагын оролцоотой үйлдлүүдийн үр дүнд хохирох нөхцөл бодитойгоор бүрдсэн байна.

2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой судалгааны мэдээлэл, дүн шинжилгээ

а/ Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг зохицуулсан байдал

Өндөр хөгжилтэй орнуудын эрх зүйн системд хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн харилцааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулсан байна. Ихэнх орнуудад Хувьцаат компанийн хуулиас гадна, тусгайлсан хуультай байна. Тухайлбал, Францад Худалдааны нөхөрлөлийн тухай хууль (1965), Германд Хувьцаат нийгэмлэгийн тухай хууль (1965), Их Британид Компанийн тухайн хууль (2006), АНУ-д муж тус бүрийн Компанийн хууль, Швейцарт Үүргийн хууль, Японд 1951 оны хууль, Италид Иргэний хуулиар энэ харилцааг зохицуулсан байх жишээтэй.

1996 оны эцэс гэхэд ОХУ, Монгол Улс, Армен, Латви, Литва, Молдав, Тажикстан гэх мэтийн хуучин социалист дэглэмтэй байсан орнууд Хувьцаат компанийн тухай бие даасан хуультай болсон. Шилжилтийн эдийн засагтай эдгээр орнуудын хуулиуд нь Роман-Германы зохицуулалтын зарчмыг үндсэндээ хадгалсан гэж судлаачид үздэг. Эдгээр орнуудын ХК-ийн тухай хуулийн агуулгад хийсэн шинжилгээний дүнгээс дараах дүгнэлтүүдийг судлаачид хийсэн байна. (2000-аад оны эхээр олон улсын нэр бүхий судлаачид, хуульчид хувьцаа эзэмшигчдийн эрхийн зохицуулалт, компанийн засаглалын байдал нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн ба ингэхдээ тусгай аргачлал боловсруулан ашиглаж, дүгнэлт зөвлөмж гаргасан байна.)

**Хүснэгт 1. Шилжилтийн эдийн засагтай зарим орны хувьцаат компанийн
эрх зүйн зохицуулалтад тусгасан стандарт элементүүд**

	<i>Чех</i>	<i>Унгар</i>	<i>Болгар</i>	<i>Польш</i>	<i>Румын</i>
(1) Шийдвэр гаргах бүрэн эрхийг тодорхой заагласан	сайн	сайн	сул	сайн	сул
(2) Удирдлагын бүтэц (2 шатлалт - гүйцэтгэх удирдлага ба захирлуудын зөвлөл)	2 шатлалт	2 шатлалт	ХЭ-ийн шийдвэрээр	Дүрмийн сан нь 0,5 сая злотоос дээш 2 шатлалт	ХЭ-ийн шийдвэрээр
(3) Захирлуудыг томилох (Санал өгсөн гишүүдийн тоо)	50% дээш	50% дээш	50% дээш	Хуульчлаагүй, зарим үед том ХЭ	ТУЗ-ын эрхийн асуудал
(4) Захирлуудыг сэлгэх	50% дээш	50% дээш	50% дээш	50% дээш	50% дээш
(5) Саналын эрхийг хянах (итгэмжлэлээр оролцох)	+	+	+	+	+
(6) Мэдээллийг ил тод болгох журам ба аудит	Сул	Өндөр стандарт	Сул	Өндөр стандарт (близки ЕС)	Сул
(а) хувьцаа худалдан авах давуу эрх	+	+	+	+	н.д.*
(б) чухал шийдвэр гаргахад мэргэшсэн хүмүүс	66%	75%	Дүрмийн сангийн 2/3	50%, 2/3, 3/4, 4/5	Ирцийн 75%-ийн 2/3
(в) Компанийг залгих (нэгтгэх) журам	-	+	-	н.д.	н.д.
(г) кумулятив санал хураалт	н.д.	н.д.	н.д.	+	н.д.
(д) 1 хувьцаа эзэмшигчийн саналын хязгаар	Байж болно	Байж болно	н.у.	Байж болно	Байж болно
(8) Ажиглагчдын зөвлөлд ажилтнуудаас оруулах	50 дээш ажилтантай дээш бол 1/3-1/2	200 дээш ажилтантай бол 1/3	н.у.	н.у.	н.у.
(9) хурлын ирцийн доод хязгаар	30%	50% дээш	Дүрмээр	н.у.	50%
(10) 1 хувьцаанд оногдох саналын эрх	1	Хязгаарлахгүй	1	1 - 5	1
(11) Хэм хэмжээг заавал гүйцэтгэх журмаар биелүүлэх (enforcement)	сул	сул	сул	сул	сул

* н.д. - мэдээлэл байхгүй, н.у. - хуулинд тусгаагүй

Хууль хэрэгжүүлэх процесс талаас нь авч үзвэл, хувьцаат капиталын дүнд томоохон өмчлөгчдийн хувийн жин хэдий чинээ их байна, хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалт төдий чинээн доогуур байна гэсэн дүгнэлтийг судлаачид хийсэн. Жишээ нь, Германы эрх зүйн загвар буюу хяналтын багц эзэмшигч давамгайлсан орнуудад (ОХУ, Төв Европын орнууд, хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд) хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудал англо-америкийн загвар бүхий эрх зүйн системтэй орнууд (хувьцаат капиталын илүү жижиглэсэн бүтэцтэй)-аас үргэлж доогуур байдаг гэж үздэг. Энэхүү дүгнэлтийг судлаачид доорх хүснэгтээр баталгаажуулсан байна.

Хүснэгт 2. Компанийн засаглалын түвшин ба үнэт цаасны зах зээлийн хөгжлийн хамаарал

Нийт капиталд томоохон хувьцаа эзэмшигчийн эзлэх хувь	Нийт рейтинг					
	<10	11-12	13-14	15-16	17-18	19-20
> 15-30			Тайвань, Өмнөд Солонгос		Япон	АНУ, Их Британи, Австрали, Швед
> 30-45			Пакистан	Энэтхэг, Ирланд, Франц	Дани, Нидерланд, Чили, Швейцар	Канад, Норвеги, Финлянд
> 45-50		Тайланд		Герман		Шинэ Зеланд, Сингапур
> 50-55	Венесуэл	Бельги, Зимбабве, Өмнөд Африкийн БНУ	Аргентин, Малайз, ОХУ	Хонконг, Израиль, Испани, Португал		
> 55-60	Индонез, Турк	Бразил, Перу, Шри-Ланк	Итали	Австри, Филиппин		
> 60-65	Египет, Мексик	Колумб	Грек			

Доорх хүснэгтэд жишээ болгон америкийн хуульчдын хөгжиж буй эдийн засагтай 17 орны Компанийн тухай хуулийн зохицуулалтын зарим нэг аспектийн хүрээнд хийсэн түүвэр судалгааны үр дүнг харуулсан байна. Загварыг ангилахдаа хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд шууд хориглосон, эсхүл тусгай журмаар зохицуулах шаардлага тавьсан гэж 2 ангилсан. Судалгаанд хамрагдсан орнуудыг дараах байдлаар ангилсан:

- *Зөвшөөрөх загвар* - Өмнөд Африк (1973, хуулийн зохицуулалт нь АНУ-ын Делавер мужаас арай илүү чанга байсан).
- *Хориглох загвар* - Польш (1991), Унгар (1988), Турк (1956).
- *Хэсэгчилсэн байдлаар хангалттай зохицуулсан загвар* - хэдийгээр зарим нэгэн шууд хориглох заалт байдаг ч хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах журмыг хуулиар нарийвчлан тогтоосон (Малайз, Сингапур, Нигер, Энэтхэг, Мексик, Чили, Египет).
- *Холимог загвар* - Үүнд хориглолт болон журмын зарим хязгаарлалттай - Хятад (1994), Аргентин (1988), Бразил (1991), Өмнөд Солонгос (1984), Индонез (1995), Чех (1992).

**Хүснэгт 3. Зарим орны Корпорацийн хууль эрх зүйн актуудаар зохицуулсан
процедурын шаардлага ба хориглолт /загваруудын харьцуулалт/**

<i>Шууд хориглолт</i>	<i>Зөвшөөрөгдөх загвар: ӨАБНУ, 1973</i>	<i>Хориглох загвар: Польш, 1991</i>	<i>Хэсэгчлэн зөвшөөрөх загвар: Энэтхэг, 1956</i>	<i>Холимог загвар: Аргентин, 1988</i>
Гаргаагүй боловч байршуулсан хувьцаанд тавих хориг	O	X	O	O
Хувьцааг нэрлэсэн үнээр зах зээлд гаргах шаардлага	O	O	O	O
Дүрмийн сангийн доод хэмжээнд тавих шаардлага	O	X	O	X
Өрийн бичиг болон давуу эрхийн хувьцаа гаргахыг хязгаарлах .	O	X	O	O
Зах зээлд гаргасан хувьцааг худалдан авахыг хориглох	X	X	X	X
Компанийн захирал болон бусад албан тушаалтнуудтай хэлцэл хийхийг хориглох	O	X	O	O
Охин компани нь толгой компанийн хувьцааг худалдан авахыг хориглох	X	-	X	X
БҮГД	2	5	2	3

<i>Процедурын шаардлага</i>	<i>Зөвшөөрөгдөх загвар: ӨАБНУ, 1973</i>	<i>Хориглох загвар: Польш, 1991</i>	<i>Хэсэгчлэн зөвшөөрөх загвар: Энэтхэг, 1956</i>	<i>Холимог загвар: Аргентин, 1988</i>
Санал хураалтын зарчим: 1 энгийн хувьцаа 1 саналын эрх	O	O	X	O
Захирлуудын зөвлөл дахь пропорциональ төлөөлөл	O	O	O	O
Ямар нэгэн үндэслэл шаардахгүйгээр захирлыг хугацаанаас нь өмнө өөрчлөх	X	X	X	X
ХЭ-ийг захирлуудтай хэлцэл хийхийг дэмжих	O	O	O	O
Дийлэнх олонхын саналаар хэлцэл хийхийг зөвшөөрөх	X	X	X	X
Компанийг өөрчлөн байгуулах, бүх активийг зарах үед хувьцааг бүрэн эргүүлэн авахыг шаардах	X	O	X	X
Их хэмжээний хөрөнгө худалдан авахад хувьцаа эзэмшигчдээр шийдвэр гаргуулах	O	X	X	O
Их хэмжээний энгийн хувьцаа гаргахад ХЭХ-аас шийдвэр гаргуулах	O	X	O	O
Давуу эрхтэй байх нөхцөлийг шаардах	O	X	X	X
Жижиг хувьцаа эзэмшигчийн хувьцаагаа худалдах боломж	O	O	O	O
Нууц санал хураалт	O	O	O	O
Бүгд	3	5	6	4

Судалгаанаас үзэхэд, шууд хориглолт нэлээд түгээмэл байна /12 оронд/. Эдгээрээс хамгийн түгээмэл нь компани өөрийн гаргасан хувьцаагаа худалдан авах, бонд болон давуу эрхийн хувьцаа гаргахыг хориглох, охин компани нь толгой компанийхаа хувьцааг эзэмшихийг хориглосон заалтууд түгээмэл байна. Зөвхөн 3 орны хувьд гаргаагүй боловч зөвшөөрөгдсөн хувьцаагаа худалдан авах, 2 оронд инсайдер хэлцэл хийхийг хориглосон байна. Аль ч оронд хувьцааны нэрлэсэн үнэ нь хувьцааны гаргасан үнэтэйгээ тэнцүү байна гэсэн тодорхойлолт байхгүй.

Хамгийн өргөн тавигдаж байгаа шаардлага бол компанийн амин чухал асуудал буюу компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, нэмэлт хөрөнгө оруулалт татах асуудалд хамаарч байна. Судалгаанд авагдсан 17 оронд энэ төрлийн тусгайлсан зохицуулалт нь ижил байх ба шийдвэр гаргахад шаардагдах кворум, саналын олонх гэсэн зохицуулалт нь өөр өөр байна. 15 оронд захирлуудын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө хязгаарлаж болохоор зохицуулсан байна.

Нийт 11 орны хуулиар компанийг өөрчлөн байгуулах болон актив хөрөнгийг нь зарж үрэх тухай хурлын үйлдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд өөрийн эзэмшиж буй хувьцаагаа зах зээлийн үнээр худалдан авахыг том хувьцаа эзэмшигчдээс шаардах эрхийг хуульчилсан байна. Мөн компани нэмж хувьцаа гаргах тохиолдолд эхний ээлжинд хувьцаа эзэмшигчиддээ санал болгох эрхийг хуульчилсан.

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тухайд:

Хувьцаа эзэмшигчдийн хувьд хамгийн чухал эрх бол саналын эрх юм. Хувьцаат компани (ХК)-д хөрөнгө оруулж хувьцаа эзэмшсэнээр хувьцаа эзэмшигч хамгийн гол нь ашгаас хувь хүртэх зорилготой. Мэдээжийн хэрэг компанийг ашигтай ажиллуулах зорилгодоо хүрэхийн тулд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, компанийн бодлого, стратегийг тодорхойлох, үйл ажиллагаанд нь хяналт тавих шаардлага бий болно. ХК-ийг удирдах дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Хувьцаа эзэмшигчид компанийн удирдлагад оролцох эрхээ дараах байдлаар хэрэгжинэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэх саналын эрх
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахыг шаардах эрх
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргахад оролцох
- ХК-ийг удирдах байгууллага /ТУЗ, Захирлуудын зөвлөл/-д сонгогдох эрх

Судлаачдын үзэж байгаагаар, хувьцаа эзэмшигчид компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох хамгийн том эрх бол саналын эрх бөгөөд энэ эрхээ зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр л эдэлнэ. “Том ч байна уу, жижиг ч байна уу, ямар ч хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг хязгаарлаж болохгүй, ингэснээрээ тухайн хувьцаа эзэмшигчийн амин чухал эрхийг үгүйсгэж, өмчлөх эрх төдийгүй шийдвэр гаргах эрхийг нь хязгаарласан бүдүүлэг алдаа болно” гэж ОХУ-ын эрдэмтэн И.Т.Тарасов бичжээ.

Хувьсгалаас өмнөх Орос оронд зарим хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг хязгаарлаж байсан түүх бий. Тухайлбал Хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн том хувьцаа эзэмшигчид саналын эрхтэй оролцож, жижиг хувьцаа эзэмшигчид зөвхөн хуралд оролцох, саналаа хэлэх эрхтэй байсан байна. Гэхдээ хуулиар жижиг хувьцаа эзэмшигчид итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаагаа нэгтгэж санал өгөх боломжтой байсан байна.

Бусад орнуудын хувьцаа эзэмшигчийн саналын эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын онцлог

Дэлхийн ихэнх орнуудын орчин үеийн хуулийн практикт бүх хувьцаа эзэмшигчид саналын эрхтэй байхаар хуульчилсан. Германы хуулиар (1965), Хувьцаат компанийн бүх хувьцаа эзэмшигч саналын эрхтэй бөгөөд аль нэгэн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг хязгаарлахыг хуулиар хориглосон байдаг. БНХАУ-ын хуулиар (1993), дээрх зохицуулалтаас гадна "1 хувьцаа 1 саналын эрхтэй байна" гэж санал хураах зарчмыг тодорхойлж өгсөн. Их Британийн хуулиар, хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй холбоотой асуудлыг нэлээд төвөгтэй байдлаар зохицуулсан байна. Тухайлбал, ерөнхийдөө хуулиар хувьцаа эзэмшигч бүр хэр том багц эзэмшиж байгаагаасаа үл хамааран 1 саналын эрхтэй байх боловч компани болгон өөрийнхөө дүрмээр санал хураах зарчмаа өөрөөр тогтоож болохоор хуульчилсан. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тооноос хамааруулан саналын эрхийн тоог тогтоож болох ба зарим хувьцааг саналын эрхгүй байхаар ч тогтоож болохоор хуульчилсан байна.

ОХУ-ын хуулиар, Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх эрхийг бүх хувьцаа эзэмшигчдэд олгоогүй. Тухайлбал, Зөвхөн энгийн хувьцаа эзэмшигчид саналын эрхтэй байна. Гэвч дор дурдсан тохиолдолд (см. п.3-5 ст.32 Закона об АО* (11) давуу эрхийн хувьцаа эзэмшигчид саналын эрхтэй байж болохоор заасан. Тухайлбал:

1. Компанийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудал
2. Компанийн дүрэмд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлах, давуу эрхийн хувьцаанд хуваарилагдах ногдол ашгийн хувь хэмжээ тогтоох, компанийг татан буулгах үед үлдэгдэл хөрөнгийн өртгийг тогтоох, хуваарилах гэх мэтийн энэ төрлийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашигтай холбоотой асуудал
3. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гарсан хэдий ч давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилаагүй, эсхүл хуваарилах шийдвэр гарсан ч ногдол ашиг олгоогүй асуудлыг ногдол ашиг бүрэн олгож дуусах хүртэл хэлэлцэх
4. Компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлж болохоор заасан бол энэ асуудлыг хэлэлцэхэд оролцох

Ерөнхий зарчмын хувьд "1 хувьцаа 1 саналын эрхтэй" байхаар хуульчилсан. Гэвч зарим тохиолдолд, тухайлбал кумулятив санал хураалтын үед өөр зарчим үйлчилж байна. Тухайлбал, Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгоход кумулятив санал хураалт явуулна. Хэрэв саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн тоо 1000 давсан тохиолдолд кумулятив санал хураалт явуулж болох ба үүнийг Компанийн дүрэмд тусгасан байх шаардлагатай. Зарчим нь, саналын эрхтэй хувьцаа болгон Захирлуудын зөвлөл (Хяналтын зөвлөл)-ийн гишүүдийн тоогоор саналын эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч саналаа нэр дэвшигчдэд хуваарилж өгөх үү, эсхүл аль нэг нэр дэвшигчид дангаар нь өгөх үү гэдгээ өөрөө шийднэ. (п.4 ст.66 Закона об АО).

ОХУ-д хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг ялгавартай тогтоосон хэдий ч бүх хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч болгон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар саналаа хэлэх эрхтэй байна гэсэн үг. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг захирлуудын зөвлөлөөс товлосон хугацаагаар тасалбар болгон гаргана. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах товыг хурал хуралдахаас 50 (45-65)-иас доошгүй хоногийн өмнө гаргана.

Хувьцаа эзэмшигч хэрэв Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсхүл хэлэлцсэн асуудлаар эсрэг санал өгсөн, мөн тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх, ашиг

сонирхол зөрчигдсөн гэж үзвэл ХЭ-ийн хурлын шийдвэр хууль зөрчсөн талаар шүүхэд гомдол гаргаж болно.

Шүүхээс хэрэв тухайн хувьцаа эзэмшигчийн санал бүх гишүүдийн шийдвэр нөлөөлөх боломжгүй, эсхүл гаргасан зөрчил нь ноцтой биш, тухайн хувьцаа эзэмшигчид хохирол учруулаагүй гэж үзвэл гомдлыг хэрэгсэхгүй байж болно.

Гурав. СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

(Бусад орнуудын эрх зүйн зохицуулалт)

3.1. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Компанийн хууль /Corporate law/ нь 50 гаруй өөр өөр системээс бүрддэг бөгөөд муж тус бүр хуультай. Мужийн хуулиуд нь компанийн үйл ажиллагааг Холбооны хуулийн хүрээнд зохицуулна. Өөрөөр хэлбэл, нээлттэй хувьцаат компаниуд нь хэдийгээр мужийн хуулиар үйл ажиллагаа явуулах боловч Холбооны үнэт цаасны хуулиудад нийцэж байх ёстой. Үүнд, 1933 оны Үнэт цаасны хууль /Securities Act/, 1934 оны Үнэт цаасны арилжааны хууль /Securities Exchange Act/, 2002 оны Sarbanes-Oxley⁶² хууль /SOXA/ гэх мэт.

Тус улсын Үндсэн хуульд зааснаар компаниуд нь аль ч мужид хуулийн этгээд болон бүртгүүлэх боломжтой байдаг тул хуулийн дараах 2 эх сурвалжид илүү ач холбогдол өгдөг. Үүнд:

- Америкийн Өмгөөллийн холбоо /American Bar Association/-оос баталсан Компанийн Бизнесийн Загварын Хууль /Model Business Corporation Act-MBCA/ нь нийт 24 мужид хэрэгждэг.
- Делавэрийн Компанийн ерөнхий хууль /Delaware General Corporation Law/ нь онцгой нөлөөтэй. Учир нь АНУ-ын компаниудын хагасаас илүү хувь нь Делавэрийн компанийн хуульд үндэслэн үйл ажиллагаа явуулж байгаа ба тус хууль нь илүү нарийвчилсан заалтуудтай, мөн мэргэшсэн шүүхтэй муж гэдэг утгаараа компанийн эрсдлийг бууруулах сайн зохицуулалт болж чаддаг гэж үздэг.

Ийнхүү практикт ашиглагдаж байгаа ач холбогдлыг нь харгалзан судалгааны захиалгад тусгагдсан асуудлуудыг “Делавэрийн Компанийн ерөнхий хууль”-аар хэрхэн зохицуулагдаж байгааг тоймлон судлав. Үүнд:

Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмших эрх

Делавэрийн Компанийн ерөнхий хуулинд энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг бүлэглэн заагаагүй бөгөөд тусгайлсан заалтуудаас түүвэрлэн харахад доорх байдалтай байна. Үүнд:

- **Санал өгөх эрхийн хүрээнд:**

Энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгоход санал өгөх эрхтэй. Үүнийг тус хуулийн 109 дүгээр зүйлийн “Дүрэм” гэсэн хэсэгт;

⁶²The Sarbanes–Oxley Act of 2002 (Pub.L. 107–204, 116 Stat. 745, enacted July 30, 2002). “Хувьцаат компанийн бүртгэлийн шинэчлэл ба хөрөнгө оруулагчийн хамгаалалтын хууль”, “Компани ба Аудитын хяналт, хариуцлагын хууль”-уудыг 2002 онд баталж Sarbanes–Oxley, Sarbox, SOX гэх мэтээр нэрлэх болжээ. Энэ нь АНУ-ын бүх хувьцаат компаниудын удирдлагын зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон нягтлан бодох бүртгэлд шинэ стандартыг бий болгосон Холбооны хууль ба тус улсын сенатор Paul Sarbanes, Төлөөлөгчдийн танхимын гишүүн Michael G. Oxley нар санаачлан батлуулсан тул ингэж нэрлэжээ.

§109. (а) Хэрэв үүсгэн байгуулагдсаны гэрчилгээнд нэрийг нь заасан бол эсвэл хувьцааны төлбөрийг хүлээн авахаас өмнө компанийн анхны дүрэм, бусад дотоод журмыг үүсгэн байгуулагчид, анхны төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаат бус компанийн хувьд түүний удирдах байгууллага батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрхтэй. Хувьцаат бус компаниас бусад компани нь өөрийн гаргасан хувьцааны төлбөрийг хүлээн авсны дараа дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгох эрх нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд хадгалагдана. Хувьцаат бус компанийн хувьд дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрх нь саналын эрхтэй гишүүдэд хадгалагдана. Өмнө дурдсаныг үл хөндөн аливаа компани нь дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүддээ, хувьцаат бус компанийн хувьд удирдах байгууллагадаа ногдуулж болно. Уг бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөл эсвэл удирдах байгууллагад ногдуулсан нь хувьцаа эзэмшигч эсвэл гишүүдийн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрхийг нь хязгаарласанд тооцохгүй.

Делавэрийн Компанийн ерөнхий хуулийн 212-р зүйлд хувьцаа эзэмшигчдийн саналын эрх; итгэмжлэгч томилох эрхийн талаар заахдаа:

§212. (а) Үүсгэн байгуулагдсаны гэрчилгээнд өөрөөр заагаагүй бол энэхүү бүлгийн 213-р зүйлд заасан нөхцөлд нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна. Хэрэв үүсгэн байгуулагдсаны гэрчилгээнд аливаа хувьцаанд нэгээс дээш эсвэл доош саналын эрх ногдохоор заасан бол энэхүү бүлэгт олонх эсвэл бусад тооны хувьцаа, саналын эрхтэй хувьцааны талаар заахдаа тухайн олонх эсвэл бусад тооны хувьцаа, саналын эрхтэй хувьцааны тухай дурдана.

(b) Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх эсвэл хурал хуралдуулахгүйгээр бичгээр шийдвэр гаргахад зөвшөөрөл олгох эсвэл олгохоос татгалзах эрхтэй хувьцаа эзэмшигч бүр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан үйл ажиллагаанд оролцож болох бөгөөд итгэмжлэлд өөрөөр заагаагүй бол итгэмжлэл нь олгосон өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй байна.

(c) Энэхүү зүйлийн (b) хэсэгт заасны дагуу тухайн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох аргыг үл хязгаарлан дараах тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигчийг уг эрхийг олгосонд тооцно. Үүнд:

(1) хувьцаа эзэмшигчид нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөө бичгээр үйлдсэн баримтаар томилж болно. Ийнхүү бичгээр үйлдэхдээ тухайн хувьцаа эзэмшигч өөрөө гарын үсэг зурах эсвэл өөрийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, ажилтан эсвэл агентаар гарын үсгийг зуруулах бөгөөд зуруулахдаа факс зэрэг хэрэгслээр дамжуулан үйлдэж болно.

• **Хувьцааг эргүүлэн худалдах, бусдад шилжүүлэх эрхийн хүрээнд:**

Тус хуульд хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдах эрхийн талаар заахдаа:

§151. (b) Аливаа төрөл, ангиллын хувьцааг компани, хувьцаа эзэмшигч эсвэл ямарваа үйл явдал болоход худалдаж, худалдан авч болно; харин хувьцааг эргүүлэн авмагц компанид 1 буюу түүнээс дээш ангилал, төрлийн 1 буюу түүнээс дээш эргэлтэд байгаа хувьцаатай болох бөгөөд эдгээр хувьцаа нь саналын эрхтэй байна. Өмнө дурдсан хязгаарлалтыг үл харгалзан:

(1) 1940 оны Хөрөнгө оруулалтын компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, тус хуулиар зохицуулагддаг хөрөнгө оруулалтын компанийн хувьцааг компани эсвэл хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр эргүүлэн авч болно.

Энэхүү заалтын дагуу эргүүлэн авч байгаа хувьцааг үүсгэн байгуулагдсаны гэрчилгээ эсвэл энэхүү заалтын (а) хэсэгт заасны дагуу уг хувьцааг гаргах талаар төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан тогтоолд заасан хугацаа, үнэ, ханш, тохиргоотойгоор бэлэн мөнгө, эд хөрөнгө, эсвэл тухайн компанийн үнэт цаасыг оролцуулан эргүүлэн авч болно.

(е) Аливаа төрөл, ангиллын хувьцааг түүний эзэмшигч эсвэл компанийн хүсэлтээр эсвэл тодорхой үйл явдал болоход тухайн компанийн өөр бусад төрөл, ангиллын хувьцаанд үүсгэн байгуулах гэрчилгээ эсвэл хувьцаа гаргах талаар төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан тогтоолд заасан үнэ, ханш, тохиргоотойгоор хөрвүүлэх эсвэл сольж болно.

§262. Компани бусад компанитай нийлэхийг эсэргүүцэж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шударга үнээр худалдан авах үүрэгтэй. /Үүнийг ерөнхий утгаар нь орчуулан оруулсан ба энэ заалт нь нэг талаас компанийн үүрэг бөгөөд нөгөө талаас хувьцаа эзэмшигчийн эрхтэй холбоотой заалт гэж үзсэн болно./

Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бусдад шилжүүлэх эрхийг 159-р зүйлд заахдаа:

§159. Аливаа компанид эзэмшиж байгаа хувьцааг хувийн өмчид тооцох бөгөөд тэдгээрийг Делавэр Кодын 6-р бүлгийн 1.8-д⁶³ заасны дагуу шилжүүлэх боломжтой. Энэхүү бүлгийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн гаргасан, энэхүү Муж улсад байнга байрладаггүй этгээд эсвэл гадаадын компанийн эзэмшиж байгаа хувьцаа эсвэл бондод энэхүү Муж улс татвар ногдуулахгүй.

Ямар нөхцөлд хувьцаа эзэмшигчийн эрхийг хаана, ямар журмаар хязгаарладаг талаар

Делавэрийн Компанийн ерөнхий хуулийн 202 дугаар зүйл /Delaware Code 8, General corporation law: § 202. Restrictions on transfer and ownership of securities/-ээр доорх хязгаарлалтыг тавьсан байна.

§202. (b) Компанийн үнэт цаасыг шилжүүлэх эсвэл шилжүүлгийн бүртгэл хийлгэх асуудал эсвэл аливаа этгээд буюу бүлэг этгээдүүдийн хамтран эзэмшиж болох үнэт цаасны тоо хэмжээний хязгаарыг үүсгэн байгуулалтын гэрчилгээ, дүрэм эсвэл хувьцаа эзэмшигчдийн хооронд эсвэл хувьцаа эзэмшигчид болон компанийн хооронд байгуулсан гэрээгээр хязгаарлаж болно. Хувьцаа эзэмшигчид нь тухайн хязгаарлалтыг хүлээн зөвшөөрсөн гэрээ байгуулсан эсвэл санал өгснөөс бусад тохиолдолд уг хязгаарлалт нь тухайн хязгаарлалт батлагдахаас өмнө гаргасан үнэт цаасанд хамаарахгүй.

Хувьцаат компанийн хяналтын багц эзэмшигч этгээдийн бусад хувьцаа эзэмшигчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн өмнө ямар үүрэг хариуцлага хүлээдэг талаар

Хувьцаат компанийн хяналтын багц эзэмшигчийн үүрэгтэй холбоотой асуудлыг тус хуулиар нарийвчлан заагаагүй бөгөөд АНУ-ын хувьд үүнтэй холбоотой асуудлууд нь Жишгийн эрх зүй буюу “case law”⁶⁴-д тулгуурладаг юм байна. Жишээ нь, *Locati v.*

⁶³Delaware Code: Title-6 Commerce and Trade, Subtitle- I Uniform Commercial Code, Article-8. Investment securities.

⁶⁴Англи-америкийн эрх зүйн систем нь нийтийн хууль буюу “common law”, өөрөөр “case law”-д үндэслэдэг ба энэ нь өмнө хэзээ нэгэн цагт болж байсан томоохон шүүхийн шийдвэрүүдэд тулгуурладаг.

Johnson, 160 Ore. App. 63 (Or. Ct. App. 1999) шийдвэрээр хяналтын багц эзэмшигч нь эрх ашгийг хамгаалах /fiduciary duty/ үүрэгтэй ба үүнд: 1) компанид хяналт тавих эрх бүхий, хувьцааны ихэнх хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч хувь хүн, 2) компанид хяналт тавих эрх бүхий, хувьцааны ихэнх хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн жижиг группын гишүүний аль алиных нь эрх ашгийг хамгаална. Мөн хяналтын багц эзэмшигч нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанид хяналт тавихын тулд заавал хяналтын багц эзэмшигч байх шаардлагагүй” гэх мэт шүүхийн шийдвэрүүдэд үндэслэдэг байна.

Хувьцаат компанийн хяналтын багц эзэмшигчийн үүрэгтэй холбоотой асуудлыг Делаверийн компанийн хуулиар нарийвчлан заагаагүй бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахтай холбоотой 253 дугаар заалтад охин компанийн хувьцааны 90-ээс доошгүй хувийг эзэмшдэг тохиолдолд хамтарсан компани болж нэгдэх болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг мөнгөөр худалдан авахыг зөвшөөрдөг. Жижиг хувьцаа эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авах шаардлагагүй бөгөөд хувьцааг зах зээлийн боломжит үнээр худалдан авах үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл freeze-outs буюу жижиг хувьцаа эзэмшигчийн зүгээс хувьцаагаа худалдах шаардлага тавихгүй гэсэн үг юм.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хамгаалдаг жишээ

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн баримт бичгүүдийн нэг нь Сарбанэс-Окслийн хууль /Sarbanes-Oxley Act/ юм. Энэ нь тодорхой нарийвчилсан зүйл заалтаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахаас илүү хуулийн зарчим нь өөрөө хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгсэл болж байгаа юм. 2002 онд батлагдсан энэ хуулиар нээлттэй хувьцаат компаниудын нягтлан бодох бүртгэлийг хянах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэвтрүүлэх, санхүүгийн тайлан бүртгэлийг сайжруулах шаардлагууд тавигдсан нь тус улсад томоохон шинэчлэлийг хийсэн төдийгүй ЭЗХАХБ, Европын холбооны гишүүн орнуудад ч тус хуулийн зарчим хэрэгжиж эхэлсэн. Нягтлан бодох бүртгэлийг хянах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэвтрүүлэх, санхүүгийн тайлан бүртгэлийг сайжруулах нь компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд албан тушаалаа урвуулан ашиглаж, хувьцаа эзэмшигчдийг хохироох гэмт хэргүүдийг таслан зогсооход гол үүрэг гүйцэтгэж байна. Жишээ нь, Healthsouth компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал нар санхүүгийн байдлын тайланд орлогыг хуурамчаар өсгөж, олон нийтэд мэдээлжээ. Компанийн бүртгэлд 2,7 тэрбум ам. долларын хуурамч орлого нэмж оруулсан бөгөөд үүндээ үндэслэн компаниас цалин, шагнал, хувьцааны опцион ба бусад ашгийг гаргуулан авсан байна. Үүнийг санхүүгийн тайланд хяналт тавьснаар илрүүлж, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авснаар тус хувьцаат компанийг санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлж чадсан.

Санхүүгийн тайлан ил тод, хяналттай байх нь хяналтын багц эзэмшигчид болон жижиг хувьцаа эзэмшигчдийг хүчтэй байх үндэслэл болохоос гадна хөрөнгө оруулагчдыг татах арга хэрэгсэл болж байна.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох талаарх хуулийн зохицуулалт

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болохтой холбоотой асуудлыг Компанийн ерөнхий хуулийн 216 дугаар зүйл /Delaware Code 8, General corporation law: §216. Quorum and required vote for stock corporations/-ийн (2), (3) дахь заалтуудад доорх байдлаар тусгасан байна. Үүнд:

(2) төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад бүх асуудлыг хуралд өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож байгаа, хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ;

(3) төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоходоо хуралд өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож байгаа, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдээс хамгийн олон санал авсан байдлыг харгалзан сонгоно; Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход шаардлагатай саналын хувийг тогтоосон хувьцаа эзэмшигчдийн баталсан дүрмийн нэмэлт, өөрчлөлтөд төлөөлөн удирдах зөвлөл нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгохгүй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох хуулийн зохицуулалт

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдүүлэхтэй холбоотой асуудлыг Компанийн ерөнхий хуулийн 216 дугаар зүйл /Delaware Code 8, General corporation law: §216. Quorum and required vote for stock corporations/-ийн ерөнхий заалт болон (1) заалтуудад тусгахдаа:

§216. Хувьцаа эзэмшигчдээр шийдвэрлүүлэх тодорхой асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай саналын хувьтай холбоотой асуудлын хувьд хувьцаа гаргах эрхтэй аливаа компанийн үүсгэн байгуулагдсаны гэрчилгээ эсвэл дүрэмд саналын эрхтэй хувьцаа буюу бусад төрлийн үнэт цаасны тоог зааж болох бөгөөд тэдгээрийн эзэмшигчид нь аливаа хуралд өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож, хурлын ирц болон шийдвэрлэх асуудлын саналын хувийг бүрдүүлэх боловч хурлын ирц нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 1/3-ээс доошгүй хувиас бүрдэх бөгөөд өөр төрөл, ангиллын хувьцаа эзэмшигчдийн саналыг тусад нь авах шаардлагатай болох тохиолдолд тухайн ангилал, төрлийн хувьцаа эзэмшигчдийн 1/3-ээс доошгүй хувь хүрэлцэн ирснээр ирц бүрдэнэ. Хэрэв тухайн компанийн үүсгэн байгуулагдсаны гэрчилгээ эсвэл дүрэмд ийнхүү заагаагүй тохиолдолд:

(1) саналын эрхтэй хувьцааны дийлэнх хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч өөрийн биеэр эсвэл итгэмжлэлээр хүрэлцэн ирсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно;

3.2. Их Британийн Компанийн тухай хуулиас

Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох талаар

Их Британид компанийн тухай хуулийн 282, 283-д зааснаар компанийн гишүүдийн хурлын шийдвэр нь энгийн болон тусгай гэсэн 2 төрлөөр гардаг. Энгийн шийдвэр нь компанийн гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэрлэгддэг бол тусгай шийдвэр нь 75-аас доошгүй хувийн саналаар шийдвэрлэгдэнэ. Тусгай шийдвэр гэдэг нь Компанийн тухай хуулийн 283-р зүйлд зааснаар 75 хувиас доошгүй олонхын саналаар шийдвэрлэгдсэн шийдвэрийг хэлнэ. Хувийн компанийн тухайд тус шийдвэр нь тусгай шийдвэр байна хэмээн заасан бол 75 хувиас багагүй саналаар шийдвэрлэнэ. Бичгээр гарсан шийдвэр нь тусгай шийдвэр байхаар заагаагүй бол энгийн шийдвэр байна.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хугацааг тухайн компанийн дүрэмд зааснаар, хэрэв дүрэмд тодорхой заагаагүй бол 28 хоног байхаар уг хуулийн 296, 297 дугаар зүйлд заасан байна. Хуульд тусгасан байдлыг харуулбал:

296-р зүйл. Гарсан шийдвэрийг зөвшөөрсөн, баталгаажуулах үйл явц

(1) Компанийн гишүүн /итгэмжлэгдсэн этгээд/ доорх баримт бичгийг хүлээн авснаар санал болгож буй шийдвэрийг зөвшөөрсөн гэж үзнэ.

(a) Зөвшөөрлөө илэрхийлж буй холбогдох шийдвэр

(b) Зөвшөөрснөө илэрхийлэх баримт

(2) Албан бичгээ эх хувь эсвэл электрон хэлбэрээр

(3) Шийдвэрийг зөвшөөрсөн бол гишүүний саналыг хүчингүй болгож болохгүй

(4) Эрх бүхий гишүүдийн олонх нь зөвшөөрсөн бол баталсанд тооцно.

297-р зүйл. Гарсан шийдвэрийг зөвшөөрснийг илэрхийлэх цаг хугацаа

(1) Гаргасан шийдвэр нь доорх хугацаанд батлагдаагүй бол хүчингүйд тооцно.

(a) Компанийн дүрэмд заасан тодорхой хугацаа

(b) Хэрэв дүрэмдээ заагаагүй бол тооцож эхлэх өдрөөс хойш 28 хоног

(2) Дээр дурдсан хугацаа өнгөрсөн бол шийдвэрийг хүчингүйд тооцно.

Компанийн тухай хуулийн 303 дугаар зүйлд компанийн гишүүд хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах эрхийг тусгайлан зохицуулсан. Компанийн гишүүд хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах асуудлаар компанийн 10-аас доошгүй хувийн хувьцаа эзэмшигч гаргах эрхтэй. Энэ хуралдуулах хугацаа нь сүүлийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас 12 сараас доошгүй хугацаанд байх ёстой. Түүнчлэн уг шаардлагыг гаргахдаа ямар асуудал хэлэлцүүлэх гэж байгаа болон ямар шийдвэр гаргуулах гэж байгаа төслөө бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлэх шаардлагатай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц (кворум)

Английн компанийн тухай хуулийн 318 дугаар зүйлд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц /кворум/-ийн талаар зохицуулсан байна. Тус хуульд зааснаар:

(a) Хэрвээ компани нэг гишүүнтэй бол хуралд нэг гишүүн байхад хангалтай.

(b) Харин бусад тохиолдолд компанийн дүрмээр зохицуулахаар заасан бөгөөд эрх бүхий этгээдүүдээс 2 хувьцаа эзэмшигч ирсэн байлаа ч ирц бүрдсэн гэж үзнэ хэмээн зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц буюу кворумыг тухайн компанийн дүрмээр зохицуулахаар заасан байна.

Компанийн тухайн хуулийн 324 дүгээр зүйлд гишүүд өөрийн эрхээ итгэмжлэгдсэн этгээдэд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх асуудлыг тусгасан байна.

Жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалсан чухал заалтыг Английн компанийн тухай хуулийн 994 дүгээр зүйлд тусгасан байна. Уг зүйлд хувьцаа эзэмшигч нь компанийн өдөр тутмын ажил хэрэг, гарсан буюу гарах гэж байгаа аливаа шийдвэр нь өөрийн болон нийт гишүүдийн эсхүл зохих бүлэг хүмүүст шударга бус, эрх ашгийг нь хөндөж байна гэж үзвэл энэ талаар шүүхэд гомдол гаргаж болох талаарх эрхийг тусгасан байна. Шүүхээс тухайн гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл зохих арга хэмжээ авч болохыг 996 дугаар зүйлд заасан байна.

Дараагийн нэг хамгаалалтыг 260 дугаар зүйлд тусгасан байна. Хувьцаа эзэмшигч нь компанийн захирлын хууль бус үйлдэл, эс үйлдлийн талаар компанийн нэрийн өмнөөс шүүхэд гомдол гаргаж болох эрхтэй байдаг байна.

Хяналтын багц

2010 оны компанийн татварын тухай хуулийн 1124 дүгээр зүйлд компанийн орлого хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж буй тохиолдолд хяналт гэсэн ойлголтот хамруулахаар заасан байна. Компанийн засаглалд 50-иас дээш хувийн хувьцааг эзэмших нь компанийг хяналтандаа байлгана гэсэн үг. Хувьцаа авах эрхийн тухайд компанийн дүрмээр зохицуулсан байдаг бөгөөд дүрэмд заасан хэмжээгээр л эзэмшлийн асуудал яригддаг байна.

2006 оны компанийн тухай тус хуульд хяналтын багц гэсэн ойлголтыг тодорхойлоогүй бөгөөд харин компанийн хувьцааны ихэнх хэсгийг эзэмшигчийн эрхийн талаар доорх заалтуудаар заасан байна. Үүнд:

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг худалдан авахтай холбоотой нөхцөлүүд: /Squeeze-out⁶⁵/

979. Жижиг хувьцаа эзэмшигчдээс хувьцаа худалдан авахад санал гаргагч этгээдийн эдлэх эрх

- (1) Заалт (2)-т санал гаргагч этгээдийн эрх мэдэл нь хувьцааны ангиллаас үл хамаарах нөхцөлүүдийг заав.
- (2) Хэрвээ санал гаргагч этгээд нь хувьцааг эзэмших эсвэл эзэмших гэрээ хийх зөвшөөрөгдсөн давуу талууд нь:
 - а) Хувьцааны үнийн 90-ээс доошгүй хувь нь санал гаргагчид хамаарагдах бол
 - б) Санал гаргагч этгээд нь саналын эрхтэй хувьцаатай ба тэдгээр хувьцаа нь 90-ээс доошгүй хувийн саналын эрхтэй бол аль ч хувьцаа эзэмшигчид мэдэгдлээ хүргүүлж болно.
- (3) Заалт (4)-т санал гаргагч этгээдийн эрх мэдэл нь хувьцааны ангиллаас хамаарах нөхцөлүүдийг заав.
- (4) Хэрвээ санал гаргагч этгээд нь хувьцааг эзэмших эсвэл эзэмших гэрээ хийх зөвшөөрөгдсөн давуу талууд нь:
 - с) Санал гаргагч этгээдэд хамаарах аль нэг төрлийн хувьцааны үнийн 90-ээс доошгүй хувьтай,
 - д) Санал гаргагч этгээд нь аль нэг төрлийн саналын эрхтэй хувьцаатай бөгөөд тэдгээр хувьцаа нь тухайн төрлийн саналын эрхтэй хувьцааны 90-ээс доошгүй хувийг тус тус эзэмшдэг бол тухайн ангилалд хамаарагдах хувьцаа эзэмшигчид мэдэгдлээ хүргүүлж болно.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх

Компанийн хувьцаа эзэмшигчийн үндсэн 3 эрх болох саналын эрх, ногдол ашиг авах эрх, татан буугдахад компанийн эд хөрөнгөөс ногдол хувь авах эрхийг Английн компанийн тухай хуульд заасан байдаг бөгөөд үүнээс гадна багцлан тоймлоход мэдээлэл авах эрх буюу компанийн хувьцаа эзэмшигч нарт илгээсэн мэдээлэл, дансны болон тайлантай холбоотой мэдээллүүдийг хуулбарлан авах (146), захирлын болон компанийн оны эцсийн тайлан, аудитын дүгнэлт зэргийг үнэ төлбөргүй гаргуулах авах (431), хувьцаат компани хувийн компани болон өөрчлөн байгуулагдсан нөхцөлд тус шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах (97), бүх гишүүдийн хурлыг зарлахыг шаардах (303), зэргээр бусад эрхүүдийн хамт зохицуулсан байна. Английн компанийн тухай хуулиас харахад тус хууль нь эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарсан бүтцийн хувьд манай хууль тогтоомжтой адилгүй юм. Тухайлбал: манай хууль тогтоомжуудад аливаа эрх үүрэг, хариуцлагыг багцлан жагсаасан байдалтай хуулинд тусгадаг бол Английн уг хуулинд

⁶⁵Squeeze out гэдэг нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж хувийг зайлшгүй худалдан авахтай холбоотой нөхцөлүүд юм.

энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг нэг бүлэг, зүйлд суулгаж өгөлгүйгээр тухайн асуудал бүрийн хувьд тодорхойлдог байна.

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд компанийн дүрэмд орсон өөрийн эзэмшиж буй хувьцаанаас илүү тооны хувьцаа худалдан авах, эсхүл компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанид нэмж хөрөнгө оруулалт хийх замаар гишүүний үүргийг нэмэгдүүлэхтэй холбоотой өөрчлөлт нь тус өөрчлөлт орохоос өмнөх тус компанийн гишүүн байсан гишүүдийг хамаарахгүй байх асуудлыг 1 дэх хэсэгт заасан нь компанийн хувьцаа эзэмшигчдэд олгосон эрх давуу эрх юм. Тус зүйлийн 2 дахь хэсэгт хэрэв гишүүн бичгийн хэлбэрээр эдгээр компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн бол энэ зүйлийн 1 дүгээр хэсэг түүнд хамаарахгүй байхаар тусгайлан зохицуулсан байна.

Компанийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд компанийн захирлуудтай холбогдох эрх мэдлийг зохицуулсан бөгөөд уг зүйлийн 3 дахь хэсэгт компанийн дүрмээр захирлуудын эрх мэдлийг хязгаарлаж болох асуудлыг зохицуулсан бол, 4 дэх хэсэгт хязгаарлалт нь компанийн хувь нийлүүлэгчээс захирлын эрх мэдлээ хэтрүүлэн явуулсан үйл ажиллагааг шалгах, гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй гэж заасан байна. Энэ компанийн хувь нийлүүлэгч нь захирлын үйл ажиллагааг шалгах, гомдол гаргах эрхийг тодорхой заасан байна.

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд компанийн дүрмээр захирлууд болон тэдгээртэй ашиг сонирхол нэгтэй этгээдүүдтэй холбоотой гэрээ хэлцлийг компанийн дүрмээр хязгаарлаж болно гэсэн зохицуулалтыг хийсэн байна.

Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд хувьцаа эзэмшигч аливаа шийдвэрийг хүчингүй болгох талаар шүүхэд гомдол гаргах эрхийг зохицуулсан байна. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хувьцаат компани болгон өөрчлөх тухай шийдвэрийг гишүүд хүчингүй болгуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй. Уг гомдлыг компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн 5-аас доошгүй хувийн хувьцаа эзэмшигч, эсхүл хэрэв компани нь хувьцаагаар хязгаарлагдаагүй бол гишүүдийн 5-с доошгүй хувь нь, эсхүл компанийн 50-аас доошгүй гишүүдийн, гэхдээ эсрэг саналтай байсан гишүүд гаргах эрхтэй байна.

Компанийн тухай хуулийн 303 дугаар зүйлд компанийн гишүүд хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах эрхийг тусгайлан зохицуулсан. Компанийн гишүүд хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах асуудлаар компанийн 10-аас доошгүй хувийн хувьцаа эзэмшигч гаргах эрхтэй. Энэ хуралдуулах хугацаа нь сүүлийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас 12 сараас доошгүй хугацаанд байх ёстой. Түүнчлэн уг шаардлагыг гаргахдаа ямар асуудал хэлэлцүүлэх гэж байгаа болон ямар шийдвэр гаргуулах гэж байгаа төслөө бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлэх шаардлагатай.

Компанийн тухай хуулийн 304 дүгээр зүйлд гишүүдийн хүсэлтээр хурал хуралдуулах талаар хүсэлт гаргасан байвал захирал 21 хоногийн дотор заавал хуралдуулах үүрэгтэй.

Компанийн тухай хуулийн 312 дугаар зүйлд компанийн урьдчилан заавал танилцуулж гаргах шийдвэрүүдийг тусгасан байна. Компанийн дүрэм хуульд заасны дагуу тухайн шийдвэрийн төслийг хурал болохоос өмнө 28-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд танилцуулж санал авсан байх ёстой. Хэрэгжих боломжгүй гэж үзэж байвал 14-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байх ёстой.

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд Компанийн дүрэмтэй холбогдох баримт бичгийг гишүүдэд гаргаж өгөхтэй холбогдох асуудлыг нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал, 32-р зүйлийн 1 дэх хэсэгт компани нь дурын хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр дараах бичиг баримтуудыг түүнд гаргаж өгөх үүрэгтэй:

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Энэ зүйлийн 1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн тайлан гэдэгт компанийн нийт хувьцааны тоо, нэгж хувьцааны нэрлэсэн үнэ, хувьцааны төрөл бүрээр, хувьцаа тус бүрийн төлөгдсөн болон төлөгдөөгүй үнийн талаарх мэдээллийг хамаарна.

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хэрэв компани дээр дурдсан шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд алдаа гаргасан этгээдэд хариуцлага ногдуулна” гэж заасан бөгөөд хариуцлага нь мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар торгуулийн хэлбэртэй байхаар тусгажээ.

3.3. Оросын Холбооны Улс

ОХУ-д компанийн эрх зүйн байдлыг 1995 онд баталсан “Хувьцаат нийгэмлэгийн тухай” холбооны хуулиар⁶⁶ зохицуулна. Энэхүү холбооны хуулиар хувьцаат компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон компанийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна. Уг хууль нь бүтцийн хувьд 14 бүлэг, 94 зүйлтэй.

Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эрх

Компанийн энгийн хувьцаа эзэмшигчид тэгш эрхтэй. Энгийн хувьцаа эзэмшигч нь холбооны хууль, компанийн дүрэмд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд өөрийн эрх мэдлийн хүрээний бүх асуудлуудад саналын эрхтэй оролцох ба ногдол ашиг авах эрхтэй. Компани татан буугдсан тохиолдолд компанийн хөрөнгөөс хувь хүртэх эрхтэй. /Хувьцаат нийгэмлэгийн тухай хуулийн 31-р зүйл./

Компанийн хувьцааны 10 хүртэлх хувийг эзэмшигчдийн тусгайлсан саналын эрхийг хувь тус бүрээр нь авч үзвэл:

Нийт саналын эрхээс эзэмшиж буй хувь	Хувьцаа эзэмшигчдийн эрх	Хуулийн заалт
1%	Хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд оролцох эрхтэй этгээдүүдийн нэрсийн жагсаалттай танилцах эрхтэй.	Хуулийн 51.4
1%	Компанид өөрийн үйл ажиллагаагаараа, эсхүл эс үйлдлээрээ хохирол учруулсан компанийн удирдлага, ерөнхий захирал, гүйцэтгэх байгууллагын гишүүний талаар шүүхэд гомдол гаргаж болно.	Хуулийн 71.5
2%	<ul style="list-style-type: none"> Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлын хэлэлцэх асуудалд асуудал оруулах, Захирлуудын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх байгууллагын гишүүн, хяналтын хорооны гишүүн, тооцооллын хорооны гишүүн болон ерөнхий захиралд нэр дэвшүүлэх, Санал болгосон асуудлынхаа шийдвэрийн төслийг оруулах. 	Хуулийн 53.1, 53.4
2%	Хэрэв хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус бүгд хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд компанийн захирлуудын зөвлөлийн гишүүнийг санал хураалтын кумулятив аргаар сонгох тухай байвал түүнд нэр дэвшүүлнэ.	Хуулийн 53.2

⁶⁶Федеральный закон “Об акционерных обществах” (Об АО) от 26.12.1995 N 208-ФЗ (принят ГД ФС РФ 24.11.1995). Эх сурвалж: <http://www.consultant.ru/popular/stockcomp/>

2%	Компани нь 2-оос дээш хувийн энгийн хувьцаа авах тухай гэрээг сайшаах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд олонхын саналаар гаргана.	Хуулийн 83.4
10%	<ul style="list-style-type: none"> Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус бүгд хурлыг хуралдуулахыг шаардах, Ээлжит бус бүгд хурлын хэлэлцэх асуудалд асуудал оруулах, Компанийн удирдлагад нэр дэвшүүлэх. 	Хуулийн 55
10%	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус бүгд хурлын талаар захирлуудын шийдвэр гараагүй, эсхүл татгалзсан тохиолдолд хурлыг хуралдуулах эрхтэй. Ингэхдээ хурлыг хуралдуулж байгаа хувьцаа эзэмшигчид нь хурлыг зарлах, зохион байгуулахтай холбоотой асуудлаар захирлуудын зөвлөлийн эрхтэй.	Хуулийн 55.8

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийг хязгаарлах нөхцөл, журам

Дүрэмд өөрөөр заагаагүй бол хуулийн дагуу компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд хязгаарласан саналын эрхтэй. Бүгд хурлаар компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг хэлэлцэх тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь саналын эрхтэй. Түүнчлэн компанийн дүрмээр тодорхой төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчийг бүгд хуралд саналын эрхтэй байхыг тогтооно.

Нэг хүнд ногдох хувьцааны хэмжээ, түүний нэрлэсэн нийт үнийг хязгаарлах болон нэг хувьцаа эзэмшигчид ногдож байгаа саналын дээд хязгаарыг компанийн дүрмээр тогтоож болно.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах нь

Хувьцаат компанийн тухай хуульд компанийн хяналтын багц эзэмшигч гэсэн нэр томъёо байхгүй. Гэхдээ холбооны хуулийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болох ба нийт хувьцааны 50 хувиас гадна ахиад 1 хувьцаа эзэмших нь шийдвэрт нөлөөлөх боломжтой хэдий ч зарим асуудлыг бүгд хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн 3/4 саналаар шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, зарим асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн хяналтын багцыг эзэмших нь хангалтгүй.

ОХУ-ын хуулиар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг дараах байдлаар хамгаална. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн бүгд хуралд оролцогчдын олонхын буюу 3/4 саналаар зарим асуудлыг шийдвэрлэх ба компанийн дүрмээр үүнээс илүү өндөр босго тавьж болохыг хуулиар зөвшөөрсөн байна. /Энэхүү журмаар шийдвэрлэх асуудлуудын жагсаалтыг “Бүгд хурлын шийдвэр”-ээс үзнэ үү./
- Компанийн захирлуудын зөвлөлийн гишүүнийг сонгохдоо санал хураалтын кумулятив аргыг⁶⁷ хэрэглэнэ. /66.4/

⁶⁷Кумулятив санал хураалт нь сонгогч хэд хэдэн саналыг нэр дэвшигчийн тоогоор өгч дараа нь хуваах сонгуулийн зарчим. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12-р сарын 7-ны 367 тоот тогтоолоор “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ыг батласан бөгөөд кумулятив аргыг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгоход хэрэглэнэ. Энэ арга нь энгийн хувьцаа тус бүр сонгогдох ердийн болон хараат бус гишүүдийн нийт тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаанд ногдох энэ санал нь ТУЗ-д эзлэх ердийн болон хараат бус гишүүний эзлэх хувьд хуваагдана.

- 1-ээс багагүй хувийн хувьцаа эзэмшигч нь компанид өөрийн үйл ажиллагаагаараа, эсхүл эс үйлдлээрээ хохирол учруулсан компанийн удирдлагад компанийн нэрийн өмнөөс гомдол гаргаж болно. /71.5/
- 25-аас багагүй хувийн хувьцаа эзэмшигч нь санхүүгийн тайлан тооцооны баримт бичиг болон удирдлагын хурлын протоколтой танилцах эрхтэй. /91.1/
- Мөн 30-аас илүү хувийн хувьцаа /дараа нь 50 хувь, 75 хувь, 95 хувь/ эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг тогтоосноос доогуур үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй. /84.2.1, 84.2.4, 84.7/

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц /кворум/

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүгд хурал нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн талаас илүү хувь нь хуралд оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр байна.

Бүгд хуралд оролцсон хувьцаа эзэмшигч гэдэг нь түүнд оролцохоор бүртгүүлсэн хувьцаа эзэмшигч байна, мөн бүгд хурал болохоос хамгийн багадаа 2 хоногийн өмнө хүлээн авсан хувьцаа эзэмшигч, сонгуулийн хуудас байна. Түүнчлэн хайрцгаар санал авах хэлбэрээр зохион байгуулж буй бүгд хуралд оролцсон хувьцаа эзэмшигч гэдэг нь саналын хуудас хүлээн авах өдөр дусахаас өмнө хүлээн авсан хувьцаа эзэмшигч, сонгуулийн хуудас байна.

Хэрэв хувьцаа эзэмшигчдийн тухайн жилийн бүгд хурлын ирц нь хүрэлцэхгүй бол хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүйгээр бүгд хурлын дахин хуралдуулна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус бүгд хурлын ирц хүрэлцээгүй бол ижил байдлаар дахин хуралдуулна.

Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн бүгд хурал нь саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 30-аас багагүй хувь нь хуралд оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр байна. 500 мянган хувьцаа эзэмшигчтэй компани нь дүрмээрээ хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлын ирцийн хувийг хуульд зааснаас багаар тогтоож болно. /58./

Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлын шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурдлыг жил бүр хийх ёстой, ингэхдээ санхүүгийн жил дууссанаас хойш хамгийн эртдээ 2 сарын дараа, хамгийн оройтлоо гэхэд 6 сараас хэтрүүлэхгүй хуралдуулна. Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлаар компанийн захирлуудын зөвлөлийг сонгох, компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах, жилийн ногдол ашиг, санхүүгийн алдагдалыг хуваах болон бүгд хурлын эрх мэдлийн хүрээний бусад асуудлуудыг шийдвэрлэнэ.

Шийдвэрийг бүгд хуралд хүрэлцэн ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар гарна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлаар асуудлуудыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

1. *Дүрэмд өөрөөр заагаагүй бол дараах асуудлуудыг зөвхөн захирлуудын зөвлөлийн санал болгосноор шийдвэрлэнэ:*
 - компанийг өөрчлөн байгуулах,
 - хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, хувьцаа нэмж байршуулах замаар компанийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх,
 - хувьцааг хуваах болон нэгтгэх,

- ашиг сонирхолтой, томоохон гэрээг сайшаан зөвшөөрөх,
 - компани нь байршуулсан хувьцааг авах,
 - санхүү-үйлдвэрлэлийн групп, ассоциаци болон бусад арилжааны байгууллагуудын нэгдэл зэрэгт оролцох талаар,
 - компанийн үйл ажиллагааг зохицуулах дотоод баримт бичгийг батлах.
2. *Дараах асуудлуудыг бүгд хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын буюу 3/4 саналаар шийдвэрлэнэ:*
- компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах,
 - компанийг өөрчлөн байгуулах,
 - компанийг татан буулгах, татан буулгах хороог байгуулах, татан буулгах завсрын болон эцсийн балансыг батлах,
 - зарласан хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, төрөл, тэдгээр хувьцааны эрхийг тогтоох,
 - компани нь байршуулсан хувьцааг авах,
 - компанийн хувьцаа болон компанийн хувьсах хувьцаанд хөрвөх эмиссийн үнэт цаасыг жагсаалтаас гаргах тухай.
3. *Дараах асуудалтай холбоотой шийдвэр нь хуулиар тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүй /шийдвэр гаргах өдөр компанийн цэвэр активын өртгийн 10 хувиас хэтрэхгүй байх/ нөхцөлд хүчин төгөлдөр байна:*
- компанийн хувьцаа болон компанийн хувьсах хувьцаанд хөрвөх эмиссийн үнэт цаасыг жагсаалтад оруулах тухай шийдвэрлэх.

Хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлаар хэлэлцэх асуудлуудын дарааллыг бүгд хурлаас батлагдсан компанийн дүрэм, бусад дотоод баримт бичгээр тогтооно. Бүгд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлыг хэлэлцэхгүй ба түүнд өөрчлөлт оруулахгүй. Бүгд хурлын шийдвэр нь хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудал байх /тухайн бүгд хуралд компанийн бүх хувьцаа эзэмшигчид оролцсон бол хамаарахгүй/, эсхүл бүгд хурлын ирцийн хувь хүрээгүй, хувьцаа эзэмшигчийн олонхын саналаар шийдвэрлэгдээгүй зэрэг хувьцаа эзэмшигчдийн бүгд хурлын бүрэн эрхийг зөрчсөн тохиолдолд хүчин төгөлдөр бус байна.

Зарим асуудлыг хэлэлцэхдээ хайрцгаар санал авах хэлбэрээр зохион байгуулах бол бүгд хурлыг хуралдуулахгүйгээр шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэх асуудлын дагуу асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Дараах асуудлуудыг хайрцгаар санал авах хэлбэрээр шийдвэрлэхгүй. Үүнд:

- компанийн захирлуудын зөвлөл сонгох,
- хяналтын хороог сонгох,
- аудиторыг батлах,
- компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах,
- жилийн ногдол ашиг болон санхүүгийн алдагдлыг хуваах.

3.4. Турк Улсын Худалдааны Тухай хуулиас /2011.01.10/ 01/02 ТООТ

Туркын 2011 оны Худалдааны хуулиар Хувьцаа эзэмшигч болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг Европын эрх зүйтэй адил нэлээд хэдэн чиглэлээр өргөжүүлсэн байна. Нэгдүгээрт: хувьцаа эзэмшигч болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг агуулга, нөлөөллийн чиглэлээр өргөжүүлсэн. Тухайлбал, актив болон пассив мэдээлэл авах эрх, зөвхөн жижиг хувьцаа эзэмшигч нарт олгосон тусгай хянах эрх, судлах эрх хамаарна.

Хоёрдугаарт: хувьцаа эзэмшигчид олгосон нэг шинэ эрх нь нэхэмжлэх эрх юм. Өөрөөр хэлбэл, Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэх эрх, компанийн нэгдэх, тусгаарлах, салах зэрэг хэлбэрийг нь өөрчлөхтэй холбогдох шийдвэрийн эсрэг өгсөн хувьцаа эзэмшигч хувь нийлүүлэгчээс гарах эрх /компани хувьцаагаа худалдан авах шаардлага/ бүхий шалтгаанаар компанийг татан буулгах.

Жижиг хувьцаа эзэмшигчид олгосон шинэ эрхүүд гэвэл жилийн тайланд хянагчийг, тусгай хянагч томилох, зөвлөлүүдэд гишүүн сонгох эрхүүд юм.

Компанийн хувьцааны 90 болон 95 хүртэлх хувийг эзэмшигч нь ямар нэг шалтгаангүйгээр 5 хувь хүртэл жижиг хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдан авч компаниас гаргах эрхийг хуульчилсан бөгөөд уг асуудлыг сүүлийн жилүүдэд Европын орнуудад хүлээн зөвшөөрөөд байгаа билээ.

Туркын худалдааны хууль нь хувьцаа эзэмшигчийн эрхийг нэлээд өргөжүүлэн зохицуулсан. Юуны өмнө хувьцаа эзэмшигчийн эрхийн жагсаалтыг баяжуулсан байна. Хуульд хувьцаа эзэмшигчид олгосон хөрөнгө, удирдлага, хянах, судалгаа шинжилгээтэй холбогдох эрхээс гадна дараах эрхүүдийг тусгасан.

- Компани нэгдэх, толгой компани эрх мэдлээ хууль бусаар ашиглах тохиолдолд /200 дугаар зүйл/ компаниас мэдээлэл авах, компаниас гарах,
- Тусгай хянагч хүсэх эрх /хуулийн 438 дугаар зүйл/
- Болзолтойгоор хөрөнгөө нэмэгдүүлэхэд санал болгох эрх /466 дугаар зүйл/
- Адил тэгш үйл ажиллагаа шаардах эрх /357 дугаар зүйл/
- Нэгдэх, нийлэх, тусгаарлах зэрэг хэлбэр өөрчлөхөд хувьцаа эзэмшигчийн хувь болон эрх нь боломжит бус болсон тохиолдолд тэнцвэржүүлэх нэхэмжлэх гаргах эрхтэй /192/
- Нэгдэх, нийлэх, тусгаарлах зэрэг хэлбэр өөрчлөх шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй /193/
- Нэгдэх, нийлэх, тусгаарлах зэрэг хэлбэр өөрчлөхөд /194/, давуу байдлаа буруугаар ашигласан удирдах зөвлөлд хариуцлага тооцох /202/
- Хянагч томилох, нэхэмжлэх /399/
- Хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэрийг хүчингүй тооцож нэхэмжлэх /447/
- Хуулийн шаардлага хангасан татан буулгах мэргэжилтэн сонгох хүсэлтийг агуулсан нэхэмжлэл гаргах эрх /537/
- Институчлэгдсэн төлөөлөгчийн тогтолцоо /428, 429/
- Төлөөлөгч хувь нийлүүлэгчдийн хурлаас өмнө удирдамж авах шаардлага /428, 429/
- Мэдээлэл авах эрх /200, 437/
- Судлах эрх /437/
- Ил тод байх
- Цахим хуудас /1524, 1527/
- Мэдэгдэх үүргийг 198 дугаар зүйлд зохицуулсан байна

198.1.Нэг этгээд компанийн хөрөнгийн 5 хувь, 10 хувь, 20 хувь, 25 хувь, 33 хувь, 50 хувь, 67 хувь, эсхүл 100 хувийг төлөөлж байгаа хувийг шууд болон шууд бусаар эзэмших болсон, эсхүл хувь нь дээрх хувиас буурсан тохиолдолд уг хувь нэмэгдсэн эсхүл буурсан ажиллагааг дууссанаас хойш 10 хоногийн дотор компани болон хуульд заасан эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Мэдэгдлийг бичгээр гаргаж, худалдааны бүртгэлд бүртгэж, зарлана.

- Удирдах зөвлөл зарим мэдээллийг мэдээлэх, илтгэхтэй холбогдох үүргийг хуульчилсан байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхтэй холбогдуулан тусгай хянагч томилох эрхийг нэмж оруулсан. Учир нь тусгай хянагчийн илтгэл нь компанийн удирдлагын хариуцлагатай холбогдох нэхэмжлэл гаргах боломжийг хувьцаа эзэмшигчдэд нээх зорилготой. Тайлангийн хэлэлцүүлгийг хойшлуулж болно. Нөгөө талаас тусгай хянагч ажиллуулах механизм байхгүй бол жижиг хувьцаа эзэмшигчийн эрх зөрчигдөж, хүлээж байсан ашгаа авахгүй байх магадлалтай. Хянагч нарыг шүүхээс сонгох боломжийг хуульчилсан байна. /438, 440/

Жижиг хувьцаа эзэмшигч нарт компанийг татан буулгахыг шаардах эрхийг олгосон. /531/

Санхүүгийн тайланг судалж байгаа хянагчийг үндэслэлтэй гэж үзвэл, эсхүл хараат бус байдлаа алдсан гэж үзвэл жижиг хувьцаа эзэмшигчид түүнийг үүрэгт ажлаас нь халах, түүнчлэн шинэ хянагч томилохыг нэхэмжлэх эрхтэй. /389/

Компанийн хөрөнгийн 1/10-ийг төлөөлж байгаа хувьцаа эзэмшигчдэд олгосон эрх:

- Удирдах зөвлөлийн гишүүн, хянагчийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй.
- Балансын асуудлыг хойшлуулах эрхтэй. (1 сар хүртэлх хугацаагаар)
- Тусгай хянагчийг томилох, хянагч нарт гомдол гаргах, шаардлагатай гэж үзвэл хянагч уг асуудлыг судалж үзээд тухайн гомдлын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд асуудал оруулах эрхтэй.

Хувь нийлүүлэгчийн саналын эрхийг 436 дугаар зүйлд хязгаарласан байна.

436.1 Хувь нийлүүлэгч өөрөө, түүний нөхөр /эхнэр/, үр хүүхэд, аав ээж, эсхүл тэдгээрийн хувь нийлүүлсэн компанитай, компани хооронд хувь хүний шинжтэй ажил хэрэг, үйл ажиллагаа эсхүл ямар нэг шүүх байгууллага, арбитра нэхэмжлэлтэй холбогдох асуудлаар санал өгөхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц (кворум)

- 418-р зүйлд Хувьцаа эзэмшигчдийн хурал болон гэрээнд хүндрүүлсэн нөхцөл заагаагүй бол компанийн хөрөнгийн $\frac{1}{4}$ -ийг эзэмшиж байгаа гишүүд ирсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал ирц бүрдсэн гэж үзэж хуралдана. Гэхдээ хуралдааны туршид $\frac{1}{4}$ гэсэн тоог хадгална. Эхний удаагийн хуралд $\frac{1}{4}$ гэсэн ирц бүрдээгүй тохиолдолд дараагийн хурлыг хийхэд $\frac{1}{4}$ гэсэн ирцийн хязгаарлалт тавихгүй. Уг хуралдаанд ирсэн гишүүдийн олонхын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэнэ.
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахдаа хөрөнгийн 50-иас доошгүй хувийг эзэмшигчид хуралд оролцсоноор ирц бүрдсэнд тооцож, олонхын саналаар шийдвэрлэнэ. Эхний хурлын ирц бүрдээгүй бол 2 дахь хурлын ирцийг 1/3 болгоно.
- 421-р зүйлд тус кворумыг ихэсгэсэн багасгасан компанийн дүрмийн заалт хүчингүй байна хэмээн заажээ.
- 421.2-т зааснаар дараах асуудлуудыг компанийн хөрөнгийн 75 хувийг эзэмшигчид болох хувьцаа эзэмшигчид ирснээр шийдвэрлэх боломжтой.
 - Балансын алдагдлыг хаахын тулд үүрэгжүүлсэн шийдвэр гаргах
 - Компанийн төвийг гадаадад нүүлгэх
 - Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, нэрийн хувийг бусдад дамжуулах асуудлыг 75 хувийн ирцтэйгээр шийдвэрлэнэ. Бусад асуудлуудын хувьд $\frac{1}{4}$ гэснээр шийдвэрлэнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

Тухайн компанийн хөрөнгийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа гишүүд хүрэлцэн ирж, тэдгээрийн олонхын саналаар шийдвэрлэгдсэн шийдвэр хүчин төгөлдөрт тооцогдоно.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал

408 дугаар зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас бусдад шилжүүлдэггүй бүрэн эрхийн хүрээнд хууль, гэрээнд тодорхой заасан асуудлаар шийдвэр гарна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

- Удирдах зөвлөлийн гишүүд сонгох, түүний хугацаа, ажлын хөлс, шагнал урамшуулал авах эрх, ажлаас чөлөөлөх
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
- Компанийн хөрөнгөнөөс худалдах
- Хуульд зааснаас бусад тохиолдолд хувьцаат компанийг татан буулгах
- Санхүүгийн тайлан, үзүүлэлтүүд
- Ногдол ашиг хуваарилах
- Удирдах зөвлөлийн жилийн тайлан, жилийн ашгаас нөөцлөх асуудал, ашгийн хувийг тодорхойлох
- Хуульд зааснаас бусад тохиолдолд хянагч, гүйцэтгэлийн хянагчийг томилох, чөлөөлөх

3.5. Герман Улс

ХБНГУ-д аж ахуйн нэгжийн эрх зүйн байдлыг 1965 онд баталсан (хамгийн сүүлд 2008 онд өөрчлөлт орсон) “Хувьцааны тухай” хуулиар зохицуулна. Энэхүү хуулиар хувьцаат нийгэмлэгийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон нийгэмлэгийн эрх зүйн байдал, нийгэмлэг болон нийгэмлэгийн гишүүний эрх, үүрэг, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна. Уг хууль нь бүтцийн хувьд 4 боть, нийт 18 бүлэг, 410 зүйл заалттай.

Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эрх

- Хувьцаа эзэмшигчдэд ижил нөхцөлд тэгш хандана.
- Нийгэмлэг өөрийн хувьцааг батлан дааж (underwriting) болохгүй.
- Хараат аж ахуйн нэгж (ААН) нь захирагч ААН-ийн хувьцааг, олонхын эзэмшигч ААН нь өөртөө олонхын оролцоотой ААН-ийн хувьцааг үүсгэн байгуулагчийн буюу батлан даагчийн хувиар, эсвэл хөрөнгө нэмэгдүүлэх зорилгоор гаргасан нэмэлт хувьцааг солих буюу тэргүүн ээлжинд авах замаар тус тус шилжүүлэн авч болохгүй. Ингэсэн бол шилжүүлэн авалтыг хүчингүй болгоно.
- Хэрэв хөрөнгө өсгөн нэмэгдүүлэх үед батлан даасан бол Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүд бүр оруулсан хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- Оруулсан хөрөнгийг хувьцаа эзэмшигчид буцаан олгохгүй. Нийгэмлэгтээ ажил үүрэг гүйцэтгэж олсон цалин хөлсийг үүнд хамруулахгүй. Мөн хувьцаа эзэмшигчийн зээлийн төлбөр, тооцооны нэхэмжлэлийг төлөхгүй.
- Хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгөнд нь хүү өгнө гэж амлах, хүү бодож өгч болохгүй.
- Нийгэмлэгийг татан буулгах үед зөвхөн балансад тусгасан ашгийг л хувьцаа эзэмшигчдэд хуваарилж болно.

4-р хэсэг. Бүх гишүүдийн хурал (БГХ)

118. Ерөнхий зүйл

- (1) Энэ хуулинд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь бүх гишүүдийн хурал дээр нийгэмлэгт холбогдох бүрэн эрхээ эдэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрх, түүнийг хязгаарлах нөхцөл, журам**Саналын эрх**

133. Хууль буюу дүрмээр илүү олонхын санал, нөхцөл тусгайлан заагаагүй бол БГХ-ын шийдвэр энгийн олонхын саналаар гарна. Сонгуульд дүрмээр өөр зохицуулалт хийж болно.

134. Саналын эрхийг хувьцааны нэрлэсэн үнээр, ширхэгийн хувьцааны хувьд түүний тоогоор тодорхойлно. Нэг хувьцаа эзэмшигч олон хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд биржэд бүртгэлгүй нийгэмлэгийн хувьд дүрэмд зааснаар дээд хэмжээ тогтоох буюу хорогдуулж хязгаарлаж болно. Хувьцааны төлбөрийг бүрэн гүйцэтгэснээр саналын эрх нээгдэнэ. Саналын эрх хэрэгжүүлэх хэлбэрийг дүрмээр тогтооно.

136. Саналын эрхгүй болох

- (3) Түүнийг хариуцлагаас чөлөөлөх буюу өрийн бичгийг нь хүчингүй болгох, эсвэл нийгэмлэг түүний эсрэг хариуцлага тооцох асуудлаар шийдвэр гаргахад хэн ч өөрөө буюу өрөөлийг төлөөлж саналын эрх эдлэхгүй. Ингэж саналын эрхгүй болсон хувьцаануудыг бусад этгээд ч ашиглах боломжгүй.
- (4) Нийгэмлэг, нийгэмлэгийн ТУЗ буюу ХЗ-ийн, эсвэл хараат ААН-ийн даалгавраар ХЭ санал өгөх үүрэг хүлээсэн аливаа гэрээ хэлцэл хүчингүй. Мөн ТУЗ буюу ХЗ-ийн саналаар ХЭ санал өгөх үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл хүчингүй.

137. Нийлээд үндсэн хөрөнгийн 10 хувь эзэмших цөөнх БГХ дээр ХЗ-ийн сонгуульд нэр дэвшүүлэх бол түүнийг санал хураалтаар БГХ-ийн шийдвэр гаргана.

179. Нийгэмлэгийн дүрмийг зөвхөн БГХ-аас үндсэн хөрөнгийн $\frac{3}{4}$ -аас дээш олонхоор өөрчилнө. Зөвхөн найруулгатай холбоотой асуудлыг ХЗ-д шилжүүлж болно.

ХК-ийн хяналтын багц эзэмшигч этгээдийн бусад хувьцаа эзэмшигчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага**20. Мэдэгдэх үүрэг**

- 25 хувь, 50 хувиас их болсон, эсвэл үгүй болсон бол хувь эзэмшигчдэд бичгээр мэдэгдэнэ.
- Мэдэгдлийг нийгэмлэгийн хуудсаар түгээнэ.

21. Нийгэмлэгийн мэдэгдэх үүрэг

- Нийгэмлэгийн хувь хэмжээ бусад хөрөнгийн компанийн 25 хувиас давсан бол оролцоотой ААН-үүдэд мэдэгдэнэ.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалахтай холбоотой туршлага**120. Чөлөөлөх**

- (1) ТУЗ болон ХЗ-ийн гишүүдийг чөлөөлөх асуудлаар бүх гишүүдийн хурал (БГХ) жил бүрийн эхний 8 сар дотор шийдвэр гаргана. Хэрэв БГХ шийдвэл, эсвэл үндсэн хөрөнгийн 10 хувь буюу 1 сая еврогийн хувь хэмжээ нийлж эзэмшсэн цөөнх шаардвал гишүүн тус бүрээр санал хураалгана.

122. Цөөнхийн шаардсанаар зарлах

- (4) Хэрэв үндсэн хөрөнгийн $\frac{1}{20}$ хамтран эзэмших хувьцаа эзэмшигчид шаардсан бол БГХ-ыг зарлана. Ингэхдээ шаардлагыг бичгээр үйлдэх ба ТУЗ-д хандсан байна. Шаардлагад зорилго, шалтгааныг тусгасан байна. Дүрэмд БГХ зарлахыг шаардах эрхийн хувь хэмжээг доогуур тогтоож болно.

- (5) Нийлээд үндсэн хөрөнгийн 1/20 буюу 500.000 еврогийн хувь хэмжээ эзэмшигч ХЭ-чид шаардсанаар БГХ-аас гарах шийдвэртэй холбоотой зүйлийг танилцуулж болно.
- (6) Шаардлагыг хангахгүй бол шүүх БГХ-ыг зарлах буюу зүйлийг танилцуулна. Зэрэгцээд шүүх БГХ-ын даргыг томилно.

137. Нийлээд үндсэн хөрөнгийн 10 хувь эзэмших цөөнх БГХ дээр ХЗ-ийн сонгуульд нэр дэвшүүлэх бол түүнийг санал хураалтаар БГХ-ийн шийдвэр гаргана.

ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох зохицуулалт

4-р хэсэг. Бүх гишүүдийн хурал (БГХ)

118. Ерөнхий зүйл

- (2) ТУЗ болон ХЗ-ийн гишүүд БГХ-д оролцох үүрэгтэй.

БГХ-ыг зарлах

121. Ерөнхий

- (1) БГХ-ыг хууль буюу дүрэмд заасан тохиолдолд, мөн нийгэмлэгийн эрх ашиг шаардсан бол зарлана.
- (2) БГХ-ыг ТУЗ энгийн олонхоор шийдэж зарлана.
- (3) БГХ-ын зарыг нийгэмлэгийн хуудсаар нийтэлнэ. Зард пүүс (худалдааны төв), нийгэмлэгийн харьяалал (бүртгэлийн), хугацаа, газар болон БГХ-д оролцох ба саналын эрхэд хамаарах нөхцөлүүдийг тусгасан байна.
- (5) Хэрэв дүрэмд өөрөөр тусгаагүй бол БГХ нийгэмлэгийн харьяаллын газар болно. Хэрэв нийгэмлэгийн хувьцаа биржийн арилжаанд хамрагддаг бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол БГХ биржийн харьяаллын газарт болно.
- (6) Хэрэв бүх гишүүд хуралдаа ирсэн буюу төлөөлөл оролцсон бол энэхүү дэд хэсэгт заасныг үл баримтлан БГХ нэгдмэл саналаар (нэг ч хувьцаа эзэмшигч эсэргүүцэхгүй бол) шийдвэр гаргаж болно.

122. Цөөнхийн шаардсанаар зарлах

- (1) Хэрэв үндсэн хөрөнгийн 1/20-ийг нийлээд эзэмшихийг хувьцаа эзэмшигчид шаардсан бол БГХ-ыг зарлана. Ингэхдээ шаардлагыг бичгээр үйлдэх ба ТУЗ-д хандсан байна. Шаардлагад зорилго, шалтгааныг тусгасан байна. Дүрэмд БГХ зарлахыг шаардах эрхийн хувь хэмжээг доогуур тогтоож болно.
- (2) Нийлээд үндсэн хөрөнгийн 20-ны нэг буюу 500.000 еврогийн хувь хэмжээ эзэмшигч ХЭ-чид шаардсанаар БГХ-аас гарах шийдвэртэй холбоотой зүйлийг танилцуулж болно.
- (3) Шаардлагыг хангахгүй бол шүүх БГХ-ыг зарлах буюу зүйлийг танилцуулна. Зэрэгцээд шүүх БГХ-ын даргыг томилно.
- (4) Нийгэмлэг БГХ-ын зардлыг, хэрэв 3 дахь хэсэгт хамаарах бол шүүхийн зардлыг гаргана.

123. Хугацаа, БГХ-д бүртгүүлэх, Нотолгоо

- (1) БГХ-ыг 30-аас доошгүй хугацааны өмнө зарлана.

124. Хэлэлцэх асуудлыг танилцуулах

- (1) БГХ-ын хэлэлцэх асуудлыг зартай хамт нийгэмлэгийн хуудсанд байрлуулна. БГХ зарласнаас хойш цөөнхөөс шаардсан бол хурлаас шийдвэр гаргуулахаар хэлэлцэх асуудлыг зар гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэхэд хангалттай.

(3) Хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгасан асуудал бүрээр хурлаас гарах шийдвэрийн төслийг ТУЗ буюу ХЗ оруулах үүрэгтэй.
Журмын дагуу хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдаагүй асуудлаар шийдвэр гаргаж болохгүй.

ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох зохицуулалт

119. БГХ-ын бүрэн эрх

(1) БГХ хуулинд заасан болон нийгэмлэгийн дүрэмд тусгагдсаны дагуу доорх асуудлаар шийдвэр гаргана. Үүнд:

1. ХЗ-ийн гишүүнийг томилох
2. Балансын ашгийг хуваарилах
3. ТУЗ болон ХЗ-ийн гишүүнийг чөлөөлөх
4. Дуусгаврын шалгагчийг томилох
5. Дүрэм өөрчлөх
6. Хөрөнгө нэмэгдүүлэх болон хорогдуулах үйл ажиллагаа
7. Үүсгэн байгуулах болон удирдлагын үйл ажиллагааг шалгах шалгагчийг томилох
8. Нийгэмлэгийг татан буулгах

(2) Хэрэв ТУЗ шаардвал нийгэмлэгийн удирдлагын асуудлын талаар.

124. Хэлэлцэх асуудлыг танилцуулах

(4) Журмын дагуу хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдаагүй асуудлаар шийдвэр гаргаж болохгүй.

129. Үндсэн хөрөнгийн 3/4-аас доошгүй олонхын саналаар БГХ-ыг зохион байгуулах болон БГХ-ын бэлтгэл хангах тухай дүрэм, журмыг БГХ-аас батална.

130. БГХ-аас гарсан шийдвэр бүрийг нотариатаар баталгаажуулна. Биржэд бүртгэлгүй нийгэмлэгийн хувьд хуулиар 3/4-ын олонхоор шийдвэр гаргахаар тогтоогоогүй бол ХЗ-ийн даргын гарын үсгээр баталжуулахад хангалттай. БГХ дуусмагц баталгаажуулсан шийдвэрүүдийг ААН-ийн бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

133. Хууль буюу дүрмээр илүү олонхын санал, нөхцөл тусгайлан заагаагүй бол БГХ-ын шийдвэр хураагдсан саналын энгийн олонхоор гарна. Сонгуульд дүрмээр өөр зохицуулалт хийж болно.

179. Нийгэмлэгийн дүрмийг зөвхөн БГХ-аас үндсэн хөрөнгийн 3/4-аас дээш олонхоор өөрчилнө. Зөвхөн найруулгатай холбоотой асуудлыг ХЗ-д шилжүүлж болно.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Principles of Corporate Governance. OECD.2004
- АНУ-ын "Делавэрийн Компанийн ерөнхий хууль" /The Delaware General Corporation Law/ <http://delcode.delaware.gov/title8/c001/index.shtml>
- АНУ-ын Үнэт цаасны тухай хууль /Securities Act/, 1933 он.
- Их Британийн Компанийн хууль, 2006.

- БНТУ-ын Худалдааны хууль, 2011 он.
- ХБНГУ-ын Хувьцааны тухай хууль, 1965 он.
- Федеральный закон "Об акционерных обществах" (Об АО) от 26.12.1995 N 208-ФЗ (принят ГД ФС РФ 24.11.1995).
Эх сурвалж: <http://www.consultant.ru/popular/stockcomp/>
- <http://www.hg.org/shareholders-rights.html>
- www.wikipedia.com
- The Enforcement of Shareholders' Agreements. Comparative Analysis of English and Russian Law. Tilburg Law School, 2012.
- Модельные законодательные положения для государств - участников СНГ о защите прав инвесторов на рынке ценных бумаг. Приняты на двадцать пятом пленарном заседании Межпарламентской Ассамблеи государств - участников СНГ (постановление № 25-7 от 14 апреля 2005 года).

**ХУВЬЦАА БАРЬЦААЛАН ЗЭЭЛДЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ТАЛААРХ ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА**
(Мэдээлэл лавлагаа)

*Д.Байгалмаа Г.Билгээ,
Ч.Онончимэг Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

Оршил

Хувьцаа барьцаалан зээл авах эрх зүйн зохицуулалтын талаарх зарим орнуудын туршлага

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улс
2. Бүгд Найрамдах Казахстан Улс
3. Бүгд Найрамдах Солонгос Улс
4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Ашигласан материал

ОРШИЛ***Судалгааны хамрах хүрээ***

Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу хувьцааг барьцаалан зээл авах боломжийг гадаадын зарим орнуудад хэрхэн зохицуулдаг талаар судлахыг зорилоо. Энэхүү зорилгын хүрээнд БНЭУ, БНКУ, БНСУ, БНХАУ-ыг хамруулан, үнэт цаас /хувьцаа нь өөрөө үнэт цаас учраас/-ыг барьцаалах эрх зүйн зохицуулалтын талаар тусгасан болно.

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хувьцааг барьцаалж зээл авч болохыг БНСУ-д Иргэний хуулиар, БНЭУ-д Гэрээний хуулиар, БНКУ, БНХАУ-д Компанийн хуулиар тус тус зөвшөөрдөг ба хувьцааг барьцаалах процессын талаар БНЭУ нь Хадгаламжийн байгууллагын хуулиндаа, БНХАУ нь Үнэт цаасны хуулиндаа нэлээд нарийн зохицуулалт хийсэн байна. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа барьцаалах, худалдах, шилжүүлэх эрхийн хүрээнд түүний хөдөлгөөнийг тухайн улсуудад бүртгэх эрх бүхий байгууллагууд хийнэ. БНСУ-ын хувьд үнэт цаасны гэрчлэгдсэн эрхийг барьцаалагчид шилжүүлэхээс гадна гэрчилгээг биет хэлбэрээр нь шилжүүлж болох эрх зүйн зохицуулалттай байна.

Хувьцаагаа барьцаалж зээл авах нь зөвхөн хувь хүн, хуулийн этгээдийн хувьд санхүүгийн эх үүсвэрээ шийдвэрлэх арга зам болох төдийгүй улс орны хувьд хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгсэл болгон ашиглаж байгаа талаар Энэтхэг улсын жишээн дээр харж болох юм.

Түүнчлэн, хувьцааг барьцаалан зээл олгогч тал буюу банк санхүүгийн байгууллагуудад тавигдах шаардлагыг хуулиар зохицуулахдаа Энэтхэгт зээлдэгч, зээлдүүлэгч талын нийт хувьцааны аль багаас нь тооцон 30 хүртэл хувийг, Казахстанд зээлдэгч талын 25 хүртэл хувийг, Хятадад зээлдэгч тал түүн дотроо зөвхөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг барьцаалж болох талаар заасан байна.

Хувьцаа барьцаалан зээл авах эрх зүйн зохицуулалтын талаарх зарим орнуудын туршлага

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улс

БНЭУ-ын Гэрээний Хууль (Indian Contract Act)-ийн 172 дахь хэсэгт “барьцаа буюу pledge”-ийг тодорхойлохдоо:

- Барьцаа нь барьцаалуулагчийн барааг барьцаалагчид хүргэх хамгаалалтын арга зам нь гэрээ бөгөөд гэрээний үүрэг биелэгдсэн үед барьцаалуулагчид буцааж өгнө.
- Барьцаа нь зөвхөн эзэмших эрх үүссэнээр бий болох ба барьцаалсан хөрөнгө нь барьцаалуулагчид хэвээр байна.

Яагаад хувьцааг барьцаалах нь онцгой нөхцөлтэй байдаг вэ.

Хувьцаа нь хуульд заасны дагуу бараа тул нийтлэг хуулиар зохицуулагдах ёстой боловч Хадгаламжийн Байгууллагын Хууль (Depositories⁶⁸ Act)-аар хувьцааг материаллаг бус (dematerialisation)⁶⁹ хэлбэрт хамруулан авч үздэг. Материаллаг бус хэлбэрт оруулах шалтгаан нь хувьцааны хууль ёсны эзэмшигч нь хувьцааг эзэмшсэнээр ашиг хүртэх сонирхолтой холбоотойгоор хувьцаагаа арилжих, шилжүүлэх, барьцаалах гэх мэт хөдөлгөөнүүдийг бүртгэж байх шаардлага гардаг.

Иймээс Гэрээний хууль (Indian Contract Act)-аар хувьцааны барьцаатай холбоотой ерөнхий асуудлуудыг зохицуулах боломжтой ба тусгайлсан заалтуудыг Хадгаламжийн байгууллагын хууль (Depositories Act), Үнэт цаас, Арилжааны Зөвлөлийн журам (Securities and Exchange Board of India regulations)-аар зохицуулж байна.

1996 оны Хадгаламжийн байгууллагын хуулийн 12-р хэсэгт зааснаар:

- Үнэт цаасыг хадгаламжийн байгууллагад хадгалах бөгөөд үнэт цаасны барьцаа, ипотека нь ч хадгаламжийн байгууллагад бүртгэгдэнэ.
- Хадгаламжийн байгууллагын урьдчилсан зөвшөөрөлтэй ашиг эзэмшигч (beneficial owner⁷⁰) буюу үнэт цаас өмчлөгч нь барьцаа болон ипотекийг үүсгэх эрхтэй.
- Ашиг эзэмшигч буюу үнэт цаас өмчлөгч бүр хадгаламжийн байгууллагад барьцаа, ипотекийн талаарх мэдэгдлээ өгч байх ёстой. Тухайлбал, хадгалагчийг бүртгэлд тэмдэглэгээ хийлгэхийг шаардах гэх мэт.
- Хадгаламжийн байгууллагын бүртгэл дэх тэмдэглэгээ нь барьцаа болон ипотекийн нотлох баримттай байна.

Тус улсын хувьд үнэт цаасны барьцаа, ипотекийн барьцааг Үнэт цаас, Арилжааны Зөвлөлийн журам (Securities and Exchange Board of India regulations)-д зааж өгсөн бөгөөд ипотекийн бүртгүүлэх процесс нь бага зэрэг ялгаатай ч үүсэх эрх нь хувьцааны барьцаатай адил.

Энэтхэгийн Үнэт цаас, Арилжааны Зөвлөлийн журам (Securities and Exchange Board of India regulations)-ын 58-р зүйлээр үнэт цаасны барьцаалах процессыг дэлгэрэнгүй заасан. Үүнд:

⁶⁸Тухайн хуулийнхаа нэр томъёоны тайлбарт “хадгаламжийн байгууллага буюу depository” гэж 1956 оны Компанийн хуулийн дагуу компанийн хэлбэрээр бүртгэгдсэн, 1992 оны Энэтхэгийн Үнэт цаас, Арилжааны Зөвлөлийн Хуулийн 12.(1A)-д заасны дагуу гэрчилгээ авсан байгууллага юм.

⁶⁹Үнэт цаасны эзэмшлийг төлөөлж буй эрхийн бичиг болох биет гэрчилгээ буюу баримтыг халж, зөвхөн бүртгэлийн бичилтийн үндсэн дээр орших хэлбэр юм.

⁷⁰“Бенефициар өмчлөгч (beneficial owner)” гэж хуульд заасны дагуу номиналь эзэмшигчийн нэр дээр өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг бүртгүүлсэн, тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрхтэй жинхэнэ өмчлөгчийг хэлнэ

- (1) Хэрвээ ашиг эзэмшигч буюу үнэт цаас өмчлөгч нь үнэт цаасаа барьцаалахаар төлөвлөсөн бол хадгаламжийн байгууллагад өргөдөл гаргана.
- (2) Өргөдлийн дагуу барьцаалах боломжтой үнэт цааснуудад барьцааны тэмдэглэгээг хийнэ.
- (3) Хадгаламжийн байгууллага нь барьцаалагчаар баталгаажуулсны дараа үнэт цааснуудыг барьцаалах боломжтой гэдгийг өргөдөл хүлээн авснаас хойш 15 өдрийн дотор шийдвэрлэж, барьцаалагч, барьцаалуулагчийн аль алинд илгээнэ.
- (4) Дээрх (3) заалтын дагуу мэдэгдлийг хүлээн аваад, барьцаалагч болон барьцаалуулагч нь барьцаа үүсгэсэн бүртгэлээ тус тусдаа хийнэ.
- (5) Хэрвээ хадгаламжийн байгууллага нь барьцааг үүсгэхгүй бол барьцаалагч барьцаалуулагчид илгээх мэдэгдэлдээ шалтгааныг нь заана.
- (6) Хэрвээ барьцаалагч болон барьцаалуулагч өргөдөл гаргахдаа барьцаалагчийн урьдчилсан зөвшилцөлгүйгээр хадгаламжийн байгууллага барьцааны бүртгэлийг хийхгүй гэдгийг заасан тохиолдолд заалт (3)-т заасан барьцааны бүртгэлийг хадгаламжийн байгууллага хүчингүй болгож болно.
- (7) Хадгаламжийн байгууллага нь барьцааны бүртгэлийг хүчингүй болгохдоо барьцаалуулагчид мэдэгдэнэ.
- (8) Барьцааны баримт бичгийн нөхцөлүүдэд үндэслэн, барьцаалагч барьцааны тайлбарыг хийж болох бөгөөд хадгаламжийн байгууллага энэхүү тайлбарыг өөрийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулна.
- (9) Заалт (8)-ын дагуу засварласны дараагаар хадгаламжийн байгууллага тухайн засварыг барьцаалагч, барьцаалуулагч 2 талд нэн даруй мэдэгдэнэ.
- (10) Хэрвээ ашиг эзэмшигч буюу үнэт цаас өмчлөгч нь ипотекийн барьцааг үүсгэхээр бол (1), (9)-р заалтуудыг мөрдөнө.
- (11) Барьцаалуулагчийн зөвшилцөлгүй гэх мэт аль ч нөхцөлтэйгөөр барьцаанд бүртгүүлсэн үнэт цаасыг бусдад шилжүүлэхгүй.

Хувьцааг барьцаалж зээл олгож байгаа тал буюу банк, санхүүгийн байгууллагын зүгээс авч үзэхэд, зээлийн эрсдлээ хааж хувьцааг барьцаалж байгаа тул тухайн хувьцааны ноогдол ашиг, зах зээлийн үнэ ханш зэрэг нь барьцааны үнэлгээнд нөлөөлнө. Иймээс зээлдэгч тал эрсдлээ харгалзан баталгаажсан хувьцаа, давуу эрхтэй хувьцаануудыг барьцаанд авах сонирхол давамгайлдаг.

БНЭУ-ын Банкны Зохицуулалтын Хууль (Banking Regulation Act, 1949)-ийн 19-р заалтаар банкны үйл ажиллагааны хязгаарлалтуудыг заасан ба хувьцааг барьцаалахтай холбоотой доорх заалтууд байна. Үүнд:

19(2). Банк нь дэд заалт (1)-ийг мөрдөх ба барьцаалагч (pledge), моргейжийн зээлдэгч (mortgage), absolute owner-ийн аль нь ч байсан тухайн компанийн хувьцаат капиталд төлсөн хувьцааны 30 хувь эсвэл банк өөрийн эзэмшдэг капитал, нөөцийн 30 хувиас хэтэрсэн хэмжээтэй хувьцааг эзэмшихгүй ба аль багаас нь тооцно.

Банк нь хуулийн энэ дэд заалттай зөрчилдөх ямар нэг хувьцааг эзэмшиж эхэлсэн өдрөө Нөөцийн Банкинд нэн даруй мэдээгээ тайлагнана гэж заасан ба хэрвээ цаг хугацаандаа тайлагнаж чадсан бол ямар нэг торгууль ноогдуулахгүй. Хэрвээ банк эдгээр хувьцаагаа 2 жилийн дотор хэлсэн заалтуудад нийцүүлнэ гэвэл Нөөцийн Банк зөвшөөрч болно.

(3). Дэд заалт (2)-т багтсан хэдий ч банк нь энэ хуулийн заалттай зөрчилдсөн хувьцааг эзэмшиж эхэлснээс 1 жилийн хугацаа өнгөрснөөс хойш барьцаалагч (pledge), моргажийн зээлдэгч (mortgage), absolute owner-ийн аль нь ч байсан банкны удирдлага, менежерүүдээс компанийн менежментэд янз бүрийн харилцаа, ашиг сонирхлын холбоотой байж болохгүй.

Энэтхэгийн Засгийн газар, Нөөцийн банкнаас 2011 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг чөлөөтэй, оновчтой, хялбаршуулах, гадагш урсах шилжүүлгийг бууруулах зорилгоор хэд хэдэн оролдлого хийсний нэг нь, оршин суугч бус хөрөнгө оруулагчдад Энэтхэгийн компанийн хувьцааг эзэмшихдээ тодорхой нөхцөл зааж, тухайн хувьцаагаа барьцаалан, “AD Category-I” банкуудаас зээл авах боломжийг олгосон байна. Ингэхдээ:

1. Барьцааг дуудах (invocation of pledge), хувьцааг шилжүүлэх тохиолдолд барьцааг үүсгэх үеийн хөрөнгө оруулалтын бодлогод нийцсэн байна.
2. Зээлийн зориулалт нь бодит бизнест ашиглагдана гэсэн албан ёсны аудиторын мэдэгдэлтэй байна.
3. Хувьцааг нь барьцаалсан Энэтхэгийн компани нь Үнэт цаас, Арилжааны Зөвлөлөөс тавих шалгуурыг дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл, Энэтхэгийн компани нь Худалдан авах хууль (Takeover Code)-ийн 8А, Үнэт цаасны гэрээ (Listing Agreement)-ний 35/41 заалтуудыг мөрдөнө.
4. Зээлдүүлэгч банк Банкны Зохицуулалтын Хууль (Banking Regulation Act)-ын 19-р заалтыг дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч банк нь тухайн зээлдэгч компанийн хувьцаат капиталд төлсөн хувьцааны 30 хувь эсвэл банк өөрийн эзэмшдэг капитал, нөөцийн 30 хувиас хэтэрсэн хэмжээтэй хувьцааг барьцаанд авч болохгүй ба эдгээрийн аль багаас нь тооцно гэсэн шаардлагуудыг тавьдаг байна.

2. Бүгд Найрамдах Казахстан Улс

БНКУ-ын Иргэний хууль /Гражданский кодекс РК⁷¹/-ийн 139-р зүйлийн 1-д, Хувьцаат компанийн тухай хууль /Закон РК Об акционерных обществах⁷²/-ийн 1-р зүйлд “хувьцаа”-г хувьцаат компаниас гаргаж буй үнэт цаас хэмээн тодорхойлоод, эзэмшигчид нь хувьцаат компанийг удирдах эрхийг олгох, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх болон Казахстаны хууль тогтоомжоор олгосон бусад эрхийг эдэлнэ хэмээн заасан байна.

Компанийн үнэт цаасыг барьцаалахтай холбоотой харилцааг Хувьцаат компанийн тухай хуулийн 31-р зүйлээр зохицуулж өгсөн байна. Хуулийн 31.1-д зааснаар компанийн үнэт цаасыг барьцаанд тавих эрхийг компанийн дүрмээр хязгаарлахгүй ба хэрэв барьцааны гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь саналын эрхтэй, мөн барьцаанд тавьсан хувьцааны ногдол ашгийг авах эрхтэй.

Хуулийн 31.2-т компани нь өөрийн байршуулсан хувьцаа эзэмшигчийн хувьцааг дараах журмын дагуу барьцаанд авч болохыг заасан байна. Үүнд:

1. эзэмшигч нь барьцаанд тавьж буй үнэт цаасны төлбөрийг бүрэн хийсэн байх,
2. компанийн барьцаанд шилжүүлэх гэж байгаа, барьцаанд хэдийн шилжүүлсэн хувьцааны нийт дүн компанийн байршуулсан хувьцааны 25 хувиас илүүгүй байх /үүнд компанийн худалдан авсан хувьцаа хамаарахгүй/,
3. хувьцаа барьцаалах гэрээг компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол захирлуудын зөвлөлөөр батлуулах.

Барьцааны гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй бол компанийн барьцаалж авсан хувьцааны саналын эрх нь хувьцаа эзэмшигчид байна, өөрөөр хэлбэл, компани нь барьцаалж авсан хувьцаагаараа санал хураалтад оролцох эрхгүй.

⁷¹Гражданский кодекс Республики Казахстан (Общая часть) (с изменениями и дополнениями по состоянию на 03.07.2013 г.). Эх сурвалж: ИС ПАРАГРАФ.

⁷²Закон Республики Казахстан от 13 мая 2003 года № 415-ІІ “Об акционерных обществах” (с изменениями и дополнениями по состоянию на 04.07.2013 г.). Эх сурвалж: ИС ПАРАГРАФ.

3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Хуулийн этгээд, хувь хүнээс компанийн хувьцаагаа барьцаалан банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авах талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүй бөгөөд харин хувьцаа нь үнэт цаасны нэг төрөл болохын хувьд Иргэний хууль, Иргэний процессийн тухайн хуулиар зохицуулдаг байна.

Тус улсын Иргэний хуулийн⁷³ VIII “Барьцааны эрх” дэд хэсгийн, “Эрх барьцаалах эрх” II бүлэгт Үнэт цаасны эрх барьцаалах /350-353 дугаар зүйл/, мөн хуулийн гэрээний эрх зүйн харилцаагаар зохицуулсан болно.

Уг Иргэний хуулийн 350-р зүйлд Тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг барьцаалах тохиолдолд үнэт цаасны гэрчилгээнд /энэ тохиолдолд тухайн гэрчилгээ нь хувь хүн, хуулийн этгээдийн нэр тодорхой байна/ гарын үсэг зурж, баталгаажуулан барьцаалагч этгээдэд уг гэрчилгээг шилжүүлэн, гэрээ байгуулснаар уг барьцаалах эрх хүчин төгөлдөр болно. Талуудын хувьд үнэт цаас барьцаалсан зээлийн гэрээний хувьд мөн хуулийн 527-553 зүйлийг удирдлага болгон байгуулна.

Зээлийн гэрээний хувьд зээлийн ханшийг тооцохдоо үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх цагийн ханшаар зээлийн хэмжээг тооцож буцаан олгохоор тусгана.

Үнэт цаасны эрх эзэмшигч этгээдийн хувьд гэрээний хугацаанд барьцааны зүйл болох эрхийг барьцаалагч /зээл олгосон банк, банк бус санхүүгийн байгууллага гэх мэт/-ийн зөвшөөрөлгүй дуусгавар болгох, барьцаалагчийн эрх ашиг хөндсөн аливаа өөрчлөлт хийх эрхгүй байна.

Үнэт цаас барьцаалсан зээлийн гэрээний хувьд нэг онцлог зохицуулалт нь Иргэний хуулийн 353-р зүйл Барьцааны зүйл болсон эрхийг хэрэгжүүлэх аргыг дараах 3 хэлбэрээр хэрэгжүүлэхээр хуульчилсан байна.

1. Барьцаалуулагч буюу үнэт цаас эзэмшигч/ этгээдийн эзэмших эрхийг шууд шилжүүлэн авахаар шаардлага гаргаж болно.
2. Барьцааны зүйл болсон шаардах эрх нь мөнгөн дэвсгэртээр байгаа тохиолдолд барьцаалагч өөрийн нэхэмжлэлийн хэмжээнд тухайн мөнгөнөөс шаардах эрхтэй.
3. Гэрээгээр тохиролцсон бол шаардах эрхийн төлбөр нь барьцаалагч этгээдийн шаардлагаас түрүүлж болох тохиолдолд барьцаалуулагч этгээдийн хувьд зээлийг гуравдагч этгээдэд хариуцуулахаар шаардлага гаргаж болно. Энэ тохиолдолд барьцааны эрх нь тухайн хариуцуулсан мөнгөний хэмжээнд байна.

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь дэлхийн томоохон зах зээл болохын хувьд хувьцаагаа барьцаалах, түүнийг ашиглан санхүүгийн байгууллагуудаас зээл авах санхүүгийн арга хэрэгсэл болохын тухайд түүний ач холбогдол болоод эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагын үүднээс 1995 оноос эхлэн эрх зүйн томоохон өөрчлөлт, зохицуулалтыг хийж ирсэн байна.

Хятадад компанийг дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийн жагсаалтад бүртгэгдсэн компани, жагсаалтад үл хамаарах гадаадын хөрөнгө оруулалттай компани, жагсаалтад үл хамаарах дотоодын хөрөнгө оруулалттай компани гэж 3 ангилдаг байна. 1997 оны Үнэт цаасны тухай хуулиар хувьцааны барьцааны 3 төрлийг тогтоосон бөгөөд 2007 оны хуулиар хувьцааны барьцааны 3 төрөл болон түүнийг бүртгэх бүртгэлийн системийг шинэчлэн тогтоосон байна.

⁷³faculty.pccu.edu.tw/~borshan/korean%20Civil%20Code.doc

1995 оны Үнэт цаасны тухай хуулиар хуулийн дагуу шилжүүлж болох хувьцааг барьцаалах бол барьцаалагч болон барьцаалуулагч бичгээр барьцааны гэрээ үйлдэж үнэт цаасны бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ. Барьцааны гэрээ бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Хэрвээ хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг барьцаалж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчинтэй болохоор зохицуулсан байдаг байна.

Хятадын дээд шүүхийн тайлбарын дагуу хуулийн дагуу шилжүүлж болох хувьцаа гэдэг ойлголтод дээр дурдсан дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийн жагсаалтад хамрагдсан компанийн хувьцааг л хамруулдаг бөгөөд жагсаалтад хамаарах болон үл хамаарах компаниудад хувьцаа барьцаалах болон тэдгээрийн хүчин төгөлдөр болох журмын талаар өөр өөрөөр тогтоодог байна.

Ихэнх гадаадын хөрөнгө оруулалттай компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг тул үүнээс үүдэн эдгээр компанийн хувьцааны барьцаатай холбоотой практикт зарим нэг хүндрэл үүсэх болсон тул хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьцааг шилжүүлэхэд Худалдааны яам, түүний салбар нэгжээс зөвшөөрөл авдаг байна.

Хэрвээ яамны зөвшөөрөлгүй хувьцаа барьцаалах тохиолдолд энэ нь банк зэрэг томоохон санхүүгийн байгууллага, зээлдэгч нарын хувьд татгалзах эрсдэлтэйд тооцогддог тул энэ нь нэг талаас аюулгүйн баталгаа болж өгдөг байна. Хэрвээ зөвшөөрөл аваагүй бол хүчингүйд тооцогддог байна.

Харин төрийн өмчийн хувьцааны тухайд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг зөвхөн захирлуудын зөвлөлийн хуралдаанаар компанийн болон салбар охин компанийн өр төлбөр аюулгүй байдлын шаардлагаар барьцаалж болох зохицуулалттай байдаг байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тухайд хувьцаа эзэмшигч нь зөвхөн өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээний хувьцааг барьцаалж болох буюу хувь оруулаагүй хувьцааг барьцаалах боломжгүй байдаг.

Хувьцаа барьцаалах зөвшөөрлийг Худалдааны яамнаас хүсэхэд дараах материалыг бүрдүүлэх шаардлагатай байдаг байна.

- Компанийн болон хувьцаа эзэмшигчийн барьцаалагчид хувьцаагаа барьцаалахыг хүссэн буюу зөвшөөрсөн шийдвэр
- Хувьцаа барьцаалах гэрээ
- Хувьцаагаа барьцаалж байгаа хувьцаа эзэмшигчийн тухайн компанид хөрөнгө оруулсан талаарх баримт бичиг
- Мэргэшсэн нягтлан бодогч буюу тус чиглэлийн компаниас хөрөнгө оруулалтыг баталгаажуулсан, хянасан талаарх тайлан

Худалдааны яам материалыг 30 хоногийн дотор хянаж зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Зөвшөөрөл авсан нөхцөлд 30 хоногийн дотор үнэт цаасны бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн нөхцөлд барьцааны гэрээ хүчин төгөлдөр болдог зохицуулалт болон Худалдааны яамнаас зөвшөөрөл авдаг хуулийн зохицуулалтууд хоорондоо давхардаж зөрчилдөөн үүсгэдэг талаар дурдсан байна.

Жагсаалтад үл хамаарах дотоодын компаниудын тухайд хувьцааны барьцааны гэрээ хувьцаа эзэмшигчдэд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болдог. Жагсаалтад үл хамаарах дотоодын хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухайд Үнэт цаасны тухай хууль болон 2005 оны Компанийн тухай хуулиар зохицуулагддаг байна. Тус хуульд зааснаар гуравдагч этгээдэд хувьцаа шилжүүлэх нөхцөлд бусад хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг шаарддаг юм байна. Энэ хэсэгт дурдаж байгаа хувьцааг бүртгэх нийтийн бүртгэлийн систем байхгүйн улмаас Хятадад дотоодын жагсаалтад үл хамаарах компанийн хувьд хувьцаа барьцаалах асуудал зогсонги байдалд орсон байна. Учир нь зээлдүүлэгч тухайн хувьцаа үнэт цаасны барьцаанд байгаа эсэх талаар буюу статусын талаарх мэдээлэл авах боломжгүй байдаг байна.

Хувьцаат компанийн тухайд хувьцаа барьцаалахад бусад хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр барьцаалж болдог байна. 2007 оны Өмчийн тухай хуулиараа дээрх нэгдсэн бүртгэлийн асуудлыг бүрэн шийдсэн гэж үздэг байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. БНЭУ-ын Хадгаламжийн байгууллагын хууль, № 22, 1996 он. (The Depositories Act, No.22, India, 1996)
2. БНЭУ-ын Үнэт Цаас, Арилжааны Зөвлөлийн Журам, 1996 он. (Securities and Exchange Board of India /depositories and participants/ regulations)
3. БНЭУ-ын Банкны Зохицуулалтын Хууль, 1949 он. (Banking Regulation Act, 1949)
4. Гражданский кодекс Республики Казахстан (Общая часть) (с изменениями и дополнениями по состоянию на 03.07.2013 г.). Эх сурвалж: ИС ПАРАГРАФ.
5. Закон Республики Казахстан от 13 мая 2003 года № 415-III "Об акционерных обществах" (с изменениями и дополнениями по состоянию на 04.07.2013 г.). Эх сурвалж: ИС ПАРАГРАФ.
6. <http://scholarlycommons.law.wlu.edu/cgi/viewcontent.cgi?article=2438&context=wlulr>
7. http://www.mongolbank.mn/documents/paymentsystems/CPSS_Glosary_Final.pdf
8. <http://indianlegalspace.blogspot.com/2011/07/pledge-of-shares-fdi.html>
9. <http://faculty.pccu.edu.tw/~borshan/korean%20Civil%20Code.doc>

**ОФФШОР БҮСИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОФФШОР БҮСЭД КОМПАНИ
БАЙГУУЛАХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА
БОЛОН ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН ОФФШОР БҮСЭД ДАНС
НЭЭХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ, АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАХ
АСУУДЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА
(Харьцуулсан судалгаа)**

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Байгалмаа,
Ч.Онончимэг, Г.Билгээ*

АГУУЛГА

Оршил

Судалгааны хэсэг

1. Оффшор бүсийн тухай ойлголт, оффшор бүсэд компани байгуулах, хөрөнгө эзэмшихтэй холбоотой харилцааны талаарх лавлагаа мэдээлэл
2. Оффшор бүсэд үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт
3. Төрийн өндөр албан тушаалтан оффшор бүсэд данс нээх, хөрөнгө эзэмших, ашиглахыг хориглох тухай эрх зүйн зохицуулалт

Хавсралт. ОХУ-ын Төрийн өндөр албан тушаалтнуудын жагсаалт

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгаанд захиалагчдын хүсэлтийн дагуу оффшор бүсийн тухай ойлголт, тодорхойлолт болон оффшор бүс ба оффшор бүс дэх компани, банк, банк бус санхүүгийн байгууллага, банкинд данс эзэмших, ашиглах зэрэг асуудлуудаар ерөнхий ойлголт өгөх, зарим орны оффшор бүсийн холбогдох хууль тогтоомжуудыг харьцуулан судлах зорилго тавив. Мөн төрийн өндөр албан тушаалтанд оффшор бүсэд банкинд данстай байх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бусад оронд бий эсэх, энэ талаарх дэлхий нийтийн хандлага ямар байгааг олдсон мэдээллийн хувьд харьцуулан судлах зорилт тавив.

Судалгааны хамрах хүрээ

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах асуудлуудыг тодруулахыг зорьсон болно. Үүнд:

- Оффшор бүсийн тухай ойлголт, тодорхойлолт
- Оффшор бүсэд компани байгуулах, банк, банк бус санхүүгийн байгууллагад данс нээх
- Энэ талаарх гадаадын зарим орны төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт
- Төрийн өндөр албан тушаалтан оффшор бүсэд данс нээхийг хориглох тухай бусад орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан 9 орны хувьд ихэнх нь (7) өндөр хөгжилтэй, санхүүгийн зах зээлийн хөгжил нь төлөвшсөн орнууд /зарим нь оффшор бүстэй/ байх тул оффшор бүсэд төрийн өндөр албан тушаалтан данс нээх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглосон эрх зүйн зохицуулалт үндсэндээ байхгүй байна. Иймд оффшор бүсийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн буюу оффшор бүсийг харьяалж байгаа орнуудын оффшор бүсэд компани байгуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалтын жишээ болгон БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс болох Макаогийн холбогдох хуулийн зохицуулалтыг дэлгэрэнгүй байдлаар судлав. /Судалгаанаас үзнэ үү/

Харин оффшор бүсэд төрийн өндөр албан тушаалтан данс нээх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглосон эрх зүйн зохицуулалттай орны жишээ болгон ОХУ-ын туршлагыг судалж, **“Зарим категорийн хүмүүст ОХУ-ын газар нутгаас гадуур гадаадын банкинд данс нээх, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалах, олон улсын санхүүгийн хэрэгсэл худалдан авах, ашиглахыг хориглох тухай”** ОХУ-ын Төрийн Думаар 2013 оны 4-р сарын 24-нд баталсан хуулийн албан бусаар орчуулж хавсаргав.

Мөн Украин улс энэ чиглэлийн хязгаарлалт хийхийг зорьж байгаа тул 2013 оны 11-р сард Украины Дээд Рада-д өргөн барьсан хуулийн төслийн талаарх мэдээллийг судалгаанд оруулав.

Судалгааны үр дүнг тоймлон дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1/ Өндөр хөгжилтэй орнуудын тухайд: Төрийн өндөр албан тушаалтнууд өөрийн орноос гадуур гадаадын банкинд данстай байх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бий эсэх, энэ талаарх хандлага ямар байгааг дэлхийн зарим өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал, Их Британи, Франц, Герман, Финланд, Украин, Өмнөд Солонгос, АНУ зэрэг орнуудын хувьд авч үзлээ. Эдгээр орнуудад энэ талаар тавьсан ямар нэгэн хориг, тусгайлсан эрх зүйн зохицуулалт олдсонгүй.⁷⁴ Өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтнууд гадаадад үл хөдлөх хөрөнгөтэй байх, гадаадын банкуудад данстай байхыг тусгайлсан хуулиар хориглоогүй гэж дээрх орнуудын хувьд хэлж болохоор байна. Эдгээр орнуудын хувьд төрийн албан тушаалтнууд нь гадаадад эзэмшиж буй актив, дансныхаа талаар эрх бүхий байгууллагад тодорхой мэдээлэх үүрэгтэй.

2/ Хуучин социалист буюу хөгжиж буй орнуудын хувьд: Төрийн өндөр албан тушаалтнууд өөрийн орноос гадуур гадаадын банкинд данстай байх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, ОХУ, Украин улсын хувьд авлига, хээл хахууль, ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх, эдийн засгийн болон мөнгө угаах зэрэг гэм хэрэгт төрийн өндөр албан тушаалтан холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс төрийн өндөр албан тушаалтнуудыг гадаадад өмнө нь нээсэн дансаа хаалгах, байршуулсан хөрөнгөө эргүүлэн татах, ил тодоор тайлагнах зэрэг үүрэг хариуцлага хүлээлгэсэн тусгайлсан хууль батлан гаргаж, цаашид гадаадын банкинд данс нээх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглосон байна.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар энэхүү хуулийн зохицуулалтанд хамрагдах Төрийн өндөр албан тушаалтнуудын жагсаалтыг баталсан бөгөөд хууль хүчин төгөлдөр болсноос

⁷⁴“Российская газета” - Федеральный выпуск №5859 от 15 августа 2012 г. Тодруулга: “Российская газета” - ОХУ-ын Засгийн газрын албан ёсны хэвлэл бөгөөд түүний статусыг Холбооны хуулиар зохицуулсан байна. Эх сурвалж: <http://www.rg.ru/gazeta/2012/08/15.html>

хойш 3 сарын дотор жагсаалтад хамрагдсан албан тушаалтнууд гадаадын банкинд байгаа дансаа хаалгах, үнэт зүйлс болон бусад санхүүгийн хэрэгсэлээ хадгалуулах, эзэмшихийг зогсоох үүрэгтэй.

Украинд 2013 оны 11-р сард төрийн өндөр албан тушаалтанд гадаадын банкинд данстай байхыг хориглох тухай хуулийн төслийг өргөн бариад байна. Энэхүү хуулийн төслийн агуулга нь ОХУ-ын хуультай төстэй бөгөөд хэрэв хууль батлагдвал Украины төрийн албан тушаалтнууд хилийн чанадад данс нээх, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгөтэй байхыг хориглохоор заажээ.

Концепцийн хувьд ийм төрлийн хуулийн зохицуулалт хийх шаардлага нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах, хөрөнгийн гадагшлах урсгалыг зогсоож дотоодын эдийн засагт чиглүүлэх, авлигаас сэргийлэх, гадаадад байгаа хөрөнгийг хууль ёсны болгож улс орондоо эргүүлэн татах зорилгоос үүдэлтэй хэмээн хуульд тодорхойлжээ.

/Дэлгэрэнгүйг судалгаанаас үзнэ үү/

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. ОФФШОР БҮСИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОФФШОР БҮСЭД КОМПАНИ БАЙГУУЛАХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд өөрийн орноос гадуур гадаадын банкинд данстай байх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт бий эсэх, энэ талаарх хандлага ямар байгааг дэлхийн зарим өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал, Их Британи, Франц, Герман, Финланд, Украин, Өмнөд Солонгос, АНУ зэрэг орнуудын хувьд авч үзлээ. Эдгээр орнуудад энэ талаар тавьсан ямар нэгэн хориг, тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.⁷⁵ Өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтнууд гадаадад үл хөдлөх хөрөнгөтэй байх, гадаадын банкуудад данстай байхыг хориглоогүй. Гэхдээ төрийн албан тушаалтнууд нь гадаад эзэмшиж буй актив, дансныхаа талаар эрх бүхий байгууллагад тодорхой мэдээлэх үүрэгтэй.

Их Британид, хэрэв Засгийн газрын төрийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн мэдүүлээгүй тохиолдолд эхлээд дотоод шалгалт хийх ба үүнийг тухайн албан хаагчийн ажиллаж байгаа яам хариуцна, эсхүл Ерөнхий сайд нь сайд нарын асуудал хариуцсан тусгай зөвлөхийг томилж шалгуулна. Шалгалтаар авлига, луйврын асуудал гарч ирвэл цагдаагийн байгууллагад шилжүүлнэ, өөрөөр хэлбэл, үүнтэй холбоотой зөрчлийг Эрүүгийн хуулиар зохицуулна.

Францын Парламент 2013 оны 9-р сард “Улс төрийн ил тод байдлын тухай” хуулийг⁷⁶ баталж, уг хуулийн дагуу 10-р сард бие даасан Олон нийтийн ил тод байдлыг зохицуулах дээд удирдлага⁷⁷ хэмээх байгууллагыг 1980-аад оны сүүлээр байгуулагдсан Улс төр дахь санхүүгийн ил тод байдлын хорооны⁷⁸ оронд байгуулагдсан байна. Тус байгууллага нь тодорхой сонгогдсон албан тушаалтан, ажилтан, албан хаагчдын санхүүгийн байдал, ашиг сонирхлын мэдүүлгийг хүлээн авах, шалгах, олон нийтэд хэвлэл мэдээллээр нийтлэх үүрэгтэй.

⁷⁵“Российская газета” – Федеральный выпуск №5859 от 15 августа 2012 г. Тодруулга: “Российская газета” - ОХУ-ын Засгийн газрын албан ёсны хэвлэл бөгөөд түүний статусыг Холбооны хуулиар зохицуулсан байна. Эх сурвалж: <http://www.rg.ru/gazeta/2012/08/15.html>

⁷⁶LOI organique n° 2013-906 du 11 octobre 2013 relative a la transparence de la vie publique.

Эх сурвалж: <http://www.legifrance.gouv.fr/>

⁷⁷Haute Autorité pour la transparence de la vie publique.

⁷⁸Commission pour la transparence financière de la vie politique.

Эдгээр албан тушаалтнуудын жагсаалтад Засгийн газрын гишүүд, тэдний орлогчид, парламентын гишүүд, сенаторууд, европарламентын гишүүд, Сайд нарын зөвлөлөөс томилдог өндөр албан тушаалтнууд, агентлагийн дарга нар, төрийн оролцоотой үйлдвэрийн газрын дарга нар, 20 мянгаас дээш хүн амтай хотын дарга нар, 100 мянгаас дээш хүн амтай томоохон хотуудын дарга нарыг оролцуулсан 7 мянга гаруй хүн хамрагдсан байна. Тус хороо нь тухайн албан тушаалд томилогдсон, эсхүл сонгогдсон этгээдийн дотоодод болон гадаадад байгаа хөрөнгө, санхүүгийн мэдүүлгийг ажил үүргээ эхлүүлэхээс нь өмнө авна. Албан тушаалтнууд хөрөнгө, орлогын мэдүүлгээ Олон нийтийн ил тод байдлыг зохицуулах дээд удирдлагад илгээх ба тус байгууллага нь хүлээн авсан мэдүүлгүүдийг холбогдох /тухайлбал, татварын/ байгууллагуудын мэдээлэлтэй тулгах, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй. Хэрэв мэдүүлгийг буруу мэдүүлсэн бол 3 жил хүртэл хорих ял, эсхүл 45 мянган еврогийн торгуультай.

Украинд 2013 оны 11-р сард төрийн албан тушаалтанд гадаадын банкинд данстай байхыг хориглох тухай хуулийн төслийг өргөн бариад байна. Энэхүү хуулийн төсөлд тусгагдснаар төрийн албан тушаалтнууд хилийн чандад үнэт цаас, үл хөдлөх хөрөнгөтэй байхыг хориглохоор заажээ.

Оффшор/offshore гэдэг нь («эргийн гадна», «хилийн гадна» гэсэн англи үгнээс гаралтай) татвар төлөвлөлтийн хамгийн түгээмэл, үр дүнтэй аргын нэгд тооцогддог. Энэхүү аргын гол зарчим нь гадаад эзэмшигчтэй компаниудыг татвараас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх явдал юм. Ийм төрлийн эрх зүйн зохицуулалттай 60 шахам орон байх ба тэдгээрийн санал болгож байгаа татварын таатай нөхцөл, эрх зүйн баталгааг гадаадын хөрөнгө оруулагчид ашиглах сонирхол их байдаг байна.

Түүхээс: Анх “оффшор” хэмээх нэр томъёог АНУ-ын зүүн эргийн нэгэн сонинд 1950-иад оны сүүлчээр хэрэглэсэн бөгөөд тухайн үед АНУ-ын хувийн компаниудын нэг нь санхүү, хууль зүйн асуудлаас бултаж, үйл ажиллагаагаа эдийн засгийн илүү таатай нөхцөлтэй газарт шилжүүлсэн тухай яригдсан аж. Гэхдээ оффшорын бүтэцийн хувьд орчин үед л яригдаж байгаа бус бөгөөд “Оффшор” хэмээх ойлголтыг эртний грекүүд ашиглаж байсан баримт байдаг байна.

Дундад зууны үед Италийн Ливорно, Триест, түүнчлэн Югославын Шибеник зэрэг газрууд оффшор бүс болж байсан төдийгүй XVIII зуунд чөлөөт худалдааны төвөөр Гибралтар болон Бангкок тодорч байсан бол XX зууны 30-аад оноос Люксембург, Панам, Нидерландын Антилийн арлуудад оффшор бүс бүрэлджээ⁷⁹.

Орчин үеийн эдийн засагт оффшор гэдэг ойлголт бий болж эрх зүйн харилцааг албан ёсоор зохицуулсан нь санхүүгийн бизнесийг татахтай холбоотой. XVIII зуунд Женев хотын зөвлөлөөс нэгэн хууль гаргасан байдаг.

Уг хуульд зааснаар банкирууд үйлчлүүлэгчдийнхээ дансыг бүртгэх ёстой. Гэхдээ тэд Хотын зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр энэхүү данс бүртгэлийг ямар ч этгээдэд задруулахгүй байх шаардлагатай аж. 1730-аад онд Германд болсон нийгэм, улстөрийн эргэлт, 1934 онд Швейцарт гаргасан Банкны нууцлалын хууль зэрэг нь Швейцар улсыг дэлхийн санхүүгийн нууцлалын төв болгож чадсан юм.

Европын баялаг болох хэдэн тэрбум ам.доллар дэлхийн хоёрдугаар дайны үед Швейцарийн банкинд аюулгүй байдлаар хадгалагдан үлдсэн түүхтэй. Энэ төрлийн бүсүүдийн үүсэл хөгжлийг Дэлхийн нэгдүгээр дайны дараах үе /Лихтенштейн Трастын хуулийг 1926 онд, Бермуд Оффшор компанийн хуулийг 1935 онд тус тус баталсан/-ээс эхлэн тоолдог бөгөөд Олон улсын валютын сангаас гаргасан албан ёсны жагсаалтад

⁷⁹<http://aoghs.org/offshore-exploration/offshore-oil-history/>

дурдсанчлан өнөөдрийн байдлаар нийт 60 гаруй улсыг энэ төрлийн бүсэд хамруулан авч үздэг⁸⁰.

Оффшор бүс: гэдэг нь гадаадын /байнгын оршин суугч бус/ зээлийн байгууллага, бусад компани нь оффшорийн бүс байгуулсан улсын зүгээс үйл ажиллагаанд нь оролцохгүй эсхүл бага хэмжээгээр оролцох нөхцөлд тухайн оронд зориулан гадаад валютаар байнгын оршин суугч бус этгээдүүдтэй /гадаадын бие хүн, хуулийн этгээд/ гүйлгээ хийдэг хот, район, улсууд юм.

Оффшор бүсүүд дараах шинжийг агуулсан байна. Үүнд:

- татварын хөнгөлөлт;
- нэргүйгээр бизнес эрхлэх;
- валютын хязгаарлалтгүй ;
- компани бүртгүүлэхэд тавигдах шаардлага маш бага, хялбар;
- хувьцаа эзэмшигчдийн хурал хийх, санхүүгийн тайлагнал зэрэг нь маш энгийн;
- бусад хөнгөлөлт

Оффшор бүс гэдэг нь эдийн засгийн чөлөөт бүсээс ялгаатай ойлголт бөгөөд оффшор бүсэд компаниудад өөрийн нутгийн гадна үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг бол эдийн засгийн чөлөөт бүсэд компаниудад тэнд үйл ажиллагаа явуулж байгаа учраас л хөнгөлөлт олгодог байна.

Оффшор бүсүүдийг Олон улсын валютын сан /ОУВС/, тухайн орны Төв банкууд тодорхой хэмжээгээр хянадаг байна. Хамгийн алдартай оффшор бүсэд Панам, Гибралтар, Кипр, Багамын арлууд, Ирланд, Лихтенштейн, Америкийн Делавэр муж улс багтана.⁸¹

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/ санхүүгийн луйврыг нуун далдлах боломж олгож байгаа орнуудын хар данс буюу жагсаалт гаргасан байна.

Хүснэгт 1.

	Нөхцөл	Орнууд
I жагсаалт	Татварын бодлого нь нээлттэй, мэдээлэл солилцох зарчмыг хүлээн зөвшөөрч хуулиндаа шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулсан орнууд	ОХУ, Европын холбооны гишүүн ихэнх орон, Япон, Хятад, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, ӨАБНУ, Арабын нэгдсэн Эмират улс, Турк Улс
II жагсаалт	Татварын бодлого нь нээлттэй байх мэдээлэл солилцох зарчмыг хүлээн зөвшөөрсөн ч хуулиндаа өөрчлөлт оруулаагүй орнууд	Андорра, Багамын арлууд, Бахрейн, Гватемал, Гибралтар, Либери, Лихтенштейн, Монако, Панам, бас Карибын тэнгис, Номхон далайн арлын хэсэг улс
III жагсаалт	Дээрх зарчмуудыг хүлээж аваагүй орнууд	Мэдээлэл байхгүй

⁸⁰http://petrowiki.org/History_of_offshore_drilling_units,
<http://www.offshore-mag.com/index/about-us/history-of-offshore.html>

⁸¹<http://www.oecd.org/tax/exchange-of-tax-information/46244704.pdf>

Хүснэгт 2. Оффшор бүсүүдийн жагсаалт

Европ	Хойд Америк	Карибийн бүс	Номхон далайн бүс
Их Британи	Канад	Антигуа ба Барбуда арлууд	Вануату
Гернси	Нью-Брунсуик	Антильский арлууд	Гонгконг
Гибралтар	АНУ	Кюрасао	Баруун Самоа
Жерси		Аруба	Кука арлууд
Ирланд		Багамийн арлууд	Лабуан
Кипр		Барбадос	Япон
Лихтенштейн		Белиз	
Люксембург		Бермудийн арлууд	
Мадейра		Британийн Виржинийн арлууд	
Мальти		Кайманы арлууд	
Монако		Невис ба Сент-китс	
Мэн арал		Панам	
Нидерланд		Тёркс ба кайкосын арлууд	
Швейцар			

Оффшор компани гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна.⁸²

Оффшор компани гэдэг нь тухайн улс орон, бүсэд амьдардаггүй ч компани байгуулж бизнес эрхэлдэг, гэхдээ энэхүү бизнес нь хууль бус үйлдэл биш бөгөөд аль ч улсад хэн ч байгуулж болохыг зөвшөөрсөн компани гэж ойлгож болно. Дэлхийд татварын маш таатай орчин бүрдүүлж, маш бага хэмжээний тогтмол хураамж төлж бизнес эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн оффшор бүсүүдэд Британийн Виржинийн арал, Кэйманы арал, Люксембург, Кипр, Хонгконг зэрэг орон, бүс мужууд юм.

Улмаар татвар бага төлөхийн тулд эдгээр орнуудад оффшор компани байгуулах, олсон орлогоо шилжүүлэх, үйлчлүүлэгч нарт зуучлах зорилготой дамжуулагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч зэрэг бизнесийн шинэ төрлүүд хөгжиж иржээ. Ийнхүү хялбар аргаар компани байгуулж болдог, татвар бага төлдөг зэрэг нь хөгжлийнхөө явцад хүний өмнөөс компани байгуулж, төлөөлөн хариуцдаг үйлчилгээ болон төлөвшжээ.

Сүүлийн үед гадаадын иргэд өөрсдийн эзэмшдэг хувьцааг (үйл ажиллагааг) бусдаас нуух, өөрийн орондоо татвар төлөхгүй байх хандлага эрс нэмэгджээ. Үүнийг дагаад оффшор бүс бүхий орнуудын тоо ч өссөн байна.

Гадаадын иргэдийн хөрөнгө, орлого нэмэгдэж, оффшор бизнесийг сонирхохын хэрээр оффшор бүсийн хөгжил цэцэглэсэн байна. Оффшор компаниуд хэд хэдэн өвөрмөц онцлогтой. Тухайлбал, татвар төлөлтийг их хэмжээгээр бууруулсан, санхүүгийн болон үйл ажиллагааны нууцлалыг дээд зэргээр хангасан, зохион байгуулалттай, хууль ёсны статустай байх явдал юм. Өөрөөр хэлбэл оффшор компани нь гадаадын иргэний хяналтад байдаг, хилийн чанадад байгуулагдсан, биеэ даасан субъект юм.

Оффшор статус нь тус компанийн эзэмшлийн баримтыг чанд нууцлахад чиглэгддэг байна. Хувьцаа, хувь эзэмшигчдийг нэрээр нь бус, нэршлээр тэмдэглэдэг болохоор оффшор компани эзэмшигчдийн нууцлал хангагддаг. Учир нь бүртгэлтэй бичиг баримтад зөвхөн нэрлэсэн эзэмшигчдийн /төлөөлөгч, итгэмжлэгдсэн хүний/ нэрс л бичигддэг аж.

⁸²<http://business.rin.ru/cgi-bin/search.pl?action=view&num=52524&razdel=6>

1. *Оффшор компани*⁸³ гэдэг нь бүртгүүлсэн орондоо аж ахуйн ажиллагаа явуулдаггүй компани бөгөөд тэдгээрийн эзэд нь эдгээр орны байнгын оршин суугч бус этгээдүүд байдаг байна. Ийм шаардлагыг компанийг бүртгэж байгаа орны зүгээс тавьдаг ба оффшор компанид ногдуулдаг татвар маш бага, эсвэл огт байхгүй, зөвхөн жил бүр багахан хэмжээний тогтмол хураамж авахаар зохицуулсан байдаг байна.

2. *Оффшор компани гэдэг нь* хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компанийн хэлбэртэй ААН, тухайн орны компаниудаас ялгаатай нь татвараас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгддөг, гэхдээ тухайн орондоо орлого олдоггүй байх ёстой, компанийн эзэд болон захирлууд нь тухайн орны иргэн бус байх ёстой гэсэн шаардлага тавигддаг байна.

Оффшор компани байгуулснаар тухайн компани өөрийн оронд байгаа компанийн татвар төлөлтийг хуулийн хүрээнд ихээхэн бууруулж чадах бөгөөд ингэснээр ашиг, орлогын татвар, хүн амын орлогын албан татвараас бүрэн чөлөөлөгдөх, ихээхэн хэмжээгээр бууруулах боломжтой болдог байна.

Оффшорын компани бүртгэдэг орнуудыг хоёр ангилдаг⁸⁴. Үүнд:

1. *Эдийн засгийн хөгжлийн түвшин өндөр биш, гэхдээ улс төрийн байдал нь харьцангуй тогтвортой байдаг жижиг улс, арлууд* /Белиз, Багамын арал, Британийн Виргиний арал, Ванауту, Каймановын арал гэх мэт/.

Эдгээр улсууд санхүүгийн үйл ажиллагаагаа тайлагнах талаар ямар ч шаардлага тавьдаггүй, санд жил бүр тогтоосон хураамж оруулахыг шаарддаг нь цорын ганц шаардлага. Тэдгээр оронд хувьцаа эзэмшигчид, захирлуудыг бүртгэдэггүй, компани эзэмшигчдийг дээд зэргээр нууцалдаг.

2. *Оффшорын нэр хүндтэй, томоохон бүсүүд*: Эдгээр бүсүүдэд оффшор компаниудаас санхүүгийн тайлан шаардаж, татварын хангалттай хөнгөлөлт олгодог. Эдгээр орнуудын хувьд Засгийн газар нь харьцангуй хатуу хяналт тавьж, захирлууд болон хувьцаа эзэмшигчдийг бүртгэнэ. Үүнд, Кипр, Хонгконг, Люксембург, Швейцар зэрэг улсууд багтана.

- *Оффшор компанийн эрх зүйн статус*⁸⁵: Оффшор компани нь зарчмын хувьд бусад компаниас ялгаа байхгүй. Тус компани нь эрх зүйн бүрэн чадамжтай субъект бөгөөд бусад хуулийн этгээдүүдтэй тэгш эрхтэй гэрээ хийж, гадаадад төлөөлөл, салбартай байж болдог. Харин гол онцлох зүйл нь гадаадын иргэний оршин суугч бус статус юм. Энэ нь оффшор фирмийн удирдлага, оффис гадаадад байрлаж болох ба огт байхгүй ч байж болно гэсэн үг юм. Компанийн хувьд компанийн эзэмшигчид, захирлууд, дүрэм журам, банкны данс зэрэг хэд хэдэн төрлийн бүртгэлтэй бичиг баримтууд байх ёстой.

Бүртгэлтэй оффис нь оффшор компанийн заавал үйл ажиллагаа явуулдаг оффис байх албагүй. Энэ нь зөвхөн эзэмшигч, эсвэл бусад этгээд оффшор компанийн төлөөлөгчтэй холбоо тогтоох хаяг аж. Үүнийг бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж болохгүй.

⁸³<http://maizorig.wordpress.com/2010/07/20>

⁸⁴<http://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/42469606.pdf>

⁸⁵<http://offshorbystro.ru/page/19267>

Оффшор компанийг бүртгүүлэх, нээх: Энэ төрлийн компани нээхийн тулд итгэмжлэгдсэн гэрээнд гарын үсэг зурахад л хангалттай төлийгүй гэрээнд фирмийг удирдахаар итгэмжлэгдсэн этгээд эзэмшигчтэйгээ бүрэн тохиролцсоны үндсэн дээр гарын үсэг зурж болно. Ихэнх тохиолдолд оффшор компанийг хоёр баримтад гарын үсэг зурснаар байгуулсанд тооцож болдог. Үүнд корпорацийн дүрмийн дагуу компаниа бүртгүүлэх өргөдөл, компанийн дотоод дүрэм ордог. Эдгээр баримт олон нийтэд нээлттэй, эсвэл хаалттай аль нэг хэлбэрээр байна.

Бүртгэлийн баримтад жинхэнэ эзэмшигчдийн овог нэрийг заахгүй байж болдог бөгөөд харин үүний оронд дор хаяж хоёр нэрлэсэн этгээд байдаг ба үүгээр оффшор компанийн эзэмшлийн нууцлалыг хангадаг аж. Гэхдээ жинхэнэ эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалсан бичиг баримтууд бүрдүүлдэг байна.

- Оффшор компанийн онцлог: Оффшор компани гэж татвар, хяналт, нууцлалын хамгийн таатай, хялбар нөхцөлийг санал болгож байгаа бүсэд байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийг хэлдэг талаар дээр дурьдсан билээ. Хэдийгээр оффшор компанийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ашиглах магадлал өндөр гэж үздэг боловч энэ төрлийн компаниар дамжуулан бизнесийн үйл ажиллагаа эрхлэх нь олон улсын худалдаа эрхлэх, хөрөнгө хамгаалах болон нууцлалыг хадгалах, татварын таатай орчинд ажиллах хамгийн оновчтой шийдлийн нэг хэвээр байсаар байна.

Оффшорын хамгийн гол онцлог бол компаниа бүртгүүлсэн улсдаа татвар төлдөггүйд оршино. Мэдээж энэ тохиолдолд тус улсад үйл ажиллагаа явуулах ёсгүй. Гэхдээ оффшор компаниуд жил бүр тодорхой хэмжээний хураамж төлдөг. Түүнчлэн компанийг бүртгэсэн газрын татварын байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн тайлан тооцоог шаарддаггүй.

Харин хоёр дахь шинж нь олон улсын бизнесийн компаниудад тусдаа хууль үйлчилдэг байна.

Гурав дахь онцлог нь компанийн эзэмшигч, компанийн бүртгэл хариуцдаг төрийн байгууллагыг холбодог бүртгэлийн агентлаг үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс гадна компанийг бүртгэсэн хэмээн улсын хураамж төлөөд л болдог аж. Оффшор компаниа ажил хэргийн холбоо тогтоохын тулд гадаадын Засгийн газрын агентлагуудтай, эсвэл янз бүрийн банкуудтай шууд бус холбоо тогтоох, гадаадын өмгөөлөгч, компанийн нэгдсэн удирдлагын үйлчилгээг авах, оффшор корпорацийг бүрдүүлэх, удирдах чиглэлээр мэргэшсэн үндэсний компанийн үйлчилгээг ашиглах ёстой.

- Оффшор компаниуд хаана байрладаг вэ: Компаниудын өөртөө татах зарчмаар нь оффшор бүсүүдийг хоёр ангилдаг.

Эхнийх нь, оффшор компаниуд бага хэмжээний татвар төлнө. Энэ ангилалд эдийн засгийн өндөр хөгжилтэй, татварын бага түвшинтэй улс орнууд ордог. Үүнд Англи, Гибралтар, Швейцар, Люксембург, Кипр зэргийг нэрлэж болно.

Хоёр дахь, нь оффшор компанийн эздийг татвараас бүрэн чөлөөлдөг орнууд юм. Гэхдээ оффшор компаниуд бүртгэлтэй орныхоо Засгийн газарт татваргүй үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааныхаа лицензийн хураамжийг төлнө. Сонгодог оффшор гэгддэг энэ ангилалд Багамын арлууд, Британийн Виржинийн арлууд, Белиз, Ирланд, Лихтенштейн, Панам, Сейшел зэрэг ордог. Энд эдийн засгийн өсөлт тийм өндөр биш боловч найдвартай, тогтвортой улс орнууд гэгддэг.

Тиймээс эдгээр газарт бүртгүүлсэн оффшоруудад эдийн засгийн аюул нүүрлэнэ гэж айлтгүй аж. Хамгийн гол нь жил бүр оффшорын үйл ажиллагаа явуулсны хураамжаа төлөхөд л хангалттай. Эхний ангилалд төрөөс оффшорын бизнест хяналт тавьдаг бол энд оффшорын үйл ажиллагаа, захирлууд, хувьцаа эзэмшигчдийн тоог анхаардаггүй, оффшорын бүртгэлийг бүрэн нууцлалын байдалтайгаар явуулдагараа онцлогтой. Ер нь дэлхийн томоохон бизнесмэнүүд эдийн засгийн тогтворгүй байдал, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд эрсдэл учирч болзошгүй гэсэн үүднээс оффшор бизнесийг сонгодог байна.

Оффшор компанийг дараах тохиолдолд байгуулдаг гэж үздэг ба үүнийг зорилгоор нь ангилвал⁸⁶:

Хувилбар 1: Сейф

Жишээлбэл та тодорхой хөрөнгө хуримтлуулаад түүнийгээ аюулгүй газар байршуулах, түүндээ түргэн хүрч чаддаг байх, чөлөөтэй захиран зарцуулах, өөрийн орны улс төрийн тогтворгүй байдлаас зайлсхийхийг хүсч байна гэж бодъё. Үүний тулд найдвартай, тогтвортой улс оронд банк байх хэрэгтэй. Гэхдээ та өөрийн нэр дээр данс нээвэл нууцлал алдагдах магадлал өндөр тул /таны нэртэй зээлийн карт танд гадаадад дансыг шууд хэлж өгөх гэх мэт/ яах ёстой вэ?

Гарц нь оффшор компани байгуулах, та захирал, та компанийн дансыг захиран зарцуулах эрхтэй ч /таныг эзэн гэдгийг хэн ч мэдэхгүй/, энэ нь хуулиар хориглоогүй, мөн энэ компанийн хууль зүйн асуудлыг зөв сонгож чадвал, та өөрийнхөө бүх асуудлыг шийднэ гэж үздэг

Хөрөнгө хадгалах тал дээр Багамын арлын хамтын нийгэмлэг, Панам, Британи Виржинийн арлууд, Белиз, Кайкос илүү алдартай. Энэ зохицуулалтын өөр нэг давуу тал бол Их Британийн одоогийн болон өнгөрсөн үеийн колон орнууд нь харилцахад тохиромжтой, банк болон түншүүд нь сайн хүлээж авдаг байна.

Хувилбар 2: Таны бизнесийн оффшор оролцогч

Гадаад эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд татварын таатай орчин, баримт бичгийн хялбар бүрдүүлбэр, санхүүгийн урсгалыг хурдасгах, үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах шаардлагатай болдог. Энэ тохиолдолд оффшор компани нь олон асуудлыг шийдвэрлэх гарц болдог. Өөрөөр хэлбэл дотоодын компани болон Олон Улсын бизнес хамтарч эрхэлдэг худалдагч, худалдан авагч хоорондын зуучлагч болдог.

Компанийн эздийн нууцлал хадгалагдаж, татвараас зайлсхийх боломжуудыг ашиглах болсон нь нууц биш бөгөөд энэ тал дээр төрийн зүгээс тавих хяналт сул, харьцангуй сүүлийн үед үүнийг бид ойлгож эхэлж байгаа гэж хэлж болно.

Жишээ: Ундаа савлах шугамыг импортлохдоо гааль болон НӨАТ төлөхгүйн тулд шугамыг оффшор компанийн нэр дээр авч, уг шугамыг нь оффшор /хамтарсан/ компанийн дүрмийн санд бүртгэдэг. Ингээд тоног төхөөрөмжийг лизингээр ашиглаж, лизингийн хүүг хилийн чанадад гаргадаг байна.

⁸⁶<http://business.rin.ru/cgi-bin/search.pl?action=view&num=52524&razdel=6>

Хувилбар 3: “Оршин суугч - Хаана ч биш”

Мөн зарим орны хууль тогтоомжийн цоорхойг гадаадад томилтоор ажиллах үедээ татвар ногдуулахаас зайлсхийхэд ашиглаж болно. Гадаадад богино хугацаагаар явах үед тухайн хүн өөрийн орноос түр хугацаагаар явсан ч очсон газрын оршин суугч болохгүй. Хэрвээ хувь хүн 2 улсад байх хугацаагаа маш нарийн тооцсон тохиолдолд л энэ боломжтой.

Ийм байдлаар хувь хүн “оршин суугч-хаана ч биш” статустай болж, орлогоо бүгдийг эсхүл заримыг нь татвар ногдуулахаас зайлсхийж болно.

Сүүлийн үед оффшорыг ашиглах зорилго нэлээд өөрчлөгдсөн. Урьд оффшор компаниудын хувьд капиталгаа гаргахын тулд ашигладаг байсан бол одоо төлбөрийг тогтворжуулах, экспорт импортыг гэрээний үнээр зохицуулах, өөрийгөө санхүүжүүлэх, зохиогчийн эрхийг худалдах, валютын гэрээний үнийг төлөх, лизингээр тоног төхөөрөмж шилжүүлэх, ажилтан хөлслөх, түүхий эд нийлүүлэх, гадаадад үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, түүнчлэн дэлхийн санхүүгийн зах дээр хөрөнгө оруулалтын болон ашгийн төлөө бизнес эрхлэхэд үр ашигтай хэрэгсэл болж байна.

Ямар улсуудад оффшор компанийн бүртгүүлдэг вэ?

Өнөөдрийн байдлаар дэлхийд 60 орчим орны хууль тогтоомжид оффшор компаниуд татварын хөнгөлөлт олгохоор тусгасан. Эдгээрээс хамгийн нэр алдартай нь Панам, Гибралтар, Кипр, Багамын арлууд, Ирланд, Лихтенштейн, Америкийн Делавэр муж.

Эдгээр орнуудыг хэд хэдэн категорид хувааж болно.

1. Эдийн засгийн хөгжлийн түвшин өндөр биш хэдий ч улс төрийн хувьд боломжтой, тогтвортой арлууд. /Багамын арлууд, Британий Виргиний арлууд, Вануату, Сейшелийн арлууд гэх мэт/ Эдгээр арлуудын хувьд оффшор компанийн хувьд тайлагналтын ямар нэг шаардлага тавьдаггүй бөгөөд цорын ганц шаардлага нь төсөвт жилд тодорхой хураамж төлөх явдал юм. Энэ төрлийн орнуудын хувьд гол төлөв хувьцаа эзэмшигч захирлуудын бүртгэл хийдэггүй, тухайн компанийн талаарх нууцлал өндөр байдаг. Ийм компаниудыг гол төлөв сейфны зориулалт, санхүүгийн гүйлгээний зорилгоор ашигладаг.
2. Зарим оронд оффшор компаниудаас гадна энгийн буюу /onshore-оншор/ компаниудыг бүртгэдэг. Энэ нь гадаадын харьяат иргэний компани бөгөөд тухайн бүртгүүлсэн орондоо аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа явуулснаар татвараас чөлөөлөгдөх статусаа алдсан компаниуд юм. Ийм учраас, тухайн бүртгэлтэй оронд аж ахуйн үйл ажиллагаа явуулаагүй гэдгээ нотлохын тулд компаниуд жил бүр аудит хийлгэж санхүүгийн тайлангаа гаргаж өгдөг байхыг шаарддаг.

Ийм орнуудын хувьд, Засгийн газрын зүгээс арай хатуу хяналт тавьдаг. Тухайлбал, хувьцаа эзэмшигчид болон захирлын бүртгэл хийдэг гэсэн үг. Гэхдээ ийм бүсэд байгуулагдсан компаниудын нэр хүнд илүү өндөр. Энэ бол Кипр, Ирланд, Гибралтар, Люксембург, Швейцар гэх мэт.

3. Оффшор бүс огт биш боловч хэрэв тухайн орны хууль, тогтоомжийг дагаж мөрдөн, үйл ажиллагаагаа хуулийн дагуу хэрэгжүүлсэн тохиолдолд компанийн хувьд аль болох бага татвар төлөх боломжтой орнууд байна. Жишээлбэл, АНУ, Их Британи, Канад зэрэг орнуудад татвар хураамж төлөх, хувьцаа эзэмшигчид

болон захирлын бүртгэлийг хөтлөх боловч тогтоосон хэмжээний хураамжийг цаг хугацаанд нь төлснөөр аюулгүй, тайван үйл ажиллагаа явуулах бөгөөд эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо маш сайн бүрдсэн байдаг. Ийм компаниудын хувьд өөрийн үйл ажиллагаа, бизнесийн нэр хүндийг авч явах, мөнгөө найдвартай хадгалах боломж бүрддэг.

Оффшор компани яаж ажилладаг вэ?:

Олон улсын эрх зүйн хувьд оффшор компани хуулийн этгээд бөгөөд үйл ажиллагаагаа бүртгүүлсэн орны хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Жишээ нь: Панамын компанийн хувьд зөвхөн Панамд татвар ногдуулна. Энэ компанийн хувьд эзэд нь гадаадын харьяат байх бөгөөд компани нь Панамд үйл ажиллагаа явуулдаггүй бол компани нь оффшор статустай болж албан ёсоор ямар ч татвар ногдуулалтаас чөлөөлөгддөг. Ийм үед энэ компани нь бүртгүүлсэн оффшор бүсдээ татвар ногдуулах субъект болохгүй бөгөөд үндсэн үйл ажиллагаагаа явуулж байгаа орондоо татвар төлөгч байна.

Оффшор компанийг хаана бүртгүүлбэл зохистой вэ?

Компанийг хаана бүртгүүлэх, ямар улсад бүртгүүлэхийг сонгох нь тухайн компанийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй ажлын схемтэй шууд холбоотой. Зарчмын хувьд бүх улсыг оффшор компанид бага татвар ногдуулдаг, оффшор компанийг татвараас бүрэн чөлөөлөгддөг гэж хувааж болно.

Энэ тохиолдолд Засгийн газарт үйл ажиллагааны лиценз сунгасны хураамжийг төлдөг бөгөөд жилд энэ нь 300-400\$-оос хэтрэхгүй. Бага татвар бүхий бүлэгт Европын орнууд, Швейцар, Люксембург, Лихтенштейн, Ирланд, Мальт гэх мэт орнууд багтдаг. Татвараас бүрэн чөлөөлөгддөг бүлэгт Төв Америкийн улсууд Панам, Багамын арал, Британий Виржиний арлууд, Белиз, Теркс, Кайкос, Кайманы арлууд. Европын компанийг бүртгэх, үйлчлэх нь 2-р бүлэгт хамаарч байгаа улсуудад компанид үйлчлэхээс нэлээд үнэтэй. Иймээс компани хаана бүртгүүлбэл дээр вэ, бүртгэх улс нь дээр дурьдсан аль бүлэгт хамаарах вэ, үйл ажиллагаа явуулж буй компанийн бизнест хэр чухал вэ, ямар хэмжээний татвар төлхөд бэлэн байх вэ гэдгээс хамаарна.

Харин хэн тухайн компанийн захирал, хувьцаа эзэмшигч байж болох вэ: Бүртгэх улсын оршин суугч бус хувь хүн, хуулийн этгээд хэн ч байж болно. Компанийн эздийн доод тоо нь 1-3 ба зарим улсад хуулийн этгээдийг компанийн захирал байхыг хязгаарладаг.

Оффшор компани бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичиг, дүрмийн сан болон нягтлан бодох бүртгэл ямар байх ёстой вэ?

Оффшор компанийн хувьд эзэд болон захирлууд нь хуулийн этгээд байх эсэхээс үл хамаарч компанийг бүртгүүлэхэд ямар ч бичиг баримт шаардахгүй. Гэсэн хэдий ч компанийн эздийн тухай мэдээлэл олонх оффшор улсад холбогдох хуулиар зохицуулагдах бөгөөд зарим орны хувьд компанийн эздийн нэрийг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Компанийн эздийн тухай нээлттэй цөөн орны нэгд компаниа бүртгүүлсэн тохиолдолд бүрэн нууцлалыг нэрлэсэн хувьцаа эзэмшигч, захирлууд хангадаг.

Компанийг бүртгүүлэхээр сонгосон улсаас хамаарч 2 долоо хоногоос 1 сарын хугацаатай компанийн бүртгэлийн үйл ажиллагаа явагдах бөгөөд зарим тохиолдолд хэрэв “Бэлэн” компанийг худалдан авахад 1 цаг зарцуулах шаардлагатай болдог.

Компаний байгуулахад дийлэнх орны хувьд үүсгэн байгуулах баримт бичиг бэлтгэн гаргах, бүртгүүлэх үйлчилгээ хураамж нь 1000 ам.доллараас хэтрэхгүй байдаг бөгөөд хуулийн этгээдийн хаяг өгөх, компанийн албан ёсны төлөөлөгчийн үйлчилгээ жилд 500-900 ам.доллар байдаг.

Компанийн дүрмийн сангийг хувьд зарим Европын орноос бусад ихэнх улсад дүрмийн сан бүрдүүлэх, компанийг бүртгүүлэх үед ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

Нягтлан бодох бүртгэлийн тайлагнал нь тухайн компанийн бүртгэх улсын хуулиар хийгддэг. Оффшор компани ямар нэг төрийн байгууллагад нягтлан бодох бүртгэлийн тайлан өгөхгүй. Гэхдээ хэдхэн тооны орны хувьд оффшор компаниас жил бүр аудитын тайлан гаргаж өгөхийг шаарддаг.

Оффшор компанийн дансны тухай ерөнхий мэдээлэл

Оффшор компани нь дэлхийн аль ч орны банкинд данс нээх боломжтой. Мөнгөн хөрөнгийн хүрэлцээтэй байдал, хөрвөх чадвар нь зөв бизнесийн маш чухал шинж юм. Мөнгөн хөрөнгийн эзэн /хувь хүн, хуулийн этгээд/ ямар ч үед өөрийн хөрөнгөө хүссэн хэмжээгээрээ захиран зарцуулах боломжтой байх ёстой. Үүнтэй холбоотойгоор ямар улсын ямар банк сонгох нь гадаадын компани байгуулах үед маш чухал асуудал байдаг.

Ямар банк сонгох вэ гэдэг асуудал зөвхөн компани төдийгүй хувь хүнд чухал бөгөөд тэдний орлого, мөнгөн хадгаламж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнүүдийг байршуулах, найдвартай хадгалах шаардлага хангасан банкыг сонгохыг эрмэлзэнэ. Харин “Улаан” паспорттой бизнесменд данс нээхийг бүх банк зөвшөөрөхгүй төдийгүй барууны банкуудын хувьд үүнээс гадна зөвлөмж гаргаж өгөхийг шаарддаг. Зөвлөмжийг тухайн банкинд нэр хүндтэй өмгөөлөгч /аудитор/, уг банкны том харилцагч, эсхүл санхүүгийн бусад байгууллагаар гаргуулдаг. Данс нээсний дараа олон банк модем, тусгай программ, интернэтийн тусламжтайгаар хөрөнгөө удирдах боломж олгодог. Эдгээр нь мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг хянах, гүйлгээг удирдах, бизнесийн үйл ажиллагаанд банктай төрөл бүрийн гэрээ, хэлцэл хийх боломжийг олгоно.

Компанийн эздийн тухай мэдээллийг хэн авч болох вэ?

Оффшор компанийг өөрт ашигтайгаар ашигласан кейс. Голландын электро техникийн “Филипс” концернийн хэрэгжүүлсэн схем нь оффшорын давуу талыг ухаалаг ашигласан тод жишээ юм. Бермудын арал дээр “Филипс” концерн даатгалын “Кингстоун Кэптив Иншуренс” нийгэмлэгийг нээсэн. Түүний цорын ганц үйлчлүүлэгч нь “Филипс” өөрөө байсан.

Голландын концерны эд хөрөнгө өндөр үнээр даатгагдсан бөгөөд эдгээр нь бизнесийн практикт устах, гэмтэх эрсдэл бага учир голдуу даатгуулах шаардлагагүй хөрөнгө байсан. Даатгалын хураамж Бермуд руу явдаг байсан. Тэндээсээ зээлийн хэлбэрээр Голландын толгой нийгэмлэг рүү ирдэг байв.

Даатгалын болон зээлийн төлбөр нь Филипсийн балансын ашгийг нэлээд бууруулж, 1 жилийн дотор татварын хэмнэлт 18 сая ам.доллараас болсон. Филипс өөрөө өөрийгөө даатгаснаа зарлаагүй бөгөөд ямар нэг байдлаар ил болсон ч хариуцлага хүлээхгүй. Өөрөөр хэлбэл, энэ хэлцэл нь хуулийн дагуу байсан.

Компанийн дэмжлэг

Хаана ч ялгаагүй компанийг дэмжих хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл аудитын тайлан мэдүүлэг /хэрэгтэй газар нь/ өгөх, шаардлагатай татвар, хураамжийг төлөх, бүртгэлийн агентад үйлчилгээний төлбөр төлөх хэрэгтэй. Хэрвээ тухайн компани нь хуулийн дагуу бүх процедур явагдсан тохиолдолд тухайн компани бүртгэлд хэвээр үлдээнэ. Компани хуулийг дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй бол тодорхой хугацааны турш торгууль төлж бүртгэлд үлдэж болох болов ч дараа нь бүх үр дагаврын хамт бүртгэлээс хасагддаг. Компанийг сэргээж болох ч энэ нь шинээр бүртгүүлхээс хэд дахин үнэтэй байдаг.

Харьяатын тухай асуудал

Олонх улс өөрийн иргэд, хуулийн этгээдийн тухайн улс дотроо олж байгаа орлогод татвар ногдуулдаг. АНУ өөрийн татвар төлөгчдөөс тухайлбал, хуулийн этгээдээс харьяаллын үндсэн дээр бүх олсон орлогод нь татвар ногдуулдаг. Ямар хүчин зүйл компанийг аль нэг улсын харьяат болгодог вэ? Оффшор бүсийн олонх нь Английн хууль тогтоомжийн системийг дагадаг. Английн шүүхэд харьяатын асуудал анх 19-р зуунд хэрэглэгдэж байсан. Английн шүүхийн шийдвэрээр компанийг оффис бүртгэгдсэн газрын харьяат гэж үзсэн. Тэндээс компанийг захирлууд удирдаж байсан. Энэ хандлага нь харьяат бусыг тогтоох хоёр хувилбарыг бий болгосон.

- Гибралтар, Ирланд гэх мэт оффшор бүсэд харьяалагддаггүй атлаа бүртгэгдсэн компаниуд. Энд компанийг бүртгэсэн улсын оршин суугч биш этгээд удирдаж эзэмшдэг ба бүртгэсэн улсын нутаг дэвсгэр дээр компани үйл ажиллагаагаа явуулдаггүй, орлого олдоггүй гэсэн үг юм. Компани нь орлогын болон бусад бизнесийн татвар төлдөггүй. Ийм компанийг оршин суугч биш гэж ойлгоно.
- Оффшор бүсэд бүртгэгдсэн оффистой байх ба орон нутгийн захирлууд компанийг удирддаг, гадаад эзэмшигчтэй компаниуд. Олон оронд ийм компани нь жилийн төлбөрөө төлчихвөл оршин суугч компанийн татвараас чөлөөлөгдөх статустай болж болдог. Жишээ нь: иргэд оффшор бүсэд компанитай байж болно. Тэд өөрсдөө компаниа удирдаж, бүртгэсэн улсын бүх төрлийн татвар төлөхөөс чөлөөлөгдөх буюу цэвэр орлогод бага зэргийн татвар төлж болдог.

Хэрвээ компанийг мэргэжлийн захирлууд бүртгэсэн улсын оршин суугчид удирдвал, оршин суугч компанийн татвараас чөлөөлөх статусыг бүртгэсэн улсын Засгийн газрын жилийн хураамжийг төлснөөр олж авч болно. Хүчин төгөлдөр хууль тогтоомжид хөрөнгөө уян хатан удирдах боломжийг хязгаарлахыг эрхэмлэсэн ямар нэг өөрчлөлт оруулахыг байнга хянаж, нэн даруй мэдэрч байх шаардлагатай.

ОИ.МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 3. Оффшор компани байгуулахад тавигдах шаардлага-харьцуулсан мэдээлэл лавлагаа

	Жил тутмын бүртгэлийн төлбөр	Жилийн тайлангийн төлбөр	Гадаадын орлогод ногдуулах татвар	Өөрийн хөрөнгийн доод хэмжээ	Зөвшөөрөгдөх валют	Орон нутгийн захирал, менежер шаардлагатай эсэх	Хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлагын хурал зохион байгуулах газар
Anguilla	US\$ 230	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Bahamas	US\$ 350	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Belize	US\$ 100	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Bermuda	US\$ 1,695	Байхгүй	Тэг	US\$ 1	Bermuda \$	Шаардлагатай	Хаана ч байж болно
British Virgin Islands	US\$ 300	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Cayman Islands	US\$ 575	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Cook Islands	US\$ 500	Тэг	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Costa Rica	US\$ 40	US\$ 50	Тэг	C 10,000	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Cyprus	Байхгүй	CYP 7	4.25%	CYP 1,000	CYP	Шаардлагатай	Хаана ч байж болно
Denmark	Тэг	Тэг	Татвар ногдуулна	DKK 125,000	DKK/Euro	Шаардлагатай	Хаана ч байж болно
Gibraltar	Тэг	J 30	Байхгүй	J 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Hong Kong	US\$ 600	US\$ 200	Тэг	HK\$ 2	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Hungary	HUF 1,500	Байхгүй	3 %	US\$ 7,500	Forint	Олонх нь байх шаардлагатай	Хаана ч байж болно
Iceland	ISK 100,000	Байхгүй	5%	ISK 500,000	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Ireland	Байхгүй	IRJ 150	Харилцан адилгүй	IRJ 2	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Isle of Man	J 430	J 50		Байхгүй	Бүх төрлийн	-	Хаана ч байж болно
Israel	US\$ 200	Тэг	Татваргүй	US\$ 2	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Jersey	J 600	J 130	Тэг	J 2	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Labuan	RM 2,600	RM 100	3%	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Liberia	US\$ 150	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Liechtenstein	CHF 1,000	Байхгүй	Орлогын 0.1%	CHF 50k	Swiss Franc	Нэг	Хаана ч байж болно
Luxembourg	Байхгүй	Тэг	Ердийн хувь хэмжээ	FLUX 1.25M	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Madeira	US\$ 1,000	Байхгүй	Varies	Т 5,000	Escudo	Шаардлагатай	Хаана ч байж болно
Malta	Байхгүй	Lm 50		Lm 500	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Marshall Islands	US\$ 450	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Mauritius	US\$ 1,500	Байхгүй	3%	US\$ 2	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Netherlands	NLG333	Байхгүй	35%	NLG 40,000	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Nevis	US\$ 220	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Niue	US\$ 350	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Panama	US\$ 150	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Saint Vincent	US\$ 100	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно
Samoa	US\$ 300	Байхгүй	Тэг	US\$ 1	Бүх төрлийн	Шаардлагатай	Хаана ч байж болно

Эх сурвалж: <http://maizorfg.wordpress.com/2010/07/20>

2. ОФФШОР БҮСЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

МАКАОГИЙН ТУРШЛАГА

Макао улсыг⁸⁷ Португалиас Хятад руу шилжүүлэхээс 61 хоногийн өмнө буюу 1999 оны 10 сарын 13-нд “Оффшор хууль” (Offshore Law. Decree-law no. 58/99M)-ийг баталж, 1999 оны 11 сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Макаогийн Оффшор хуулинд хэд хэдэн оффшор арга хэрэгслүүдийн зохицуулалтыг тусгасан ба тухайлбал, бизнес эрхэлж байгаа компаниуд, банк, даатгалын компаниуд, трастууд зэрэг оффшор байгууллагуудын зөвшөөрлийг баталгаажуулах гэх мэт.

Хууль батлах болсон шалтгаан нь Макаогийн нутаг дэвсгэр дээрх эдийн засгийн байдал нь гуравдагч орнуудын түвшин рүү чиглэж, дэд бүтэц түүн дотроо тээвэр, харилцаа холбоо сайжирч байгаа, 25/87/M тоот хууль⁸⁸ (Decree-law no. 25/87/M)-иар тодорхойлсон эхлэлийн загвар болох тухайн бүс нутаг дахь олон улсын бизнесийн төвийн хөгжлийг бататгах явдал байв. Ингэснээр санхүүгийн салбарт, зөвхөн зээлийн байгууллагуудад үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх төдий биш, бусад санхүүгийн байгууллагууд, санхүүгийн зуучлагчид, түүнчлэн даатгалын компаниуд, эдийн засгийн агентууд Макаогийн оффшор бүсэд үйл ажиллагаа явуулах боломж нээгдэнэ гэж үзсэн.

Мөн бусад хууль эрх зүйд өргөн хэрэглэгддэг трастын хөрөнгийн менежмент бүхий байгууллагын тогтолцоог хуульчлан тогтоохоос гадна оффшор борлуулалтын үйлчилгээ, туслах үйлчилгээг тодорхойлох асуудал байлаа.

Эдгээрийг нэгтгэн харахад, Макао Олон Улсын Хөгжлийн Төв болгох зорилготойгоор энэхүү хуулийг баталжээ. Оффшор хууль (Offshore Law. Decree-law no. 58/99M) нь 7 бүлэг 80 зүйлтэй.

- Бүлэг I, II - нийтлэг заалтууд болон тодорхойлолтууд
- Бүлэг III - оффшорын санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтыг тусгахдаа оффшор банк, оффшор даатгал, давхар даатгал болон каптив даатгал (captive insurance)-ын үйл ажиллагааг багтаасан.
- Бүлэг IV - оффшор трастын үйл ажиллагаа
- Бүлэг V - оффшор борлуулалтын болон туслах үйлчилгээнүүдийн талаарх зохицуулалт
- Бүлэг VI, VII - хориглох асуудлууд, шийтгэлийн арга хэмжээ, бусад шийдвэрлэх асуудлууд.

Оффшор хуулийн онцлог шинж чанар:

1. Зөвшөөрлийн системийг тусгасан. Макаод оффшор бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хүсэж байгаа компаниудад зөвшөөрөл авах процедурыг зааж өгсөн. Ингэхдээ хуулийн 3-р зүйл (prior authorization)-ээр заасан тодорхой шаардлагуудыг хангасан байх ёстой.
2. Оффшор байгууллагуудын төрлийг тодорхойлсон. Үүнд, Макаод бүртгэлтэй (offshore subsidiary), эсвэл гадаадад бүртгэлтэй (offshore branch) компаниудын аль нь ч зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаж болно. Ингэснээр тус хуулиар Олон улсын бизнесийн компани, тэдгээрт хөнгөлөлт эдлүүлэх шаардлага гэх мэт арга хэрэгслээрээ бүхэлдээ ялгаатай.

⁸⁷Макао нь БНХАУ-ын тусгай захиргааны бүсийн нэг юм. Сувдан голын баруун эрэгт Хонгконг-оос 60 км-ийн зайтай оршдог. Хойд талаараа Гуандонг мужтай хиллэж, зүүн болон өмнөд талаараа өмнөд Хятадын далайгаар хүрээлэгддэг. XVI зууны дунд үеэс 1999 он хүртэл Португал улсын колончлолд байсан. 29.7 km² газар нутагтай, 568,700 орчим хүн амтай ба дэлхий дээрх хамгийн их хүн амын нягтаршилтай газар юм.

⁸⁸58/99M тоот Оффшор хууль батлагдснаар тус хуулийн 79а заалтаар 25/87/M тоот хууль хүчингүй болсон.

3. Бизнесийн хүрээг тодорхойлсон. Оффшор борлуулалтын үйлчилгээ (экспорт, импорт), арын албаны туслах үйлчилгээ, оффшор санхүү, оффшор банк, оффшор даатгал болон давхар даатгал, оффшор итгэлцэлийн үйлчилгээтэй холбоотой компаниудыг зохицуулдаг.
4. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг заасан. Үүнд санхүүгийн бус секторт зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь Макаогийн Худалдаа, Хөрөнгө Оруулалтыг Хамгаалах Институт (Instituto de Promocao do Comercio e Investimento de Macau "IPIM") ба санхүүгийн секторт зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь Валютын Удирдлагын Газар (Autoridade Monetaria de Macau "AMCM") юм.
5. Татварын хөнгөлөлт эдлүүлэхэд тодорхой нөхцөлүүдийг заасан. Нэгэнт тус бүс нутагт оффшор байгууллагыг үүсгэн байгуулж буй тохиолдолд үйл ажиллагаанд нь татвараас хөнгөлөх дэмжлэг үзүүлдэг. Үүнд тодорхой нөхцөлүүдийг заасан ба үүнийг доор дэлгэрэнгүйгээр оруулсан болно.

Макаогийн оффшор байгууллагуудыг хууль эрх зүйн зохицуулалтаараа Британийн Виржинийн арлын Олон Улсын Бизнесийн компаниуд болон Хонгконгийн компаниудаас зарим ялгаатай талуудыг хүснэгтээр харьцуулав.

Хүснэгт 4.

	<i>Британийн Виржинийн арлын ОУ-ын бизнесийн компани</i>	<i>Хонгконг компани</i>	<i>Макаогийн оффшор байгууллага</i>
Шүүх эрх мэдэл- хуулийн систем	Британи загвар буюу нийтлэг эрх зүй	Британи загвар буюу нийтлэг эрх зүй	Португал загвар буюу Иргэний эрх зүй
Зохицуулалтын хэрэгсэл	ОУ-ын Бизнесийн Компанийн Хууль (IBCA)-аар зохицуулдаг	Гонконгийн компанийн захирамж (HongKong Companies Ordinance)- аар компанийг зохицуулдаг.	Зөвшөөрлийн систем нь Макаогийн Оффшор хуулиар зохицуулагддаг.
Байнгын оршин суугчдын худалдаа	Зөвшөөрдөггүй	Зөвшөөрдөг	Зөвшөөрдөггүй
Валют	Аль ч төрлөөр	Аль ч төрлөөр	<i>МОР буюу Macau pataca</i>
Хяналтын зөвшөөрөл	Компанийн бүртгэл	Компанийн бүртгэл	<i>IPIM эсвэл ACIM</i>
Оффис	Бүртгэгдсэн агентын хаяганд	Гонконг дахь аль нэг байранд	<i>Макаод оффистой байх ба 1 оффшор байгууллага 1 хаягтай байна.</i>
Хяналт, нягтлан бодох бүртгэл	шаарддаггүй	шаарддаг	<i>шаарддаг</i>
Худалдааны хязгаарлалт	ОУ-ын бизнесийн компанийн хууль (IBCA)-ийн 5 дахь заалтаас өөр хязгаарлалт тавиагүй	None, except prohibited by law	<i>Зөвхөн зөвшөөрөлтэй үйлдвэр</i>
Нэр	Бүтэн бичнэ.	Нэрний төгсгөлд "Ltd" тэмдэглэгээтэй байна.	<i>Нэр нь тусгайлсан илэрхийлэлтэй байна. Тухайлбал, "Macau commercial offshore", "Macau auxiliary offshore" гэх мэт.</i>
Албан ёсны хэл	Англи хэл	Англи, Хятад хэл	<i>Хятад, Португал хэл</i>

Макаогийн Оффшорын Хуулийн I бүлгийн 2-р зүйлд заасан тодорхойлолтуудаас:

- a) “Оффшор үйл ажиллагаа (offshore activity)” гэж pataca-аас бусад валютын тооцох нэгжээр, зөвхөн байнгын бус оршин суугчдийн дагаж мөрдөх гадаад зах зээл рүү чиглэсэн аливаа нэг эдийн засгийн үйл ажиллагаа юм.
- b) “Оффшор бүс (offshore sector)” гэж Макаогийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн, үйл ажиллагаа нь энэхүү хуулийн хүрээнд хэрэгждэг оффшор байгууллагууд юм.
- c) “Оффшор байгууллага (offshore institution)” гэж хуулийн этгээд эсвэл бие даасан эрх зүйн статусгүй ч оффшор үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг хэлнэ.
- d) “Оффшор охин компани (offshore subsidiary)” гэж Нутаг дэвсгэрийн хууль (Territory’s law)-ийн дагуу хуулийн этгээд болон бүртгүүлсэн, тэр нь хувь эзэмшдэг өөр байгууллагаар хянагддаг, эсвэл хууль ёсны, гэрээгээр хүлээсэн нөхцөлүүдтэй оффшор байгууллагыг хэлнэ.
- e) “Оффшор салбар (offshore branch)” гэж бие даасан хууль эрх зүйн статусгүй оффшор байгууллага бөгөөд гадаадад бүртгэлтэй боловч салбар нь тус улсын нутаг дэвсгэрийн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг хэлнэ.
- g) “Оффшор борлуулалтын үйлчилгээний байгууллага (offshore commercial services institution)”: Засгийн газрын шийдвэрээр зөвшөөрөгдөж, албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн жагсаалт дахь аль нэг үйл ажиллагааг эрхэлж байгаа оффшор байгууллага.
- h) “Оффшор туслах үйлчилгээний байгууллага (offshore auxiliary services institution)”: Оффшор охин компани, эсвэл гадаадад бүртгэлтэй байгууллагын салбар нь тэдний үүсгэн байгуулагдах зорилгоос хамаарах ба Засгийн газрын шийдвэрээр зөвшөөрөгдөж, албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн туслах үйлчилгээнүүдийн аль нэгэнд нь хамааралтай бол оффшор туслах үйлчилгээний байгууллага гэнэ.

Зөрчил, түүнд ногдуулах торгуулийн талаар:

Оффшор хуулийн VI бүлэгт зөрчил болон түүнд ноогдуулах торгуулийн талаар доор хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 5.

70-р зүйл	Зөрчлүүд	Торгууль	Торгууль ноогдуулах бүрэн эрх
1 (a)	V бүлэгт заасан зөвшөөрөлгүй оффшор үйл ажиллагаа явуулсан бол	MOP ⁸⁹ 100,000-500,000	IPIM
1 (b)	Хориглосон үйл ажиллагаа явуулсан бол	MOP75,000-300,000	IPIM
1 (c)	V бүлэгт заасан бизнесийг эхлүүлэх (commencement of business)-тэй холбоотой нээлтийн төлбөр төлөөгүй бол	MOP50,000-200,000	IPIM
1 (d)	Хуулийн дараах зүйлүүдийг зөрчсөн бол: 5 (Form of OI), 9 (Place of business), 10 (Official language), 20(name), 64 (name), 66 (submission of accounts), 15 (rules of conduct)	MOP20,000-100,000	IPIM

⁸⁹Macao Pataca = 0.1251 US Dollar (1 MOP = 0.1251 USD), 2013 оны 12 сарын 17-ны байдлаар.
<http://www.currency.me.uk>

Татварын хөнгөлөлтийн талаар:

Оффшор хуулийн 2-р зүйлээр татварын дэглэмүүдийг заасан бөгөөд оффшор байгууллагууд нь орлогын татвар (income tax), үйлдвэрлэлийн татвар (industrial tax), хөдлөх хөрөнгийн татвар (property tax), үл хөдлөх хөрөнгийн татвар (real estate tax), тэмдэгтийн хураамж (stamp duty) гэх мэт татвар хураамжийн бүх төрлөөс бүрэн хөнгөлөлт эдэлдэг. Энэхүү татварын хөнгөлөлтүүдийг эдлэхэд зарим нөхцөлүүдийг заасан байна. Үүнд:

- Орлогын татварын хөнгөлөлтийг эдлэхдээ зөвхөн оффшор үйл ажиллагааны хэлэлцээрээс бий болсон орлоготой үед орлогын татвартай холбоотой зохицуулалтанд болзол тавьсан мэдүүлгийг баталгаажуулахыг шаардахгүй.
- Үйлдвэрлэлийн татварын хөнгөлөлт эдлэхдээ “Industrial Tax Regulations”-ын 8, 9-р зүйлүүдэд нийцүүлэн облигаци гаргасан оффшор байгууллагууд энэхүү хөнгөлөлтөнд хамрагдахгүй.
- Хөрөнгө нь оффшор бизнест хамаарахгүй бол хөнгөлөлт эдлэх болсноос хойш 5 жилийн дотор хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой татварын хөнгөлөлт эдлэхгүй.
- Тухайн бүсэд байнгын оршин суух зөвшөөрөлтэй менежерүүд болон өндөр мэргэшсэн түвшний ажилтнуудын цалин хөлснөөс авах мэргэжлийн татвар (professional tax)-ыг тухайн оффшор байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсний дараах 3 дахь жилийн 12 сарын 31-ийг хүртэлх хугацаанд хөнгөлөлт үзүүлнэ.

Оффшор байгууллагын үйл ажиллагааны төлбөр:

Оффшор хуулийн 14-р зүйлд зааснаар Макаогийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан оффшор байгууллага нь эхлэлийн (opening fee) болон үйл ажиллагааны (operating fee) гэсэн 2 төрлийн төлбөр төлнө. Эхлэлийн төлбөрийг үйл ажиллагааг анх эхлүүлэхээс өмнө төлөх бол үйл ажиллагааны төлбөрийг хагас жил тутамд төлнө.

Хүснэгт 6.

Оффшор борлуулалтын үйлчилгээний байгууллага	Үйл ажиллагааны төлбөр
Бүртгэгдсэн капитал: MOP25,000-100,000	MOP5,000
Бүртгэгдсэн капитал: MOP100,001-1,000,000	MOP10,000
Бүртгэгдсэн капитал: MOP1,000,0001-ээс дээш	MOP15,000
Оффшор туслах үйлчилгээний байгууллага	Үйл ажиллагааны төлбөр
Бүртгэгдсэн капитал: MOP25,000-100,000	MOP3,000
Бүртгэгдсэн капитал: MOP100,001-1,000,000	MOP6,500
Бүртгэгдсэн капитал: MOP1,000,0001-ээс дээш	MOP10,000

Зөвшөөрөгдсөн, хориглосон үйл ажиллагаа:

Макаогийн оффшор бүсэд тус хуулийн 2-р зүйлээр заасан санхүүгийн үйлчилгээ, траст менежмент, борлуулалтын үйлчилгээ, туслах үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байдаг.

Харин оффшор институтын хориглох үйл ажиллагаанд байнгын оршин суугчид гадагш шилжүүлэг хийх, өөрөөр хэлбэл, үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт, түрээс, лизинг хийх, эсвэл худалдан авалтанд зээлийн баталгаа гаргах, барьцааг баталгаажуулах болон байнгын оршин суугчдтай холбоотой аль нэг төрлийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Мөн дотоодын мөнгөн тэмдэгт (pataca)-ээр гадагш шилжүүлэг хийхийг хориглоно.

Гүйцэтгэх засаглалын тэргүүнээр батлагдсан оффшор байгууллагуудад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны жагсаалт:

1. Худалдаа, үйлчилгээний төлөөлөгч (commercial and service agents)
2. Гадаадын орнуудад борлуулалтын үйл ажиллагаа (overseas selling activities)
3. Худалдаа мэдээллийн дамжуулалт (trade information dissemination)
4. Усан болон нисэх онгоцны удирдлага, менежмент (management and administration of ships and aircraft)
5. Баримт бичгийн үйлчилгээ (documentation services)
6. Хэрэглэгчдэд зориулсан дуудлагын төв (call centers for customer support)
7. Хяналт, хамгаалалт (investigation and security)
8. Техник хангамжийн зөвлөгөө (hardware consultant)
9. Программ хангамжийн зөвлөгөө (software consultant)
10. Өгөгдлийн боловсруулалт (data processing)
11. Өгөгдлийн сантай холбоотой үйл ажиллагаа (data base related activities)
12. Судалгаа, хөгжлийн үйл ажиллагаа (research and development activities)
13. Хууль зүйн үйлчилгээ (legal activities)
14. Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн зөвлөгөө (accounting, audit and fiscal consultant)
15. Менежмент, бизнесийн зөвлөгөө (management and business consultant)
16. Архитектор, инженерчлэл (architectural, engineering and related activities)
17. Туршилт, техникийн шинжилгээ (tests and technical analysis)
18. Сав баглаа боодол (packaging)
19. Арын алба (back offices)
20. Сургалтын хөтөлбөр (training programmes)

Практикт, Оффшор хууль нь Макаогийн оффшор эдийн засгийг сайжруулахад хөрөнгө оруулалтыг татах бодит хэрэгсэл болж чадаж байна.⁹⁰ Судалгааны захиалгын хүрээнд тус хуулиас харахад Макаогийн оффшор банкуудад данс нээхэд тодорхой хязгаарлалтууд байхгүй байна.

Тус хуулиас ерөнхийд нь харахад үндсэн 3 зарчимд тулгуурласан байна. Үүнд:

- Оффшор байгууллага нь Макаогийн бус мөнгөн тэмдэгт ашиглах,
- Оффшор байгууллагын хэрэглэгчид нь Макаогийн бус оршин суугч байх,
- Оффшор байгууллага нь Макаогийн бус зах зээл рүү хандах ёстой.

3. ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН ОФФШОР БҮСЭД ДАНС НЭЭХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Оросын Холбооны Улс

1999 оны нэгдүгээр сараас эхлэн Оросын ямар ч байгууллагын гадаад оффшортой ямар нэг төрлийн хэлцэл хийгдсэн тохиолдолд татварын шалгалтыг явуулахаар зохицуулсан бөгөөд энэ чиглэлээр “Гэмт хэргийн замаар олж авсан орлого, мөнгө угаахтай тэмцэх тухай” хуулийг батлан мөрдүүлж эхэлсэн. Дотоодын оффшорыг байгуулахад хамгийн том эрсдэл бол орон нутгийн захиргаатай зөрчилдөх явдал байдаг.

ОХУ-д хөнгөлттэй компани /Оросын оффшор компани гэхдээ жинхэнэ утгаараа оффшор компани биш боловч олон шинжээр оффшор компанитай төстэй, хөнгөлттэй компани ч гэж нэрлэдэг/ гэж байх ба Оросын бусад компани, үйлдвэрийн адил давхар татвараас

⁹⁰Yvonne S W Fong (Director of Maninvest Asia Limited)

зайлсхийх, олон улсын хөнгөлөлттэй гэрээнүүдийг ашиглах эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, Оросоос бусад улстай хийгдсэн давхар татварын гэрээг ашиглах эрхтэй байдаг гэсэн үг.

Ердийн гадаадын оффшор бол энэ гэрээний давуу нөхцөлийг эдэлдэггүй байна. Оросын хөнгөлөлттэй компани нь ямар ч улсад өөрийн төлөөлөгчийн газраа нээж болох ба тухайн улс Оростой татварын гэрээтэй бол энэ компани нь ОХУ-д хөнгөлөлттэй хувь хэмжээгээр татвар төлөх болно.

Оросын татварын хууль тогтоомж нь гадаадын оффшор компанид нэлээд хатуу хандах ба гадаадын ямар ч этгээдийн үйл ажиллагаанд саад тотгор учруулж байдаг. Учир нь Оросын компани нь орлогоо гадаадын компани руу шилжүүлэх үедээ гадаадын иргэдийн орлогын албан татварыг суутгаж, төсөвт төвлөрүүлэн шилжүүлэх үүрэгтэй байдаг. /Үүнд орлогын татвараас гадна НӨАТ хамаарна/. Хэрвээ гадаадын компани нь Оросын татварын байгууллагад бүртгүүлж, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар аваагүй бол гадаадын компанид мөнгө, ашиг орлого шилжүүлэх үед Оросын компани орлогын татвар болон НӨАТ-ыг суутган төсөвт шилжүүлэх үүрэг хүлээдэг.

Оросын хууль тогтоомж нь хялбар ойлгомжтой байдаг. Иймд хууль зөрчих, бусдад хууртагдах боломж бага, ойлгоход энгийн хялбар гэж үздэг тул ийм үйлдэл боллоо гэж үзэхэд шүүхэд процедур нь хялбар байдаг. Оросын хууль тогтоомжоор, өөр оронд үнэт цаас эзэмших, гадаадын банкинд данс нээх үед ОХУ-ын Төв банк болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд (СНГ)-ын холбогдох байгууллагуудын зөвшөөрөл шаарддаг. Зөвшөөрлийг авах процедур маш нарийн төвөгтэй байдаг.

Түүнээс гадна гадаадын ямар нэг компанид ажиллах, цалин хөлс авах, тухайлбал тэр компанийн захирал байх нь хөнгөлөлт эдлэх нөхцөл болохгүй. Өөрөөр хэлбэл, захирал, ажиллагсад нь өөрийн цалин хөлсөө мэдүүлж, Оросын иргэний адил татвар төлөх үүрэгтэй. Оросын бага татвартай компаниуд нь хуулийн болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүд, үйл ажиллагааны баримт бичгүүдээ зөв бүрдүүлснээр Оросын хууль тогтоомжид бүрэн нийцүүлэн ажилладаг.

Гадаадын оффшороос ялгаатай нь Үндэсний Аюулгүй байдлын /цагдаа, тагнуул зэрэг хүчний байгууллагууд/ байгууллагууд Оросын оффшор компаниудыг бага сонирхдог, учир нь оффшор компанийн үйл ажиллагаа зөвхөн ОХУ-ын нутаг дэвсгэр дотор явагддаг учраас татварын байгууллага л үүнийг анхаардаг байна.

Оросын хөнгөлөлттэй компанитай гэрээ байгуулсан этгээд нь гадаадын оффшор компани байсан тохиолдолд ОХУ-ын Татварын хуулийн 40.2.3-т /үнэ тарифыг зөв хэрэглэсэн эсэх/ зааснаар татварын хяналтыг явуулдаг. Хэрэв татварын байгууллага талуудын гэрээгээр тогтоосон үнийг зах зээлийн үнээс, эсхүл тухайн бүтээгдэхүүнтэй ижил төстэй бараа бүтээгдэхүүнийн үнээс 20 хувиар их буюу бага тогтоосон тохиолдолд татварын алдангийг зах зээлийн үнээс тооцож ногдуулах эрхтэй.

**“ЗАРИМ КАТЕГОРИЙН ХҮМҮҮСТ ОХУ-ЫН ГАЗАР НУТГААС ГАДУУР
ГАДААДЫН БАНКИНД ДАНС НЭЭХ, МӨНГӨН ХӨРӨНГӨ БОЛОН ҮНЭТ
ЗҮЙЛС ХАДГАЛАХ, ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН
АВАХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ” ОХУ-ЫН ХУУЛЬ**

/Албан бус орчуулга/

*ОХУ-ын Төрийн дум. 2013 оны 04 сарын 24
Холбооны зөвлөлөөр дэмжигдсэн огноо: 2013.04.27*

Нэгдүгээр зүйл.

Энэхүү хуулиар ОХУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах, лобби үйл ажиллагааг журамлах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үндэсний эдийн засагт татан оруулах, авлигалтай тэмцэх үйл ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг сайжруулах зорилгоор албан үүргийнхээ дагуу ОХУ-ын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа зарим категорийн хүмүүсийг ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадуур гадаадын банкинд данс нээх, үнэт зүйлс хадгалах, олон улсын санхүүгийн хэрэгсэл худалдан авах, ашиглах үйл ажиллагааг хориглох, мөн энэхүү хориглох заалтанд хамрагдах хүмүүсийн категорийг тодорхойлох, хориглолтыг зөрчиж буй эсэхэд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлагын асуудлыг зохицуулна.

Хоёрдугаар зүйл.

1. ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадуур гадаадын банкинд данс нээлгэх, үнэт зүйлс хадгалах, гадаадын санхүүгийн хэрэгсэл худалдан авах, ашиглахыг дараах этгээдүүдэд хориглоно. Үүнд:

1.1 Доорх албан тушаал эрхэлж байгаа хүмүүс:

- а/ ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтнууд⁹¹/государственные должности/
- б/ ОХУ-ын Ерөнхий прокурорын 1-р орлогч ба орлогчид
- в/ ОХУ-ын Төв банкны Захирлуудын зөвлөлийн гишүүд
- г/ ОХУ-ын Холбооны улсын субъектүүдийн төрийн өндөр албан тушаалтнууд
- д/ ОХУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Ерөнхий прокуророос томилж, чөлөөлдөг ОХУ-ын Холбооны улсын төрийн албан тушаалтан
- е/ Холбооны улсын субъектүүдийн гүйцэтгэх засаглалын байгууллагуудын орлогчид
- ж/ ОХУ-ын хуулийн хүрээнд байгуулагдсан, ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилж, чөлөөлдөг төрийн өмчит ААН, корпораци, сан болон бусад байгууллагуудын удирдах албан тушаалтнууд
- з/ Хотын захиргаа болон орон нутаг, районы захиргааны дарга

2.2 Хуулийн 1.1-д заасан албан тушаалтнуудын гэр бүлийн хүн, насанд хүрээгүй хүүхэд

2.3 Холбооны улсын хуулиар хориглосон бусад хүмүүс

2. Хуулийн 1.3-т заасан этгээдүүдэд гадаадын банкинд байгаа дансаа хаалгах, эд хөрөнгө, үнэт зүйлсээ хадгалуулахыг зогсоох, олон улсын санхүүгийн хэрэгслүүдээ худалдан борлуулах тодорхой хугацаа олгох ба энэ асуудлыг зохих журмын дагуу хянан шалгаж, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

⁹¹Государственные должности- ХУ-ын Үндсэн хууль, бусад хуульд заасан Холбооны улсын болон ОХУ-ын субъектүүдийн төрийн эрх барих байгууллагуудын албан тушаалтаннууд. Жагсаалтыг ард хавсаргав.

3. Энэ хуулийн 1.1-д заасан хориглолт нь Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий прокуророос томилогдсон боловч ОХУ-ын газар нутгаас гадна орших ОХУ-ын төрийн болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудын албан ёсны төлөөлөгчийн газрын албан тушаалтнууд, тэдгээрийн гэр бүл, хүүхдэд үйлчлэхгүй.

Гуравдугаар зүйл.

1. Хуулийн 1.1, 1.2 - т заасан этгээдүүд нь энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор гадаадын банкинд байгаа дансаа хаалгах, үнэт зүйлс болон бусад санхүүгийн хэрэгсэлээ хадгалуулах, эзэмшихийг зогсоох үүрэгтэй. Заасан хугацаанд хадгаламж дахь хөрөнгөө татаж, дансаа хаалгах арга хэмжээ аваагүй бол тухайн томилогдсон албан тушаалаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь зогсоох, ажлаас халах арга хэмжээ авна.

2. Хуулийн 1.1, 1.2, 1.3-т заасан этгээдүүд хуульд заасан хугацаанд шаардлагыг хэрэгжүүлж чадахгүй тохиолдолд хөрөнгө захиран зарцуулах эрхийг нь хязгаарлах, саатуулах арга хэмжээг тухайн этгээдийн банкны харилцах данс, үнэт зүйлс болон санхүүгийн хэрэгслийг хадгалж буй орны эрх бүхий байгууллагатай хамтран тухайн орны хууль эрх зүйн хүрээнд 3 сарын хугацаанд авч хэрэгжүүлнэ.

3. Олон улсын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах байгууллагын хөрөнгийн итгэмжлэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдах байгууллагыг үүсгэн байгуулагч, ийм төрлийн байгууллагын удирдах бүрэлдэхүүнд ордог. Энэ хуулиар гадаадад данс нээх, эзэмших, хөрөнгө захиран зарцуулахыг хориглосон албан ташаалтан хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор энэ чиглэлийн үйл ажиллагаагаа зогсоож, чөлөөлөгдөх ёстой.

Дөрөвдүгээр зүйл.

1. Хуулийн 2-р зүйлийн 1.1-д заасан этгээдүүд ОХУ-ын Үндсэн хууль, авлигатай тэмцэх тухай хууль, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг болон холбогдох бусад хуулийн дагуу Хөрөнгө орлогын мэдүүлэгтээ өөрийн нэр дээр болон гэр бүлийн хүн, насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр байгаа ОХУ-ын газар нутгаас гадуур эзэмшиж байгаа орлого, хөрөнгө, түүнтэй адилтгах эд зүйл болон тэдгээрийн орлогын эх сурвалжийг мэдүүлнэ.

2. Хуулийн 1.1-д заасан албан тушаалууд дээр нэр дэвшиж байгаа этгээдүүд мөн дээр дурдсан хууль, тогтоомжуудын хүрээнд өөрийн болон эхнэр, хүүхдийн нэр дээр байгаа хөрөнгө, орлогоо мэдүүлэхээс гадна гадаад улсад эзэмшиж байгаа данс, мөнгөн хөрөнгө, үнэт зүйлс, санхүүгийн хэрэгслүүдийн талаар мэдүүлнэ.

3. Иргэн /түүний эхнэр, хүүхэд/ энэхүү хуулиар гадаадад данс эзэмших, захиран зарцуулхыг хориглосон албан тушаалд томилогдсоноос хойш 3 сарын дотор эзэмшиж буй дансаа хаах, үнэт зүйлс хадгалуулахаа зогсоох, санхүүгийн хэрэгслүүдээ худалдан борлуулах үүрэгтэй.

Тавдугаар зүйл.

1. Энэ хуулийн дагуу гадаадын банкинд данс нээлгэх, хөрөнгө хадгалах, үнэт зүйлс болон санхүүгийн бусад хэрэгсэл эзэмших, захиран зарцуулахыг хориглосон этгээдийн хууль сахин биелүүлэх ажиллагаанд хяналт шалгалт хийх шийдвэр гаргахдаа тухайн этгээд хориглолтыг дагаж мөрдөхгүй байгаа талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэнэ.

2. Мэдээллийг дараах байгууллага, албан тушаалтнуудаас бичгээр ирүүлнэ.

Үүнд:

- 1/ хууль сахиулах байгууллага, бусад төрийн байгууллага, төв банк, зээлийн байгууллагууд, бусад байгууллагууд, орон нутгийн удирдах байгууллагууд, авлигатай тэмцэх болон хуулийн зөрчил илрүүлэх байгууллагын хэлтэс, албаны ажилтнууд, төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, төв банкны албан тушаалтнууд, олон улсын банкууд, олон улсын байгууллагууд
- 2/ Байнгын ажиллагаатай улс төрийн намуудын удирдах байгууллагууд, хуулийн дагуу байгуулагдсан иргэний нийгмийн байгууллагууд,
- 3/ ОХУ-ын нийгмийн танхим/ общественная палата/
- 4/ Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүд

3. Нэр хаяггүй мэдээлэл нь хяналт шалгалт явуулах үндэслэл болохгүй.

Зургаадугаар зүйл.

1. Хяналт шалгалт явуулах шийдвэрийг Үндсэн хууль болон авлигатай тэмцэх хууль, бусад хуулийн хүрээнд энэ хуулиар тогтоосон хориглолт болон хязгаарлалтыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллагын холбогдох албан тушаалтан гаргана.

2. Хяналт, шалгалт явуулах үйл ажиллагааг Үндсэн хууль, авлигатай тэмцэх хууль, бусад хуулиар тогтоосон хориглолт болон хязгаарлалтыг сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих журмын дагуу гүйцэтгэнэ.

3. Хяналт шалгалтыг Үндсэн хууль, авлигатай тэмцэх хууль, бусад хуулиар тогтоосон хориглолт болон хязгаарлалтыг сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих журамд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

Долоодугаар зүйл.

1. Хяналт, шалгалтыг Үндсэн хууль, авлигатай тэмцэх хууль, бусад хуулиар тогтоосон хориглолт болон хязгаарлалтыг сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллага, тэдгээрийн салбар, хэлтсүүд болон албан тушаалтнууд явуулна.

2. Хяналт шалгалтыг явуулах байгууллага, албан тушаалтан дараах эрхтэй.

Үүнд:

- 1/ өөрийн санаачилгаар хуулийн 1.1-д заасан этгээдүүдтэй ярилцлага хийх
- 2/ хуульд заасан мэдээлэл өгөх үүрэг бүхий байгууллагуудаас ирүүлсэн нэмэлт материалуудыг үзэж судлах
- 3/ мэдээлэл гаргаж өгсөн байгууллага, хүмүүстэй уулзаж гаргаж ирүүлсэн мэдээлэл, материалтай холбоотой тайлбар, тодруулга авах
- 4/ прокурорын байгууллага, бусад төрийн болон орон нутгийн байгууллага, гүйцэтгэх засаглалын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, банкуудад хандаж хуулиар гадаадын банкинд данс нээх, өмч хөрөнгө болон үнэт зүйлс хадгалах эрхгүй хүмүүсийн нэр дээр байгаа данс, үнэт зүйлс, санхүүгийн хэрэгслүүдийн талаарх мэдээлэл баримт гаргуулж авах.
- 5/ хувь хүн, иргэнээс хяналт шалгалт явуулж байгаатай холбогддуулан мэдээлэл лавлагаа гаргуулж авах талаар зөвшөөрөл авах

3. Хяналт шалгалт хийж байгаа байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу мэдээлэл гаргаж өгөх үүрэг бүхий байгууллагууд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу дурдсан хугацаанд холбогдох мэдээллийг гаргаж гөнө.

Наймдугаар зүйл.

Энэхүү хуулиар гадаадын банкинд данс нээх, эзэмших, үнэт зүйлс болон хөрөнгө, бусад санхүүгийн хэрэгсэл эзэмших эрхээ хязгаарлуулсан албан тушаалтан, түүний эхнэр, хүүхэд дараах эрхтэй. Үүнд:

- 1/ хяналт шалгалт хийж байгаа асуудалтай холбогдуулан бичгээр тайлбар, тодруулга өгөх
- 2/ нэмэлт материал гаргаж өгөх, түүнтэй холбоотой тайлбар тодруулгыг бичгээр өгөх
- 3/ хяналт шалгалт явуулж байгаа байгууллага, албан тушаалтны ярилцлага хийсэн байдал, явуулж буй үйл ажиллагаатай холбоотой гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргах. Гомдлыг зайлшгүй авч үзнэ.

Есдүгээр зүйл.

Энэ хуулийн заалтанд хамрагдаж байгаа, гадаадын банкинд данс нээх, хөрөнгө, үнэт зүйл болон санхүүгийн хэрэгсэл эзэмших эрхгүй албан тушаалтан түүнтэй холбоотой хяналт шалгалт явуулах шийдвэр гаргаснаас 60 хоногийн дотор тухайн албан тушаалаас түдгэлзүүлж болно. Дээрх хугацааг хяналт шалгалт явуулах шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан 90 хоног хүртэл сунгаж болно. Тухайн этгээдийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн хугацаанд уг этгээдийн гадаадын банкинд байршуулсан мөнгөний албан тушаалд хамаарах агуулга хадгална.

Аравдугаар зүйл.

Энэхүү хуулийн хүрээнд ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадуур гадаадын банкинд данс нээх, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалуулах, санхүүгийн хэрэгсэл эзэмших эрхээ хязгаарлуулсан албан тушаалтны хуулийг сахин биелүүлээгүй зөрчил нь ОХУ-ын Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон тухайн этгээдийн эрх зүйн статусыг тодорхойлсон заалтуудыг зөрчиж итгэл эвдсэнд тооцогдох ба хугацаанаас нь өмнө тухайн албан тушаалаас чөлөөлөх, бүрэн эрхийг нь хязгаарлах, ажлаас халах үндэслэл болно.

ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин
Москва, Кремль
№79-ФЗ

ХАВСРАЛТ.**ОХУ-ын Төрийн өндөр албан хаагчдын
холбогдох лавлагаа**

Государственные должности - ОХУ болон Холбооны улсын субъектүүдийн төрийн байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон төрийн өндөр албан тушаалтнууд. Эдгээр албан тушаалтнууд нь төрийн албан хаагч /государственная служба/-аас ялгаатай. ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1995.01.11-ны өдрийн 32 тоот зарлигаар дараах албан тушаалтнуудыг төрийн өндөр албан тушаалтанд тооцож жагсаалт баталсан. Үүнд:

1. ОХУ-ын Ерөнхийлөгч
2. Ерөнхий сайд
3. Ерөнхий сайдын 1-р орлогч
4. Ерөнхий сайдын орлогч- /бүс нутаг хариуцсан Ерөнхийлөгчийн төлөөлөгч/

5. Шадар сайдууд
6. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
7. ОХУ-ын Сайд нар
8. ОХУ-аас гадаад суугаа бүрэн эрхэт элчин сайд нар
9. ОХУ-аас олон улсын байгууллага, гадаада суугаа албан ёсны төлөөлөгчид
10. Холбооны хурлын Холбооны зөвлөлийн дарга
11. Холбооны хурлын зөвлөлийн даргын 1-р орлогч
12. ХУ-ын Холбооны хурлын зөвлөлийн дарга, орлогч, комиссийн гишүүд
13. ХУ-ын төрийн Думын дарга, дэд дарга,
14. Төрийн думын Хороодын дарга, орлогчид
15. Төрийн думын дэд, түр хороодын дарга
16. Төрийн думын гишүүд /Хороодын гишүүд/
17. Үндсэн хуулийн цэцийн дарга, дэд дарга, шүүгчид, нарийн бичгийн дарга
18. Дээд шүүхий дарга, орлогч, шүүгчид
19. Арбитрийн шүүхийн дарга, орлогч, шүүгчид
20. ОХУ-ын Ерөнхий прокурор
21. ОХУ-ын мөрдөн шалгах хорооны дарга
22. ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
23. Хүний эрхийн хорооны дарга
24. ОХУ-ын субъектүүдд гүйцэтгэх засаглалын дээд байгууллагуудын дарга нар
25. Үндэсний аудитийн /Счётная палата/- газрын дарга, орлогч, аудиторууд
26. Төв банкны ерөнхийлөгч
27. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, орлогч, нарийн бичгийн дарга, гишүүд/ орон тооны/
28. ОХУ-ын шүүхийн дарга, орлогч, шүүгчид
29. ОХУ-ын дээд шүүхийн дэргэдэх Шүүх департаментийн /судебный департамент/ ерөнхий захирал

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. <http://aoghs.org>
2. <http://petrowiki.org>
3. <http://www.offshore-mag.com>
4. <http://www.oecd.org>
5. <http://business.rin.ru>
6. <http://maizorig.wordpress.com>
7. <http://www.oecd.org>
8. <http://offschorbystro.ru>
9. <http://business.rin.ru>
10. <http://maizorig.wordpress.com>
11. Макаогийн Оффшор хууль (Offshore Law. Decree-law no. 58/99M), 1999 он. <http://bo.io.gov.mo>
12. Yvonne S W Fong, "An introduction to Offshore Law of Macau", HongKong, 2003.
13. <http://www.mta.mn>
14. "Российская газета" – Федеральный выпуск №5859 от 15 августа 2012 г. Эх сурвалж: <http://www.rg.ru/gazeta/2012/08/15.html>
15. Францын "Улс төрийн ил тод байдлын тухай" хууль - LOI organique n° 2013-906 du 11 octobre 2013 relative a la transparence de la vie publique. Эх сурвалж: <http://www.legifrance.gouv.fr/>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БА ХУДАЛДААНЫ АЛБАН
ТАТВАР, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ, ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ**
(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог, Г.Билгээ,
Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

Оршил

Судалгааны үр дүн

1. НӨАТ болон худалдааны татвар хоорондын ялгаатай ойлголт ба зохицуулалт
2. Гадаадын зарим орны НӨАТ болон худалдааны татварын эрх зүйн зохицуулалт
 - 2.1. Австрали /НӨАТ-Бараа ажил үйлчилгээний татвар/
 - 2.2. Индонези /НӨАТ/
 - 2.3. Казахстан /НӨАТ/
 - 2.4. Канад /НӨАТ-Бараа үйлчилгээний татвар/
 - 2.5. Нидерланд /НӨАТ/
 - 2.6. ОХУ /НӨАТ/
 - 2.7. БНХАУ /НӨАТ/
 - 2.8. Чили /НӨАТ/
 - 2.9. АНУ /Худалдааны татвар/
 - 2.10. Энэтхэг /НӨАТ, Худалдааны татвар/

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудад мөрдөж буй татварын төрөл, хувь хэмжээ

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар шууд бус татварын нийтлэг хувилбар болох Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалт, эдгээр татваруудын хоорондын ялгаа, давуу болон сул тал зэргийг онолын ойлголт, зарим орны туршлага, олон улсын чиг хандлагад тулгуурлан харьцуулан судалсан болно.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд:

- НӨАТ-ын системтэй орнууд: Индонези, Казахстан, Канад, Нидерланд, ОХУ, БНХАУ
- НӨАТ-Бараа ажил үйлчилгээний татвартай орнууд: Австрали, Чили
- Худалдааны татвартай орнууд: АНУ, Энэтхэг зэрэг орнуудыг сонгон авч татварын эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн хүрээнд 1993 оноос Худалдааны татварыг нэвтрүүлж, 1998 оноос Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ болгон өөрчилсөн түүхтэй. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Ernst & Young Их Британий олон улсын Аудит-консалтинг компаниас⁹² 2013 онд дэлхийн 150 гаруй орны татварын системийн талаар гаргасан лавлагаа мэдээллээс⁹³ суурь мэдээллээ авсан бөгөөд үүнийг үндэслэн НӨАТ-ыг сонгодог утгаар нь нэвтрүүлсэн, цогц системтэй орнуудын төлөөлөл болгож Индонези, Казахстан, Канад, Нидерланд, ОХУ, БНХАУ-ыг, уул уурхайн салбар амжилттай хөгжсөн орнуудын төлөөлөл болгож Австрали, Чили улсуудыг, худалдааны татвартай орнуудын төлөөлөл болгож АНУ, Энэтхэг зэрэг орнуудыг сонгон авч судалсан болно. Дээрх мэдээллээс үзэхэд, дэлхийн ихэнх улс НӨАТ-ыг хэрэглэж байгаа бөгөөд татварын систем дэх шууд бус татварын чухал төрөл болох нь харагдаж байна.

Түүнчлэн Олон Улсын Валютын Сан (IMF)-гаас гаргасан мэдээллээр, дэлхийн 140 гаруй улс НӨАТ-ыг нэвтрүүлэн мөрдөж байгаа бөгөөд энэхүү татварын төрөл нь гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөгүй, destination principle буюу экспортод тэг хувиар татвар ногдуулж, импортод үндсэн хувь хэмжээгээр татвар ногдуулдаг зарчим нь гадаад худалдааны олон талт гэрээ хэлцэл, Дэлхийн худалдааны байгууллагын нийтлэг зарчимд нийцэж байна⁹⁴ хэмээн дүгнэсэн байдаг.

Дээрх судалгаануудаас үзэхэд, дэлхийн улс орнуудын Засгийн газрууд НӨАТ-ыг төсвийн орлого бүрдүүлэх томоохон арга хэрэгсэл хэмээн үзэж, татварын системдээ нэвтрүүлсэн нь харагдаж байна. Цөөн улс орныг эс тооцвол НӨАТ-ын систем нь стандарт тогтолцоотой бөгөөд хөрш орнууд болон эдийн засгийн төстэй бүтэцтэй зарим орны хувьд манай орны нөхцөлд тохирохуйц нэг талаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас татвар төлөгчдөд учирч буй дарамтыг бууруулах сонирхолтой туршлагауд ажиглагдаж байна. /судалгаанаас үзнэ үү/

Онолын хувьд авч үзвэл, нэмэгдсэн өртгийн албан татвар бол шууд бус татварын арга хэрэгсэл юм. **Шууд татвар нь** хүн ам, үйлдвэрийн газар, байгууллагын мөнгөн орлогод оногдуулдаг, ямар нэгэн борлуулалт, ажил үйлчилгээгээр дамжуулахгүйгээр авч байгаа татвар бол **шууд бус татвар нь** үнийн нэмэгдлийн хэлбэрээр илэрхийлэгдэж, хэрэглэгчдийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үед ногдуулж, борлуулагчаар дамжин хэрэглэгчдийн өмнөөс төсөвт төлөгддөг татвар юм. Дэлхийн бусад улс орнуудад борлуулалтын татвар, худалдааны татвар, жижиглэнгийн худалдааны татвар, гүйлгээний татвар, НӨАТ, онцгой татвар гэх мэтийн олон төрлийн нэр, зорилт бүхий хэрэглээний татваруудыг авч байна. Нэршлийн хувьд Нэмэгдсэн өртгийн албан татварыг НӨАТ (value added tax), хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар (goods and service tax) гэх мэтээр нэрлэж байна⁹⁵.

НӨАТ ба Худалдааны татварууд нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай нь судалгаанаас харагдаж байна. Энэ хоёр татварын аль нэгийг нь сонгох явдал илүү гүнзгий судалгаанд үндэслэх нь ойлгомжтой. Судлаачдын үзэж байгаагаар төр засгаас энэ асуудлыг шийдвэрлэхдээ шинжлэх ухааны тооцооллын дүнг харгалзахгүй, зөвхөн улс төрийн нөлөөгөөр хууль баталж байна гэдэг.⁹⁶

⁹²Их Британийн Аудитор-Консалтинги компани/ http://ru.wikipedia.org/wiki/Ernst_%26_Young

⁹³[http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/\\$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf](http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf)

⁹⁴John Brondolo, Ron McMorran, Robin Adair, 1999, Mongolia: Improving the design and administration of the VAT IMF-Worldbank

⁹⁵<http://www.iltod.gov.mn/?p=1956>

⁹⁶НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. <http://fingazeta.ru/discuss/49959/>

Ерөнхийд нь авч үзвэл, НӨАТ-ын татварын системийг зөв зохион байгуулж чадсан тохиолдолд татварын давхардлаас зайлсхийх, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шат бүхэнд татвар тооцох, НӨАТ-ыг буцаан олгосноор хямд өртөгтэй бүтээгдэхүүн экспортод гаргах, үйлдвэрлэлийн болон борлуулалтын бүх шатанд татвар ногдуулах гэх мэтийн онцлогууд байх боловч татвар шударга байх, төлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилддөг хэмээн судлаачид үздэг. Ялангуяа НӨАТ-ын татварыг хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамт үүсгэн үнэ хөөрөгдөх нөхцөл бүрдэнэ. Татвар төлөгчийн төлбөрийн чадвартай уялдаж чаддаггүйгээс өрхийн орлого хуваарилалтад сөргөөр нөлөөлж, хэрэглээг бууруулснаар амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөг гэж судлаачид үзэж байна.

Худалдааны татварын хувьд, нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүхэнд татвар давхардуулан оногдуулах, бараа, үйлчилгээний үнэ өсөх, татварын буцаан олголт хийгдэхгүй учраас экспортлогч компанийн хувь татварын ачаалал нэмэгдэх гэх мэтийн онцлогууд байдаг байна.

НӨАТ манай улсад хэрэгжээд удаагүй ч онолын хувьд ч, судалгааны түвшинд ч төгс боловсронгуй болж чадаагүй байгаа татварын төрөл юм. Өнөөгийн байдлаар дэлхий дээр НӨАТ-ын системийг нэвтрүүлээгүй орнууд ч байна. *Тухайлбал*, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, мөн Багамын арлууд, Бахрейн, Британийн Виржиниа, Бермуд, Бруней, Хонгконг, Макао, Кейманы арлууд, Гибралтар, Гуэрнси, Ирак, Кувейт, Ливи, Малдив, Оман, Катар, Сан-Марино, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс зэрэг 17 улс, автономит мужууд НӨАТ-гүй байгаа бөгөөд тэдгээрээс АНУ болон Арабын орнуудад НӨАТ-ыг нэвтрүүлэх талаар асуудал яригдаж байна.

Нэг. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БОЛОН ХУДАЛДААНЫ ТАТВАР ХООРОНДЫН ЯЛГААТАЙ ОЙЛГОЛТ БА ЗОХИЦУУЛАЛТ

Нэр томьёоны ялгаатай ойлголт:

Эх сурвалж	НӨАТ	Худалдааны татвар
Dictionary of taxation terms /English-Russian-German-French/ TACIS, First Edition, 1996	ENG - value added tax; VAT Худалдаалжбайгаабараа, үйлчилгээний үнийн дүнгээс хувь тооцож авах, эсхүл импортолж байгаа тодорхой бараа, үйлчилгээний үнийн дүнгээс хувь тооцож авах шууд бус татвар /англи хэлнээс/ RU - налог на добавленную стоимость, НДС Үйлдвэрлэл, солилцоо, дахин худалдаалах үе шат бүхэнд нэмэгдсэн өртөгт ногдуулдаг татварын систем. Барааны үнэд шингээх замаар шаталсан байдлаар төсөвт шилжүүлэх татвар /орос хэлнээс/	ENG - sales tax Худалдах, худалдан авах гэрээ дуусгавар болоход худалдаалсан бүх барааны үнийн дүнгээс хувь тооцож авах албан татвар /англи хэлнээс/ RU - налог с оборота; налог на продаж Хэрэглэгчийн худалдан авч байгаа бараа, эсхүл үйлчилгээний үнэд шингэсэн татвар /орос хэлнээс/ Жич: Худалдааны татвар нь орон нутгийн татварын ангилалд хамаарч байна.

<p>Г.Цэрэндагва Эдийн засгийн ухаан УБ-2013, хуудас 221</p>	<p>Нэмэгдсэн өртгийн татвар нь түүхий эдээс бүтээгдэхүүн хийж хэрэглэгчдэд хүргэх түвшинд нэмж бий болгосон өртгөөс татвар авдаг арга юм. Жишээ нь: улс татвар авахдаа үйлдвэрийн бүтээсэн өртөг, таваарын үнийн завсрын өртгөөс эхлээд, дараа нь бөөний худалдааны байгууллагын үнэ, үйлдвэрлэгчийн үнийн зөрүүгээс, эцэст нь жижиглэн худалдах дэлгүүрийн үнэ, бөөний худалдааны байгууллагын зөрүүгээс татвар тус тус авна.</p>	<p>Худалдааны татварын нэг төрөл нь нэмэгдсэн өртгийн татвар юм. Энэ нь татварыг янз бүрийн аргаар цуглуулах бодлогын нэг жишээ юм. Өөрөөр хэлбэл татварыг бэлэн болсон бараанаас ч эсвэл түүнийг үйлдвэрлэлийн шатанд ч авч болно. Үйлдвэрлэлийн үе шатуудад зөвхөн нэмэгдсэн өртөг нь татвар ногдуулах зарчмаар татвар хураах аргыг нэмэгдсэн өртгийн татвар илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл таваарын өртгөөс түүнд оролцсон ногдуулах үйл явц юм. Учир нь анхны түүхий эдийн өртгөөс түүний үйлдвэрлэсэн газарт нь татвар авчихсан учраас үйлдвэрлэлийн дараагийн үе шатанд татвар авахгүй гэсэн санаа юм.</p>
<p>ТЕГ, МУИС-ХЗС, ШУА Монгол Улсын албан татварын эрх зүй УБ-2009</p>	<p>НӨАТ нь үйлдвэрлэлийн үе шат бүр дээр нэмэгдэн гарч байгаа нэмүү өртгөөс авч байгаа албан татвар юм. Нэмүү өртөг /VA/ гэдэг нь зөвхөн тухайн шат дамжлаг дээр гарч байгаа цалингийн зардал /V/ ашгийн /m/ нийлбэр бөгөөд татвар төлөгч зөвхөн түүнд ногдох татвараа төсөвт шилжүүлдгээрээ нэмэгдсэн өртгийн албан татвар нь бусад татвараас ялгаатай.</p>	
<p>Борлуулалтын татвар ба НӨАТ-ын судалгаа http://www.iltod.gov.mn/?p=1956</p>	<p>НӨАТ (value added tax) буюу зарим улс оронд хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар буюу (goods and service tax) гэж нэрлэдэг. Өнөөгийн манай улсад хэрэглэж байгаа татвар нь борлуулалтад ногдсон НӨАТ-аас худалдан авалтдаа төлсөн НӨАТ-ыг хасаж тооцдог тогтолцоо юм. НӨАТ-ын гол онцлог нь татварын дарамтыг хэрэглэгчид үүрэх бөгөөд үйлдвэрлэгчдийн төлсөн татварыг хасалт хийж буцаан олгодог онцлогтой.</p>	<p>Худалдааны татвар буюу (sales tax). Энэ татвар нь НӨАТ-ын тогтолцоотой ойролцоо бөгөөд зөвхөн татвар ногдуулах үйлдвэрлэл үйлчилгээний түвшингөөр ялгагддаг. Үйлдвэрлэлийн худалдааны татвар, бөөний худалдааны татвар, импортын худалдааны татвар гэх зэрэг олон хувилбартай.</p>

• **Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/**

Бараа, үйлчилгээний хэрэглээнд ногдуулах татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ гэх бөгөөд бараанд ногдох НӨАТ-ыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд ногдуулж, төлж байдаг. Үүнд: түүхий эд, материал худалдан авах, түүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг бөөний үнээр нийлүүлэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа зэргийг дурдаж болно. Харин үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ыг уг үйлчилгээ эцсийн хэрэглэгчид хүрэх үед ногдуулдаг.

НӨАТ-ын орлого цуглуулах чадварыг (НӨАТ-ын бүтэц, хэрэгжүүлэх аргачлал болон татварын албаны хууль хэрэгжүүлэх чадварыг хамтатган үзүүлэх хэмжигдэхүүн) татварын байр суурь болон татвар төлөгчдийн тоон үзүүлэлт гэсэн хоёр хэмжүүрээр хэмждэг⁹⁷.

НӨАТ (**value added tax**) буюу зарим улс оронд хэрэглээний татвар (consumption tax), бараа үйлчилгээний татвар (goods and service tax) гэж нэрлэдэг. Энэхүү татварын хувьд борлуулалтад ногдсон НӨАТ-аас худалдан авалтдаа төлсөн НӨАТ-ыг хасх тооцдог тогтолцоо юм.

Аливаа татвар нь тухайн улс орны төсөв, татварын тогтолцооны нэг хэсэг байж цогц хэлбэрээр хэрэгждэг. НӨАТ нь шууд бус татварын хувьд бусад татваруудтай уялдаатай байдаг. Жишээ нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн этгээд нь бусдад төлсөн НӨАТ-аа зардлаар тооцдоггүй байхад НӨАТ-аас чөлөөлөгдсөн этгээд нь түүнийг бараа, ажил үйлчилгээний өртөгт шингээж татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцдог.

Өөрөөр хэлбэл НӨАТ-ын гол онцлог нь татварын дарамтыг хэрэглэгчид үүрэх бөгөөд үйлдвэрлэгчдийн төлсөн татварыг хасалт хийж буцаан олгодог онцлогтой.

Хэрэглээ нь харьцангуй тогтмол шинжтэй, өсөлт бууралтын хэмжээ бага байдгаас НӨАТ-ын төсвийн орлогын “тогтмол эх үүсвэр” гэж үздэг. Ийнхүү татварын орлогын хэмжээ өсөж байгаа нь Монгол Улсын эдийн засаг тэлж, хэрэглээ, гадаад худалдааны эрэлт, хөрөнгө оруулалт өссөнтэй холбоотой юм.


НӨАТ-ын хувьд Засгийн газраас үзүүлдэг нийгмийн халамжийн зориулалттай эрүүл мэнд, боловсрол, нийтийн тээврийн үйлчилгээ, мөн шашны үйлчилгээ, төрийн байгууллагын үйлчилгээ, орон сууц түрээслэх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, батлан хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийн импорт гэх мэт бараа ажил үйлчилгээнд татвар ногдуулах нь зохимжгүй байдаг. Төрөөс үзүүлэх үйлчилгээнд НӨАТ ногдуулах нь нийгмийн бодлогод үл нийцэх ба татварын нэмэлт дарамт бий болгож төсвийн зардлыг л нэмэгдүүлнэ гэж үздэг байна.

Мөн түүнчлэн банк, даатгал, үнэт цаас, санхүүгийн салбарын үйлчилгээний НӨАТ ногдох борлуулалтын хэмжээг тодорхойлоход гарах хүндрэлээс шалтгаалан НӨАТ-аас чөлөөлдөг.

Иргэний агаарын тээврийн онгоц, түүний сэлбэг хэрэгсэл, аялал жуулчлал, буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн барааг Олон улсын гэрээ конвенц, нийтлэг жишигт үндэслэн татвараас чөлөөлөх ба дипломат төлөөлөгчийн газрууд, экспортын бараа ажил үйлчилгээ, гадаад оронд үзүүлсэн үйлчилгээнд 0 хувиар татвар ногдуулах нь түгээмэл байна.

Нөгөө талаар НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа этгээд нь эцсийн хэрэглэгч гэж тооцогддог. Жишээ нь банкны үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг. Энэ нь банк өөрийн үйлчилгээний орлогодоо НӨАТ ногдуулахгүй гэсэн утгатай боловч нөгөө талаас хэрэглэгчийн хувьд бүхий л худалдан авалтдаа (дулаан цахилгаан, холбоо, интернэт, ажлын байрны түрээс, тоног төхөөрөмж, програм хангамж гэх мэт) НӨАТ төлдөг. Иймд татвараас чөлөөлөгдөж байгаа хувь хүмүүс, хуулийн этгээдүүд, жижиг бизнес эрхлэгчид нь хэрэглэгчийн хувьд НӨАТ-ын бааз суурийг багасгадаггүй онцлогтой.

⁹⁷Эдгээр үзүүлэлтүүд нь Шинэ Зеланд улсад 65 ба 103 хувьтай байдгаас нь хамгийн шилдэг бүтэцтэй НӨАТ-тай улс гэж тооцогддог байна.

Монгол Улсын хуулиар НӨАТ ногдуулах жишээ⁹⁸**НӨАТ-ын хувь хэмжээ:**

НӨАТ-ын хувь хэмжээг улс бүр өөрийн онцлогт тохируулан тогтоох бөгөөд татварын хувь хэмжээ нь 10-25 хувийн хооронд хэлбэлзэж байна. Зарим улс оронд нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс нь хамааруулан бараа бүтээгдэхүүнд НӨАТ-ын хэд хэдэн хувь хэмжээг байдгийг дараах хувь хэмжээнээс харж болно. Үүнд:

- Хүнс, эмнэлгийн болон хүүхдийн бараа бүтээгдэхүүнд бууруулсан хувь хэмжээг /2-10%/
- Стандарт буюу үндсэн хувь хэмжээг /12-23%/ үйлдвэрийн болон бараа үйлчилгээнд
- Өсгөсөн хувь хэмжээг /25%-аас дээш/ тансаг хэрэглээний зүйлд ногдуулдгаас тодорхой байна.

Хэд хэдэн улс оронд /Канад, Ирланд, Их Британи, Мексик/ дотооддоо борлуулж байгаа бүлэг бараа, үйлчилгээнд тэг хувь хэмжээг идэвхтэй ашигладаг. Бууруулсан хувь хэмжээг болон тэг хувь хэмжээг ашигладаг бараа, үйлчилгээг дурдвал:

- Сонин хэвлэлд бууруулсан болон тэг хувь хэмжээг бараг бүх улс оронд /Канад, Япон, Шинэ Зеланд, Туркээс бусад/,
- Хүнсний бүтээгдэхүүнд ойролцоогоор 18-23 улс оронд бууруулсан хувь хэмжээг,
- Эмийн бүтээгдэхүүнд ойролцоогоор 11 улс,
- Олон нийтийн тээврийн хэрэгсэлд 10 гаруй,
- ХАА-н хүнсний бүтээгдэхүүнд бараг бүх улс орон хөнгөлөлттэй хувь хэмжээг хэрэглэж байна.

Гэвч олон улсын жишгээс харахад цаашдаа нэгдсэн нэг хувь хэмжээг хэрэглэх чиг хандлага харагдаж байна. Учир нь олон хувь хэмжээг хэрэглэх нь татвар хураахтай холбоотой зардлыг нэмэгдүүлдэг, өсгөсөн хувь хэмжээ нь тухайн барааны эрэлтийг бууруулж орлого хуваарилахад сөрөг нөлөөг үзүүлдэг, бууруулсан хувь хэмжээг бүх

⁹⁸www.mongoltax.mn

түвшний хэрэглэгчид адил түвшинд хүртдэг учир орлогын хуваарилалтыг хүссэн үр дүн гардаггүй гэх мэт шалтгаантай.

НӨАТ-ыг 10 хувиас доогуур ногдуулах нь ховор байдаг. НӨАТ-ын хувь хэмжээ дунджаар Европын Холбооны улсуудад 19.5 хувь, ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад 17.7 хувь, Латин Америкийн улс орнуудад 14.2 хувь, мөн Азийн орнуудын хувьд дунджаар 10.8 хувь байх бөгөөд Сингапур 7 хувь, Япон 5 хувь зэрэг цөөн орон доогуур хувь хэмжээтэй байдаг.

Харин худалдааны албан татварыг хэрэглэдэг улс орнуудын хувьд 3-8.25 хувь хэмжээ хэлбэлздэг.

- **Худалдааны татвар**

Худалдааны татвар нь 1918 онд зохиогдсон НӨАТ-ыг бодвол хамаагүй эртний буюу МЭӨ 2000 жилийн өмнө үүссэн гэж эрдэмтэд баталсан байна. Өнөө цагт Худалдааны татварыг орон нутгийн, эсхүл бүсийн хэмжээнд хэрэгжүүлдэг татвар болоод байна. Ингэхдээ уг татварын хувь хэмжээг орон нутгийн, эсхүл бүс нутгийг удирдах байгууллагаас тогтоох болсон бөгөөд бүр үүнээс болж Энэтхэгийн муж улсуудын хооронд татварын “хувь хэмжээний дайн” болж байжээ.⁹⁹

Худалдааны татвар буюу (**sales tax**) нь НӨАТ-ын тогтолцоотой ойролцоо бөгөөд зөвхөн татвар ногдуулах үйлдвэрлэл үйлчилгээний түвшингөөр ялгагддаг. Үйлдвэрлэлийн худалдааны татвар, бөөний худалдааны татвар, импортын худалдааны татвар гэх зэрэг олон хувилбартай.

Эдгээр хувилбаруудаас түгээмэл ашиглагддаг нь жижиглэнгийн худалдааны татвар буюу (**retail sales tax**) юм. Энэ татварыг зөвхөн эцсийн хэрэглээнд ногдуулдаг бөгөөд бизнесийн хэрэглээнд ногдуулдаггүй. Бараа, ажил үйлчилгээ борлуулагч нь худалдан авагчаа эцсийн хэрэглэгч болон бизнесийн зорилгоор худалдан авч байгаа үйлчлүүлэгч гэж ялгавартай хандах шаардлагатай байдаг. Буцаан олголт хийдэггүй давуу талтай гэж тооцогддог боловч татвараас зугтах боломж илүү өндөр байдаг. Канадын Онтарио, Манитоба муж, АНУ-ын Аризона, Индиана мужуудад ногдуулж байна.

Манай улсын хувьд 1998 оноос өмнө худалдааны татвартай байсан бөгөөд 1998 оны 01 сарын 06-нд НӨАТ-ын тухай хууль батлагдаж, мөн оны 07 сарын 01-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

АНУ бол үндэсний худалдааны татваргүй цорын ганц хөгжингүй улс. Германы үндэсний худалдааны татвар 19 хувь, Их Британи 20 хувь, Өмнөд Солонгос 10 хувьтай байна.

ОХУ-д Худалдааны татварыг 2 ч удаа нэвтрүүлж байжээ: 1991 онд ЗХУ-ын хуулиар хэрэгжиж эхэлсэн бол 1998 онд шинээр ОХУ-ын орон нутгийн татвар хэлбэрээр ногдуулж байсан. Одоогийн үйлчилж байгаа НӨАТ нь 2004 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн Татварын тухай хуулийн 28 бүлэг хүчин төгөлдөр болсон байна.

АНУ-ын муж улсуудын түвшинд Худалдааны татварыг хэрэгжүүлж байгаа. Цахим худалдаа гарч ирсэнтэй холбогдуулан худалдагч, худалдан авагч тус бүр өөр өөр муж улсад байхад барааны агуулах нь гурав дахь мужид байх гэх мэт асуудлаас болж уг татварын удирдлагыг хялбаршуулж болох юм.

⁹⁹НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. 21.06.2012.
<http://fingazeta.ru/discuss/49959/>

- **НӨАТ болон Худалдааны татварын ялгаатай ойлголт¹⁰⁰:**

НӨАТ-ын давуу болон сул тал:

- Уг татварын тогтолцоог сайн зохион байгуулж чадсан тохиолдолд татварын давхардлаас зайлсхийх боломжтой.
- НӨАТ нь бараа бүтээгдэхүүний үе шат бүр дээр төлөгдсөн НӨАТ-ыг бүрэн тооцдог.
- Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа НӨАТ-ын хуулиар экспортын бүтээгдэхүүний “0” хувьтай байгаа бүтээгдэхүүний хувьд экспортлогчид орц худалдан авахдаа бүх НӨАТ-аа буцаан авч, манай улсаас экспортоор гарч байгаа бүтээгдэхүүний хувьд ямар ч НӨАТ шингээгүй байдаг.
- Татварын ачааллын тэгш хуваарилалт
- Татвар төлөхөөс зайлсхийх боломжгүй, хүндрэлтэй
- Бараа худалдан авагчийн статусыг шалгах шаардлагагүй /эцсийн худалдан авагч мөн эсэхийг/
- Зуучлагч /дамын наймаачид/ татвар төлнө.

НӨАТ тогтоосон орнуудын ерөнхий чиг хандлагаас харвал энэ төрлийн татварыг татварын тогтолцоонд нэг голлох татвар болон хувирсан. Үндсэн шалтгаан нь нэмэгдсэн өртгийн албан татвар нь¹⁰¹:

- Төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог;
- Татвар хураахад хялбар учир татварын тогтолцоог гажуудуулах нь бага;
- Татварын хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлдэг;
- Олон Улсын нийтлэг, стандарт загвартай тул олон улсын жишигт нийцсэн татварын тогтолцоог бүрдүүлэхэд хялбар зэрэг давуу талуудыг олгодог.

Дутагдалтай талыг нь:

- Татварын шударга байх, төлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилдөх /хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир татвар төлөгчийн төлбөрийн чадвартай уялдаж чаддаггүйгээс нийгмийн орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамтыг үүсгэн, шударга бус тогтолцоо бүрдэнэ./
- Орлого хуваарилалтаар сөрөг нөлөөтэй /бага орлоготой өрхийн хувьд НӨАТ нь хэрэглээгээр дамжин төлдөг учир зайлшгүй бодит хэрэглээгээ бууруулахаас өөр аргагүй болдог нь тэдний амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөг./

Худалдааны татварын давуу болон сул тал:

- Худалдааны татварын үед нийлүүлэлтийн сүлжээний эхний шатанд төлсөн татвар хоёр дахь шатны нийлүүлэгчийн борлуулалтын үнэнд шингэсэн байдаг учраас татварыг давхардуулан оногдуулдаг.
- Бараа үйлчилгээний жижиглэнгийн үнэнд шингэсэн худалдааны татварын хэмжээ нийлүүлэлтийн сүлжээнд байгаа үе шатны тооноос хамаарна. Ингэснээр компаниуд үйлдвэрлэлдээ ашигладаг ихэнх орцыг “өөрсдөө нийлүүлэх” сонирхолтой болж, энэ нь гол төлөв жижиг, дунд хэмжээний нийлүүлэгчдэд хохиролтой байдаг.
- Худалдааны татвар нь компаниудыг үйлдвэрлэлийн орц, түүхий эдийг импортоор авах замаар дотоодын худалдан авагч татвар төлөхөөс зайлсхийх хандлагыг бий болгодог. Ийнхүү импортын бүтээгдэхүүний сонгосноор дотоодын үйлдвэрлэгч компаниудын эдийн засгийг доройтуулах хандлагыг бий болгодог.
- Худалдааны татварын хувьд экспортлогчид хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлсэн ч экспортлогчдын орцонд шингэсэн худалдааны татварыг буцаан олж авах

¹⁰⁰НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета. <http://fingazeta.ru/discuss/49959/>

¹⁰¹ТЕГ, МУИС-ХЗС, ШУА Монгол Улсын албан татварын эрх зүй, УБ-2009.

боломжгүй байдаг. Энэ татварын дарамт нь НӨАТ-тай улсуудын экспортлогчидтай харьцуулахад харьцангуй татварын дарамтыг бий болгож, экспортлогч компаниудын эдийн засгийн чадавхыг сул болгодог байна.

- Худалдааны татварын хувьд удирдлага, зохион байгуулалтын хувьд НӨАТ-аас энгийн зохион байгуулалттай байдаг давуу талтай боловч татварын ачааллын тэгш бус хуваарилалттай байна.
- Татвар төлөхөөс зайлсхийх боломжтой
- Бараа худалдан авагчийн статусыг шалгах шаардлагатай /эцсийн худалдан авагч мөн эсэхийг/
- Зуучлагч /дамын наймаачид/-д татвар ногдуулах боломжгүй.

Дээр дурдсан давуу болон сул талуудыг дэлгэрүүлэн авч үзье. Ямар ч татварын гол үзүүлэлтүүдийн нэг бол татвар төлөхөөс зайлсхийх боломж байгаа эсэх юм. НӨАТ болон Худалдааны татварыг харьцуулбал, Худалдааны татварын системийн хувьд худалдагчийн зүгээс түүний барааг худалдан авч байгаа этгээд эцсийн худалдан авагч мөн эсэх талаар асуулт байнга гарч ирнэ¹⁰²: (1) хэрэв “тийм” бол худалдагч нь худалдан авагчаас татвар авна, (2) хэрэв “үгүй” бол бараагаа татваргүй худалдана. Гэхдээ худалдан авагч нь авч байгаа бараагаа худалдах зорилготой өөр нэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглана гэж мэдүүлэх боломжтой, гэтэл хэрэг дээрээ бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдахгүй. Энэ тохиолдолд худалдан авагч худалдааны татвараас зайлсхийж байгаа хэрэг. Мэдээж худалдан авалт бүрд Худалдааны татварыг ногдуулж болох боловч энэ тохиолдолд татварын ихээхэн хэмжээний ачаалал бий болно.

Энэхүү хоёр татварын давуу тал нь хадгаламж болон хөрөнгө оруулалтад хамаарахгүй явдал юм. Орчин үед улс орнууд, тэр байтугай хөгжилтэй гэж тооцогддог орнуудад шууд татвараас татгалзах хандлагатай болж, шууд бус татвар, тэр дундаа НӨАТ-ыг сонгох болсон байна. Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралаар Европын ихэнх улсуудад НӨАТ-ын татварын хувь хэмжээгээ нэмэгдүүлсний нэг нь Унгар улс хамгийн өндөр буюу 27 хувь болгож тогтоосон байна.

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НӨАТ БОЛОН ХУДАЛДААНЫ ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- **Австрали /НӨАТ-Бараа ажил үйлчилгээний татвар/**

Уул уурхайн салбар өндөр хөгжсөн, ашигт малтмалын арвин их нөөцтэй энэ улс НӨАТ-ыг бараа ажил үйлчилгээний татвар (goods and service tax) гэсэн нэртэйгээр 2000 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн бөгөөд энэ татвар нь ирээдүйд тус улсын төсвийн орлогын 4 гол эх үүсвэрийн нэг байх болно¹⁰³ гэж хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад нэлээд сүүлд НӨАТ нэвтрүүлсэн орны хувьд хуулийн бүтэц, зохицуулалтууд нь харьцангуй боловсронгуй, орчин үеийн шинжтэй гэж тооцогддог байна.

Татварын хувь хэмжээ нь 10 хувь бөгөөд экспорт болон олон улсын тээврийн үйлчилгээнд тэг хувиар татвар ногдуулдаг, эрүүл мэнд боловсролын үйлчилгээ, хандив тусламж, буяны үйл ажиллагаа, газартай холбоотой гүйлгээ, зарим хүнсний бүтээгдэхүүнийг энэ татвараас чөлөөлдөг байна. Аж ахуйн нэгжийн хувь 75000 австрали доллар, ашгийн бус байгууллагын хувьд 150000 австрали доллараас дээш борлуулалттай бол татвар төлөгчөөр бүртгүүлэх үүрэг үүснэ.

¹⁰²НДС или налог с продаж. Зарубежный опыт. Евгений Воловик эксперт, Финансовая газета.

<http://fingazeta.ru/discuss/49959/>

¹⁰³Dr Ken Henry report 2009, Australia's future tax system.

Австралийн НӨАТ-ын тогтолцоонд татвар төлөгч нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхдээ хэд хэдэн сонголт хийх боломжтой байдаг. Тухайлбал НӨАТ ногдуулах зарчимаа тодорхойлохын тулд Нягтлан бодох бүртгэлийн аккрузал болон мөнгөн суурийн аль нэгийг сонгох боломжтой аж. 2 сая австрали доллараас доош борлуулалттай бол мөнгөн суурийг сонгодог байна.

Энэ нь жижиг бизнес эрхлэгчдэд учрах татварын дарамт, мөнгөн урсгалын хомсдолыг бууруулах ач холбогдолтой байна. Мөн тайлан гаргах хугацааг сар, улирал, жилээр гэж сонгох боломжтой бөгөөд зөвхөн 20 саяас дээш борлуулалттай бол сараар тайлан гаргадаг аж.

Австралийн НӨАТ-ын тогтолцоонд уул уурхайн салбарт зориулсан тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд бусад татвар төлөгчдийн нэгэн адилаар зохицуулагджээ.

- **Индонези /НӨАТ/**

Индонези улс нь уул уурхайн салбараас дотоодын нийт бүтээгдэхүүний багагүй хэсгийг бүрдүүлдэг ашигт малтмал, газрын тос, байгалийн хийгээр баялаг орны нэг бөгөөд ази тивийн хөгжиж буй орны тоонд ордог тул тул энэхүү зөвлөмжид жишээ болгон авлаа.

Индонезийн НӨАТ-ын тухай хуулийг¹⁰⁴ баталснаар тус улс нь 1985 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн өмнө нь үйлчилж байсан худалдааны татварыг халж НӨАТ нэвтрүүлжээ. Тус улсын хувьд үйл ажиллагааны чиглэлээс хамаарч 180-360 сая индонези рупи буюу 26-52 сая төгрөгтэй тэнцэх хэмжээтэй борлуулалт хийсэн тохиолдолд НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг байна.

Тус улсын хуулиар нийтийн мэдээллийн хэрэгсэл, зочид буудал болон ресторан бусад хоолны газрын хоол хүнс, тус улсад олборлосон уул уурхайн бүтээгдэхүүн, өрөмдлөгийн ажил НӨАТ-аас чөлөөлөгддөг байна. Мөн эрүүл мэнд боловсрол, банк, санхүү, даатгалын үйлчилгээ, шуудан, нийтийн тээврийн үйлчилгээ татвараас чөлөөлөгддөг байна.

НӨАТ нь манай улстай адил 10 хувь бөгөөд тайланг сараар гаргадаг байна. Татварын тайлангаа цаг хугацаандаа өгдөг, татварын ямар нэгэн өргүй зэрэг тодорхой шалгуур үзүүлэлтийг хангасан байгууллагыг “алтан” статустай татвар төлөгчид оруулна.

“Алтан” статустай татвар төлөгчийг жил бүр Татварын ерөнхий захирал /DGT–Director General of Tax/ тогтооно. “Алтан” статустай татвар төлөгч нь урьдчилан аудитын шалгалтад орж, НӨАТ-ын буцаан олголт эрт авах боломжтой. Хэрэв “алтан” статустай татвар төлөгч нь татварын буцаан олголтоо хэтрүүлж авсан нь аудитын шалгалтаар тогтоогдвол захиргааны торгуулийг 100 хувь төлнө.

- **Казахстан /НӨАТ/**

Казахстан Улс нь газарзүйн байрлал болон эдийн засгийн бүтцийн хувьд Монгол Улстай төстэй бөгөөд ашигт малтмал, газрын тосны асар их баялагтай орон тул жишээ болгон оруулав.

Казахстан Улс 2009 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн НӨАТ-ын шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж эхэлсэн¹⁰⁵ бөгөөд татвар ногдуулах зүйл, чөлөөлөлт буцаан олголттой холбоотой хэд хэдэн чухал өөрчлөлтүүдийг шинэчлэн мөрдөж эхэлжээ.

¹⁰⁴Indonesia VAT Law.

¹⁰⁵Налоговый кодекс РК.

Татварын хувь хэмжээ нь 12 хувь бөгөөд, тайланг улирлаар гаргадаг байна. Мөн тайлан гаргаснаас хойш 10 хоногт багтаан татвараа төлөх үүрэг хүлээдэг байна.

НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босго нь 42390000 тенге буюу 286500 ам.доллар, ойролцоогоор 360 сая монгол төгрөгтэй тэнцэнэ. Зарим төрлийн эм, эмчилгээний эм бэлдмэл, түүхий эд, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортын НӨАТ-аас чөлөөлдөг байна. Онцлог нь Төв банкинд худалдсан үнэт металд тэг хувиар НӨАТ ногдуулдаг байна.

- **Канад /НӨАТ-Бараа үйлчилгээний татвар/**

1991 оны 01 сарын 01-ний өдрөөс Холбооны улсын болон муж улсын худалдааны татварыг уялдуулсан өвөрмөц татварыг бий болгожээ. Энэ татварыг нэвтрүүлснээр үйлдвэрлэгчдийн худалдааны татвар болон харилцаа холбооны татварыг хүчингүй болгожээ.

Тус улсын холбооны улсын бараа үйлчилгээний татвар (goods and service tax) буюу НӨАТ-ын хувь хэмжээ нь 5 хувь байдаг. 30000 канад доллараас дээш борлуулалттай аж ахуйн нэгж, 50000 канад доллараас дээш борлуулалттай ашгийн бус байгууллага татвар төлөгчөөр бүртгэгдэнэ.

Энэ улсын гол онцлог нь муж улсууд нь өөрийн худалдааны татвартай ба 2 төрлийн шууд бус татварыг давхар ногдуулдаг. Гэвч сүүлийн үед муж улсууд эдгээр 2 татварын нэгтгэж эхэлсэн байна. Одоогоор Алберта, Юкон, Нанюват, Баруун хойд муж зөвхөн холбооны 5 хувийн НӨАТ-тэй байгаа ба нийлмэл татварыг Бритиш Колумбия 12, Манитоба 12, Нью Бруинсвик 13, Лабрадор 13, Ньюскотиа 15, Онтарио 13 хувиар тус тус ногдуулж байна. Түүнчлэн 2 татварыг ногдуулах дараалал нь муж бүрд өөр байдгаас нийлмэл хувь хэмжээ нь мөн өөрчлөгддөг аж.

Онцлог тал нь экспортын бараа үйлчилгээнээс гадна зарим хүнсний бүтээгдэхүүн, жороор олгогдох эм, дотоодын болон олон улсын нийтийн тээврийн үйлчилгээ, эмнэлгийн тоног төхөөрөмжид тэг хувиар татвар ногдуулдаг байна. Эрүүл мэнд боловсрол, банк санхүүгийн үйлчилгээнээс гадна хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

- **Нидерланд /НӨАТ/**

Нидерланд Улс нь 1968 онд батлагдсан НӨАТ-ын тухай хуулиар¹⁰⁶ зохицуулагдана. НӨАТ-ын стандарт хувь хэмжээ 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно.

Буруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Мөн түүнчлэн ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кино театр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тоглоомын парк, амьтны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

¹⁰⁶fnref1 Wet op de omzetbelasting 1968 – Wet OB.

Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013

- **ОХУ /НӨАТ/**

Нэг талаас хөрш орон, нөгөө талаас худалдаа эдийн засгийн томоохон түншийн хувьд ОХУ-ын НӨАТ-ын тогтолцоог авч үзлээ. 2001 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн НӨАТ нь ОХУ-ын төсвийн орлогын 30-35 хувийг бүрдүүлдэг төсвийн орлогын хамгийн том эх үүсвэр юм.

ОХУ-ын НӨАТ-ын хуулийн үг хэллэгийг маш нарийн чанд, дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээг чөлөөлөлтөд хамааруулахдаа энэ чөлөөлөлтөд эмнэлгийн тоног төхөөрөмж, хиймэл эрхтэн, түүний түүхий эд сэлбэг, тахир дутуу хүний тэрэг тэргэнцэр, харааны шил, линз (нарны шилнээс бусад), гоо сайхны мэс заслаас бусад хувийн болон эмнэлэгийн эмчилгээ, оношилгооны үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, цус хүлээн авах, сэлбэх үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж, задлан шинжилгээ, жирэмсэн эхчүүд болон нярай хүүхдийн асаргаа, наркологийн эмчилгээ, өндөр настны болон тахир дутуу хүмүүсийн асрамжийн газрын үйлчилгээ хамаарна гэж нарийн зааж өгсөн байна.

Тус улсад ерөнхий хувь хэмжээ нь 2004 оноос эхлэн 18 хувь бөгөөд зарим хүнсний бараа, эм, хүүхдийн хувцас, ном, сонин сэтгүүлийн борлуулалтад 10 хувиар ногдуулдаг байна. Татвар төлөгчөөр бүртгүүлэх босго нь 2 сая рубль буюу ойролцоогоор 90 сая төгрөг байна.

Татварын тайлан гаргах хугацаа нь улирлаар тооцогдох ба татвараа улирлын дараа сарын 20-ний дотор тайлагнаж төлнө.

Хамгийн сонирхолтой хэсэг нь НӨАТ-ын буцаан олголттой холбоотой хэсэг юм. НӨАТ-ын буцаан олголт нь ОХУ-ын татварын тогтолцооны хамгийн эмзэг хэсэг гэж тооцогддог бөгөөд түүнийг буцаан олгохын тулд маш олон тооны баримт материал шаардаж, олон төрлийн шаардлага тавьдаг байна. Тухайлбал экспортод гаргасан барааны НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулж буцаан олгохын тулд тэдэнд экспортын орлого нь бараа хилээр гарснаас хойш 6 сарын дотор ОХУ-ын банкинд дахь дансанд орсон байх, бараа солилцоогоор төлбөрийг авахаар тохиролцсон бол уг бараа нь ОХУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн нь гаалийн байгууллагаар нотлогдсон байх, бэлэн мөнгө хүлээн авсан бол уг мөнгөө ОХУ-ын арилжааны банкинд дахь дансанд төвлөрүүлсэн нь банкны тодорхойлолтоор нотлогдсон байх гэх мэт шаардлага тавьдаг байна.

Мөн барааг экспортод гаргасан гаалийн мэдүүлэг, барааг хилээр нэвтрүүлсэн гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн бичиг баримт, экспортын орлого дансанд төвлөрсөн тухай арилжааны банкны тодорхойлолт, санхүүгийн тайланд тусгасан тэмдэглэл, татвар төлөгчийн хүсэлт, экспортын гэрээний 1 хувь гэх мэт материалыг хавсаргахыг шаарддаг байна. Хэрэв илүү төлөлтийг баталгаажуулах явцад аливаа зөрчил илэрвэл буцаан олголт олгохоос татгалзах үндэслэл болдог байна.

ОХУ-ын Төв банк, эрдэнэсийн санд худалдсан алмаз болон үнэт металл, мөн цаашид боловсруулахаар худалдсан үнэт металлын агуулга бүхий хүдэр, баяжмалын борлуулалт, Төв банк болон Эрдэнэсийн сангаас борлуулсан үнэт металл болон алмазын борлуулалт НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

- **БНХАУ /НӨАТ/**

Манай орны худалдаа, эдийн засгийн гол түнш, томоохон хөрөнгө оруулагч бөгөөд хөрш орны хувьд тус орны НӨАТ-ын тогтолцоог жишээ болгон авав.

Хятад Улс НӨАТ-ыг 1984 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн зөвхөн 24 төрлийн бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн бол 1994 оноос эхлэн өнөөгийн мөрдөж байгаа хууль

хэрэгжиж эхэлжээ. БНХАУ-ын НӨАТ-ын тогтолцоо нь дэлхийд хамгийн нүсэр бөгөөд хамгийн хүчтэй “орлого цуглуулагчид” тооцогддог ба улсын төсвийн орлогын 40-47 хувийг цуглуулдаг байна.

НӨАТ-ын хувь хэмжээний хувьд татвар төлөгчдийг 2 ангилдаг бөгөөд 500000 юаньас доош борлуулалттай үйлдвэрлэл эрхлэгчид, 800000 юаньас доош борлуулалттай худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг жижиг татвар төлөгчид гэж тооцно.

Жирийн НӨАТ төлөгчид нь Монгол Улсад хэрэгждэг падааны аргаар буюу борлуулалтын НӨАТ болон худалдан авалтын НӨАТ-ын зөрүүгээр төлөх татвараа тодорхойлдог бол жижиг татвар төлөгчид нийт борлуулалтын орлогын 3 хувиар НӨАТ төлдөг байна.

Экспортын бүтээгдэхүүнд 0 хувиар, өргөн хэрэглээний хүнсний ногоо, үр тариа, хөдөө аж ахуй, ой, далайн болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ном, сонин сэтгүүл, усан хангамж, халаалт, шатдаг хий, шингэрүүлсэн түлш, ахуйн хэрэглээний нүүрс, нэр бүхий металл болон металл бус эрдсийн түүхий эд, нүүрс, бордоо, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүн, ХАА-н машин техник зэрэг нэр бүхий зарим бараа ажил үйлчилгээнд 13 гэсэн хувь хэмжээгээр, бусад бараа, үйлчилгээнд 17 хувиар НӨАТ ногдуулна.

Боловсрол шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний зориулалтаар импортолсон тоног төхөөрөмж, хөдөө ахуйн анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувь хүн, хоршоолол, нөхөрлөлийн өөрсдийн тарьж ургуулсан болон үржүүлсэн бүтээгдэхүүн, буцалтгүй тусламжийн бараа, тахир дутуу хүнд зориулсан тоног төхөөрөмж, тахир дутуу хүмүүсийн үзүүлсэн үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

Үүний зэрэгцээ барилга, нийтийн тээвэр, банк, санхүү, даатгалын үйлчилгээ, аялал жуулчлал, шуудан, харилцаа холбоо, соёл, урлаг, спорт, уран сайхны үйлчилгээ, тоглоом, амралт зугаалгатай холбоотой үйлчилгээнд НӨАТ ногдуулдаггүй бөгөөд эдгээр үйлчилгээнд Бизнесийн татвар гэдэг тусгай татвар ногдуулдаг байна.

Бас нэг онцлог нь үндсэн хөрөнгө болох байшин барилга, тоног төхөөрөмж худалдан авах үед төлсөн НӨАТ-ыг хасаж тооцдоггүй байна. Энэ нь НӨАТ-ын илүү төлөлт, буцаан олголт нэмэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх боловч нөгөө талдаа хөрөнгө оруулалтын өртөг, элэгдлийн зардлыг нэмэгдүүлэх, улмаар орлогын албан татварын хэмжээг бууруулах нөлөөтэй байна.

НӨАТ-ын падааны ашиглалтыг хянахад хүндрэлтэй байдгаас зарим тохиолдолд НӨАТ-ын падааныг татвар төлөгчийн өмнөөс татварын алба холбогдох баримтыг үндэслэн олгох журам ч зарим мужуудад үйлчилж байна. Импортын үйлчилгээнд НӨАТ болон Бизнесийн татварын хувьд урвуу ногдуулалд буюу reverse charge rule-ийг мөрдөж байна.

• Чили /НӨАТ/

Чилийн Татварын албаны дарга Julio Periera-ийн 2011 оны 3-р сарын 23-ны өдөр тавьсан Татварын орлогын тухай илтгэлд¹⁰⁷ дурдсанаар зэс, молибденийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Чили улсын 2010 оны нийт төсвийн татварын орлого 17,7 триллион песо байснаас НӨАТ-ын орлого түүний 47,7 хувь буюу 8,3 триллион песо байгааг дурджээ. Үүний зэрэгцээ 2011 онд Чилийн татварын албаны гол зорилт нь “НӨАТ-ын ногдуулалтад тавих хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэх явдал” гэж онцолжээ.

¹⁰⁷The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago.

Тэр бээр хэлэхдээ дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ тааламжтай өндөр түвшинд байгаа нь улс орны эдийн засагт нэн тааламжтай нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч НӨАТ нь цаашид төсвийн орлого бүрдүүлэх хамгийн гол хэрэгсэл байх болно гэжээ. Үүнээс үзэхэд Чили улс төсвийн орлогоо бүрдүүлэхдээ НӨАТ-ын үүрэг, ач холбогдлыг тэргүүн ээлжид тавьж байна.

Чили Улсын НӨАТ нь падааны аргад суурилсан бөгөөд бараа ажил үйлчилгээний үнийн дүнгийн 19 хувиар ногдуулдаг байна. Сар бүр тайлан гаргадаг.

- **АНУ** /Худалдааны татвар/

Эдийн засгийн цар хүрээ, хөгжлийн түвшингөөр дэлхийд тэргүүлэгч АНУ-ын хувьд өнөөг хүртэл холбооны улсын түвшинд НӨАТ нэвтрүүлээгүй байгаа бөгөөд ялангуяа НӨАТ-ын тогтолцоог эсэргүүцэгчид энэ орныг жишээ болгон авч эсэргүүцлээ дэвшүүлэн тавьдаг тул учир шалтгааныг нь судлах, дүгнэлт гаргах зайлшгүй шаардлагатай. Иймд энэ улсад яагаад өнөөг хүртэл холбооны хэмжээнд НӨАТ-ыг нэвтрүүлэхгүй байгааг бусад эрдэмтэн судлаачдын судалгаанаас авч үзвэл:

АНУ-ын 50 муж улсын 45 нь шууд бус татварын аливаа нэг хэлбэрийг төсвийн орлогоо бүрдүүлэхэд ашигладаг бөгөөд жижиглэнгийн худалдааны татвар голлох байр суурь эзэлж байна.

АНУ-д холбооны хэмжээнд НӨАТ нэвтрүүлэх санаачилга анх 1862 онд иргэний дайны үед дараа нь 1942 онд Дэлхийн II дайны үед хүчтэй тавигдаж байжээ. Улмаар 1969 онд ерөнхийлөгч Р.Никсон, 1977 оны эхээр ерөнхийлөгч Форд, түүний дараа ерөнхийлөгч Ж.Картер, 1984 онд ерөнхийлөгч Р.Рейган, 2005 онд ерөнхийлөгч Ж.Бушийн Засгийн газрууд татварын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд орлогын албан татварын үүргийг бууруулж НӨАТ нэвтрүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах санаачилгуудыг гаргаж байжээ. Гэвч тухай бүр дэмжлэг олоогүй байна. Уэйнийн их сургуулийн профессор Алан Шенкийн тайлбарласнаар¹⁰⁸ өнөөгийн Б.Обамагийн Засгийн газар төсвийн алдагдлыг бууруулах, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог санхүүжүүлэх эх үүсвэр хайх арга замыг судалж байгаа бөгөөд энэ 2 асуудлыг зэрэг шийдвэрлэх цорын ганц арга нь НӨАТ гэжээ.

НӨАТ нэвтрүүлэх асуудал нь тухай улс орны эдийн засагт олон зэрэг дүн авчрах ач холбогдолтой ч улс төрийн шийдлийн хувьд “амиа хорлолт” болдог ажээ. Тухайлбал 1986 онд Япон Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий сайд Я.Накасонэ, 1991 онд Канад Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий сайд Б.Малруни нар сонгуульд ялагдаж байсан ба Австрали Улсад НӨАТ нэвтрүүлсэн ерөнхий Ж.Ховардын нам парламентад олон суудлаа алдаж байжээ.

АНУ-ын Дотоод орлогын газарт ирүүлсэн нийт орлогын тайлангийн талаас доош буюу 45-48 хувь нь татвар төлөхөөргүй, хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан тайлан байдаг бөгөөд хэрэв НӨАТ нэвтрүүлбэл хүн бүр татвар төлдөг илүү шударга зарчимд шилжинэ гэж үздэг. Гэвч амархан аргаар хэт их төсвийн орлого цуглуулах нь төрийн алба, засгийн газрыг томорход хүргэж эдийн засгийн бүтцэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ гэдэг үзэл өнөөг хүртэл давамгайлсан хэвээр байна.

Судлаачдын үзэж байгаагаар¹⁰⁹, АНУ-д НӨАТ нэвтрүүлэхээс татгалзахад хүргэдэг үндсэн шалтгаанууд нь улс төрийн шалтгаанаас гадна дараах бүлэгт хуваагдахаар байна. Үүнд:

¹⁰⁸Alan Schenk, 2011, Prior US flirtations with VAT, VAT reader, Tax analysts,

¹⁰⁹Douglas Holtz-Eakin, 2011. The case against VAT, VAT reader, Tax analysts.

1. НӨАТ нэвтрүүлэх нь төсвийн зардлыг бууруулах төсөв санхүүгийн бодлогын ерөнхий зарчимд нийцэхгүй. НӨАТ нэвтрүүлснээр төсвийн алдагдлыг бууруулах боломжтой боловч энэ нь улмаар төсвийн зарлагыг нэмэгдүүлэхэд хүргэж НӨАТ-ын хувь хэмжээг байн байн нэмэгдүүлэхэд хүргэнэ. Тухайлбал АНУ саяхан НӨАТ-ын хувь хэмжээгээ 2 хувиар нэмсэн нь дээрх учир шалтгаантай холбоотой.
2. НӨАТ-ын тухай хуулийг хэлэлцэх явцад түүний бүтэц дизайн, ялангуяа хувь хэмжээ, чөлөөлөлтийн хүрээ хэрхэн өөрчлөгдөхийг таамаглах аргагүй.
3. Муж улсууд дийлэнх нь шууд бус татварыг төсөв бүрдүүлэхдээ ашигладаг тул тэдгээрийг холбооны татвартай уялдуулах, эсхүл өөрчлөх нь зөвхөн улс төрийн хувьд бус хэрэгжүүлэх боломжийн хувьд төсөөлшгүй юм.
4. Бага орлоготой хүмүүс нь орлогынхоо дийлэнх хэсгийг хэрэглээнд зарцуулдгаас НӨАТ нь бага орлоготой хүмүүст илүү дарамттай байдаг. Энэ нь мөн дундаж орлоготой хүмүүст ч хамаарах тул орлого хуваарилалтын зарчимд нийцдэггүй байна.
5. Төсвийн алдагдал өндөр, эдийн засгийн байдал зөвхөн хямралаас гарах түвшинд байгаа өнөө үед татварын тогтолцоонд шинэчлэл хийх нь эдийн засгийг дахин хямрахад хүргэнэ гэж үзэж байна.

• **Энэтхэг /НӨАТ, Худалдааны татвар/**

Энэтхэг Улсад үндэсний худалдааны татварын зэрэгцээ НӨАТ-ын татварыг зарим нэр төрлийн бараанд ногдуулдаг байна. Үндэсний худалдааны татварын тухай хуулийг¹¹⁰ 1956 онд баталж, 1957 оны 1-р сарын 5-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Энэхүү хууль нь муж улс хооронд бараа шилжүүлэх буюу бараа худалдахад ногдуулж байгаа татварын харилцааг зохицуулна. Муж улс хоорондын бараа шилжүүлэхэд нэг муж улсаас нөгөө муж улсад бараа шилжүүлэх, мөн бараа эзэмших эрхийн бичиг шилжүүлэхийг багтаана. Өөр муж улсад бараа худалдаж байгаа хүн бүр бүртгүүлж худалдааны татварыг төлөх ёстой.

Анхандаа Худалдааны татварын хувь хэмжээ 1 хувь байгаад 2-3 хувь болж өсөж байгаад 1975 онд 4 хувь хүртлээ өссөн байна. Харин 2008 оны 7-р сарын 1-ээс 3-2 хувь болж эргэж буусан бөгөөд бараа худалдан авч байгаа худалдан авагч, түүний оршин суугаа муж улсаас энэ хувь хамаарна. Хэрэв бараа худалдан авагч нь үйлдвэрлэгч, худалдагч, эсхүл Үндэсний худалдааны татварын тухай хуулиар тогтоосон журмын дагуу барааг ашиглах гэж байгаа бол хөнгөлөлттэй буюу 2 хувийн татвар ногдуулна.

Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд АНУ-аас гадна Багамын арлууд, Бахрейн, Британийн Виржиниа, Бермуда, Бруней, Хонгконг, Макао, Кейманы арлууд, Гибралтар, Гуэрнси, Ирак, Кувейт, Ливи, Мальдив, Оман, Катар, Сан-Марино, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс зэрэг 17 улс, автономит мужууд НӨАТ-гүй байгаа бөгөөд тэдгээрээс Арабын орнуудад НӨАТ нэвтрүүлэх асуудал тавигдаж эхлээд байна. Түүнчлэн БНАСАУ (Хойд Солонгос) 15 хувиар, Куба 2-20 хувиар НӨАТ ногдуулдгийг ч дурдаж болно.

¹¹⁰Central Sales Tax Act /CST/, 1956. http://dor.gov.in/acts_rules.

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудад мөрдөж буй татварын төрөл, хувь хэмжээ

№	Улсын нэр	Татварын төрөл	Мөрдөж эхэлсэн хугацаа	Татварын хувь хэмжээ	Нэмэгдүүлсэн болон бууруулсан хувь хэмжээ
1	Albania	НӨАТ Value-added tax (VAT)	1995.04.27	10-20%	
2	Argentina	НӨАТ Value-added tax (VAT) Гүйлгээний татвар Turnover tax	-	10.5-21%	Нэмэгдүүлсэн 27%
3	Armenia	НӨАТ Value-added tax (VAT)	1993.07.01	20%	
4	Aruba	Орлогын татвар Revenue tax (RT)	2007.01.01	1.5%	
5	Australia	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST)	2000.07.01	10%	
6	Austria (EU ¹¹¹)	НӨАТ Value-added tax (VAT)	1973.01.01	19-20%	Бууруулсан 10-12%
7	Azerbaijan	НӨАТ Value-added tax (VAT)	1992.01.01	18%	
8	Barbados	НӨАТ Value-added tax (VAT)	1997.01.01	17.5%	Бууруулсан 8.75%
9	Belarus	НӨАТ Value-added tax (VAT)	1991.12.19	20%	Бууруулсан 10%
10	Belgium (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1971.01.01	21%	
11	Bolivia	НӨАТ Value-added tax (VAT)	1986.06	13-14.94%	
12	Bonaire, Sint Eustatius and Saba (BES-Islands)	Хэрэглээний татвар General expenditure tax	2011.01.01	6-8%	Зарим бараа бүтээгдэхүүнд 18%-30%
13	Botswana	НӨАТ Value-added tax (VAT)	2002.07.01	12%	
14	Brazil	Холбооны НӨАТ State Value-Added Tax (ICMS)	1989	1,5-35%	/ICMS/ Муж улс дотор 1.5-35% Муж улс хооронд таваарын эргэлт мужаас хамаарч 7-12% /IPI/ Таваарын ангилалаас хамаарч 0-330%, /ISS/ Орон нутгаас хамаарч PIS-PASEP 0,65% ¹¹³ COFINS 3% ¹¹⁴ , 6% ¹¹⁵
		Мужийн НӨАТ Federal Value-Added Tax (IPI)	1964		
		Орон нутгийн үйлчилгээний татвар Municipal Service Tax (ISS)	1968		
		Холбооны нийгмийн татвар ¹¹²	1990		
15	Bulgaria (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1994.01.01	9-20%	
16	Canada	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST) Нэгтгэсэн үйлчилгээний татвар ¹¹⁶ Harmonized Services Tax (HST)	1991.01.01	5-9.5%	

¹¹¹EU-European Union member state¹¹²Contribuição para os programas de integração social e de formação do património public (PIS-PASEP)-/үгчилж орчуулбал/ Нийгмийн нэгдсэн хөтөлбөр, болон нийгмийн фондуудад зориулсан нэмэр хандив¹¹³/кумулятив системн дагуу орлогын татварыг төсөөлөн тооцоох аргад хамаарах татвар төлөгчид /1,65%/ кумулятив бус системн дагуу жилийн бодит орлогын татвар тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/¹¹⁴/кумулятив системн дагуу орлогын татварыг төсөөлөн тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/¹¹⁵/кумулятив бус системн дагуу жилийн бодит орлогын татвар тооцоох аргад хамаарах татвар төлөгчид/¹¹⁶GST буюу бараа ажил үйлчилгээний татвар болон PST буюу орон нутгийн худалдааны татварыг нэгтгэн ногдуулдаг нэгтгэсэн үйлчилгээний татвар юм

17	Chile	НӨАТ Value-added tax (VAT)	1974.12.31	19%	
18	China	НӨАТ Value-added tax (VAT)	1994.01.01	13-17%	
19	Colombia	НӨАТ Value-added tax (VAT)	1983.12.29	5-16%	
20	Costa Rica	НӨАТ Value-added tax (VAT)	1982.11.08	13%	Бууруулсан 5-10%
21	Croatia	НӨАТ Value-added tax (VAT)	1998.01.01	25%	Бууруулсан 5-10%
22	Curacao	Гүйлгээний татвар Turnover tax (TOT)	1999.03.01	6%	
23	Cyprus (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1992.07.01	8%	Бууруулсан 5-8%
24	Czech Republic (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1993.01.01	21%	Бууруулсан 15%
25	Denmark (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1967.07.03	25%	
26	Dominican Republic	Үйлдвэржсэн бараа үйлчилгээний татвар Tax on the Transfer of Industrialized Goods and Services	1992.05	18%	Энэхүү татвараа 2014.12.31-нээс 16%
27	Ecuador	НӨАТ Value-added tax (VAT)	1991.12.31	12%	
28	Egypt	Үндэсний худалдааны татвар General sales tax	1991.05.03	10%	
29	El Salvador	НӨАТ Value-added tax (VAT)	1992.07	13%	
30	Estonia (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1991.01.01	9-20%	
31	Finland (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1994.06.01	24%	Бууруулсан 10-14%
32	France (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1994.06.01	24%	Бууруулсан 10-14%
33	Georgia	НӨАТ Value-added tax (VAT)	1993.12.24	18%	
34	Germany (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1968.01.01	7-19%	
35	Ghana	НӨАТ Value-added tax (VAT)	1998.03.18	12.5%	
36	Greece (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1987.01.01	23%	Бууруулсан 6.5-13%
37	Guatemala	НӨАТ Value-added tax (VAT)	1992.07.01	12%	Бууруулсан 5%
38	Honduras	НӨАТ Value-added tax (VAT) Худалдааны татвар Sales tax	1964.01.01	12-15%	
39	Hungary (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1988.01.01	27%	Бууруулсан 5-18%
40	Iceland	НӨАТ Value-added tax (VAT)	1990.01.01	25.5%	Бууруулсан 7%
41	India	НӨАТ Value-added tax (VAT) Үйлчилгээний татвар Service tax Үндэсний худалдааны татвар Central sales tax (CST)	2005.04.01 1994 1956	12.5-15% 12.36% 2%	

42	Indonesia	НӨАТ Value-added tax (VAT)	1984.01.01	10%	
43	Ireland, Republic of (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1972.11.01	23%	Бууруулсан 4.8%, 9% 13%
44	Isle of Man	НӨАТ Value-added tax (VAT)	1973.04.01	20%	Бууруулсан 5%
45	Israel	НӨАТ Value-added tax (VAT)	1976.06.01	17%	
46	Italy (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1973.01.01	21%	Бууруулсан 4%-10%
47	Japan	Хэрэглээний татвар Consumption tax	1989.04.01	5-8%	2014.04.01-ний өдрөөс уг татварыг 8%, 2015.10.01-нээс 10% болгоно.
48	Jersey, Channel Islands	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST)	2008.05.06	5 %	
49	Jordan	Үндэсний худалдааны татвар General sales tax Үндэсний татвар General Tax Онгой татвар Special Tax	1994.06	4-16%	
50	Kazakhstan	НӨАТ Value-added tax (VAT)	1991.12.24	12%	
51	Kenya	НӨАТ Value-added tax (VAT)	1990.01.01	12-16%	
52	Korea (South)	НӨАТ Value-added tax (VAT)	1977.01.01	10%	
53	Latvia (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1995.05.01	12-21%	
54	Lebanon	НӨАТ Value-added tax (VAT)	2002.02.01	10%	
55	Lithuania (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1994.05.01	21%	Бууруулсан 5-9%
56	Luxembourg (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1969.08.05	15%	Бууруулсан 3-12%
57	Macedonia, Former Yugoslav Republic of	НӨАТ Value-added tax (VAT)	2000.04.01	5-18%	
58	Malaysia	Худалдааны болон үйлчилгээний татвар Sales tax and service tax	1972.02.29	5-10%	
59	Malta (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1999.01.01	18%	Бууруулсан 5-7%
60	Mauritius	НӨАТ Value-added tax (VAT)	1998.09.07	15%	
61	Mexico	НӨАТ Value-added tax (VAT)	1980.01.01	16%	Бууруулсан 11%
62	Moldova	НӨАТ Value-added tax (VAT)	1998.07.01	20%	Бууруулсан 8%
63	Morocco	НӨАТ Value-added tax (VAT)	1986.01.01	20%	Бууруулсан 7-14%
64	Namibia	НӨАТ Value-added tax (VAT)	2000.11.27	15%	
65	Netherlands (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1969.01.01	21%	Бууруулсан 6%
66	New Zealand	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST)	1986.10.01	15%	
67	Nicaragua	НӨАТ Value-added tax (VAT)	1984.12.21	15%	
68	Nigeria	НӨАТ Value-added tax (VAT)	1993.08.24	5%	

69	Norway	НӨАТ Value-added tax (VAT)	1970.01.01	25%	Бууруулсан 8-15%
70	Pakistan	Худалдааны татвар Sales tax			
71	Panama	НӨАТ Value-added tax (VAT)	1976.12.22	7%	Нэмэгдүүлсэн 10%-15%
72	Papua New Guinea	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST)	2004.01.01	10%	
73	Paraguay	НӨАТ Value-added tax (VAT)	1992.07.01	5%-10%	
74	Peru	НӨАТ Value-added tax (VAT)	1991.08.01	18%	
75	Philippines	НӨАТ Value-added tax (VAT)	1988.01.01	12%	
76	Poland (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1993.07.05	23%	Бууруулсан 5-8%
77	Portugal (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1986.01.01	23%	Бууруулсан 6-13%
78	Puerto Rico	Худалдааны болон ашиглалтын татвар Sales and use tax (SUT)	2006.11	7%	
79	Romania (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1993.07.01	24%	Бууруулсан 5%-9%
80	Russian Federation	НӨАТ Value-added tax (VAT)	1991.12.06	18%	Бууруулсан 10%
81	Rwanda	НӨАТ Value-added tax (VAT)	2001.01.01	18%	
82	Serbia	НӨАТ Value-added tax (VAT)	2005.01.01	20%	Бууруулсан 8%
83	Singapore	Бараа ажил үйлчилгээний татвар Goods and services tax (GST)	1994.04.01	7%	
84	Sint Maarten	Орлогын татвар Revenue tax (RT)	1997.01.01	5%	
85	Slovak Republic (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1993.01.01	20%	
86	Slovenia (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1999.07.01	20%	Бууруулсан 8.5%
87	South Africa	НӨАТ Value-added tax (VAT)	1991.09.30	14%	
88	Spain (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1986.01.01	21%	Бууруулсан 4-10%
89	Sweden (EU)	НӨАТ Value-added tax (VAT)	1969.01.01	25%	Бууруулсан 6-12%
90	Switzerland	НӨАТ Value-added tax (VAT)	1995.01.01	8%	Бууруулсан 2.5-3.8%
91	Taiwan	Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсний татвар Business tax Бизнесийн орлогын татвар Gross Business Receipt Tax (GBRT)	1931.06.13	0-5% 0.1-25%	2011.10-р сард уг эрх зүйн актаа шинэчлэн найруулгаар баталсан
92	Tanzania	НӨАТ Value-added tax (VAT)	1998.07.01	18%	
93	Thailand	НӨАТ Value-added tax (VAT)	1992.01.01	7%	2014.01.01-ээс уг татварын хэмжээгээ 10% болгохоор шийдвэрлэсэн.

94	Trinidad and Tobago	HӨАТ Value-added tax (VAT)	1990.01.01	15%	
95	Tunisia	HӨАТ Value-added tax (VAT)	1998.06.02	18%	Бууруулсан 6%-12%
96	Turkey	HӨАТ Value-added tax (VAT)	1984.11.02	18%	Бууруулсан-8%
97	Uganda	HӨАТ Value-added tax (VAT)	1996.07.01	8%	Бууруулсан 18%
98	Ukraine	HӨАТ Value-added tax (VAT)	1992.01.01	20%	2014.01.01-нээс уг татварын хэмжээгээ 17% болгохоор шийдвэрлэсэн.
99	United Kingdom (EU)	HӨАТ Value-added tax (VAT)	1973.04.01	20%	Бууруулсан 5%
100	Uruguay	HӨАТ Value-added tax (VAT)	1972.12.29	22%	Бууруулсан 10%
101	Venezuela	HӨАТ Value-added tax (VAT)	1993.10.01	8-16.5%	
102	Vietnam	HӨАТ Value-added tax (VAT)	1999.01.01	10%	Бууруулсан 5%
103	Zambia	HӨАТ Value-added tax (VAT)	1995.07	16%	
104	Zimbabwe	HӨАТ Value-added tax (VAT)	2004.01.01	15%	

Эх сурвалж: *Worldwide VAT, GST and sales tax guide 2013*

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Сангийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 283 тоот тушаалын хавсралт "Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам".
- Монгол Улсын НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага. О.Цогт. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл. УБ., 2011.08.10. Эх сурвалж: www.mta.mn.
- СЯ-ны ТБЗГ-ын статистик мэдээ. Эх сурвалж: www.mof.gov.mn
- СЯ-ны ТБЗГ-ын www.iltod.gov.mn вэб сайт, 2011 он.
- Татварын ерөнхий газрын мэдээллийн эмхэтгэл 2011 он www.mta.mn
- Dictionary of taxation terms /English-Russian-German-French/ TACIS, First Edition, 1996.
- Г.Цэрэндагва "Эдийн засгийн ухаан". УБ., 2013 он.
- ТЕГ, МУИС-ХЗС, ШУА "Монгол Улсын албан татварын эрх зүй" УБ 2009 он.
- Борлуулалтын татвар ба НӨАТ-ын судалгаа <http://www.iltod.gov.mn/?p=1956>
- Kathrryn James, 2011, Exploring the origin and global rise of VAT, 15, Vat Reader, Tax analysts.
- Indonesia VAT Law.
- Налоговый кодекс РК.
- ftnref1 Wet op de omzetbelasting 1968 – Wet OB. Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013
- Налоговый кодекс Российской Федерации (НК РФ), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость.
- Worldwide VAT, GST and sales tax guide, 2013.
- The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago.
- <http://www.government.nl/issues/taxation>
- [http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/\\$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf](http://www.ey.com/Publication/vwLUAssets/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide/$FILE/2013-worldwide-VAT-GST-and-sales-tax-guide.pdf)
- John Brondolo, Ron McMorran, Robin Adair, 1999, Mongolia: Improving the design and administration of the VAT IMF-Worldbank.

**ТҮРЭЭСИЙН ТАТВАРЫН ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**
(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл,
Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

ОРШИЛ

Судалгааны зорилго

Захиалагчийн хүсэлтийн дагуу Монгол Улс болон гадаадын зарим улс оронд баримталж буй түрээсийн татварын бодлого, холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар судлахыг зорилго болгов.

Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын иргэний хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон АНУ, Ирланд, БНСУ, Малайз, Кени, Канад зэрэг улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийсэн болно.

Судалгааны товч

Манай улсын түрээсийн татварын зохицуулалтын хувьд Хувь хүний орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудаар тус тус зохицуулагдах бөгөөд хувь хүний орлогын албан татвар төлөгч */Монгол Улсын иргэн, Монгол Улсад оршин суух гадаад улсын иргэн, Монгол Улсад оршин суудаггүй гадаад улсын иргэн/* нь түрээсийн орлогод 10 хувийн татвар төлөх бол Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгж хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө түрээслэн олсон орлогод ямар хэмжээний татвар төлөх нь тодорхойгүй байна. Учир нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд татвар ногдох орлогод хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө түрээслэсний орлогыг оруулан хуульчилсан боловч холбогдох бусад заалтад энэ төрлийн орлогод ногдуулах татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулаагүй зэргээс тодорхойгүй үр дагавар бий болсон байна.

Гадаадын зарим орны хувьд:

Судалгаанд хамруулсан улс орнуудаас түрээсийн орлогод хамгийн өндөр татвар ногдуулдаг /дунджаар/ улс нь Малайз байх бөгөөд түрээслүүлэгч нь үл хөдлөх хөрөнгө түрээслүүлсэнээс олсон орлогын хэмжээнээс хамааран 22.1-25.1%, БНСУ-д татвар ногдуулах орлогоос хамааран 6-38%, Ирландад 20%, АНУ-д арилжааны түрээсийн татвар 6%, Кенид мөн түрээс ногдуулах орлогын хэмжээнээс хамааран 10-30% байдаг байна. Мөн татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох, хөнгөлөлт, чөлөөлөлт, мэдүүлэх хугацаа гэх мэт шаардлагатай бусад харилцааг улс бүрийн хуулиар зохицуулсан байх бөгөөд үүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны тайлангийн 2 дугаар хэсгээс үзнэ үү.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үндсэн 3 төрөл байх бөгөөд энэ нь:

- Арилжааны түрээс
- Орон байрны түрээс
- Аж үйлдвэрлэлийн түрээс

гэсэн төрөл байх бөгөөд уг зориулалтаас шалтгаалан түрээсийн үндсэн төлбөр болон

татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт нь өөр өөр байна. Үүнээс манай улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан үл хөдлөх хөрөнгийн түрээсийн төрлүүдээс арилжааны түрээс болон арилжааны түрээсийн татварыг түлхүү судласан болно. Арилжааны түрээс нь түрээслэгч ашгийн төлөөх өөрийн бизнес, үйл ажиллагаандаа зориулан үл хөдлөх хөрөнгийг түрээслэх үйл явц юм. Судалгааны дүнд ихэнх улсад арилжааны түрээсийн зүйл нь томоохон худалдааны төв дэх байр, талбай, албан тасалгаа, их дэлгүүр, албан тасалгаа болон бусад үйлчилгээний цогцолбор, ресторан гэх мэт арилжааны үйл ажиллагаа явуулах объект байдаг байна. Дэлгэрэнгүйг тайлангаас үзнэ үү.

1. ТҮРЭЭС, АРИЛЖААНЫ ТҮРЭЭСИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ БА МОНГОЛ УЛС ДАХЬ ТҮРЭЭС, ТҮРЭЭСИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улс дахь түрээсийн эрх зүйн зохицуулалт: Түрээс гэх ойлголтын хувьд дийлэнх улсад Иргэний хууль болон түүнд хамаарах хууль тогтоомжоор тодорхойлох бөгөөд гэрээний эрх зүйд “түрээсийн гэрээ” нь нэг том салбар судлагдахуун болно.

Монгол Улсын түрээсийн төрөл болон холбогдох бусад харилцаа нь Иргэний хуулийн тусгай ангийн 25 дугаар бүлгийн “Эд хөрөнгө хөлслөх”, 25 дугаар бүлгийн 2 дугаар дэд бүлэг дэх “Орон сууц хөлслөх”, 26 дугаар бүлэг дэх “Санхүүгийн түрээс”, 27 дугаар бүлэгт заасан “Түрээс” зэрэг харилцааг тус тус зохицуулсан байдаг. Үүнээс 27 дугаар бүлэг дэх “Түрээс”-ээр “Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.”¹¹⁷ гэсэн нь энэ бүлэг дэх түрээсийн зохицуулалт нь гадаад орнуудад хэрэгжүүлж буй арилжааны түрээсийн агуулгатай ижил төстэй байгаа юм.

Монгол Улс дахь түрээсийн татварын эрх зүйн зохицуулалт: Манай улсын хувьд түрээсийн татварыг “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-уудиа тус тус зохицуулж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль: Тус хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтаар Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийн татвар ногдуулах орлогыг үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсаны орлого гэх үндсэн 3 төрөлд ангилан хуульчилсан. Үүнээс 9 дүгээр зүйлд хөрөнгийн орлогыг хуульчилан тогтоосон бөгөөд 9.1.1-т заасанчлан “хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого”-д татвар ногдуулахаар заасан. Харин тус хуулийн 16 дугаар зүйлд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлогыг орхигдуулан зохицуулсан байна.

17 дугаар зүйлд албан татварын хувь хэмжээ тогтоосон бөгөөд энэ зүйлийн зохицуулалтад түрээсийн орлогын албан татварын хувь хэмжээ зохицуулагдаагүй байна. Мөн 18 болон 19 дүгээр зүйлүүдэд заасан албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай зохицуулалтад мөн л түрээсийн орлогын талаарх ямар нэгэн зохицуулалт үгүй байгаа нь албан татвар ногдуулах ёстой орлогод хөдлөх үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлогыг хамруулан хуульчилсан ч хувь хэмжээ болон хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг шаардлагатай зохицуулалтад хамруулалгүй орхигдуулсан нь аж ахуйн нэгжийн түрээсийн орлогын татварыг тодорхойгүй болгосон байна.

¹¹⁷Монгол Улсын Иргэний хууль, 27-р бүлэг, 318.1 дах заалт

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль: Энэ хуулийн 3 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд албан татвар ногдох орлогыг хуульчилан тогтоосон байдаг. Үүнд:

8 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

8.1.Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараах орлогод албан татвар ногдуулна:

8.1.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

8.1.2.үйл ажиллагааны орлого;

8.1.3.хөрөнгийн орлого;

8.1.4.хөрөнгө борлуулсны орлого;

8.1.5./Энэ заалтыг 2009 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

8.1.6.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.7.урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал;

8.1.8.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого;

8.1.9.шууд бус орлого.

гэж заасан. Хуулийн 13 дугаар зүйлээр хөрөнгийн орлогод юу юу хамаарахыг тодорхойлсон бөгөөд 13.1.1-т түрээсийн орлого нь эд хөрөнгийн орлогод хамаарахыг, 13.2-т түрээсийн орлогод хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө түрээслэсний орлого хамаарахыг тус тус хуульчилан тогтоосон байна.

Тус хуулийн 19 дүгээр зүйлд хөрөнгийн орлогод албан татварын ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох тухай заасан бөгөөд 19.1.1-т *“Хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос тухайн хөрөнгийг түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээр нь”* албан татвар ногдох орлого нь тодорхойлогдоно гэж заасан. Харин хуулийн 23 дугаар зүйлээр татварын хувь хэмжээг тогтоосон бөгөөд хөрөнгө түрээслэсний орлогын албан татвар 10% байхаар хуульчилан тогтоосон байдаг.

Эдгээр хуулийн зохицуулалтаас үзэхэд хувь хүний орлогын албан татвар төлөгч /Монгол Улсын иргэн, Монгол Улсад оршин суух гадаад улсын иргэн, Монгол Улсад оршин суудаггүй гадаад улсын иргэн/ нь түрээсийн орлогод 10 хувийн татвар төлөх бол Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгж хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө түрээслэн олсон орлогод ямар хэмжээний татвар төлөх нь тодорхойгүй байна.

Түрээсийн тухай олон улсын ойлголт: Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн тухай олон улсад тогтсон нийтлэг ойлголт байдаг. Энэ нь түрээслэгч нь түрээслүүлэгчийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг ашигласныхаа төлөө харилцан тохиролцсон төлбөр төлж байгаа харилцаа гэж тодорхойлсон байдаг. Түрээсийн гэрээ нь аман болон бичгийн хэлбэртэй байхыг зөвшөөрсөн байдаг боловч одоогоор ихэнх улс оронд түрээсийн гэрээ түүнтэй холбоотой аливаа харилцааг хуулиар тогтоосон байна. Тус судалгаанд хамруулахаар түүвэрлэсэн улс орнуудад түрээсийн гэрээг бичгээр үйлдэхээр заасан байна. Гэвч судалгааны захиалагчийн хүсэлт нь түрээсийн татвар тул энэхүү тайланд түрээсийн тухай дэлгэрүүлэн авч үзсэнгүй.

Олон улсын хэмжээнд арилжааны түрээсийг хэрхэн тодорхойлдог тухай: Арилжааны түрээсийг тодорхойлохын тулд юуны өмнө “түрээсийн зүйл” болох үл хөдлөх хөрөнгийг тодорхойлох нь зайлшгүй юм. Үл хөдлөх хөрөнгийн үндсэн 3 төрөл байна. Үүнд:

- “Арилжааны үл хөдлөх хөрөнгө” буюу “*Commercial real estate*”
- “Орон сууцны үл хөдлөх хөрөнгө” буюу “*Residential real estate*”
- “Үйлдвэрлэлийн үл хөдлөх хөрөнгө” буюу “*Industrial real estate*”

Ийнхүү ангилах нь үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын зориулалтыг харгалзан ангилах бөгөөд энэ нь түрээсийн суурь үнэ, түүнээс хураах татварын хувь хэмжээнд нөлөөлдөг байна. Арилжааны үл хөдлөх хөрөнгө нь бизнесийн буюу ашиг олох зорилгоор, орон сууцны үл хөдлөх хөрөнгө нь амьдран суух зорилгоор, үйлдвэрлэлийн үл хөдлөх хөрөнгө нь аж үйлдвэрлэл болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах үл хөдлөх хөрөнгийг ойлгоно.

Үүнээс “Арилжааны үл хөдлөх хөрөнгө”-ийн түрээсийг “Арилжааны түрээс” гэх бөгөөд арилжааны үл хөдлөх хөрөнгөд худалдааны талбай, албан газар, ресторан, ШТС, олон давхар албан газар болон худалдааны цамхаг гэх мэт худалдаа, үйлчилгээ эрхлэх объектууд хамрагдана. “Арилжааны үл хөдлөх хөрөнгийн түрээс” нь ихэвчлэн талбайн түрээс байдаг.¹¹⁸

Арилжааны түрээсийн гэрээ нь бусад түрээсийн гэрээний адил үл хөдлөх хөрөнгийн түрээсийн нөхцөл болон хугацаа гэх мэт үндсэн нөхцлүүдийг харилцан тохиролцсон гэрээ бөгөөд “орон сууцны түрээс”-ээс ялгагдах онцлог нь түрээслэгчдийн хувийн бизнес болон бусад худалдааны зорилгоор ашиглагддаг байна.

Түүнчлэн “Арилжааны түрээс” нь хугацааны хувьд урт хугацаатай (10 буюу 15 жил хүртэл), богино хугацаатай (нэг сар ба түүнээс дээш) байж болно. Хэлбэрийн хувьд бичгээр, эсхүл аман болно.

Арилжааны түрээс нь түрээслүүлэгч болон түрээслэгчийн аль алинд нь ашиг өгөхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, түрээслүүлэгч буюу эзэн нь түрээсээс орлого олох ба орлогоо баталгаажуулахын тулд бүх зардлыг хяналтандаа байлгахыг хүсдэг. Харин түрээслэгч буюу хөлслөгч нь түрээсийн зардлыг аль болох боломжийн үнэ өртөг тогтоохыг хүсдэг. Иймээс түрээслэгч болон түрээслүүлэгч нь цаг үедээ тохируулан үе үе хэлэлцээр хийх боломжтой байх нь тэдний аль альны эрх ашгийг хангах бөгөөд үүнийг “зөв төрлийн түрээс” гэнэ.¹¹⁹ Өөрөөр хэлбэл арилжааны гэрээ нь энэ онцлогоосоо хамаарч заавал зөв төрлийн түрээс байх шаардлагатай.

Захиалагчийн хүсэлтийн дагуу судалгааны дараагийн хэсэгт гадаадын зарим орон дахь түрээсийн татварын зохицуулалт, тэр дундаа Арилжааны түрээсийн татварын зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзэх болно.

2. ТҮРЭЭСИЙН ТАТВАРЫН ТАЛААРХ ГАДААД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 1) БНСУ-ын түрээсийн татварын зохицуулалт
- 2) Малайзын түрээсийн татварын зохицуулалт
- 3) АНУ-ын Нью-Йорк хотын арилжааны түрээсийн татварын тухай хуулийн зохицуулалт
- 4) Ирланд улсын түрээсийн татварын зохицуулалт
- 5) Кени улсын түрээсийн татварын тухай хуулийн зохицуулалт
- 6) Канад улсын орон сууцны түрээсийн тухай хуулийн зохицуулалт

¹¹⁸<http://www.investopedia.com/terms/c/commercialrealestate.asp>

¹¹⁹http://realestate.about.com/od/commercialrealestat1/tp/lease_types.htm

2.1. БНСУ-ын түрээсийн татварын зохицуулалт

БНСУ нь түрээсийн татварын бие даасан эрх зүйн зохицуулалтгүй бөгөөд түрээсийн эрхийн зохицуулалтыг Иргэний хуулиар, түрээсийн татварын зохицуулалтыг Татварын ерөнхий хуулиар зохицуулсан байна.

Түрээсийн эрхийн зохицуулалт:

БНСУ-ын хувьд хуулиар тариалангийн газрыг түрээсийн зорилгоор ашигладаггүй бөгөөд барилгын түрээс, бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх эрхийн хувьд уг түрээсийн эрх нь тухайн үл хөдлөх хөрөнгө, бусдын газар дээрх хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээдэд хамаарна. Түрээсийн гэрээ болон түрээсийн эрхийн харилцааг Иргэний хуулийн VI дэд хэсэг 303-319 дүгээр зүйлээр зохицуулсан байна.

Түрээслэгч этгээдийн хувьд түрээсийн гэрээнд тухайн хөрөнгийн хууль ёсны эзэмшигч мөн эсэх, түрээсийн эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, давхар түрээсийн зохицуулалт, түрээсийн төлбөрийг өсгөх, бууруулах шаардлага гаргах, түрээсийн татварын зохицуулалт, гэрээг дуусгавар болгохыг шаардах эрхийн талаар зайлшгүй тусгадаг байна.

Түрээслэх эрхийн хүчинтэй хугацаа нь 10 жилээс илүү байж болохгүй бөгөөд холбогдох этгээдийн хувьд хэрэв 10 жилээс урт хугацаагаар хийсэн тохиолдолд түүнийг 10 жилээр богиносгож тооцно. Барилга түрээслэхтэй холбоотой түрээсийн гэрээг 1 жилээс богино хугацаагаар хийсэн тохиолдолд 1 жилээр сунгаж тооцно.

Түрээсийн татварын зохицуулалт, татвар тооцох аргачлал:

БНСУ-ын хувьд түрээсийн орлогод оногдох татварын ашигтай хэмжээ сарын орлого US\$1,50 татварын хэмжээ дунджаар 15.1% байх бөгөөд татварын хувь хэмжээг тооцох аргачлал нь тухайн татвар төлөгчөөс хамаарч татварын зэрэглэлээр өөр өөр байна.

Хувь хүнд ногдуулах татвар:

Гадаадын харьяат иргэний хувьд тус улсад Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулан, үндсэн хөрөнгө эзэмшиж, түрээслүүлж орлого олох боломжтой байдаг. Энэ тохиолдолд тус улсын хуулиар хориглосон эрх зүйн зохицуулалт байхгүй. Харин өөрийн компанийн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн татварын байгууллагад бүртгэлтэй байхад хангалттай бөгөөд энэ шаардлага хангагдсан тохиолдолд уг компанийн хувьд улсад төлөх татварыг төлсний дараа түрээсийн орлогоо гадагш нь өөр улсад шилжүүлэх боломжтой болно.

Орлогын албан татвар:

Орлогын албан татварыг хуулиар түгээмэл орлого, тэтгэврийн орлого, үндсэн хөрөнгийн орлого болон татварын шимтгэл гэж ангилдаг. Түгээмэл орлогын татвар ногдуулах татварын хэмжээ тэтгэврийн орлого болон үндсэн хөрөнгийн татвараас татвар ногдуулалтын зэрэглэлийн хувьд өөр өөр байдаг.

Татварын ерөнхий хуулиар түгээмэл орлогын татварын ангилал дараах орлогууд хамаарна. Үүнд: хүүгийн орлого (тусад нь татвар оногдуулсан хүүг хасаж тооцно), дивидентийн орлого (татвар авсан дивидентийг оролцуулахгүй), үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого, бизнесийн үйл ажиллагааны орлого, мэргэжлийн үйлчилгээний орлого, хөдөлмөрийн хөлс гэх зэрэг бусад орлогууд.

Татварыг ногдуулахдаа дээр дурьдсан орлогуудыг нийт орлого гэж үзэн нийт орлогоос хуулиар зөвшөөрөгдөх хасалт хийх бөгөөд үлдсэн орлогыг нэгтгэж холбогдох (прогрессив) зэрэглэлээр татвар оногдуулна.

Хүснэгт 1. Орлогын албан татвар¹²⁰

<i>Татварт хамрагдах орлого (US\$)</i>	<i>Татварын хэмжээ</i>
12 сая хүртэл (US\$10,743)	6%
12 million - 46 million (US\$41,183)	15% бүлэглэсэн байдлаар US\$10,743
46 million - 88 million (US\$78,785)	24% - US\$41,183
88 million - 300 million (US\$268,584)	35% -US\$78,785
Over 300 million (US\$268,584)	38% бүх орлогыг оролцуулан US\$268,584

Түрээсийн орлого:

Тус улсын хувьд түрээсийн орлогыг хувийн компаниар дамжуулан хувь хүмүүс олох бөгөөд татварыг прогрессив зэрэглэлээр ногдуулна. Үл хөдлөх хөрөнгийн түрээсэнд хуулиар тогтоосон татварын ямар нэг хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй. Энэ тохиолдолд татвар ногдуулах орлогод түрээсийн нийт орлого багтах ба сүүлийн таван жилийн хугацаанд гарсан алдагдал ба хуулиар зөвшөөрөгдсөн зардлуудыг хасаж тооцно.

Тус улсын хувьд татвар төлөгч өөрөө үнэлэх татварын системтэй бөгөөд хувь хүн өөрийн татварын орлогоо мэдүүлж, оногдох татварыг хуульд заасан хугацаанд төлнө. Ийнхүү татвараа төлөхдөө татварын орлого нь татварын хөнгөлөлт, чөлөөлөгдсөн тохиолдолд зохих бичиг баримтын бүрдүүлэлтийг хуулийн хүрээнд хийж бүрдүүлсэн байхыг шаардана.

Тус улсын хуулиар татварын зэрэглэлээс шалтгаалан хувь хүний орлогын татварыг тооцох хоёр аргачлал байдаг. Үүнд:

Case 1: Орлого - (орлого *үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагааны зардлын зэрэглэл 20-66% хооронд байна). Энэ зэрэглэлийг хэрэв түрээсийн орлого KRW24 million (US\$21,487)-ээс бага байвал хэрэглэнэ.

Case 2: Орлого - үндсэн зардлууд (орлого *үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зардлын зэрэглэл 15-48% байх). Үндсэн зардлыг хөдөлмөрийн өртөг, худалдан авалтын зардал болон түрээсийн өртөг бүрдүүлдэг.

Үндэсний Татварын Газраас (ҮТГ) жил бүр зардлын зэрэглэлийг боловсруулж гаргадаг.

Хэрэв түрээсийн орлого KRW24 million (US\$21,487)-аас бага мөн хөрөнгийн үнэлэмжийг KRW900 million (US\$805,751) гэж үзвэл, эхний тохиолдлыг энд ашиглаж хувь хүний татварын орлогыг тооцно. Жишээнээс харахад, боломжит орлогын татвар нь нийт түрээсийн 2.48 хувь болж байна. Гэхдээ жилийн түрээсийн орлого KRW20.7 million (US\$18,532) ээс бага байж тодорхой таамаг гарсан байх ёстой.

Үндсэн хөрөнгийн түрээсийн орлогод түрээслэгч мөн НӨАТ-10 хувийг төлнө.

¹²⁰Global Property Guide

2.2. Малайз улсын түрээсийн татварын зохицуулалт

Малайзад түрээсийн орлогын татвар харьцангуй өндөр хэмжээтэй байдаг. Түрээсийн орлогод ногдох татварын боломжит хэмжээ:

Сарын орлого	US\$1,500	US\$6,000
Татварын хэмжээ	22.4%	25.1%

Түрээсийн татварын хувьд тус улсын иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн нь хуулиар тогтоосон хүрээнд бүх төрлийн үл хөдлөх хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгө түрээслэж байгаа тохиолдолд түрээсийн орлогын татварыг 26 хувиар тогтоосон.

Түрээсийн татварыг тооцохдоо орлого бий болгогч зардлууд тухайлбал, зээлийн хүү төлөлтийн зардлууд, засварын зардлууд, орон сууцны үнэлгээний татвар, түрээс цуцлах болон зуучийн хураамж зэрэг зардлуудыг нийт түрээсийн орлогоос хасаж тооцно. Элэгдэл хорогдолыг орлогоос хасахгүй ба хөрөнгийн хөнгөлөлт орон сууцны болон бизнесийн барилгуудад хамаарахгүй юм байна. Гадны иргэн түрээсийн орлоготой байвал 10%-ийн эзэмшигчийн татвар төлнө. Эзэмшигчийн татварыг орлогын татварын эсрэг аккредитивлэж болох магадлалтай.

Түрээсийн татвараас хасагдах орон сууцны үнэлгээний татвар гэдэг нь орон нутгийн чанартай татвар бөгөөд орон нутгийн эрх бүхий байгууллагаас тухайн жилд тогтоосон байрын түрээсийн жилийн үнэд суурилсан байх бөгөөд дундажаар 6% байна.

Түрээс цуцлалтын шимтгэл бол орон нутгийн чанартай татвар бөгөөд газартай холбоотой хөрөнгөд хамаарна. Жилд нэг фиит хавтгай дөрвөлжинд 1 sen (US\$0.003) - 2 sen (US\$0.007) төлнө.

Kuala Lumpur	Зардал (US\$)		Хувь (р.а.)	Үнэ м² (US\$)	
	Худалдаж авах үнэ	Сарын түрээс		Худалдаж авах үнэ	Сарын түрээс
65 м²	177,580	805	5.44	2,732	12.38
120 м²	315,480	1,282	4.87	2,629	10.68
175 м²	405,300	1,811	5.36	2,316	10.35
300 м²	825,300	3,201	4.65	2,751	10.67
Kuala Lumpur - Condominiums					
400 м²	1,146,000	4,812	5.04	2,865	12.03
600 м²	1,731,000	6,048	4.19	2,885	10.08
1000 м²	2,889,000	9,130	3.78	2,899	9.13

2.3. АНУ-ын арилжааны түрээсийн татварын зохицуулалт

АНУ-д үл хөдлөх хөрөнгийн түрээсийн 3 төрөл байх ба үүнээс захиалагчийн хүсэлтийн дагуу худалдааны буюу арилжааны түрээсийн татварын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан авч үзэх болно. Ингэхдээ АНУ-ын Нью-Йорк /New-York/ түрээсийн татварыг жишиг болгон авч үзье.

Нью-Йорк хотын хувьд Нью-Йорк Хотын Захиргааны Кодын /New York City Administrative Code/ 11 хууль болох Санхүү ба Татварын тухай хуулийн 7-р бүлгийн “Арилжааны түрээс,

түрээсийн татвар”¹²¹-ын тухай хуулийн зохицуулалтаар түрээсийн татварын тухай харилцааг зохицуулдаг байна.

Арилжааны түрээсийн татвар /Commercial Rent Tax – CRT/

Арилжааны түрээсийн татвар нь арилжааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгийг ашиглаж буй түрээслэгчидэд ногдуулах татварыг ойлгоно. Тэгвэл “Арилжааны түрээс ба түрээсийн татвар”-ын тухай 7-р бүлгийн 701 дүгээр зүйл дэхь хуулийн нэр томъёоны тайлбарт зааснаар “Tenant” буюу “Түрээслэгч” нь төлбөр төлөгч этгээд эсхүл төлбөр төлөх шаардлагатай үл хөдлөх эд хөрөнгө түрээслэгч, давхар түрээслэгч, эрх эзэмших, зөвшөөрөл эзэмших зэрэг хэлбэрээр түрээсийн төлбөр төлөгчийг ойлгоно¹²² гэж заасан байна.

Хэрэв Нью-Йорк хотын дараах бүсэд аливаа худалдаа, бизнес, мэргэжлийн болон бусад арилжааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор талбай түрээслэж байгаа хэн боловч Арилжааны түрээсийн татвар төлөх субъект болно. Үүнд:

- Манхаттэн дүүрэгт байрлах бол,
- Жил бүрийн эсхүл жилд хөрвүүлсэн нийт түрээсийн төлбөр нь хамгийн багадаа 250,000 ам доллар бол,
- Богино хугацааны түрээс, орон сууцыг давхар түрээслэх, театрын бүтээлд ашиглах ба ашгийн бус хэлбэрээр ашиглах зэрэг татвараас чөлөөлөх бусад шалгуурыг хангаагүй тохиолдолд заавал худалдааны түрээсийн татвар төлөгч байна.

Санамж: Жилийн татвар ногдуулж болох түрээсийн хэмжээ нь 250,000-300,000 ам доллар бүхий түрээслэгчдийг татвараас хэсэгчлэн чөлөөлөх sliding-scale буюу татварын өөрчлөгддөг хэмжүүрийн кредитэд хамруулна.

Хэрэв доорх нөхцлийг хангаж байвал арилжааны түрээсийн татвар төлнө. Үүнд:

- Өөрийн эхнэр /нөхөр/-ийн, эсвэл эцэг эхийн эзэмшлийн байшингийн талбайг түрээслэгч бол,
- Аливаа нэг талбайг өөрийн эхнэр /нөхөр/ эсхүл хамтран амьдрагч биш хэн нэгэнтэй хамтран эзэмшдэг бол,
- Өөрийн ашигладаг, эсхүл хувьцаа эзэмшдэг корпорацийн эзэмшлийн байранд талбай бүхий бол,
- Охин компани эсхүл толгой корпорацийнхаа эзэмшлийн байранд талбай бүхий корпораци бол,
- Өөрийн ажилтны эсхүл хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн байранд талбай бүхий корпораци бол Арилжааны түрээсийн татварыг заавал төлөх ёстой.

Татварын хувь хэмжээ:

Үндсэн түрээсийн 6 хувьд татвар ногдуулна. Бүх татвар төлөгчид үндсэн түрээсийн 35 хувьд хөнгөлөлт эдлэх ба энэ нь бодит татварын хувийг 3,9% болгон бууруулдаг. Үүнээс гадна, хэрэв таны нийт үндсэн түрээс 35% хөнгөлөлт эдлэхээсээ өмнөх байдлаар 250,000-300,000 ам долларын хооронд бол татварын кредит бүхий болохыг зөвшөөрнө.

¹²¹<http://codes.lp.findlaw.com/nycode/ADC/11>

¹²²NYCode, Title-7, Commercial rent and rental tax, article 701.

Үндсэн түрээсийг тооцох:

Байрлал бүрт түрээслэгчийн төлсөн төлбөр
 - Давхар түрээслэгчээс авсан давхар түрээс
 = Үндсэн түрээс*

* - Хэрэв үндсэн түрээс нэг жилээс бага (эсвэл улиралын буцаалтын үед 3 сараас бага) бол буцаалтыг бүхэл үеийн туршид ногдуулан нэгж жилийн болгох ёстой. Ийнхүү нэг жилийн болгосон үндсэн түрээсээс зохих татварын хувийг тодорхойлно.

Татвар төлөх аргачлал:

Улирал тутмын ба жил бүрийн Арилжааны түрээсийн татварын буцаалтыг ашиглан төлөх ёстой тэтгэврийг тооцон тогтооно:

1-р алхам:

- Татвар ногдуулах ёстой үндсэн түрээсийг тооцоолон гаргах,
- Төлсөн бүх түрээсээс "Арилжааны буцаан төлөлтийн хөтөлбөр" /Commercial Revitalization Program/-т заагдсан буюу зөвшөөрөгдсөн бүх хөнгөлөлтүүдийг хасах,
- Татварын хөнгөлөлтийн 35%-ийг хасна.

2-р алхам:

Хэрэв үл хөдлөх хөрөнгийг буцаан төлөлтийн сар /month of the return/ бүрт түрээслээгүй бол 1-р алхам дахь буцаан төлөлтийн бүх л үеийн туршид болгосон дүнг баримтлан бүтэн жилийн болгож тооцоолно. Үүнийг үндсэн түрээсийг түрээсэлсэн саруудад хуваагаад гарсан дүнг 3-р улиралын буцаан төлөлт эсвэл жилийн буцаан төлөлтөөр үржүүлнэ.

3-р алхам:

1-р алхамд гаргасан дүнг (эсвэл 2-р алхамд гаргасан хэсэгчлэн түрээслэсэн үеийн зохих дүнг) ашиглаж ногдуулах татварын хувийг 0 % эсвэл 6%-р тодорхойлно.

4-р алхам:

3-р алхамаас тооцон гаргасан татварын хувийг 1-р алхамаар тооцсон үндсэн түрээсийн дүнд харгалзуулан бодож татвар ногдуулалтыг тооцоолон гаргана.

Хэрэв түрээслэгч нь Манхаттэн дүүрэгт нэгээс илүү олон үл хөдлөх хөрөнгө түрээслэдэг бол өөрт ногдох татварыг тодорхойлохын тулд байршил бүр дээр татвар төлөх аргачлалын дээрх 4 алхамыг давтан үйлдэнэ.

Татвараас чөлөөлөх нөхцөл:

Хэрэв дараах нөхцлүүдийг хангаж байвал татвар төлөх субъект биш. Үүнд:

1. Түрээслэгчийн жилийн үндсэн түрээс 35% хөнгөлөлт ба Арилжааны хөнгөлөлтийн хөтөлбөрт хамрагдахаас өмнө 250,000 ам доллараас дээш бол заавал татварын буцаалтын материал бүрдүүлэн мэдүүлнэ.
2. 14 өдрөөр эсвэл татварын бага хугацаагаар байр түрээслэж байгаа бол.
3. Шалны талбайн 75-аас багагүй хувийг бусад зорилгоор түрээслэж байгаа бол. Үүнд зочил буудал ажиллуулах орохгүй.
4. Тухайлсан театрын бүтээлийн зорилгоор хөрөнгө түрээслэж байгаа бөгөөд бүтээл эхэлсэнээс хойш эхний 52 долоо хоногийн хугацаанд чөлөөлнө.
5. Хэрэв төрийн алба эсвэл ашгийн бус шашны өглөг, буяны эсвэл боловсролын байгууллага бол. Бусад ашгийн бус байгууллагуудын хувьд түрээсийн хөрөнгийг арилжааны зорилгоор ашиглаагүй бөгөөд Санхүүгээс татвараас чөлөөлөх тухай бичиг авсан бол Арилжааны татвар төлөхгүй.

6. Түрээслэгч дэлхийн худалдааны төвийн бүсэд байрлаж байгаа бол Арилжааны татвар төлөгч субъект биш.

Мэдүүлэх болон материал бүрдүүлэх хугацаа:

Түрээслэгч бүр урд жилийн 6 сарын 1-ээс 3 сарын 31 хүртэлх жил бүрийн буцаан төлөлтийн материалыг 6 сарын 20-нд буюу түүнээс өмнө мэдүүлэх ёстой. Харин дараах 2 нөхцлийг хангасан бол дурьдсан хугацаанд мэдүүлэхгүй байж болно. Үүнд:

- (а) Татвар ногдуулах хөрөнгө бүрээс олдог түрээс (аливаа хөнгөлөлт чөлөөлөлтөөс өмнөх) 200,000 ам доллар эсвэл түүнээс бага,
- (б) Давхар түрээслэгч нараас авдаг түрээс 200,000 эсвэл түүнээс бага бол дээр дурьдсан хугацаанд мэдүүлэхгүй байж болно.

Татвар ногдуулахуйц түрээслэгч бүр нь улиралын буцаан төлөлтийн материал бүрдүүлэх ёстой.

Татвар төлөгч нь Арилжааны түрээсийн татвартай холбогдолтой ямар тэмдэглэлийг хадгалах ёстой вэ?

Татвар ногдуулах үл хөдлөх хөрөнгө бүхий газрын эзэн бүр, түрээслэгч бүр давхар тэмдэглэлүүдийг хадгалах ёстой. Үүнд:

- Түрээслэгч эсвэл давхар түрээслэгч бүрийн биеийн байцаалт
- Төлбөл зохих түрээсийн төлбөр
- Төлсөн ба авсан төлбөр
- Үл хөдлөх хөрөнгийн байршил
- Эзэмшлийн хугацаа
- Төлбөл зохих түрээсийн төлбөрийг тогтоосон лиценз, эсвэл зөвшилцөл, эсвэл түрээслэгчийн эрх бүхий гэрээ

Санхүүгээс шалгах хүсэлт гаргах тохиолдолд бүх тэмдэглэл бэлэн байх ёстой. Төлбөл зохих түрээс, түрээслэгчийн эрх зэргийг заасан бүх лиценз ба зөвшөөрлийг хугацаа нь дууссанаас хойш 3 жил хадгалах ёстой. Бусад тэмдэглэлүүдийг ч (хугацаанаас нь өмнө устга гэсэн зөвшөөрөл бичгээр гараагүй бол) жилийн буцаан төлөлтөд бүрдүүлсэнээс хойш 3 жил хадгалах ёстой.

Хэрэв жилийн дунд хэсэгт түрээсийн харилцаа төгсгөл болвол дараах буцаалтыг бүрдүүлнэ. Үүнд: Эрхэлж байсан үйл ажиллагаа дууссанаас хойш 20 өдрийн дотор төлөгдөнө. Татварын дүнг үндсэн түрээсийн төлбөр, бизнес эрхэлж байсан татварын жилийн тухайлсан хэсэгт газрын эргэн төлөх төлбөр зэргийг оролцуулан тооцон гаргана. Хэрэв лицензээр үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээсийн төлбөрийг үргэлжлүүлэн төлөх ёстой. Эсвэл аливаа нэг учир шалтгаанаар түрээсийн төлбөрөө үргэлжлүүлэн төлбөл шаардагдах буцаан төлөлтийн материал бүрдүүлэн мэдүүлэх ёстой.

2.4. Ирландын түрээсийн татварын зохицуулалт

Түрээсийн татварын талаар баримталж буй бодлого: Ирландад түрээсийн харилцаа өндөр хөгжсөн байдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн үндсэн төрлүүдийг хуульчилсан байх бөгөөд орон сууцны түрээс, арилжааны түрээс зэрэг төрөл байна. Үүнээс арилжааны түрээс нь албан ажил болон ашиг олох зорилго бүхий аливаа бизнес эрхлэхээр түрээслэж буй үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийг арилжааны түрээс гэнэ. Түрээсийн татварыг түрээслүүлэгчийн түрээсийн орлогоос тооцон ногдуулдаг байна. Түүнчлэн хуульд заасны дагуу түрээсийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх нөхцөлүүдийг мөн хуульчилан тогтоожээ. Түрээсийн төрөл, түүнд ногдуулах татвар, татвар тооцох аргачлалын тухай илүү дэлгэрэнгүйг нэг бүрчлэн авч үзье.

Түрээсийн татварын эрх зүйн зохицуулалт:

Ирландад Түрээсийн татварын харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

1. Татварын тухай хууль (Tax act)
2. Санхүүгийн тухай хууль (Financies act),
3. Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай хууль /the Landlord and Tenant (Amendment) act 1980/ (the Residential Tenancies Act, 2004)
4. Орон сууцны түрээсийн тухай
5. Иргэний тухай хуулиудаар зохицуулдаг байна.¹²³

Түрээсийн татварын төрөл зүйлүүд:

Түрээсийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Эд хөрөнгө түрээслэх, /байшин, байр, орон сууц, ажлын байр ба тариалангийн газар/
- Бусдын эрхийг түрээслэх, /зар суртчилгааны тэмдэг, самбар босгох, тавих, харилцаа холбооны дамжуулагч хэрэглэх, замын эрхийг хэрэглэх төлбөр/
- Спортын эрх олгох /загасчлах, буудлага хийх зөвшөөрөл/,
- Түрээсийн гэрээнд тусгагдаагүй орон байрны үйлчилгээ, урсгал засвар хийлгэсний хөлсийг түрээслэгчийн талаас төлсөн төлбөрүүд,
- Тариалангийн газар түрээслэх,
- Эд хөрөнгө хэрэглэхтэй дагалдах туслах үйлчилгээний төлбөрүүд,
- Түрээсээ төлөөгүй тохиолдлыг зохицуулах бодлогын дагуух даатгалын нөхөн төлбөрүүд

Орон сууцны болон арилжааны түрээсийн эзэмших эрх:

Арилжааны болон орон сууц түрээслэгчийн эрхийг 1980, 1994 оны “Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай” хуулиар баталгаажуулдаг. Эдгээр хуулиудад урьдын түрээсийн гэрээ дуусгавар болж, шинэ түрээс эхлүүлэх эрх бүхий байхын тулд түрээлэгч дараах 4 тэнцэтгэлийн аль нь болохыг батлах ёстой.

- *Бизнесийн эрх:* Хэрэв түрээслэгч бизнесийн ажлын зорилгоор бизнесийн байрыг тасралтгүй **5 жил** эзэмшсэн бол түрээлэгчийг бизнесийн эрхтэй гэж үзнэ.
- *Урт хугацааны өмчлөлийн эрх:* Орон сууцны болон бизнесийн байрыг тасралтгүй **20 жил** эзэмшсэн бол урт хугацааны өмчлөлийн эрхтэй гэж үзнэ.
- *Засан сайжруулах эрх:* Бизнесийн болон орон сууцны байр түрээслэх үндсэн хэмжээний 2/1-ээс багагүй хэмжээг засан сайжруулалт хийсэн бол,
- *Түрээсийн хуулийн эрх:* 1980 оны “Түрээсийн эзэн ба түрээслэгчийн тухай хууль”-ийн 14 ба 15-р хэсгүүдэд зааснаар Арилжааны болон орон сууцны байрны зарим түрээслэгч нарт 1960-1967 оны түрээсийн хязгаарлалтын хуулиар шинээр түрээслэх эрх олгодог байна. Түрээсийн гэрээ сунгах болзол хангасан түрээслэгч нь хүсэлт гаргах бөгөөд түрээсийн гэрээг 5 жил тутамд сунгана.

Түрээсийн орлогоос татвар ногдуулах:

Түрээсийн орлогод бодит татварын жилийн үндсэн дээр татвар ногдуулна. Орлогын тухай мэдээллийг жил тутмын татварын мэдүүлэгийн холбогдох хэсэгт тодорхой мэдүүлэх ёстой. PAYE системээр татвар төлдөг буюу харьцангуй бага түрээсийн орлоготой хүмүүсийн хувьд татварын кредитийг нь багасгах ба стандарт хувь хэмжээг нь бууруулах зэргээр зохицуулан татварыг хурааж болно. Эсвэл татварыг Өөрийн Үнэлгээний Системээр (Self Assessment system)–р ногдуулан хураана. (Leaflet IT 10 Guide to Self-Assessment).

¹²³<http://www.revenue.ie/en/tax/it/leaflets/it70.html>

Түрээсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт:

Түрээсийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн тухай 2011 оны Санхүүгийн хуулийн 23, 24-р зүйлүүдэд хуульчилсан бөгөөд орон сууцны хөрөнгийг түрээслэгчдийн хөнгөлөлтийг идэвхтэй хязгаарлах эсвэл бүр мөсөн цуцлах үндэслэлүүд байдаг ба, энэ нь бас түрээс эхэлсэн тухай тогтоолоос хамаарна. Тогтоол нь хэмжиж болохуйц үр дагаваруудын тухай эдийн засгийн үр нөлөөний үнэлгээний үр дүн хэвлэн нийтлэгдсэнээс хойш 60 хоногоос багагүй хугацаанд гарна.

Харин хөнгөлөлтийн тухайд татварын хөнгөлөлтийн бүс нутагт байршилтай эд хөрөнгийг орон сууцны хэлбэрээр түрээслэх зорилгоор худалдан авах, барих ба, шинэчлэн засварлахад гаргасан зарим тодорхой зардалд ногдуулна.

Хөнгөлөлтийг тооцохдоо тухайн эд хөрөнгийн зөвшөөрөгдөхүйц хэмжээний өртөгийн нийт дүнг түүнийг болзол ханган түрээслэж эхэлсэн анхны жил нь түрээсийн орлогод хамруулалгүйгээр зардал гэж тооцно. Ямарваа эдлээгүй хөнгөлөлтийг дараах жилүүдэд нь түрээсийн орлого биш харин түрээсийн алдагдал хэмээн шилжүүлэн тооцож болно. Хэрвээ болзол ханган анх түрээслэж эхэлснээс хойших 10 жилийн дотор тухайн эд хөрөнгө, бусдад худалдагдах гэх зэргээр болзол хангахгүй болсон тохиолдолд хөнгөлөлтийг цуцална.¹²⁴

Мөн орон сууцны зориулалтын түрээсийн байрыг шинэчлэн засвар хийсэн тохиолдолд тухайн зардлын зохих хэсгийг (эхний 1-6 жилд 15%, 7 дахь жилд нь 10%) долоон жилийн туршид Ирландын түрээсийн орлогоос хасаж тооцдог. Хэрвээ засвар хийснээс эсвэл шинэчлэн засварлаад анх түрээслэж эхэлснээс хойших 10 жилийн доторх хугацаанд тухайн хөрөнгө худалдагдах эсвэл болзол хангахаа больвол хэдийнээ үзүүлсэн хөнгөлөлтийг уг хөрөнгө худалдагдсан эсвэл болзол хангахаа больсон өдрийг хүртлэх хугацаанд олгосон нийт дүнг буцаан нэхэмжилж авна.¹²⁵

Өрөө түрээслэхэд үзүүлдэг хөнгөлөлт:

Хэрвээ бусдад түрээслэж буй өрөөнүүд нь тухайн хүний үндсэн орон сууцны өрөө бол хоол хүнс, угаалга эсвэл эдгээртэй ижил төрлийн эд зүйлс ба үйлчилгээний хөлсүүдийг оролцуулаад авч буй нийт дүн ("зохих хэмжээ") нь жилийн үнэлгээний хэмжээнээс (одоо жилийн 10 000 евро) хэтрэхгүй бөгөөс зохих нийлбэр дүнгийн ашиг ба алдагдал зэргийг татварын орлогод тэглэн үзнэ. Тэгэхээр эдгээр ашгийг орлогын татвар, Хөрөнгө түрээслэх Ирландын Схем (PRSI), Ерөнхий Нийгмийн Шимтгэл (USC) зэрэгт хамааралгүй гэж үздэг. (Ерөнхий Нийгмийн Шимтгэл (USC) нь 2011 оны 1-р сарын 1-нээс эхлэн орлого ба эрүүл мэндийн шимтгэлээр солигдсон болно). Алдагдалыг өөр бусад түрээсийн ашгаас нь тэнцэтгэн тооцож болохгүй.

Энд зохих нийт дүн гэдэг нь бусад тооцооны өмнөх хэлбэрээр байна. Тухайлбал, энэ дүн хэмжээний орлогыг олоход гаргасан ямар ч зардлыг тооцоогүй байгаа болно. Энэ мэт зохих орлогын дүн хэмжээнд нэгээс илүү, олон хүн эрх бүхий бол хэмжээ хязгаарыг нь тэдэнд тэгш хуваарилах болно.

Гэр бүлийн хэрэгцээний орон сууцны төлбөрийг тухайн нэг хүний хүүхэд нь төлдөг тохиолдолд тэр хүүхэд нь түрээсийн төлбөртөө татварын хөнгөлөлт хүссэн, эс хүссэнээс үл хамааран тухайн хүн өрөө түрээслүүлсний хөнгөлөлт эдлэх боломжгүй. Энэхүү хязгаарлалт нь 2007 оны 1-р сарын 1-ний өдөр ба түүнээс хойш хүчин төгөлдөр болсон. Гэр бүлийн үеэл, бүл гэх зэрэг бусад гишүүд түрээсийг төлж байх тохиолдолд энэ мэт хориг хязгаар байхгүй.

¹²⁴A Guide to Section 23) Relief - Rented Residential Relief in a Tax Incentive Area

¹²⁵Countrywide Refurbishment Scheme

2010 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон өрөөний түрээсийн хөнгөлөлтөнд хэн нэгний түрээсийн төлбөрийг шууд ба шууд бусаар түүнтэй холбоотой хүн төлсөн бол хамрагдахгүй. Өөрөөр хэлбэл үр хүүхэд, садан төрөл болон албаны хүндээ түрээслүүлээд авсан төлбөр нь түрээсийн хөнгөлөлтөнд хамрагдахгүй юм.

Энэ хөнгөлөлт нь мөргэжийн зээлийн хөнгөлөлт болон орон байраа бусад шилжүүлсэнтэй холбоотой капитал хөрөнгийн орлогын татвараас чөлөөлөгдөх зэрэгт огтхон ч нөлөөлөхгүй.

Өрөөны түрээсийн хөнгөлөлтийг хэдийд буюу чухам аль үнэлгээний жил авахаа тухайн хүн жилийн үнэлгээний тайлан мэдүүлэхдээ болон мэдүүлэхийн өмнө сонгож болно.

Хэрвээ энэ хөнгөлөлтийн хүсэлтийг гаргах бол жилийн татварын мэдүүлэгтээ ашиг ба алдагдал зэрэг нь орлогын татварт хамрагдах боломжгүй тэрхүү зохих дүн хэмжээг тодорхой гаргаж өгөх ёстой байдаг байна.¹²⁶

Түрээсийн төлбөр тооцох арга:

Газрын эзэн бүрэн тавилгатай хоёр байрыг түрээслэдэг байлаа гэж бодъя! Тавилгын өртөг нь Байр 1 ба Байр 2 тус бүр харгалзан €2,400 ба €8,000, бөгөөд хоёуланд нь засвар үйлчилгээг хийж явах шаардлагатай*.

Үүнд татвар ногдуулахдаа түрээсийн орлогыг дараах маягаар тооцон бодно:

	Байр 1, €	Байр 2, €
Нийт түрээс	4,000	18,000
Үүнээс хасах нь:		
Даатгал	800	1,000
Газрын түрээс	300	
Цахилгаан/Халаалт	1,200	1,200
Засвар	900	1,700
**Хүү	1,000	2,000
Нийт хасах нь	4,200	6,900
Илүү гарах нь		11,100
Дутах нь	(200)	
Татвар ногдуулах түрээсийн орлого	10,900	
Үүнээс хасах нь:		
Засвар үйлчилгээ	1,300	
Case V-р татвар ногдуулах дүн	9,600	

* Засвар үйлчилгээний өртөг нь €1,300 (€2,400 @ 12.5% + €8,000 @ 12.5%)

** Хүү хасах нь түрээсийн орон сууцыг худалдаж авсан, шинэчлэн засварлахад зарцуулах үүднээс авсан зээлээс үүдэлтэй ба, энэ нь 2009 оны 4-р сарын 7-ны өдрөөс эхлэн тооцогдож буй хүүний 75%-р хязгаарлагдана. Ийнхүү хязгаарлах үүднээс хүүг өдөр бүрээр өсөх хэлбэрээр үзнэ. Энэ зээлийг авсан өдөр нь хамааралгүй.

Үүнийг гүйцэтгэн хийх агент нь заавал мэргэжлийн хүн байх албагүй. Тухайлбал, гэр бүлийн аль нэгэн гишүүн эсвэл өөр бусад хэн нэгэнд жил тутмын татварын мэдүүлгийг хийх ба ямарваа татварын тооцоог хийх үүрэг хариуцлагыг даатгаж болно¹²⁷.

¹²⁶Part 7.1.32 (PDF 54 KB) of the Income Tax, Capital Gains Tax and Corporation Tax Manual.

¹²⁷(Part 45.1.4 (PDF, 40 KB) of the Income Tax, Capital Gains Tax and Corporation Tax Manual)

Гадаад улс дахь түрээсийн татварын тухай: Ерөнхийдөө, улсын гадна байрлах хөрөнгийн түрээсийн орлогод үнийг улсын дотор хүлээж авч байна уу, гадаадад авч байна уу гэдгээс үл хамааран бүтэн татвар ногдуулна. Ийм татварыг Case III of Schedule–р журамлан ногдуулна.

Тухайн хүн нь тус улсад оршин суугч биш байх тохиолдолд эсвэл 2009 болон түүнээс өмнөх онуудад, тус улсын оршин суугч биш боловч Ирланд хүн байх тохиолдолд татвар ногдуулах түрээсийн орлогыг нь тооцоолохдоо тус улсад хүлээн авсан нийт бүх дүнгээс зардлыг нь хасахгүй ба ямар нэг хөнгөлөлтгүйгээр бүтнээр авч тооцно.

Үүнтэй адил хасалтыг *түрээсийн орлогод ногдуулах татварыг* тооцохдоо тэрхүү түрээсийн орлогыг улсын дотор авсан мэтээр бодсоноор хийж болно. Улсын нутаг дэвсгэрийн гадна байрлах хөрөнгийг худалдан авах, сайжруулах, засварлах зорилгоор авсан зээлийн хүүг хасаж тооцох нь хэрвээ энэ нь зөвхөн тус улсын дотор үүссэн бол боломжтой юм.

Улсын нутаг дэвсгэрээс гадна байршилтай хөрөнгийг түрээслэх явцад гарсан алдагдалыг тус улсын дотоод дахь хөрөнгийг түрээслэсний түрээсийн орлоготой (аль эсвэл эсрэгээр тус улсын дотоодод алдсаныг гадаад дахьтай) тэнцэтгэн бодож болохгүй. Тэр мэт алдагдалыг гагцхүү ирээдүйн тус улсын гадаад дахь хөрөнгийн түрээсийн орлоготойгоо л тэнцэтгэн бодож болно.

Тус улсаас өөр улс дахь хөрөнгийг түрээслэсэн орлого нь түрээслэгчийн жил тутмын татварын мэдүүлгийн гадаад орлогын хүснэгтэнд бөглөгдөх ёстой.

Хувийн түрээсийн байранд ногдуулах түрээсийн хөнгөлөлт: (*Rent Relief for Private Rented Accommodation*)

Энэ хөнгөлөлт нь ямар нэг хувийн түрээсийн орон сууцыг үндсэн гэр орноо болгон түрээслэдэг түрээслэгчийн түрээсийн төлбөрт хамаарна. Түрээслэгч энэхүү хөнгөлөлтийг хүссэн хүсэлтээ *Form Rent 1-Claim for Rent Relief on Private Rented Accommodation* маягтыг бөглөн мэдүүлнэ. 2011 оны Санхүүгийн хуулийн 14-р хэсэгт: 2010 оны 12-р сарын 7 болон түүнээс өмнө болзол хангасан түрээсийн байрыг түрээслэгчийн болзолыг бүрэн ханган түрээслэж байсан хүмүүст энэ хөнгөлөлтийг 7 жилийн хугацаанд үзүүлэх үе шатуудыг заасан байдаг. Хөнгөлөлт олгосон түрээсийн нийт дүнг аажим бууруулах зарчмаар явсаар 2018 он буюу удаах онуудад хамгийн их хөнгөлөлтийг үзүүлэхээр тогтоосон байдаг.

Харин 2010 оны 12-р сарын 8 ба түүнээс хойш түрээсээ эхлүүлсэн түрээслэгчдийн хувьд энэ хөнгөлөлтөнд хамрагдах боломжгүй. Хууль ёсны дагуу бол тус улсад оршин суугч түрээслүүлэгч нь түрээслэгчийн хүссэн үед түрээсийг шууд түүнд төлсөн болохыг гэрчлэх баримтыг өгөх ёстой. Хуульд зааснаар бол түрээслэгч нь тус улсад оршин суудаггүй бол түүнд шууд төлсөн буюу түүний банкны дансанд шилжүүлсэн эсвэл гадаадад оршин суудаг агентад нь төлсөн бол тухайн түрээслэгч нь нийт төлбөл зохих түрээсийн дүнгээс орлогын татварын стандарт тогтоосон хувийг (2011: 20%) хасах ёстой байдаг байна.

Энэ хөнгөлөлтийг басхүү гадаад улсад байршилтай байрны түрээсийг төлөхөд хэрэглэдэг.

Арилжааны /Худалдааны/ түрээсийн тухай:

Худалдаа буюу арилжааны түрээс нь байшин барилга эсвэл эд хөрөнгөөс нилээд өөр зохицуулалт дээр үндэслэж байдаг. Түрээслүүлэгчийн хувьд, худалдааны түрээс бол цэвэр хөрөнгө оруулалтын хэлбэрээр эзэмшсэн эд хөрөнгөөс эргэн орж ирж буй орлогыг хүртэх арга зам эсвэл эд хөрөнгөөс зарим түүнд шаардагдах хэмжээнээс илүү орлого,

тухайлбал, капитал эсвэл орлого олох арга зам мөн. Түрээслэгчийн хувьд худалдааны түрээс гэдэг бол капитал бий болгохыг оролдолгүйгээр бизнесийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгө түрээслэж байгаа явдал юм.

Худалдааны түрээс нь ихэвчлэн:

- ажлын байрны,
- худалдааны эсвэл
- аж үйлдвэрлэлийн гэх зэрэг өөр өөр төрөл хэлбэрийн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой байдаг.

Тэдгээр нь нэг эсвэл олон түрээстэй холбоотой байж болно. Мөн богино хугацааны буюу 5 жилийн доторх хугацааны түрээс ба урт хугацааны түрээс хоёрын хооронд ялгаа бий. Богино хугацааны түрээст үндсэндээ түрээсийг эргэн харах нөхцөл заадаггүй ба засвар үйлчилгээний тухайд барилгын зөвхөн дотоод засалтай холбогдуулан заана. Урт хугацааны түрээст бол түрээсийг эргэн харах ба (заримдаа) “цуцлах” нөхцөлүүдийг заасан байх бөгөөд түрээслэгч нь барилгын бүтцийг оролцуулан дотоод ба гадаад засвар үйлчилгээг хийх үүрэгтэй байна.

FRI - Түрээс:

Түүхийн үүднээс үзэхэд, худалдааны түрээс нь харьцангуй энгийн бичиг баримт байсан бол одоо цагт нээлттэй зах зээлийн түрээсийн нөхцлөөр, таван жил тутамд сунгах үедээ л зөвхөн ханшийг нь нэмж болохуйцаар 20 жилийн хугацааны нөхцөлтэй хийдэг FRI буюу Бүрэн засварлаж, хариуцдаг түрээс гэж нэрлэгддэг өргөн цар хүрээтэй (бүгдийн багтаан тусгасан) хэлбэртэй болж хөгжсөн байна.

Үүнээс гадна түрээс нь оролцогч талууд стандарт түрээсийн нөхцөлийг харилцан адилгүй өөр болгож буй нарийн дэлгэрэнгүй тусгай зөвшөөрлийн бичиг хэрэглэх болсон нь түрээсийг улам бүр нарийн болгож байна. Энэ нь Түрээслүүлэгч буюу “Худалдааны төвийн” эзэн, хэн нэгэн гол дэлгүүрийг түрээслэгчид бусдаас илүү таатай нөхцөлийг зөвшөөрсөнөөс үүсч болно. Хэдийгээр ийм тусгай зөвшөөрөл бичгийн утга агуулга нь тухайн түрээслэгчийн хувийн хэрэг боловч түрээслүүлэгч болон түүний залгамжлагчдын хооронд хийгддэг байна.

Бүхэл барилгыг нэгэн хүнд түрээслүүлэхэд, түрээслэгч нь тухайн барилгын бүх урсгал засварыг хийх үүрэгтэй байна. Барилгын аль нэг хэсгийг түрээслэхэд түрээслүүлэгч хууль ёсоор барилгын үндсэн бүтэц ба нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээ зэргийг хариуцах ба, гарах өртөгийг нь түрээслэгч дээр үйлчилгээний төлбөр болгон тооцож авна. Аль ч тохиолдолд түрээслүүлэгч өөрийн хөрөнгө оруулалтыг хамгаалах үүднээс барилгын баталгаат байдлыг хянах ёстой ба, түрээслэгч нар нь энэ өртөгийг түрээсийн төлбөрөөрөө нөхөн гаргаж өгөх үүрэгтэй байдаг байна.

Талууд зөвхөн түр зуурын түрээсийн гэрээ байгуулахыг зорих тохиолдлууд бий. Бүх тохиолдолд, түрээслүүлэгчид нь **1980 оны Түрээслүүлэгч ба Түрээслэгчийн Хууль** (1994 онд нэмэлт өөрчлөлт орсон), 2008 оны Иргэний хуульд зааснаар 5 жил тутамд /онцгой тохиолдол биш бол/ шинэ түрээсийн гэрээ хийх ёстой нөхцөлүүдийг хэрэгжүүлэх ёстой байдаг байна. Тэгэхээр түрээсийн гэрээ 4 жил 9 сараас хэтрэхгүй байх ёстой (*түрээсийг улиралаар төлөх боломжтой*) ба, эсвэл 4 жил 11 сараас хэтрэхгүй (*түрээсийг сараар төлөх боломжтой*) байх ёстой ба, хэрвээ түрээслэгч хугацаа хэтрүүлэн эзэмшвэл түрээслүүлэгчийн хувьд хугацаа хэтэрснээс хойших ямарваа түрээсийн төлбөрийг хүлээн авахгүй байх нь чухал юм. Үгүй бөгөөс түрээслэгч түрээсээ үргэлжлүүлэхээс өөр аргагүй болдог. 1980 оны Түрээслүүлэгч ба Түрээслэгчийн тухай хуулийн 17 (1) (а) (өөрчлөлт) нь 1994 оны Газрын Эзэн Ба Түрээслэгчийн Хуулийн 4-р өөрчлөгдсөн нь цаашдаа ч

өөрчлөгдөх болно гэдгийг анхаарна уу. Одоо бүх бизнесийн түрээслэгчдийн хувьд 1980 оны хуулийн нөхцөлүүдийг 2008 оны Иргэний Хуулийн 47-ын (олон өөр өөр нөхцөлүүд) дагуу гэрээ байгуулах эрхтэй байна.

2.5. Кени улсын түрээсийн татварын хуулийн зохицуулалт

Хууль: Кени улсын хуулийн 470-р бүлэг Орлогын татварын тухай хуулийн 3(2) (a) (iii) хэсэгт дурдсан зүйлсэд түрээсийн татвар ногдуулна. Дээр нь орон сууцны бус барилгад /худалдааны/ мөн 476 бүлгийн 5,6 дугаар хэсэг дэх НӨАТ-ын хуулийн дагуу татвар тооцно.

Юунд татвар ногдуулах вэ: Бүх түрээс, урамшуулал эсвэл өмч хөрөнгийг эзэмших эсвэл ашиглах бусад бүх нөхцөл.

Татварын хэмжээ: Татварын хэмжээ нь татвар ногдуулж буй хүн нь хувь хүн эсвэл компани хуулийн этгээд эсэх мөн оршин суугаа болон түр оршин суугаа эсэхээс хамаардаг.

1. Тухайн улсад оршин суугаа хувь хүмүүст тооцох жил тутмын татварын хэмжээг дараах байдлаар тооцдог (цэвэр түрээсийн орлогыг багтаасан нийт жилийн орлого);

Анхны 121,968 Кени шиллинг	10%
Дараагийн 114,912 Кени шиллинг	15%
Дараагийн 114,912 Кени шиллинг	20%
Дараагийн 114,912 Кени шиллинг	25%
466,704 Кени шиллингээс дээш нийт орлогод	30%

Анхааруулга: Дээрх төлбөрийг “шаталсан” гэж үзнэ.

2. Улсын харъяа компанид жилийн цэвэр орлого мөн бусад орлого хэрэв байвал нийтэд нь 30%-тай тэнцүү/нэг шатлалт татвар ногдуулж тооцно.

3. Түр оршин суугаа хүмүүст (татварын зорилгоор) нийт түрээсээс 30 хувийн суутгал татвар авах ба энэ нь сүүлийн татвар бөгөөд тэдэнд зардал мэдүүлэхийг зөвшөөрдөггүй.

4. Нөхөрлөлд зөвхөн ганц түрээсийн нэхэмжлэл байх боловч талууд өөр өөрсдийн түрээсийн орлогодоо татвараа төлнө.

5. Нас барсан эзний өмч

Нас барсан эзний өмчийн хуримтлагдсан цэвэр түрээсийн орлогод /түрээсийн төлбөрийн дагуу/ ААН/аж ахуй нэгж/-ийн ашгийн 30%-ийн татвар ногдуулдаг.

6. Орон сууц бус байрны түрээсийн НӨАТ (арилжааны түрээс)

Энэ нь НӨАТ-ийн хуулийн 3 дахь жагсаалтаар татвараас чөлөөлөгдөхгүй ба 16 %-иар татвар ногдуулна.

Хуулийг мөрдөхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

Татвар төлөх, буцаалт мэдүүлэх зэргээр Кенийн орлогын алба захиргаатай холбоотой үйл ажиллагаанд шилжүүлэг хийхийн тулд хэрвээ таньд байхгүй бол хувийн нууц дугаартай болох хэрэгтэй. Онлайнгаар уг дугаарыг олгодог. Бүртгүүлэхийн тулд www.kra.go.ke

Тайлангийн хугацааны 4 дэх сарын 20-нд 6 дахь сарын 20-нд 9 дэх сарын 20-нд 12 дахь сарын 20-нд гэсэн 4 удаа татвар төлдөг. Тайлангийн хугацаа дууссаны дараах 4 дэх сарын 30-н гэхэд татварын бүх баланс/үлдэгдлийг төлөх ёстой.

Түрээсийн бүх өмч хөрөнгөнд дараах зүйлсийг тусгасан бүртгэл байх хэрэгтэй.

- a) газар эзэмшигчийн дугаар
- b) баригдсан он
- c) анхны эзэмшлийн гэрчилгээ
- d) барьсан өртөг
- e) барилгын төлөвлөгөө
- f) зээлийн гэрээ
- g) түрээслэх боломжтой нэгжийн тоо болон нэгж бүрийн түрээс
- h) хүлээн авсан түрээс, түрээсийн баримт тайлан
- i) холбогдох зардал (падаан болон зардал тооцох мөнгөний баримтууд)
- j) түрээс/эзэмших гэрээ
- k) түрээсийн орлогын банкны данс

Түрээсийн орлогын ашгийн татвар:

- Түрээсийн төлбөрийн баримт бэлдэх; өмч хөрөнгийн тоо, өмч бүрт авсан түрээс, хүлээн авсан нийт түрээс, өмч бүр дээр гарсан бүх зардал
- Төлбөл зохих түрээсийг гаргахын тулд зөвхөн зөвшөөрөгдсөн, дэмжигдсэн зардлыг хасна. Татвар тооцох жишээнүүдийг дор харуулсан.
- Татвар ногдуулах ёстой түрээсийн ашгийг мэдүүлж түүнд түрээсийн төлбөрийн баримтыг хавсаргаснаар татварын мэдүүлэг бүрдэнэ. Хэрэв та онлайнаар татварын мэдүүлгээ өгөхийг хүсвэл онлайн татварын мэдүүлгийн загвар дээр түрээсийн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.
- Тайлангийн хугацаа дуусаад 6 сарын дотор өөрийн тооцоолон гаргасан мэдүүлгээ өгнө.

Арилжааны түрээсийн НӨАТ:

Түрээслэгчдэд тогтоосон НӨАТ-ыг үзүүлсэн НӨАТ-ын тайланг (зарлагын НӨАТ) тухайн сард хийсэн худалдан авалтанд зөвшөөрөгдсөн НӨАТ (орлогын НӨАТ) бэлдэнэ. Дараа сарын 20-нд нь төлбөрийг мэдүүлж НӨАТ-ын буцаалтыг гүйцээнэ.

Тайлбар: Түрээслэгчдэд ирсэн баримт/падаан нь төлсөн НӨАТ-ын харуулж электрон татварын бүртгэлд бүртгэгдэх хэрэгтэй.

Онлайнаар татварын мэдүүлэг өгөхөд дараах зүйлсийг анхаарна: Онлайнаар мэдүүлэхийн тулд татвар төлөгч нь бүртгэлтэй байх хэрэгтэй.

Түрээсийн төлбөрийн жишээнүүд:

ЖИШЭЭ 1: Оршин суугаа хувь хүмүүс

- A.** Ноён Газрын эзэн түрээс авдаг дараах 2 өмч хөрөнгөтэй:
 - А өмч 5 нэгжтэй нэг нэгжийг сарын 20000 шиллингээр түрээсэлдэг.
 - В өмч 10 нэгжтэй нэгийг нь сарын 15000 шиллингээр түрээсэлдэг.
- B.** 2010 оны тайлангийн хугацааны турш бүх өрөөг хүн түрээсэлж байсан.
- C.** Тайлангийн хугацаанд тэрээр дараах зардлуудыг гаргасан;
 - 1) газрын татвар - Kshs. 10,000
 - 2) өмч хөрөнгийн даатгал - Kshs. 20,000
 - 3) агентийн/зуучлагчийн хөлс - Kshs. 30,000
 - 4) засвар - Kshs. 160,000

- 5) сургуулийн төлбөр - Kshs. 120,000*
- 6) зээлийн хүү - Kshs. 85,000
- 7) цахилгаан - Kshs. 60,000
- 8) тухайн жилд түүний үндсэн зээлийн буцаан төлөлт - Kshs. 250,000**

D. Түүний тайлангийн хугацаа 2010 оны 12 сарын 31-нд дуусна.

E. Татвар ногдуулах түрээсийг тооцохдоо:

Тухайн жилийн нийт түрээсийн орлого:

A өмч - 5 өрөө x Kshs. 20,000 x 12 сар 1,200,000

B өмч - 10 өрөө x Kshs. 15,000 x 12 сар 1,800,000

Нийт түрээсийн орлого - Kshs 3,000,000

Бага: зөвшөөрөх зардал - (Kshs.):

газрын түрээс 10,000

даатгал 20,000

зуучлагчийн хөлс 30,000

засвар 160,000

зээлийн хүү 85,000

цахилгаан 60,000 365,000

Татвар ногдуулах түрээсийн цэвэр орлого (Kshs.) 2,635,000

Тайлбар:

* Сургуулийн төлбөр бол хувийн зарлага учир хасалт хийхийг зөвшөөрөхгүй.

** Үндсэн зээлийн эргэн төлөлт бол үндсэн хөрөнгө ба хасахыг зөвшөөрөхгүй.

F. Тухайн жилийн ноён газрын эзний татварын тооцоо (түүнд өөр ямар ч орлого байхгүй гэж үзвэл/байхгүй тохиолдолд):

Тухайн жилд гарсан татвар ногдуулах жилийн цэвэр түрээсийн орлого - **Kshs. 2,635,000**

Эхний Kshs. 121,968 - 10% 12,197

Дараагийн Kshs. 114,912 - 15% 17,237

Дараагийн Kshs. 114,912 - 20% 22,982

Дараагийн Kshs. 114,912 - 25% 28,728

The balance Kshs. 2,168,296 - 30% 650,488

Нийт төлөх ёстой татвар 731,632

Бага: Хувь хүний татварын хөнгөлөлт 13,944

Төлөх ёстой цэвэр татвар **717,688**

G. Хэрэв газрын эзэн тухайн жилд нэг удаадаа 150,000 шиллингийн тэнцүү татварыг 4 удаа буюу нийт 600,000 шиллинг татвар төлсөн бол 2011 оны 4 сарын 30 гэхэд 117,688 шиллинг төлөх үлдэгдэлтэй байх байсан. Харин тэрээр огт татвар төлөөгүй бол бүх 717,688 шиллингийн татварыг 2011 оны 4 сарын 30-аас өмнө төлөх ёстойн дээр торгууль, хуулийн дагуу заасан хугацаанд төлөөгүйн улмаас гарсан хүүг мөн нэмж төлнө.

ЖИШЭЭ 2: Оршин суугаа ХХК /татбар төлөгч нь ХХК тохиолдол/

Дээрх тохиолдолд газрын эзэн оршин суугаа ХХК буюу Ноён Газрын эзэн ХХК байсан бол дээр тооцсон цэвэр түрээст ААН-ийн 30 хувийн татвар ногдуулж бусад нь хэвээр үлдэх байсан ба гагцхүү татварын чөлөөлөлт байхгүй болно.

Тиймээс татварын тооцоо дараах байдалтай болно:

Татвар ногдуулах цэвэр түрээс (Kshs.)	2,635,000
ААН-ийн татвар – 30%	790,500
Less: хугацаанд нь төлсөн татвар	600,000
30/4/11-ээс өмнө төлөх ёстой үлдэгдэл	190,500

ЖИШЭЭ 3: Түр оршин суугаа иргэд хувь хүн /татвар төлөгч нь түр оршин суугч бол/

Түр оршин суугаа хүний нийт түрээсийн орлогоос 30%-ийн суутгал татвар авах ба энэ нь эцсийн татвар байна. Тиймээс татварын тооцоо дараах байдалтай болно:

Нийт түрээсийн орлого (Kshs.)	3,000,000
Суутгал татвар – 30%	900,000
(Энэ нь сүүлийн татвар гэдгийг анхаарна уу)	

Гадаадад буй Кени иргэд: Кени улсаас гадна байгаа ч улс дотроо өмч эзэмшиж байгаа Кени иргэн олсон түрээсэндээ татвар төлөх ёстой. Түр оршин суугаа (470 бүлгийн орлогын татварын хуулийн 2 дугаар хэсэгт заасанчлан) бол нийт дүнгээс 30%-ийн татварын суутгал хийж энэ нь эцсийн татвар болно. Гэхдээ хэрвээ цэвэр түрээсийн орлого дээр шаталсан татвар бол оршин суугч иргэн төлнө. (Жишээ 1-ийг харна уу).

Нэмэлт тодруулга: Түрээсийн орлогын болон үл хөдлөх хөрөнгийн татварын талаар илүү дэлгэрэнгүйг www.kra.go.ke хуудаснаас аварай.

2.6. Канад улсын орон сууцны түрээсийн тухай хуулийн зохицуулалт

Хуулийн зохицуулалт: Канадын Манитоба мужийн Орон сууцны түрээсийн татварын тухай хууль¹²⁸ нь түрээслүүлэгч, түрээслэгчийн эрх, үүргийн харилцааг зохицуулсан байна.

Орон сууцны түрээсийн татварын тухай хуулийн 1(1)-р зүйлд зааснаар “түрээсийн байр” гэдэгт түрээслүүлэгчийн талаас бэлтгэсэн тавилгатай, цахилгаан зуух, хөргөгч, угаалгын машин, эсхүл хатаагч зэрэг ахуйн техниктэй байрыг ойлгоно хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл бүрэн тавилгатай байрыг хэлдэг байна. Дараах төрлийн орон байр түрээсийн байр гэсэн ойлголтод хамаарахгүй.¹²⁹ Үүнд:

- зочид буудал, дэн буудал, жуулчдын байр, нийтийн дотуур байр,
- улиралын чанартай, эсхүл түр зуурын орон байр,
- орон сууцны барилгын барилгачдын түр оршин суух байр,
- нөхөн сэргээх болон бусад эмчилгээний тусламж авах зорилгоор түр байрлаж байгаа эмчлүүлэгчийн байрлаж байгаа байр,
- орон байр түр хугацаанд шаардлагатай байгаа этгээдийн байрлаж байгаа байр,
- боловсролын байгууллагын сурагч нарт зориулсан дотуур байр,
- шашны байгууллагын ажиллагсдад зориулсан орон байр,
- өвчний сүүлийн шатандаа байгаа өвчтөнийг асрах зорилгоор эмнэлгийн, эсхүл асрамжийн газрын харьяа орон байр.

Түрээсийн гэрээг амаар, бичгээр болон болзолт /implied/ байдлаар байгуулж болно. Гэрээнд түрээслэх хугацааг заах, эсхүл түрээсийн хугацаанд үйлчилгээ үзүүлэх бол гэрээг бичгээр үйлдэнэ. Хэрэв түрээслүүлэгч нь түрээсийн гэрээнд үйлчилгээ үзүүлэх талаар тусгасан бөгөөд түүнээсээ татгалзахаар болвол гэрээнд гарын үсэг зурсанаас хойш 48 цагийн дотор /бямба, ням болон баярын өдрүүд хамаарахгүй/ гэрээг цуцлаж болно. Түрээслүүлэгч нь гэрээг цуцлахаар болсоныг бичгээр, эсхүл факсаар мэдэгдэх ба үүний дараа гэрээг хүчингүйд тооцно. /Хуулийн 7(1)-р зүйл/

¹²⁸The Residential Tenancies Act. Assented to December 14, 1990. This version is current as of May 1, 2013. Эх сурвалж: <http://web2.gov.mb.ca/laws/statutes/ccsm/r119e.php>.

¹²⁹Мөн хуулийн 3(1)-р зүйл.

Орон сууцны түрээсийн татварын тухай хуулийн 25-р зүйлд зааснаар: Түрээслүүлэгч нь түрээсийн байрны төлбөрийг нэмэгдүүлэх, эсхүл хямдруулах гэж байгаа бол түрээслэгчид хуульд заасан журмын дагуу бичгээр 3 сарын дотор мэдэгдэх үүрэгтэй. Түрээсийн байранд шинэ гэрээгээр орж байгаа түрээслэгчийн эхний 3 сард байрны төлбөрийг түрээслүүлэгч нь нэмэгдүүлэхгүй.

Орон сууцны түрээсийн татварын тухай хуулийн 140.3 (2)-р зүйлд түрээсийн үйлчилгээний төлбөрийн талаарх зохицуулалтад энэ төрлийн төлбөрийн хэмжээнд хязгаар тогтоохгүй гэсэн байна. Өөрөөр хэлбэл, түрээслүүлэгч нь өөрөө түрээсийн үйлчилгээний төлбөрийг тогтоох аж.

Түрээслүүлэгч нь түрээслэгчээс дараах төрлийн барьцаа төлбөрийг авна.¹³⁰ /барьцаа төлбөр /a security deposit/:

1. гэрийн тэжээмэл амьтан тэжээсний барьцаа төлбөр /a pet damage deposit/,
2. түрээслэгчийн аюулгүй байдлын барьцаа төлбөр /a tenant services security deposit/.

Барьцаа төлбөрүүдийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. *Барьцаа төлбөр* - түрээслүүлэгчийн түрээслэгчид үзүүлэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр. Түрээслүүлэгч нь түрээслэгчид энэ төрлийн барьцаа төлбөр авах тухайгаа түрээсийн гэрээ байгуулахаас өмнө түрээслэгчид мэдэгдэх үүрэгтэй.
2. *Гэрийн тэжээмэл амьтан тэжээсний барьцаа төлбөр* - түрээслэгчийн түрээсийн байрандаа тэжээж байгаа гэрийн тэжээмэл амьтантай холбоотой түрээслүүлэгчийн гүйцэтгэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр. Түрээслэгч нь түрээсийн байрандаа гэрийн тэжээмэл амьтан байлгах бол түрээслүүлэгч түүнээс гэрийн тэжээмэл амьтны барьцаа төлбөрийг шаардах эрхтэй. Хэрэв тухайн амьтан нь хууль тогтоомжид заасан хөтөч нохой, туслагч амьтан бол энэхүү барьцаа төлбөрийг авахгүй.
3. *Түрээслэгчийн аюулгүй байдлын барьцаа төлбөр* - түрээслэгчийн аюулгүй байдал, түүнийг ханган биелүүлэхтэй холбогдсон түрээслүүлэгчийн гүйцэтгэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр.

Дээрх барьцаа төлбөрүүд нь түрээсийн гэрээнд заасан түрээсийн эхний сарын төлбөрийн 1/2-ээс хэтрэхгүй байна. Хэрэв түрээсийн байранд түрээслэгчтэй өөр нэгэн этгээд хамт амьдрах бол түрээслүүлэгч нь барьцаа төлбөрийг нэмж төлөхийг шаардах эрхтэй.

Түрээслүүлэгч нь дараах тохиолдолд түрээсийн байрны нөхцөл байдалтай танилцана.¹³¹ Үүнд:

- түрээсийн гэрээний хугацаа эхлэхээс өмнө,
- давхар түрээст шилжүүлэх үед,
- гэрийн тэжээмэл амьтан түрээсийн байранд байлгах зөвшөөрөл авсан түрээслэгчийн гэрээ эхлэх үед тус тус танилцана.

Дээрх түрээсийн гэрээний хугацаа даасах үед түрээсийн байрны нөхцөл байдалтай танилцана.

Түрээслүүлэгч нь түрээсийн байрыг найдвартай байлгахын тулд хаалга, цоож болон бусад хэрэгслэлээр хангах үүрэгтэй бөгөөд хоёр тал харилцан тохиролцохгүйгээр хаалга, цоож болон бусад хэрэгслэлийг дур мэдэн солихгүй. Түрээслүүлэгч нь онц

¹³⁰Мөн хуулийн 29-р зүйл.

¹³¹Мөн хуулийн 39-р зүйл.

ноцтой нөхцөл байдал үүссэн, түрээслэгч өөрөө зөвшөөрсөн зэргээс бусад тохиолдолд түрээслэгчийн байранд нэвтрэх эрхгүй. Мөн түрээслүүлэгч нь гэрээтэй холбоотой албан ёсны мэдэгдэлийг түрээслэгчийн түрээсийн байранд оруулж өгч болох ба ингэхдээ энэ талаараа түрээслэгчид 24 цагийн өмнө мэдэгдэх үүрэгтэйг Орон сууцны түрээсийн татварын тухай хуулийн 53-р зүйлээр тогтоосон байна.

Талууд хуулиар тогтоосон журмын дагуу бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр түрээсийн гэрээг цуцлагдсанд тооцно. Үүнээс гадна түрээслэгч түрээсийн төлбөр төлөхөөс татгалзсан үед түрээсийн гэрээ дуусгавар болно.¹³²

Хэрэв түрээсийн гэрээг амаар, эсхүл болзолт хэлбэрээр байгуулахдаа талууд хугацааг заасан бөгөөд уг хугацаа дуусгавар болсон, түрээслэгч үргэлжлүүлэн суухгүй бол энэ тухайгаа түрээслүүлэгчид нэг сарын дотор мэдэгдэх үүрэгтэй. Харин түрээсийн гэрээг амаар, эсхүл болзолт хэлбэрээр байгуулахдаа талууд хугацааг заагаагүй тохиолдолд түрээслэгч нь түрээсийн төлбөр төлөх сүүлийн өдөр түрээслүүлэгчид үргэлжлүүлэн суухгүй тухайгаа мэдэгдэх учиртай. Энэхүү хугацаанаас хоцорсон тохиолдолд түрээсийн төлбөрийг үргэлжлүүлэн төлөхийг хуулийн 87-р зүйлд заасан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Иргэний хууль. 2002 он
2. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль. 2006 он
3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль. 2006 он

БНСУ:

4. <http://www.kpmg.com/Global/en/IssuesAndInsights/ArticlesPublications/taxation-international-executives/korea/pages/income-tax.aspx>
5. <http://www.lexology.com/library/detail.aspx?g=37d137f2-b837-4e9e-a49e-8717e7ee257c>
6. <http://www.itrworldtax.com/Guide/537/South-Korea.html>
7. <http://www.itrworldtax.com/Guide/537/South-Korea.html>

Ирланд:

8. <http://www.globalpropertyguide.com/-Rental Income Tax - Ireland Compared to Continent>
9. <http://www.taxworld.ie/taxes/it/current/summary-ireland- Income Tax Summary Ireland 2013>
10. <http://www.ird.govt.nz/forms-guides/number/forms-200-299/ir264-guide-rental-income.html-Rental income IR264>
11. http://www.mcginibney.com/tax_on_rental_income.htm#To- Tax on Rental Income - A Guide
12. <http://www.revenue.ie/en/tax/it/leaflets/it70.html- A Revenue Guide to Rental Income - IT 70>
13. <http://www.revenue.ie/en/tax/it/rental-income.html- Rental Income>
14. [http://www.irishstatutebook.ie/1980/en/act/pub/0010/print.htm- landlord and Tenant \(amendment\) act, 1980](http://www.irishstatutebook.ie/1980/en/act/pub/0010/print.htm- landlord and Tenant (amendment) act, 1980)
15. <http://irishtaxback.ie/rental-income-expenditure-news/- Rental Income>

АНУ:

16. <http://codes.lp.findlaw.com/nycode/ADC/11>
17. NYCode, Title-7, Commercial rent and rental tax
18. http://realestate.about.com/od/commercialrealestat1/tp/lease_types.htm

Кени:

19. www.kra.go.ke
20. Орлогын татварын тухай хууль
21. НӨАТ-ийн хууль

Канад:

22. The Residential Tenancies Act.
23. <http://web2.gov.mb.ca/laws/statutes/ccsm/r119e.php>.

¹³²Мөн хуулийн 81, 82-р зүйл.

3

БҮЛЭГ

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ - БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ
ЗАРЧИМ, ХУВААРИЛАЛТЫН БҮТЭЦ**
(Бодлогын судалгаа)

Д-р Г. Алтан-Оч

АГУУЛГА

1. Ерөнхий ойлголт
2. Эрдсийн гэрээний төрлүүд
3. Бүтээгдэхүүн хуваах гэрээний ерөнхий агуулга
4. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үзүүлэлтүүд
5. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд хийсэн зарим дүн шинжилгээ
6. Бусад салбарт хэрэглэсэн олон улсын туршлага

Дүгнэлт

Нэг. Ерөнхий ойлголт

Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) нь газрын тосны хайгуул, олборлолтын явцад хамгийн түгээмэл хэрэглэгддэг гэрээний хэлбэр юм. БХГ-ний талууд нь нэг талаас ашигт малтмалын өмчлөгч болох төр, нөгөө талаас хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаанд техникийн болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх гадаадын нефтийн компани (ГНК) байдаг. Төрийг ихэвчлэн засгийн газар юмуу эсвэл үндэсний нефтийн компани (ҮНК) гэх мэт түүний аль нэг агентлаг төлөөлдөг. ГНК нь эрсдэл хүлээж, үйлчилгээ үзүүлсэнийхээ шанд гаргасан нефтийн бүтээгдэхүүний тодорхой ногдол хувийг эзэмших эрх эдэлдэг. Тэгэхдээ төр нь нефтийн бүтээгдэхүүний өмчлөгч хэвээр үлддэг. Төр буюу түүний төлөөлөл болсон ҮНК нь хайгуул болон олборлолтын шатанд төрөл бүрээр оролцох өргөн боломжтой байдаг. Түүнээс гадна БХГ байгуулахад ихэвчлэн хоёр талын төлөөлөл багтсан хамтын удирдах байгууллага байгуулдаг ба тэр нь үйл ажиллагааг хянаж, мониторинг хийж ажилладаг.

БХГ-г анх 1966 онд Индонезид хэрэглэж эхэлсэн түүхтэй. Үндэсний тусгаар тогтнолын үзэл санаа улам дээшлэхийн хэрээр гадаадын компани, түүний концессыг улам ихээр шүүмжлэх болсон. Үүний улмаас засгийн газар шинээр концесс өгөхөө больсон байдаг. Үр дүн нь хэн хэндээ ашиггүй гацаа үүссэн учир хуулиа өөрчлөхөөс аргагүй байдалд хүрсэн. БХГ ингэж Индонезээс эхлээд баруун европоос бусад бүх нефть боловсруулдаг улсуудад түгэн дэлгэрсэн байдаг. Баруун европоос зөвхөн Мальт улс л ашигладаг.

БХГ нь бусад гэрээнүүдээс хоёр зүйлээр ялгагддаг. 1-рт, ГНК нь хайгуулын бүхий л эрсдлийг үүрдэг. Хэрэв нефть олдохгүй бол тэр ямар ч нөхөн төлбөр авахгүй. 2-рт, төр нь эрдэс баялаг, уурхайн байгууламж аль алийг нь өмчилдөг. Суурь шинжийн БХГ байгуулсан үед 4 янзын үндсэн орлогоос ашиг олдог. Үүнд: 1. ГНК нь төрд олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын татвар (роялти) төлнө. 2. Ашигт малтмалын татварыг хассаны дараа нийт бүтээгдэхүүний тохирсон хувийг (жишээ нь, 40%) ГНК зардлаа нөхөх зориулалтаар захиран зарцуулах эрхтэй. 3. Ингээд үлдсэн бүтээгдэхүүнийг “ашигт газрын тос” гэх ба төр, ГНК хоёр тохирсон ёсоор (жишээ нь төр-65%, ГНК-35%) хувааж авдаг. 4. ГНК нь өөрт ногдох ашигт газрын тосондоо орлогын албан татвар төлнө. Өнгөрсөн хугацаанд БХГ маш их өөрчлөгдсөн бөгөөд өнөөдөр олон янзын хэлбэртэй болсон.

1966-аас 1998 оны хооронд л гэхэд дэлхийн 74 улсад нийт 268 БХГ байгуулсан байна. Эдгээр гэрээнүүдийг бүсчилсэн байдлаар хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 1. Бүсүүд

Бүс	Гэрээний тоо	Хамгийн олон гэрээ
Ази ба Австрали	80	Индонези (37)
Төв америк ба Кариб	21	Гватемал (7)
Зүүн европ	28	Азербайжан (7)
Европ	2	Мальт (2)
Ойрхи дорнод	41	Йемен (17)
Хойд африк	15	Египет (6)/Ливи (6)
Өмнөд ба Төв африк	69	Нигер (10)
Латин америк	14	Перу (4)

Хоёр. Эрдсийн гэрээний төрлүүд

Эрдсийн салбарт гэрээ байгуулах хоёр үндсэн арга байдаг: хоёр талын хэлэлцээр, сонгон шалгаруулалт (тендер). Хэлэлцээрийн үед ҮНК нь хайх, олборлох, эрдсийг экспортлох концессыг авахын төлөө тухайн улсын засгийн газарт хандаж хэлэлцээрт ордог. Компанийн зүгээс засгийн газарт тодорхой хэмжээний роялти төлбөр хийснээр гэрээг авдаг уламжлал тогтсон. Ийм гэрээ нь хэтэрхий нэг талыг барьсан, компанид илүү ашигтай байдаг. Учир нь компани эрдэс баялаг болон үйлдвэрлэлийн түвшнийг хянах боломжтой, өргөн эрхтэй байдаг. Энэхүү тэнцүү бус байдал нь засгийн газарт мэдээлэл дутмаг байх, мөн эрэл хайгуул явуулах санхүүжилт олоход бэрхшээлтэй байдлаас үүдэлтэй байдаг.

Ихэвчлэн засгийн газрын оронд ҮНК хэлэлцээрт оролцдог. Энд гурван шалтгаан байдаг. 1-рт, ҮНК-иуд нь засгийн газрыг бодвол баялгийн орд, уг ашигт малтмалд ямар технологи илүү тохиромжтой, гадаадын компанийн ажлын чадамжийн талаар илүү сайн мэдээлэлтэй байдаг. 2-рт, ҮНК нь засгийн газрыг бодвол улс төрөөс арай бага хамааралтай байдаг. 3-рт, ҮНК нь дотооддоо бүхий л эрэл хайгуул, олборлолтын ажлыг зохицуулж байдаг тул эдгээрт дотоодын компаниудыг татан оролцуулж, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх боломжоор хангах чадвартай байдаг.

Сонгон шалгаруулалтаар гэрээ байгуулахын тулд тодорхой стандартыг хангасан байх шаардлагатай. Тендерийн нөхцөл нь хуулийн хүрээнд роялти болон шагналын (бонус) төлбөрт голчлон тулгуурласан байдаг. Ялгавартай тендерийн сонгон шалгаруулалтын үед засгийн газар шийдвэр гаргахдаа тодорхой ялгавар гаргах боломжтой. Үүний нэг хэлбэр нь үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл юм.

Газрын тосны хувьд гэрээний 4 үндсэн төрөл байдаг: концесс, БХГ, үйлчилгээний гэрээ, хамтарсан үйлдвэр. Тодорхой нэг зорилгоор эдгээр төрлүүдийн алийг нь ч хэрэглэж болно. Ялгаа нь гэвэл, гадаадын компанид олгож байгаа хяналтын түвшин ямар байна вэ? нөхөн олговрыг хэрхэн зохицуулах вэ? ҮНК-ийн оролцооны түвшин хэр байна вэ? гэдэгт байдаг.

Ойрхи Дорнодын туршлагаас үзэхэд, сонгодог концессын гэрээ нь 3 зүйлээр тодорхойлогдоно. 1-рт, гадаадын компанид олборлох эрхийг зөвхөн эзлүүд нутагт, заримдаа улсыг бүхлээр нь өгсөн. 2-рт, гэрээг урт хугацаатай байгуулсан. 3-рт, гадаадын компани аль эрдсийг, хэзээ, хэрхэн олборлох талаар бүрэн эрхтэй байсан. Үйлдвэрлэл явуулах үүрэг хүлээгээгүй. Тиймээс газрын тосны үнэ унасан үед гадаадын компани

ямар нэгэн торгууль хүлээхгүйгээр үйлдвэрлэлээ бууруулах боломжтой байсан. Эзэн улс бүтээгдэхүүнд суурилсан төлбөр авахаас өөр дорвитой эрх эдэлдэггүй байсан.

Орчин үеийн концесс, тусгай зөвшөөрлийн гэрээний суурийг Оман (1967), Абу Даби (1974)-гийн концессын гэрээнүүд тавьсан. Тэдгээрт гадаадын компанид эрэл хайгуул, олборлолт, экспортын онцгой эрхүүд байгаа ч гэрээний хугацааг багасгасан, ажиллах үүрэг хүлээсэн, эрхээсээ татгалзах болзол, илүү өндөр роялти болон урамшууллын заалтууд туссан байна. Мөн төр буюу ҮНК хамтарсан үйлдвэрийн бүрэлдэхүүнд багтах нь ердийн зүйл болжээ. Шинэчилсэн концессын гэрээ нь 3 чухал асуултад чиглэсэн. Гадаадын компанид хэр их эрх өгсөн бэ? Орлогыг хэрхэн хувааж байна вэ? Гадаадын компани улсын хэрэгт хэр оролцож байна вэ?

Концесс, БХГ хоёрын үндсэн ялгаа нь эрдсийн өмчлөлд байдаг. Концессын үед бүх түүхий нефть ГНК-ийн бүрэн мэдэлд байдаг бол, БХГ-ний үед эзэн улсын өмчлөлд байх ба ГНК-д оногдох түүхий нефтийн эрхийг түүний эрсдэл үүрч, үйлчилгээ үзүүлсний төлөөх нөхөн олговор буюу шан гэж ойлгож болно. БХГ нь Индонезээс Египет, Ливи, Алжир зэрэг Африк, Ази, Ойрхи Дорнод, Өмнөд болон Төв Америкийн газрын тос олборлогч бусад улсуудад түгэн дэлгэрсэн бөгөөд ялангуяа хуучин ЗХУ болон Каспийн бүс нутагт илүү тархжээ.

Үйлчилгээний гэрээ нь ерөнхийдөө БХГ-тэй төстэй боловч цэвэр үйлчилгээний гэрээ нь бага зэрэг ялгаатай. ГНК нь хайгуул, олборлолтын эрсдэл үүрэгчийн хувиар тохирсон тогтмол хөлс буюу өөр төрлийн нөхөн олговор авдаг. Гэрээний нэр хэлж байгаа шиг ГНК нь үйлчилгээ үзүүлж, туршлага (ноу-хау) нийлүүлдэг. Гэхдээ тэрээр бүтээгдэхүүнд хувь эзэмшдэггүй. Эрсдэл үүрч үйлчилгээ үзүүлдэг учраас сүүлийн үед иймэрхүү төрлийн гэрээг “эрсдэл-үйлчилгээний гэрээ” гэж нэрлэдэг болсон. Ийм гэрээг анх Мексик (1950) хэрэглэсэн боловч 1960-аад оны сүүлээр ихэд дэлгэрч Иран, Иракт олон гэрээ байгуулагджээ. Энэхүү хоёр гэрээний ялгаатай тал нь гэрээлэгч хөлс авдагт, үйл ажиллагаанд хяналт тавьдагт байдаг.

Хамтарсан үйлдвэр байгуулсан нөхцөлд ГНК, төр (эсвэл түүний аль нэг агентлаг) хоёул нефть олборлох үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тохирсон хувиар бүтээгдэхүүнд өмчлөх эрх эдэлнэ. Иймээс төр нь роялти, татвар, ашигт газрын тосноос гадна цэвэр ашгаас хувь хүртдэг. Гэвч энэхүү ашиг нь зардалтай. Учир нь төр олборлолт, үйл ажиллагааны зардлын ногдох хувийг хариуцдаг. Нэмж тэмдэглэхэд, ГНК нь борлуулалт эхэлтэл хайгуулын бүхий л шатанд төрийн хувьцааны оролцоог дааж явдаг. Хамтарсан үйлдвэр нь хувьцаат компанийн болон гэрээт гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Хувьцаат компанийн хувьд талууд тодорхой хувьцаа эзэмшинэ. Гэрээт үйлдвэрийн хувьд талууд үйл ажиллагааны гэрээ байгуулах ба бүтээгдэхүүний тодорхой хувь эзэмшдэг. Анхны хамтарсан үйлдвэрүүд 50:50 хувьцааны харьцаатай байсан бол Ливи (1973) улсын Occidental компанитай байгуулсан гэрээнээс хойш төр (засгийн газар) хамтарсан үйлдвэрийн 51 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмших болсон.

Ингээд одоо мөрдөгдөж байгаа гэрээнүүдийг эрсдэл үүрэх болон эрсдэл үл үүрэх байдлаар нь ангилж хүснэгтээр үзүүлье:

Хүснэгт 2. Үндсэн гэрээний төрлүүдийн эрсдэл ба шан

<i>Гэрээ</i>	<i>Гадаадын гэрээлэгч</i>	<i>Төр (Засгийн газар)</i>
Концесс	Бүх эрсдэл/Бүх шан	Бүтээгдэхүүн ба үнээс шан хүртэнэ
Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Хайгуулын эрсдэл/ Шангийн хувь	Шангийн хувь
Хамтарсан үйлдвэр	Эрсдэл ба шангийн хувь	Эрсдэл ба шангийн хувь
Цэвэр үйлчилгээний гэрээ	Эрсдэлгүй	Бүх эрсдэл

Гурав. Бүтээгдэхүүн хуваах гэрээний ерөнхий агуулга

БХГ-нд хоёр тал оролцдогийн нэг тал нь Засгийн газар (ЗГ). Засгийн газрыг төрийн тэргүүн, аль нэг яам, эсвэл ҮНК төлөөлдөг. ҮНК маш ихээр гэрээ байгуулдаг. Нөгөө талаас ГНК оролцдог. Гадаад гэрээлэгч нь ганц компани байхаасаа илүүтэй хамтарсан үйлдвэр буюу консорциум байх нь маш элбэг. Гэвч гадаад гэрээлэгч хэд ч байсан гэрээний бүтцэд нөлөө үзүүлэхгүй. Тэднийг нэг түнш гэж үзнэ. ГНК нь газрын тосны орд газарт үйл ажиллагаа явуулдаг ч нэлээдгүй операторууд ДНК-ийг олборлолтын ажилд шууд оролцохыг зөвшөөрдөг байна.

Түүхий нефть олборлож эхэлмэгц, ГНК түүнээс хамаарсан роялти (ашигт малтмалын татвар)-г засгийн газарт төлж болно. Зарим улсад роялти төлдөггүй тохиолдол бий. Роялтиг бэлнээр төлсөн тохиолдолд тэр нь засгийн газарт нэн даруй орох мөнгөн урсгал болно. Харин бэлэн бус төлбөрөөр хийгдвэл дотоодын үйлдвэрлэл болон экспортод зориулсан үнэгүй түүхий нефтийн байдлаар хийгдэнэ. Хэрэв бэлнээр хийгдэж байгаа бол гарцын үнэ цэнийг тогтоох явдал туйлын ач холбогдолтой болдог. БХГ-г зарласан үнэ тохирч байгуулсан гэж үзье. Тэгвэл нефтийг яг нийлүүлэх үед, зарласан үнэ нь спот (эсвэл зах зээлийн) үнээс өндөр байвал засгийн газарт давуу талтай. Эсрэгээрээ зарласан үнэ нь спот үнээс доогуур байвал гадаад гэрээлэгчид ашигтай. Аль ч тохиолдолд роялти нь төсөл ашигтай эсэхээс үл хамааран Засгийн газарт орох хамгийн багаар бодсон орлого юм. Эндээс ашиг бага байх тусам ГНК-д үзүүлэх сөрөг нөлөө хамгийн их гэдэг нь харагдана. Хэрэв роялти хураамжийг орлогын албан татвараас хорогдуулж тооцдог бол засгийн газрын нийт орлого багасна гэсэн үг. Иймд роялтиг зардал гэж үздэг бол засгийн газарт илүү сайн.

Хоёрдахь шатанд оператор зардлынхаа зарим хэсгийг урьдчилж тохирсон хувь хэмжээгээр бүтээгдэхүүнээс тооцон авч хаадаг. Үүнийг “зардлын тос” гэж нэрлэдэг. Ихэнх гэрээнүүд зардлын тосны хязгаарыг 50 хувь (дундаж нь 33.3 хувь)-иар тогтоосон байдаг. Ийм хязгаарлалтгүй ч гэрээ бас байна¹³³. Зардал нөхөх түвшин нь тухайн талбайн онцлогоос шалтгаална.

Үлдсэн газрын тосыг “ашгийн тос” гэж нэрлэдэг ба ГНК, Засгийн газар харилцан тохирсон хувиар¹³⁴ хувааж авна. ГНК харин энэ дүнгээсээ орлогын албан татварыг Засгийн газарт төлдөг¹³⁵. Уг татварыг ДНК нь ГНК-ийн нэрийн өмнөөс төлдөг олон тохиолдол байна, эсвэл Засгийн газар энэ татвараа огт авдаггүй ч тохиолдол байна.

Үнэн хэрэгтээ БХГ-үүд дээрхээс илүү олон параметртэй байдаг. Зарим үзүүлэлтүүдийг дор авч үзье.

Төсвийн систем. Татварын түвшин БХГ-нд томоор тодорхойлогдсон байдаг. Хэрэв Засгийн газар нь өндөр роялти хураамж, ашгийн тосны ихэнх хувийг авахаар гэрээ хийгдвэл орлогын албан татвар хураах орон зай тэр хэмжээгээр багасч, ГНК-г эс урамшуулах болно. Засгийн газрын авах хэмжээ ихсэх тусам хамтын ажиллагаан дахь ГНК-ын сонирхол харилцан буурч байдаг. Ер нь ГНК ерөнхийдөө орлогын албан татварыг төлөх үүрэгтэй байдаг.¹³⁶ Гэвч ихэнхдээ шууд төлөгддөггүй учир нь Засгийн газрын ашгийн тосны хувь дээр нэмэгддэгт оршино. Орлогын албан татвар уг үйлдвэрийн ашигтай ажиллагаас хамаардаг бол роялти хураамж ашигт ажиллагаанаас үл хамаарна.

¹³³Перу, Тринидад&Тобаго-гийн зарим гэрээ, Ливийн эртний БХГ-г харж болно. Энэ нь 2 үр дагавартай. Үүнд: 1) Ашгийн тосны хэмжээ нэмэгдэнэ. Талууд ногдох хувиа хүртэнэ. Хэрэв татвар зонхилж байвал татварын суурь ихэссэнээр Засгийн газар илүү орлого олно гэсэн үг. 2) ГНК зардлаа ашгийн тосны хувиасаа нөхөх болно.

¹³⁴Ихэнх тохиолдолд ашгийн тосыг Засгийн газарт ашигтайгаар хуваарилдаг.

¹³⁵Энд нэг зүйлийг маш сайн ойлгох хэрэгтэй: Татварыг бүх ашгийн тосонд БУС зөвхөн ГНК-д ногдох хэсэгт ногдуулна.

¹³⁶Энд нэг зүйлийг маш сайн ойлгох хэрэгтэй: Татварыг бүх ашгийн тосонд БУС зөвхөн ГНК-д ногдох хэсэгт ногдуулна.

Татвараас чөлөөлөх. Зарим БХГ-үүд эхний тодорхой хугацаанд, жишээлбэл 5 жилд татвараас чөлөөлөхөөр заасан байдаг¹³⁷. Үүний шалтгаан нь ирээдүйн хөрөнгө оруулалтыг шагнаж урамшуулахад оршино. Гэвч цаг хугацааны асуудал их чухал. Орлогын татвар үйлдвэрлэл эхэлсэн үед л хэрэгждэг. Тэгвэл төслийн эхнээс 5 жилийн татварын чөлөөлөлт олгосон гэж үзвэл хайгуул хийж 3 жилийг өнгөрөөсний дараагийн 2 жилд л татварын чөлөөлөлт эдэлнэ гэсэн үг. Тиймээс уг шагнал урамшуулал үр дүнтэй байх үүднээс цаг хугацааны хувьд үйлдвэрлэл эхлэхээс өмнө биш байхаар бодолцох нь чухал. Тэгэж чадвал ГНК татвараас чөлөөлөх хугацаанд амжиж түргэн хугацаанд эрдэс баялгийг боловсруулахаар шамдах болно.

Урамшуулал. Урамшуулал нь эзэн орны бас нэгэн орлогын эх үүсвэр юм. БХГ-үүдэд ихэнхдээ гарын үсэг зурах, бүтээгдэхүүн гарах, зарим тохиолдолд нээлт хийх үед ГНК төлөхөөр тусгасан байдаг. Гарын үсгийн урамшууллыг гэрээ байгуулах үед нэг удаа төлнө. Энэ нь эдийн засгийн хувьд авч үзвэл, хайгуул, олборлолтын үр дүнгээс үл хамаарсан зээлийн шинжтэй бөгөөд өнөөгийн үнэ цэнийг бууруулж байдаг. Нэлээн ховор хэрэглэгддэг нээлтийн урамшуулал нь мөн нэг удаа хийгддэг төлбөр. ГНК-ийн боловсруулсан техник, эдийн засгийн даалгавар (хөгжлийн төлөвлөгөө)-ыг ҮНК-ийн зүгээс баталгаажуулж, арилжааны нээлт хийсний дараагаар шаарддаг. Харин бүтээгдэхүүний урамшуулал нь хэвшсэн байдаг. Энэ нь бүтээгдэхүүн тодорхой шатанд хүрмэгц төлөгдөхөөр тусгасан байдаг. Мөн тодорхой давтамжтай ч байж болно. Уг урамшууллыг ашигтай байхаас үл хамааран төлөхөөс гадна ихэнх гэрээнүүдэд татвараас хорогдуулахаар тусгасан байдаг.

Дотоод борлуулалтын үүрэг (ДБУ). Хэрэв Засгийн газрын эрх ашиг дотоодын хэрэгцээгээ газрын тосоор хангахаар байгаа бол ГНК-д ДБУ хүлээлгэдэг. Бусад ихэнх хувьсагчийн адил энэ үзүүлэлт ч мөн олон төрлийн шинжтэй байдаг. Ялгаа нь шаардагдах хэмжээ, төлөх үнийн аль алинд илэрхийлэгдэнэ. Гэрээнд ГНК-д оногдох ашгийн тосны тодорхой хувийг, зарим тохиолдолд 100 хувь, дотоодын хэрэгцээнд нийлүүлэхийг тусгадаг. Ингэхдээ Үнэ ч бас янз бүр байдаг. Зарим гэрээнүүдэд маш их хямдруулсан үнэ тохиролцсон байдаг. Хэрэв үнийг дотоодын мөнгөн тэмдэгтээр хийвэл ГНК-д бас муугаар нөлөөлдөг.

Экспорт, импортын гаалийн татвар. Хайгуул, боловсруулалтын тоног төхөөрөмж, материалд гаалийн татвар ногдуулах нь маш ховор байдаг. Эзэн оронд байдаг хүнс гэх мэт бүтээгдэхүүнд харин гаалийн татвар ногдуулдаг. Гаалийн татвараас чөлөөлөх үндэслэл нь тоног төхөөрөмж орж ирсэн даруйдаа буюу гэрээний төгсгөлд Засгийн газарт шилждэгт оршино.

Гэрээний хугацаа ба арилжааны шинж. БХГ нь хайгуул болон олборлолтын гэрээ юм. Гэрээнд хамгийн богино хайгуулын хугацааг тогтоож, тодорхой хугацаагаар сунгах боломжтойгоор тусгасан байдаг. Үе шат бүрийн эцэст ГНК нь гэрээт талбайгаас тодорхой хувийн эрхээсээ татгалздаг нь түгээмэл практик. Хэрэв арилжааны нээлт зарлагдаж, ажлын хөтөлбөр батлагдмагц олборлолтын үе эхэлнэ. Зарим гэрээнд олборлолтын хугацааг заасан байдаг бол нөгөөд нь гэрээний нийт хугацааг заасан байдаг. Жишээ нь, Хайгуулын хугацаа 3 жил, үүний дараа 2 жилээр тус бүр 2 удаа сунгах боломжтой, олборлолтын хугацаа 25 жил, 5 жилээр сунгах боломжтой. Нөгөөтэйгүүр, гэрээний нийт хугацаа 30 жил, үүнээс хайгуулд дээд тал нь 7 жилийг зарцуулна гэж зааж болно. Энд орхигдуулж үл болох нэгэн зүйл байгаа нь, арилжааны шинжийг яаж тодорхойлох вэ, хэн уг талбайг эдийн засгийн хувьд ашигтай, эсвэл ашиггүй гэж тогтоох вэ, гэдэг асуудал. ГНК-ийн хувьд хайгуулын зардал нь ихэвчлэн их хэмжээний далд зардал бөгөөд түүнийг олборлолт эхэлмэгц түүхий тосоор нөхөж эхэлдэг. Хэрэв нөхөн төлбөрийн хэмжээ маш их бол энэ нь Засгийн газарт өр төлбөр болж, түүхий бүтээгдэхүүнд ногдох хувийг нь багасгана. Зарим гэрээнд гадаадын гэрээлэгчид олборлолтыг үр ашигтай явуулах талаар

¹³⁷Зарим гэрээнүүдэд роялти хураамжаас ч чөлөөлсөн байдаг.

шийдвэр гаргахыг зөвшөөрсөн байдаг ч Засгийн газар авах жишиг дүнгээ тогтоосон байдаг. Ингээд авах дүн нь ГНК-ийн зорилттой нийцэж байвал ордыг олборлох ажлыг эхлүүлдэг. Энэ асуудал нь зардлын нөхөн төлбөрийн хязгаар тогтоогоогүй болон роялти байхгүй буюу бага БХГ-нд чухал ач холбогдолтой.

Ажлын хөтөлбөр. Ажлын хөтөлбөр нь дэлбэлэх, өрөмдөх, мэдээлэл боловсруулах, санхүүгийн үүрэг, дотоодын ажиллах хүчийг ажилд авах зэрэгтэй хамаатай ГНК-ийн амлалт үүргийг томьёолж өгдөг. Энэхүү хувьсагчийн хувьд хэлэлцээрт орж, сонгон шалгаруулалт явуулдаг нь ердийн нийтлэг зүйл болжээ. Ажлын амлалт бол хэлэлцээрийн нэлээн чухал сэдэв. Хайгуулын ажлын их бага хэсэг нь үр дүнд хүрч олборлолт явуулах хэмжээнд хүрч, зардлаа нөхөх орлого оруулдаг учир энэ нь хайгуулын эрсдлийн ихэнхийх багтаадаг.

Оролцоо. Ихэнх гэрээ ҮНК-ийг үйлдвэрлэлд оролцох боломжоор хангасан байна.¹³⁸ Гэвч энэ нь ҮНК хайгуулын шатанд зардал болон эрсдэлд хувь оруулна гэсэн үг биш юм. Ихэнх нь сонирхлын тээгч байдаг. ГНК хайгуулын үеийн бүхий л туршид зардал, эрсдлийг үүрдэг ба ҮНК-ийг тээж явдаг. Хэрэв талбайн арилжааны нээлтийг зарласан бол ҮНК нь ажлын сонирхлоо хэрэгжүүлэх (тэгэх албагүй ч) боломжтой. Оролцооны 5 хувь (Индонезийн зарим БХГ-үүд)-иас эхлээд 50 хувь (Алжир 1991, Хятад, Индонезийн зарим БХГ-үүд) хүртэл хэлбэлзэнэ. Гэвч 15 хувь (Малайз, Вьетнам) ба 25 хувь (Ангол, зарим Малайзийн БХГ-үүд) байх нь түгээмэл. Оролцох эсэхээ илэрхийлэхээс гадна хэзээ оролцох вэ, оролцооны хэлбэр юу вэ, зардлын ногдол хувь хэмжээ ямар байх вэ, санхүүжилт яаж босгох вэ зэрэг асуудлуудыг шийдэх хэрэгтэй болно. ҮНК-ийн санхүүжилт голчлон бүтээгдэхүүнээс гардаг. ГНК-ийн зүгээс авч үзвэл, өдөр тутмын үйл ажиллагааг удирдахад түншийн нөлөөлөл байх учраас эзэн орны аливаа оролцоог төдийлөн таашаадаггүй. Хоорондоо зөрчилтэй үзэл баримтлал нь төслийн үр ашигт муугаар нөлөөлж болзошгүй.

Тогтмол ба хөвөгч масштаб. Роялти, зардлын тос, ашгийн тос, бүтээгдэхүүний урамшууллыг тогтсон тогтмол хувиар тооцож болно. Эсвэл хөвөгч (хувьсагч) масштаб ашиглаж болно. Сүүлчийнх нь одоо стандарт болсон. Энд их олон төрлийн хөвөгч масштабыг хэрэглэж болох боловч дундаж өдрийн бүтээгдэхүүн болон Р-фактор¹³⁹ хоёрыг хамгийн түгээмэл хэрэглэж байна.

Эзлэхүүнд суурилсан хөвөгч масштабын жишээн дээр Индонезийн нэгэн гэрээг ашгийн тосны хувь хэмжээг хүснэгтээр харуулбал, ҮНК-ийн хувь 61.5385 хувиас багагүй, харин ГНК-ийн хувь 19.2308%-иас буухгүй байгаа нь харагдана.

Хүснэгт 3. Индонезийн ашгийн тос

Өдрийн дундаж олборлолт (bbl-баррель тос)	ҮНК (%)	ГНК (%)
<=50,000	61.5385	38.4615
50,001-150,000	71.1538	28.8462
=>150,001	80.7692	19.2308

Нөгөөтэйгүүр, Р-фактор нь орлогыг зардалд харьцуулсан харьцааг илэрхийлнэ. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, ГНК-ийн зардлын нөхөн төлбөр болон ашгийн тосны орлогын хуримтлагдсан нийлбэрийг тодорхой үеийн туршид гаргасан хуримтлагдсан зардалд хуваана. Азербайжаны нэгэн БХГ-ний жишээн дээр үүнийг хүснэгтээр харуулъя.

¹³⁸Оролцоогүй гэрээнүүдийг Египет, Оман, Катар, Йемен, Филиппин, Нигери, Туркменистан улсуудад харж болно.

¹³⁹R-Factor

Хүснэгт 4. Азербайжаны ашгийн тос

<i>Р-фактор</i>	<i>ҮНК (%)</i>	<i>ГНК (%)</i>
R<1.50	50	50
1.50<=R<2.00	60	40
2.00<=R<2.25	62.5	37.5
2.25<=R<2.50	65	35
2.50<=R<2.75	70	30
2.75<=R<3.00	75	25
3.00<=R<3.25	80	20
3.25<=R<3.50	85	15
R>=3.50	90	10

Хөвөгч масштабын загварыг ихэвчлэн хүлээгдэж буй нээлтийн хэмжээнд тулгуурлан хийдэг. Гэрээ эзлэхүүнд, эсвэл Р-факторт тулгуурласан байна уу гэдгээс үл хамааран хувь хэмжээг тогтоож байгааг анхаарах хэрэгтэй. Хэрэв хувь хэмжээ хэт өндөр бол масштаб уян хатан чанараа ихэнхдээ алдана. Ерөнхийдөө хөвөгч масштаб нь гэрээг илүү уян хатан болгодог. Төслийн үр ашиг нэмэгдэх тусам Засгийн газрын авах хэмжээ өсдөг. Энэ системд Засгийн газрын авах хэмжээ нь төслийн үр ашгийн функц болдог бол тогтмол системд эсрэгээрээ үр ашиг нь Засгийн газрын авах хэмжээний функц болдог.

Дөрөв. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үзүүлэлтүүд

БХГ байгуулахад хэрэглэгдэх үзүүлэлтүүдийг 6 категорид ангилан хуваасныг 5-р хүснэгтэд харуулав. Үүнд суурь мэдээллийн дор гэрээлэгч талууд, гэрээнд гарын үсэг зурсан огноо, газрын тос олборлох ордын байршил, талбай, түүний онцлог, ойн бүсэд үү, уул нуруунд уу, хэр талд уу гэх мэт түүнчлэн оншор (дотоод түнш), эсвэл оффшор (гадаад түнштэй) эсэхийг багтааж авч үзнэ. 2 дахь категорид гэрээний элементүүдийг багтаав (үнэндээ ингэж хэлэх нь буруу юм, хүснэгтэд үзүүлсэн бүх үзүүлэлтүүд гэрээний элемент мөн билээ). 3 дахь категорид хайгуул, олборлолтыг оруулахаас гадна хайгуул дууссаны дараа олборлолт явуулах боломжгүй талбайн нийт гэрээлсэн талбайгаас хорогдуулах хувиар илэрхийлэгдэх эрхээс татгалзах гэрээний заалтыг хамруулна. 4 дэх категорид ГНК-иас Засгийн газарт төлөх, эсвэл үл төлөх урамшууллуудыг хамруулав. 5 дахь категорид бүх төрлийн албан татвар, ялангуяа орлогын албан татвар, гаалийн татвар, үнийн дээд хязгаар, дотоод борлуулалтын үүрэг (ДБҮ)-ийг багтаав. Үнэндээ ДБҮ нь татвар биш боловч ерөнхийдөө маш их хямдрал үзүүлдэг учраас ГНК-ийн санхүүгийн үүрэг гэж үзнэ. Эцсийн бүлэгт эрх зүйн орчны зохицуулалт болох төрөл бүрийн арбитраж болон шүүх, ГНК-ийн заавал ажиллах үүрэг, ҮНК-ийн оролцоо зэргийг тусгасан.

Хүснэгт 5. Үзүүлэлтүүд

<i>Суурь</i>	<i>БХГ-ны элемент</i>	<i>Хайгуул ба олборлолт</i>	<i>Урамшуулал</i>	<i>Татвар хураамж</i>	<i>Эрх зүйн орчин</i>
Улс	Роялти/АШО	Хайгуул	Гарын үсэг	Орлогын албан татвар	Ажиллах үүрэг
Он	Зардлын тос	Олборлолт	Нээлт	Экспортын татвар	Оролцоо
Дотоод түнш	Ашгийн тос	Га (талбайн хэмжээ)	Бүтээгдэхүүн	Импортын татвар	Арбитраж
Гадаад түнш		Эрхээсээ татгалзах		Үнийн дээд хязгаар	
Талбай				Дотоод борлуулалтын үүрэг (ДБҮ)	

Роялти. Ихэнх гэрээнүүдийн роялти тогтмол утгатай байна. Харин зарим улсуудад, жишээ нь Хятад, Туркменистан, Сири, Йемен, Алжир, Египет, Чили, Эфиоп, Габон, Нигери улсуудад хөвөгч роялти хэрэглэжээ. Хөвөгч татвар хэрэглэсэн үед бодит олборлолтыг мэдэх боломжгүй учир хамгийн дээд утгыг авч үздэг.

1966-1998 оны хооронд авч үзэхэд, Ази болон Зүүн европын роялти бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур буюу 4% ба 5%-иас хэтрэхгүй байхад бусад бүсэд 7%-9% байна. Энэхүү зөрүүтэй байдлыг Азийн олон гэрээнүүдэд, ялангуяа Азийн гэрээнүүдийн бараг талыг бүрдүүлдэг Индонезид роялти тусгаагүй байдагтай холбож үзэж болох талтай. Роялтигийн оронд 20%-ийн анхны шатахууны облигац¹⁴⁰ (АШО) хэрэглэдэг. АШО-г ашгийн тосны хувь хэмжээгээр харилцан талууд хуваах бөгөөд энэ нь роялтитэй мөн чанар адилхан юм. Засгийн газрын ашгийн тосны хувь и 50-90% гэж үзвэл, Засгийн газарт анхны бүтээгдэхүүний 20%-ийн 10-18% ногдоно. Үүнийг 10-18%-ийн роялти гэж ойлгож болохгүй учир нь энд бүх түүхий тосноос тооцдог роялти биш харин түүхий тосны гаралтын тавны нэгийг л авч үзэж буй. Тиймээс Азид бодит роялти үнэндээ гэрээлсэн роялтигаас өндөр гэж болно.

Түүнээс гадна Азийн гэрээнүүдийн 30% нь роялтийг хэлэлцэж буюу тендэрээр¹⁴¹ тохирдог тул хэмжээг нь тогтоох боломжгүй байна. Ялгаа үүсэх бас нэгэн шалтгаан бол хамгийн доод болон дээд роялтигийн зай их зөрүүтэй байгаатай холбоотой. Азид 0-12.5% байхад, Зүүн европт 0-17.5% байна. Бусад бүх бүсэд зөрүү нь хамгийн багадаа 20% байна. Латин Америкт хамгийн доод болон дээд роялтигийн хэмжээний ялгавар 45%¹⁴² байна. Энэ утгыг хасаад тооцвол тухайн бүсийн дундаж 20% байна. Одоогийн байдлаар роялтигийн хэмжээ улам нэмэгдэх хандлагатай байна, ялангуяа Зүүн европ, Хойд африкт. Хойд африк, Төв америк, Карибийн бүсэд дундаж роялти хамгийн өндөр буюу 10% байгаа ба цаашид өсөх хандлагатай. Цэвэр экспортлогч цэвэр импортлогчтой харьцуулахад илүү роялти төлдөг, мэдээж оншор гэрээ нь оффшортой харьцуулахад ГНК-ийн хувьд илүү хүнд юм.

Судалгаанаас үзэхэд, нийт БХГ-ний 91% нь роялти 0%, 10%, 12.5%, 20% гэсэн 4 ангилалын аль нэгэнд хамаарч байхад үлдсэн 9%-ийн ихэнх нь 12.5-20%-ийн хооронд байна. Нэг гэрээ 20%-иас их (Чили-45%), харин тавхан гэрээ 10%-иас доогуур роялти тохирсон байна.

Зардлын тос. Гэрээнүүдийн бараг 1/3 нь жилийн зардлын тосны олговрыг хөвөгч масштабаар, эсвэл дээд үнэ хүртэл хэлэлцэж буюу тендэрээр тохирохоор заасан байна. Зардлын тосны олговор 0% (Ливи, Перу, Румын, Тринидад)-иас 100% (Индонези, Либери, Бахрайн, Гватемали, Алжир, Энэтхэг, Азербайжан, Нигери)-ийн хооронд хэлбэлзэж байна. Энд хоёр зүйлийг тэмдэглэх нь зүйтэй. 1-рт, дээрх улсуудад бүх гэрээ 0% эсвэл 100% гэж хийгдэхгүй байна. 2-рт, тосны бүрэн нөхөн олговрыг зөвхөн тодорхой хугацаатай уяж өгсөн байна. Жишээ нь, эхний 5 жил. Ингэж хэрэглэх нь татварын чөлөөлөлттэй утга ижил юм.

Дараах ажиглалтыг хамгийн дээд утгаар нь авч үзсэн болно. 1966 оноос хойш зардлын тосны дундаж хамгийн бага нь Ойрхи дорнодод 37% байхад Латин америкт 45%, Хойд африкт 49% байна. Хамгийн өгөөмөр зардлын нөхөн төлбөртэй бүс гэвэл Ази 66% байхад Төв америк 69%-тай байна. Зүүн европ, Өмнөд/Төв африкт зардлын тосны хувь хэмжээ дэлхийн дунджийн түвшинд байна. Роялтитэй нэгэн адил зардлын тосны хувийн дээд, доод утгын зөрүү асар их байна. Азид зардлын тосны хувь хэмжээ 20%-100% байхад Ойрхи дорнодод 25-100%, Өмнөд/Төв африкт 30-100% хооронд хэлбэлзэж байна.

¹⁴⁰FTP - first tranche petroleum

¹⁴¹Филиппиний зарим болон Монголын хоёр гэрээ ийм нөхцөлтэй.

¹⁴²Чилид байгуулсан нэг гэрээний роялти 45%.

Одоогийн хандлага дэлхийн бараг бүх бүсэд зардлын тосны хувь нэмэгдэх чигтэй байхад харин Ойрхи дорнодод дундаж 40%-иас бага зэрэг буурах хандлагатай. Зардлын тосны дэлхийн дундаж одоогоор 70% байна.

Судалгаанаас үзэхэд, нийт гэрээний бараг тэн хагас нь зардлын тосны хувийг 40% эсвэл 100% гэж тохирсон байна. Харин 1/3 нь 30% буюу 50%-тай байна. 0%-тай гэрээ 2.5%-ийг эзэлж байгаа бол үлдсэн 20.5% нь 20-29% хооронд байна. Зардлын тосны хувийг ихэвчлэн бүхэл тоогоор тогтоож байгаа нь ажиглагдсан. Ингэхдээ 40% гэсэн тоо 45%-иас хавьгүй олон байна.

Ашгийн тос. Нийт 268 гэрээний зөвхөн 45 нь л тогтмол утга хэрэглэсэн бол бусад нь ямар нэгэн гарцад буюу өгөөжид суурилсан хөвөгч масштаб хэрэглэжээ. Хөвөгч масштаб олонх нь байгаа учир 6-р хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн судалгааг хамгийн бага (минимум), хамгийн их (максимум) утгаар авч үзэх шаардлагатай болов. Хүснэгтэд ГНК-ийн хувьд үзүүлэлтүүдийг харуулсан байгаа боловч Засгийн газрын хэмжээг тооцоолоход их хялбархан буюу 100-аас ГНК-ийн хэмжээг хасахад гарах юм. Судалгаанаас үзэхэд, ГНК-д ногдох дундаж ашгийн тосны максимум хэмжээ хамгийн өндөр нь Төв америкт 65% байхад хамгийн нам нь хол тасархай 28%-тай Ойрхи дорнод байна. Минимум хэмжээний тухайд Ойрхи дорнод 16%-тай хамгийн доод түвшинд байгаа бол Төв америк, Зүүн европ, Латин америк 39%-тай хамгийн өгөөмөр зан гаргажээ.

Хүснэгт 6. ГНК-д ногдох ашгийн тос

	<i>Дундаж ашгийн тос</i>		<i>Максимум ашгийн тос</i>		<i>Минимум ашгийн тос</i>	
	<i>Максимум</i>	<i>Минимум</i>	<i>Дээд</i>	<i>Доод</i>	<i>Дээд</i>	<i>Доод</i>
Ази	44.15	28.21	100	15	60	10
Төв америк	64.71	36.57	95	40	85	20
Латин америк	48.00	38.80	50	40	50	30
Зүүн европ	51.93	37.00	80	40	60	10
Ойрхи дорнод	27.80	15.75	60	11.8	40	7.5
Хойд африк	38.67	18.00	100	19	50	10
Өмнөд төв африк	55.69	29.17	100	15	75	5

Одоогоор максимум ашгийн тосны хувь хэмжээ Ойрхи дорнодыг эс тооцвол өсөх хандлагатай. Харин Ойрхи дорнодод энэ нь нэлээн доогуур буюу 25%-тай байгаа боловч цаашид буурах шинжтэй. Латин америк ч мөн адил 45%-иасаа доошлох төлөвтэй. Оффшор гэрээг оншортой харьцуулахад ашгийн тос илүүтэй өсөх хандлага ажиглагдаж байна. Оффшорын хувьд ажиглагдсан бас нэгэн онцлог гэвэл, хөрвөгч масштабыг өгөөжид суурилсан биш харин илүүтэй эзлэхүүнд суурилсан байдлаар ашиглажээ. Хоёр хувьсагчийн аль алины хувьд экспортлогч ГНК-д импортлогчтой харьцуулахад бүр бага таашаалтай юм.

Роялти болон зардлын тосны адилаар ашгийн тосны хувьд ч тодорхой тоог голчлон хэрэглэж байгаа нь ажиглагдсан. Гэрээнүүдийн 1/3-ээс олонход нь ГНК-ийн ашгийн тосны хувь хэмжээ 10% юмуу эсвэл 30%-тай байна. Ерөнхийдөө 2/3 (гуравны хоёр)-ийн минимум ашгийн тосны хувь хэмжээ 5-30% хооронд байна. Максимум ашгийн тосны хувьд ойролцоо дүр зургийг харж болно. Бүх гэрээний ¼ (дөрөвний нэг) нь 40 буюу 50%-ийн аль нэгийг сонгосон байна. Зөвхөн 8 БХГ-нд 20% максимумтай байгаа бол бараг 30% нь 50%-иас дээш максимум тохирчээ. Энд мөн л бүхэл тоо хэрэглэх нь давамгайлж байна. Ингэснээр минимум болон максимум ашгийн тосны ялгавар нь 0, 10, 20, 30, 40%-д эргэлдэж байна. Гэхдээ 40%-иас илүү (85% хүртэл) ялгавар тогтоосон гэрээ 18 байна.

Гэрээний хугацаа. Судалгаанаас ажиглахад, хайгуулын минимум болон максимум хугацаа бүсүүдээр авч үзвэл ялгаатай боловч сүүлийн үед нэлээн их зөрүүтэй болсон байна. Зөвхөн Ойрхи дорнод болон Латин америкт л хайгуулын хугацаа дэлхийн дунджаас доогуур байгаа бол Өмнөд болон Төв африкт харин дэлхийн дунджаас илүү хугацаа хайгуулд зарцуулж байгааг дурдах нь зүйтэй. Гэвч хандлага нь маш өргөн хүрээнд ялгаатай байна. Өмнөд болон Төв африк болон Зүүн европт гэрээнд тусгасан хайгуулд зарцуулах хугацааг илүү нэмэгдүүлж байхад Ази болон Ойрхи дорнодод эсрэгээрээ илүүтэй бууруулж байна. Олборлолтын максимум хугацаа эрст тэс ялгаатай байгаа ба Ойрхи дорнодод 23 жил байгаа бол Латин америкт 30 жил байна. Хандлага нь бүхэлдээ буурах шинжтэй. Нэг бүсийн хүрээнд ч авч үзэхэд хайгуулын болон олборлолтын хугацаа маш их ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй. Ийм үр дүн ялангуяа Ази болон Өмнөд/Төв африкт их байна.

Талбай. Эхний хайгуулын дараа эрхээсээ татгалзах талбайн хэмжээ мөн л янз бүр байна. Азид 20% байгаа бол Өмнөд/төв африк, Зүүн европт 35% байна. Өсөх, буурах хандлага нь мөн л бүсүүдийн хувьд эрс ялгаатай. Эрхээсээ татгалзсан талбайн хамгийн өндөр болон нам хувь хэмжээний ялгавраар нь авч үзвэл, Хойд африкт 10% байхад Азид даруй 50% байна. Оншор, оффшорын хувьд экспортлогч уу, эсвэл импортлогч уу гэдгээсээ хамаарч ижилхэн түвшинд байна.

Урамшуулал. Маш цөөхөн гэрээнд л нээлтийн урамшуулал тусгасан байна. Иймээс энэхүү үзүүлэлтийг судалгаанд авч үзсэнгүй. Харин гарын үсгийн болон бүтээгдэхүүний урамшууллын талаар судлахад, бүсүүдийн хооронд эрс тэс ялгаа байгаа нь ажиглагдлаа. Ерөнхийдөө Зүүн европ доод туйлыг нь бүрдүүлж байгаа бол дээд туйлыг нь Ойрхи дорнод төлөөлж байна. Бүтээгдэхүүний урамшуулал оншор, оффшорын хувьд адилхан түвшинд байна. Харин гарын үсгийн урамшуулал оншор гэрээнд оффшороосоо илүү өндөр тусгагдсан байна. Экспортлогчид илүү өндөр гарын үсгийн урамшуулал төлж байхад импортлогчид бүтээгдэхүүний урамшуулал илүү төлдөг болохыг ажиглаж болно. Масштабын доод болон дээд түвшинд байрласан бүсүүдэд гарын үсгийн урамшуулал эрс нэмэгдэх хандлагатай байхад бусад бүх бүсэд хэвээрээ буюу багавтар буурч байна.

Харин эдгээр бүсэд бүтээгдэхүүний урамшуулал нэмэгдэх хандлагатай. Цаашид гарын үсгийн урамшуулал Зүүн европ болон Азид хамгийн бага, харин Ойрхи дорнод болон Төв америкт хамгийн дээд хэмжээнд хүрэх төлөвтэй. Нөгөөтэйгүүр, бүтээгдэхүүний урамшуулал дунджаар Зүүн европ болон Төв америкт хамгийн бага байгаа бол Ойрхи дорнод болон Ази, Өмнөд/Төв африкт хамгийн их хэмжээтэй байна. Бүтээгдэхүүний урамшууллын хамгийн бага тархалтыг Зүүн европ болон Хойд африкт, харин ихийг Ази болон Өмнөд/Төв африкаас ажиглаж болно.

Татвар. Татварын хувьд 0-60% хооронд хэлбэлзэж байгаа бол хэн төлж байгаагаар ч ялгаатай байна. Нийт гэрээний 1/3-д нь ГНК татвараа шууд төлж байна. Харин 20% орчимд нь ҮНК нь ГНК-ийн нэрийн өмнөөс татварын тооцоог хийхээр тохиролцжээ. Цаашилбал 20% орчимд нь татварын талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байдалтай байна. Үлдсэн тохиолдолд татварыг хэлэлцэж тохирохоор тусгасан байна. Орлогын албан татварын дундаж ГНК, эсвэл ҮНК байхаас үл хамааран 45% байгаа нь ажиглагдлаа. Энэ хэмжээ нь цаг хугацааны туршид харьцангуй тогтвортой байна. Үүний шалтгаан нь энгийн бөгөөд татварыг гэрээгээр тохиролцдоггүй харин тухайн улсын хууль эрх зүйгээр зохицуулдаг оршино. Татварын хууль тогтоомж өөрчлөгдөх нь нэн ховор байдаг онцлогтой. Өөрчлөлт орсон ч тун ялихгүй хэмжээтэй байдаг.

Хөгжлийн чиг хандлага. БХГ байгуулж эхэлснээс хойш роялти өөрчлөгдөхгүй өгийг хүргэжээ. Гэвч 1980-аад оны дунд үеэс хойш нэлээн ялгаатай болж ирсэн нь ажиглагдлаа. Хязгааргүй нөхцөл бүхий гэрээнүүд олшрохын хэрээр зардлын тосны хэмжээ үлэмж

нэмэгдэв. Роялтитэй адил өнөөдөр зардлын тосны маш их ялгаатай байдлыг харж болно. 1970-аад оны сүүлд 0-40% хооронд хэлбэлзэж байсан бол одоо 0-100%¹⁴³ болсон байна. 1970-аад оны сүүл хүртэл ГНК-ийн ашгийн тосны хувь 50%-иас хэтрэхгүй байсан бол одоо минимум ногдол хувь 85%-д хүрсэн байна. Цөөн тооны гэрээнүүдэд минимум хувийг 50%-иас доош нь оруулахгүй ч гэж тохирсон байдалтай. Максимум ашгийн тосны хувь хэмжээ ч мөн адил харилцан нэмэгдсэн байна; зарим гэрээнүүдэд 100% ажиглагдсан¹⁴⁴. Энэ нь хөвөгч масштаб ихээр хэрэглэх болсонтой шууд холбоотой.

Хайгуулын хугацаа ч минимум, максимумын хувьд аль аль нь буурсан. Хайгуулын хугацаа буурсны үр дүнд Засгийн газар үйлдвэрлэлд илүүтэй хяналт тавих боломжтой болсон. Учир нь хайгуулын дараах үе шатуудад Засгийн газар буюу ҮНК-ийн зөвшөөрөл байнга шаардлагатай. Гэхдээ дэвшилтэт технологийн үр дүнд энэ нь буурах учиртай. Үүний дүнд эрхээсээ татгалзах хэмжээ мөн буурсан. Эртний БХГ-нүүдэд эрхээсээ татгалзах хэмжээ 0-50% хооронд байсан бол одоо энэ нь 1970-аад оны дунд үед 15%-25% болж буурсан. Гэхдээ одоогийн хандлага багавтар өсөх чигтэй байна.

Төрөл бүрийн урамшууллын хувьд тэдгээр нь ихэвчлэн хөвөгч масштаб хэрэглэдэг болсонтой холбоотой түүнийг нарийн чанд тогтоох боломжгүй юм. Нээлтийн урамшуулал бараг хэрэглэхээ больсон. Бүтээгдэхүүний урамшуулал багавтар өссөн бол гарын үсгийнх эсрэгээр байна. Бүтээгдэхүүний урамшуулал ихэнхдээ хөвөгч масштабтай байгаа учир зөвхөн максимум утгыг нь авч үзсэн болно. Дээрхтэй ижил шалтгаанаар ашгийн тосны бодит хүлээж авсан буюу төлсөн хэмжээг тодорхойлох боломжгүй юм.

Бусад үзүүлэлтүүдийн хувьд маш их зөрүүтэй байгаа учир дэлхийн хэмжээнд харьцуулалт хийх нь утгагүй билээ. Ийм учраас цөөхөн хэдхэн улсад гаалийн татвар болон үнийн дээд хязгаар тогтоосныг дурдаад өнгөрөе. ДБҮ-ийн хувьд тооцоололд ашиглаж байгаа үнийг аль болох хямдруулахаа больж, зарласан үнэ гэхээсээ зах зээлийн үнийг илүүтэй хэрэглэх боллоо. Ажиллах үүрэг ч цаг хугацааны явцад уян хатан болсон. Түүнийг тендерээр буюу хэлэлцээрээр тохиролцдог болсон төдийгүй хайгуулын үе шат бүрийн эцэст дахин авч үздэг болсон. ҮНК-ийн оролцоо харин үргэлж их ялгаатай байсаар ирсэн. Оролцооны хувь хэмжээ 5%-51% хооронд, харин дундаж нь 23% байна. Ихэнх гэрээнд ҮНК оролцох эрхтэй боловч заавал үүрэг хүлээхгүй байхаар тусгажээ.

Тав. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд хийсэн зарим дүн шинжилгээ

Аливаа төслийн техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д нөлөөлдөг гол хоёр үзүүлэлт бол дотоод өгөөжийн хувь (ДӨХ)¹⁴⁵ болон өнөөгийн цэвэр үнэ цэнэ (ӨЦҮ)¹⁴⁶ юм. ДӨХ нь оруулсан хөрөнгө оруулалтыг тухайн хувиар зээлсэн гэж үзвэл түүнийг нөхөх хувь хэмжээг илэрхийлнэ. Энэ нь өнөөгийн орлогын үнэ цэнийг өнөөгийн зардлын үнэ цэнэд харьцуулсан хорогдуулалтын хувьтай тэнцүү. ӨЦҮ нь өнөөгийн орлогын үнэ цэнээс өнөөгийн зардлын үнэ цэнийг хассан ялгавраас тодорхой хорогдуулалтын хувиар тооцсоныг хэлнэ.

Хэрэв ӨЦҮ сөрөг гарвал ДӨХ хорогдуулалтын хувиас бага болох ба уг төслийг ашиггүй гэж үзнэ. Хэрэв ӨЦҮ, ДӨХ хоёул эсрэгээр бол тэдгээрийн илүү сайн хувилбар байхаас үл хамааран үйлдвэрлэлийг зөвшөөрөх (ТЭЗҮ-г батлах) нь зүйн хэрэг.

Гэрээлэгч хоёр талын хоорондох ашгийн тосны харьцаанаас хамаарч ДӨХ, ӨЦҮ хэрхэн өөрчлөгдөхийг шинжлэх нь чухал ач холбогдолтой. Хэрэв ашгийн тосны харьцаа 60/40 байсныг 50/50, дараа нь 40/60 болгож үзэхэд, газрын тосны үнэ доод түвшинд байвал

¹⁴³Алжир, Азербайжан, Чили, Гватемали, Энэтхэг, Индонези, Либери, Нигери

¹⁴⁴Энэтхэг, Либери, Ливи, Уганда, Зайри

¹⁴⁵IRR - Internal Rate of Return

¹⁴⁶NPV - Net Present Value

ДӨХ-ийн хэмжээ 25% байснаа 32 буюу 38 болж тус тус нэмэгдэнэ. Үүнтэй адилхан, хэрэв ГНК татвар төлөхөөр бол татварын чөлөөлөлт ДӨХ-ийг мэдэгдэхүйц нэмэгдэхэд хүргэж байна. Энэхүү нэмэгдэл нь газрын тосны үнэ нэмэгдэхэд улам өснө.

Роялтигийн өөрчлөлт мөн нөлөө үзүүлнэ. ГНК нь өндөр роялти төлөх тусам олборлолт эрт дуусахад (үнийг тогтмол гэж үзвэл) гайхаад байх зүйлгүй билээ. Гэхдээ шинжилгээнээс үзэхэд, барель тосны үнэ 5 доллар (\$5bbl¹⁴⁷)-оор өсөхөд (бусад бүх үзүүлэлтүүд тогтмол гэвэл) ДӨХ бараг хоёр дахин нэмэгдэж байхад роялтигийн төлбөрөөс үл харгалзан ӨЦҮ олон дахин өсч байна. Эндээс роялти болон татварын хослол ДӨХ болон ӨЦҮ-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг болох нь харагдана. Дахин тэмдэглэхэд, үнийн өсөлт ГНК-ийн ашгийг нэмэгдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ Засгийн газрын орлогыг үлэмж нэмэгдүүлнэ. Мөн зардлын тосны бүрэн нөхөн олговрын үед (зардлын тос 100%) дээрх хослолын нөлөө суларч байгааг харж болно. Энэхүү хослол нь бага үнийн түвшний үед үл мэдэгдэх нөлөө үзүүлж байснаа өндөр үнийн түвшинд ерөнхийдөө алга болж байна. Түүнчлэн бага үнийн түвшний үед зардлын тосны хэмжээ 40% байх нь зардлаа бүрэн нөхөхөд хангалтгүй гэдэг нь харагдсан.

Шинжилгээнээс үзэхэд, ГНК-ийн хувьд татвар төлөх нь роялтитай харьцуулбал ашиггүй байна. Дээрх хоёр үзүүлэлтийг 7-р хүснэгтээс үзүүлснээс харахад, 15%-ийн роялти төлөх нь 20%-ийн татвараас илүүтэй ДӨХ, ӨЦҮ-г бууруулж байна. Эндээс, ихэвчлэн хараалгаж байдаг роялти¹⁴⁸ нь энэ дэлхийн хамгийн муу зүйл байх *албагүй* гэсэн дүгнэлт хийж болно.

Хүснэгт-7. Роялти болон татварын харьцуулалт

<i>Роялти</i>			<i>Татвар</i>		
%	ӨЦҮ@12 ¹⁴⁹	ДӨХ	%	ӨЦҮ@12	ДӨХ
5	42,466	40	15	36,681	37
8	39,302	38	18	34,469	35
10	37,194	37	20	32,995	35
12.5	34,557	35	22.5	31,151	34
15	31,920	34	25	29,308	33

Зургаа. Бусад салбарт хэрэглэсэн олон улсын туршлага

Газрын тос, байгалийн хийгээс бусад салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээг ашигласан нэгэн тохиолдол бол Батлан хамгаалахын бүтээгдэхүүн хуваах гэрээ¹⁵⁰ юм. Уг гэрээг¹⁵¹ Канад улс, АНУ хоёрын хооронд анх 1956 онд байгуулсан бөгөөд 1956, 1957, 1961, 1962 онуудад тус тус өөрчлөлт оруулж байжээ. Гэрээнд Канадын талаас Батлан хамгаалахын бүтээгдэхүүний яам¹⁵², Худалдааны корпораци¹⁵³ болон АНУ-ын талаас Цэргийн яам¹⁵⁴, Усан цэргийн яам¹⁵⁵, Нисэх хүчний яам¹⁵⁶, Батлан хамгаалахын хангамжийн агентлаг¹⁵⁷ тус тус оролцжээ. Гэрээний зорилго нь хил дамнасан цэргийн худалдааны тэнцвэр (баланс)-ийг хангахад оршино.

Үүнтэй төстэйгээр цэргийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хуваах зориулалтаар байгуулсан Батлан хамгаалахын судалгаа хуваах хөтөлбөр¹⁵⁸ ч гэж бас байдаг.

¹⁴⁷bbl – барель тос

¹⁴⁸Ашигт ажиллагаанаас үл хамааран төлдөг учраас ихэнхдээ компаниуд өширхдөг.

¹⁴⁹Барель тосны үнэ 12 доллар гэж үзээд хийсэн ӨЦҮ-гийн тооцоо.

¹⁵⁰file:///DPSAe Canada-USA.pdf

¹⁵¹file:///DPSAe Canada-USA.pdf

¹⁵²Department of Defence Production (Canada)

¹⁵³Canadian Commercial Corporation

¹⁵⁴Department of the Navy

¹⁵⁵Department of the Navy

¹⁵⁶Department of the Air Force

¹⁵⁷Defense Supply Agency

¹⁵⁸Defense Development Sharing Program

ДҮГНЭЛТ

1. Газрын тосны салбарт олон янзын гэрээний хэлбэрийг ашигладаг ч бүтээгдэхүүн хуваах гэрээг хамгийн өргөн дэлгэр хэрэглэдэг.
2. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд олборлолт явуулж, бүтээгдэхүүн гаргаж эхэлсэнээс хойш л гадаадын нефтийн компанид олборлолтын өмнөх болон үйл ажиллагааны зардлаа нөхөх асуудал яригддаг. Иймд зардлыг тодорхойлох нь үл тохиролцооны сэтгүүр болж болзошгүй.
3. Онолоор бол, засгийн газар нь үйлдвэрлэлд хяналт тавьдаг гэх боловч үнэн хэрэгтээ бүх эрсдлийг үүрч буй хувийн түнш нь төслийг удирддаг. Гэвч сүүлийн үед үндэсний нефтийн компаниуд нь олонтаа хамтын үйлдвэрт оролцох эрхээ хэрэгжүүлэх сонирхолтой болсон.
4. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц, гадаадын нефтийн компанийн суурилуулсан бүх тоног төхөөрөмж, дэд бүтэц, барилга байгууламж нь засгийн газрын өмч байдаг. Гэсэн хэдий ч бүтээгдэхүүн хуваах гэрээ нь гадаадын компаниудын, ялангуяа АНУ-д бүртгэлтэй, анхаарлыг их татдаг. Учир нь тэд өмчилдөггүй ч, ашигт малтмалын орд амьд байх бүхий л хугацааны туршид нөөцийг тайлан балансдаа тусгах боломжтой. Энэ нь эрх зүйн гэхээсээ илүүтэй хандалтын чадавхтай гэдэг утгаараа боломжтой байдаг.
5. Хайгуулын үе шат дуусаж ордын бодит хэмжээ тогтоогдож, үндсэн характеристикиуд мэдэгдэх болсон ч бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлүүдийг ихэсгэх буюу багасгах байдлаар өөрчилж үл болно. Ажил эхлэхээс өмнө тохирсон байдаг учраас хайгуулын эхний үе шатанд ажиллах үүрэг хүлээсэн бол үүнтэй төстэй асуудал мөн үүсэж болзошгүй. Гадаадын нефтийн компанийн хувьд хайгуулыг богино хугацаанд явуулсны дараа хойших ажлуудаа төлөвлөх сонирхолтой байдаг. Нэгэнт олборлолт эхэлсэн бол зардлын тосоор, төсөл алдагдалтай ч байхаас үл хамааран гадаадын нефтийн компани гаргасан зардлаа нөхөж авдаг. Янз бүрийн гэрээнүүдэд зардлыг ихэвчлэн татвар ногдуулах орлогоос хасч тооцдог. Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд гадаадын нефтийн компанид оногдох ашгийн тос юм. Иймээс гадаадын нефтийн компаниуд зардлын нөхөн олговрыг аль болох өндөр байлгах маш их дуртай байдагт гайхаад байх зүйлгүй, зарим гэрээнүүдэд бүр зардлын тосны хэмжээг хамгийн их буюу 100%-иар тогтоосон ч байдаг. Засгийн газрын хувьд зардлын тосны хэмжээ их байх тусам ашгийн тосноос түүнд ногдох хэмжээ улам багасна гэсэн үг. Иймд энэхүү байдлаас гарах нэг арга бол роиялтигаар дамжуулан тодорхой орлогын урсгал бий болгох явдал юм.
6. Хорогдуулалтын хувиас хамааран эдийн засгийн түрээсийн утгаар улсын төсөв хангалттай бүрэлдэхгүйгээс зарим төсөл үр ашиггүй байж болно. Ингэж хатуурхах нь орлогоо максимумд байлгах зорилгод нь гарз хохирол учруулдаг гэдгийг засгийн газар хүлээн зөвшөөрөх болсон. Ийм учраас ихэнх бүтээгдэхүүн хуваах гэрээнд ашгийн тосыг хуваахдаа хөвөгч масштабыг ашигладаг болсон. Гадаадын нефтийн компанийн өгөөжийн хувь хэмжээнд суурилсан хөвөгч масштаб нэлээн үр дүнтэй гэдэг нь харагдсан. Энэхүү Р-фактор гэгч нь гэрээ илүү ашигт чиглэсэн болохыг илэрхийлдэг. Гэхдээ гэрээний үзүүлэлтүүдийн бүтэц муу бол газрын тосны үнэ хямд байх үед тэдгээр нь удаашруулах (эс урамшуулах) нөлөө үзүүлдэг. Хэрэв газрын тосны үнэ өндөр бол эдийн засгийн түрээсийн хэмжээ их байна. Засгийн газрын авах хэмжээ үлэмж боловч гадаадын нефтийн компанийн хувьд төсөл үр ашигтай бол муу бүтэцтэй схем ч гэсэн удаашралт биш.
7. Эдийн засгийн онолд бүтээгдэхүүн хуваах гэрээг гадаадын нефтийн компанийн хувьд үр дүнгүй, ашиггүй гэрээ гэж үздэг. Ийм учраас бүтээгдэхүүн хуваах гэрээ нь эдийн засгийн гэхээсээ илүүтэй улс төрийн гэрээ мөн.

**МОНГОЛ УЛС ДАХЬ УРАНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ, АШИГЛАЛТТАЙ
ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**
(Дүн шинжилгээ)

Ц.Болормаа, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

- I. Уран ашиглалтын эрх зүйн орчин
- II. Цацраг идэвхт хог хаягдалтай холбоотой эрх зүйн зохицуулалт

Хавсралт. Ураны хайгуул, олборлолт, ашиглалт, хаягдалтай холбогдох эрх зүйн орчны мэдээлэл

ОРШИЛ***Судалгааны зорилго***

Монгол Улс дахь ураны хайгуул, олборлолт, ашиглалттай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал, эрх зүйн баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоог тодруулахыг зорьсон болно.

Хамрах хүрээ

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн сангаас олон улсын гэрээ конвенц, хууль, бодлогын баримт бичиг, Үндэсний болон засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөө, салбарын дүрэм журам гэх мэт нийт 41 эрх зүйн баримт бичиг байх бөгөөд үүнээс хууль болон бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн хүрээнд судалгааны анализ хийлээ.

Судалгааны товч

Ураны хайгуул болон олборлолт, ашиглалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг дараах түвшнээр ангилж болохоор байна. Үүнд:

- 1) Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц
- 2) Монгол Улсын төрөөс баримтлах бодлого
- 3) Салбарын хууль тогтоомж
- 4) Салбарын дүрэм, журам
- 5) Үндэсний болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө
- 6) Холбогдох бусад хууль тогтоомж гэсэн 6 түвшинд хамаарагдаж байна. Үүнд:

Олон улсын гэрээ, конвенц-7, бодлогын баримт бичиг-5, салбарын гол хууль тогтоомж-4, салбарын үйл ажиллагаандаа баримтлах дүрэм журам-14, хөтөлбөр, төлөвлөгөө-4, холбогдох бусад хууль-7 буюу нийт 41 эрх зүйн баримт бичиг байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц нь

1. Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц
2. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ
3. Цөмийн ослыг нэн даруй мэдээлэх тухай конвенц
4. Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх тухай конвенц
5. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр

6. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол
7. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц

Тус салбарт Монгол Улсын төрөөс баримтлах бодлого

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Салбарын хууль тогтоомж

1. Цөмийн энергийн тухай хууль
2. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
3. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль
4. Хог хаягдлын тухай хууль

Салбарын дүрэм, журам

- Авто замын салбарт цөмийн хэмжүүр ашиглахад дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм
- Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ
- Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах заавар
- Барилгын материалыг цацрагийн хяналтанд хамруулах тухай журам
- Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам
- Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам
- Рентген кабинет, ионжуулагч туяа үүсгэгч аппарат төхөөрөмжийг ашиглах, суурилуулах болон рентген шинжилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм
- Хайгуулын ажлын тайлан хүлээн авах дотоод заавар
- Хайгуулын ажлын төлөвлөгөө хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмал олборлох уул уурхайн төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авахад тавигдах үндсэн шаардлагауд ба ТЭЗҮ хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэх уулын ажлын тайланг хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэх уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны дотоод заавар
- Цөмийн болон цацрагийн улсын хяналтын албаны дүрэм¹⁵⁹

Үндэсний болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө

1. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр
2. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
3. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
4. Монгол Улсыг үйлдвэржүүлэх Үндэсний хөтөлбөр /2009-2016 он/

¹⁵⁹http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=172&Itemid=105

Холбогдох бусад хууль тогтоомж

- Ашигт малтмалын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль

Судалгааны тайлан: Уран ашиглалтын эрх зүйн орчин, хог хаягдалтай холбоотой эрх зүйн орчин гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд үүнтэй хамаарах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн заалтуудыг түүвэрлэсэн хүснэгтийг хавсралтаар оруулсан болно.

Түүнчлэн уран ашиглалттай холбоотой эхний бүлэгт хайгуул, тусгай зөвшөөрөл, олборлолт ашиглалттай холбогдох эрх зүйн зохицуулалтын анхаарвал зохих зүйлүүдийг авч үзсэн болно.

I. УРАН АШИГЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цацраг идэвхт ашигт малтмалын салбарт хүчин төгөлдөр үйлчилж буй бүхий л эрх зүйн баримт бичиг нь уран ашиглах үйл ажиллагаанд чиглэгдсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д зааснаар “Ашигт малтмал ашиглах” гэдэг нь газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг ойлгоно гэж заасан байна. Иймд ашиглалт гэдэг ойлголтод:

- Олборлох
- Баяжуулах
- Үйлдвэрлэх
- Экспортлох буюу худалдан борлуулах үйл ажиллагаанууд багтана.

Цацраг идэвхт ашигт малтмалын салбарын эрх зүйн актуудаас Ашигт малтмалын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн талаар бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр болон салбарын холбогдох дүрэм, журам заавар, орд ашиглалтын Хөрөнгө оруулалтын гэрээ голчлон ашиглагдана. Судалгаанд хуулийн этгээд, татвар хураамж, гааль болон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бусад эрх зүйн зохицуулалтыг оруулаагүй болно. Иймд судалгааны энэ хэсэгт:

- Цөмийн энергийн тухай хууль
- Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр гэсэн гол 3 баримт бичгийн зохицуулалтыг нарийвчлан судлах бөгөөд холбогдох бусад эх сурвалжийн заалтыг мөн авч үзэх болно.

Түүнчлэн 2013 оны 11 сард төрийн өмчит “МонАтом” ХХК улсын хэмжээнд хэрэгжүүлж буй ураны төслүүдээс Дорнод аймгийн нутаг дахь Дулаан уул, Зөөвч овооны ордод Францын “Арева Майнз” компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байна. Тус гэрээгээр “МонАтом” компаниар төлөөлүүлсэн Монголын тал 34 хувийг эзэмшиж байгаа бөгөөд гэрээний талаарх бусад зохицуулалтыг судалгаанд хамруулах боломжгүй юм.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого: 2009 оны Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичиг юм. Тус бодлогын баримт бичгийн 3-ийн 2 болон 3 дугаар зүйлээр ашиглалттай холбоотой төрийн бодлогыг тодорхойлсон байна. Үүнд:

3.2.Олборлолт, боловсруулалт, баяжуулалт, тээвэрлэлт:

3.2.1.цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах, баяжуулах, цаашид цөмийн түлшний үйлдвэр байгуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.2.нөөц нь тогтоогдсон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглахад төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын адилаар тогтооно.

3.2.3.цацраг идэвхт ашигт малтмалын ордыг дагалдагч ашигт малтмалын хамт цогц байдлаар бүрэн ашиглах бодлого баримтална.

3.2.4.цацраг идэвхт агуулга өндөртэй нүүрс, нүүрсний үнс, фосфорит болон бусад ашигт малтмалаас дэвшилтэт техник технологи хэрэглэн цацраг идэвхт элементийг ялгаж ашиглана.

3.2.5.цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх бодлого баримтална.

3.2.6.цацраг идэвхт ашигт малтмалаас гаргаж авсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын болон олон улсын гэрээнд нийцүүлэн гагцхүү энхийн зориулалтаар экспортлоно.

3.2.7.цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах, ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох, тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн хяналтан дор явуулна.

Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах нөхцөлийн хувьд энэхүү бодлогын баримт бичигт зааснаар хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан дотоод, гадаадын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нийцсэн урт хугацааны гэрээ байгуулан, хамтран ажиллана гэж заасан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагч нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.3.2.1.Ерөнхий нөхцөл:

а/энэхүү бодлогын 1.4-т заасан нөлөө бүхий улстай харьцах тухай бодлого зарчимд нийцсэн;
б/Монгол Улсын нутаг дэвсгэрт олборлосон цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан;
в/цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийг хийх санхүүгийн чадавхтай;

г/цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн;
д/үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй.

3.3.2.2.Техник технологийн хувьд:

а/цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай;
б/цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой;
в/цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай;
г/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашигладаг.

3.3.2.3.Байгаль орчин, аюулгүй ажиллагааны хувьд

а/хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар туршлага хуримтлуулсан;
б/уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг;
в/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг явуулж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийдэг.

3.3.2.4.Нийгмийн асуудлаар:

а/бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог;
б/ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай;
в/компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн.

Цөмийн энергийн тухай хууль:-ийн 2 болон 4 дүгээр бүлгээр цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах салбар дахь төрийн зохицуулалт болон хөрөнгө оруулалтын гэрээний талаар заасан байдаг. Түүнчлэн цацраг идэвхт болон цөмийн ашиглалттай холбоотойгоор заавал хөндөгдөх сэдэв болох тусгай зөвшөөрлийн талаар энэ хуулийн 3-р бүлэгт заасан байдаг.

Тусгай зөвшөөрөл: Цацрагт идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага болон тусгай зөвшөөрөл олгох журам, өргөдөл гаргах журам, хугацаа түүнийг сунгах, төлбөр хураамж, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болох үндэслэл зэргийг энэ хуулийн 3-р бүлгээр зохицуулсан бөгөөд дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан байна. Үүнд:

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

15.1. Дараах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

- 15.1.1. Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;
- 15.1.2. Цөмийн төхөөрөмж ашиглах;
- 15.1.3. Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах;
- 15.1.4. Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;
- 15.1.5. Цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;
- 15.1.6. Цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;
- 15.1.7. Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх;
- 15.1.8. Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

Ашиглалттай холбоотой төрийн бодлого, эрх зүйн орчны хүрээнд дараах эргэлзээтэй асуудал байгааг анхаарна уу. Үүнд:

Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зааснаар *“Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох*” гэсэн нь Цөмийн энергийн тухай хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.7 *Идэрх хүснэгтээс үзнэ үү!* дахь заалттай зөрчилдөж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Цөмийн энергийн тухай хуулиар тогтоосон үйл ажиллагаа нь шар нунтагаас хэтэрсэн эсэх нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл “шар нунтагаас цааш үргэлжлэхгүй байх” гэдэг нь ямар утгыг илэрхийлж байгаа ойлголт болохыг, энэ ойлголтод цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой ямар ямар үйл ажиллагаа хамаарч байгаа болохыг нарийн тодорхойлох шаардлага тулгарч байна. Ямар тохиолдолд “шар нунтагаас цааш үргэлжилсэн” болохыг тодорхой тогтоох шаардлага байна.

Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль:-ийн 5 дугаар зүйлд цөмийн энерги, технологи ашиглах тухай дараах заалтууд бий. Үүнд:

“5.1. Цөмийн эрчим хүч, технологийг зөвхөн цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр анагаах ухаан, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэл, судалгаа зэрэг гагцхүү энхийн зорилгоор Монгол Улсын олон улсын гэрээний дагуу олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн ашиглана.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан зорилгоор болон Монгол Улсын хил орчимд хүн ам, байгаль орчны аюулгүй байдалд шууд нөлөөлөх буюу алсдаа сөргөөр нөлөөлж болзошгүй цөмийн шаар, аюултай хог хаягдал булшлах буюу хадгалуулахгүй байх талаар

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг /ОУАЭА/ болон олон улсын холбогдох бусад байгууллага, цөмийн хөтөлбөр бүхий улстай хамтран ажиллана.” гэж заасан нь цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн, өөрөөр хэлбэл цөмийн хянагдашгүй хэлбэрээс хамгаалсан эрх зүйн орны маш тодорхой хамгаалалт болсон.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр: Тус хөтөлбөрийн 2009 онд Засгийн газрын 222 дугаар тогтоолоор баталсан бөгөөд “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул хийх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, экспортын шинэ эх үүсвэрийг бий болгох, цөмийн энерги ашиглах замаар Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор баталсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 7 зорилт дэвшүүлсэн бөгөөд үүнээс 6 дахь зорилт буюу “Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих ажлын бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Үүнд:

- 4.6.1. Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, олон улсын байгууллагын санал зөвлөмжийг авч ажиллах;
- 4.6.2. Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих хөрөнгө оруулагчдыг мэргэжлийн тодорхой нөхцөл, шалгуурын дагуу сонгох;
- 4.6.3. Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг дэд бүтцийн хамт барьж байгуулах;
- 4.6.4. Цөмийн эрчим хүч ашиглахын ач холбогдол, эдийн засгийн үр нөлөө, байгаль экологийн ашиг тусыг олон нийтэд сурталчлан таниулах;
- 4.6.5. Гадаад орнуудад цөмийн энерги ашиглаж байгаа үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг судлан үзэхэд энхийн зорилгоор ашиглах ойлголтын хүрээн дэх бүх үйл ажиллагааг зөвшөөрсөн байгаа нь харагдаж байна.

Цацраг идэвхт ашигт малтмал олборлохоос эхлэн баяжуулах үйлдвэр, худалдан авалт болон худалдаа, цөмийн эрчим хүчтэй холбоотой бүх асуудлыг хуулийн хүрээнд зөвшөөрсөн байна.

Монгол Улсын нэгдэн орсон Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ болон түүнд нийцүүлэн гаргасан цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль зэрэг нь энхийн зорилгоор ашиглах эрх зүйн орчны баталгаа болж байгаа юм.

II. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Цөмийн хаягдал булшлах эсэх тухай асуудал нь өнөөдөр нийгэмд хүчтэй маргаан үүсгэж байгаа бөгөөд эрх зүйн орчны түвшинд хэрхэн зохицуулагдсаныг судалгааны энэ хэсэгт багтаав. Энэ асуудлыг судалснаар анхаарвал зохих дараах асуудал байна. Үүнд:

- а) Хаягдлын хүрээнд “цөмийн хаягдал” ба “цацраг идэвхт хаягдал” гэсэн 2 ойлголт байгаа нь хаягдлын эх үүсвэрийн хувьд өөр гаралтай ч хүрээлэн байгаа орчинд үзүүлэх үр дагаварын хувьд ижил эсэх ойлголтыг нэг мөр болгох. Нэг мөр болгох гэхийн учир хууль тогтоомж дахь “аюултай хог хаягдал” гэсэн тодорхойлолтод цацраг идэвхт хаягдал багтах бөгөөд цөмийн хаягдал гэсэн ойлголтыг нэр

томьёоны хувьд хуульчлан тогтоогоогүй боловч хууль болон хөтөлбөрүүдэд энэ нэр томьёо хэрэглэгдсэн байна. Тиймээс энэ 2 нэр томьёо нь нэг ойлголт уу, өөр өөр ойлголт уу гэдгийг хуулийн хүрээнд нэг мөр болгох нь чухал.

Түүнчлэн Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн зохицуулалтаар цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар тусгайлан үйлдвэрлэгдсэн *“цөмийн зэвсгийн хаягдал”* нь дээрх 2 хаягдлаас өөр ойлголт эсэхийг тодруулах.

- b) Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн баталснаар цөмийн хаягдал булшлахтай холбоотой эрх зүйн зохицуулалт тус хуулийн хүрээнд үгүй болсон. Харин цөмийн энергийн тухай хуулиар цацраг идэвхт хаягдал болон цөмийн хаягдалтай холбоотой зөвшөөрсөн агуулгатай зохицуулалтууд байгааг тайлангийн энэ хэсэгт оруулав.
- c) Цөмийн хаягдал булшлахтай холбоотой Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт Цөмийн энергийн тухай хуулийн хаягдалтай холбоотой заалттай зөрчилдөж байна гэж үзэх үндэслэл байна.
- d) Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуульд зааснаар цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэсэн тусгай ангиллын цацраг идэвхт болон цөмийн зэвсгийн хаягдал булшлах, тээвэрлэн өнгөрүүлэхийг хориглосон байна.

Цацраг идэвхт болон цөмийн хог хаягдалтай холбоотой эрх зүйн орчныг:

- Хууль болон олон улсын гэрээ, конвенц
- Хөтөлбөр

гэсэн үндсэн 2 түвшинд судлан үзсэнийг доорх судалгааны мэдээллээс үзнэ үү.

А) Хог хаягдалтай холбоотой олон улсын гэрээ болон дотоодын хуулийн зохицуулалт

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн аливаа хэм хэмжээнээс үзэхэд *“цацраг идэвхт хог хаягдал”* ба *“цөмийн хаягдал”*, *“цөмийн зэвсгийн хаягдал”* гэсэн 3 нэр томьёо хэрэглэгдэж байгаа нь харагдах бөгөөд *“Цөмийн энергийн хууль”*-нд **цацраг идэвхт хаягдал** гэх ойлголтыг нэр томьёоны хувьд тодорхойлон хуульчилсан бөгөөд **цөмийн хаягдал**, **цөмийн зэвсгийн хаягдал** гэх ойлголтыг тодорхойлсон эрх зүйн акт одоогоор үгүй байна.

Мөн 2012 онд шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн нэр томьёоны тайлбар хэсэгт аюултай хог хаягдал гэдэгт цацраг идэвхт хаягдлыг багтаан тодорхойлсон бөгөөд цөмийн хаягдлын тухай тодорхойлолт үгүй юм.

Цөмийн энергийн тухай хуулийн 3.1.16-д *“цацраг идэвхт хаягдал”* гэж *цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг ойлгоно*¹⁶⁰ гэж заасан.

Иймд энэ 2 нэр томьёогоор нэг зүйлийг нэрлэж байна уу, 2 өөр ойлголт уу, хор аюулын шинж чанараар ялгаатай эсэх, байгаль орчин болон хүн, амьтан ургамалд үзүүлэх сөрөг нөлөө, хор уршгийн ялгаа гэх мэт асуудлыг нэг мөр болгох нь ач холдогдолтой байна.

1. Хог хаягдалтай холбоотойгоор Монгол Улсын нэгдэн орсон конвенц:

Монгол Улс 1996 оны 12 сард “Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц”-д нэгдэн орсон байна. Гэвч тус конвенцийн оршил хэсэгт зааснаар:

¹⁶⁰Цөмийн энергийн тухай хууль. 2009 он., Төрийн ордон.

Цацраг идэвхт чанартайн улмаас олон улсын хяналтын бусад систем, түүний дотор цацраг идэвхт материалд тусгайлан хэрэглэгддэг олон улсын гэрээ хэлэлцээрт хамаарагдах хог хаягдлууд энэхүү Конвенцид үл хамаарна.

гэсэн нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг устгах, булшлах аливаа харилцааг зохицуулахгүйг илэрхийлж байна. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон 138¹⁶¹ гэрээ, конвенцид цацраг идэвхт материалын хог хаягдалд хамаарах гэрээ хэлэлцээр байгаагүй нь одоогийн байдлаар олон улсын гэрээ, конвенцийн түвшинд цацраг идэвхт болон цөмийн хаягдлын импорт болон хадгалалтын асуудал нээлттэй гэдгийг харуулж байна.

2. Хог хаягдалын тухай хуулийн хүрээнд:

Цацраг идэвхт болон цөмийн хог хаягдлын хувьд 2000 оны 11 сарын 03-ны өдөр батлагдсан “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль”-иар зохицуулдаг байсан боловч 2012 оны 5 дугаар сарын 17-ы өдөр тус хуулийг хүчингүй болгож оронд нь “Хог хаягдлын тухай” хуулийг шинэчлэн найруулж мөн өдөр баталсан байна.

Хүчингүй болсон энэ хуулийн 3-р зүйлд аюултай хог хаягдлыг тодорхойлоод улмаар аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох гэсэн 4-р зүйлд:

4.1. Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.
4.2. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно

зэрэг цацраг идэвхт болон цөмийн хаягдал булшлахыг хориглосон заалт байсан бөгөөд Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад энэ зүйл заалтыг хассан байна.

Тодруулбал шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн 3-р зүйл буюу хуулийн нэр томьёоны тодорхойлолтын 3.1.3 дахь заалтад:

3.1.3. “аюултай хог хаягдал” гэж хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхтэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хий хэлбэрийн хог хаягдлыг ойлгоно.

гэж тодорхойлсон боловч тус хуулийн 4-р зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлохдоо:

4.1.Энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна.

гэж заасан.

Үр дагавар: Ингэснээр **“Хог хаягдлын тухай” хуулийн бүх заалтууд цацраг идэвхтэй хог хаягдалд үйлчлэхгүй болж байна.** Шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн 17-р зүйлийн 1 болон 2 дахь заалтад аюултай хог хаягдлыг Монгол Улсад импортоор оруулах, хил дамжуулан тээвэрлэхийг хориглосон боловч дээр хэлсэнчлэн 4-р зүйлийн 1 дэх заалтын дагуу энэ хориглолт нь цацраг идэвхт хог хаягдалд үйлчлэхгүй.

¹⁶¹<http://www.legalinfo.mn/annex/details/6?lawid=307>

3. Цөмийн энергийн тухай хуулийн хүрээнд:

Цөмийн энергийн тухай хуульд цөмийн болон цацраг идэвхт хаягдалтай холбоотой дараах заалтууд байна. 3 дугаар зүйлд заасан нэр томъёоны хэсэгт “цацраг идэвхт хаягдал булшлах” ойлголтыг тодорхойлохдоо “... зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлахыг ойлгоно”¹⁶² гэжээ.

Хуулийн 9 дүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн тухай заалтын:

9.1.7.Цөмийн төхөөрөмж барих газрын байршлыг сонгох;
9.1.8.Цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

гэсэн заалт байгаа юм.

Энэ заалт нь судалгааны дараагийн хэсэгт гарах Засгийн газрын Хөтөлбөрийн заалтуудтай зөрчилдөж байх бөгөөд /В хэсгээс үзнэ үү/ үүнтэй ижил зохицуулалт тус хуулийн 11.3, 11.6.6, 15.1.4, 15.1.7, 15.1.8, 42-р зүйлүүдэд цөмийн болон цацраг идэвхт хаягдалтай холбоотой дараах зохицуулалт хуульчлагдсан байна.

Эдгээр зохицуулалтыг нэг бүрчлэн авч үзвэл:

11.3.Төрийн захиргааны байгууллага нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна.

11.6.6.Цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

15.Тусгай зөвшөөрөл авах

15.1.4.Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;

15.1.7.Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх;

15.1.8.Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

42 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад тавих үндсэн шаардлага

42.1.Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

42.2.Цөмийн болон цацраг идэвхт материалыг улсын байцаагчийн дүгнэлт, тусгай зөвшөөрөлгүйгээр булшлах, хаягдал болгохыг хориглоно.

42.3.Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:

42.3.1.Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг чанд мөрдөх;

42.3.2.Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлах ажлыг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэх.

42.4.Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

¹⁶²Цөмийн энергийн тухай хуулийн 3.1.22 дахь заалт.

Ингэж зааснаар цөмийн хаягдал булшлах хийгээд цацраг идэвхт хаягдал булшлахтай холбоотой харилцаа нь салбарын хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн байх бөгөөд эдгээр заалт болон Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалттай зөрчилдөж байгааг судалгааны тайлангийн В хэсгээс үзнэ үү.

4. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн хүрээнд:

Тус хуулийн нэр томъёоны хэсэгт "цөмийн зэвсэг" гэж цөмийн хянагдашгүй эрчим хүч гаргаж дайны зориулалтаар ашиглаж болох цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг ойлгоно гэсэн байдаг. Тэгвэл үүнтэй холбоотой цөмийн зэвсгийн хаягдал булшлах, дамжуулан тээвэрлэхийг хориглосон дараах зохицуулалт байна. Үүнд:

- 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цөмийн зэвсэгтэй холбогдсон дараах үйлдэл, үйл ажиллагааг явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглоно:
- 4.1.1. цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлгах;
 - 4.1.2. цөмийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх;
 - 4.1.3. цөмийн зэвсгийг турших буюу хэрэглэх;
 - 4.1.4. цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах.
- 4.2. Цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно.

В) Холбогдох хөтөлбөрүүд дэх хаягдлын зохицуулалт

Засгийн газрын болон тус салбарын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хаягдлын талаарх дараах заалт байна. Үүнд:

"Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2-р бүлэгт:

- Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх **цацраг идэвхт болон химийн хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгох;**
- Монгол Улсын нутаг дэвсгэрт **цөмийн хаягдал булшлахыг хориглоно;**

гэж заасан нь ч тус заалт нь 2021 он хүртэл хэрэгжих "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн 4.3.5-р заалт болон Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 42 дугаар зүйлийн холбогдох заалттай зөрчилдөж байна. /тайлангийн 10 дугаар нүүрэн дэх хүснэгтээс үзнэ үү/

"Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн 4.3.5-д:

Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж байгуулах.

гэж заасан нь хөтөлбөрүүдийн түвшинд хаягдалтай холбоотой заалтууд зөрчилдөж байна.

ХАВСРАЛТ.

Ураны хайгуул, олборлолт, ашиглалт, хаягдалтай холбогдох эрх зүйн орчны мэдээлэл

1. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ			
№	Конвенцийн нэр, нэгдэн орсон огноо	Үндсэн зохицуулалт	Тайлбар
1	Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц 1986 онд нэгдэн орсон	Энэхүү конвенцид оролцогч улсууд цөмийн энергийг энх тайвны зорилгоор хөгжүүлэх, хэрэглэх бүх улсын эрх, цөмийн энергийг энх тайвны зорилгоор хэрэглэснээс үүдэж ашиг олох тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, цөмийн энергийг энх тайвны зорилгоор ашиглах олон улсын хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх шаардлагатай гэдэгт итгэж, цөмийн материалыг хууль бусаар эзэмшиж ашигласнаас гарч болох ослоос урьдчилан сэргийлэхийг эрмэлзэж, цөмийн материалтай холбогдолтой гэмт хэрэг бол ноцтой сэтгэл түгшээсэн зүйл бөгөөд ийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийтгэх үр дүнтэй, зохих ёсны арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай гэдэгт итгэж, оролцогч улс бүрийн үндэсний хууль тогтоомж, энэхүү конвенцийн дагуу цөмийн материалыг биечлэн хамгаалах үр дүнтэй арга хэмжээ боловсруулахын тулд олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлагатай байгааг ухамсарлаж, энэхүү конвенц цөмийн материалыг аюулгүй зөөвөрлөхөд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж, дотоодын хэрэгцээнд ашиглах, хадгалах, тээвэрлэхэд цөмийн материалыг биечлэн хамгаалахын чухлыг мөн цохон тэмдэглэж, цэргийн зорилгоор ашиглаж буй цөмийн материалыг үр дүнтэй биечлэн хамгаалахын чухлыг хүлээн зөвшөөрч, ийм материал нь биечилсэн хатуу чанд хамгаалалтад байгаа хийгээд цаашид энэ хэвээр байх ёстойг ойлгож, дараах зүйлийг хэлэлцэн тохиров.	
2	Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ 1963 он	Энэхүү гэрээнд оролцогч цөмийн зэвсэгтэй улс гүрэн бүр цөмийн зэвсэг буюу цөмийн бусад дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэл, мөн ийм зэвсэг буюу дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэлд тавих хяналтыг шууд ба шууд бусаар хэнд ч үл дамжуулах, үүний нэгэн адил цөмийн зэвсэг буюу цөмийн бусад дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэл үйлдвэрлэх буюу ямар нэгэн аргаар олж авах хийгээд ийм зэвсэг буюу дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэлд тавих хяналтыг гартаа авах явдалд цөмийн зэвсэггүй ямар нэг улсад ямар нэг замаар туслах, өөгшүүлэн дэмжих, өдөөн ятгахгүй байх үүрэг хүлээнэ.	

3	Цөмийн ослыг нэн даруй мэдээлэх тухай конвенц 1987 он		
4	Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх конвенц 1987 он	Нэгдүгээр зүйл. Ерөнхий заалт Оролцогч улсууд өөр хоорондоо болон Олон улсын атомын энергийн агентлагтай цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд түүний хор уршгийг аль болох багасгаж хүний амь, эд хогшил, байгаль орчныг гадагш алдагдсан цацраг идэвхт бодисын нөлөөнөөс хамгаалахын тулд хамтран ажиллана.	Нэг тогтоолын хавсралтаар зэрэг баталсан байна.
5	Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр 1972 он		
6	Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол 2001 он		
7	Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	<p>Конвенцийн үйлчлэх хүрээ Энэхүү Конвенцид хил дамжуулан тээвэрлэх объект болох дор дурдсан хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” гэж үзнэ: а/Хог хаягдал нь нэгдүгээр хавсралтын аль нэг ангилалд орсон боловч . . . дугаар хавсралтад заасан аливаа шинж чанарыг агуулаагүй бол; б/Хог хаягдал нь /а/ хэсэгт хамаарахгүй боловч экспортлогч, импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу аюултай тогтоогдсон буюу аюултайд тооцогддог бол. Хил дамжуулан тээвэрлэж байгаа хаягдал нь энэхүү Конвенцийн 2 дугаар хавсралт дахь аль нэг ангилалд хамаарагдаж байгаа бол түүнийг “бусад хог хаягдал” гэж үзнэ. Цацраг идэвхт чанартайн улмаас олон улсын хяналтын бусад систем, түүний дотор цацраг идэвхт материалд тусгайлан хэрэглэгддэг олон улсын гэрээ хэлэлцээрт хамаарагдах хог хаягдлууд энэхүү Конвенцид үл хамаарна. Далайн тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагааны явцад гардаг болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт тусгагдсан хог хаягдлууд энэхүү Конвенцид мөн үл хамаарна.</p>	Монгол Улсын нэгдэн орсон энэхүү гэрээгээр цацраг идэвхт хог хаягдал энэхүү гэрээний үйлчлэх хүрээнээс гадуур байгаа бөгөөд ингэснээр Цацраг идэвхт хог хаягдлын талаарх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ			
№	Баримт бичгийн нэр, огноо	Үндсэн зохицуулалт	Тайлбар
1	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	<p>3.2.4.Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого</p> <p>3.2.4.1.Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.</p> <p>3.2.4.4. Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.</p> <p>3.5.4. Хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах</p> <p>3.5.4.3.Хог хаягдлаас эрчим хүч, нөөц баялаг, түүхий эд бий болгох технологи бүхий үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. Аюултай хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хортой, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлнэ.</p> <p>3.5.4.5.Химийн хорт болон аюултай бодис, биологийн гаралтай материал, ионжуулагч цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмалтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хяналтын чадавхыг бэхжүүлнэ.</p>	Үзэл баримтлалын урантай холбогдох эдгээр заалт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.
2	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого	<p>5.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого</p> <p>5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого</p> <p>Өндөр технологт тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох санхүүгийн чадамж, хуримтлалыг бүрдүүлнэ.</p> <p>Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</p> <p>Стратегийн зорилт 1. Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлогыг баримтална:</p> <ul style="list-style-type: none"> Оюу толгойн зэс, алтны, Цагаан суваргын зэсийн, Таван Толгойн нүүрсний, Асгатын мөнгөний, Цавын полиметаллын, Төмөртэйн төмрийн хүдрийн, Чойр-Нялгын нүүрс, битумын, Цайдамын хүрэн нүүрсний, Мардай, Гурванбулагийн ураны болон бусад томоохон стратегийн орд газруудыг ашиглаж эхлэх; Эдийн засгийн хувьд үр ашиг багатай ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; 	

3	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого	<p>8 зүйл бүхий бодлогын баримт бичиг бөгөөд</p> <ul style="list-style-type: none"> • Нийтлэг үндэслэл • Бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зарчим • Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт • Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагаа • Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа • Эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, хүний нөөц • Эрх зүйн орчин <p>Салбарын удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаа гэсэн үндсэн 8 зүйлд тус баримт бичгийн зохицуулалт багцлагдсан бөгөөд судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.</p>	
4	Монгол Улсын төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025/	<p>4 зүйл бүхий бодлогын баримт бичиг нь бүх төрлийн эрдэс баялгийн хайгуул, олборлолт, ашиглалт, үйлдвэрлэлд хамаарах ерөнхий бодлогыг тодорхойлсон бөгөөд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, үйлдвэрлэлийн талаар нэр цохсон зохицуулалт үгүй.</p> <p>3.2.2.6.-д Монгол Улсад гүйцэтгэж байгаа төрөл бүрийн геологийн судалгаа /байгалийн рашаан, гидрогеологийн судалгаа, байгалийн хий, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, инженер геологи гэх мэт/-ны мэдээлэл, нөөц, үр дүнгийн тайланг үндэсний геомэдээллийн нэгдсэн санд хамруулж улсын бүртгэлд авах тухай заасан бөгөөд бодлогын баримт бичгийн бусад заалтууд бүх төрлийн эрдэс баялгийн салбарт баримтлагдана.</p>	Ерөнхий зохицуулалт бүхий эрдэс баялгийн салбарын бодлого
5	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	<p>Зорилт-11. Агаарын бохирдол, орчны доройтлыг бууруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэн, газар нутгийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бэхжүүлнэ.</p> <p>11.2. Аюултай хог хаягдлыг устгах байгууламж байгуулах, хогийн төвлөрсөн цэг байгуулах бэлтгэл хангах;</p>	Хог хаягдлын тухай хуулиар аюултай хог хаягдал гэдэг ойлголтод цацраг идэвхт хаягдал багтана.
3. ХУУЛЬ			
№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Тайлбар
1	Цөмийн энергийн тухай хууль 2009 он	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
2	Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2009 он	1. Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шинэчлэн бүртгэнэ.	

3	Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль 2000 он	<p>1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйл болох Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь, түүний дотор агаар мандал, газар, ус, газрын хэвлийг цөмийн зэвсгээс ангид байлгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цөмийн зэвсэгтэй холбогдсон дараах үйлдэл, үйл ажиллагааг явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглоно:</p> <p>4.1.1. цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлгах;</p> <p>4.1.2. цөмийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх;</p> <p>4.1.3. цөмийн зэвсгийг турших буюу хэрэглэх;</p> <p>4.1.4. цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах.</p> <p>4.2. Цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно.</p>	
4	Ашигт малтмалын тухай хууль 2006 он	4.1.2.“цацраг идэвхт ашигт малтмал” гэж уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;	
5	Хог хаягдлын тухай хууль 2012 он	<p>1.1.3. “аюултай хог хаягдал” гэж хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхтэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хий хэлбэрийн хог хаягдлыг ойлгоно.</p> <p>4.1.Энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна.</p>	
6	Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 он	4.7. Цөмийн энергийн салбарт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад энэ хуулийн 20 дугаар зүйл хамаарахгүй бөгөөд уг харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар ² зохицуулна.	
7	Эрчим хүчний тухай хууль 2001 он	<p>2.3.Цөмийн эрчим хүч ашиглахтай холбогдсон харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.</p> <p>3.1.23.“цөмийн эрчим хүчний нөөц” гэж эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор цөмийн эрчим хүчний эх үүсвэрт ашиглаж болох цөмийн түлшийг;</p> <p>3.1.24.“цөмийн эрчим хүч” гэж цөмийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн эрчим хүчийг;</p> <p>3.1.25.“цөмийн эрчим хүчний эх үүсвэр” гэж цөмийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж эрчим хүч үйлдвэрлэж байгаа байгууламжийг;</p> <p>4-р зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх</p> <p>4.1. Улсын Их Хурал эрчим хүчний талаарх төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.</p>	

4. ХӨТӨЛБӨР			
№	Хөтөлбөрийн нэр, огноо	Холбогдох зохицуулалт	Тайлбар
1	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 2012 он	<p>1. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах бодлогыг хэрэгжүүлнэ: Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар дараах зорилтыг хэрэгжүүлнэ: - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах; 2. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхт болон химийн хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгох; - Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булшлахыг хориглоно; - Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох</p>	
2	Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2012 он	<p>43.6 Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. 43.7 Цацраг идэвхт ашигт малтмалын орд газруудыг түшиглэн Дорноговь, Дундговь, Дорнод аймгуудад боловсруулах үйлдвэр барьж байгуулах ажлыг зохион байгуулна 43.8 Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцсэн, үндэсний мэдээллийн санг бүрдүүлнэ. 268 Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булшлахыг хориглох 268.1 Ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай конвенцид нэгдэн орж Цөмийн хаягдлын талаар Монгол Улсын баримталж байгаа бодлого, хууль эрх зүйн холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг хангана. 268.2 Хилийн боомтууд дахь цацрагийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, хүний нөөцийн чадавхийг сайжруулна. 269 Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох 269.1 Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулна.</p>	

3	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр /2009-2021 он хүртэл/	<p>Хөтөлбөрийн зорилго.</p> <p>2.1.Хөтөлбөрийн зорилго нь “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул хийх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, экспортын шинэ эх үүсвэрийг бий болгох, цөмийн энерги ашиглах замаар Монгол Улсын эрчим хүний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.</p> <p>4.3.3. Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, баяжуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, олон талын оролцоотой үйлдвэр байгуулах</p> <p>4.3.5. Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж байгуулах</p> <p>4.3.6. Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг дэд бүтцийн хамт барьж байгуулах</p>	Тус хөтөлбөр нь 8 зүйлтэй, 2021 он хүртэл хэрэгжинэ. Үүнээс анхаарвал зохих заалтыг түүн оруулсан ба учир нь уг хөтөлбөрийн заалтууд Засгийн газрын 2012-2016 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалттай зөрчилдөж байна.
4	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр /2009-2016 он/	<p>Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>14.25 Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, баяжуулах үйлдвэр байгуулах.</p>	

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Олон улсын гэрээ, конвенц:

1. Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц. 1986 он.
2. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ. 1963.
3. Цөмийн ослыг нэн дариу мэдээлэх тухай конвенц. 1987он.
4. Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх тухай конвенц 1987он.
5. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр. 1972 он.
6. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол. 2001 он.
7. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц. 1996 он.

Хууль:

8. Цөмийн энергийн тухай хууль
9. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
10. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль
11. Хог хаягдлын тухай хууль
12. Ашигт малтмалын тухай хууль
13. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
14. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
15. Газрын тухай хууль
16. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
17. Эрчим хүчний тухай хууль
18. Хөрөнгө оруулалтын тухай хууль

Бодлогын баримт бичиг:

19. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
20. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
21. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
22. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого
23. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Хөтөлбөр:

24. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, 2009
25. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үй ажиллагааны хөтөлбөр, 2012
26. Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2012
27. Монгол Улсыг үйлдвэржүүлэх Үндэсний хөтөлбөр /2009-2016 он/

Ашигласан мэдээллийн сан:

28. УИХ-ын Тамгын газрын дотоод сүлжээний хуулийн сан
29. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
30. Цөмийн энергийн газрын вэб хуудас:
http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=52&Itemid=108
31. Засгийн газрын вэб хуудас: www.zasag.mn

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗРЫН ТОСНЫ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**
(Харьцуулсан судалгаа)

Г.Билгээ, Ч.Онончимээ

АГУУЛГА

Оршил

1. Судалгааны үр дүн, санал, зөвлөмж
2. Газрын тосны эрх зүйн зохицуулалтын чиг хандлага, ангилал
3. Гадаадын зарим орны газрын тосны эрх зүйн зохицуулалт
 - 3.1. Норвеги
 - 3.2. Казахстан
 - 3.3. ОХУ

4. Дүгнэлт

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Захиалагчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний эрх зүйн харилцааг дараах байдлаар тодруулан авч үзэхийг зорьсон болно.

- Газрын тосны хууль, эрх зүйн зохицуулалт;
- Газрын тосны өмчлөлийн асуудал, газрын тосны эрх зүйн зохицуулалт төрийн оролцоо, эрх хэмжээ;
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх зүйн зохицуулалт;
- Тусгай зөвшөөрөл, хуулийн хариуцлага, хохирол нөхөн төлөх асуудлыг хэрхэн зохицуулсан талаар зэрэг болно.

Хамрах хүрээ

Судалгааны явцад дараах улс орнуудын ашигт малтмалын хуулиудыг харьцуулан судалсан болно. Үүнд:

- Норвеги: Газрын тосны үйл ажиллагааны тухай хууль, 1996 он,
- Казахстан: Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль, 2010 он,
- Орос: Газрын хэвлийн тухай хууль, 1992 он.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгаанаас үзэхэд газрын тос өнөөдөр хамгийн чухал түүхий эдийн тоонд зүй ёсоор орж байна. Тийм ч болохоор түүнийг эзэмших, захиран зарцуулах эрхийн төлөөх тэмцэл улс гүрнүүд, бизнесийн бүлэглэлүүдийн дунд 200 гаруй жил үргэлжилсээр байна. 2011 оны байдлаар дэлхийн хэмжээгээр 1383,2 тэрбум баррель газрын тосны нөөц байгаа гэсэн тооцоо байх бөгөөд газрын тосны нөөцийн хэмжээг судлаач бүр өөр өөрөөр тогтоодог.

Газрын тосны хууль тогтоомжийн хүрээнд тухайн улс оронд явагдаж ирсэн газрын тосны үйл ажиллагааны түүхэн хандлага, түүнд баримталдаг хууль тогтоомжуудын онцлогоос хамаарч хууль тогтоомж, горимууд нь маш өргөн агуулга хүрээг хамарсан,

эсхүл тухайн хууль нь товчхон бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийн тулд дагалдсан төрөл бүрийн эрх зүйн актаар журамласан байдаг.

Гэвч нийтлэг нэг баримталдаг зарчим нь газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт явуулах үйл ажиллагааны туршид тухайн орон нутаг хийгээд бүс нутгийн хэмжээнд байгаль орчин, нийгмийн бусад асуудлаар оршин суугчид, нийгэм олон нийтэд үзүүлж болзошгүй сөрөг үр дагавар, нөлөөллүүдийг урьдчилсан тооцсон байх шаардлагатай. Тухайлбал, ОХУ-ын хууль тогтоомжоор энэ асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Энэ асуудал ялангуй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц тогтолцоо нь холбооны улсын байдлаар зохин байгуулагдсан улсуудад нэн чухлаар тавигддаг байна. Учир нь холбооны улсын хувьд газрын тос, байгалийн хийн нөөцийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон асуудлыг тухайн муж улс, эсхүл орон нутгийн засаг захиргааны хүрээнд шийдвэрлэн зохицуулж байх зарчим үйлчилдэг байна.

Норвегийн Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн үзэл баримтлалаас үзэхэд, улс орны бие даасан байдал ба ашигт малтмалын салбарын бодлогын анхаарал хандуулах гол асуудал нь орон нутаг, бүс нутаг болон муж улсад хамгийн үр ашигтай байх шаардлагыг хангасан байх ёстой гэсэн агуулга тусгагдсан байна. Норвегид газрын тос олборлох лицензийг дагалдуулан хайгуулын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг ч мөн олгодог байна.

1. Газрын тосны эрх зүйн зохицуулалтын чиг хандлага, ангилал

Газрын тосны хайгуул, олборлолттой холбоотой хууль эрх зүйн орчин, холбогдох хууль тогтоомжуудыг харьцуулан судлахад хуульчилсан арга, хэлбэр талаасаа улс орон бүрд янз бүр байх ба агуулга, зохицуулалтууд нь нэн ялгаатай байна. Эдгээрийг эрх зүйн тогтолцоо болон зохицуулалт талаас нь авч үзвэл дараах байдлаар ангилан авч үзэж болох юм. Үүнд:

- Тухайн хууль тогтоомжоор зохицуулалтуудыг бүхэлд нь нарийвчлан тусгасан тогтмол агуулга бүхий хатуу зохицуулалттай **/fixed content system or freezing provisions/** гэрээ, эрх зүйн тогтолцоо;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх бүхий л төрлийн үйл ажиллагааг нийтэд нь хамруулан хэлэлцээр явуулах гэрээний эрх зүйн тогтолцоо **/agreement system/**, эсхүл шууд хэлэлцэн тохиролцох хэлэлцээр **/direct negotiating/-**ийн арга
- Гэрээ хэлэлцээрийн эрх зүйн дээр дурдсан хоёр төрлийн тогтолцоонд хоёуланд нь суурилж, тэдгээрийн аль аль нөхцөлүүдийг харгалзан үзэх завсрын агуулга бүхий уян хатан эрх зүйн тогтолцоо **/flexible content system/** буюу холимог эрх зүйн тогтолцоо **/hybrid system/**

Мөн түүнчлэн газрын тосны эрх зүйн зохицуулалтыг чиг хандлагаар нь, ашигт малтмал, газрын тосны өмчлөлийн харилцаанаас хамааруулан эрдэс баялгийн төрийн өмчлөлд байх үе дэх эрх зүйн зохицуулалт, хайгуулаар илрүүлж, нөөц тогтоохын өмнөх үе буюу эрдэс баялгийн өмчлөгч тодорхой бус байх үеийн эрх зүйн зохицуулалт, мөн зарим улс орны шашны номлолд тусгасан Исламын бүсэд баримтлах эрх зүйн чиг хандлага зэргээр нь авч үзэж болох юм.

- Эрдэс баялаг төрийн буюу улсын өмчлөлд байх ухагдахуунд суурилсан хуулийн тогтолцоо **/Domanial Law System/-**ны онцлог нь эрдэс баялгийн нөөцийн хайгуул, олборлолтын үйл ажиллагааг газар нутаг дээрээ явуулж байгаа тухайн муж улсын хувьд энэхүү үйл ажиллагаанд улсын зүгээс тавих шаардлага, баримтлах

нөхцөлүүд, эрдэс баялгийн зүйлийг өмчлөх тогтолцоо нь тогтсон хэв загвартай, тогтвортой стандарчлагдсан байдаг байна. Энэ тогтолцооны сонгодог жишээ нь АНУ юм. Мөн түүнчлэн Зүүн Европын орнууд, Мексик, Чили, Бразил, Аргентин зэрэг орнууд нь энэ чиглэлээр өөрийн гэсэн практик туршлага хуримтлуулсан бөгөөд төрийн зүгээс эрдэс баялгийн салбарт давамгайл эрхтэй оролцдог тул газрын тосны үйл ажиллагаа, ялангуяа техникийн болон санхүүгийн чиглэлээр туслан гүйцэтгэх ажил, үйлчилгээнд хувийн салбарын оролцоог хязгаарладаг байна.

- Хайгуулаар илрүүлж, нөөц тогтоохын өмнөх үеийн эрдэс баялгийн өмчлөгч тодорхой бус байх ухагдахуунд суурилсан хуулийн тогтолцоо **/Regalian system/**-ны үндсэн зарчим ашигт малтмалын тогтоосон нөөц хөрөнгийг өмчлөх эрх нь бүрэн олгогдоогүй, өмчлөгч нь тодорхойгүй байх үед төрийн зүгээс эрдэс баялгийн нөөцийг эзэмших, ашиглалт явуулах эрх, чиг үүргийг тодорхойлсон тусгайлан горимыг үндсэн хоёр аргаар тогтоож өгдөг.
 - Тухайн муж болон улс нь ашиглалт явуулах том хэмжээний эрдэс баялгийн ордод тэрхүү эрдэс баялгийг хэн түрүүлж хайгуул хийж илрүүлэн нөөц тогтоосон байна, тэр этгээдэд өмчлөх эрх олгож, ашиглалт явуулах баталгаа өгдөг байна. Төрийн зүгээс ийнхүү хайгуул хийж, олж тогтоосон нөөцийг олборлох эрхийг хэрхэн олгох, ямар журмаар ашиглуулах нөхцөлийг урьдчилан тодорхойлсон байдаг. Эрдэс баялгийн нөөцийг олж илрүүлэх болон түүний дараа төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны горимыг ийнхүү тогтоох нь хайгуулын үе шатанд болон түүний дараа олборлох эрх эзэмшигчийг шилж сонгох үйл ажиллагаанд төрийн зүгээс давуу эрхтэй оролцох байдлыг хязгаарлагдсаараа онцлогтой.
 - Төрийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх горим болон түүний эрх зүйн зохицуулалтын механизмуудыг хуулиар тогтоож, аль оновчтойг нь хэрэглэх эрх мэдэлтэй байх зарчим байна. Үүнийг төрийн “бие даасан эрх хэмжээ” гэж нэрлэх бөгөөд жишээ нь, газрын тосны хайгуулын шатанд төрийн эрх бүхий байгууллагын зүгээс хайгуулын ажлыг гүйцэтгэх эрх авсан этгээдийн үйл ажиллагааны явц байдалд хяналт тавих, ажиглалт явуулах, байгалийн эрдэс баялгийн нөөцийг аль болох бүрэн хэмжээнд тогтооход нь дэмжлэг үзүүлэх зэргээр оролцдог байна.
- Исламын бүсэд баримтлах чиг хандлага **/The Islamic perspectives/**. Энэ бүсийн орнуудад бизнес, худалдаа-арилжааг дэмжих болон гэрээ хэлэлцээрт чөлөөтэй оролцох, газар болон хөдлөх хөрөнгийн хувийн өмчийн эрхийг хамгаалахыг дэмжсэн агуулгыг баримталдаг хуулийн зохицуулалттай. Коран судрын агуулгад гэрээ бол улсын, хувийн салбар, албан тушаалтнуудыг оролцуулаад гэрээнд оролцогч талуудын аль алиныг төлөөлөх, талуудын харилцан итгэл хүлээсэн байх үзэл санааг агуулсан байхыг тусгасан байдаг. Ашигт малтмалын өмчлөлийн эрх зүйн харилцаанд шариатын хууль-номлолыг үндэс болгодог.

Дэлхийн ихэнх улс орны хувьд байгалийн баялаг, ашигт малтмалын нөөцийг тухайн улсын нэрийн өмнөөс өмчлөгч этгээд хэн байх, хэрхэн өмчлүүлэх, түүгээр дамжуулан ашигт малтмалыг олборлуулах, ашиглуулах, хуульчлан тогтоосон горимыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага тооцох, ашигт малтмал ашиглах эрхийг нь дуусгавар болгох, шилжүүлэх, ашигт малтмалын нөөц ашиглах этгээдээс ашигт малтмал ашигласны төлбөрийг улсын орлогод авах, уг орлогын удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг Үндсэн хуулиараа зохицуулсан байдаг байна. Нийт 152 орны Үндсэн хуулийн хүрээнд энэ чиглэлээр хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд¹⁶⁴:

¹⁶⁴Elliff v. Texon Drilling Co., 146 Tex.575, page 582.

- Хуучин социалист орнууд, мөн Энэтхэг, Мексик, Перу, Габон зэрэг зах зээлийн эдийн засагт шилжсэн орнуудын хувьд тодорхой нэр төрлийн эрдэс баялгийн нөөцийг улсын өмчлөл, мэдэлд байлгах харилцааг Үндсэн хуулиараа хуульчлан тогтоосон байдаг. Харин ашигт малтмалын тодорхой төрлүүдийг улсын өмчлөлд үе уламжлан байлгах асуудлыг салбар хуулиуд болон гүйцэтгэх засаглалын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрээр зохицуулсан байдаг байна.
- Зарим эрдэс баялгийн нөөцийг өмчлүүлэх эрхийг Үндсэн хуулиндаа хүлээн зөвшөөрсөн байна. Хэрэв хувийн өмчлөлд байгаа ашигт малтмалын нөөцийг улсын өмчлөл, мэдэлд шилжүүлэн авсан бол түүний төлөө нөхөн олговор олгож байх тухай ерөнхий нөхцөлийг судалгаанд хамрагдсан 152 орны 93 улс нь Үндсэн хуульдаа тусгасан байна.

Газрын тосны харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн үндсэн гурван хэлбэр байдаг. Үүнд:

1/ Тогтмол агуулга бүхий хатуу зохицуулалттай эрх зүйн тогтолцоо - Энэ нь тухайн орны үндэсний хэмжээнд үйлчлэх хууль тогтоомжид тухайн гэрээнд оролцогч талуудын эрх үүргийг нарийвчлан тусгаж өгдгөөрөө онцлогтой. Ийм төрлийн хууль тогтоомжийн хэлбэрийг АНУ, Канад, Австрали, Латин Америкийн орнууд, Дани, Франц, Герман, Голланд, Их Британи, Норвеги зэрэг орнууд хэрэглэдэг байна.

Энэ хэлбэр нь газрын тосны хайгуул, олборлолттой холбоотой бүх төрлийн гэрээний нөхцөлүүдийг салбар хуульдаа тусгасан бөгөөд зарим нэг нөхцөлийг тусгайлан журамладаг байна. Энэхүү тогтолцоо нь хайгуул, олборлолтын гэрээнд оролцогч талуудад адил тэгш нөхцөлүүдийг бүрдүүлдгээрээ давуу талтай. Хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын тогтмол агуулгатай хатуу хэлбэрийг газрын тосны салбартаа баримтлах нь бусад компаниудыг татан оролцуулахад бэрхшээл үүсгэдэг уян хатан бус нөхцөлтэй, эсхүл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд доогуур үнийн жишиг баримтлахыг тулган хүлээлгэх хандлагатай байдаг зэрэг сул талтай гэж үздэг байна.

Хуулийн энэхүү тогтолцоо нь хөгжиж буй орнуудад хувьд тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа компанийн газрын тосны үйл ажиллагаа, түүнтэй холбоотой татварын эрх зүйн орчныг тогтвортой байлгах, гэрээ хэлэлцээрийн эрх зүйн орчныг тодорхой болгодогтоо давуу талтай.

2/ Гэрээнд суурилсан эрх зүйн тогтолцоо - Энэ нь хөрөнгө оруулагч тал олборлолт явуулах оронтой бие даасан, тусгайлсан гэрээний онцгой нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцох явдал юм. Гэхдээ гэрээний агуулга нь ерөнхий, эсхүл үйл ажиллагааны үе шат бүхэнд гэрээний нөхцөлүүд нь нийцэж үйлчлэх шаардлагатай учраас учир дутагдалтай байдаг. Ийм хэлбэрийн эрх зүйн зохицуулалттай үед гол төлөв тухайн орны Засгийн газар, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий байгууллага үйл ажиллагааныхаа хүрээнд газрын тосны гэрээ хэлэлцээр байгуулахад оролцдог.

Ингэхдээ бүтээгдэхүүн хуваах, тусгай зөвшөөрөл олгоход үйлчилж буй уламжлалт нөхцөлүүд, тухайн эрх зүйн зохицуулалтын зохих шалгуур болох стандарт гэрээний нөхцөлүүд, эсхүл тусгай зөвшөөрлийн шаардлага болон нөхцөлүүдийг гэрээ байгуулахдаа ашигладаг байна. Түүнчлэн газрын тосны компаниудтай гэрээ байгуулахдаа төсөвт нөлөөлөх хүчин зүйлийн үйлчлэлийг нэмэгдүүлэхгүй тогтвортой байлгах талаар хэлэлцэн тохиролцож, энэ хүрээнд тухайн орны Засгийн газрын зүгээс тодорхой амлалт, үүрэг авах боломжтой боловч нэгэнт тохиролцож гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа уг гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь хүндрэлтэй байх сөрөг талтай. Өөрөөр

хэлбэл гэрээгээр тохиролцож амлалт авах нь гэрээнд заасан татварын үйлчлэх орчинд ямар нэг өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн орны эдлэх эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарласан байдаг.

3/ Гэрээний уян хатан эрх зүйн тогтолцоо - Энэ нь дээр дурдсан хоёр эрх зүйн тогтолцооны хосолмол хувилбар юм. Өөрөөр хэлбэл ашигт малтмал эзэмшигч орон холбогдох хууль тогтоомжоор эрх зүйн зохицуулалтын горим журмыг нарийвчлан тогтоохын зэрэгцээ тодорхой зарим нөхцөлүүдийг онцгойлон авч үзэж, бие даасан зохицуулалт хийх эрх эдэлдгээрээ онцлогтой.

Газрын тос олборлуулагч эзэн орны хувьд тусгай зөвшөөрлийн нөхцөлүүдийг тодорхойлох, тухайн ашигт малтмалын олборлолтын талаар гэрээ хэлэлцээр хийх, нөөцийг үнэ хаялцуулан өрсөлдөөний журмаар шийдвэрлэх суурь нөхцөл болгон ашиглах, гэрээний загварын төсөл бэлтгэх, шаардлагатай бол гэрээний нөхцөлүүдэд өөрчлөлт оруулах боломжтой байх зэрэг уян хатан гэрээний эрх зүйн тогтолцоог хүлээн зөвшөөрдөг байна.

Хоёр. Гадаадын зарим орны газрын тосны эрх зүйн зохицуулалт

2.1 НОРВЕГИ

Хууль эрх зүй

Норвеги улсад далайн гүний газрын тос олборлох үйл ажиллагаа 1965 оноос эхэлсэн бөгөөд одоо экспортолж байгаа газрын тосны хэмжээгээрээ дэлхийд 6-д жагсаж байна. Норвеги байгалийн нөөцийн экспортоороо хүчтэй эдийн засгийг бий болгож чадсан туршлагатай улс бөгөөд Legatum нь Oxford Analytica болон Gallup World Poll Service-тэй хамтран Норвегийг дэлхийн хурдацтай хөгжиж байгаа улсын тоонд оруулсан байна. Газрын тос болон байгалийн хийн нөөцийн олборлолтоосоо татварын орлогын 36 хувийг, экспортын 51 хувийг бүрдүүлж, нөөцөө маш ухаалаг ашиглаж, хуваарилж чадсан байна.

Тус улсын газрын тос, хийн талаар баримтлах бодлого нь прагматик шинжээрээ ялгарч ирсэн бөгөөд энд «нүүрс-устөрөгч бол ард түмний хөрөнгө» гэсэн үзэл баримтлалыг анхнаасаа хэрэгжүүлж иржээ. Норвегийн газрын тосны салбарт дараах бодлогыг баримталдаг байна¹⁶⁵. Үүнд:

- Далайн ёроолын газрын хэвлий дэх газрын тосны нөөц нь төрийн өмч байна /Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн 1-1/;
- Газрын тосны нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Норвеги улсын нийгмийн ашиг сонирхолд бүхэлд нь нийцүүлсэн байх /Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн 1-2/;
- Газрын тосны үйл ажиллагаанд олон улсын газрын тосны байгууллагуудыг оролцуулах,
- Үндэсний экспертизын төв ажиллуулах.

Норвеги улс нь судалгаанд дурдагдсан газрын тосны тухай хууль тогтоомжийн үндсэн гурван хэлбэрээс тогтмол агуулга бүхий хатуу зохицуулалттай эрх зүйн тогтолцоог ашигладаг орон юм. Тус улсын газрын тосны үйл ажиллагаа нь 1996 онд батлагдсан “Газрын тосны үйл ажиллагааны тухай” хуулиар¹⁶⁶ зохицуулагдах бөгөөд уг хууль нь нийт 11 бүлэг, 85 зүйлтэй.

¹⁶⁵Norway: Petroleum regime. Ministry of Petroleum and Energy.

¹⁶⁶Act 29 November 1996 No. 72 relating to petroleum activities.

Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулиар Газрын тосны нөөцийн удирдлага; лиценз олгох журам; газрын тос олборлоход тавигдах шаардлага; газрын тостой холбоотой үйл ажиллагааг зогсооход бэлтгэх журам; лицензийн бүртгэл болон барьцаа; байгаль орчинд учруулсан хохирлын хариуцлага; Норвегийн загасчдад нөхөн олговор олгох журам; аюулгүй ажиллагаанд тавигдах онцгой шаардлага зэрэг бүлгүүдээр зохицуулсан харилцааг агуулсан байна.

Нөөцийн удирдлага

“Газрын тосны нөөцийн удирдлагыг тус улсын Хаан энэхүү хууль болон Парламентын гаргасан шийдвэрийн дагуу хэрэгжүүлнэ.

Газрын тосны нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Норвеги улсад урт хугацаанд хамгийн үр ашигтай байх, үүнтэй уялдуулан тухайн нөөцийн удирдлага нь улсын төсвийн орлого бүрдүүлэх, иргэдийн сайн сайхан аж байдал, ажил эрхлэлтийг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, Норвегийн худалдаа, аж үйлдвэржилтийг сайжруулан хүчирхэгжүүлж, аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, түүний сацуу бүсийн болон орон нутгийн талаар явуулах бодлого, түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг газрын тосны нөөцийн удирдлагын явцад анхааралтай харгалзан үзнэ” гэж Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн 1.2-т заажээ.

Лиценз олгох журам

Тус улсын төрөөс өөр хэн ч Газрын тосны үйл ажиллагааны тухай хуульд заасан шаардлагын дагуу лиценз аваагүй бол газрын тосны үйл ажиллагааг явуулахгүй байх талаар хуулийн 1.3-р зүйлд заасан байна.

Газрын тосны хайгуулын лиценз

- Хуулийн этгээд, Европын эдийн засгийн бүс /EEA – European Economic Area/-д оршин суудаг хувь хүнд хайгуул хийх лицензийг Яамнаас /Газрын тос, эрчим хүчний яам/ олгоно.
- Хайгуулын лиценз нь газрын тосны хайгуул эрхлэхийг зөвшөөрнө.
- Лицензэд тодорхой хугацаа заагаагүй бол лицензийг 3 жилийн хугацаагаар олгоно.
- Лицензэд хайгуул хийхийг зөвшөөрсөн бүсийг заавал заана.

Газрын тос олборлолтын лиценз

- Тус улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн хуулийн этгээд, Европын эдийн засгийн бүст оршин суудаг хувь хүнд олборлолтын лицензийг олгоно.
- Тогтоосон нөхцөлийн дагуу Зөвлөл дээр Хаан олгоно.
- Олборлолтын лиценз нь уг лицензэд заасан бүсэд газрын тосны хайгуул, хайгуулын өрөмдлөг хийх, олборлох эрхийг олгоно.
- Олборлолтын лиценз нь нэг, эсхүл хэд хэдэн блок, эсхүл блокийн хэсэг газрыг хамарч болно.
- Олборлолтын лиценз авах зорилгоор хамтын ажиллагааны гэрээг Яаманд хүргүүлэх бөгөөд Яам энэ төрлийн гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй.

Яам нь журмын дагуу олборлолтын лиценз авах хүсэлт гаргаж болох бүс нутгийг зарлах бөгөөд ингэхдээ “Норвегийн сонин” (Norsk Lysingsblad) болон Европын Холбооны албан ёсны сэтгүүлд холбогдох мэдээллийг, Яамнаас тогтоосон журмын хамт нийтлүүлнэ.

Зарласан бүс нутагт олборлолтын лиценз авах хүсэлтээ хамгийн багадаа 90 хоногийн дотор хүргүүлнэ.

Хаан нь ирсэн хүсэлтийн дагуу заавал лиценз олгохгүй байж болно. Мөн Хаан нь урьдчилан зарлахгүйгээр лиценз олгож болох ба ингэхдээ дээр дурдсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олборлолт явуулах газрыг зарлах бөгөөд, лиценз олгох гэж байгаа бүсийн ойролцоох оролцох боломжтой этгээдүүдэд тэгш боломж олгох ёстой. Хаан нь лиценз олгох нэмэлт журам болон бүртгэлийн төлбөрийг тогтоох бол Яам нь олборлолтын лицензгүйгээр зөвхөн хайгуулын өрөмдлөг хийх зөвшөөрөл олгоно.

Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн 3.6-д “Хаан нь Норвегийн төр уг хуулиар тогтоосон журмын дагуу газрын тосны үйл ажиллагаанд оролцох ёстойг тогтоож болно” гэсэн нь энэ салбарт оролцох төрийн оролцоог бий болгодог байна. Мөн Хаан нь лиценз эзэмшигчид олборлолтын үйл ажиллагаа явуулах бүс нутагт хийх ажил үүргийн нарийн хуваарийг тогтоож өгч болохыг хуулийн 3.8-р зүйлд хуульчилсан.

Олборлолтын лицензийн хугацааг хуулийн 3.9-д заасан бөгөөд хугацаа 10 хүртэл жил байна. Хэрэв лицензэд үүнээс богино хугацаа олгосон Яамд хугацааг сунгах ба нийт хугацаа 10 жилээс хэтрэхгүй байна.

Хуулийн 3.8-д заасан үүргээ биелүүлсэн лиценз эзэмшигчийн лицензийн хугацааг, мөн хувь хүний лицензийн хугацааг хүсэлт гаргасан тохиолдолд энгийн тохиолдолд 30 хүртэл жилээр, онцгой тохиолдолд 50 хүртэл жилээр сунгаж болно. Ингэхдээ лиценз эзэмшигчийн үйл ажиллагаа явуулж байгаа бүсийн аль хэсэгт лицензийг сунгахыг Хаан тодорхой журмын дагуу тогтооно. Хугацааг сунгах хүсэлтээ лицензийн хугацаа дусахаас 5 жилийн өмнө гаргах ба хугацааг сунгахтай холбоотой журмыг Яам тогтооно.

Яам нь онцгой нөхцөл байдалд олборлолтын лиценз хүчинтэй байгаа бүсэд хайгуулын лицензийг олгож болох ба ямар хугацаагаар ямар төрлийн хайгуул хийж болохыг тогтооно.

Лиценз эзэмшигч нь 3.9-д заасан хугацаанд лиценз эзэмших эрхээсээ татгалзаж болно. Хэрэв хуанлийн жил дусахаас хамгийн багадаа 3 сарын өмнө энэхүү хүсэлтээ гаргасан бол тухайн жил дуусгавар болоход лиценз эзэмших эрхийг түдгэлзүүлнэ. Яам эрх түдгэлзүүлэхээс өмнө олборлолтын лицензээр тогтоосон холбогдох үүргийг биелүүлэхийг лиценз эзэмшигчээс шаардаж болно.

Дээрх хоёр лицензээс гадна Яам газрын тосны тээвэрлэлт, ашиглалтад зориулж онцгой нөхцөлөөр лиценз олгож болно.

Газрын тос тээвэрлэх төхөөрөмж, дамжуулах хоолой зэрэг барилгын, ашиглалтын төлөвлөгөөг, хүсэлтийн хамт өгөх ба Яам асуудлыг авч үзээд тодорхой хугацаагаар лицензийг олгож, шаардлагатай бол хугацааг сунгана.

Газрын тос олборлолт

Газрын тосны үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр бүлэгт газрын тосыг олборлоход тавигдах шаардлагуудыг тусгасан байна. Үүнд:

- Үр ашигтай олборлолт хийх: тухайн орд газраас аль болох их хэмжээний газрын тос олборлох, олборлосон газрын тосыг оновчтой техник, тогтвортой эдийн засгийн зарчимд нийцүүлэн боловсруулах ёстой, лиценз эзэмшигч нь өөрийн олборлолтын стратеги, техник шийдэл болон бусад үйл ажиллагааныхаа үйл явцад үнэлэлт өгч байх.

- Газрын тосны орд газарт явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах: төлөвлөгөөг гаргаж Яамаар зөвшөөрүүлэх, төлөвлөгөөний агуулгын хувьд аюулгүй байдлын, арилжааны болон экологийн эдийн засаг, нөөц, техник тодорхойлолтууд, мөн тээвэрлэлт, ашиглалтын болон бусад асуудлыг оруулсан байна.
- Лиценз эзэмшигчийн хүсэлтээр Яам нь тухайн эзэмшигчийн олборлох газрын тосны хэмжээг тодорхой хугацаатай хамт тогтоож өгнө.
- Лиценз эзэмшигч нь олборлолтын лицензийн төлбөрийг хуулийн 3-9-д заасан хугацаа дууссаны дараа төлнө.
- Газрын тосыг хаана, ямар хэлбэрээр эрэгт хүргэхийг Хаан тогтоосон журмын дагуу хэрэгжүүлнэ.
- Үндэсний хэрэгцээг хангах: Хааны шийдвэрлэснээр лиценз эзэмшигч нь олборлосон газрын тосноосоо үндэсний хэрэгцээнд зориулж шаардлагатай газар олгоно. Түүнийг тээвэрлэлтийн асуудал болон хэнд хүргэх зэргийн Хаан шийдвэрлэнэ.

2.2 КАЗАХСТАН

Хууль эрх зүй

Их Британийн газрын тос, байгалийн хийн томоохон компани болох BP компани 2012 оны сүүлээр БНКУ-ын газрын тосны нөөцийг 30 тэрбум баррель буюу 3,9 тэрбум тонн хэмээн тооцоолсон нь дэлхийн нөөцийн 1,8 хувийг эзэлж байна.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль¹⁶⁷ нь 2010 онд батлагдсан бөгөөд бүтцийн хувьд нийт 15 бүлэг, 130 зүйлтэй. Хуулийн 8, 9 дүгээр бүлгүүдэд газрын тосны үйл ажиллагаа, далайд болон дотоод улсын сав газарт газрын тостой холбоотой үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Өмчлөл

Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 10.1-д БНКУ-ын Үндсэн хуулиар тогтоосны дагуу газрын хэвлий, түүний ашигт малтмалууд төрийн өмч байна гэж заасан байна. Тус улсын засгийн газар энэ хуулиар тогтоосон үндэслэл, нөхцөлийн дагуу газрын хэвлийг ашиглуулах эрхийг олгоно.

Үндэсний аюулгүй байдал, хүн амын аюулгүй байдал болон хүрээлэн буй орчныг хамгаалах үүднээс БНКУ-ын Засгийн газрын шийдвэрээр зарим газрын хэвлийн газрыг ашиглахыг хязгаарлах, эсхүл хориглоно.

Төрийн эдлэх хөнгөлөлттэй бөгөөд давуу эрх

БНКУ нь газрын хэвлий ашиглагч субъектүүдээс ашигт малтмал худалдан авах эрхтэй. Ийнхүү худалдан авахдаа газрын хэвлийг ашиглагч субъектын анх гэрээ байгуулсан үеийн ашигт малтмалын нэмэгдээгүй үнээр худалдан авах давуу эрхтэй.

Хэрэв гэрээнд үнэ заагаагүй бол Засгийн газрын ашигт малтмал худалдан авах тухай гэрээ байгуулсан үеийн ашигт малтмалын дэлхийн зах зээл дээрх нэмэгдээгүй үнээр газрын хэвлийг ашиглагч субъектээс худалдан авах давуу эрхтэй.

¹⁶⁷Закон Республики Казахстан от 24 июня 2010 года № 291-IV «О недрах и недропользовании» (с изменениями и дополнениями по состоянию на 04.07.2013 г.)

Худалдан авах ашигт малтмалын хэмжээ, төлбөрийн нөхцөлийг гэрээнд заах бөгөөд /Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 12./ хэрэгжүүлэх үйл явцыг хуулиар зохицуулна.

Газрын хэвлийг ашиглах

Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 28-д зааснаар дараах тохиолдолд газрын хэвлийг ашиглаж болно. Үүнд:

1. газрын хэвлийг улсын геологийн судалгаа,
2. хайгуул,
3. олборлолт,
4. хайгуул болон олборлолт,
5. хайгуул, эсхүл олборлолттой холбоогүй газар доогуур байгууламж барих, ашиглах.

Түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа эрхлэх бол тогтмол хугацаагаар, бусад ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа эрхлэх бол тур хугацаагаар газрын хэвлийг ашиглах эрх авна.

Казахстаны болон гадаадын иргэн, хуулийн этгээд газрын хэвлийг ашиглах эрхийг авч болно. Газрын хэвлийг ашиглагч нь түгээмэл тархацтай ашигт малтмал болон хувийн хэрэгцээндээ гүний ус олборлодог этгээдээс бусад үйл ажиллагаа эрхлэгч байж болно. /Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 29./

Гэрээ байгуулсаны үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх үүснэ. Харин гэрээг дараах нөхцөлийн үндсэн дээр байгуулна:

- Уралдаанд түрүүлж шалгарсны үр дүнд хайгуул, олборлолтын, хамтарсан хайгуул, олборлолтын гэрээ байгуулна.
- Шууд хэлэлцээрийн үндсэн дээр гэрээ байгуулж болно.

Ашигт малтмалын нөөцийг боловсруулах үйл ажиллагаа нь газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаанд хамаарахгүйг хуулийн 45-д заасан байна.

Газрын тосны үйл ажиллагаа

Газрын тосны үйл ажиллагааг явуулахдаа хайгуул хийсэн бол тухайн орд газарт туршилтын олборлолт хийж болох талаар хуулийн 82-т заасан байна. Туршилт хийх нөхцөл, хугацааг хуулиар тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллага тогтооно.

Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 84-т “аж үйлдвэрийн олборлолтын нүүрс-устөрөгчийн нэгдлийн нөөц орд” гэсэн ойлголт байгаа бөгөөд энэ нь газрын хэвлийгээс ашигт малтмалын тогтоосон нөөцийг зүй зохистой, иж бүрэн ашиглалтын тооцоотой олборлох зорилготой цогц үйл ажиллагааг ойлгоно. Энэхүү үйл ажиллагааг Казахстаны Засгийн газраас тогтоосон нэгдсэн дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

Нүүрс-устөрөгчийн нэгдлийн ордыг дараах тохиолдолд аж үйлдвэрийн олборлолтын үйл ажиллагааг оруулна. Үүнд:

1. хайгуул хийгдсэн, туршилтын олборлолт хийгдсэн газрын тосны орд газар
2. улсын зүгээс нүүрс-устөрөгчийн нэгдлийн нөөцийн шинжилгээ хийж, Ашигт малтмалын нөөцийн улсын балансад бүртгэгдсэн
3. хэрэгжүүлэх гэж байгаа төслийг аж үйлдвэрийн аюулгүй байдлын салбарын эрх бүхий байгууллага зөвшөөрсөн
4. үйл ажиллагааны төслийн барим бичгүүдийн шалгаж, баталгаажуулна.

Үйл ажиллагаа явуулагч нь хайгуул, эсхүл олборлолтын үр дүнд тус улсын хил орчмын газар тухайн орд газар хилийн зааг дээр байвал, уг асуудлыг эрх бүхий багууллага шийдвэрлэлтэй үйл ажиллагаагаа нэн даруй зогсоох шаардлагатайг Казахстаны Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 89-оор тогтоосон байна.

Газрын тосны үйл ажиллагаа явуулж байх үйл явцад осол болон бусад аюултай нөхцөл байдлаас бүх шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг заавал авах, арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулахыг хуулийн 87-оор тогтоосон байна.

Хэрэв газрын хэвлийг ашиглаж байгаа субьектын хайгуул, эсхүл олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа орд газар нь бусад газрын хэвлийг ашиглаж байгаа субьектын гэрээт газар бол талууд сонголтоороо дараах үүрэгтэй /Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хуулийн 90.1.1/:

1. Тухайн ордод хайгуул, эсхүл олборлолт хийх эрхийг аль нэг талд шилжүүлэх;
2. Талууд нэг гэрээгээр тухайн ордыг хэсэгчлэн хувааж, үйл ажиллагаа явуулах;
3. Тухайн ордод хайгуул, олборлолтыг хамтран ажиллах гэрээний үндсэн дээр явуулж, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр боловруулах бөгөөд ингэхдээ эрх бүхий байгууллагаас урьдчилан хянуулна.

Талууд хамтран хайгуул, эсхүл олборлолт хийх бол гэрээ, хөтөлбөрт тусгасан гүйцэтгэх үүргийнхээ дагуу хариуцлага хүлээнэ.

2.3 ОХУ

Хууль эрх зүй

ОХУ-д газрын тосны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг бие даасан хууль байхгүй бөгөөд уул уурхайтай холбоотой харилцааг зохицуулагч суурь хууль болох Газрын хэвлийн тухай холбооны хуулиар¹⁶⁸ уг харилцааг зохицуулна. Газрын тосны хэвлийн тухай хууль нь 1992 онд батлагдсан, бүтцийн хувьд оршил, 7 бүлэг, нийт 63 зүйлтэй.

Газрын хэвлийн тухай хуулийн оршилд зааснаар Оросын нутаг дэвсгэрийн¹⁶⁹ газрын хэвлий болон эрэг орчмын хөрс /континентальный шельф/¹⁷⁰ зэргийн геологийн судалгаа, ашиглалт, хамгаалалт, мөн түүнчлэн газрын хүлэр /торф/ болон гүний ус, нуур гэх мэт бусад өвөрмөц эрдэс баялаг зэрэг уул уурхайн ашигт малтмалыг ашиглах, боловсруулахтай холбоотой харилцааг энэхүү хуулиар зохицуулна гэсэн байна. Мөн уг хууль нь газрын хэвлийг иж бүрэн, зүй зохистой ашиглах, хамгаалах эрх зүйн болон эдийн засгийн үндсэн зохицуулалт болж, улс орны болон тус улсын иргэдийн ашиг сонирхлыг, мөн түүнчлэн газрын хэвлий, түүний баялгийг ашиглагчдын эрхийн хамгаалахаар зохицуулсан хэмээн заасан байна.

Ашигт малтмалын нөөц, газрын хэвлийг ашиглахад төрийн бодлогын дараах үндсэн зорилгыг хэрэгжүүлнэ¹⁷¹:

- ОХУ-ын эдийн засгийн тогтвортой хөгжил, тус улсын иргэдийн чинээлэг аж амьдралыг нэмэгдүүлэх зорилготойгоор Оросын ашигт малтмалын нөөцийн тасралтгүй үйлдвэрлэх, үр ашигтай эзэмших,

¹⁶⁸Закон РФ от 21 февраля 1992 г. N 2395-1 "О недрах".

¹⁶⁹ОХУ-ын нутаг дэвсгэрт тус улсын субьектүүдын нутаг дэвсгэр, дотоодын ус болон эзэмшлийн далай, түүний агаарын орон зай хамаарна. /ОХУ-ын Үндсэн хуулийн 67.1./

¹⁷⁰ОХУ нь эрэг орчмын хөрс дээр холбооны хууль, олон улсын эрх зүйн баримт заасан журмын дагуу бүрэн эрхтэй хэмээн Үндсэн хуулийн 67.2-т тус тогтоожээ.

¹⁷¹"Конституционно-правовое регулирование недропользования в России, странах Европы и Америки" В.К.Филатов /Кафедра конституционного и муниципального права Российский университет дружбы народов/.

- Орос улсын хойч үеийн одоогийн болон ирээдүйн ашиг сонирхолд нийцүүлэн ашигт малтмалын нөөцийг зүй зохистой, иж бүрэн ашиглах,
- Орос улсын геополитикийн, тэр дундаа ашигт малтмалын дэлхийн зах зээл дээр ашиг сонирхлыг нь хамгаалах.

Газрын хэвлийн тухай хууль нь газрын хэвлийн өмчлөл, холбооны ач холбогдол бүхий газрын хэвлий, холбооны төрийн байгууллагуудын эрх, үүрэг; газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрлүүд, ашиглах хязгаарлалт, субъектүүд, тэдний эрх, үүрэг, ашиглах хугацаа, эрх авах, түүнийгээ шилжүүлэх, түдгэлзүүлэх; газрын хэвлийг ашиглах, хамгаалахад тавигдах шаардлага, Ашигт малтмалын геологи-эдийн засгийн тооцоо болон өртгийн үнэлгээ хийх, ашигт малтмалын нөөцийн тооцоо, бүртгэл, газрын хэвлийг хамгаалах; газрын хэвлийг ашиглахтай холбоотой төрийн оролцоо, энэ талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх зорилт, тавих хяналт; газрын хэвлийг ашиглалтын төлбөрийн систем, хэмжээ; хариуцлага хүлээлгэх, маргаан шийдвэрлэх; олон улсын гэрээ зэрэг харилцаануудыг зохицуулсан байна.

ОХУ-д газрын тосны салбарын шинжээчид газрын тостой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах бие даасан хууль хэрэгтэй гэж үзэж байгаа бөгөөд тус улсын эх баригчид ийм хуультай болох оролдлогыг олон жилийн турш хийж байна. Газрын тостой холбоотой харилцааг зохицуулах бие даасан Газрын тосны тухай хуулийг бүр 1995 онд Төрийн Дум, Холбооны зөвлөлөөр баталж байсан боловч ерөнхийлөгч нь уг хуулийг баталж, гарын үсэг зураагүй байна.

Өмчлөл

ОХУ-ын Үндсэн хуулийн¹⁷² 9-д зааснаар газар болон бусад байгалийн нөөцийг Оросын ард түмний амьдрал, үйл ажиллагааны үндэс болгон ашиглаж, хамгаалах ба тэдгээр нь хувийн, улсын, орон нутгийн, бусад хэлбэрийн өмчид байж болно гэсэн байна.

Тус улсын үндсэн хуулийн эрх зүйн түүхэнд анх удаа 1993 оны Үндсэн хуульд “байгалийн нөөц” гэсэн нэр томъёо орж ирсэн. ОХУ-ын Ерөнхийлөгчийн Холбооны байгалийн нөөцийн тухай зарлигаар газар, ус, ой, газрын хэвлий, амьтан, ургамал зэргийг байгалийн нөөцөд оруулсан. Гэвч шинжлэх ухаан улам бүр хөгжиж байгаа орчин үед “байгалийн нөөц”-д газар, газрын хэвлий, ус, атмосферийн агаар, ой, ургамал болон амьтны аймаг багтах болсон.

Гэтэл Газрын хэвлийн тухай хуулийн 1.2-т ОХУ-ын хилийн дотор байгаа усан доорх орон зайг хамруулан газрын хэвлий, түүний ашигт малтмал, эрчим хүчний болон бусад байгалийн нөөц нь төрийн өмч гэж заасан нь зөвхөн энэ хуулиар төр нь газрын хэвлийн монополи өмч аж. Энэ нь холбооны улсын хувьд ОХУ болон түүний субъектүүдийн хооронд газрын хэвлийг хуваах асуудлаар зөрчилдөх явдал гарч байгаа юм.

Газрын хэвлийн тухай хуулийн 10-т холбооны төрийн байгууллагууд нь Холбооны субъектүүдтэй хамтран ОХУ-д хамааралтай газраас бусад Газрын хэвлийн улсын санг удирдана гэсэн нь тус улсын газрын хэвлийн өмчлөгч субъект нь ОХУ болон түүний субъектүүд болж байна.

ОХУ болон ОХУ-ын субъектүүд хамтран газар, газрын хэвлий, ус болон байгалийн бусад баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахаар Үндсэн хуулийн 72-т, Газрын хэвлийн тухай хуулийн 1.2-т тус тус тусгасан байна.

¹⁷²Конституция Российской Федерации. Принята всенародным голосованием 12 декабря 1993 г.
Эх сурвалж: <http://constitution.kremlin.ru/>

Мөн заалтад газрын хэвлийг худалдах, худалдан авах, бэлэглэх, өв залгамжлуулах, хандивлах, барьцаалах, барьцаанд тавих болон өөр бусад хэлбэрээр албадан хураагдах ёсгүй гээд гагцхүү холбооны хуулийн хүрээнд газрын хэвлийг ашиглах эрхийг хураах, эсхүл нэг этгээдээс нөгөөд шилжүүлнэ гэж заажээ.

Ашигт малтмал болон бусад байгалийн баялагийг газрын хэвлийгээс лицензийн нөхцөлтэйгээр олборлох нь холбооны, ОХУ-ын субъектүүдын, хувийн болон бусад хэлбэрийн өмчид байж болно. /Газрын хэвлийн тухай хуулийн 1.2./

Тус улсад газрын тос нь холбооны болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын төрөлд багтсан байна.

- Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зорилгоор зарим газрыг холбооны ач холбогдол бүхий газрын хэвлийд хамааруулахаар ОХУ-д Газрын хэвлийн тухай хуульд заасан байна. Ашигт малтмалын улсын балансад үндэслэн 2006 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэд хэдэн ашигт малтмалууд, түүний дотор 70 сая тонноос дээш газрын тосны нөөцтэй газрын хэвлийг холбооны ач холбогдол бүхий баялагтай газарт хамааруулна. /Газрын хэвлийн тухай хуулийн 2.1./
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөцийн үндсэн нэр төрлийн жагсаалтыг ОХУ-ын Засгийн газрын 1996 оны 50 тоот тогтоолоор баталсан бөгөөд жагсаалтад газрын тосыг багтаасан байна.

Ашигт малтмалын геологи-эдийн засгийн тооцоо болон өртгийн үнэлгээ

Газрын хэвлийн баялгийг ашиглах харилцааг зохицуулах болон эрдэс баялгийн базыг хөгжүүлэх зорилтыг шийдвэрлэхийн тулд байгалийн баялгийг олборлох, хайгуул хийх, боловсруулахын тулд зайлшгүй байдлаар геологи, технологи, экологи, эдийн засгийн болон бусад тооцоо судалгааг иж бүрэн хийж байхаар хуульчилсан байна.

Учир нь ашигт малтмалын ордын нөөцийг илрүүлж тогтоосны дараа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах шаардлага байна уу, үгүй юу гэсэн шийдвэрийг эдийн засаг, үндэсний аюулгүй байдал талаас нь геологи-эдийн засгийн тооцоо судалгаа, үнэлгээг үндэслэн гаргадаг. Үүний үр дүнд тухайн ордын нөөцийн хэмжээ, чанарыг тооцон ашиглалт явуулснаар эдийн засгийн үр ашиг гарах эсэх, олборлолт хийх боломж, тээвэр, дэд бүтэц, боловсруулалтын зардал зэргийг тооцсон өртгийн үнэлгээг гаргаж, татвар шингэсэн борлуулалтын үнийг бодитойгоор тооцон гаргадаг байна. Ашигт малтмалын геологи-эдийн засгийн тооцоо болон өртгийн үнэлгээ хийх аргачлалыг ОХУ-ын Засгийн газрын холбогдох байгууллага баталдаг.

Газрын хэвлийг ашиглах нь

Газрын хэвлийг үндсэн зургаан зорилгоор ашиглах ба үүнд ашигт малтмалын орд газрыг хайх, үнэлэх, түүнийгээ олборлох үйл ажиллагаа хамаарч байна. Ингэхдээ Үндэсний аюулгүй байдлыг хангах болон хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор Газрын хэвлийн хэсэг газрыг ашиглахыг хязгаарлах, эсхүл хориглоно.

Газрын хэвлийг ашиглахтай холбогдолтой үйл ажиллагааны аль нэг төрлийг хэрэгжүүлэх бол тухайн үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл буюу лиценз шаардлагатай. Газрын хэвлийг ашиглагч субьектын эрх, үүрэг нь газрын хэвлийг ашиглах лицензийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Лиценз

Газрын хэвлийн тухай холбооны хуулийн 11-д тодорхойлсноор лиценз бол газрын хэвлийг тодорхой хилийн дотор, заасан зориулалтаар, тогтоосон хугацаанд, урьдчилан тохиролцсон шаардлага, нөхцөлийг мөрдлөг болгон ашиглах эзэмшигчийн эрхийг баталсан эрхийн бичиг юм. Үйл ажиллагаа явуулах эрх, хугацаанаас хамаарч өөр хоорондоо ялгаатай хэд хэдэн төрлийн лиценз байдаг. Лиценз олгохдоо холбогдох газрыг ашиглах эрхийг хамт олгоно.

Ашигт малтмал олборлоход олгосон лицензийг бичгээр, эсхүл амаар явагдах уралдаан, эсхүл үнэ хаялцуулах худалдаагаар олгоно. Энэхүү харилцааны ерөнхий зохицуулалтыг Газрын хэвлийн тухай хуулиар зохицуулж, нарийвчилсан харилцааг хэд хэдэн эрх зүйн баримт бичгээр¹⁷³ зохицуулагдана. /Газрын хэвлийн тухай хуулийн 11.3/

Газрын хэвлийг ашиглах лиценз олголтын процессыг 4 үе шатанд хамааруулдаг. Үүнд:

1. Ашиглуулахаар өгөх гэж байгаа газрын хэвлийн хэсэг газрыг тодорхойлох
2. Газрын хэвлийн нөхцөлийг тодорхойлох
3. Газрын хэвлийг ашиглагчийг сонгох
4. Газрын хэвлийн хэсэг газрыг ашиглуулахаар өгөх

Лиценз эзэмшигч нь өмчийн хэлбэрээс үл хамааран энгийн нөхөрлөлийн гишүүн, гадаадын иргэн, хуулийн этгээд байна.

Лиценз олгох үнэ хаялцуулах худалдааны системд газрын хэвлий ашиглах эрхийг авах илүү өндөр төлбөр санал болгосон оролцогч нь ялагч болно. Харин уралдааны системд оролцогчдын санал болгосон төлбөрийн хэмжээнээс гадна экологи болон эдийн засгийн шаардлагуудыг харгалзаж үзнэ. Энэхүү систем нь үнэ хаялцуулах худалдааны системээс илүү уян хатан боловч зүй бусаар ашиглагчдад боломжтой байдаг хэмээн тус улсын зарим судлаачид үзэж байна.

Тэмцээний ялагчийг тодруулах гол шалгуур нь геологийн судалгааны шинжлэх ухаан-техникийн түвшин болон газрын хэвлийг ашиглах, ашигт малтмалыг бүрэн олборлох, тухайн нутаг дэвсгэрийг нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр, холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, газрын хэвлий, хүрээлэн байгаа орчныг бүтэмжтэй хамгаалах, Холбооны улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол зэргийг тооцно.

Хэрэв зарим оролцогчид тэмцээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй бол лиценз олгодог эрх бүхий байгууллага нь тэдгээр оролцогчдод ялагчийг тодорхойлж байгаа үндэслэлүүдээр нэмэлт нөхцөлийг тогтооно.

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрлөөс хамаарч ашиглах хугацаа янз бүр жил байна. Газрын хэвлийг үр ашигтай ашиглах, хамгаалахын тулд ашигт малтмалыг олборлох техник-эдийн засгийн үндэслэлээр тогтоосон хугацаанд орд газрыг ашиглахыг зөвшөөрнө. Газрын тос, байгалийн хийн агуулахын барилга барихад зориулагдсан газрын хэвлийн хэсэг газрыг ашиглах хугацааг хязгаарлахгүй. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр ашиглалтын хугацааг сунгана.

¹⁷³ «Положение о порядке лицензирования пользования недрами», утвержденными Постановлением Верховного Совета РФ от 15.07.92 № 3314-1; Положение о Федеральном горном и промышленном надзоре России, утвержденным Указом Президента РФ от 18.02.93 № 234; инструкция «О порядке предоставления горных отводов для разработки газовых и нефтяных месторождений» утвержденными постановлением Госгортехнадзора РФ от 11 сентября 1996 г. и другими нормативными документами.

Ашигт малтмалын хайгуул, олборлох лицензийг уралдаан, эсхүл үнэ хаялцуулах худалдааны дүгнэлтээр яамд болон Холбооны субъектүүдйн гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай хамтарсан хорооны шийдвэрийг үндэслэн ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яам олгоно.

Лиценз олгосны дараа түүний бүртгэлийн ажиллагаа явагдана. Лицензийг бүртгэх явцад холбооны болон орон нутгийн сангууд лицензийн баримт бичгүүдийн зөв байгаа эсэх, хуульд нийцсэн эсэх зэргийг хянаж үздэг байна.

Газрын хэвлийг ашигласны төлбөр

Газрын хэвлийн тухай хуулийн 39-д зааснаар газрын хэвлийг ашигласны нэг удаагийн болон тогтмол төлбөр болон бусад татвар, төлбөрийг холбооны улсын холбогдох хуулиудын дагуу төлнө гэсэн байна. Газрын тосны үйл ажиллагаатай холбоотой төлбөрийн хэмжээг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Газрын хэвлийг ашигласны тогтмол төлбөрийн төрөл, хэмжээ

	Төлбөрийн хэмжээ /газрын хэвлийн 1 кв.км бүрд ногдох рублийн хэмжээ/	
	Доод хэмжээ	Дээд хэмжээ
ашигт малтмалын ордын хайгуул хийж, нөөцийг тогтоох зорилготойгоор газрын хэвлийг ашигласны тогтмол төлбөрийн хэмжээ:		
нүүрс-устөрөгчийн нөөц	120	360
нүүрс-устөрөгчийн нөөц <ul style="list-style-type: none"> • эрэг орчмын хөрс • ОХУ-ын эдийн засгийн бүс • ОХУ-ын нутаг дэвсгэрийн хил хязгаараас давсан ч тус улсын хууль үйлчлэх хүрээнд 	50	150
ашигт малтмалын ордын хайгуул хийх зорилготойгоор газрын хэвлийг ашигласны тогтмол төлбөрийн хэмжээ:		
нүүрс-устөрөгчийн нөөц	5 000	20 000
нүүрс-устөрөгчийн нөөц <ul style="list-style-type: none"> • эрэг орчмын хөрс • ОХУ-ын эдийн засгийн бүс • ОХУ-ын нутаг дэвсгэрийн хил хязгаараас давсан ч тус улсын хууль үйлчлэх хүрээнд 	4 000	16 000
	Тонн бүрд ногдох рублийн хэмжээ	
Газрын тос болон байгалийн хийн концентрат хадгалах	3,5	5

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Elliff v. Texon Drilling Co., 210 S.W.2d 558 /Tex.1949/.
2. Ernest E.Smith&Jacquiline Lang Weaver, Газрын Тос, Байгалийн Хийн Талаарх Техас муж улсын хууль - /The Texas Law Of Oil And Gas/-ын 2 дахь хэвлэл, 2007 он бүлэг 8-12 болон 15 дахь бүлэг/
3. Act 29 November 1996 No. 72 relating to petroleum activities.
4. Закон Республики Казахстан от 24 июня 2010 года № 291-IV «О недрах и недропользовании» (с изменениями и дополнениями по состоянию на 04.07.2013 г.)

5. Конституция Российской Федерации. Принята всенародным голосованием 12 декабря 1993 г. Эх сурвалж: <http://constitution.kremlin.ru/>
6. Закон РФ от 21 февраля 1992 г. N 2395-1 "О недрах".
7. "Конституционно-правовое регулирование недропользования в России, странах Европы и Америки" В.К.Филатов /Кафедра конституционного и муниципального права Российский университет дружбы народов/.
8. Перечень основных видов стратегического минерального сырья (утв. распоряжением Правительства РФ от 16.01.1996 г. N 50-р).
9. http://en.wikipedia.org/wiki/Defence_Production_Sharing_Agreement
10. [file:///DPSAe Canada-USA.pdf](file:///DPSAe%20Canada-USA.pdf)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНГЭЭХ ЧАДВАР, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС (Мэдээлэл лавлагаа)

Д-р Г.Алтан-Оч, Ц. Элбэгзаяа

Судалсан байдал: Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол доорх эх сурвалж буюу цахим хуудасны мэдээллийг ашигласан болно. Үүнд:

1. "Absorptive capacity", Wikipedia (The Free Encyclopedia) http://en.wikipedia.org/wiki/Absorptive_capacity
2. H. Nguyen nap, "Foreign Direct Investment Absorptive Capacity Theory", Eindhoven University of Technologies (TU/e), Netherlands, 2009 https://smartech.gatech.edu/bitstream/handle/1853/35267/1238510767_HN.pdf;jsessionid=D139491CF6F758308ED6D385CF328803.smart2?sequence=1
3. Beatrice Parkas, "Absorptive Capacities and the Impact of FDI on Economic Growth", DIW Berlin, Germany, 2012 <file://SSRN-id2038182.pdf>
4. Соёмбо 2 баг, "Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа", Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хоргоо, 2011 <file://Soyombo II bag - negdsen tailan - last version.pdf>

Нэг. Ерөнхий ойлголт

Удирдахуйн шинжлэх ухаанд шингээх чадварыг "шинэ мэдээллийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх, түүнийг өөрийн болгох, улмаар ашиг олоход хэрэглэх аж ахуйн нэгжийн чадавх"¹⁷⁴ гэж анх 1990 онд тодорхойлсон байдаг. Түүнийг хувь хүн, бүлэг этгээд, байгууллага дээр, цаашилбал улсын хэмжээнд ч авч үзэж болно. Угтвар нөхцөл нь өмнөх мэдлэг (мэдлэгийн сан, мэдлэгийн урсгал) болон хэлхээ харилцаа¹⁷⁵ мөн. Судалгааны хүрээ нь аж ахуйн нэгж (ААН)-ийн инновацийн чадавх, тэмүүллийн түвшин, бүтэц зохион байгуулалтын суралцах байдлыг хамардаг. Иноватив (шинэ санаачлагатай) байхын тулд аливаа ААН өөрийнхөө шингээх чадварыг хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг.[1]

Шингээх чадварт хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл бол өмнөх мэдлэг болон олон талт үндэс суурь¹⁷⁶ юм. Ийм учраас байгууллагууд шингээх чадвараа хөгжүүлэхийн тулд эрдэм шинжилгээний ажлыг¹⁷⁷ гол загвараа болгодог. Мөн ААН-үүд *пост фактум*¹⁷⁸ үр дүнг (жишээлбэл, патент гэх мэт) хялбархан худалдаж авахын оронд эрдэм шинжилгээний ажил (ЭША)-д хөрөнгө оруулдаг шалтгааныг шингээх чадвар гэж үздэг. Дотоодын ЭША-ын баг нь тухайн ААН-ийн шингээх чадварыг нэмэгдүүлнэ. ААН ЭША-д хөрөнгө оруулах тусам гадны шинэ мэдээллийг бүрэн хүлээж авах чадавхтай болдог.[1]

Cohen, Levinthal нар олон талт байдал нь хувь хүнд "огт байгаагүй шинэ нийгэмлэг болон харилцаа холбоос" бий болгох боломж олгодог гэж үзсэн байдаг. Иймээс тэд янз бүрийн хүмүүсийг хамтарч ажиллуулах, юмс үзэгдлийг өөр өнцгөөс харах боломж олгохуйц олон талт баг авч ажиллуулахыг эрхэмлэдэг байв.[1]

Шингээх чадвар нь хуримтлагдах шинжтэй. Энэ нь байгууллагын хувьд, тогтмол байдалтай хөрөнгө оруулах нь нэг удаа бөөн хөрөнгө оруулахаас илүү дөхөмтэй гэсэн үг. Шингээх чадвараа хөгжүүлэх зорилгоор нэгэн үед гаргасан зүтгэл чармайлтыг дараагийн үед арвижуулахад амар байдаг.[1]

¹⁷⁴Cohen and Levinthal (1990), "Absorptive capacity: A new perspective on learning and innovation", Administrative Science Quarterly, Volume 35, Issue 1, pg. 128-152

¹⁷⁵communication

¹⁷⁶background

¹⁷⁷Research and Development

¹⁷⁸Post factum

Cohen, Levinthal нар ЭША-д хөрөнгө оруулахыг маш ихээр анхаарч үзсэн бол олон судлаачид хожим нь шингээх чадварт нөлөөлдөг зарим өөр үзүүлэлтүүдийг нээн илрүүлж, улмаар 2002 онд байгууллагын шингээх чадвар хэмээх шинэ тодорхойлолт бий болгон үзэл санааг нь баяжуулан хөгжүүлсэн¹⁷⁹. Zahra, George нар шингээх чадварыг “ААН мэдлэгийг олж авах, өөрийн болгох, хувиргах болон ашиглах замаар зохион байгуулалт, бүтцийн динамик чадавхтай болохуйц зохион байгуулалтын хэвшмэл ажил¹⁸⁰, процессийн нэгдэл” гэж шинээр тодорхойлсон. Мөн шингээх чадварыг дотор нь болзошгүй шингээх чадвар¹⁸¹, хэрэгжүүлэх шингээх чадвар¹⁸² гэж хуваан авч үзсэн байдаг.[1]

Болзошгүй шингээх чадвар. Zahra, George нарын үзсэнчлэн, болзошгүй шингээх чадвар нь хоёр элементээс бүрдэнэ. Эхнийх нь *мэдлэг олж авахтай* холбоотой, “өөрийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой гадны мэдлэгийг олж тогтоох, түүнийг олж авах чадавх”-ад хамаарна. Хоёрдахь нь мэдлэгийг *өөрийн болгох чадавхтай* холбоотой бөгөөд “гадны эх үүсвэрээс олж авсан мэдээллийг ойлгох, хөрвүүлэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх зорилгоор ААН-ийн авч хэрэгжүүлэх хэвшмэл ажил, процесс”-д хамаарна. Нэгтгэн дүгнэвэл, “болзошгүй шингээх чадвар нь ААН-ийг гадны мэдлэгийг олж авамтгай, өөрийн болгомтгой болгодог”.[1]

Хэрэгжүүлэх шингээх чадвар. Хэрэгжүүлэх шингээх чадвар нь нэг талаас “байгаа мэдлэг болон шинээр олж авч, өөрийн болгосон мэдлэгийг хослуулах замаар хэвшмэл ажлуудаа боловсронгуй болгох, сайжруулах чадавх” буюу *хувиргах чадавхыг* илтгэдэг. Нөгөөтэйгүүр, хэрэгжүүлэх шингээх чадвар нь ААН-ийн *ашиглах чадавхыг* илтгэх бөгөөд үндсэндээ шинээр олж авсан мэдлэгийг үйлдвэрлэл, үйлчилгээндээ нэвтрүүлэх замаар санхүүгийн ашиг олох чадавх юм. Хэрэгжүүлэх шингээх чадвар нь хувиргах болон ашиглах чадавхын функц юм.[1]

Zahra, George нар шингээх чадварын элемент бүрд тохирсон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг санал болгосон байдаг. Үүнд:

- Мэдлэг олж авах чадавх (ЭША эрхэлсэн жил, ЭША-д оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ)
- Өөрийн болгох чадавх (ААН хоорондын патентийн ишлэлийн тоо, ААН-ийн эрдэм шинжилгээний нийтлэлийг бусад ААН-ийнхэд ишлэсэн тоо)
- Хувиргах чадавх (шинэ бүтээгдэхүүний санаа гаргасан тоо, эрдэм шинжилгээний шинэ төсөл санаачилсан тоо)
- Ашиглах чадавх (патентийн тоо, шинэ бүтээгдэхүүн танилцуулсан тоо, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мөчлөгийн урт)

Сэдэвтэй холбогдох бусад судалгааны чиглэлүүд. Шингээх чадвартай холбогдох эрдэм шинжилгээний ажлууд дараах сэдвүүдэд төвлөрч байна. Үүнд: эрдэм шинжилгээний ажил, мэдлэгийн удирдлага (менежмент), бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, хамтын ажиллагаа¹⁸³, нийгмийн баялаг¹⁸⁴, бэлтгэн нийлүүлэгчийн интеграци, хэрэглэгч (худалдан авагч/үйлчлүүлэгч)-ийн интеграци, байгууллага хоорондын нийлэмж¹⁸⁵ гэх мэт[1]

Өнөө үед онолын судалгаа нь байгууллагын суралцах чадвар, аж үйлдвэрийн эдийн засаг, ААН-ийн нөөцөд суурилсан үнэлгээ болон динамик чадавх¹⁸⁶ зэрэг чиглэлээр хөгжиж байна. Тухайн онол нь үндсэндээ боловсронгуй болсон бөгөөд шингээх чадвар гэдгийн дор динамик чадавхыг ойлгодог болжээ.[1]

¹⁷⁹Shaker Zahra and Gerry George (2002), “Absorptive Capacity: A Review, Reconceptualization, and Extension”, Academy of Management Review, Volume 27, Issue 2, pg. 185-203

¹⁸⁰routines

¹⁸¹ Potencial absorptive capacity

¹⁸²Realized absorptive capacity

¹⁸³External interactions

¹⁸⁴Social capital

¹⁸⁵Inter-organizational fit

¹⁸⁶Capability

Шингээх чадвартай холбоотой хоёр концепци байдаг. Үүнд:

- Хүлээн авах чадвар¹⁸⁷: Технологийн тухай мэддэг байх, түүнийг олж тогтоох, үр бүтээлтэй ашиглан давуу байдал олж авах нийтлэг чадамж¹⁸⁸
- Шинэлэг (инноватив) хэвшмэл ажил: Инновацийн чармайлтад төвлөрөх бөгөөд найдвартай ажиллагааг хангахуйц, нэвтрүүлсэн хэвшмэл ажлууд[1]

Хөрөнгө оруулалтын шингээх чадвар нь 2 үе шаттай байдаг. Эхний үе шатыг хөрөнгө оруулалтын бөөний¹⁸⁹ хөрөнгийн үе гэх ба гадаадын хөрөнгө оруулалтын төслийг практикт хэрэгжүүлэхийг хэлнэ. Удаах үе шатанд хөрөнгө оруулалтын үр ашгийг эзэн улсын дадал чадвар¹⁹⁰ болгон хувиргадаг.[2]

Хоёр. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) гэж ерөнхийдөө нэг улсаас нөгөө рүү хөрөнгө, технологи, ноу-хау урсахыг хэлнэ. Олон улсын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтаас шууд өгөөж хүртдэг бол эзэн орон ямар ашиг хүртэх нь тодорхойгүй байдаг. Өнгөц харахад, хөрөнгө, боловсронгуй технологи, сайжруулсан удирдахуйн чадвар зэрэг ашиг тусыг тухайн улсад хүртээнэ. Гэвч *эдгээр ашиг тус нь автоматаар эзэн улсын үр ашиг¹⁹¹ болж хувирдаггүй*. Энэхүү процесс нь эзэн улс хангалттай шингээх чадвартай байх нөхцөлийг шаарддаг. Хөгжиж буй олон улсууд ГШХО-ыг урин далладаг боловч ГШХО-аас ашиг шингээж авахын тулд анхан шатны нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой гэдгийг ойлгодоггүй. Nunnemkamp (2004) аливаа улс ГШХО-ыг ашиглахаас урьтаж эдийн засгийн хөгжлөө минимум түвшинд хүргэсэн байх шаардлагатай, эс бөгөөс ГШХО-аас их зүйл хүлээгээд нэмэргүй гэжээ.[2]

1990-ээд оноос хойш дэлхий даяар ГШХО-ын хэмжээ огцом өссөн. ГШХО-ын хэмжээ 1990 оны үеэс даруй 3 дахин нэмэгдсэн бол 2000 оны байдлаар, хувийн хөрөнгийн урсгалын 50%-иас илүүг хөгжиж буй улсуудад орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Эндээс ГШХО нь дэлхийн бөмбөрцгийг маш их хамарсан, хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих хүчтэй хөшүүрэг болж ач холбогдол нь улам бүр нэмэгдэж, даяаршлын нэгэн илэрхийлэл болсон нь харагдана.[3]

Гэвч хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтөд ГШХО-ын үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байна. Үүний шалтгааныг өмнөх үеийн судалгаануудад тухайн улсын шингээх чадвараас хамаардаг гэж үзсэн. Энэхүү тайлбарын үндэс нь, хөгжиж буй улс нь дэвшилт технологид хандсанаар өөрийнхөө хөдөлмөрийн нийт бүтээмж¹⁹² (ХНБ)-ийг нэмэгдүүлнэ гэсэн ГШХО-ын үзэл санаанд (номлолд) оршино.[3]

ГШХО-аас аливаа эзэн улс ашиг хүртэхийн тулд хангалттай шингээх чадвартай байх ёстой. Шингээх чадвар нь **хүний баялгийн нөөц, дотоодын компаниудын шингээх чадвар, санхүүгийн систем, биет дэд бүтэц, ЭША-ын түвшин, технологийн болон байгууллын¹⁹³ хөгжлөөс** шууд хамаардаг.[2]

Эдийн засгийн өсөлтийг тодорхойлох хүчин зүйлүүд нь шингээх чадварыг тодорхойлдог үзүүлэлтүүдээс бүрдэх бөгөөд өмнөх судалгаануудад эдгээрийг **санхүүгийн зах зээлийн хөгжил, хүний баялгийн түвшин, худалдааны нээлттэй байдал, байгалийн баялаг элбэг байх, өрхийн орлогын түвшин, технологийн зааг** гэж тогтоосон байдаг.[3]

¹⁸⁷Receptivity

¹⁸⁸Ability

¹⁸⁹disbursing

¹⁹⁰Competence

¹⁹¹Spillover

¹⁹²Total-factor Productivity

¹⁹³institutional

ГШХО-ын үзүүлэх нөлөө тухайн улсын онцлог бүхий шингээх чадвараас хамаарна. Судалгаанаас үзэхэд, ГШХО нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлдөг бөгөөд хүний баялаг болон санхүүгийн тогтолцооны түвшнээс *мэдэгдэхүйц* хамаардаг. Гэхдээ тэрээр хөгжиж буй орнуудад өсөлтийн бусад үзүүлэлтүүдийг орлох бус, харин ч гүйцээн дүүргэж өгдөг.[3]

Санхүүгийн зах зээл сайн хөгжсөн улс оронд хөдөө аж ахуй буюу газрын тосны экспорт бага байсан ч оршин тогтнохын үндэс болсон нийгмийн хангалуун байдал¹⁹⁴ дээшлэхэд ГШХО оновчтой тохирдгийг тогтоосон. Судалгаанаас үзэхэд, хэрэв хүний баялгийн хөгжил доогуур эзэн улсад зөвхөн санхүүгийн зах зээл нь сайн хөгжсөн бол ГШХО эерэг үр дагавар үзүүлж байгаа нь ажиглагдсан. Мөн эрчимтэйгээр арилжаа эрхэлж буй газрын тосоор баян улсуудын эдийн засгийн өсөлтөд ГШХО бага нөлөөлдөг нь харагдсан.[3]

Өмнөх судалгаануудаас харахад, ГШХО нь зөвхөн боловсронгуй санхүүгийн зах зээл болон хүний баялаг харьцангуй дээд түвшинд хүрсэн нөхцөлд л эдийн засгийн өсөлтөд нөлөөлж үр ашгаа өгдөг нь тогтоогдсон. Мэдээж ГШХО-ын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг эхний шууд үр ашиг нь гадаадын хөрөнгө оруулагчаас орж ирэх шууд санхүүжилтийн хөрөнгө юм. Удаах үр ашиг нь ихэвчлэн баян улсаас ядуу улс руу шилжих технологи нэвтрэлтээс¹⁹⁵ бүрдэнэ. Romer (1990) нэг ажилтанд ногдох ДНБ¹⁹⁶ улс орнуудын хувьд асар их зааг ялгаатай байна гэдгийг анх удаа олж харсан (өөрөөр хэлбэл, технологи болон бүтээмжийн зааг буюу ХНБ). Үндэстэн дамнасан корпорациуд (ҮДК) дэлхийн ЭША-ын дийлэнхийг хийдгийн хувьд, тухайн хөгжиж буй улсад тэдгээрийн оршин байгаа нь технологи дамжуулалтыг¹⁹⁷ тэтгэдэг. Энэхүү процесс нь технологи дууриалгах¹⁹⁸/зүгшрүүлэхээс¹⁹⁹ авахуулаад аж үйлдвэрүүдийг холбох гүүр болон өндөр бүтээмжийн шинжээр илэрдэг.[3]

Технологи нэвтрүүлэлт нэмэгдэх, бүтээмж дээшлэх, хөгжиж буй зах зээл рүү хандах, бизнесийн ноу-хау дамжуулах болон ажилтныг сургах зэргээр ГШХО нь тухайн эзэн улсын эдийн засгийн өсөлтөд зөвхөн эерэг нөлөө үзүүлдэг гэж үздэг нийтлэг зөн совин²⁰⁰ оршдог. Үр дагавар нь хөгжиж буй улсууд ГШХО-ын хязгаарлалтыг хялбаршуулж, татварын урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх маягаар гадаадын хөрөнгийг урин даллаж байгаагаар илэрнэ. Гэвч ГШХО болон эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарлын чиглэл ямар байгаа буюу ГШХО эдийн засгийн өсөлтийг хангаж байгаа эсэх, эсвэл эсрэгээрээ юу гэдгийг одоогоор *тодорхойлох боломжгүй* байгааг туршлага харууллаа. Ихэнх тохиолдолд үгүй байна. Микро түвшний өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнээс харахад, ГШХО эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлэхгүй байгаа бол макро эдийн засгийн (улсын салбар дамнасан ГШХО-ын урсгалын хүрээний) судалгаанаас үзэхэд, ГШХО эзэн улс шингээх чадвартай нөхцөлд л өсөлтийг түргэсгэдэг. Өөрөөр хэлбэл, эдгээр судалгаанууд гадаадын технологийг нутагшуулах түвшин нь хөгжиж буй улсын шингээх чадвараас хамааралтай гэдгийг харуулж байна.[3]

Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD²⁰¹)-ын 2002 оны тайланд, ГШХО нь технологийн үр ашгийг өдөөж, хүний баялаг бүрэлдэн тогтоход дэмжлэг үзүүлж, олон улсын худалдааны интеграцийг хөхиүлэн дэмжиж, илүү өрсөлдөөнтэй бизнесийн орчин бий болохыг тэтгэж, байгууллагын цар хүрээг өргөжүүлэн тэлдэг хэмээн тусгажээ. Мөн ГШХО-аар дамжин буй технологи аль болох “цэвэр” байх тусам эзэн улсын байгаль орчин, нийгмийн байдалд сайнаар нөлөөлнө гэжээ.[2]

¹⁹⁴welfare

¹⁹⁵Technology diffusion

¹⁹⁶Дотоодын нийт бүтээгдэхүүн

¹⁹⁷Technology transfer

¹⁹⁸imitation

¹⁹⁹adoption

²⁰⁰Common intuition

²⁰¹Organization for Economic Co-operation and Development

De Mello (1997) технологийн зааг хэдий чинээ их байвал ГШХО-аас эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө төдий хэмжээгээр бага байна гэж хэлсэн.[2]

Borensztein, De Gregorio болон Lee (1998) нарын үзсэнээр, аж үйлдвэрийн бүхий л салбарт шинэ технологийн үр шимийг түгээн дэлгэрүүлэх үүргийг мэргэжилтэй боловсон хүчин гүйцэтгэдэг. Эзэн улсын хүний баялгийн түвшин зөвхөн минимум түвшинд байхад л ГШХО нь эдийн засгийн өсөлтийг түргэсгэх чадвартай байдаг. Тэд ГШХО-ын нөлөөгөөр өсөлт бий болох нь хөрөнгийн хуримтлалаас биш харин технологи нэвтрэлтээс илүүтэй шалтгаалдаг гэж үзсэн.[3] Nunnemkamp (2004) тэмдэглэсэнчлэн, ҮДК-д өмнө нь бэлтгэгдсэн ажилтныг авч ажиллуулах нь дотоодын компаниудын хувьд үр дүнтэй.[2]

Blomstrom, Lipsey болон Zejan (1994) нар ГШХО-ын нөлөөгөөр эдийн засаг өсөх нь боловсролоос бус харин тухайн эзэн улсын өрхийн орлогын түвшнээс илүүтэй шалтгаална гэж үзсэн.[3]

ГШХО эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх бас нэгэн шалгуур үзүүлэлт бол Balusubramayam, Salisu болон Sapsford (1999) нарын үзэж байгаагаар худалдааны нээлттэй байдал юм.[3]

Дэлхийн 69 орны 1975-2000 оны хоорондох ГШХО-ын хэмжээ, эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч бусад хүчин зүйлүүдийг судалж үзэхэд, ДНБ-д эзлэх ГШХО-ын хэмжээ Сингапур улсад хамгийн өндөр бөгөөд Өмнөд Африкаас даруй 47 дахин их байна. Дэлхийн дундаж 1.76% байна. Дээрх хугацаанд хамгийн өндөр өсөлтийг Өмнөд Солонгос үзүүлжээ (6.081%). Удаах байрыг Хятад 5.835%-иар эзлэх бөгөөд энэ улсын ДНБ-ий хэмжээ хугацааны эхэнд сүүлээсээ 2 дугаарт бичигдэж байв.[3]

Дээрх судалгаанд шингээх чадварыг эс тооцон үзвэл, эдийн засгийн өсөлтөд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлүүд нь гарааны үеийн өрхийн орлогын түвшин, хүний баялаг, хөрөнгө оруулалтын индекс (ДНБ-нд эзлэх нийт хөрөнгө оруулалтын хувь хэмжээ) байна. Эдгээр үзүүлэлтийн регрессийн коэффициент эерэг бөгөөд 5%-ийн түвшинд эрс мэдэгдэхүйц илэрч байна. ГШХО (регрессийн коэф: 0.224) эерэг, 10%-ийн түвшинд мэдрэгдэх бөгөөд ДНБ-ий өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг нь ажиглагдлаа. Санхүүгийн хөгжлийн үзүүлэлтийн коэффициент (хувийн зээл²⁰²) эерэг бөгөөд 10%-ийн түвшинд мэдэгдэхүйц статистиктай байна. Энэ нь юу вэ гэвэл, хувийн зээлийн хувь хэмжээ 1% өсөхөд ДНБ-ий өсөлт 0.05% байна гэсэн үг.[3]

Харин шингээх чадварыг хамтруулан тооцож үзвэл, ГШХО-санхүүгийн хөгжлийн индекс гэсэн хослол 5%-ийн мэдэгдэхүйц түвшинд 2 дахинаас илүүтэйгээр өсөлтөд нөлөөлдөг болох нь харагдлаа. Эндээс ГШХО-аар эдийн засгийн өсөлтийг хангахад санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин шийдвэрлэх үүрэгтэй гэдэг дүгнэлт хийж болохоор байна. ГШХО-Хөдөө аж ахуй гэсэн хослолын хувьд, харилцан хамаарлын коэффициент сөрөг бөгөөд үл мэдэгдэхүйц байна. Эндээс дүгнэхэд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нь ГШХО-аар дамжин эдийн өсөлтөд бага нөлөө үзүүлдэг. Газрын тосны экспорт, хүний баялгийн хувьд ГШХО-ын итгэлцүүр эерэг боловч үл мэдэгдэхүйц байгаа бол худалдааны нээлттэй байдлын хувьд харин ч сөрөг (үл мэдэгдэхүйц) нөлөөтэй байна.[3]

Цаашлаад өрхийн орлогын үзүүлэлтийг судалж үзэхэд, хөгжингүй болон өрхийн орлого ихтэй OECD-ын орнуудад ГШХО-ын итгэлцүүр сөрөг бөгөөд үл мэдэгдэхүйц байна. Гэхдээ хүний баялаг болон худалдааны нээлттэй байдлаар, бүр цаашлаад хувийн зээл болон хөдөө аж ахуйгаар ч шингээх чадварыг төлөөлүүлэн авч үзвэл, ГШХО-ын итгэлцүүр мэдэгдэхүйц болж байгаа нь харагдлаа. Түүнчлэн, ГШХО-сургалт гэсэн хослол 5%-ийн

²⁰²Private credit

түвшинд мэдрэгдэж байна. Энэ нь хүний баялгийн оюуны өндөр чадавх нь ГШХО-аар дамжин эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлдөг гэж өмнөх судалгаануудад дурдсан байдгийг нотолж байна.[3]

Байгалийн баялаг арвин байх нь эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүйг судалгаа харууллаа. Эрчимтэйгээр олборлож буй газрын тосоор баян улсуудын өсөлт нь ҮДК-иудын тэдгээр орнуудад оруулах хөрөнгө оруулалтыг бууруулахад нөлөөлж байна.[3]

Ингээд дээрх гадаадын шууд хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаанууд дээр үндэслэн доорх байдлаар дүгнэх буюу анхаарал татах асуудлуудыг нэгтгэн тоймлож болохоор байна. Үүнд:

1. Улсын эдийн засгийн өсөлтийг тодорхойлох хүчин зүйлүүд нь шингээх чадварыг тодорхойлох үзүүлэлтүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь санхүүгийн зах зээлийн тогтолцоо, хүний нөөцийн баялгийн оюуны чадавх, байгууллын тогтолцоо, өрхийн орлого, худалдааны нээлттэй байдал, биет дэд бүтэц, эрдэм шинжилгээний ажил буюу технологийн заагийн түвшин болон байгалийн нөөцийн баян байдал болно.
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас эерэг үр ашиг хүртэхэд хамгийн үр дүнтэй хүчин зүйл буюу амин чухал үүрэгтэй шалгуур үзүүлэлт бол хамгийн бага түвшний хүний нөөцийн баялаг болон сайн хөгжсөн санхүүгийн зах зээлийн тогтолцоо юм.
3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгосон орнуудад байгалийн нөөцөөр хомс буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ бага ч гэсэн санхүүгийн зах зээлийн тогтолцоо нь сайн хөгжсөн улсууд багтаж байна.
4. Сайн хөгжсөн санхүүгийн зах зээлийн нөхцөл нь хүний баялгийн босго түвшинтэй харьцуулахад илүү давамгай ач холбогдолтой.

Гурав. Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар[4]

Сүүлийн жилүүдэд манай улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулалтын орчин нөхцөл сайжирч, эдийн засгийн бодит салбарууд болон дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хурдацтайгаар нэмэгдсээр байна. Манай улсад 90 орчим орны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийж, 40 орчим улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талын хэлэлцээр байгуулжээ.

Дэлхийн зах зээл дэх газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, түүхий эдийн үнэ тариф огцом өсч, үүнтэй уялдан “Оюу толгой”, “Таван толгой” зэрэг ашигт малтмалын баялаг, томоохон орд, газруудын ашиглалттай холбоотойгоор манай улсын уул уурхайн салбарт ихээхэн хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөл бүрдээд байна. Хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар яригдах болж тухайн нэг оронд оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалт ашигтай байх эсэх нь тухайн орны хөрөнгө оруулалтын шингээх чадвараас ихээхэн хамаардаг болохыг судлаачид тогтоосон байдаг. Манайд гадаадын хөрөнгө оруулалт ихээр орж ирж байгаа хэдий ч үр дүн нь хангалтгүй байх тохиолдол байсаар байна. Энэ нь шингээх чадвар муутайн шинж гэж дүгнэсэн байдаг.

2007 онд зохион байгуулагдсан Монголд хөрөнгө оруулагчдын техникийн уулзалтын үеэр 2015 он хүртэл хугацаанд Монголын үндэсний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд 10 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шингээх чадвар бий гэж дүгнэсэн байдаг.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар манай улсад хийгдсэн судалгааны ажлуудаас эдийн засгийн ухааны доктор, профессор, академич Т.Доржийн 2008 онд хийгдсэн “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар”, мөн академич Т.Доржоор удирдуулсан оюутны дипломын ажлууд, 2011 онд Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооноос ойрын жилүүдэд уул уурхай болон дэд бүтцийн салбарт олон төслүүд хэрэгжихээр байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, манай улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар нарийвчилсан тооцоо судалгаа хийх зорилгоор “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа”-г хийсэн байна. Уг судалгаанд мөн эдийн засгийн ухааны доктор, профессор, академич Т.Дорж зөвлөхөөр ажилласан байна.

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар хийгдсэн анхны бодлогын судалгаа гэж хэлж болох “Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа” нь өргөн хүрээг хамарсан, гадны эрдэмтэдийн дэвшүүлсэн онол, практик, аргачлал, тооцоо судалгаа, санал зөвлөмжийг нэг бүрчлэн тусгасан томоохон судалгааны ажил юм.

Уг судалгааны ажилд дотоодын болон гадаадын шууд хөрөнгө оруулалт манай улсад эрчимтэй өссөөр байгаа хэдий ч одоо болтол Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаар тодорхой судалгаа хийгдээгүй байгааг онцолсон байна. Энэхүү судалгааг хийснээр манай улс цаашдаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөртөө татахад үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой юу эсвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахаасаа өмнө шингээх чадвартай болох хэрэгтэй юу гэдгийг зохистой шийдвэрлэх боломжтой болно хэмээн үзжээ.

2008-2012 оны байдлаар манай улсын уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтмол нэмэгдэж, 2010 онд ГШХО-ын 80 хувьд хүрсэн тооцоо байна. Тус судалгаанд хөрөнгө оруулалтын шингээх чадварын тухай ойлголт, онол, практик, хэрэглэгдэж болох болон ихэвчлэн хэрэглэдэг салбарууд, тодорхойлогч хүчин зүйлс буюу шингээх чадварт нөлөөлдөг хүчин зүйлсийг эрдэмтэд, судлаачид янз янзаар тодорхойлж, олон сонирхол татахуйц судалгааны үр дүн гарсан талаар дэлгэрэнгүй дурдсан байна.

Ихэнх судалгааны ажлуудад гадаадын хөрөнгө оруулалт ашигтай байх эсэх нь тухайн орны хөрөнгө оруулалтын шингээх чадвараас ихээхэн хамаардаг болохыг тогтоосон байна. Хувь хүмүүс шингээх чадвараа дээшлүүлж чадвал энэ нь байгууллагын шингээх чадварыг өсгөнө, байгууллагууд шингээх чадвараа дээшлүүлж чадвал улс орны шингээх чадвар өснө гэсэн хөрөнгө оруулалтын шингээх чадварын үндсэн санаад тулгуурлан Сигне Кругстрап, Линда Матаар нар:

1. Технологийн ялгаа
2. Ажиллах хүчний боловсролын түвшин
3. Санхүүгийн хөгжил
4. Институцийн хөгжил гэсэн хүчин зүйлүүдийг ашиглан тухайн нэг улс орны хөрөнгө оруулалтын шингээх чадварыг тодорхойлох боломжтой гэж нотолсон байдаг.

Дээр дурдсан 4 хүчин зүйлийн дагуу Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар хэр байгаа, шингээх чадварт нөлөөлөх техник технологийн нөлөө, загвар, тооцоолол, ажиллах хүчний нөлөөлөл, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх, санхүүгийн системийн нөлөөлөл ба эдийн засгийн халалтын судалгаа, мөн хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх институцийн хөгжлийн нөлөөллийг эдийн засгийн судалгаа, шинжилгээний олон аргаар тооцоолон судалж, үнэлэлт дүгнэлт өгсөнөөс тоймлон авч үзвэл:

1. Техник, технологийн түвшин хөрөнгө оруулалтын шингээх чадварт хэрхэн нөлөөлж байгаа талаар:

Манай улсын эдийн засагт ХАА, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Энэ нь эдийн засагт аж үйлдвэрийн салбар тэргүүлж буй мэт дүр зургийг харагдуулж байгаа боловч мэдлэг шингэсэн, эцсийн үйлдвэрлэл маш бага харин эрдэс түүхий эдийн олборлолтод суурилсан, уул уурхайн салбарын хөгжил түлхүү болж, уг салбарын цөөн нэр төрлийн бараа, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнээс манай эдийн засаг ихээхэн хамааралтай байна.

ГШХО-ын улс орны хөгжилд үзүүлэх нөлөөллийг технологийн зөрүүний индексийн арга (Ли болон Лю, 2005), бүтээгдэхүүний технологийн агууламжид үндэслэх арга (Эдвардо Бронгстейн, 1996), бүтээмжид үндэслэсэн арга (Алмас Хэшимати 2010)-ыг ашиглан тодорхойлдог. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч байгаа орны техник технологийн хөгжил хэдий чинээ бага байна, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тус улсын өсөлтөд үзүүлэх нөлөө төдий чинээ бага байдаг байна.

Технологийн зөрүүний индексийн аргаар босго оноог 12.6 гэж тодорхойлсон байдаг бөгөөд технологийн зөрүүний индекс 12.6-аас бага байвал тухайн оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт эерэгээр нөлөөлж байна гэсэн үг юм. Манай орны хувьд энэ үзүүлэлт нь 1990-2010 онуудад технологийн зөрүүний индекс 12.6-аас дээгүүр утгатай байгаа нь тухайн хугацаанд технологийн түвшнийхээ хувьд ГШХО-ын үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй гэсэн дүгнэлтийг өгчээ.

Монгол Улсын технологийн зөрүүний индекс өнгөрсөн 20 жилийн хугацаанд тогтворгүй байсан. Тиймээс манай улсын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалаас үр ашиг олохын тулд технологийн дэвшил хийх шаардлагатай гэж үзсэн байна. Мөн уг судалгаанд Монгол Улс одоогоор судлагдаж, олборлох, ашиглах үйл ажиллагаа эрчимжиж байгаа эрдэс баялгийн төрлөөс хамааруулан технологийн зөрүүний индекс багатай улсаас хөрөнгө оруулалт авснаар хөрөнгө оруулалтын шингээх чадвараа нэмэгдүүлэх боломжтой боловч энэ нь урт хугацаандаа үр ашигтай байж чадахгүй гэж үзжээ.

Манай улсын экспортын бүтээгдэхүүний технологийн агууламжийг шинжлэхэд технологийн агууламжгүй бүтээгдэхүүн 1994 онд нийт экспортын 74 хувийг эзэлж байсан бол 2004 онд 43 хувь хүртэл буурсан нь экспортын хувьд гарсан ахиц юм. Гэвч 2005-2010 онд нийт экспортод эзлэх технологийн агууламжгүй бүтээгдэхүүний хувь 44.66-аас 83.22 хувь хүртэл өсчээ. Нам, дундаж доор, дундаж, өндөр технологит бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь 1994-2004 онд харьцангуй тогтвортой байсан боловч 2005 оноос тасралтгүй буурсан байна.

Япон, АНУ, Герман, БНСУ зэрэг орны хувьд экспортын бүтээгдэхүүнд нам технологит бүтээгдэхүүн 10-20 хувь, дундаж өндөр технологит бүтээгдэхүүн 30-40 хувь, өндөр технологит бүтээгдэхүүн 20-40 хувийг эзэлж байдаг бол манай улсын хувьд нам технологит бүтээгдэхүүн 83.22 хувийг эзэлж, өндөр технологит бүтээгдэхүүний экспорт бараг байхгүй байна.

Бүтээгдэхүүний технологийн агууламжийн аргаар шинжлэн үзэхэд манай улс технологийн хоцрогдолд орсон гэж дүгнэжээ. Хэрвээ дундаж доод түвшнээс дээш технологийн агууламж бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарч технологийн бодлого хөтөлбөр хэрэгжүүлбэл хөрөнгө оруулалтын хэмжээ болон үйлдвэрлэлийн хэмжээг эрс нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн.

Манай улсын ДНБ-ий 60 орчим хувийг 5 дэд салбар үйлдвэрлэж, экспортын орлогын 70-аас дээш хувийг 5 нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж байгаа бөгөөд ноолуураас бусад нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүн байна. Үүнээс манай улсын эдийн засгийн бүтцийг хөдөө аж ахуй, уул уурхайн олборлох салбарын бүтээгдэхүүн зонхилсон өрөөсгөл бүтэцтэй хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улсын экспортын бүтцийн 80-аас дээш хувийг технологийн багтаамжгүй бүтээгдэхүүн, үлдсэн дийлэнх хэсгийг нам, дунд технологи шингэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ нь нийт экспортын 80 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байгаатай холбоотой. Эндээс манай улс технологийн агууламжгүй, нэмүү өртөг шингээгүй бүтээгдэхүүнийг голлон экспортолж байна.

Өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн урт хугацааны өсөлтөд нөлөөлөх технологийн нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг байхад манай улсын хувьд судалгаа ба хөгжилд оруулсан зардлын нийт төсөвт эзлэх хувь нэмэгдэхгүй байна.

Аж үйлдвэр, дэд бүтэц, технологийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг ОУЗЗ дээр гаргахын тулд тэргүүлэх салбарын технологийн хөгжлийн зураглалыг хийдэг тогтолцоотой болох, үндэсний технологийн хөгжлийн түвшний үнэлгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тогтмол хийдэг болох, манай орны хувьд технологийн хоцрогдлыг багасгах, үндэсний тэргүүлэх чиглэлийн технологиудыг дотооддоо хөгжүүлж, шаардлагатай технологийг гадаадын орнуудаас авч нутагшуулах, ирээдүйн технологийг бий болгохын тулд одооноос шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

2. Хөрөнгө оруулалтын шингээх чадварт ажиллах хүчний чадавх нөлөөлөх нь:

1993 онд батлагдсан гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд “Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуй нэгж байгуулах, эсхүл Монголын ААН-тэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ”²⁰³ гэж тодорхойлжээ. Энэхүү хуульчилсан тодорхойлолтоос үзвэл хөрөнгө оруулалт нь эд хөрөнгийг бий болгохоос гадна оюуны үнэт зүйлсийг тодруулбал хүний оюунлаг хүчин зүйлийг багтаасан ойлголт учраас хүний хүчин зүйл, хүний хөгжил, ажиллах хүчний боловсролын түвшний хөрөнгө оруулалтыг шингээх чадварт үзүүлэх нөлөөллийг судлах энэ талын тооцоог бодитой хийх нь өндөр үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг бий болгоно.

Онолын үүднээс үзвэл ГШХО орж ирэх нь эдийн засгийн өсөлтөд эерэг шууд нөлөөтэй бөгөөд эдийн засгийн хөгжилд орчин үеийн шинэ техник, технологи, хүмүүсийн ерөнхий мэдээлэл, мэдлэг, чадвар дээшлэх, ажлын байр бий болох (өрхийн орлого нэмэгдэх), дэд бүтцийн орчин сайжрах, татварын орлого өсөх зэрэг хөгжлийн үзүүлэлтээр дамжин дам нөлөөг үзүүлдэг. Хөрөнгө оруулалтын дээрх эерэг үр дүн бий болохын хэрээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх бөгөөд үүнтэй уялдан санхүүгийн зах зээл улам бүр тогтвортой болно.

Гадаадад боловсрол эзэмшсэн мэргэжилтний тоо хэдий чинээ их байвал төдий чинээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын эерэг нөлөө өндөр байна гэж үздэг. Ажиллах хүчний боловсролын түвшний хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзсэн судалгааг хийхэд ажиллах хүчний чанарын түвшинтэй заавал холбох хэрэгтэй болдог. Ажиллах хүчин бол хүн аливаа нэг хэрэгцээний өртгийг бий болгох явцад ашиглаж байгаа оюуны болоод биеийн хүчний чадвар юм.

²⁰³“Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” УБ 1993. 2 дахь тал.

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр олон улсын хөрөнгө оруулалттай, ажилчин хүчний хөдөлмөрийн үнэлэмж өндөр хар зам тавих, барилга байгууламж барих, тохижилт хийх, тоног төхөөрөмж угсрах зэрэгт яагаад Монгол ажилчид ажиллахгүй гадаадын хятад ажилчид голлон ажиллаад байгаагийн шалтгаан нь хөдөлмөрийн нийлүүлэлтийн чанарын түвшин, ажиллах хүчний чанар хувийн хэвшлийн нөхцөлд гологдож байгаатай холбоотойг Монголын хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэсэн байна.

Иймээс ажиллах хүчний чанарыг өндөржүүлэхэд шууд хөрөнгө оруулалт нь мэргэжлийн өндөр түвшинг шаардах талаасаа ч, ерөөсөө боловсрол эзэмшээгүй байсан ч шууд хөрөнгө оруулалт нь ажиллах хүчний чанарыг өндөржүүлдэг гэж үздэг.

Боренсзтай, Корковик, Ливэйжи, Эйлфейро нарын онолын үүднээс авч үзсэн ч ажиллах хүчний чанар өндөржиж бүтээмж өсч, орлогыг илүү ихээр бий болгож, ажиллах хүчний ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлдэг болохыг тодорхойлсон байна. Хамгийн гол нь ШХО нь мэргэжил, мэргэшил олгох цаг хугацааг хэмнэдэг гэж үзжээ.

Ажиллах хүчний чанарын өсөлт нь ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлэх төдийгүй, бүтээмжийг өсгөх, олон улсын зах зээлээс шууд хөрөнгө оруулалтыг илүү олох, хүмүүс эрх чөлөөгөө эдлэх гол хүчин зүйл болдог байна.

Манай улсын ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувийг сүүлийн 10 жилээр авч үзвэл эхний 8 жилд дунджаар 20 орчим хувь байснаа 2009-2010 онд 24 хувь болж өссөн байна. Энэ үзүүлэлтийг дэлхийн улс орнуудын хандлагатай харьцуулж үзвэл ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувь харьцангуй доогуур байгаа нь ажиллагчдын дотор хувиараа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэгчдийн эзлэх хувийн жин өндөр байгаатай холбоотой байж болох юм. Хэрэв Монгол Улсад нийт ажиллагчдын 50,0–аас дээш хувийг эзэлж байгаа хувиараа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэгчдийн хөдөлмөрийн орлогыг оруулан тооцвол ДНБ-нд цалин хөлсний эзлэх хувийн жин дэлхийн түвшинд ойртох магадлалтай юм. Тиймээс малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг аж ахуйн зохион байгуулалтад оруулах нь бүтээмж болон цалин хөлсний аль алийг нь нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

Манай улсын хувьд хөдөлмөрийн бүтээмж болон дундаж цалингийн өөрчлөлтийн хооронд эерэг хамааралтай байгаа бөгөөд хөдөлмөрийн бүтээмж буурахад цалин хөлс буурч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхэд дундаж цалин өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь цалин хөлсийг нэмэгдүүлэх хүчин зүйл гэдгийг илэрхийлж байна. Ажиллах хүчний зардал нь зөвхөн цалингаар хязгаарлагдахгүй, ажиллагсдын шагнал, урамшуулал, хоол, унааны зардал нийт зардалд тооцогдох ёстой. Мөн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу ажиллагчид цалин орлогоосоо нийтдээ 29 хувийн таван төрлийн татвар, шимтгэл төлдөг.

Монгол Улсад эдийн засгийн өсөлт нэмэгдэх хирээр нэрлэсэн дундаж цалин өсч байгаа ч инфляцийн түвшнээс хамааран бодит цалингийн өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, ажиллагчдын дундаж цалин 2005 онд 9 хувь, 2006 онд 26 хувь, 2007 онд 35 хувь, 2008 онд 58 хувиар тус тус нэмэгдсэн боловч түүний бодит өсөлт 2005 онд -0.8 хувь, 2006 онд 20, 2007 онд 17.7, 2008 онд 36.4, 2009 онд 5.4 хувь, 2010 онд 0.6 хувь байна. Энэхүү бодит цалингийн өсөлтөд тухайн жилийн инфляцийн түвшин нөлөөлж байгаа бөгөөд инфляцийн түвшин дундаж цалингийн өсөлтөд ойртох тутам ажилчдын цалингийн бодит өсөлт багасч, дундаж цалингийн өсөлтөөс инфляцийн түвшин бага байхын хирээр дундаж цалингийн бодит өсөлт харьцангуй өндөр болж байна. Үүнээс үзвэл цалин хөлсний өсөлт, түүний ажиллагчдын амьжиргаанд үзүүлэх нөлөө макро эдийн засгийн тогтвортой байдлаас ихээхэн хамааралтай байна.

Судалгаанаас харахад Монгол Улсын хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь ажиллах хүчний нөөц боломжийг өндөр түвшинд ашиглах, түүнд хүрэх оновчтой арга зам, гарцыг тодорхойлох ёстой гэж үзээд оновчтой гарц нь ажиллах хүчний хөрөнгө оруулалтыг шингээх чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай зардлын прогнозыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан тооцох явдал гэж үзсэн байна. Ингэснээр бүх хүмүүст таатай, бүтээмж өндөртэй, зохистой хөдөлмөрийг бий болгох, олон улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн бодлогод нийцэж зохицох болно. Хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээлийн ийм оновчтой бодлогод хүрэх зорилтын үүднээс Монгол Улсын хүн ам, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хүчний ашиглалттай уялдсан 2012-2021 оны хөгжлийн стратегид үндэслэсэн Монгол Улсын хөрөнгө оруулалтыг шингээх ажиллах хүчний чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай зардлын 2012-2021 оны прогнозыг эдийн засаг, математикийн аргаар тооцож дараах санал дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт нь боловсрол олгох хугацааг хэмнэдэг учир боловсролд зориулсан зардалтай уялдуулж байх
- ГШХО-ыг тухайн орны хүн капиталын хөгжлийн түвшинг хамт авч үзсэн нөхцөлд л эдийн засгийн өсөлтөд бусад капиталын бүрдлийн хэлбэрүүдээс илүү үр ашиг өгдөг байна.
- Өндөр хөгжилтэй орнуудад боловсрол эзэмшсэн мэргэжилтний тоо хэдий чинээ их байвал төдийн чинээ гадаадын хөрөнгө оруулалтын эерэг нөлөө өндөр байна гэдгийг бодолцон хөрөнгө оруулалтад тусгах, инвестиц хүнд зориулсан хөрөнгө оруулалтыг тооцдог байх
- Эрчимтэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах хөдөлгөгч хүч болдог тул шууд хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийг дэмжихэд түлхүү хуваарилах шаардлагатай байна.

3. Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх санхүүгийн системийн нөлөөлөл

Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт сүүлийн 10-аад жилийн хугацаанд харьцангуй тогтвортой өсч, сүүлийн жилүүдэд ДНБ-ий 30-40 хувьтай тэнцэх түвшинд хэлбэлзэж байна. Нийт хөрөнгө оруулалтад дотоодын хөрөнгө оруулалт 40 хувийг, гадаадын хөрөнгө оруулалт 60 хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын 50-55 орчим хувийг тоног төхөөрөмж, 25-30 хувийг барилга угсралт, 15-20 хувийг бусад зүйлд зарцуулж байна.

Дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байна. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлын хэмжээ 2010 онд 664,3 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 38 хувиар өсч, харин 2011 онд хөрөнгийн зардлын хэмжээ өмнөх онтой нь харьцуулахад бага зэрэг буурсан буюу 627,7 тэрбум төгрөгөөр батлагджээ. Зарим судалгаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч буй орны санхүүгийн зах зээлийн хөгжил тодорхой хөгжлийн түвшинд хүрсэн тохиолдолд улс орны хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг гэж баталсан байдаг.

Санхүүгийн тогтвортой байдал гэх ойлголт нь өргөн хүрээг хамардаг бөгөөд /Олон улсын валютын сан/ ОУВС болон улс орнуудын хувьд тэдгээрийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын орчин, банк санхүүгийн зах зээл, үнэт цаасны зах зээл болон бусад салбаруудыг төлөөлүүлэн авч үздэг. Аливаа улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь тухайн улс орны хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг байдаг. Улс орон болгон өөрийн онцлогоос хамааралтайгаар санхүүгийн тогтвортой байдлыг авч үздэг.

Манай орны хувьд санхүүгийн тогтвортой байдлыг эдийн засгийн орчин, олон улсын эдийн засаг үнийн орчин, хөрш орнуудын эдийн засгийн байдал, санхүүгийн салбарыг төлөөлүүлэн авах (манай орны хувьд санхүүгийн зах зээлийн 95.3 хувийг банкны

салбар эзэлдэг) боломжтой. ОУВС-аас санхүүгийн системийн тогтвортой байдал, түүнийг хүчирхэгжүүлж хяналт тавих, үнэлгээ хийхэд туслах зорилгоор санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцдог болсон. Өнгөрсөн үеүүдэд гарч байсан олон улсын банк, санхүү, эдийн засгийн хямралууд нь санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-аас тооцоолох шаардлагыг бий болгосон бөгөөд гишүүн орнуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн жагсаалт болон тооцоолох аргачлалыг боловсруулан гаргасан байдаг. Үүний үр дүнд санхүүгийн тогтвортой байдлын 40 үзүүлэлтийг ОУВС-ийн удирдах зөвлөлд танилцуулан батлуулсан байдаг. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь тухайн улс орны санхүүгийн салбарын дүр зургийг харуулах бөгөөд олон улсад мөрддөг тул улс орнуудаар харьцуулалт хийхэд тохиромжтой гэж үздэг.

Одоогийн байдлаар, манай улсын банкны салбарт 14 банк нийт 1,272 салбар нэгж, 11,760 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Банкуудын нийт харилцагчдын тоо 2011 оны 8 дугаар сарын байдлаар 6.1 сая болж өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 3.2 саяар өссөн байна. Мөн нийт хадгаламж эзэмшигчид 1.1 дахин буюу 200 мянга, эзэлдэгчид 90 мянгаар буюу 18.2 хувиар өссөн байна. 2012 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудын нийт активын хэмжээ 10.9 триллион, үүний 92 хувь хөшүүрэг эзлэж байна. Активын хэмжээ сүүлийн гурван жилийн хугацаанд 1.85 дахин өссөн хэдий ч хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт нь хөшүүргийн өсөлтийг гүйцэхгүйгээс шалтгаалан эрсдэл даах чадвар буурч байна. 2000 оноос хойш авч үзвэл дунджаар 12 хувь байгаа ба 2012 оны жилийн байдлаар 8,3 хувь байгаа нь дундаж утгаас доогуур буюу эрсдэл даах чадвар бага байна хэмээн дүгнэсэн байна.

Манай улсын 6 банк гадаадын хөрөнгө оруулалттай буюу эзэмшилд байгаа бөгөөд энэ нь нийт системийн 43%-г эзэлж байна. Өөрөөр хэлбэл Монголын санхүүгийн системд гадаадын хөрөнгө оруулалт маш их хэмжээгээр нэвтэрсэн нь харагдаж байна. Монголбанкны явуулж буй бодлого нь санхүүгийн болоод эзэмшлийн хувьд эрүүл тогтвортой байлгах үүднээс арилжааны банкуудад тавьж буй хяналт шалгалтаа чангатгаж байна.

Манай орны эзэлдэх зэрэглэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Фич, Мүүдиз, Стандарт энд Пүэрс байгууллагууд “B+”²⁰⁴ хэмээн тогтоосон байна.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх санхүүгийн системийн нөлөөллийн судалгаанаас дараах хэд хэдэн дүгнэлтийг хийсэн байна. Үүнд: Засгийн газрын хэрэгжүүлж буй Төсвийн бодлого нь макро эдийн засгийн суурь хөгжил, иргэдийн амьжиргааны баталгаат байдал зэрэгт түлхүү анхаарч байна. Нөгөө талдаа эдгээр бодлого нь хэт их үрэлгэн нүсэр бүтцээр явж байгаа нь эргээд эдийн засагтаа сөрөг хамаарлыг авчрах магадлалтай. Ялангуяа хөгжиж буй орны хувьд үнийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой байдал нь хамгаас чухал бөгөөд үүний төлөө мөнгөний болон төсвийн бодлого уялдаж байх ёстой байдаг. Мөн Монгол Улсын эдийн засагт мөнгөний бодлогын арга хэрэгсэлд гарах өөрчлөлт 4-8 улирлын дараа инфляцид хамгийн хүчтэй нөлөөлдөг ба мөнгөний бодлогын харьцангуй удаан үйлчлэл нь төсвийн идэвхтэй, хариуцлагатай бодлого явуулахыг шаардсан баримт хэмээн ойлгож болно. Өөрөөр хэлбэл, эрдэс баялгаас хараат байж тогтвортой мөчлөг сөрсөн, хариуцлагатай төсвийн тогтолцоотой байх хэрэгтэй гэсэн санаануудыг гаргасан байна.

Тус судалгаанд уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, түүнийг дагасан их хэмжээний мөнгөн урсгалын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт огцом нэмэгдэж улмаар мөнгөний зөрүүг халааж байгаа ба төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр нийт эрэлтийг урамшуулж иргэдийн хэрэглээгээр дамжин эдийн засаг халж байна гэж үзсэн байна. Эдийн засаг халахын хэрээр түүнийг мөнгөний нийлүүлэлт өмч буй нь гэнэтийн уналтыг бий болгох магадлал

²⁰⁴ Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 5 дахь илтгэл, 2013 он.

өндөр байдгийг бусад улсуудын жишээнээс харж болох бөгөөд уул уурхайн олборлолт дагасан эрэлтийн илүүдэл бүх салбарт шингэж нийт эрэлтийг дэвэргэн дахин хямралын байдлыг давтах нөхцөл байдал бүрдээд байгааг онцолсон байна. Арилжааны банкуудын зээл олголтын байдлаар ялган үзвэл иргэдийн хэрэглээний зээлийн хэмжээ огцом ихээр нэмэгдэж буй нь иргэдийн эрэлтийг улам ихээр урамшуулж халалт нэмэгдэхэд үлэмж нөлөөтэй байна.

Эндээс улсын төсөв түүний урсгалын зардлын өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн халалт бий болж байна гэж үзэх үндэслэлтэй бөгөөд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа нь манайх шиг түүхий эдийн арвин баялаг нөөцтэй орны хувьд эерэг нөлөөтэй боловч тогтвортой өсөлтийн орчныг бүрдүүлж чадахгүй байгаа нь алдаатай үзэгдэл юм. Төсвийн орлогын илүүдэл нь нэг талаас эдийн засгийг дэмжих чухал хэрэгсэл ч нөгөө талаас эдийн засаг дахь тэлэх бодлогыг хөөргөдөг сул талтай. Мөн судалгаанд манай улс дан ганц түүхий эдийн үнэ дээр түшиглэсэн эдийн засгийг хөгжүүлж байгаа нь эрсдэлтэй хэмээн үзсэн байна. Монголын санхүүгийн системийн хөгжил эрчимтэй явагдаж байгаа бөгөөд банк давамгайлсан бүтэцтэй байгаа нь санхүүгийн зуучлалыг цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Харин МУИС-ЭЗС, Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн хамтран явуулсан бодлогын судалгааны дүгнэлтээс харахад Төсвийн бодлого нь бизнесийн мөчлөг дагасан шинж чанартай байна гэж удаа дараа тэмдэглэсэн ба улсын төсөв, төсвийн бодлого нь эдийн засгийг тогтворжуулах үүрэг, зорилгоосоо хазайж эдийн засгийн бодлого чанараа алдаж байна гэж дүгнэсэн байна.

Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн хоорондын нөлөөллийг тооцоход зэсийн ханш нь хөрөнгө оруулалтад богино хугацаанд эерэг нөлөөтэй байгаа ч дунд хугацаанд бага зэрэг сөрөг нөлөөтэй, зээлийн хүү нь хөрөнгө оруулалтад сөрөг, Хэрэглээний үнийн индекс нь хөрөнгө оруулалтад нэг улирлын дараа эерэгээр нөлөөлж байгаа бол харин хоёр улирлын дараа сөргөөр нөлөөлнө гэсэн үр дүн гарчээ. Энэ нь ерөнхийдөө зэсийн ханш хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэй байгааг харуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулагч нар нь мөнгөө үнэгүйдлээс хамгаалах зорилгоор бас хөрөнгө оруулалт хийдэг болох нь харагдаж байна. Зээлийн хүү өсөх нь компаниудын зээл авах боломжийг хязгаарладаг учраас хөрөнгө оруулалт нь зээлийн хүүнээс сөргөөр хамаарч байна. Зээлийн хүү 1%-иар буурахад нийт хөрөнгө оруулалт 31370 сая төгрөгөөр нэмэгдэх хандлагатай гэж үзжээ.

4. Хөрөнгө оруулалтын шингээх чадварт институцийн хөгжлийн нөлөөлөл

Институци нь хүмүүсийн хооронд үүсч буй харилцаа, үйлдлийг зохицуулах журмууд ба тэдгээрийг хэрэгжүүлэх орчин, хэрэгслүүд гэж үзэж болно. Шинжлэх ухааны утгаар нь авч үзвэл институци нь хүмүүсийн хоорондох аливаа харилцаа, солилцоог журамласан нийгмийн журмууд бөгөөд:

- албан журмууд /хууль, хуулийн зохицуулалт, эрх зүйн орчин/
- албан бус нийгмийн журмууд /нийгмийн ёс, дэг, уламжлал/
- тэдгээрийн биелэлт, хэрэгжилт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Мөн бизнесийн дүрэм журам, өмчийн эрхийн хамгаалал, авлигал зэргийг институцийн үзүүлэлт болгож авч үзсэн. Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч маш олон дутагдалтай тал, санал шүүмжлэл, эсэргүүцэлтэй тулгарсаар ирсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс Засгийн газраас бодлогын чанартай олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн өөр нэг бүлэг хууль бол Чөлөөт бүсийн тухай, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, Замын-Үүд

эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай, Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд юм. Хэдийгээр эдгээр хууль хөрөнгө оруулалтын асуудлыг боломжийн хэмжээнд зохицуулсан боловч төрийн албаны хүнд суртал, гадаад сурталчилгаа, хөрөнгө оруулагчдыг татах бодлого, хөрөнгийн гачигдал, ажлын арга барил, зохион байгуулалтаас шалтгаалж тун хангалтгүй хэрэгжиж байна хэмээн дүгнэсэн байна.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо зах зээлд чиглэсэн (market-seeking), ашигт малтмалд чиглэсэн (resource-seeking), үйлдвэрлэлийн бүтээмжид чиглэсэн (efficiency-seeking), стратегийн нөөц баялаг болон чадварт чиглэсэн (strategic asset or capability-seeking) хөрөнгө оруулалтын алинд нь түлхүү анхаарал тавих, дэмжих, ямар хөнгөлөлт үзүүлэх бодлогыг сайтар тодорхойлох хэрэгтэйг судалгааны баг онцолсон байна.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас дэлхийн 140 орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадварыг үнэлэхэд, Монгол Улс энэ үзүүлэлтээр харьцангуй их хөрөнгө оруулалт татаж чадсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй өндөр чадавхтай орнуудын жагсаалтад²⁰⁵ багтах болсон байна.

Хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг өргөтгөж, үйлдвэрлэлийг бүтээмжийг дээшлүүлдэг. Манай улсын хувьд харамсалтай нь тийм ч үр өгөөжтэй байдал ажиглагдахгүй байна хэмээн судалгааны төгсгөлд дурдсан байна. 2002-2008 онуудад хөрөнгө оруулалт 69.2% өссөн байхад нийт бүтээмж 62.1%-иар дээшилсэн байна. Манай улсын хөрөнгө оруулалтын ихэнх хувь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж байгаа учраас бүтээмжийг төдийлөн ихээр нэмэгдүүлж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулалт нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих урамшууллын механизм болж эдийн засагт үр өгөөжөө өгч байгаа бодит үр дүн муу байна. Дэд бүтцэд төвлөрсөн хөрөнгө оруулалтыг хийж байгаа нь төдийлөн үр ашгаа өгөхгүй удаашралтай байна. Эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн салбар руу хандсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлөөр сул бүс нутагт оюуны хөрөнгө оруулалтыг түлхүү хийх тал дээр анхаарах хэрэгтэй гэсэн санал зөвлөмжүүдийг тусгасан байна. Тус судалгааны эдийн засгийн шинжилгээ, тооцооллын үндсэн дээр гарсан гол дүгнэлтүүдээс дурдвал:

Хөрөнгө оруулалт болон ДНБ-ий хугацаа хоорондын хамаарлаас харахад хөрөнгө оруулалт ерөнхийдөө хугацааны 1 үеийн хожимдолтойгоор үр ашгаа өгдөг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл энэ жил хийгдсэн хөрөнгө оруулалт дараа жилийн ДНБ-ий өсөлтөд чухал нөлөөтэй гэсэн үг. Хөрөнгө оруулалтын үр ашгийг хэмждэг нэг үзүүлэлт болох ICOR²⁰⁶ коэффициент буурах хандлагатай байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг өсч байгааг харуулж байна.

Хэсгийн корреляцийн шинжилгээнээс харахад ДНБ-ий 22% нь хөрөнгө оруулалтын оролцоотой бий болж байна. Үүнээс хувийн хөрөнгө оруулалт нь 14%, улсын хөрөнгө оруулалт нь 8% орчмыг нь бий болгож байна. Хувийн хөрөнгө оруулалт нь улсын хөрөнгө оруулалтаас 1.75 дахин өндөр үр ашигтай байна.

ДНБ нь хөрөнгө оруулалтанд эерэг нөлөөтэй байна. ДНБ 1 сая төгрөгөөр нэмэгдэхэд дараагийн улиралд нь хөрөнгө оруулалт 1.24 сая төгрөгөөр нэмэгдэх хандлагатай байна.

²⁰⁵http://www.investmongolia.com/forum/speech/1stday/FIFTA%20Chairman_B.Ganzorig-mon.pdf

²⁰⁶Incremental capital output rate

Татварын орлого нь хөрөнгө оруулалтад сөрөг хамаарч байна. Онолын хувьд татварын орлого нь хөрөнгө оруулалтад эерэг эсвэл сөрөг нөлөөтэй эсэх нь маргаантай байдаг. Учир нь татварын орлого нь төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг гэдэг утгаараа төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар нийт хөрөнгө оруулалтад эерэг нөлөө үзүүлдэг. Гэвч аж ахуйн нэгж, компаниудын ашгийг бууруулдаг учраас компаниудын өөрийн хөрөнгө оруулалтыг бууруулдаг. Энэ талаасаа бол татварын орлого нь нийт хөрөнгө оруулалтад сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Эцэст нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэж, доорх асуудлуудыг онцолж байна. Үүнд:

1. Манай улсын хувьд хөрөнгө оруулалт ерөнхийдөө хугацааны 1 үеийн хоцрогдолтойгоор үр ашгаа өгдөг байна. Өөрөөр хэлбэл энэ жил хийгдсэн хөрөнгө оруулалт дараа жилийн ДНБ-ий өсөлтөд нөлөөлнө гэсэн үг юм.
2. Манай санхүүгийн тогтолцоонд банкны салбар давамгайлж байгааг өөрчилж санхүүгийн зуучлалыг цаашид хөгжүүлэх шаардлагатай.
3. Монгол Банкаас явуулж буй мөнгөний хатуу бодлого нь зөвхөн зээлийн хүүг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг бууруулах байдлаар илэрч буй болохоос биш эдийн засгийг хөргөхөд үзүүлэх нөлөө нь бага байна.
4. Манайд ДНБ-ий өсөлтийн 22%-ийг хөрөнгө оруулалтаас хангаж байгаа бол үүний 14%-ийг хувийн, үлдсэн 8%-ийг улсын хөрөнгө оруулалт эзэлж байна. Нийт хөрөнгө оруулалтын 6.5% эзэлдэг аж ахуйн нэгжийн хувийн хөрөнгө оруулалт нь улсын хөрөнгө оруулалтаас даруй 1.75 дахин өндөр үр ашигтай байна.
5. Хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг өргөтгөж, бүтээмжийг дээшлүүлдэг. Манай улсын хувьд харамсалтай нь тийм үр өгөөжтэй байдал ажиглагдахгүй байна.
6. Манай улсын хөрөнгө оруулалтын ихэнх хувь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж байгаа учраас бүтээмжийг төдийлөн ихээр нэмэгдүүлж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл болон техникийн даалгавар боловсруулах чадавх сул, олон улсын гэрээний эрх зүйгээр мэргэшсэн хүний нөөц дутагдаж байна.

Хөрөнгө оруулалтын шингээх чадварын талаарх гадаад дотоодын онол, арга зүйн судалгааны мэдээлэл, материалыг /гадаад хэл дээр байж болно/ файлаар болон хэвлэмэл байдлаар ирүүлнэ үү гэсэн захиалагчийн хүсэлтийн дагуу доор дурдсан мэдээ мэдээлэл, судалгааны ажлуудыг хүргүүлж байна. Үүнд:

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээрх материал:

1. Т.Ганчимэг, 2009 он, "Макро эдийн засгийн хөрөнгө оруулалтын үр ашгийг хэмжих нь"
2. Т.Дорж, 2008 он, "Хөрөнгө оруулалтын шингээх чадвар" судалгаа
3. Соёмбо баг, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, 2011 он, "Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа" БС-02
4. Гантулга, ERI (Эдийн засгийн судалгааны хүрээлэн), 2012 он, "Монгол Улсын уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлж буй үр ашгийг дээшлүүлэх зарим арга"

Гадаад хэл дээрх материал:

5. Cohen, W.M. and D.A. Levinthal (1990), Absorptive capacity: A new perspective on learning and innovation., Administrative Science Quarterly
6. Signe Krogstrup, Linda Matar, 2005, Foreign Direct Investment, Absorptive Capacity and Growth in the Arab World
7. Borensztein, E, De Gregorio, J, and Lee, J-W. 1998: How Does Foreign Direct Investment Affect Economic Growth Journal of International Economics.
8. H. Nguyen G. Duysters J. Patterson H. Sander "Foreign Direct Investment Absorptive Capacity Theory"
9. Li, Xiaoying and Xiaming Liu, 2005, Foreign Direct Investment and Economic Growth: An Increasingly Endogenous Relationship, World Development, forthcoming.
10. UNCTAD, 2004, World Investment Report 2004: The Shift Towards Services. York and Geneva: UN.
11. Sourafel Girma, Holger Gorg, 2005, Foreign direct investment, spillovers and absorptive capacity: evidence from quantile regressions
12. Beatrice Farkas, 2012, Absorptive capacity and impact of the PDI on economic growth
13. Davide castellani ise-universita di urbino, 2002, Technology gaps, absorptive capacity and the impact of inward investments on productivity of european firms
14. CEIOPS' Advice for Level 2 Implementing Measures on Solvency SCR standard formula Loss-absorbing capacity of technical provisions and deferred taxes, 2009
15. Xiaolan fu, 2008, Foreign direct investment, Absorptive capacity and regional innovation capabilities: Evidence from China
16. United nations development programme, 2007, Asian foreign direct Investment in Africa
17. Yuko Kinishita and Chia-Hui Lu, 2006, On the Role of Absorptive Capacity: FDI Matters to Growth
18. Isabel Elvarex and Raquel Marin, FDI and world heterogenities: The role of absorptive capacities Thomas Farole and Deborah Winkler, Policy Research Working Paper, 2012, Foreign Firm Characteristics, Absorptive Capacity and the Institutional Framework, The Role of Mediating Factors for FDI Spillovers in Low-and Middle-Income Countries



УИХ-ын Тамгын газар ©
“СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ – XVI БОТЬ”

УИХ-ын Тамгын газрын хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2014.03.24
Хэвлэлийн хуудас: 32 х.х, Хэвлэсэн тоо: 300 ширхэг
Цаасны хэмжээ В5

УБ., 2014